Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2026

02

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч:

Доктор, профессор Ц.Ганболд ОУМА-ийн академич

Сэтгүүлийн ерөнхий редактор:

Докторант, хурандаа Г.Галбадрах Хилийн албаны сургуулийн захирал, хилийн цэргийн 0345 дугаар ангийн захирагч

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Докторант,
Хошууч Т.Баяр-Эрдэнэ Хилийн албаны сургуулийн Инженер техникийн тэнхимийн профессор

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ:

ОУМА-ийн академич, доктор, тэргүүлэх профессор, хурандаа Г.Дагважамц

РЕДАКЦЫН ГИШҮҮД:

Доктор, хурандаа Х.Асхар

Доктор, хурандаа Ц.Одонгэрэл

Доктор, хурандаа Б.Нямжав

Доктор, дэд хурандаа Б.Мөнхбат

Докторант, хурандаа М.Баттулга

Докторант, хурандаа М.Мөнхбаяр

Докторант, Хурандаа Г.Одон-Ертөнц

Докторант, дэд хурандаа М.Ганбаатар

Хурандаа М.Амарсанаа

ГАДААД ГИШҮҮД

Шинжлэх ухааны доктор, профессор Филиппов Станислав Александрович

Доктор, профессор Жулак И

Доктор, профессор Жеймс Б.Паттисон

Доктор, дэд профессор Хармаев Юрий Владимирович

Дугаарыг эрхэлсэн: **Хэвлэлийн хуудас:** 20.8

Докторант,

Хошууч Т.Баяр-Эрдэнэ

Хянан тохиолдуулсан:

Доктор, профессор, хурандаа Ц.Ганболд

Редакцын хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, VIII хороо, Хилчний гудамж, ДХИС-ийн хичээлийн III байр, 518 тоот

Утас: 976 86008998

Цахим шуудан: hilsudlal@gmail.com

Эрхлэх байгууллага: Монголын Хил Судлалын Академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль, Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ
МОНГОЛЫН ХИЛ СУДЛАЛЫН АКАДЕМИ, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛЬ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ СУДЛАЛЫН ТӨВИЙН ОНОЛ-МЭДЭЭЛЛИЙН СЭТГҮҮЛ

27 ДАХЬ ЖИЛДЭЭ **УЛИРАЛД НЭГ УДАА**

№02

2026 он

АГУУЛГА

ХИЛ СУДЛАЛ-ОНОЛ ПРАКТИК

Ё.Хадхүү: Харилцан ажиллагааны агуулга (үндэс)-ын тухай ойлголт

Т.Баяр-Эрдэнэ: Ухаалаг хил: ойлголт, чиг хандлага

Б.Баярмагнай: Хил залгаа улсуудын хил хамгаалалтын талаар баримтлах бодлого, үйл ажиллагааны онцлог

Д.Бадамдорж: Гадаад орнуудын хил хамгаалалтын арга, тактик, туршлага сургамж

Д.Бямбабаяр: Байлдааны бэлэн байдлын онол арга зүй

Э.Нямзагд: Улсын хилийн аюулгүй байдлын үндсэн ойлголтууд, системийн онолтой холбогдох нь

Ц.Дабааням: Орчин үеийн үхэлд үл хүргэх зэвсгийн хэрэглээ ба хандлага

Ц.Цэвээнравдан: Монгол Улсын голын усаар хиллэдэг хэсэгт голын эргийн нуралтын эрсдэлийн үнэлгээ хийх

ХИЛИЙН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБА

Б.Алтангэрэл: Хилийн хяналт шалгалтад профайлинг ашиглах хэрэгцээ шаардлага

Г.Болортунгалаг: Хил хамгаалалтад профайлинг нэвтрүүлэх нь border profile log-in

ЦЭРГИЙН СУРГАЛТ, БЭЛТГЭЛ

Т.Амарзаяа: Цэргийн сургалтын талаарх үндсэн ойлголт

А.Амгаланбаяр: Хилийн цэргийн “цэргийн албаны зохион байгуулалт”-д хийсэн шинжилгээ

А.Баасанбат: Хил хамгаалах байгууллагын мэргэшүүлэх, давтан сургах сургалтын үр нөлөө ба чанарын үнэлгээ: практик, онолын шинжилгээ

Б.Гомбосүрэн: Е сургалт түүний мөн чанар давуу болон сул тал

Д.Түмэнцэцэг: Дотоод хэргийн их сургуулийн спортоор хичээллэдэг сонсогч, суралцагч хичээллэдэггүй сонсогч, суралцагчдын ялгаатай байдал бие бялдар, ачаалал даах чадвар

Х.Түвшинтөгс: Хилийн албаны офицеруудын бие бялдрын бэлтгэлжилтийн өнөөгийн байдал

Э.Сандагжав: Хүн барьцаалсан гэмт хэргийн нөхцөлд явагдах хэлэлцээрийн тактикийн хэрэгжилт ба үр ашгийн шинжилгээ

ХИЛЧДИЙН СЭТГЭЛ СУДЛАЛ

М.Базарсад: Хилчдийн амьдралын чанарыг whoqol-bref аргыг ашиглан судлах нь

Л.Лхагвасүрэн: Хил орчмын нутгийн залуу гэр бүлийн төлөвлөлт, тогтвортой байдалд нөлөөлөх хүчин зүйлс

Б.Рагчаа: Гэр бүлийн харилцаа, хилийн цэргийн салбарын албаны үйл ажиллагаанд нөлөөлөх нь

А.Хүрэлцоож: Төвөөс хэт алслагдсан байдал хилийн цэргийн салбарын алба хаагчдын ажлаас гарах сэдэлд нөлөөлөх нь

Э.Мандал: Эх хэл нь хилийн аюулгүй байдлын нэг салшгүй хэсэг мөн

ИНЖЕНЕР, ТЕХНИК ТЕХНОЛОГИ

Г.Одон-Ертөнц: Олон улсын хил хамгаалалтын чиг хандлага ба мэдээллийн технологид суурилсан хамгаалалтын арга зам

Ш.Ундарга: Хилийн аюулгүй байдалд нисгэгчгүй нисэх хэрэгслийн үзүүлэх сөрөг нөлөө, түүнийг шийдвэрлэх технологийн гарц

Б.Цолмон: Нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн үүсэл, хөгжил ба олон улсын хил хамгаалалтад ашиглагдсан байдал

М.Баттулга: Улсын хил хамгаалалтад ухаалаг камер, мэдрэгчийн технологийг ашиглах судалгаа

Д.Хөлгөн: Хиймэл дагуулын мэдээг хил хамгаалалтад ашиглах нь

ХИЛИЙН ЭРХ ЗҮЙ

Н.Бадраа: Мөнгө угаах гэмт хэрэг ба хил хамгаалалтын уялдаа холбоо, харилцан хамаарал

А.Шинэжил: Зөрчлийн тухай ойлголт хилийн цэргийн эрх бүхий албан тушаалтны шалгах зөрчил

С.Бямба-Эрдэнэ: Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтэд хил хамгаалах байгууллага нөлөөлөх нь

Н.Жинжиймаа: Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд хиймэл оюун ухааны хэрэглээ: Монгол Улсын эрх зүйн орчны шинжилгээ

П.Эрдэнэбаатар: Орон сууцны захиалга авч бусдыг залилах гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүйн онцлог

ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ АГУУЛГА (ҮНДЭС)-ЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Ё.ХАДХҮҮ*
Хил судлалын доктор, хурандаа

**хариуцлагатай зохиогч: yokhadkhuu@gmail.com*

Хураангуй: Харилцан ажиллагааны агуулга нь зорилгоо биелүүлэхийн тулд талууд (цэрэг, байгууллага, улс орнууд) хүч хэрэгслээ нэгтгэн, байрлал, цаг хугацаа болон чиглэлээр уялдуулан зохион байгуулах цогц үйл ажиллагааг хэлнэ. Үүнд даалгавар, зорилтыг хуваарилах, харилцаа холбоо тогтоох, үйл ажиллагааг нэгтгэн удирдах, дэмжлэг үзүүлэх зэрэг элементүүд багтдаг.

Өөрөөр хэлбэл бие биедээ нөлөөлөх, мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа уялдуулах, нөөц бололцоогоо нэгтгэх үйл явц юм. Энэ нь олон улсын харилцааны түншлэл (гэрээ, хэлэлцээр), цэрэг-стратегийн зохион байгуулалт, болон удирдах, захиргааны эрх зүйн харилцаа гэх мэт олон салбарт илэрдэг.

Харилцан ажиллагааны агуулгын онол нь хүмүүсийн нийгэм, байгууллагын орчин дах үйлдэл, харилцааг тэдний дотоод хэрэгцээ, сэдэл (мотиваци)-д тулгуурлан тайлбарладаг хандлага юм. Энэ нь хүмүүс юуны тулд хамтран ажиллаж, ямар хэрэгцээг (биологийн, нийгмийн) хангахыг зорьж буйг судалдаг бөгөөд Маслоу, Мак Клелланд, Херцберг нарын онолууд голлодог.

Харилцан ажиллагааны агуулгын үндсэн талууд:

Зорилгын нэгдмэл байдал: Талууд нийтлэг ашиг сонирхол, хамтын үр дүнд хүрэхийн тулд үйл ажиллагаагаа уялдуулах.

Мэдээлэл солилцоо: Мэдээллийн харилцаагаар дамжуулан шийдвэр гаргах, үйл явцыг удирдах.

Үйлдэл, нөлөөлөл: Материаллаг болон процессын түвшинд бие биеэ дэмжих, хянах, нийлүүлэн ажиллах.

Зохион байгуулалт: Цаг хугацаа, орон зай, хүч хэрэгслийн хувьд нэгдсэн төлөвлөгөөний дагуу ажиллах.

Харилцан ажиллагааны агуулгын гол шинжүүд:

Харилцан хамаарал: Оролцогчдын үйл ажиллагаа нэг нэгнээсээ хамаарч, нэгнийх нь үйлдэл нөгөөдөө шууд нөлөөлдөг.

Хамтын зорилго: Талууд нийтлэг эрх ашиг буюу харилцан хожих (win-win) зарчмыг баримталдаг.

Зохион байгуулалттай үйл явц: Тодорхой дүрэм, журам, харилцан дэмжлэг, уялдаа холбоонд тулгуурладаг.

Диалектик холбоо: Зөрчилдөөнтэй нөхцөлд ч гэсэн зохистой тэнцвэрийг олохыг эрмэлздэг.

Түлхүүр үг: Харилцан ажиллагаа, анги байгууллага, дээд штаб, удирдлага

Удиртгал. 2016 оны 09-р сард Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль шинэчлэгдсэн бөгөөд уг хуулийн 1-р бүлгийн 5-р зүйлийн 2-т “батлан хамгаалах үйл ажиллагааны зорилго нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах, иргэний аюулгүй байдлыг хангахад оршино; 8-р зүйлийн 1-д Монгол Улсын төрийн

цэргийн байгууллын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ гэж тус тус заасан.

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд бүс нутгийн үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодис, зэвсэг, галт хэрэгслийн хууль бус наймаа, олон улсын алан хядах ажиллагаа идэвхжиж, улс төр, эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс улсын хил зөрчих, дүрвэх, цагаачлах, хил орчмын нутаг дэвсгэр, хилийн боомтод нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болох магадлал өсөн нэмэгдэж, улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийн тоо жилээс жилд өсөж, хил орчмын оршин суугчид төвд тэмүүлсэн нутгийн гүн рүү нүүсэн нүүдэлтэй уялдан хил орчмын нутаг дэвсгэр эзэнгүйдэх хандлага нэмэгдэж байгаа зэргээс шалтгаалж хил хамгаалалтын нягтрал үр дүнг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаад дүгнэлт хийж, улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах, явуулахад харилцан ажиллагааг нарийн зохион байгуулах нь тулгамдсан асуудлын нэг болж байна.

Үндсэн хэсэг. Харилцан ажиллагаа (interation, interoperability/cooperation) гэдэг нь хоёр буюу түүнээс дээш талууд (хүн буюу хүмүүс, бүлэг, системүүд, байгууллагууд) нэгдмэл зорилгын төлөө мэдээлэл, туршлага, нөлөөллийг солилцох, бие биеэ дэмжин үйл ажиллагааг уялдуулах, нэгдсэн нэг үр дүнд хүрэхийн тулд хамтран ажиллах үйл явц юм. Энэ нь зөвхөн мэдээлэл дамжуулах төдийгүй, харилцан нөлөөлөх, итгэлцэлд суурилсан стратегийн түншлэл, соёл, зан үйлийн цогц нэгдэл билээ. Өөр хэлбэл үр ашгийг нэмэгдүүлж, харилцан ойлголцлыг бий болгодог.

Харилцан ажиллагаа нь оролцогч талуудын зорилго нэгдэх, мэдээлэл солилцох, хамтран шийдвэр гаргах, хариуцлагаа хуваалцах замаар үр дүнд хүрдэг цогц үйл явц юм. Үүнд ижил тэгш эрх, харилцан ойлголцол, үр ашиг, итгэлцэл зэрэг онцлог шинжүүд илэрдэг. Энэ нь зохион байгуулалттай хамтын үйл ажиллагааны үндэс болно.

Харилцан ажиллагааны үндсэн онцлогууд:

-*Нэгдсэн зорилго буюу Зорилго уялдуулах:* Талууд нийтлэг зорилт буюу нэгдсэн үр дүнд хүрэхийн тулд үйлдлээ уялдуулдаг (үр дүн, ашиг тусыг нэмэгдүүлэх чиглэлтэй), Нийтлэг зорилго, шийдлийг тодорхойлж, үйл ажиллагааг нэгтгэх.

-*Мэдээлэл солилцоо буюу харилцаа холбоо:* Зөв мэдээллийг зөв цагт, зөв хүнд нь хүргэх, өөрөөр хэлбэл мэдээллийг зөв дамжуулж, ойлголцлыг бий болгох.

-*Уялдаа холбоо:* Талуудын үйлдэл хоорондоо зөрчилдөхгүй, бие биеэ нөхөх.

-*Итгэлцэл ба нээлттэй байдал:* Харилцан ажиллагааны суурь нь бие биедээ итгэх итгэл, мэдээллийг нээлттэй солилцоход оршдог.

-*Ижил тэгш эрх:* Талууд хамтын ажиллагааны явцад бие биеэ хүндэтгэж, тэгш эрхийн үндсэн дээр харилцан тохиролцдог.

-*Хариуцлага хуваалцах:* Үр дүнгийн хариуцлагыг талууд хамтран үүрч, гарсан эрсдэл, амжилтыг хуваалцдаг.

-*Уян хатан байдал:* Цаг үеийн нөхцөл байдал, орчны өөрчлөлтөд дасан зохицож, төлөвлөгөөгөө өөрчлөх чадвар.

-*Харилцан ашигтай байх:* Талууд хоёулаа үр шим хүртэх буюу "хамтаар хожих" (win-win) зарчим.

-*Хяналт үнэлгээ:* Харилцан ажиллагааны үр дүнг тооцох.

Хэрэглээний хүрээ:

-*Байгууллага/Ажлын байр:* Харилцаа, хандлага, үйлдлээ эерэг болгож, хамтын бүтээмжийг нэмэгдүүлэх.

-Технологи/Мэдээллийн систем: Өөр өөр системүүд хоорондоо өгөгдөл солилцох, хамтран ажиллах.

Удирдлага/Байлдааны ажиллагаа: Төрөл бүрийн хүчин (хуурай замын, агаарын, хилийн цэргийн, дотоодын цэргийн, цагдаагийн гэх мэт) нэгдсэн удирдлагаар ажиллах.

Товчхондоо, харилцан ажиллагаа нь хамтын хүчээр илүү өндөр үр дүнд хүрэх чадвар юм.

Харилцан ажиллагаа нь үр ашигтай, богино хугацаанд илүү их үр дүнд хүрэх боломжийг бүрдүүлдэг бөгөөд олон улсын харилцаа, байгууллагын удирдлага болон хувь хүмүүсийн харилцаанд чухал үүрэгтэй.

Харилцан ажиллагаа нь диалектик шинжтэй буюу үйлчлэл дундаа оршин байдаг тул талуудын харилцан хамаарлыг нэмэгдүүлдэг байна.

Харилцан ажиллагааг (харилцаа) хамрах хүрээ, түвшин, хэлбэрээр нь өөрийн дотоод (сэтгэл зүй), бие хүн хоорондын, бүлэг/байгууллагын, нийгмийн болон олон нийтийн гэж ангилдаг. Энэ нь мэдээлэл солилцох, хамтран ажиллах, нөлөөлөх замаар зорилгодоо хүрэх, харилцан ойлголцох үйл явц юм.

Харилцан ажиллагаанд тавигдах гол шаардлагууд нь нэгдсэн зорилго, төлөвлөгөө, цаг үеэ олсон мэдээлэл солилцоо, хариуцлагын хуваарилалт болон техникийн нийцэл юм. Энэ нь үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, үр дүнтэй хамтын ажиллагааг бүрдүүлэхэд чиглэдэг.

Харилцан ажиллагааны үндсэн шаардлагууд:

-Нэгдсэн удирдлага, төлөвлөгөө: Харилцан ажиллагааг нэгдсэн зорилго, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах.

-Мэдээллийн солилцоо: Талууд үнэн зөв мэдээллийг шуурхай солилцох.

-Үүрэг, хариуцлагын хуваарилалт: Харилцан ажиллагааны явцад оролцогч талуудын үүрэг, оролцоог тодорхой болгох.

-Техник, технологийн нийцэл: Техник хэрэгсэл, программ хангамжийн нэгдмэл байдлыг хангах.

-Харилцан уялдаа: Үйл ажиллагааг техникийн болон зохион байгуулалтын хувьд уялдуулах.

Үйл ажиллагааны талбараас хамаарах шаардлагууд:

-Харилцаа холбооны салбар: Тусгай зөвшөөрлийн нөхцөл, стандартын шаардлагыг хангах.

-Төрийн байгууллага: Үйл ажиллагааны уялдааг хангах, үндсэн сүлжээний оновчтой бүтэц.

-Санхүүгийн чадвар: Харилцан ажиллагааг хэрэгжүүлэх санхүүгийн боломжтой байх.

Харилцан ажиллагааны эерэг, сөрөг хүчин зүйлүүд:

Харилцан ажиллагааны эерэг хүчин зүйлсэд харилцан итгэлцэл, нээлттэй харилцаа, хамтын зорилго, нөхөрсөг хандлага ордог бол сөрөг талд үл ойлголцол, хариуцлагагүй байдал, түрэмгий зан авир, мэдэмхийрэх хандлага нөлөөлдөг. Эерэг орчин бүтээмжийг өсгөж, сөрөг хандлага нь үл ойлголцол, ажлын бүтээмж буурахад хүргэдэг.

Харилцан ажиллагааны эерэг хүчин зүйлүүд (Нөлөөлөл):

-Итгэлцэл ба хүндэтгэл: Багийн гишүүд бие биедээ итгэж, үзэл бодлыг нь хүндэтгэх.

-Нээлттэй, ил тод харилцаа: Мэдээллийг цаг тухайд нь, үнэн зөв солилцох.

- Хамтын зорилго: Нийтлэг амжилтад хүрэхийн тулд нэгдсэн зорилготой байх.

-Эерэг хандлага, урам зориг: Ажлын байран дээр нөхөрсөг, дэмжлэг үзүүлсэн орчин бүрдүүлэх.

-Үр дүнтэй хамтын ажиллагаа: Ажлын байрны соёл болон соёлын ялгааг ойлгох.

Харилцан ажиллагааны сөрөг хүчин зүйлүүд (Бэрхшээл):

-Үл ойлголцол ба буруу мэдээлэл: Мэдээллийн солилцоо дутуу эсвэл буруу байх.

-Түрэмгий, зөрүүд зан авир: Хурал дээр уурлах, санаагаа тулгах, бусдын яриаг таслах.

-Мэдэмхийрэгч (Know-it-all) хандлага: Өөрийнхөө бурууг хүлээн зөвшөөрдөггүй, зөвхөн өөрийнхөөрөө зүтгэдэг байх.

-Ажлын байрны стресс, бухимдал: Хувийн сэтгэл ханамжгүй байдал бусдад сөргөөр нөлөөлөх.

-Хариуцлагагүй байдал: Ажлаа цагт нь хийдэггүй, биелүүлдэггүй байх.

Эдгээр хүчин зүйлүүд нь ихэвчлэн хүрээлэн буй орчин (гэр бүл, ажлын газар, нийгэм) болон хувь хүний хүмүүжил, хандлагаас бүрддэг.

Харилцан ажиллагааны үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд:

Зорилго ба даалгавар: Нийтлэг зорилгыг тодорхойлж, тал бүрийн гүйцэтгэх үүргийг нарийн тодорхойлох.

Хүч хэрэгслийн уялдаа: Орон тооны болон хүч нэмэгдүүлсэн галын хэрэгсэл, техник, хүн хүчний ажиллагааг нэгтгэх.

Байрлал, цаг хугацаа: Ажиллагааг зөв байрлалд, товлосон хугацаанд, нэгдсэн төлөвлөгөөний дагуу хийх.

Удирдах харилцаа: Мэдээлэл солилцох, албан ёсны болон албан бус сувгаар дамжуулан удирдлага, гүйцэтгэгчдийн хооронд ойлголцол бий болгох.

Дэмжлэг: Шаардлагатай нөөц, үйлчилгээ, туслалцааг цаг тухайд нь үзүүлэх.

Энэхүү үйл ажиллагаа нь цэргийн тактикаас авхуулаад байгууллагын менежмент болон олон улсын стратегийн түншлэлийн хүрээнд хамтын ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгддэг.

Харилцан ажиллагааны үндсэн ойлголтууд:

Мэдээлэл, энергийн солилцоо: Талууд үзэл бодол, итгэл үнэмшил, хандлагаа солилцдог.

Харилцан нөлөөлөл: Бие биедээ нөлөөлөх, сэтгэл санааны байдлыг мэдрэх, харилцан ойлголцох үйл явц.

Хамтын үйл ажиллагаа: Тогтсон зорилгын төлөө нэгдэн, туршлагаа солилцож, хамтран үйлдэл хийх.

Түншлэл: Эрх тэгш, итгэлцэл дээр суурилсан хамтын ажиллагааг бэхжүүлэх.

Харилцан ажиллагааны зарчмууд:

Тодорхой байх: Мэдээлэл ойлгомжтой, тодорхой байх.

Бүхэл бүтэн байх: Харилцааны үйл явц бүх талыг хамарсан байх.

Албан ёсны бус харилцааг ашиглах: Шаардлагатай бол албан бус сувгаар мэдээлэл солилцох.

Харилцан ажиллагааны үндсэн ангилал:

Харилцан ажиллагааг (intercourse/interaction) агуулга, зорилго, арга хэрэгслээр нь ерөнхийд нь *материаллаг* (бүтээгдэхүүн солилцох), *когнитив* (мэдлэг солилцох), *кондицион* (сэтгэц-физиологийн байдал солилцох) гэж ангилдаг. Мөн харилцааг *аман* (яриа) болон *аман бус* (дохио зангаа), *албан* болон *албан бус* гэж ангилах нь түгээмэл.

Агуулгаар нь: -*Материаллаг:* Үйл ажиллагааны бүтээгдэхүүн, юмс солилцох (хэрэгцээ хангах). **-***Танин мэдэхүйн (Когнитив):* Мэдлэг, мэдээлэл солилцох, суралцах. **-***Кондиционн (Сэтгэц-физиологийн):* Сэтгэл санааг өргөх, тайвшруулах, бие биедээ нөлөөлөх.

Хэлбэрээр нь: -*Аман харилцаа:* Яриа, хэлэлцүүлэг. **-***Аман бус харилцаа:* Нүүрний хувирал, дохио зангаа, биеийн хэлэмж.

Бичгийн харилцаа: Албан бичиг, цахим шуудан.

Зорилгоор нь: -*Холбох:* Мэдээлэл дамжуулах. *-Төлөвшүүлэх:* Хүмүүжил, хандлагад нөлөөлөх. *-Баталгаажуулах:* Харилцааг тогтвортой байлгах.

Салбарын тусгай ангилал: -*Байгууллагын (Цахим/Холбоо):* Харилцаа холбооны тухай хуулийн дагуу харилцан холболтын техникийн нөхцөл, үйлчилгээний зохицуулалт. *Эдийн засгийн:* Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэлээр (ҮСХ-ны ангилал). *Цэргийн:* Байлдааны үеийн хамтын ажиллагаа, галын хэрэгслийн зохицуулалт.

Харилцан ажиллагааны мөн чанар нь хоёр буюу түүнээс дээш талууд нэгдмэл зорилгын төлөө нөөц бололцоогоо нэгтгэн, харилцан ашигтай, уялдуулан хамтран ажиллаж, үр дүнг хуваалцах үйл явц юм. Энэ нь үгэн болон үгэн бус хэлбэрээр мэдээлэл солилцож, ойлголцолд хүрэх замаар хамтын ажиллагааг бэхжүүлдэг.

Харилцан ажиллагаа гэдэг нь операц (байлдааны ажиллагаа)-ийн ерөнхий зорилгыг хангахын тулд нэгдэл, стратегийн ач холбогдолтой тулалдаан, байлдааны ажиллагаа явуулж буй нэгтгэл, ангиудын зорилго, үүрэг (объект), байр, цаг хугацаа, тавигдсан стратегийн болон байлдааны үүргийг биелүүлэх аргаар нь харилцан уялдуулж зохицуулсан ажиллагаануудын цогц болно.

Операц (байлдааны ажиллагаа)-ийн зорилго, түүнд оролцож байгаа цэргийн бүрэлдэхүүнээс хамаарч харилцан ажиллагаа нь стратегийн, стратеги-тактикийн болон тактикийн гэж байна.

Стратегийн харилцан ажиллагаа: Стратегийн харилцан ажиллагаа (түншлэл) нь улс орнуудын эсвэл байгууллагуудын хооронд урт хугацааны, харилцан ашигтай, өндөр итгэлцэл дээр суурилсан хамтын ажиллагааны дээд түвшин юм. Энэ нь улс төр, эдийн засаг, батлан хамгаалах зэрэг салбарт хамтын зорилгод хүрэхэд чиглэдэг.

Үндсэн шинж чанарууд:

-Урт хугацааны бодлого: Богино хугацааны ашгаас илүүтэй, алсын хараатай, тогтвортой харилцааг эрхэмлэдэг.

-Иж бүрэн хамрах хүрээ: Зөвхөн нэг салбараар хязгаарлагдахгүй, худалдаа, дэд бүтэц, технологи, соёл зэрэг олон салбарыг хамардаг.

-Харилцан ашигтай байдал: Талууд эрх тэгш, бие биедээ ашигтай байх зарчмыг баримтална.

-Итгэлцэл ба ауулгүй байдал: Улс төрийн өндөр итгэлцэл ба бүс нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэдэг.

Монгол Улс ОХУ, БНХАУ, АНУ, Япон зэрэг орнуудтай стратегийн түншлэлийн харилцаатай бөгөөд энэ нь гадаад бодлогын чухал хэсэг болдог.

Стратеги-тактикийн харилцан ажиллагаа: Стратеги нь урт хугацааны зорилго, нэгдсэн бодлогыг (хол, ойрын төлөвлөлт) тодорхойлдог бол тактик нь түүнд хүрэх бодит, шуурхай үйл ажиллагааг (ойрын үйлдлүүд) илэрхийлдэг. Энэ хоёр нь харилцан уялдаатай байж, стратеги нь тактикийг чиглүүлж, тактик нь стратегийн зорилгыг биелүүлдэг.

Стратеги-тактикийн харилцан ажиллагааны үндсэн зорчим:

-*Нэгдмэл байдал:* Стратеги, тактик нь нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх ёстой бөгөөд нэг нь нөгөөгөө үгүйсгэж болохгүй.

-*Залгамж чанар:* Төрийн болон байгууллагын бодлогын залгамж чанарыг хадгалах үүднээс тактикийн үйл ажиллагаа нь стратегийн урт хугацааны чиглэлтэй нийцэх ёстой.

-*Шуурхай байдал:* Тактик нь нөхцөл байдал, цаг үеийн өөрчлөлтөд хурдан дасан зохицож, стратегийн зорилгыг биелүүлэхэд чиглэсэн шуурхай үйлдэл хийнэ.

-*Харилцан мэдээлэл солилцоо:* Стратеги төлөвлөлт болон бодит үйл ажиллагаа нь харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах замаар оновчтой шийдвэр гаргадаг.

Стратеги нь "юу хийх" (зорилго), харин тактик нь "яаж хийх" (арга зам) гэдгийг тодорхойлж, хамтдаа хамгийн үр дүнтэй үр дүнд хүргэдэг.

Тактикийн харилцан ажиллагаа: Тактикийн харилцан ажиллагаа гэдэг нь байлдааны зорилгыг амжилттай биелүүлэхийн тулд салбар, нэгжүүд (танк, явган цэрэг, их буу, нисэх хүчин гэх мэт) өөр хоорондоо болон дэмжлэг үзүүлэх хүчнүүдтэй цаг хугацаа, байрлал, зорилгын хувьд уялдуулан хамтран ажиллах цогц ажиллагаа юм. Энэ нь галын хүч, маневр, хамгаалалтыг оновчтой хослуулан дайсныг устгах, байлдааны чадавхыг дээшлүүлэхэд чиглэдэг.

Тактикийн харилцан ажиллагааны үндсэн бүрэлдэхүүн:

-*Удирдлага ба зохион байгуулалт:* Командлагчаас өгсөн тушаал, шийдвэрийг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэх.

-*Галын дэмжлэг:* Их буу, миномёт болон агаарын дэмжлэгтэйгээр явган цэрэг, танкны довтолгоог хангах.

-*Маневр:* Салбаруудын байрлалыг шуурхай сольж, дайсныг бүслэх буюу цохилт өгөх.

Хамгаалалт ба тагнуул: Нисгэгчгүй нисэх хэрэгсэл болон (дайсны хорлон сүйтгэх ажиллагаанаас хамгаалах)

Стратеги нь цэргийн урлагийн дээд шат бөгөөд улс орны бүх Зэвсэгт хүчнийг дайнд бэлтгэх, дайн том хэмжээний операц (стратегийн операц гэдэг)-ийг удирдаж явуулах онол практикийг хамардаг. Стратеги нь улс төрийн бодлогоос шууд урган гарах бөгөөд түүнд захирагдана. Стратеги нь Зэвсэгт хүчин бүх ай цэргийн хувьд нэгдмэл байна.

Стратеги (Грек хэлнээс στρατηγία stratēgia, "цэргийн удирдагчийн урлаг; генералын алба, командлал, жанжин" нь тодорхой бус нөхцөлд нэг буюу хэд хэдэн урт хугацааны эсвэл ерөнхий зорилгод хүрэх ерөнхий төлөвлөгөө юм. Цэргийн тактик, бүслэлт, логистик гэх мэт хэд хэдэн ур чадваруудыг багтаасан "жанжны урлаг" гэсэн утгаараа энэ нэр томьёо нь МЭ 6-р зуунд Зүүн Ромын нэр томьёонд ашиглагдаж, барууны хэл рүү орчуулагдсан байдаг. Түүнээс хойш 20-р зууныг хүртэл "стратеги" гэдэг үг нь дайснууд хоёулаа дайсагнасан цэргийн мөргөлдөөнд "хүсэл зорилгын диалектикаар хүч хэрэглэх, заналхийлэх, бодитоор ашиглах зэрэг улс төрийн зорилгоо биелүүлэхийг оролдох цогц арга замыг" илэрхийлэх болсон.

Зорилгодоо хүрэх нөөц нь ихэвчлэн хязгаарлагдмал байдаг тул стратеги чухал байдаг. Стратеги гэдэг нь ерөнхийдөө зорилго, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, зорилгодоо хүрэх үйл ажиллагааг тодорхойлох, үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөөцийг дайчлах явдал юм.

Стратеги нь зорилгодоо (зорилго) арга хэрэгслээр (нөөц) хэрхэн хүрэхийг тодорхойлдог. Байгууллага нь хүрээлэн буй орчиндоо дасан зохицох эсвэл өрсөлдөх

үед стратеги нь зорилготой байж болно, эсвэл үйл ажиллагааны загвар болгон бий болно.[4] Үүнд стратеги төлөвлөлт, стратегийн сэтгэлгээ зэрэг үйл ажиллагаа орно.

Мак Гиллийн их сургуулийн Хенри Минцберг стратегийг стратеги нь төлөвлөлт гэж үздэгтэй харьцуулах шийдвэрийн урсгалын хэв маяг гэж тодорхойлсон бол Хенрик фон Шеел стратегийн мөн чанарыг өвөрмөц үнэ цэний хослолыг бий болгох үйл ажиллагаа гэж тодорхойлсон. Үйл ажиллагааг өөрөөр хийх эсвэл өрсөлдөгчдөөсөө өөр үйл ажиллагаа явуулах. Харин Макс Мак Кеоун (2011) "стратеги нь ирээдүйг тодорхойлох явдал" бөгөөд "боломжтой арга хэрэгслээр хүссэн зорилгодоо хүрэх" гэсэн хүний оролдлого гэж үздэг. Владимир Квинт стратегийг "Үнэнчээр дагаж мөрдвөл урт хугацааны амжилтыг хангахуйц сургаалыг олох, томьёолох, хөгжүүлэх систем" гэж тодорхойлсон.

Тактик. Тактик нь салбар, анги, нэгтгэлийн байлдааныг бэлтгэж явуулах онол, практикийг хамаарна. Тэр нь ерөнхий тактик, тусгай тактикуудад ангилагдана.

Ерөнхий тактик нь бүх төрөл, мэргэжлийн салбар, анги, нэгтгэлийн нэгдсэн нэг бодлого төлөвлөгөөгөөр явагдах байлдааны онол, практик юм. Ийм нэгдсэн нэг бодлого төлөвлөгөөгөөр явагдах байлдааныг ерөнхий цэргийн байлдаан гэнэ.

Тактикийн онол нь орчин үеийн байлдааны шинж чанар, агуулгыг шинжлэн судалж, тактикийн хүч хэрэгслээр явуулах зэвсэгт тэмцлийн зүй тогтол, зарчмуудыг нээн илрүүлнэ.

Цэргийн салбар, ангийн байлдааны боломжийг судлан тогтоож, байлдааныг бэлтгэж явуулах аргыг боловсруулна. Тактикийн онолын хөгжлийн үр дүн, дүгнэлтүүд нь дүрэм, заавар, сурах бичиг, гарын авлага, цэргийн онолын бүтээлүүдэд тусгалаа олдог.

Тактикийн практик тал нь байлдаанд бэлтгэх, түүнийг явуулах үеийн захирагч, цэргийн алба хаагчдын үйл ажиллагаагаар илэрнэ. Тэр нь цагийн байдлын мэдээ цуглуулах, судлах, шийдвэр гаргах, байлдааны үүргийг захирагчдад хүргэх, байлдааныг төлөвлөх, цэрэг, газар орныг байлдаанд бэлтгэх, байлдааныг явуулах, салбар, ангиудыг байлдаанд удирдах, байлдааны бүх талын дэмжлэг, хангалтыг зохион байгуулж хэрэгжүүлэх зэрэг олон талт үйл ажиллагааг хамаарна.

Орчин үед тактикийн үүрэг нь маш өндөр юм. Энэ нь сүүлийн үед болсон хязгаарлагдмал жижиг дайны сургамж, туршлагаар нотлогдож байна. Нэг талаар, ерөнхий цэргийн байлдааны, дайсныг ялахад эзлэх байр суурь өндөр хэвээрээ байна. Нөгөө талаар, тактикийн салбар, ангиудтай байлдааны үүрэг гүйцэтгэх боломж үлэмж их өсөж байна. Ийм учраас тактик (тактикийн бэлтгэл)-ийн ач холбогдол өсөж, цэргийн байлдааны бэлтгэлийн чухал хэсэг, цэргийн сургуулийн сургалтын голлох хичээл болж байгаа юм. Тактик нь цэргийн урлагийн хамгийн хөгжил хөдөлгөөнтэй, уян хатан бүрэлдэхүүн хэсэг юм. Техник технологийн дэвшил хурдсаж, зэвсэгт тэмцлийн хэрэгсэл төгөлдөржин, армийн бие бүрэлдэхүүний боловсрол, соёл, ёс суртахууны дайчин чанар өсөх хэмжээгээр тактикт улам бүр өөрчлөлт, шинэчлэлт гарч, төгөлдөржин боловсронгуй болсоор байна. Тактик цэргийн практик үйл ажиллагаатай улам бүр нягтран ойртож байна. Түүний хөгжлийн төвшин, офицер, штаб, цэргийн тактикийн бэлтгэлийн чанар нь байлдаанд ялах урьдчилсан тулгуур нөхцөл болно. Тактикийн үүргийн хүрээ асар өргөн юм. Тэр нь зэвсэг, байлдааны техникийн хөгжлийн төвшин, ирээдүйн байлдааны шинж чанар, түүнийг явуулах арга, гүйцэтгэж болзошгүй байлдааны үүргийн төлөв байдал агуулга, хэлбэрээр тодорхойлогдож байна.

Тактикийн чухал үүрэг нь газар дээр болон агаарын, электроны, мэдээллийн өрсөлдөөний төвөгтэй цагийн байдалд салбар, ангийн байнгын бэлэн байдлыг

хангахад чиглэсэн арга хэмжээг боловсруулж, амьдралд хэрэгжүүлэх, орчин үеийн стандартын биш байлдааныг явуулах аргыг боловсруулах, түүнд цэргийг сургах явдал юм. Өндөр технологийн эрэн эхэлж, шинэ зарчим дээр үндэслэсэн хөнөөх хэрэгсэл өргөнөөр нэвтэрч байгаа нь, нэг талаар түүнийг эзэмшиж, түүнд нийцсэн байлдааны тактикийг боловсруулах, нөгөө талаар дайсны тийм зэвсгээс хамгаалах, цэргийн аюулгүй байдлыг хангах арга, журмыг боловсруулан амьдралд хэрэгжүүлэхийг шаардаж байна.

Орчин үеийн зэвсэгт тэмцлийн хэрэгсэл салбар, ангиудын зэвсэглэлд нэвтэрч байгаа нь байлдааны шинж чанар, түүнийг явуулах нөхцөлийг үндсээр нь өөрчилж байна. Тактик энэ өөрчлөлтийг илрүүлж, орчин үеийн байлдааны ерөнхий төлөв байдал, тодорхой онцлог талыг тогтоосноор, түүнд бэлтгэх, явуулах шинэ арга, зарчмыг тодорхойлох үүргийг хүлээж байна. Энэ утгаараа, тактик нь бүтээлч шинжтэй юм. Байлдаанд бүх төрөл, мэргэжлийн цэргийн гал, цохилт, маневр, цэргийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг ухаалгаар нягт хослуулснаар дайсныг ялж болно. Тактикийн үүрэг нь ерөнхий цэргийн байлдааны энэ хослолын хамгийн зохистой харьцааг тодорхойлж, түүнд оролцогч хүч хэрэгслийн оролцооны хувь хэмжээг тогтоох явдал юм. Тактикийн чухал үүргийн нэг нь дайсны хүч хэрэгсэл, тэдгээрийг байлдаанд хэрэглэх үзэл бодол, төрөл бүрийн байлдааныг явуулах аргыг судалж, дайсны хүчтэй ба сул тал, зэвсэглэл, техник, цэргийн зохион байгуулалт, ажиллагааны тактикийн үндсийг илрүүлэх явдал юм. Үүний үр дүнд өөрийн ажиллагааны арга, хэлбэрийг тодорхойлж, оюун санаа, цэргийн урлагаар давамгайлгах нөхцөлийг бүрдүүлнэ. Түүнээс гадна, тактик нь цэргийн удирдлага, байлдааны бүх төрлийн хангалтын асуудлыг судалж, түүнийг янз бүрийн нөхцөлд хэрэгжүүлэх практик зааварчилгааг боловсруулна. Салбар, ангийн бие бүрэлдэхүүний ёс суртахуун, сэтгэл зүйн өндөр чанарыг хангах, байлдааны үүргийг амжилттай биелүүлэх сэтгэл санааны бат тогтвортой байдлыг бүрдүүлэхэд тактик чухал үүрэг нөлөөтэй юм. Зэвсэгт тэмцлийг үр ашигтай явуулах ашиг сонирхлын үүднээс, тактикийн хөгжлийн үр дүн, дүгнэлтэд тулгуурлан цэргийн салбар, ангийн бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл, байлдааны бэлтгэлийн төвшинд тавигдах шаардлага боловсруулагдана. Энэ утгаараа тактик нь чиглүүлэн залах шинж чанартай юм.

Дүгнэлт, санал.

Бид энэхүү эрдэм шинжилгээний өгүүллэгээрээ “Харилцан ажиллагааны онол, арга зүйн талаарх асуудлыг дэс дараалалтайгаар судалж “Хил судлал” сэтгүүлд цувралаар нийтлүүлэн эрдэмтэн судлаач, багш, сонсогчид болон бакалавр, стратеги, хил судлалын магистрантууд бусад уншигчдадаа хүргэж байгаа билээ. Дашрамд өгүүлэхүйд: Хилчин эрдэмтэн, судлаач миний хувьд “Хил судлал” сэтгүүл нэгэн үе завсарласан ч дахин гарах болсонд маш талархалтай байдаг. Иймд энэ сэтгүүлийн 2026 оны эхний дугаарт “Харилцан ажиллагааны арга зүй” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийг нийтүүлсэн. Өнөөдрийн дугаарт “Харилцан ажиллагааны агуулга”-ын тухай асуудлыг судлан нийтлүүлж байна.

Товчхондоо энгийн болон цэргийн байгууллага дах харилцан ажиллагааны агуулгын асуудлыг харьцуулан судлав. Судалгаанаас үзэхэд харилцан ажиллагааг тодорхойлсон хэд хэдэн томьёолол нь тухайн байгууллага энгийн салбарынх уу, цэргийн салбарынх уу гэдгээс хамааралтайгаар өөр өөр илэрхийлэгдэж байна. Тэдгээр нь салбар мэргэжлийн онцлогоос шалтгаалан үг, өгүүлбэрийн хэллэгээр ялимгүй ялгаатайгаас бус агуулгаараа харилцан ажиллагааг л тодорхойлжээ. Мөн “харилцан ажиллагаа”-ны тухайд энгийн, цэргийн байгууллагын болоод улс орны дотоод, гадаадын улс орнуудын хоорондын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан “хамтын

ажиллагаа”, “түншлэлийн харилцаа” гэх зэргээр нэрлэсэн ойлголтууд ч байна. Эдгээр нь байгууллага хоорондын нэгэн зорилго чиглэлтэй нийтлэг үйл явцыг илтгэж байгаа харилцан ажиллагааны сэдэв юм. Жишээлбэл: ОХУ-ын Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Монгол Улсын Зэвсэгт хүчний жанжин штабын дарга нар 2026 оны 4 дүгээр сард харилцан ажилласныг хамтын ажиллагаа гэж нийтэлсэн.

Санал. ОХУ, Монгол улсын жанжин штабуудын дарга нарын уулзалтын хүрээнд улмаар батлан хамгаалах яамдын харилцан ажиллагааг л тодотгож байгаа үйл явц юм.

Дараагийн дугааруудад “Харилцан ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт” сэдвээр судалж эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэх зорилготой ажиллаж байна.

Ашигласан эх сурвалж:

1.Ё.Хадхүү. Харилцан ажиллагааны онол арга зүй, сургалт арга зүйн фондын лекц
2.Цахим ном.
3.Нэвтэрхий толь.
4.Хүннү булан. 2026 он

УХААЛАГ ХИЛ: ОЙЛГОЛТ, ЧИГ ХАНДЛАГА

Т.БАЯР-ЭРДЭНЭ*
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Инженер техникийн тэнхимийн профессор, Хил судлалын докторант, хошууч

**Хариуцлагатай зохиогч: Bayarerdene.t@uia.gov.mn*

Хураангуй: Орчин үеийн хил хамгаалалт нь технологийн эрчимтэй хөгжил, даяаршил, хил дамнасан аюул заналын өөрчлөлттэй уялдан шинэ шатанд шилжиж байна. Энэ хүрээнд "ухаалаг хил" хэмээх ойлголт нь мэдээллийн технологи, Artificial Intelligence, өгөгдлийн анализад тулгуурласан, эрсдэлийн удирдлагад чиглэсэн хил хамгаалалтын шинэ загвар болж төлөвшиж байна. Уг өгүүлэлд ухаалаг хилийн мөн чанар, үндсэн шинж, хөгжлийн чиг хандлагыг авч үзэв.

Түлхүүр үгс: ухаалаг хил, хил хамгаалалт, Artificial Intelligence, Internet of Things, эрсдэлийн удирдлага

Үндсэн хэсэг

Бидний амьдралд "ухаалаг" буюу "smart" гэдэг үг, ойлголт орж ирээд багагүй хугацаа өнгөрчээ. Ухаалаг төр, ухаалаг гэр, ухаалаг утас, ухаалаг барилга, ухаалаг хот, ухаалаг самбар, ухаалаг хил гэх мэт.

XX зууны сүүл үеэс мэдээллийн технологи хөгжихийн хэрээр "smart буюу ухаалаг" гэдэг ойлголт техник, систем, цахим орчинд өргөн хэрэглэгдэх болж, "өөрөө мэдээлэл боловсруулдаг, дасан зохицдог, автоматажсан" гэсэн шинэ агуулга нэмэгдсэн.

Smart буюу ухаалаг гэдэг нь ухаантай гэсэн хүний шинж чанарыг бус өгөгдөлд суурилсан, автомат ажиллагаатай, төрөл бүрийн мэдрэгчтэй, хиймэл оюунд суурилсан, нэгдсэн удирдлагад холбогдсон систем юм.

Технологийн салбарт ухаалаг утас, ухаалаг цаг, ухаалаг орон сууц, ухаалаг автомашин гэсэн чиглэлээр хөгжиж байгаа бөгөөд энд интернэт сүлжээнд холбогдож, өгөгдөл боловсруулах, хэрэглэгчийн зан төлөвт тохирох, автомат удирдлагатай байх гэсэн утгыг илэрхийлнэ. Харин төрийн болон цэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдлын салбарт ухаалаг хот, ухаалаг засаглал, ухаалаг хил, ухаалаг аюулгүй байдал гэсэн ойлголтууд бий болсон бөгөөд мэдээллийн нэгдсэн систем, хиймэл оюун, хяналт мэдрэгч, дата-анализ, эрсдэлийн үнэлгээ, автомат удирдлагад суурилсан үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд ихээхэн нөлөөлж байна.

Дэлхийн зарим улсууд улсын хилийн халдашгүй дархан байдал, хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа хил хамгаалалтыг технологид суурилж зохион байгуулах буюу "У***хаалаг хил***" гэсэн загварыг бий болгожээ.

"Smart border" буюу ухаалаг хил нь мэдээлэл, дохиолол хяналтын хэрэгсэл, хиймэл оюун, автомат хяналт, дата анализад суурилан улсын хил хамгаалалтын үр дүнтэй, эрсдэлд суурилсан, урьдчилан сэргийлэх хэлбэрт шилжүүлсэн орчин үеийн хил хамгаалалтын загвар юм.

Ухаалаг хил нь олон төрлийн технологийн нэгдэл дээр суурилдаг бөгөөд дараах үндсэн элементүүдээс бүрдэнэ. Үүнд:

1.Биометр систем (ШНА-д)
-Царай таних
-Хурууны хээ
-Нүдний солонгон бүрхэвч
2.Төрөл бүрийн дохиоллын мэдрэгч, хяналтын хэрэгсэл

-Дулаан мэдрэгч
-Хөдөлгөөн мэдрэгч
-Радарын систем
-Хиймэл дагуул
-Нисгэгчгүй нисэх хэрэгсэл/дрон
3.Хиймэл оюун ба дата анализ
-Сэжигтэй хөдөлгөөнийг илрүүлэх
-Зан төлөвийн анализ хийх
-Эрсдэлийн үнэлгээ хийх
-Урьдчилан таамаглаж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх
4.Автомат шалган нэвтрүүлэх систем
-Цахим гарц буюу e-gate
-Ухаалаг гарц буюу SmartGate

Эдгээр технологийн шийдлүүдийг Европын холбоо (“Smart Borders Package”, “Entry/Exit System (EES)”, “ETIAS”), Америкийн Нэгдсэн Улс (AI-д суурилсан эрсдэлийн үнэлгээ, автоматжуулсан худалдаа, зорчигчийн мэдээллийн систем), Сингапур (Smart Checkpoint) зэрэг улсууд хил хамгаалалтдаа нэвтрүүлэн ашиглаж байна.

_ Ухаалаг хил хамгаалалт нь хил хамгаалалтын үр дүнг дээшлүүлэх, хүний хүчин зүйлээс хамааараг алдааг багасгах, эрсдэлийг урьдчилан илрүүлэх боломжийг нэмэгдүүлэх, шуурхай шийдвэр гаргаж удирдах ажиллагааг, хил нэвтрэх хугацааг шуурхай болгох зэрэг давуу талтай боловч дараах эрсдэл, сул талуудыг дагуулж байна.

Үүнд кибер аюулгүй байдал, өндөр өртөгтэй технологи, техникийн хараат байдал, хиймэл оюуны хэвийн ажиллагаа зэрэг болно.

Тухайлбал Европын холбоонд 2025 онд нэвтрүүлсэн Entry/Exit System нь нэг хүний олон нэр ашиглах, хуурамч бичиг баримт ашиглах, визний зөрчлийг илрүүлэх чадвар сайжирсан, хил нэвтрэх хугацаа багассан, Шенгений бүсэд зөвшөөрөгдсөн хугацаанаас хэтэрсэн этгээдүүдийг илрүүлэх боломж дээшилсэн байна. Гэвч хувь хүний биометр мэдээлэл хэт их төвлөрч, хувь хүний мэдээллийн аюулгүй байдалд эрсдэл үүссэн. Мөн техникийн саатлын улмаас хил дээр оочер, дугаар үүсэх, иргэдийн бухимдал үүсэх зэрэг сул талууд ажиглагджээ.

АНУ-ын хувьд “Simplified Arrival” системийг томоохон нисэх буудлуудад ашиглаж байгаа бөгөөд бичиг баримт шалгах хугацааг бууруулж, зорчигчийн урсгалын хурдыг нэмэгдүүлсэн байна. Олон улсад эрэн сурвалжлагдаж байсан гэмт хэрэгтнүүдийг биометрийн системийн тусламжтай илрүүлж, хиймэл оюунаар сэжигтэй зорчигч, ачааг урьдчилан ангилах боломж бүрджээ.

Гэсэн хэдий ч Африк болон Ази гаралтай хүмүүс дээр царай таних системийн алдаа өндөр гарчээ.

Сингапур улсын хувьд Woodlands checkpoint системийг ашигласнаар олон мянган зорчигчдыг богино хугацаанд шалгах боломжтой болсон төдийгүй гадаадын иргэн харьяатын газар, гааль, тээврийн системүүд нь нэгдсэн платформд холбогдсон.

Гэхдээ энэ систем нь дэд бүтцийг байгуулахад өндөр зардал гаргасан бөгөөд бүх олон төрлийн мэдээллийг агуулсан нэгдсэн дата систем нь кибер халдлагад өртөх эрсдэлийг нэмэгдүүлжээ.

Дүгнэж хэлэхэд Ухаалаг хил нь хил хамгаалалтын үр дүн, эрсдэлийн удирдлага, шуурхай ажиллагааг мэдэгдэхүйц сайжруулж байгаа боловч кибер аюулгүй байдал, хүний эрх, хувийн мэдээллийн хамгаалалт, технологийн хараат байдлын шинэ төрлийн

сорилтыг мөн бий болгож байна. Иймээс ухаалаг хилийн хөгжил нь зөвхөн технологийн асуудал бус, эрх зүй, ёс зүй, мэдээллийн аюулгүй байдал, хүний эрхийн зохистой тэнцвэрийг шаардсан цогц бодлогын асуудал болж байна.

Монгол Улс нь хоёр их гүрэн болох ОХУ болон БНХАУ-тай хиллэдэг, өргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн амын нягтаршил багатай, урт хуурай газрын хилтэй улсын хувьд хил хамгаалалтын онцгой геостратегийн нөхцөлд оршдог. Ийм нөхцөл нь уламжлалт хүний хүч давамгайлсан хил хамгаалалтын тогтолцоог дангаар нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болгож, технологид суурилсан “ухаалаг хил”-ийн хөгжлийн хэрэгцээг нэмэгдүүлж байна.

Өнөөдөр БНХАУ нь дэлхийн хамгийн өндөр технологижсон хилийн хяналтын системийг хөгжүүлж, хиймэл оюун, нүүр таних технологи, big data, ухаалаг хяналтын сүлжээ, автомат хяналтын платформуудыг хил хамгаалалтдаа өргөн ашиглаж байна. Ялангуяа Шиньжан, Төв Азийн чиглэлд олон түвшний мэдрэгч, камер, дрон, AI-д суурилсан хяналтын системийг нэвтрүүлсэн нь “ухаалаг хил”-ийн өндөр түвшний жишээ болж байна.

Нөгөө талаас ОХУ нь хил хамгаалалтад инженерийн саад, радиолокаци, автомат хяналтын систем, нисгэгчгүй төхөөрөмж, хиймэл дагуулын тандалт ашиглах чиглэлд хөгжүүлэлт хийж байгаа боловч өргөн уудам хил, геополитикийн аюулгүй байдлын нөхцөлөөс шалтгаалан уламжлалт цэрэг-инженерийн хамгаалалтын элемент өндөр хэвээр байна.

Энэ нөхцөлд Монгол Улсын хилийн аюулгүй байдалд дараах аюул, занал, эрсдэл бий болж байна: Үүнд:

- Технологийн хөгжлийн түвшний ялгаа нэмэгдэж байна;
- Хил дамнасан мэдээллийн урсгал, худалдаа, тээвэр эрчимжиж байна;
- Хууль бус шилжилт хөдөлгөөн, контрабанд, кибер болон мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл өөрчлөгдөж байна;
- Уул уурхай, боомтын ачаалал нэмэгдэж байна;
- Алслагдсан бүсэд хүний хүчээр тасралтгүй хяналт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.

Иймээс Монгол Улсад “ухаалаг хил”-ийн тогтолцоог үе шаттай хөгжүүлэх шаардлага үүсэж байна. Гэвч өндөр хөгжилтэй орнуудын загварыг шууд хуулбарлах бус Монгол орны газарзүйн онцлог, уур амьсгал, хүн амын тархалт, эдийн засгийн боломж, инженерийн дэд бүтэц, хил хамгаалалтын тогтолцооны онцлог зэрэг хүчин зүйлтэй уялдуулан хөгжүүлэх нь чухал юм.

Монгол Улсын хувьд хамгийн бодитой хөгжлийн чиглэл нь эрсдэл өндөртэй чиглэлд ухаалаг техник технологийг түлхүү ашиглах, боомтуудад биометр болон автомат шалган нэвтрүүлэх систем нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, UAV/Drone ашиглалтыг нэмэгдүүлэх, хиймэл оюунд суурилсан эрсдэлийн үнэлгээ ашиглах, хил хамгаалалтын инженерийн байгууламжийг ухаалаг дохиолол-хяналтын системтэй уялдуулах зэрэг болно.

Гэсэн хэдий ч Монгол Улсад санхүүгийн хязгаарлалт, дэд бүтцийн хөгжил, кибер аюулгүй байдлын чадавх, мэргэжлийн хүний нөөц, мэдээллийн нэгдсэн тогтолцооны асуудал зэрэг сорилтууд бодитоор оршиж байна.

Иймээс Монгол Улсын “ухаалаг хил”-ийн хөгжил нь зөвхөн техник худалдан авах асуудал бус, харин үндэсний хэмжээний дата бодлого, кибер аюулгүй байдал, инженерийн хангалт, хүний нөөцийн чадавх, эрх зүйн орчин, байгууллага хоорондын мэдээллийн интеграц зэрэг цогц шинэчлэлтэй уялдах шаардлагатай байна.

Монгол Улс геостратегийн байрлал, урт хуурай газрын хил, хүн амын тархалтын онцлогоос шалтгаалан ухаалаг хилийн технологийг хөгжүүлэх бодит хэрэгцээ өндөр байгаа бөгөөд хөрш орнуудын технологийн хөгжлийн нөлөө, бүс нутгийн аюулгүй байдлын шинэ сорилтууд нь хил хамгаалалтын уламжлалт тогтолцоог технологид суурилсан, мэдээлэлд төвлөрсөн, эрсдэлд суурилсан ухаалаг удирдлагын тогтолцоо руу үе шаттай шилжүүлэх шаардлагыг улам нэмэгдүүлж байна.

Дүгнэлт

Орчин үеийн хил хамгаалалт нь уламжлалт инженерийн байгууламж, хүний хүч давамгайлсан тогтолцооноос технологид суурилсан, өгөгдөлд төвлөрсөн, автомат удирдлагатай тогтолцоо руу шилжиж байна. Энэ өөрчлөлтийн гол илэрхийлэл нь “ухаалаг хил” юм.

Ухаалаг хил нь зөвхөн техник технологийн шинэчлэл бус, харин хил хамгаалалтын философи, удирдлага, эрсдэлийн үнэлгээ, шийдвэр гаргах ажиллагааны шинэ хэлбэр болж байна. Цаашид хиймэл оюун, их өгөгдөл, автомат хяналтын системийн хөгжилтэй уялдан ухаалаг хилийн технологи улам боловсронгуй болж, үндэсний аюулгүй байдлын чухал тулгуур чиглэл хэвээр байх төлөвтэй байна.

Ашигласан эх сурвалж

1. European Commission. *Smart Borders Package*. Brussels, 2024.
2. Frontex. *Technology and Innovation in Border Management*. Warsaw, 2023.
3. International Organization for Migration (IOM). *Border Management and Information Systems*. Geneva, 2022.
4. Gessner, T. *Smart Systems Integration*. VDE Verlag, 2007.
5. Palagin, O. et al. *Information Technology and Integrated Tools for Support of Smart Systems Research Design*. arXiv, 2018.
6. Leaman, J. *A Comprehensive Review of Smart Systems*. arXiv, 2017.
7. European Union Agency eu-LISA. *Entry/Exit System (EES)*, 2025.
8. CBP. *Biometric Entry-Exit Program*. United States Customs and Border Protection, 2024.
9. ICAO. *Biometric Identification and Border Security*. Montreal, 2021.
10. World Customs Organization. *Smart Borders and Coordinated Border Management*. Brussels, 2020.

ХИЛ ЗАЛГАА УЛСУУДЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

Б.БАЯРМАГНАЙ*
Удирдлагын академийн хилийн стратегийн 8012 дугаар дамжааны суралцагч, хошууч

**хариуцлагатай зохиогч: baarmagnajbambazav278@gmail.com*

Хураангуй: Судалгаанд манай улстай хил залгаа орших Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагааны онцлогийг харьцуулан шинжилж, тэдгээрийн аюулгүй байдлын үзэл баримтлал, зохион байгуулалтын бүтэц, технологийн хэрэглээ, мөн бүс нутгийн онцлогт тулгуурласан арга барилыг авч үзсэн. Судалгааны үр дүнгээс харахад хоёр улс хил хамгаалалтын салбарт төвлөрсөн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, өндөр технологид суурилсан хяналтын системийг өргөн ашиглаж байна. Гэвч геополитик байрлал, эдийн засгийн хүчин зүйлс, хүн ам зүйн ялгаанаас шалтгаалан тэдгээрийн бодлого болон хэрэгжилтийн хэлбэр, онцлог харилцан адилгүй байна.



Abstract

This study conducts a comparative analysis of the border protection policies and operational characteristics of the Russian Federation and the People's Republic of China, examining their security concepts, organizational structures, use of technology, and region-specific approaches. The findings indicate that both countries implement centralized management systems in border protection and extensively utilize technology-based surveillance systems. However, due to differences in geopolitical positioning, economic conditions, and demographic factors, their policies and modes of implementation exhibit distinct characteristics.

Түлхүүр үгс: Хил хамгаалалт, үндэсний аюулгүй байдал, Орос, Хятад, бодлого, технологи

Keywords: Border security, national security, Russia, China, policy, technology

Оршил: Улсын хил нь бүрэн эрхт байдлын илэрхийлэл төдийгүй үндэсний аюулгүй байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Дэлхийн томоохон гүрнүүд болох Орос, Хятад улс нь өргөн уудам газар нутаг, урт хилтэй тул хил хамгаалалтын бодлого нь тэдний аюулгүй байдлын стратегид онцгой байр суурь эзэлдэг. Энэхүү өгүүлэл нь дээрх хоёр улсын хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагааны онцлогийг системтэйгээр харьцуулан авч үзэхэд чиглэнэ.

Монгол Улс *Оросын Холбооны улс* *БНХАУ*

Зураг 1. Хил залгаа улсуудын төрийн сүлд, хилийн баганын зураг

Онолын үндэс ба судлагдсан байдал:

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хил залгаа улсын хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагааны талаар Монгол Улсын төрийн хилийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга зам, ерөнхий хөтөлбөр Ш.Арвай-1998, Төрөөс улсын хил, түүний хамгаалалтын талаар баримталсан бодлогыг судалсан нь Б.Бат-Эрдэнэ-2003, Монгол Улсын хилийг тогтоож хамгаалсан нь П.Сүндэв-2003, Оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд улсын хил, хязгаар нутгийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь Х.Жекей-2004, Хил судлалын шинжлэх ухааны онол практикийн зарим асуудал Д.Нямдорж-2014, Монгол Улсын хилийн цэргийн байгуулалтыг боловсронгуй болгох нь А.Энхтөр-2021, Хил судлал Ц.Ганболд-2022 нарын эрдэм шинжилгээний бүтээлүүд нь онол, практикийн үйл ажиллагаанд тусгалаа олон хэрэгжиж байгаа боловч сүүлийн жилүүдэд хил залгаа улсад гарч буй цэрэг, улс төрийн нөхцөл байдал, хууль, эрх зүйн баримт бичгүүд, тус улсуудын хил хамгаалалтын талаар баримтлах бодлого, үйл ажиллагааг тусгайлан судалсан байдал хомс байгаа нь дээрх сэдвийн хүрээнд судалгаа хийх шаардлага зүй ёсоор гарч байна.

Хил хамгаалалтын бодлогын онолын үндэс:

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого гэж улс, нийгэм, хувь хүний ашиг сонирхлыг хилийн орон зайд хангахад чиглэсэн төрийн гадаад дотоод улс төрийн бодлогыг хэлнэ. Уг бодлогыг хэрэгжүүлэгч гол субъектүүд нь улс орны гадаад харилцаа, хууль хяналт, хил хамгаалалт, тагнуул, гааль, эдийн засаг, эрүүл ахуй, байгаль орчин, батлан хамгаалах гэх мэт асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд байдаг. Хил судлалын шинжлэх ухааны объект нь улсын хил хилийн аюулгүй байдлын асуудал байдаг бөгөөд түүний судлах зүйлд хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хууль, зүй тогтол, арга хэлбэр, зарчмууд, түүний тулгамдсан асуудал, хөгжлийн чиг хандлага зэрэг асуудал хамрагддаг. (Д.Нямдорж, 2014)

Хил хамгаалалтын бодлого нь улсын үндэсний аюулгүй байдлын бодлогын салшгүй хэсэг бөгөөд гол зорилго нь улсын хилийг хууль бусаар нэвтрэх, хил дамнасан гэмт хэрэг, терроризм, хууль бус худалдаа, хүн амын хяналтгүй шилжилт зэрэг эрсдэлийг бууруулахад чиглэдэг. Судлаач Б.Энхбат (2022)-ын тодорхойлсноор, хил хамгаалалтын бодлого нь цэрэг, дипломат, эдийн засаг, технологийн хамгаалалтын олон түвшний харилцан уялдаатай тогтолцоо юм.

Өнөөгийн олон улсын харилцаанд “хатуу хамгаалалт” (military security) болон “зөөлөн хамгаалалт” (soft border management) гэсэн хоёр чиг хандлага зэрэгцэн оршиж байна. Хатуу хамгаалалт нь хил дээрх цэргийн болон технологийн хяналт давамгайлдаг бол зөөлөн хамгаалалт нь хил орчмын хамтын ажиллагаа, эдийн засгийн уялдаа, мэдээллийн солилцоог чухалчилдаг.

Судалгааны арга зүй:

Судалгаанд харьцуулсан шинжилгээний арга, баримт бичгийн задлан шинжилгээ (policy analysis), хоёрдогч эх сурвалжийн тойм судалгааг ашиглав. Албан ёсны бодлогын баримт бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэл, олон улсын байгууллагын тайлангуудыг үндэслэл болгон авч үзсэн.

Оросын Холбооны Улсын хил хамгаалалтын бодлого:

Оросын Холбооны Улс дэлхийн хамгийн урт хуурай газрын хилтэй (ойролцоогоор 60,000 км) бөгөөд түүнийг хамгаалахад өндөр төвшний цэргийн, технологийн болон мэдээллийн нэгдсэн систем ашигладаг. Хил хамгаалалтын алба нь Холбооны Аюулгүй Байдлын Албанд (ФСБ) харьяалагддаг бөгөөд хилийн орон зайг стратегийн гурван бүсэд ангилж хамгаалдаг.

Шууд хамгаалалтын бүс—хил орчим дахь цэргийн болон инженерийн байгууламж;

Хяналтын бүс—хилээс 30–50 км-т байрлах ажиглалт, тагнуулын сүлжээ;

Стратегийн дэмжлэгийн бүс—бүс нутгийн аюулгүй байдлыг хангах зориулалттай хилийн дотоод бүс (Ministry of Defence of the Russian Federation, 2023).

Сүүлийн жилүүдэд тус улс нь хил хамгаалалтад хиймэл дагуулын хяналт, дрон, автомат хяналтын систем, радарын сүлжээг ашиглах замаар дижитал хилийн хамгаалалт руу шилжиж байна. Геополитикийн хувьд баруун (Европ) чиглэлд НАТО-гийн нөлөөнд төвлөрсөн хатуу хамгаалалт, харин зүүн чиглэлд (Азийн орнуудтай) харьцангуй зөөлөн, хамтын ажиллагаанд суурилсан бодлого хэрэгжүүлдэг (Petrov, 2022).

ОХУ-ын төр нь үндэсний аюулгүй байдал хангагдах үндсэн нөхцөлийн нэг нь улсын хилийг найдвартай хамгаалах явдал гэж үздэг. ЗХУ байх үед тус гүрний хил үндсэндээ баталгаажиж, найдвартай хамгаалагдаж байсан боловч ЗХУ задарснаас хойш ОХУ-ын хилийн баталгаажилт, хамгаалалтад эерэг бус ноцтой үр дагавар бий болсон байна. Түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн нэг нь ЗХУ-ыг бүрдүүлж байсан 15 улсаас ялангуяа баруун хойд, баруун, өмнөд чиглэлд орших 14 улс бие даасан тусгаар тогтносон улс болсноос, тэдгээр улсууд, ОХУ-ын хооронд улсын хил эдүгээ хүртэл тодорхойлогдож, албан ёсоор тогтоон тэмдэглэгдэж амжаагүй, ЗХУ-ын үед байсан хилийн цэргийн дөрвөн тойрог, олон арван хилийн отряд, заставууд тусгаар тогтносон улсуудын нутагт үлдэх болсон тул тэднийг татан буулгахаас өөр аргагүй болжээ.

ОХУ-ын Холбооны хилийн албыг, хилийн харуул, хилийн цэрэг гэх мэт уламжлалт тогтолцоог хадгалсан суурин дээр 2003 оноос эхлэн байгуулж ОХУ-ын холбооны аюулгүй байдлын албанд харьяалуулсан байна. Тэгэхдээ энэ алба нь “Төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлогыг улсын хилийг манах, хамгаалах хүрээнд хангаж, хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн гүйцэтгэх засаглалын бие даасан холбооны байгууллага мөн” гэдгийг тодорхойлж, ОХУ-ын холбооны сайдын зэрэгтэй, хилийн цэргийн командлагч, хурандаа генерал цолтой, ОХУ-ын засгийн газрын өргөн мэдүүлснээр ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар тохоон томилогддог албан тушаалтан гэж үзсэн байна. (Д.Нямдорж, 2014)

Холбооны хилийн алба нь цэргийн байгууллага бөгөөд бүтэц нь хилийн албыг тайван ба цэрэг дайны үед хилийн албаны хүч хэрэгслийг удирдах үндсэн байгууллага болох штаб, салбар байгууллага болох 8 департаментаас бүрдэх болжээ. Үүнд төв аппарат нисэх хүчин, зэвсэглэл, олон улсын гэрээ эрхийн, далай тэнгисийн, хилийн хяналтын, ар талын, тагнуулын зэрэг департментууд багтаж байна. Холбооны хилийн алба нь бүтцийн хувьд Батлан хамгаалах тойргуудтай ойролцоо, тэгэхдээ тэдгээрийн харьяалах зурвас стратегийн зорилтуудын нэгдмэл байдлыг хангах чиглэлтэй уялдуулан байгуулагдсан нь ажиглагддаг. Өнөөдрийн байдлаар Холбооны хилийн алба нь 8 бүсийн тойрог, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн бүрэлдэхүүн болох 5 улсад байрлуулсан хязгаарын шуурхай бүлгүүдээс бүрдэж байна. Бүсийн хязгаарын удирдах газрууд дотроо хязгаарын 4-5 газраас бүрдэж байна. Жишээ нь: Төвийн холбооны тойргийн бүсийн хязгаарын удирдах газар Воронежод төвтэй, Смолёнск, Брянск, Курск, Белгород гэсэн нийт 4 хязгаарын газартай юм. Энэ мэтчилэн бүс нутгийн Өмнөд тойрог, Привольж, Урал, Сибирь, Алс Дорнод, Баруун хойд, түүнчлэн Умард туйлын буюу Арктикийн бүс гэсэн тойргуудад хуваагдаж байгаа ба хязгаарын шуурхай бүлгүүд нь Тажик, Армян, Абхаз, Өмнөд Осет, Казахстан, Беларуст өөрийн анги, нэгтгэл, агаар, зенитийн хүчинтэй байрлаж байна.

Монгол Улстай хил залгасан хилийн бүх хэсэгт хилийн аюулгүй байдлыг Новосибирск хотод төвтэй Сибирийн холбооны тойргийн бүс нутгийн хязгаарын удирдах газар хариуцан хэрэгжүүлж байна. Энэ удирдах газар нь дотроо Омск, Новосибирск, Алтайн Бүгд Найрамдах Улс, Тува, Буриад, Чита эдгээр 6 газарт төвлөрсөн хязгаарын газруудаас бүтэц нь бүрджээ. Зураг № 2




Зураг 2. Холбооны Хилийн албаны Сибирийн тойргийн харьяа хилийн газруудын байршил.

Манай улстай хил залгасан хэсэгт ОХУ-ын холбооны субъект болох Бүгд Найрамдах Тува Улс, Уулын Алтай, Эрхүү, Бүгд Найрамдах Буриад Улс, мөн Чита тэдгээрийн зах хязгаарын олон районууд оршдог. Улсын хилийн дийлэнх хэсэг нь инженер-техникийн хэрэгслээр иж бүрэн төхөөрөмжлөгдөж, хилийн шугамын дагуух өндөрлөг газруудад хяналтын бэхжүүлсэн бат бэх байр, байгууламж баригдаж, агаарын ба газар усны орон зай нь өдөр шөнийн хяналтад авагдсаны зэрэгцээ дунджаар 5-10 км-т нэг застав, хязгаарын тасаг, харин 300-500 км хэсэгт комендатур, хэлтэс, отряд, газар оногдох нягтралтайгаар хамгаалалт явагдаж улсын хил зөрчсөн этгээдийг нисэх хэрэгсэл, нисдэг тэрэг, тусгай зориулалтын хүч, техник ашигласан шуурхай бүлгээр шийдвэрлэх, бүх шатны удирдлагад орчин үеийн автоматчилсан мэдээлэл холбооны хэрэгсэл ашиглан хил хамгаалалтыг зохион байгуулдаг бүтцийн тогтолцоотойгоос гадна улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр, хүн амын суурьшил, хөдөлгөөн гүйцэтгэх алба, цагдаагийн алба, казак маягийн цэрэгжсэн хүч, иргэдийн нэгдсэн хяналт, шалгалтын тогтолцоонд багтаж байна. (Н.Наранжамц, 2012)

Институцийн бүтэц:

Оросын Холбооны Улсын хил хамгаалалт нь төвлөрсөн удирдлагатай бөгөөд Холбооны аюулгүй байдлын албанд (ФСБ) харьяалагддаг хил хамгаалах албаар хэрэгждэг. Энэ нь цэрэгжсэн бүтэцтэй, үндэсний аюулгүй байдлын системийн салшгүй хэсэг юм.



Бүдүүвч 1. ОХУ-ын хил хамгаалалтын талаар баримтлах бодлогын чиглэл.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил хамгаалалтын бодлого:

БНХАУ нь нийтдээ 22,000 км урт хуурай газрын хилтэй бөгөөд 14 улстай хиллэдэг бөгөөд тус улсын хил хамгаалалтын бодлого нь “аюулгүй байдал ба хөгжил”-ийн тэнцвэр дээр үндэслэгддэг. Ардын зэвсэгт цагдаагийн хүчний хил хамгаалалтын ангиуд нь Дотоод хэргийн яаманд харьяалагддаг бөгөөд төвлөрсөн удирдлага, өндөр технологийн хяналтыг баримталдаг.

Тус улсын хил хамгаалалтын бодлого дараах гурван чиглэлд төвлөрдөг (State Council of the PRC, 2022):

Төрийн төвлөрсөн удирдлага ба хууль эрх зүйн хяналт – Хил орчмын бүсэд нэгдсэн хяналтын дэглэм тогтоох, хил дамнасан гэмт хэрэгтэй хатуу тэмцэх;

Эдийн засаг, худалдааны уялдаа – “Бүс ба зам” санаачилгын хүрээнд хил дамнасан эдийн засгийн бүс байгуулах, хил орчмын бүс нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх;

Технологийн хамгаалалт – хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын систем, нүүр таних технологи, дрон, хиймэл дагуулын мэдээлэл ашиглан хил нэвтрэлтийн хяналтыг автоматжуулах.

Хил хамгаалалтыг зөвхөн аюулгүй байдлын хэрэгсэл бус, хөгжлийн бодлогын хэрэгжилтийн баталгаа гэж үздэг нь онцлог юм.

БНХАУ нь улсын хилийг тодорхойлох, тогтоох, тодотгох, эрх зүйгээр баталгаажуулах, хилийг манах, хамгаалах, түрэмгийллийг няцааж хилээ сэргээх, бодлого үйл ажиллагаа нь ерөнхийдөө олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмаас онцгойлон ялгардаггүй боловч улсын хилийн талаар төрөөс баримтлах бодлого нь дараах онцлогтой салбар бодлогуудаас бүрдэж байна.

Тухайлбал: *Улсын хилийн баталгаажилт, хамгаалалтыг бэхжүүлэх стратегийн ач холбогдлын өсөлт:*

Төрийн бодлого нь стратегийн хил хамгаалах цар хүрээнд маш тодорхой байх нь зүйтэй гэж үздэг байна. Үүнд:

БНХАУ-ын "хилийн асуудал одоо ба ирээдүйд хурц хэвээр" байна гэж үздэг. Тус улс нь хөрш улсуудтай улсын хилийг ерөнхийд нь тогтоож амжсан. 19, 20 дугаар зууны зааг дээр тухайлбал, 1997 онд Британийн колони байсан Хонгконг, 1999 онд Португалийн эзэмшилд байсан Макао зэрэг газар нутгаа эргүүлэн өөрийн мэдэлд авч, маргаантай гэж үзэж байсан Киргизээс 12 км^2, Казахстанаас 407 км^2 нутаг авч, Орос улстай хилээ тогтоож Даманы арлыг эргүүлэн авсан. Эдүгээ хилийн хувьд шийдэгдээгүй газар нутаг далай, тэнгис мөн хуурай газрын хил хязгаарт байдаг гэж үздэг. Монгол улсын тусгаар тогтнолыг үгүйсгэх бодлого, үйлдэл өмнөд хөршөөс түүхэн хугацаанд нэг бус удаа гарч байсан. Эдүгээ төр нийгмийн зарим зүтгэлтэн, судлаачдын зүгээс зүй бус хандлага гаргаж байгаа нь харагддаг.

Улсын хилийн баталгаажилт, хамгаалалт нь БНХАУ–ын тусгаар тогтнол, хөгжлийг ханган хамгаалдаг "бэхлэлт" юм. Иймээс улсын хил манах, хамгаалах нь Хятад улсын хүчин чадал, чадавхыг илтгэх "цонх" гэж үздэг байна.

Эндээс урган Хятад улс хил манах цэрэг, сонгомол зэвсэглэл техникээр хангагдаж, ахуй нөхцөл нь тайван байдалд төдийгүй дайны үед хилчид, анги салбар үүргээ бүрэн гүйцэтгэх бололцоо нөхцөлөөр эхний ээлжид хангаж байхыг чухалд үздэг байна. Харин хилийн орон зай бусад хил орчмын нутаг дэвсгэр нь "жижиг хэмжээний дайн, /зэвсэгт мөргөлдөөн, тулгаралт/ болох үед түүний талбар" болж томоохон хэмжээний дайн тулалдаан болох үед "стратегийн хамгаалалтын бүс" болно гэж үздэг. Эндээс үүдэн хил хамгаалах хүч, ХАЧА-ийн хил халхлах анги, нэгтгэл, ардын зэвсэгт цагдаа, орон нутгийн иргэний цэрэг нь нэгэн зорилготой нэгдмэл бодлого үйл ажиллагаанд зангидагдан хил, хязгаарын аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлжээ. (А.Энхтөр, 2021)

БНХАУ нь улсын хил хамгаалах бодлогоо хэрэгжүүлэхийн тулд шинжлэх ухааны онол, практикийн нэгдсэн тодорхой зарчмуудыг баримталж байна. Үүнд:

Улсын хилийн баталгаажилт, хамгаалалтыг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх зарчим

Улсын хилийг тодорхойлж, тогтоон хоёр ба олон улсын эрх зүйгээр баталгаажуулж бэхжүүлэх нь улсын хилийн хамгаалалтын үндсэн агуулгыг тодорхойлдог гэж өмнөд хөрш үздэг.


Улсын хил түүний орчмын газар нутаг, тэнд илэрдэг үзэгдэл, үйлдэл бүхэн олон улсын харилцаа, БНХАУ болон хөрш улсуудын ашигтай холбоо бүхий "эмзэг асуудал" гэж үздэг. Яагаад гэвэл "Улсын хил дээр гарсан аливаа асуудлыг аль нэг улс дангаар бус хөрш орнуудтай гэрээ хэлэлцээр хийж шийдвэрлэхэд" хүргэдэг. Тэр ч байтугай "олон улсын ээдрээтэй асуудлын гогцоог үүсгэх аюулд" хүргэдэг.

Эдгээр асуудлыг шийдвэрлэж зохицуулахад "өчүүхэн жижиг алдаа гаргавал БНХАУ-ын улс төрийн, стратегийн эрх ашгийг хохироож, олон улсын харилцаанд таагүй" нөлөөлдөг. Ийм учраас улсын хилийн талаар баримтлах "бодлого, хилийн хууль дүрмийг системтэй судалгаанд түшиглэн, шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж мөрдөх" шаардлагатай.

Улсын хил хамгаалах бодлогод улсын хилийн тухай шинж байдал, зүй тогтлыг тусган нэгдсэн тогтолцоо бүрдүүлж түүнд "иргэд, зорчигчид улсын хилээр орох, гарах, хил орчмын нутаг дэвсгэрт оршин суух, зорчих, үйлдвэр, хөдөлмөр эрхлэх зэрэг төрөл бүрийн үйл ажиллагааны дэглэм журмыг хуулиар тогтоож, бүрэн заавар гаргаж" ашиглахыг чухалд үздэг байна.

Институцийн бүтэц:

Хятад улсын хил хамгаалалт нь Ардын зэвсэгт цагдаагийн хүчин (PAP) болон олон агентлагийн хамтын ажиллагаанд тулгуурладаг. Сүүлийн жилүүдэд иргэний болон цэргийн интеграцчлал нэмэгдсэн.



Бүдүүвч 2. БНХАУ-ын хил хамгаалалтын талаар баримтлах бодлогын чиглэл.

Харьцуулсан шинжилгээ

д/д	Үзүүлэлт	ОХУ	БНХАУ
1	Удирдлагын бүтэц	Цэрэгжсэн, төвлөрсөн	Олон агентлагийн уялдаа
2	Технологийн хэрэглээ	Дунд-өндөр	Өндөр, AI төвтэй
3	Геополитикийн чиглэл	Батлан хамгаалах давамгай	Эдийн засаг + аюулгүй байдал
4	Хил орчмын бодлого	Хүн ам сийрэг, хамгаалалт төвтэй	Хөгжил + хяналт хосолсон

Манай улстай хил залгаа хөрш хоёр улсын нийтлэг тал нь хил хамгаалалтыг үндэсний аюулгүй байдлын чухал хэсэг гэж үздэг, төвлөрсөн удирдлагатай, технологийн хэрэглээг нэмэгдүүлж байгаа явдал юм. Харин ялгаатай тал нь Хятад улс эдийн засгийн интеграц, дижитал технологийг илүү түлхүү ашиглаж байхад Орос улс уламжлалт цэрэг-стратегийн арга барилыг илүү баримталж байна.

Хэлэлцүүлэг:

Хил залгаа улсуудын хил хамгаалалтын бодлого нь нийтлэг зорилготой боловч хэрэгжүүлэх арга зүй, стратегийн чиг баримжаагаараа ялгаатай. Орос улс цэргийн хамгаалалт, геополитикийн сөргөлдөөнд суурилсан бодлого баримталдаг бол Хятад улс эдийн засгийн интеграц, технологийн хяналттай холбосон бодлого хэрэгжүүлдэг.

Монгол Улсын хувьд энэхүү хоёр загварыг харьцуулан судалснаар дараах сургамжийг гаргаж болно.

Үүнд:

Хил хамгаалалт нь зөвхөн цэргийн асуудал бус, эдийн засаг, мэдээллийн аюулгүй байдал, бүс нутгийн хамтын ажиллагааны бодлого байх ёстой;

Хил залгаа орнуудтай итгэлцэлд суурилсан хил дамнасан хамтарсан хяналт, мэдээллийн солилцоо, сургалтын тогтолцоо хөгжүүлэх шаардлагатай;

Хил орчмын хөгжлийг аюулгүй байдлын бодлоготой уялдуулах нь урт хугацаанд тогтвортой байдлыг хангах үндэс болно.

Оросын Холбооны Улсын талаас авч үзвэл, хил хамгаалалтын цэргийн дэглэм, мэдээллийн хяналт өндөр тул Монгол Улсын хойд хил харьцангуй тогтвортой, цэргийн аюул багатай бүсэд тооцогддог. Гэвч сүүлийн жилүүдэд Украины хямрал, барууны хориг арга хэмжээ зэргээс шалтгаалан тус улсын хил хамгаалалтын бодлого улам хаалттай болж, хил дамнасан худалдаанд тодорхой хүндрэл гарч байна.

Харин Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил хамгаалалтын бодлого эдийн засгийн интеграцитай нягт уялдсан тул Монгол Улсын өмнөд хил эдийн засгийн боломж, эрсдэлийн огтлолцол болж байна. “Бүс ба зам” санаачилга, Гашуунсухайтын боомтын ачаа тээврийн урсгал зэрэг нь эдийн засгийн харилцан хамаарлыг гүнзгийрүүлж буй ч, хэт төвлөрсөн хяналтын бодлого нь Монголын хил орчмын дэд бүтцийн тэгш бус хөгжилд нөлөөлөх эрсдэлтэй.

Монгол Улс эдгээр туршлагаас тэнцвэртэй, хамтын ажиллагаанд суурилсан хил хамгаалалтын бодлого боловсруулж, технологийн дэвшлийг ашиглах, хил орчмын хөгжлийн бодлогыг аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдуулах шаардлагатай байна.

Дүгнэлт:

Хил залгаа улсуудын хил хамгаалалтын бодлого нь тус бүрийн геополитик, эдийн засгийн чиг хандлага, технологийн хөгжилтэй нягт уялддаг. Оросын Холбооны Улсын бодлого цэргийн хүч, технологийн хяналтад тулгуурладаг бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил хамгаалалтын бодлого эдийн засгийн өсөлт, мэдээллийн технологийн уялдаа, хөгжлийн бодлогоор илэрхийлэгддэг.

Монгол Улс эдгээр туршлагыг харгалзаж, өөрийн онцлог, газар зүйн байрлалд тохирсон хамтын ажиллагаанд тулгуурласан, технологийн дэвшилтэй хил хамгаалалтын бодлого хэрэгжүүлэх шаардлагатай.

Энэ нь зөвхөн хил хамгаалалтад бус улс орны тусгаар тогтнол, эдийн засгийн аюулгүй байдал, бүс нутгийн энх тайвныг хангах урт хугацааны баталгаа болох юм.

Ашигласан материал

Н.Наранжамц. (2012). *Бүс нутаг-хил хамгаалалтын талаархи үзэл бариимтлал.* улаанбаатар.

Д.Нямдорж, Ц.Ганболд. (2014). *Хил судлалын шинжлэх ухааны онол практикийн зарим асуудлууд.* Улаанбаатар.

А.Энхтөр. (2021). *Монгол Улсын хилийн цэргийн байгуулалтын онол, практикийн асуудал.* Улаанбаатар.

argazui, s. (n.d.).

batbayar. (2025). batbayar. *hiliin asuudal*, 69.

batdorj. (2025). hil sudlal. *sudalgaa*, 10-11.

hhnnlhknmklmcv, g., & fBL, d. (n.d.).

ГАДААД ОРНУУДЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН АРГА, ТАКТИК, ТУРШЛАГА СУРГАМЖ

Д.БАДАМДОРЖ*

Дотоод Хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн багш, докторант, дэд хурандаа

**хариуцлагатай зохиогч: badkadorj@gmail.com*

Хураангуй: Энэхүү судалгааны ажлын зорилго нь дэлхийн тэргүүлэх улс орнуудын хил хамгаалалтын арга, тактик, технологийн туршлагыг судалж, Монгол Улсын хил хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах боломжтой практик санал, зөвлөмжийг боловсруулахад оршино. Судалгаанд АНУ, Европын Холбоо, Израил, Австрали, Япон зэрэг улс орнуудын хилийн хамгаалалтын загварыг харьцуулан шинжилсэн бөгөөд хил хамгаалалтын орчин үеийн технологи, тактикийн хандлага, олон улсын хамтын ажиллагааны тогтолцоог судалсан болно. Судалгааны үр дүнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлд тодорхой санал, зөвлөмж боловсруулав.

Түлхүүр үг: хил хамгаалалт, ухаалаг хил, БННУ, биометр, Frontex, хилийн аюулгүй байдал, олон улсын туршлага, Монгол Улс

НЭГ. ОРШИЛ

Орчин үед улс орнуудын хилийн аюулгүй байдал нь зөвхөн цэрэг-улс төрийн асуудал биш, харин эдийн засаг, нийгэм, хүмүүнлэгийн олон талт асуудлыг хамарсан цогц тогтолцоо болж хөгжжээ. Дэлхийн нийт улс орнуудын 60 гаруй хувь нь хилийн хамгаалалтдаа дэвшилтэт технологи нэвтрүүлж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлж байна.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн газрын 2023 оны тайланд дурдсанчлан, дэлхий нийтийн хилийн зөрчлийн тоо сүүлийн 10 жилд 34%-иар нэмэгдсэн бөгөөд энэ нь хил хамгаалах уламжлалт арга, тактикийг дахин нягтлан үзэх, шинэчлэх шаардлагыг улам тодорхой болгосон байна.[1]

Монгол Улс нь Орос, Хятад гэсэн хоёр их гүрний хооронд 8,262.6 км урт хилтэй, манай улсын хилийн хамгаалалтын тогтолцоо нь газарзүйн онцлог, эдийн засгийн чадавх, хүний нөөцийн хязгаарлалттай нөхцөлд ажилладаг. Иймд гадаад орнуудын туршлагыг судлан, бидний нөхцөлд тохирох шилдэг практикуудыг тодорхойлох нь онол, практикийн ихээхэн ач холбогдолтой юм.

1.1. Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь дэлхийн тэргүүлэх улс орнуудын хилийн хамгаалалтын арга, тактикийг харьцуулан судалж, Монгол Улсын хил хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах зөвлөмж боловсруулахад оршино. Зорилтуудыг дараах байдлаар томьёолов:

- Дэлхийн тэргүүлэх улс орнуудын хилийн хамгаалалтын загварыг харьцуулан шинжлэх
- Орчин үеийн технологийн хэрэглээлийг судлах
- Олон улсын хамтын ажиллагааны тогтолцоог дүгнэх

[1]United Nations Office on Drugs and Crime. (2023). World Drug Report. UNODC Publications.

- Монгол Улсын нөхцөлд тохирсон практик санал боловсруулах

1.2. Судалгааны арга зүй

Судалгааны ажилд харьцуулсан шинжилгээ, баримт бичгийн судалгаа, систем шинжилгээний аргуудыг ашигласан. Мэдээллийн эх сурвалжид НҮБ, Frontex, INTERPOL, Дэлхийн гаалийн байгууллагын тайлан, тухайн улс орнуудын хил хамгаалах байгууллагын албан ёсны баримт бичгүүд, болон олон улсын эрдэм шинжилгээний бүтээлүүдийг ашигласан болно.

ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1. Дэлхийн тэргүүлэх улс орнуудын хил хамгаалалтын загвар

АНУ-ын Гаалийн болон хил хамгаалах газар (CBP) нь жил бүр 400 сая гаруй хүнийг улсын хилээр шалган нэвтрүүлдэг ба дэлхийн хамгийн том хилийн байгууллага болно. CBP-ийн 2022-2026 оны стратегид дурдсанчлан, "ухаалаг хил" (Smart Border) концепци нь технологи болон хүний нөөцийг оновчтой хослуулж, аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ хуулийн дагуу нэвтрэх урсгалыг хялбарчлахад чиглэдэг.

Европын Холбооны Frontex байгууллага нь EUROSUR мэдээллийн системээр дамжуулан гишүүн улсуудын хоорондох мэдээлэл солилцоог хангаж, хамтарсан ажиллагааг зохицуулдаг. 2023 оны эрсдэлийн дүн шинжилгээнд зааснаар, EUROSUR систем нь хилийн зөрчлийг илрүүлэх чадварыг 45%-иар нэмэгдүүлсэн байна.[2] Европын Хил, Эргийн Хамгаалалтын Агентлаг болох Frontex нь Европын Холбооны гишүүн орнууд болон Шенгений бүсийн гишүүн орнуудад Европын Холбооны гадаад хилийг удирдах, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд дэмжлэг үзүүлдэг.

Фронтекс нь Европын Холбооны гадаад хил дээр хилийн хяналтын үйл ажиллагааны шилдэг төв бөгөөд шилжилт хөдөлгөөний чиг хандлага, хил дамнасан гэмт хэрэгт өртсөн бүх гишүүн орнууд болон хөрш зэргэлдээ Европын Холбооны бус орнуудтай тагнуул, мэргэжлийн мэдээллээ хуваалцдаг.

Европын Холбооны анхны дүрэмт хувцастай хууль сахиулах алба болох Байнгын корпустай болсноор Фронтекс нь Европын Холбооны үйл ажиллагааны салбар болж хувирсан.

Европын Холбооны гадаад хил дагуу болон түүнээс цааших үйл ажиллагаанд олон зуун алба хаагчид оролцдог. Тэд хилийн хяналт, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, цагаачлалын шилжилт хөдөлгөөн ажиллагаанд туслах зэрэг олон төрлийн ажлыг гүйцэтгэдэг. Алба хаагчид Европын хамгийн том ололт амжилтуудын нэг болох Шенгений бүсийг хамгаалахын тулд эрх баригчидтай хамтран ажилладаг.

[2]Frontex. (2023). Risk Analysis for 2023. European Border and Coast Guard Agency.



Зураг 1. Фронтексын алба хаагч
Эх сурвалж: https://www.frontex.europa.eu/careers/standing-corps/about/

Хүснэгт 1. Дэлхийн тэргүүлэх улс орнуудын хил хамгаалалтын харьцуулалт

Улс орон	Хил хамгаалалтын арга	Технологийн хэрэглээ	Онцлог тактик
АНУ	Смарт хил, мэдрэгчийн сүлжээ	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV), биометр	Рискэд тулгуурласан шалгалт
ЕХ (Frontex)	Бүсийн хамтын ажиллагаа	EUROSUR мэдээллийн систем	Ухаалаг хил хамгаалалт
Израил	Газар доорх мэдрэгч, ухаалаг хаалт	AI-д суурилсан камерын сүлжээ	Олон давхаргат хамгаалалт
Австрали	Тэнгис, агаарын патруль	Дронын хяналт, ухаалаг камер	Бүсийн хамтын ажиллагаа
Япон	Тэнгисийн эрэг хамгаалалт, хяналт	Радар систем, UAV	Технологи давамгайлсан хяналт
БНХАУ	Гүнзгий хамгаалалтын систем	AI, нүүр таних технологи	Иж бүрэн нийгмийн хяналт

Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэл, 2024

2.2. Орчин үеийн технологийн хэрэглээ

Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV буюу дрон) нь хил хамгаалалтын хамгийн хурдацтай хөгжиж буй технологийн нэг болоод байна. АНУ-ын CBP нь MQ-9 Reaper дроноор хойд хилийнхээ 7,000 гаруй миль нутгийг хянадаг.[3]

Биометрийн технологи нь хилийн нэвтрэх цэг дэх хүний таних явцыг хурдасгаж, хуурамч бичиг баримтаар нэвтрэх оролдлогыг илрүүлэх чадварыг ихээхэн нэмэгдүүлсэн. Дэлхийн 80 гаруй улс одоогоор биометрийн паспорт ашиглаж байгаа бөгөөд энэ тоо жил бүр нэмэгдсээр байна.

Газар доорх мэдрэгчийн сүлжээ (underground sensor network) нь Израилын хилийн хамгаалалтын нэг гол технологи бөгөөд газар доорх туннел, далд нэвтрэлтийг илрүүлэхэд маш үр дүнтэй болох нь нотлогдсон. Хиймэл оюун ухаанд суурилсан дүн шинжилгээний систем нь олон мэдрэгчийн мэдээллийг нэгтгэн боловсруулж, хилийн зөрчлийн магадлалыг урьдчилан тодорхойлдог.

Хүснэгт 2. Хилийн хамгаалалтад хэрэглэгдэх дэвшилтэт технологийн харьцуулалт

Технологи	Хэрэглэгч улсуудын тоо	Үр нөлөөний түвшин	Монголд нэвтрүүлэх боломж
UAV / Дрон хяналт	60+ улс	Өндөр	Боломжтой, нутаг дэвсгэрт тохиромжтой
Мэдрэгчийн сүлжээ	40+ улс	Өндөр	Нэн тэргүүнд нэвтрүүлэх шаардлагатай
Биометрийн систем	80+ улс	Дунд-өндөр	Боомт дээр нэвтрүүлэх боломжтой
AI-д суурилсан шинжилгээ	30+ улс	Маш өндөр	Бэлтгэл шат шаардагдана
Ухаалаг хашаа/хаалт	25+ улс	Өндөр	Нэн чухал хэсэгт хэрэглэх

Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэл, INTERPOL 2022 тайланд тулгуурлан

2.3. Хилийн хамгаалалтын тактик стратеги

Эрсдэлд тулгуурласан хандлага (Risk-Based Approach) нь орчин үеийн хилийн хамгаалалтын гол зарчим болжээ. Энэ хандлагын дагуу хилийн байгууллагууд хязгаарлагдмал нөөцийг хамгийн өндөр эрсдэлтэй хэсэгт төвлөрүүлж, бага эрсдэлтэй хэсэгт нэвтрэлтийг хялбарчилдаг.[4]

Олон давхаргат хамгаалалт (Multi-layered defense) нь Израил, Австрали зэрэг улсуудын хил хамгаалалтын үндсэн зарчим юм. Энэ тогтолцооны дагуу хил хамгаалах ажиллагаа нь гадаадад буй цагаачлалын хяналтаас эхлэн, улсын хилийн шугам, хилийн дотоод хяналт гэх мэтчилэн олон давхаргаар явагддаг.

Мэдээлэл тагнуулд тулгуурласан хамгаалалт (Intelligence-led border security) нь INTERPOL болон гишүүн улсуудын байгууллагуудын хооронд урьдчилсан мэдээлэл солилцох тогтолцоо дээр тулгуурладаг. Энэ систем нь угаасаа зөрчил гарахаас өмнө илрүүлэх боломжийг бүрдүүлдэг.[5]

2.4. Олон улсын хамтын ажиллагааны загварууд

[3]U.S. Customs and Border Protection. (2022). CBP Strategy 2022–2026. Department of Homeland Security.
[4]Международный опыт охраны государственной границы. (2021). Сборник аналитических материалов. Москва: ПОГРАНИЧНЫЙ ИНСТИТУТ.
[5]INTERPOL. (2022). Border Management and Security. INTERPOL Global Complex for Innovation.

Европын Холбооны хил хамгаалалтын хамтын ажиллагаа нь дэлхийн хамгийн том бүс нутгийн интеграцийн жишиг болоод байна. Олон улсын цагаачлалын байгууллагын (IOM) 2023 оны тайланд дурдсанчлан, ЕХ-ны хамтын хилийн хамгаалалт нь хоёр талын гэрээт хамтын ажиллагаатай харьцуулахад зардлыг 38%-иар бууруулж, үр дүнг 52%-иар дээшлүүлсэн байна.[6]

АНУ, Канад хоёрын "Beyond the Border" хамтын ажиллагааны хүрээнд хоёр улсын хилийн байгууллагууд урьдчилсан мэдээлэл солилцох, хамтарсан ажиллагаа явуулах, хилийн нэвтрэх цэгүүдийг нэгдсэн удирдлагаар зохицуулах гэрээ байгуулсан нь хоёр талын хамтын ажиллагааны амжилттай жишиг болжээ.

ОБСЕ-гийн хилийн аюулгүй байдал, менежментийн хүрээнд гишүүн улсууд хил хамгаалалтын сургалт, технологийн туршлага солилцох, хамтарсан сургуулилт явуулах зэрэг олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.[7]

ГУРАВ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

3.1. Монгол Улсын хил хамгаалалтын одоогийн байдлын дүн шинжилгээ

Манай улсын нийт 8,252,6 км хилийн 62% нь нарийн хяналт, тандалтын тогтолцоогүй бөгөөд хил хамгаалах боловсон хүчин 7 мянга гаруй алба хаагчид байна. Хил хамгаалах байгууллагад бүртгэгдсэн тоон мэдээлэлд 2020 онд Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн талаар 20806, 2021 онд 14070, 2022 онд 18984 лавлагаа, мэдээлэл гаргаж өгсөн нь өссөн үзүүлэлттэй тухайн үйлчилгээ нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна.[8]

Монгол Улсын хил хамгаалалтын тогтолцоонд дараах сул тал, боломжуудыг тодорхойлсон болно:

Хүснэгт 3. Монгол Улсын хил хамгаалалтын SWOT шинжилгээ

ДАВУУ ТАЛ (S)	СУЛ ТАЛ (W)
• Байгалийн саад бэрхшээл (говь, нуур, ой) • Хамтын ажиллагааны уламжлал • Нийгмийн хяналтын тогтолцоо	• Технологийн хоцрогдол • Хүний нөөцийн дутагдал • Санхүүжилтийн хязгаарлалт
БОЛОМЖ (O)	**АЮУЛ (T)**
• Олон улсын хамтын ажиллагаа • Технологи дамжуулалт • Гадаадын тусламж, хөрөнгө оруулалт	• Хилийн зөрчлийн нэмэгдэл • Гэмт хэргийн сүлжээний хөгжил • Цаг агаар, байгалийн нөхцөл

Эх сурвалж: Судлаачийн шинжилгээ, 2024

3.2. Гадаад орнуудын туршлагаас авах сургамж

Судалгааны явцад дэлхийн тэргүүлэх улс орнуудын хил хамгаалалтаас дараах гол сургамжийг тодорхойлов:

1. Технологи + хүний нөөцийн оновчтой хослол: Ямар ч дэвшилтэт технологи нь сайн бэлтгэгдсэн, мэргэшсэн боловсон хүчнийг орлох боломжгүй. Амжилттай загваруудын нийтлэг онцлог нь технологи болон хүний нөөцийг бие биеэ нөхөх байдлаар ашигладаг.

[6]International Organization for Migration. (2023). World Migration Report 2023. IOM.
[7]ОБСЕ/OSCE. (2022). Border Security and Management: National and Regional Perspectives. OSCE Publications.
[8] Хил хамгаалах ерөнхий газар хэрэглэгчийн үнэлгээ 2022

2. Мэдээлэл тагнуул давамгайлсан хамгаалалт: Зөрчил гарч нутаг дэвсгэрт нэвтэрсний дараа илрүүлэхээс илүүтэй урьдчилан мэдсэн, мэдрэмжтэй хариу арга хэмжээ нь илүү үр дүнтэй.

3. Олон улсын хамтын ажиллагаа: Хил хамгаалалт нь нэг улсын хэмжээнд шийдэгдэх асуудал биш тул хөршийн болон бүс нутгийн хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай.

4. Уян хатан, тасралтгүй хөгжих тогтолцоо: Гэмт хэргийн арга барил байнга хувьсан өөрчлөгдөж байдаг тул хил хамгаалалтын тогтолцоо нь тасралтгүй шинэчлэгдэж байх ёстой.

5. Хууль, эрх зүйн орчин: Технологийн хэрэглээ нь иргэний эрх, нууцлалыг хамгаалах хуулийн тогтолцоотой уялдах ёстой бөгөөд энэ нь хамтын ажиллагааны суурь болдог.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар гадаад орнуудын хил хамгаалалтын арга, тактик, технологийн туршлагыг харьцуулан шинжлэхэд дараах дүгнэлтэд хүрлээ:

1.АНУ, ЕХ, Израил, Австрали, Япон зэрэг улсуудын хилийн хамгаалалтын амжилтын гол хүчин зүйл нь дэвшилтэт технологи, олон улсын хамтын ажиллагаа, мэргэшсэн боловсон хүчний оновчтой хослол болохыг тогтоов.

2.UAV, биометр, мэдрэгчийн сүлжээ, AI-д суурилсан шинжилгээний систем зэрэг технологиуд нь хил хамгаалалтын үр ашиг, үр нөлөөг эрс дээшлүүлдэг болохыг баримтад тулгуурлан нотолсон.

3.Монгол Улсын хил хамгаалалтын тогтолцоо нь технологийн хоцрогдол, хүний нөөцийн хязгаарлалт, санхүүжилтийн дутагдал гэсэн гол бэрхшээлтэй тулгарч байгаа нь судалгааны дүнд тодорхойлогдов.

4.Монгол Улсын газарзүйн онцлог (говь цөл, нуур, ой) нь хилийн байгалийн саад бэрхшээл болох боловч тэдгээрийн цоорхойг нөхөх технологи, тактикийн шийдэл шаардлагатай байна.

ТАВ. САНАЛ

Судалгааны дүгнэлтэд тулгуурлан дараах саналуудыг дэвшүүлж байна:

5.1. Богино хугацааны санал (1-3 жил)

- Хилийн шалган нэвтрүүлэх боомтуудад биометрийн таних системийг нэвтрүүлэх бөгөөд үүний тулд БНХАУ, ОХУ-ын хилийн байгууллагатай техникийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах
- Хилийн харуулын цэргүүдийн тоо, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, тэдний сургалтын программыг гадаад орнуудын туршлагад суурилан шинэчлэх
- Хилийн мэдээллийн нэгдсэн удирдлагын системийг бий болгох

5.2. Дунд хугацааны санал (3-7 жил)

- UAV-ийн хяналтын системийг манай улсын нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан нэвтрүүлэх – ялангуяа нийт хилийн 40%-д хамаарах говийн бүсэд
- Мэдрэгчийн сүлжээний анхдагч туршилтыг нэн чухал хэсэгт хэрэгжүүлэх
- Хилийн хамгаалалтын чиглэлээр Монгол-Орос, Монгол-Хятадын тусгай хамтарсан ажиллагааны хүрээг бий болгох

5.3. Урт хугацааны санал (7-15 жил)

- Монгол Улсын "Ухаалаг хил" концепцийг боловсруулж, хэрэгжүүлэх – AI, биометр, UAV, мэдрэгчийг нэгдсэн тогтолцоонд нэгтгэх
- Хил хамгаалалтад зориулсан дотоодын технологийн хөгжлийг дэмжих

• Бүс нутгийн хил хамгаалалтын хамтын ажиллагааны тогтолцоог тэргүүлэгч байр сууринаас хөгжүүлэх

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. United Nations Office on Drugs and Crime. (2023). **World Drug Report 2023.** UNODC Publications. https://www.unodc.org/wdr2023

2. Frontex. (2023). **Risk Analysis for 2023.** European Border and Coast Guard Agency. Warsaw.

3. U.S. Customs and Border Protection. (2022). **CBP Strategy 2022–2026.** Department of Homeland Security.

4. Пограничный институт. (2021). **Международный опыт охраны государственной границы: Сборник аналитических материалов.** Москва.

5. International Organization for Migration. (2023). **World Migration Report 2023.** IOM. Geneva. https://worldmigrationreport.iom.int

6. INTERPOL. (2022). **Border Management and Security.** INTERPOL Global Complex for Innovation.

7. Хил хамгаалах ерөнхий газар хэрэглэгчийн үнэлгээ (2022). Улаанбаатар.

8. Schmitt, M. N. (Ed.). (2017). **Tallinn Manual 2.0 on the International Law Applicable to Cyber Operations.** Cambridge University Press.

9. World Customs Organization. (2023). **Customs and Border Control: Global Best Practices.** WCO. Brussels.

10. OSCE. (2022). **Border Security and Management: National and Regional Perspectives.** OSCE Publications.

ХАВСРАЛТ

Хавсралт А. Хилийн хамгаалалтын технологийн тухай товч тайлбар

UAV (Нисгэгчгүй нисэх төхөөрөмж / UAV): Хилийн тандалт, хяналтад ашигладаг нисгэгчгүй нисэх аппаратууд бөгөөд хүнд хүрэхэд хэцүү нутгийг хянах, хялбархан тасрах боломжтой.

EUROSUR: Европын Холбооны хилийн хяналтын мэдээллийн нэгдсэн систем. Гишүүн улсуудын хооронд бодит цагийн мэдээлэл солилцоог хангадаг.

Биометрийн систем: Хурууны хээ, нүүр царай, нүдний тор зэрэг хүний биологийн шинж тэмдгийг ашиглан таних технологи.

AI (Хиймэл Оюун Ухаан): Олон эх сурвалжийн мэдээллийг нэгтгэн боловсруулж, хилийн зөрчлийн эрсдэлийг урьдчилан таамаглах, дохиоллын систем.

БАЙЛДААНЫ БЭЛЭН БАЙДЛЫН ОНОЛ АРГА ЗҮЙ

Д.БЯМБАБАЯР*
Хил судлалын магистрант, ахмад

**хариуцлагатай зохиогч: Byambaa.boxer@gmail.com*

Хураангуй: Байлдаан нь дайтагч талуудын салбар, анги нэгтгэлийн ялалтад хүрэхийн тулд явуулж байгаа зохион байгуулалттай зэвсэгт тэмцэл, хуурай замын цэрэг, нисэх хүчин, тэнгисийн цэргийн тактикийн ажиллагааны үндсэн хэлбэр юм.

Байлдааны мөн чанар нь дайсныг бут цохих (устгах, олзлон авах, чухал хэсэг (зааг, объект)-ыг эзлэн авах, эсвэл тэдгээрийг бат барих, тэрчлэн тактикийн бусад үүргийг биелүүлэхийн тулд зорилго, үүрэг, байр, хугацаагаар уялдуулан зохицуулсан гал, цохилт, маневр, аюулгүй байдлаа хангах ажиллагааны нэгдэл юм.

Байлдааны зорилго нь түүний хүлээгдэж байгаа эцсийн үр дүн юм. Тэр нь хориглолтод-дайсны тактикийг няцаасан (тогтоон барьсан)-аар, давшилтад-эсрэг байгаа дайсныг бут цохиж (устгаж, олзолж), заасан хэсг (зааг, объект)-ыг эзлэн авснаар хангагдах бөгөөд мөн анги, салбарын авсан үүргээс хамаарч янз бүрийн агуулгатай ч байж болно.

Байлдааны дэмжлэгийн зорилго нь дайсныг хөнөөсөн (дарсан, устгасан) хэмжээгээр, байлдааны хангалтын зорилго нь салбар, ангийн байлдааныг амжилттай явуулах нөхцөлийг бүрдүүлсэн, тэрчлэн, материал, техникээр тасралтгүй хангаснаар хэрэгжинэ.

Байлдааны зорилгын хэрэгжилтийн чухал үзүүлэлт нь цэргийн алба хаагч, тасаг, салааны аюулгүй байдлыг хангасан төвшин, өөрөөр хэлбэл, хохирол эрсдэлийн хэмжээ болно. Хэдийгээр тавигдсан байлдааны үүрэг биелсэн (заасан хэсэг, зааг, объектыг эзэлсэн, дайсны давшилтыг няцаасан, тогтоон барьсан) боловч их хэмжээний хохирол амссан бол тухайн байлдааны зорилгыг амжилттай хэрэгжсэн гэж үзэх үндэс бага юм.

Түлхүүр үг: Байлдаан, бэлэн байдал, зэргүүд, мөн чанар.

Удиртгал: Байлдаан нь өөрөө *гал, цохилт, маневр, аюулгүй байдлаа хангах* гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

Гал нь цэргийн цохилтыг бэлтгэж, түүнийг дэмжиж, дагах болсноор цохилтын байлдааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг болдог. Өөрөөр хэлбэл байлдааны амжилтыг дэмжих үндсэн арга, дайсныг хөнөөх /дарах, устгах/ цорын ганц хэрэгсэл бөгөөд маневр үйлдэх таатай нөхцөлийг ч бүрдүүлдэг билээ.

Галын нөлөөллийн хүч нь их буу, зенитийн хэрэгслийн гал, нисэх онгоц, нисдэг тэрэг, ердийн цэнэгтэй пуужин, байлдааны хөлөг онгоцны зэвсгийн цохилт, тэрчлэн, атаклаж /хориглож/ байгаа танкны болон явган /мотобуудлагын/ анги, салбаруудын, агаарын десантын галыг уялдуулан зохицуулж хэрэглэсэнд оршино.

Галын хэрэгслүүдийн өсөн нэмэгдэж байгаа боломж нь алсын зайнаас галын байлдаан хийх таатай нөхцөлийг бий болгож, хүрээг нь улам бүр өргөжүүлж байна. Төрөл бүрийн хараалах, чиглүүлэх хэрэгсэл /гэрэллэг ба шөнийн хараа/-ийн чанар сайжирч, удирдлагатай галт хэрэглэл ашиглах болсон нь түүний үр дүнг эрс дээшлүүлээ. Тактикийн пуужин, их буу, нисэх онгоц, нисдэг тэрэгний зэвсгийн хүчээр дайсанд хөнөөл учруулахыг галын цохилт гэнэ. Их бууны гал нь тусгай байнд явуулах,

хуралдуулсан, дараалан хуралдуулсан, бөөгнөрүүлсэн, хаалтан болон галын давлагаа гэх мэт олон төрлүүдтэй байдаг. Харин нисэх онгоц, нисдэг тэрэгний цохилт нь ганцаарчилсан байнд хийх, бүлгийн, цувраажсан, бөөгнөрүүлсэн хэмээн ангилагдана.

Цэргийн *цохилт* нь дайсныг бут цохиж дуусгах, тогтоосон хэсэг /зааг, объект/-ыг эзлэн авах зорилгоор нэгтгэсэн гал ба танк, явган /мотобуудлагын/ цэргийн анги, салбарын эрчимтэй урагшлах хөдөлгөөн, агаарын десантын ажиллагааны нэгдэл юм. Атаклаж /эсрэг атаклаж/ байгаа анги, салбарын цохилтын хүчийг, юуны өмнө, тэдгээрийн зэвсэглэлийн галын хүч тодорхойлдог. Гал, цэргийн хөдөлгөөний нягт уялдаа, харилцан ажиллагаа нь цэргийн цохилтын чухал үзүүлэлт болно.

Маневр нь байлдааныг явуулах таатай нөхцөлийг бүрдүүлэх ашиг сонирхлын үүднээс үйлдэх цэргийн зохион байгуулалттай хөдөлгөөн, гал, цохилтын хэрэгслийг шилжүүлэн чиглүүлэх үйл ажиллагаа юм. Маневр нь хүч хэрэгслийн /цэргийн гэж нэрлэх нь бий/, *галын* ба *цохилтын* байна.

Орчин үеийн ерөнхий цэргийн байлдаанд цэргийн маневр нь газраар болон агаараар үйлдэгдэж болох бөгөөд тэр нь дайсныг олон чиглэл /түүний дотор ар талаас/-ээс атаклаж, түргэн бут цохих боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ. Байлдааны явцад хүч хэрэгслийг дахин бүлэглэх /хуралдуулах, тараан байрлуулах/-ийн тулд фронт руу болон фронтын дагуу маневрлана. Тойрох маневрыг, ихэвчлэн, дайсныг хажуу жигүүрээс нь цохихын тулд хийх бөгөөд тэр нь фронтоос давшиж буй цэрэгтэй галын болон тактикийн харилцан ажиллагаатай байна. Ороох маневрыг дайсныг ар талаас нь цохих, бүслэхийн тулд нэлээд алсуур, гүнд хийх бөгөөд тэр нь фронтоос ажиллаж байгаа салбаруудтай зөвхөн тактикийн харилцан ажиллагаатай байдаг. Буруулах маневр нь, голдуу өөрийн салбаруудыг дайсны цохилтын дороос гаргаж, аюулгүй байдлыг нь хангах, илүү ашигтай байрлал эзлэх зорилгоор хийнэ. Буруулах маневрыг зөвхөн ахлах захирагчийн зөвшөөрлөөр буюу урьдчилан төлөвлөсний үндсэн дээр гүйцэтгэнэ. Бууруулалтыг байлдааны ов мэх болгон ашиглаж болно.

Маневр ямагт нууцаар, богино хугацаанд түргэн хийгдэх ёстой. Орчин үеийн ерөнхий цэргийн байлдаанд маневр нь зөвхөн газраар төдийгүй, агаараар хийгдэх нь элбэг юм. Энэ нь дайсныг янз бүрийн талаас нь, түүний дотор ар талаас нь түргэн бут цохих боломжийг олгоно.

Үндсэн хэсэг.

Байлдааны бэлэн байдал гэж зэвсэгт хүчин, цэргийн анги, нэгтгэлүүд тайван цагт болон дайны үед гэнэтийн халдлагад хариу өгөх, үүрэг гүйцэтгэх, байлдааны ажиллагааг шуурхай эхлүүлэх чадварыг тогтоосон хугацаанд, бүрэн бүрэлдэхүүнээрээ хангах, зэвсэг техник, нөөц бололцоогоо хурдан дайчлах чадварыг хэлнэ.

Байлдааны бэлэн байдлын гол бүрэлдэхүүн хэсгүүд:

Шуурхай байдал: Цагийн байдал өөрчлөгдөхөд нэн даруй хариу арга хэмжээ авах.

Техник, зэвсэглэл: Зэвсэг техник нь ашиглалтын бүрэн чадвартай, бэлэн байх.

Хүний нөөц: Бие бүрэлдэхүүн үүргээ ухамсарласан, мэргэшсэн, хувцас хэрэглэлээр хангагдсан байх.

Удирдлага, холбоо: Тушаал, шийдвэрийг шуурхай дамжуулах, удирдах тогтолцоо бэлэн байх.

Бэлэн байдлын зэргүүд:

1. Байнгын бэлэн байдал: Ердийн нөхцөл.
2. *Өндөржүүлсэн бэлэн байдал:* Аюул заналхийлж эхлэх үе.
3. *Бүрэн бэлэн байдал:* Дайн, зэвсэгт мөргөлдөөн эхэлсэн үе.

Товчоор хэлбэл удирдлагын баримт бичгээр тогтоосон, товлосон хугацаанд тавигдсан байлдааны зорилтыг биелүүлэхэд бэлэн болох цэргийн байдал. Цэргийг байлдааны бэлэн байдлын тогтоосон зэргүүдэд шууд дамжуулан оруулна[9]

Байлдааны бэлэн байдалд тавигдах үндсэн шаардлага:

-Шуурхай байдал: Цагийн байдал гэнэт өөрчлөгдөхөд товлосон хугацаанд үүрэг гүйцэтгэхэд бэлэн байх.

-Хүний нөөцийн бэлэн байдал: Цэргийн алба хаагчид байнгын, өндөржүүлсэн бэлэн байдалд байж, үүргээ ухамсарласан байх.

-Зэвсэг техникийн бүрэн байдал: Байлдааны техник, зэвсэг хэрэгсэл нь ашиглалтын шаардлага хангасан, бүрэн ажиллагаатай байх.

-Удирдлага, холбоо: Тушаал, шийдвэрийг тасралтгүй, найдвартай дамжуулах холбооны систем.

-Хамгаалалт: Өөрийн хүч хэрэгслийг дайсны цохилтоос хамгаалах, тандах аюулгүй байдлын систем.

-Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

Байлдааны бэлэн байдлын зэрэг нь нөхцөл байдлаас хамаарч "Байнгын", "Өндөр", "Аюулын", "Бүрэн" гэсэн шатлалтай байна.

Байлдааны бэлэн байдлын үндсэн агуулга:

-Бие бүрэлдэхүүний бэлтгэл: Цэргийн алба хаагчдыг товлосон хугацаанд цуглуулах, үүрэг гүйцэтгэх чадварыг хангах.

-Зэвсэг техник, материаллаг нөөц: Зэвсэг, техникийг байлдааны байдалд оруулах, шатахуун, хоол хүнс, бусад материалын нөөцийг бүрдүүлэх, шинэчлэх.

-Удирдлагын тогтолцоо: Бүх шатны удирдлагын байгууллагуудын бэлэн байдлыг хангах.

-Байрлал, шилжилт: Цэргийн анги, салбарыг байрлалаас нь гаргах, дайчилгааны бэлтгэлд шилжүүлэх.

Байлдааны бэлэн байдлын түвшнийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тогтоож, баталгаажуулдаг.

Байлдааны журам гэдэг нь цэргийн анги, салбарууд тулалдааны үед тактикийн даалгавраа биелүүлэхийн тулд байрлах, маневрлах эмх цэгцтэй зохион байгуулалт юм. Энэ нь дайсныг устгах, хамгаалах, довтлох үед хүч хэрэгслийг оновчтой хуваарилах, харилцан ажиллагааг хангах үндсэн хэлбэр болдог.

Байлдааны журмын үндсэн шинж чанарууд:

-Хэлбэрүүд: Шугаман, цуваа, хосолсон зэрэг тактикийн нөхцөлөөс хамаарсан олон төрөл байна.

-Бүтэц: Тасаг, салаа, ротын түвшинд дарга нар байлдааны журмыг тогтоож, хяналт тавьдаг.

-Зорилго: Дайсны галын хохирлыг багасгах, өөрийн хүчийг хадгалах, маневр хийх боломжийг бүрдүүлэх.

-Хэрэгжилт: Орчин үед орчин үеийн зэвсэгт мөргөлдөөний шинж чанарт нийцүүлэн, уян хатан, тараангуй хэлбэрийг ашиглаж байна.

Байлдааны журмыг зөв тогтоох нь тулалдааны амжилтын үндэс болдог.

Байлдааны журмын тараангуй хэлбэр нь дайсны гал, цохилтоос бөөн хохирол үзэх аюулаас зайлсхийх арга мөн. Салаа нь дайсныг галын уутанд оруулан цохилт өгөх, галаар нягт харилцан ажиллах боломжийг ханган тасаг, тасаг /танк, танк/-аар, харин тасаг нь галын бүлгүүдээр байр, галт байр эзлэн байлдааныг зохион байгуулан

[9] Монгол Улсын хилчний тайлбар толь. Уб., 2003 он

явуулна. Тэгэхдээ тэр нь чухал чиглэлд шаардлагатай үед богино хугацаанд хүчээ хуралдуулах боломжийг ямагт хадгалж байх ёстой. Хүч хэрэгслийг хэт тараангуйлан байрлуулах нь салаа /тасаг/-ны галын нягтралыг бууруулах, маневр үйлдэх мөрийн хэмжээг ихэсгэх, харилцан ажиллагаа, удирдлагыг хүндрүүлнэ.

Байлдааныг төлөвлөх. Байлдааныг төлөвлөх нь салаа, түүнээс дээших нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээ юм. Гэвч дайсантай зах нийлээгүй буюу байлдааныг урьдчилан төлөвлөж байгаа үед тасаг, бүлэг, тэр ч байтугай, цэргийн алба хаагч ч ажиллагаагаа төлөвлөж болно. Цэргийн алба хаагчийн байлдааны төлөвлөгөө нь болох гэж буй ажиллагааг урьдчилан төсөөлж, ажиллах журмаа тогтоох, түүнийгээ газар орон дээр багцаалан тодорхойлох, цаг хугацаагаар оноон хуваарилах, нөхдийнхөө ажиллагаатай уялдуулан тохирох зэргээр хязгаарлагдана.

Салаа, тасгийн байлдааны үндэс. Салаа нь тактикийн анхан шатны орон тооны салбар бөгөөд рот, салааны байлдаан явуулах үндсэн хүч мөн. Салаа нь орон тоогоор буюу нэмэгдүүлсэн хүч хэрэгсэл /хавсрагдсан дэмжих/-тэйгээр болон салааны тактикийн бүлгээр, тасаг нь орон тоогоор эсвэл нэмэгдүүлсэн хүч хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэнэ.

Хавсрагдсан хүч, хэрэгсэл нь салаа, тасгийн захирагчийн мэдэлд түр хугацаагаар өгсөн салбар, галын хэрэгсэл. Дэмжих хүч, хэрэгсэл нь ахлах захирагчийн шийдвэрээр салаа, тасгийн ашиг сонирхолд үүрэг гүйцэтгэх салаа, тасгийн салбар, галын хэрэгсэл юм. Энэ хүч хэрэгсэл нь ахлах захирагчийн шууд захиргаанд байж үүргээ гүйцэтгэнэ.

Байлдаан нь тактикийн ажиллагааны нэг хэлбэр бөгөөд салаа, тасгийн орон тооны, нэмэгдүүлсэн хүч, хэрэгслийн зорилго, үүрэг, байр, зааг, чиглэл, цаг хугацаагаар уялдуулан зохицуулсан гал, атак, маневр, аюулгүй байдлаа хангах ажиллагааны нэгдэл мөн.

Гал нь дайсны амьд хүч, галын хэрэгслийг хөнөөх үндсэн хэрэглүүр бөгөөд тэр нь танкны явган цэргийн байлдааны машин /ЯЦБМ/, хуягт тээвэрлэгчийн, буудлагын зэвсгийн, нэмэгдүүлсэн хүч, хэрэгслийн байна.

Атак нь салаа, тасгийн хүчээр богино хугацаанд, ойрын зайд, нэгэн зэрэг дайсныг устгах буюу бут цохих өндөр эрчимтэй гал, хөдөлгөөний цогц юм. Тэр нь явган, машинтай болон холимог байна.

Маневр нь хүч хэрэгслийн болон галын байна. Хүч хэрэгслийн маневр нь фронт руу, фронтын дагуу, байлдааны журмын гүн тийш байж болох бөгөөд түүний үндсэн төрөл нь ороох, тойрох, буруулах, байрлалаа солих ажиллагаа юм. Дайсны хажуу жигүүр, ар талд гарах зорилгоор гал ба тактикийн харилцан ажиллагаатай хийх маневрыг ороох, дайсны ар талд гарах зорилгоор тактикийн харилцан ажиллагаатай хийх маневрыг тойрох гэнэ.

Байлдааны журмын гүн тийш хийгдэх маневрыг буруулах гэнэ. Түүнийг өөрийн цэргийг дайсны цохилтоос гаргаж, илүү ашигтай байрлал эзлэх зорилгоор гүйцэтгэнэ. Зарим тохиолдолд бууруулалтыг байлдааны ов мэх болгон ашиглана. Байрлалаа солих ажиллагаа нь бэлтгэл болон бусад байр /тулгуурт байр, галын байр, зааг/ гэх мэтэд гарахаар ахлах даргын зөвшөөрлөөр үйлдэх шилжилт бөгөөд тактикийн хувьд ашигтай байрлал эзлэх, дайсныг төөрөгдөлд оруулах, салаа, тасгийг дайсны гал, цохилтын нөлөөллөөс гаргах зорилгоор хийгдэнэ.

Галын маневр нь дайсныг устгах, хөнөөх галын үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор хийгдэх гал шилжүүлэх, дахин хуваарилах, хуралдуулах ажиллагаа юм.

Аюулгүй байдлаа хангах ажиллагаа нь байлдааны ажиллагааг хохирол, эрсдэлгүйгээр биелүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээний цогц юм. Үүнд бие

бүрэлдэхүүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, ёс суртахуун сэтгэл зүйн өндөр чанар, зэвсэглэл байлдааны техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах, материал хэрэгслийг үр ашигтай зарцуулах, цэргийн албан хаагчдын эрхийг хамгаалах, зэвсэгт мөргөлдөөний явцад олон улсын эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа хамрагдана.

Байлдааны журам нь хүч, хэрэгслийг байлдаан явуулахаар дэлгэн байрлуулсан байгууламж юм. Тэр нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

-байлдаанд тавигдсан үүргийг амжилттай биелүүлэхэд зохицсон байх,

-дайсны хяналт, цохилт, галд аль болох бага өртөхүйц байх,

-өөрийн зэвсгийг үр дүнтэй ашиглах боломжийг хангасан байх,

-газар орны нөхцөлд тохирсон байх,

-маневрлах, байлдааны явцад хүч хэрэгслийг шилжүүлэн байрлуулах боломжтой байх,

-нягт харилцан ажиллагаа, удирдлагын тасралтгүй байдлыг хангахуйц байх.

Салааны байлдааны журам нь тасгууд хавсрагдсан хүч, хэрэгслийг дэлгэн байрлуулсан байгууламж болно.

Салааны байлдааны журам нь нэг шугамд, өнцөг урагш, өнцөг хойш, баруун, зүүн тийш шат хэлбэртэй байж болох ба түүний элементүүдийн хоорондын завсар, зай нь салбаруудын болон галын нягт харилцан ажиллагааг хангахуйц байх ёстой.

Салаа, тасаг нь байлдаанд дараах үндсэн зарчмуудыг мөрдлөг болгоно.

-байлдааны байнгын бэлэн байдлыг хангах,

-хүч хэрэгслийг гамнах,

-хүч хэрэгслийг хуралдуулах, тараангуй байрлуулахыг зөв хослуулах,

-гэнэтийн ажиллагаа, байлдааны ов мэх хэрэглэх,

-нягт харилцан ажиллах,

-байлдааныг оюунлагаар явуулах.

Байлдааны байнгын бэлэн байдлыг хангах гэж салаа, тасаг байлдаанд биеэр, ур чадвараар болон оюуны чадавхаар бэлэн байхыг хэлнэ.

Биеэр бэлэн байх нь бие бүрэлдэхүүн, байлдааны журмын элементүүд байраа эзэлсэн, зэвсэг, байлдааны техник байлдаанд ашиглахад бэлтгэгдэж, галт хэрэглэл, материал хэрэгслийн нөөцөөр хангагдсан. Бие бүрэлдэхүүн байлдааны ажиллагаа явуулах бэлтгэлтэй байх нөхцөл мөн.

Ур чадвараар бэлэн байх нь салаа, тасгийн байлдааны чадавхын итгэлцүүр 0.6-аас доошгүй байж, бие бүрэлдэхүүн эзэмшсэн зэвсгээр дайсныг 0.5-аас багагүй магадлалтайгаар устгах, техник, тоног хэрэгслийг гацаа шалтгаангүй ажиллуулах дадлагатай болсон байх нөхцөл мөн.

Оюуны чадавхаар бэлэн байх нь бие бүрэлдэхүүн, ёс суртахуун, сэтгэл зүйн хувьд байлдаанд бэлтгэгдсэн, мэргэшсэн оюунлаг ур чадвар, сэтгэлгээний өндөр хурдаараа дайсныг давамгайлж байх нөхцөл мөн.

Хүч хэрэгслийг гамнах нь хүч хэрэгслийг дайсны гал, цохилтод өртүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлснээр, салаа, тасгийн захирагчаас үндэслэлтэй шийдвэр гарсан байлдааныг ухаалаг удирдаж явуулснаар, бие бүрэлдэхүүн гар нийлэмжтэй чадварлаг ажиллан дайсанд үлэмж хохирол учруулснаар хангагдана.

Хүч хэрэгслийг хуралдуулах, тараангуй байрлуулахыг зөв хослуулах нь салаа, тасгийн бие бүрэлдэхүүн, нэмэгдүүлсэн хүч, хэрэгслийг дайсны цохилт, галд нэгэн зэрэг өртүүлэхгүй байх, үүнтэй нэгэн зэргээр чухал чиглэлд богино хугацаанд маневарлан хүч хуралдуулж, дайсны эмзэг хэсэгт хүчтэй хөнөөл учруулах нөхцөлийг хангаснаар хэрэгжинэ.

Салааны хүч хэрэгслийг тараангуй байрлуулах газар орны хэмжээ нь тасгууд, галын хэрэгслийн тактикийн болон галын харилцан ажиллагааг хангахуйц байна. Тогтоон барих, түйвээх байлдааны үед тэр нь түүний хариуцлагын бүсийн хүрээнд байна.

Гэнэтийн ажиллагаа, ов мэх хэрэглэх нь дайсныг хүлээгээгүй газар, цагт нь тэдний урьдчилан тооцоогүй арга, хэлбэрийг ашиглан хөнөөх, төөрөгдөлд оруулах замаар салаа, тасгийн байлдааныг амжилттай явуулах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Энэ нь өнгөлөн далдлах, хуурамч объект байгуулах, төөрөгдүүлэх ажиллагаа явуулах, шөнө хязгаартай үзэгдэх нөхцөлийг ашиглах, дайсны гүнд нууцаар нэвтрэн тусгай үүрэг гүйцэтгүүлэх зэрэг олон талт ажиллагаагаар хангагдана.

Нягт харилцан ажиллах нь салаа, тасаг хүчин чармайлтыг зорилго, үүрэг, байр, зааг, чиглэл, цаг хугацаа, ажиллагааны арга, хэлбэрээр нь уялдуулан зохицуулахад чиглэгдэнэ. Харилцан ажиллагаа нь галын ба тактикийн байна.

Галын харилцан ажиллагаа нь төрөл бүрийн зэвсгийн галыг байнуудад хуваарилах, гал явуулах арга, дэс дараалал, галын төрөл ба нягтралыг нарийвчлан тогтоох, галын маневр, гал удирдах журмыг тодорхойлж хэрэгжүүлснээр хангагдана.

Тактикийн харилцан ажиллагаа нь салаа, тасаг, нэмэгдүүлсэн хүч, хэрэгсэл, зэргэлдээх салбаруудын байрлал, маневр, шилжилт, ажиллагааны арга, хэлбэрийг уялдуулан зохицуулснаар хангагдана.

Байлдааныг оюунлагаар явуулах нь давуу хүчтэй дайсныг бага хүчээр няцаах, туйлдуулан ядраах, улмаар бут цохин устгах шинэ арга, хэлбэрийн эрэл хайгуулыг уйгагүй явуулснаар хангагдана. Салаа, тасгийн захирагч, бие бүрэлдэүүн нь байлдааныг бэлтгэж явуулахдаа шинэлэг санаа, загварчлагдаагүй бүтээлч сэтгэлгээгээр хандах ёстой.

Бие бүрэлдэхүүний оюуны чадавхыг байнга дээшлүүлэх, хүний хөгжлийг хангах нь салаа, тасгийн байнгын зорилт мөн.

Байлдааны бэлэн байдлын төлөвлөлт. Байлдааны бэлэн байдлын төлөвлөлт нь Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүдийг тайван цагаас дайны үеийн бүтэц, зохион байгуулалтад шуурхай шилжүүлэх, улс орны аюулгүй байдлыг хангах цогц арга хэмжээ юм. Үүнд дайчилгааны төлөвлөгөө боловсруулах, нөөц бүрдүүлэх, тактикийн сургуулилт хийх, зэвсэг техникээр хангах ажиллагаанууд багтдаг.

Байлдааны бэлэн байдлын төлөвлөлтийн үндсэн бүрэлдэхүүн:

-Дайны үеийн бүтэц: Зэвсэгт хүчнийг дайны үеийн зохион байгуулалтад шилжүүлэх төлөвлөгөө боловсруулах, дайчилгааны нөөцийг бэлтгэх.

-*Удирдамж ба шийдвэр:* Зэвсэгт хүчнийг байлдааны бэлэн байдлын дээд зэрэгт шилжүүлэх, дайны байдалд шилжүүлэх тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх.

-*Сургуулилт ба шалгалт:* Нэгтгэл, ангиудын байлдааны бэлэн байдлыг шалгах, тактикийн нэгдсэн сургуулилт (жишээ нь, "Хааны эрэлд") хийх.

-*Зэвсэглэл, техник:* Орчин үеийн зэвсэг, техникээр хангах, сум хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх.

-*Кибер аюулгүй байдал:* Байлдааны ажиллагааг кибер аюулгүй байдлын цэргийн хүчээр дэмжих.

Хэрэгжүүлэх үе шат:

1.Төлөвлөлт: Зэвсэгт хүчнийг дайнд ашиглах ерөнхий төлөвлөгөөг батлах.

2.Бэлтгэл: "Бэлэн байдлын жил" болгон зарлаж, тактикийн сургуулилт хийх.

3.Хэрэгжүүлэлт: Өндөр түвшинд бэлтгэгдсэн мэргэжлийн цэргээр байлдааны үүрэг гүйцэтгэх.

Энэхүү төлөвлөлт нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалахад чиглэсэн чухал үйл ажиллагаа юм.

Гадаадын улс орнуудын байлдааны бэлэн байдал

Гадаадын улс орнуудын байлдааны бэлэн байдал нь олон улсын геополитикийн нөхцөл байдал, аюулгүй байдлын заналхийллээс шалтгаалан өндөр түвшинд байдаг.

Сүүлийн үеийн мэдээллээс үзэхэд цэргийн хүчээ зузаатгах, технологийн шинэчлэл хийх, хамтарсан сургуулилт хийхэд анхаарлаа хандуулж байна.

Зарим улс орнуудын байлдааны бэлэн байдлын чиг хандлага:

-*ОХУ:* Зүүн Европ дах цэргийн хүчээ зузаатгах, цэрэг-стратегийн орчны өөрчлөлтөд бэлэн байх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

-*БНХАУ:* 2020-2030 оны хооронд зэвсэгт хүчинд хиймэл оюун ухаан нэвтрүүлж, өндөр цэцтэй ухаалаг зэвсэг, байлдааны системд шилжих шинэчлэлийг эхлүүлсэн.

-*АНУ:* Зүүн Европ дахь нөхцөл байдалтай холбогдуулан цэргийн хүчээ зузаатгаж, байлдааны хөлөг онгоц, нисэх онгоцнуудыг нэмж илгээн, 8,500 орчим цэргийг байлдааны өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэн байна.

-*Тайван:* Хятадтай дайтахад бэлэн байдлаа хангаж, өөрийгөө хамгаалах чадавхыг дээшлүүлж байна.

Байлдааны бэлэн байдлыг хангах арга хэмжээнүүд:

-*Хууль эрх зүйн орчин:* Дайны байдлын үед гадаадын цэргийн хүчнийг өөрийн нутаг дэвсгэрт оруулах, цэргийн хамтын ажиллагааны гэрээг батлах эрх зүйн зохицуулалтуудтай.

-*Улс орны бэлэн байдал:* Түрэмгийллээс хамгаалахад улс төр, эдийн засаг, нийгэм, цэргийн арга хэмжээг нэгтгэн улс орны хэмжээнд бэлэн байдлыг хангадаг.

-*Цэргийн шинэчлэл:* Зэвсэгт хүчнийг байлдааны бэлэн байдлын дээд зэрэгт шилжүүлэх баримт бичгийг батлах, тайван цагийн бүтцийг өөрчлөх зэрэг ажлууд хийгддэг.

Эдгээр бэлэн байдлын арга хэмжээнүүд нь улс орнуудын аюулгүй байдлыг хангах, болзошгүй халдлагаас сэргийлэх зорилготой юм

Гадаадын өндөр хөгжилтэй болон цэргийн хүчин чадал ихтэй улс орнуудын байлдааны бэлэн байдлыг хангах тогтолцоо нь орчин үеийн дайны хэлбэр, технологийн дэвшил, сэтгэл зүйн нөлөөлөлд тулгуурласан онцлогтой байна.

Гадаадын орнуудын байлдааны бэлэн байдлын гол онцлогууд:

-*Цэргийн сэтгэл зүйн нөлөөлөл:* АНУ зэрэг орнууд сүүлийн 30 гаруй жилд армийн байлдах чадвар, байлдааны бэлэн байдлыг дээшлүүлэхэд цэргийн сэтгэл судлалын шинжлэх ухааны ололтыг эрчимтэй ашиглаж байна.

-*Мэдээллийн дайн ба сэтгэцэд нөлөөлөх үйлчлэл:* ОХУ-ын зэвсэгт хүчний шинэчлэлийн хүрээнд мэдээллийн дайн болон сэтгэцэд нөлөөлөх үйлчлэлийг байлдааны бэлэн байдлын чухал хэсэг гэж үзэж, цэрэг болон тусгай албадын үйл ажиллагаанд өргөнөөр ашиглаж байна.

-*Байнгын бэлэн байдал:* Олон улсад зэвсэгт хүчнийг тайван цагт ч байлдааны байнгын бэлэн байдалд байлгаж, улс орны аюулгүй байдлыг хангах тогтолцоог байнга шинэчилж, бэхжүүлж байдаг.

-*Хууль эрх зүйн зохицуулалт:* Зэвсэгт хүчин нь улс төрөөс ангид байж, зөвхөн улс орны аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэйгээр хууль эрх зүйн хүрээнд ажилладаг.

Гадаадын улс орнуудын байлдааны бэлэн байдал нь үндэсний аюулгүй байдлыг хангах, болзошгүй түрэмгийллийг няцаах, дайны үед үүрэг гүйцэтгэх чадавхыг тодорхойлдог цогц ойлголт юм. Энэ нь зөвхөн цэргийн хүчин чадлаар

хязгаарлагдахгүй, эдийн засаг, технологи, нийгмийн хүчин зүйлстэй салшгүй холбоотой байдаг.

Байлдааны бэлэн байдлын агуулга, мөн чанар:

-*Стратегийн цогц байдал:* Байлдааны бэлэн байдал нь зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдийг тайван цагаас дайны цагийн зохион байгуулалтад богино хугацаанд шилжүүлэх чадвар юм. Үүнд цэргийн алба хаагчдын бэлтгэл, зэвсэг техникийн бүрэн бүтэн байдал, удирдлагын тогтолцооны шуурхай ажиллагаа багтана.

-*Уламжлалт бус дайны шинж чанар:* Орчин үед байлдааны бэлэн байдал нь зөвхөн уламжлалт дайн төдийгүй, хүч тэнцвэргүй дайн (Asymmetric Warfare), кибер халдлага, мэдээллийн дайн зэрэг орчин үеийн аюул заналхийлэлд дасан зохицох чадварыг багтааж байна.

-*Эдийн засаг, нөөцийн чадавх:* Цэргийн зардал нь улс орны эдийн засгийн боломжоос давсан байх нь сөрөг үр дагавартай байдаг тул батлан хамгаалах зардал, зэвсэглэлийн шинэчлэл нь эдийн засгийн тогтвортой байдалтай уялдах ёстой.

-*Геополитикийн хүчин зүйл:* Улс орнууд өөрийн геополитикийн байршил, аюулгүй байдлын орчинд үндэслэн цэргийн хүчирхэг бодлого боловсруулдаг.

-*Стратегийн бие даасан байдал:* АНУ зэрэг томоохон гүрнүүд эрчим хүчний болон нөөцийн бие даасан байдлыг байлдааны бэлэн байдлын гол үндэс гэж үзэж, стратегийн нөөцөө бүрдүүлдэг.

Байлдааны бэлэн байдлын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд:

1.Цэргийн хүчин чадал: Зэвсэг техникийн шинэчлэл, бие бүрэлдэхүүний сургуулилт.

2.Удирдлага, холбоо: Богино хугацаанд шийдвэр гаргах, анги нэгтгэлүүдийг удирдах тогтолцоо.

3.Логистик, хангамж: Дайны үед цэрэг болон ар талыг тасралтгүй хангах чадвар.

Дэлхийн улс орнуудын хувьд байлдааны бэлэн байдал нь үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах, улс орны оршин тогтнох үндэс болсон цэргийн чадавхыг дээд зэргээр хадгалах үйл ажиллагаа юм.

Гадаадын улс орнуудын зэвсэгт хүчний байлдааны бэлэн байдлын зэргүүд нь тухайн улсын үндэсний аюулгүй байдал, геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байдаг боловч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн түвшингүүд байдаг.

Ерөнхийдөө байлдааны бэлэн байдлыг дараах зэргүүдэд хуваадаг:

-*Байнгын (Тайван цагийн) бэлэн байдал:* Зэвсэгт хүчин ердийн горимоор ажиллаж, сургалт бэлтгэл, төлөвлөлтөө хийх.

-*Өндөржүүлсэн бэлэн байдал:* Аюулгүй байдалд заналхийлсэн тохиолдолд анги салбаруудыг богино хугацаанд хөдөлгөөнд орох чадвартай болгох.

-*Байлдааны бэлэн байдал:* Дайны аюул нүүрлэсэн үед цэргийн хүчийг бүрэн дайчлах.

-*Байлдааны дээд зэрэг:* Байлдааны ажиллагаа эхлэх, цэргийн хүчийг бүрэн дүүрэн ашиглах үеийн нөхцөл байдал.

Орчин үеийн чиг хандлага:

Орчин үед цэргийн стратеги нь ерөнхий бэлэн байдлаас гадна Агаарын цэргийн командлал, тусгай хүчний анги салбаруудын шуурхай ажиллагаанд ихээхэн анхаардаг болсон. Мөн ОХУ зэрэг орнууд цэргийн тойргийн бүтцээ шинэчлэн, стратегийн бэлэн байдлаа дээшлүүлж байгаа нь орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанартай холбоотой юм.

Төлөвлөлт, зохион байгуулалт: Гадаадын улс орнуудын байлдааны бэлэн байдлын төлөвлөлт, зохион байгуулалт нь орчин үеийн геополитикийн нөхцөл байдал, зэвсэгт мөргөлдөөний шинж чанарын өөрчлөлтөөс хамааран цогц, уян хатан хэлбэрт шилжиж байна. Энэхүү тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах, дайны үеийн бүтэц, зохион байгуулалтыг урьдчилан төлөвлөхөд чиглэгддэг.

Байлдааны бэлэн байдлын төлөвлөлт, зохион байгуулалтын гол чиг хандлагууд:

-*ОХУ-ын зэвсэгт хүчний шинэчлэл:* ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2024 оны 2 дугаар сарын зарлигаар зэвсэгт хүчний тойргийн бүтцийг шинэчлэн зохион байгуулж, цэргийн бүтцийг дайны үеийн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчилж байна.

-*БНХАУ-ын "Ардын дайн" номлол:* 1990-ээд оны эхэн хүртэл БНХАУ-ын цэргийн номлол нь "Ардын дайн" буюу масс хүчний төвлөрөл, нийтийн дайчилгаанд суурилж байсан бол өдгөө орчин үеийн технологид суурилсан байлдааны чадавхыг дээшлүүлэхэд төвлөрч байна.

-*Цэргийн стратегийн өөрчлөлт:* Гадаадын улс орнууд цэргийн албан хаагчдын иргэний эрхийг хуулиар хязгаарлах замаар байлдааны бэлэн байдал, улс төрийн төвийг сахисан байдлыг хангах тогтолцоог бүрдүүлдэг.

-*Дайны үеийн төлөвлөлт:* Зэвсэгт хүчний дайны үеийн бүтэц, зохион байгуулалт, цэргийг байлдааны бэлэн байдлын дээд зэрэгт шилжүүлэх, дайнд ашиглах ерөнхий төлөвлөгөөг боловсруулах нь батлан хамгаалах бодлогын үндэс болдог.

Байлдааны бэлэн байдлын зохион байгуулалт нь геополитикийн орчин, хөрш орнуудын цэргийн хүчин чадалтай нягт холбоотой бөгөөд зэвсэгт мөргөлдөөний шинж чанарын өөрчлөлтөд нийцүүлэн цэргийн сургалт, бэлтгэлийг тасралтгүй сайжруулж байна.

Гадаадын улс орнуудын байлдааны бэлэн байдлын дүн шинжилгээ.

Гадаадын улс орнуудын байлдааны бэлэн байдлын дүн шинжилгээ нь орчин үеийн геополитикийн нөхцөл байдал, зэвсэгт мөргөлдөөний шинж чанарын өөрчлөлтөөс шалтгаалан цогц байдлаар хийгддэг.

2024-2026 оны нөхцөл байдалд үндэслэн хийсэн дүн шинжилгээгээр дараах үндсэн чиглэлүүдийг онцолж байна.

Байлдааны бэлэн байдлыг тодорхойлогч гол хүчин зүйлс:

-*Цэргийн бүтцийн шинэчлэл:* ОХУ-ын зэвсэгт хүчний тойргийн бүтцийг шинэчлэн зохион байгуулах зэрэг *ОХУ-ын зэвсэгт хүчний шинэчлэлийн явц (I) – NISS* зарлиг, АНУ болон барууны орнуудын *цэргийн дүрэм, заавруудын* нь цаг үеийн аюулгүй байдлын нөхцөл байдалд нийцүүлэн байнга шинэчлэгдэж байна.

- Орчин үеийн дайн нь уламжлалт хүчин чадлаас гадна *Asymmetric Warfare (тэнцвэргүй дайн*) буюу 4 дүгээр үеийн дайны хэлбэрийг ашиглах болсон.

-*Тагнуул, тандалтын үүрэг:* Цэргийн мэдээлэл, дүн шинжилгээ, сансрын тандалт нь *Зэвсэгт хүчний тухай хуулиар* байлдааны бэлэн байдлын гол тулгуур болдог.

-*Сэтгэл зүйн ажиллагаа:* Аюулгүй байдлыг хангах, цэргийн заль мэх, сэтгэл зүйн ажиллагааг цэргийн дүрэмд өндөр түвшинд тусгадаг.

Дүн шинжилгээний чиг хандлага:

1.Бэлэн байдлын зэрэг: Улс орнууд зэвсэгт хүчнээ байлдааны бэлэн байдлын дээд зэрэгт шилжүүлэх, дайны байдал зарлах, хил хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуух ажиллагааг тогтмол сургуулилдаг.

2.Мэргэжлийн удирдлага: Ерөнхий хянан шалгагч нар нь батлан хамгаалах чадварын түвшнийг үнэлэх болон даалгаврын биелэлтийг шалгах, мэргэжлийн түвшинд зохион байгуулах үүрэгтэй.

3.Түүхэн туршлага: Таван замын байлдаан зэрэг түүхэн үйл явдлуудаас суралцах, халхын голын дайны туршлагыг судлах нь өнөөгийн байлдааны тактикт чухал ач холбогдолтой.

Ерөнхийдөө, гадаадын улс орнуудын байлдааны бэлэн байдал нь зөвхөн цэргийн хүч чадлаар бус, технологи, тагнуул, сэтгэл зүйн болон уламжлалт бус дайны арга хэрэгслийг хослуулан ашиглахад чиглэгдэж байна.

Дүгнэлт: Манай улс 1939 оны Халх голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайн, 1940-1948 баруун хилийн тулгаралтуудыг байлдааны ялалтаар дуусгаж монгол эх орноо баатарлагаар хамгаалсан түүхэн гавьяатай.

Энэ бүх ялалт, амжилтын үндэс нь байлдааны бэлтгэл сургуулилтыг тасралтгүй зохион байгуулж, төрөл мэргэжлийн цэргийн анги, салбар, бүлгүүдийн байлдааны бэлэн байдлыг өндөр түвшинд байлгаж ажилласны үр дүн билээ.

1990 оноос буюу ардчилсан хувьсгалын он жилүүдэд улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангахад төр засгийн үүргийг нэр төртэй биелүүлж улмаар олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд амжилттай үүрэг гүйцэтгэж дэлхийн цэрэг, арми болоод байгаа нь мөн л байлдааны бэлэн байдлын ямар ч түвшний зэргүүдэд итгэл төгс ажиллаж чадвараа харуулсаар байна.

Орчин цагийн байлдаанд өргөнөөр ашиглагдаж байгаа шинэ техник технологийн өөрчлөлтийг судалж, түүнд төрөл мэргэжлийн цэргийн анги, салбар, бие бүрэлдэхүүнийг тууштай сургаж бэлтгэх, байлдааны бэлэн байдлыг хангах явдал нь тулгамдсан асуудлын нэг хэмээн дүгнэж байна.

Ашигласан ном зүй:

1.Байлдааны дүрэм 1 100

2.Байлдааны дүрэм 2 100

3.Хилчний тайлбар толь. 2003.

УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД, СИСТЕМИЙН ОНОЛТОЙ ХОЛБОГДОХ НЬ

Э.НЯМЗАГД*
ДХИС-ийн Удирдлагын академийн 8012 дугаар дамжааны суралцагч, магистрант, хошууч

**хариуцлагатай зохиогч: zagdaaerdenetuya@gmail.com*

Системийн ерөнхий онолын тухайд товчхон ...

Асуудлыг зөвхөн нэг өнцгөөс биш олон талаас нь бүхэлд нь авч үзэхийг системийн ерөнхий онол чиглүүлж өгдөг. Аливаа том систем нь түүнийг бүрэн тодорхойлж чадахуйц ямар нэгэн бичил хэсгүүдээс бүрддэг бөгөөд тэр нь цаашдаа үелэн давтагдах шинж чанартай байдаг нь системийн онолын үндсийг бүрдүүлдэг гэж болно. Системийн ерөнхий онол гэдэг нь бүхний тухай ойлголт юм.

Энэ онол нь энгийн жижиг хэсгээс аварга том ертөнцийг хүртэл бүгдийг тайлбарлана гэсэн хэрэг ажээ. Танин мэдэхүйн бүх мэргэжилтнүүд системийн ерөнхий онолыг мэдэх ёстой бөгөөд дэлхий дээрх бодит зүйлийн тухай мэдлэг нь өөрөө системт ойлголт мөн.[10] Амьдрал гэдэг органик нийлмэл молекулууд энгийнээр тогтсон, тэдний дотор, тэдгээрийн хооронд нэгэн зэрэгцээ гадаад орчинтой энерги, мэдээллийн солилцоо хийх үндсэн дээр өөрийгөө барьж байдаг, өөрийгөө бүтээдэг, өөрөө хөгждөг аугаа том систем юм.

Системийн онол нь:

1. Систем байнгын ерөнхий нэг онолтой байх;
2. Системийн зорилго нь гаднаас тавигдсан байх;
3. Систем зорилгодоо хүрэхийн тулд тодорхой үйлдэл хийх;
4. Системийн үйл ажиллагааны үр дүн системээсээ хамаарахгүй гэсэн дөрвөн аксиом;

1. Хадгалагдах (үйл ажиллагаа) хууль;
2. Учир шалтгааны хязгаарлалтын хууль;
3. Зорилгын шатлан удирдах хууль;
4. Системийн шатлан удирдах хууль гэсэн дөрвөн хууль дээр үндэслэгддэг.[11]

Хилийн аюулгүй байдлын ойлголтууд, системийн онол ёсоор...

Хилийн аюулгүй байдлыг хангах систем гэдэг нь хилийн аюулгүй байдлыг хангах орчны харилцааг зохицуулах үзэл баримтлалын үндсүүд, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд, хуулийн дагуу хилийн аюулгүй байдлыг хангахад оролцож байгаа харилцан хамаарал бүхий төрийн захиргааны болон олон нийтийн байгууллага, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгод нийцсэн үйл ажиллагааны нэгдэл, үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг юм.[12]

Хилийн аюулгүй байдлын асуудал нь, системийн аюулгүй байдлын асуудал болж, орчин үеийн хөгжлийн бүх төвшинтэй уялдан холбогдож байдаг учраас яахын аргагүй тулгамдсан асуудлын нэг юм.

Хилийн аюулгүй байдал гэдэг нь “улсын хил, хязгаар нутаг (хилийн орон зай)-т үндэсний аюулгүй байдал найдвартай хангагдах гадаад, дотоод нөхцөл баталгаатай хангагдах явдал”[13] юм. Хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын төрийн, орон

[10]Б.Болдсайхан. Системийн аюулгүй байдлын асуудлууд. УБ. 2008. х.7
[11]Б.Болдсайхан. Системийн онолын үндэс (Системийн аюулгүй байдлын асуудлууд. УБ. 2008. х.20)
[12]Д.Дашдаваа. Улсын хилийн аюулгүй байдлыг хангах зарим арга зам. УБ. 2011. х.80
[13]Ш.Арвай. Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол. УБ. 2005. х.185

нутгийн засаг захиргааны болон төрийн бус байгууллагууд хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт өөрсдийн эрх мэдлийн хүрээнд улс төр, эрх зүй, дипломатын болон батлан хамгаалах, цэргийн, хилийн, тагнуулын, гаалийн, экологийн, хүн-мал эмнэлгийн болон бусад арга хэмжээг нэгдмэл бодлоготой, харилцан уялдаатай явуулах үйл ажиллагаагаар хангагдана.

Систем нь ажиллах тодорхой хүрээлэл, түүний элементүүдийн үйл ажиллагааны ерөнхий орчинтой байдаг. Өөрөөр хэлбэл амьдрал, үйл ажиллагааны нөхцөл болсон зохих хүрээлэл, гадаад орчноос ангид ямар ч систем үүсэж, оршин тогтнож чадахгүй.

Монгол Улсын хилийн орон зай нь улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал хангагдаж байгаа улсын хил, хилийн болон хил орчмын нутаг дэвсгэр, агаарын орон зайнаас бүрдэнэ. Өөрөөр хэлбэл хилийн орон зайг Монгол Улсын хил болон хилийн ойролцоо байгаа сумуудын хил талын газар нутаг, түүн дээр оршин байгаа төр, нийгэм, ард иргэд, хилийн болон гааль хорио цээрийн хяналт явагддаг шалган нэвтрүүлэх боомт, түүний орчинд хилийн шинж чанартай явагдаж байгаа үйл ажиллагааны нийгэм-газар зүйн тухайн хэсэг юм.

Хилийн орчин гэж хилийн орон зайн ойлголтоосоо гадна хилийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхтэй шууд холбоо бүхий төрийн байгууллага, нийгэм, иргэдийн амьдрал үйл ажиллагаа, улс хоорондын харилцааны хэсэг мөн.

Систем өөрөө хоорондоо тодорхой зорилго, зүй тогтлын дагуу харилцан холбогдсон элементүүдээс бүрдсэн харьцангуй тогтвортой шинж чанарыг агуулж чадаж байгаа цогц бүхэллэг хэсгүүд юм. Систем гэдэг нь харилцан үйлчлэл бүхий элементүүдийн багц бөгөөд өгөгдсөн ашигтай үр дүнд хүрэхийн тулд харилцан үйлчлэлцэж байгаа сонгомлоор хамрагдсан элементүүдийн иж бүрдэл юм бол үндэсний (хилийн) аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд Байгаль орчныг хамгаалах алба, Гаалийн алба, Дипломат алба, Иргэний хамгаалалтын алба, Мэргэжлийн хяналтын алба, Зэвсэгт хүчин, бусад цэрэг, Татварын алба, Тусгай алба, Батлан хамгаалах яам, Хууль зүйн яам, Гадаад харилцааны яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Сангийн яам, Уул уурхайн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны дотоод зохион байгуулалт, бүтцийг бүрдүүлэгч элементүүд[14] болж байна.

Системийн гол ялгагдах шинж нь ямар нэгэн “зорилго”-ыг агуулсан байдаг. Зорилгогүй систем гэж үгүй ба элементүүд тодорхой зорилго дор нэгдэн харилцан үйлчлэлцэж байдаг.Систем гаднын тодорхой үйлчлэлд, байнга өөрийн үйлдлээр хариулах онцлог бүхий багц элементүүдтэй байдаг. Хэрэв гаднын үйлчлэлд хариулахгүй, мэдрэхгүй байвал систем биш юм. Гаднын тодорхой үйлчлэлд байнгын хариулт өгөх нь системийн зорилго юм. Ингэхлээр системийн үйлдлийн чиглэлийг зорилго нь тодорхойлно.

Аль ч системүүд өөрийн байнгын үйлдлээр ялгардаг, өөрийн зорилго чиглэлээрээ бие биеэсээ ялгагддаг. Систем нь зориудын тодорхой зорилгын доор тогтдог. Тэгэхээр зорилго системийг тодорхойлогч хүчин зүйл юм. Зорилго байвал систем байна, зорилго байхгүй бол систем байхгүй гэж үзэж болно. Аль ч систем нь тавьсан зорилгодоо хүрэхийн төлөө үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

Хилийн аюулгүй байдлыг хангах гол зорилго нь хилийн орчинд Монгол Улсын Үндэсний язгуур ашиг сонирхлыг гадаад, дотоод аюул заналаас хамгаалах төр,

[14]Д.Нямдорж, Ц.Ганболд бусад. Хил судлал. УБ. 2011. х.15

нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангахдаа юуны урьд хилийн талаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, зэргэлдээ улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх бүх талын бололцоо бүрдүүлэхэд оршино.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд:

❖ Улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн аюулгүй байдлыг хангах бүх нөхцөлийг бүрдүүлэх;

❖ Улсын хилийн талаарх олон улсын эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох;

❖ Улсын хил дээр болон хил орчмын нутаг дэвсгэрт цэргийн аюул, хурцадмал байдал, зэвсэгт болон зэвсэггүй мөргөлдөөн гарахаас урьдчилан сэргийлэх талаар улс хоорондын хэлэлцээр байгуулах;

❖ Бусад улс орны зүгээс өөрийн орны нутаг дэвсгэрт хүчээр шилжин суурьших, эдийн засгийн түрэмгийллийн эсрэг чиглэсэн арга хэмжээ авах;

❖ Улсын үндэсний эрх ашгийн үүднээс хилийн орон зайд цэрэг улс төрийн бүлэглэл болон бусад улсын зүгээс тусгаарлагдмал байдалд орох аюулыг арилгах;

❖ Ямар ч хэлбэрийн гэмт хэргийн үйлдлийг (санаатайгаар улсын хил зөрчих, хууль бусаар буу зэвсэг, мансууруулах бодис, эд зүйлс нэвтрүүлэх, хил дамнасан гэмт бүлэг орж ирэх г.м) таслан зогсоох чадвартай байхын тулд улсын хил хамгаалалтыг бэхжүүлэх;

❖ Улсын тусгаар тогтнол, түүний материалын болон оюуны баялгийн эсрэг гарч болзошгүй ямарваа үйлдлийг таслан зогсоох;

❖ Улсын хилийн хамгаалалт эрхэлсэн байгууллагуудыг бэхжүүлэх, хил, хязгаар нутгийн хамгаалалтыг сайжруулах;

❖ Улсын хил хамгаалах үүрэг бүхий субъектүүдийн нэгдмэл ажиллагааг хангах;

❖ Хамгаалалт эрхлэх бүх субъектийн алба, байлдааны болон бусад боломжийг дээшлүүлэх, бэлэн байдлыг өндөржүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх.[15]

Үүнээс үзвэл системийн зорилго нь тодорхой чиглэгдсэн үйл ажиллагааны үр дүнд хүрэх гэсэн эрмэлзэл юм байна. Аль ч системийн зорилго нь зорилтот үр дүндээ хүрэх гэсэн үйлдэл аж.

Зорилгоо биелүүлэхийн тулд систем үйлдэл хийдэг. Хэрэг дээрээ систем өөрийнхөө үйлдлээр зорилгоо биелүүлж үр дүнд хүрдэг.

Гаднын үйлчлэлийн хариуд системийн хийж байгаа үйлдлийг “хариу үйлдэл” гэх бөгөөд энэ хариу үйлдэл нь хилийн аюулгүй байдлыг хангах өөрөөр хэлбэл улсын хилийг манах хийгээд хамгаалах хэлбэрээр илэрч байна.

Оросын холбооны улсын хил судлалын эрдэмтэд улсын хилийг манах (охрана) ажиллагааг “Хил хамгаалах байгууллага өөрийн хүч хэрэгслээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг улсын хилийг манах” гэх бөгөөд, хилийг хамгаалах (защита) ажиллагааг “төрийн хилийн бодлогоор үүрэг хүлээсэн субъектүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг улсын хилийг хамгаалах”[16] гэнэ гэж тайлбарлаад эрх зүйн баримт бичгүүддээ тусгаж хэрэгжүүлээд явж байна. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, төрийн бодлогын хэрэгжилтийг хангах үйл

[15]Ю.И.Авдеев, С.В.Алёнкин и др. Правовая основа обеспечения национальной безопасности РФ. М. 2004. с.16

[16]Д.Дашдаваа. Хилийн аюулгүй байдлын тогтолцоо бүрдүүлэх асуудалд. Хил судлал сэтгүүл. 2009 №3, 4. х.12

ажиллагааг улс орон даяар уялдуулан зохицуулах чиг үүргийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хариуцна[17] гэжээ.

Тэгвэл хариуцах гэж хүлээн авах, үүрэг болгож авахын нэр агаад хариуцлага гэж 1. Хариуцах үйлийн нэр, хариуцсан үүрэг, хариуцлагын (нэгдэл), эцэст нь хариуцлага хүлээх этгээд; 2. Хууль зөрчсөн хэрэгт хариуцлага хүлээлгэх хэмээн[18] тайлбарлажээ. Тэгвэл:

1. Оршин тогтнохуйн аюулгүй байдал

Энэ хүрээнд улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал; хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал; хүн ам, удмын сангийн аюулгүй байдал; соёл иргэншлийн аюулгүй байдлыг Батлан хамгаалах яам, Хууль зүйн яам, Гадаад харилцааны яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам хариуцаж;

2. Эдийн засгийн аюулгүй байдал

Энэ хүрээнд эдийн засгийн олон тулгуурт бүтэц; хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого; төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдал; эрчим хүч, эрдэс баялгийн салбарын бодлого; гадаад худалдаа, интеграцийн бодлогыг Сангийн яам, Уул уурхайн яам, Гадаад харилцааны яам хариуцаж;

3. Дотоод аюулгүй байдал

Энэ хүрээнд үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх; Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх; үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх; нийгмийн тогтвортой байдлыг хангах асуудлыг Хууль зүйн яам хариуцаж;

4. Хүний аюулгүй байдал

Энэ хүрээнд хүний эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх; хүнсний аюулгүй байдал, амьдрах орчны аюулгүй байдал; иргэдийг үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах асуудлыг Эрүүл мэндийн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам хариуцаж;

5. Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал

Энэ хүрээнд усны нөөцийн хомсдолоос сэргийлэх; уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын үр дагаврыг бууруулах; биологийн олон янз байдлыг хадгалах, нөөцийн хомсдолоос сэргийлэх; хүрээлэн байгаа орчны бохирдлыг бууруулах; байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Онцгой байдлын ерөнхий газар хариуцаж;

6. Мэдээллийн аюулгүй байдал

Энэ хүрээнд мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах; мэдээллийн бүрэн бүтэн байдал; мэдээллийн нууцлал; мэдээллийн хүртээмжтэй байдлыг Тагнуулын ерөнхий газар тус тус хариуцаж хангуулах нь зүйтэй гэж үзэж байна. Гагцхүү тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал хүлээгдэж байна. “Гаднын хүчин”-ий үйлчлэлгүйгээр ямар ч хариу үйлдэл байхгүй. Хилийн аюулгүй байдалд үзүүлэх “гаднын хүч” нь түүнд учрах аюул, заналын хэлбэрээр илэрнэ.

Монгол Улсын хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй ноцтой аюулуудад:[19]

- Хилийн орчимд хөрш зэргэлдээ улсуудын цэргийн бүлэглэлүүдийн тоо нэмэгдэх;
- Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт гадаадын тусгай албадын тагнах, хорлон сүйтгэх үйл ажиллагааны хүрээ өргөжих;

[17]Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 4.2.4
[18]Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь.УБ. 1966. Х.666
[19] Д.Дашдаваа. Улсын хилийн аюулгүй байдлыг хангах зарим арга зам. УБ. 2011.

❖ Хил залгаа улсуудын хилийн орчимд улс төр, үндэстэн хоорондын шашны болон бусад сөргөлдөөн, орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөн зэрэг гадаад дотоод, түгшүүрт байдлын голомт үүсэх;

❖ Гуравдагч орны иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин олноороо цагаачлах, тэдний зарим нь хилийн ойролцоо үлдэхийг оролдох;

❖ Гадаадын иргэд, тэр дундаа хууль бус цагаачдыг эдийн засгийн орон зайд нэвтрүүлэх;

❖ Хил орчмын улсуудын найрамдалт холбоо харилцаа сулрах;

❖ Улс орон гадаад эдийн засгийн байр сууриа алдах, хил залгаа бүс нутгийн зах зээлд гарах нь багасах;

❖ Гэмт хэргийн бүлэглэлүүдийн хууль бус наймаа болон гэмт үйлдэл, ялангуяа улсын хилийн зарим хэсэгт олон улсын хар тамхины наймаа идэвхжих;

❖ Олон улсын терроризм, өөрийн оронд болон зэргэлдээх улсад улс төрийн салан тусгаарлах бүлэглэлүүд бий болж холбоо харилцаагаа өргөжүүлэхэд хилийн орон зайг ашиглуулах;

❖ Дээрмийн бүлэглэлүүд хилийн зурвас, хил орчмын нутаг дэвсгэрт террорист ажиллагаа үйлдэх хэлбэрээр илэрч болохыг судлаачид тогтоогоод байгаа юм. Ийнхүү гаднын хүчин зүйл нь шалтаг болж, үйлчлэлийн үр дүн нь уршиг болдог.

Зорилгод хүрэхийн тулд уг систем юунаас тогтож вэ гэдэг нь хамаагүй, ямар ч тохиолдолд зорилгоо биелүүлэх боломж нь системийг тодорхойлж байдаг. Систем ийнхүү түүнд өгөгдсөн зорилго, түүний үр дүн хоёроор тодорхойлогддог байна.

Хилийн аюулгүй байдал дараах арга хэмжээг авснаар хангагдана.[20] Үүнд:

1.Улсын хилийг халдашгүй дархан байлгаснаар;

2.Хөрш улстай сайн хөршийн найрамдалт харилцаа, энх тайванч хамтын ажиллагаа хөгжүүлэх, хилийн орон зайд олон улсын эрх зүйн зарчмуудыг хэрэгжүүлснээр;

3.Хувь хүн, хуулийн этгээдээр хилийн болон хил орчмын дэглэм, боомтод мөрдөх журмыг сахиулснаар;

4.Улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг сахин хангаснаар;

5.Хилийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий төр захиргааны болон бусад байгууллагуудын хүч хэрэгслийн нэгтгэн ажиллуулснаар. Ер нь цаашдаа интернэтийн мэдээлэл, сансрын холбоонд тулгуурласан дээд эрэмбийн оюунлаг мэдээллийн даяарчлалд орж амьдрах цаг үедээ тулж очоод байна. Өнөөдөр шинжлэх ухааны асар их мэдээлэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, товхимол... гэх мэтийн олон хэлбэрээр хөврөн овоологджээ.

Энэ нь өдрөөс өдөрт “хунгарласан цас” шиг хуримтлагдан байгаа мэдээллийн бөөгнөрөлд боловсруулалт хийхгүйгээр цааш хөгжих боломжгүй юм. Асар их мэдээллийг богино хугацаанд боловсруулж ашиглах шаардлагыг дээд эрэмбийн хөгжлийн өнгө аяс руу чиглэгч хүмүүн төрөлхтөнд цаанаас нь цаг хугацааны асар их хурд шаардаад байгаатай холбоотой. Даяаршиж буй өнөөгийн нөхцөлд дэлхий дахины хөгжлийн ерөнхий чиг хандлага, төлөв нь манай гадаад орчин, язгуур ашиг сонирхолд хэрхэн нөлөөлж болохыг урьдчилан харахад төвөгтэй болжээ. Хэдий тийм боловч бодит мэдээлэл, нарийн ажиглалт, судалгаанд үндэслэж, Монгол улсын гадаад орчин, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжилд учирч болзошгүй аюул, заналыг зөв тооцоолон тодорхойлж, урьдчилан сэргийлэх, аюулыг зайлуулах буюу хамгийн бага эрсдэлтэйгээр давж туулах зөв арга, шийдлийг олох нь чухал юм. Хилийн аюулгүй

[20]Академия Федеральной ПС РФ. Пограничный словарь М. 2010. с.8

байдлыг хангах гэдэг нь хилийн орчинд учирч болзошгүй дотоод, гадаад аюул, заналыг арилгах, улс орны үндэсний ашиг сонирхлыг найдвартай хамгаалахад чиглэгдсэн төрийн байгууллага, нийгмийн институци, иргэдийн цогц үйл ажиллагаа юм.[21] Хилийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн хоёр үндсэн зорилтуудыг шийдвэрлэх шаардлагатай ба энэ нь нэгдүгээрт, хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюул, занал буй болохоос урьдчилан сэргийлэх, хоёрдугаарт, тэдэнд тохирсон сөрөг арга хэмжээг авч хэрэгжүүлэх явдал юм.

Систем нь өөрийн зорилго чиглэлт хөдөлгөөн ба өөрийн зорилгод хүрэх хөдөлгөөнөө хадгалахыг эрмэлздэг учир энэ үйлдлийг гүйцэтгэхэд зарцуулах энерги, эдгээр үйлдлийг гүйцэтгэх элементүүд ба үйлдлийн дараалал үйлдэл, өөрөө хадгалагддаг. Системийн хоорондын ба системийн элементүүдийн хоорондын харилцан үйлчлэл нь хэрэг дээрээ тэдний хоорондын холбоо юм. Систем нь түүний элементүүдийн харилцан үйлчлэл ба элемент хоорондын холбоог үүсгэдэг. Системийн үйлдлийн үр дүн нь түүний функц юм. Зорилгодоо хүрэхийн тулд систем зорилтот чиглэлтэйгээр тодорхой үйлдлийг гүйцэтгэх ёстой. Зорилго нь системийн аргумент, үйлдлийн үр дүн нь функц болно. Систем ба функц гэсэн ойлголтууд салшгүй холбоотой. Функциональ бус систем гэж байдаггүй. Системд тодорхой гаднын хүчин үйлчилбэл тэр заавал тодорхой өөрмөц үйлдлийн үр дүн өгдөг. Ингэснээрээ функциональ болдог. Үйлдлийн үр дүн тавьсан зорилготой таарч байхыг системийн үр ашигтай байдал гэнэ. Системийн үр ашигтай байдал тэдгээрийн функцтэй шууд холбоотой. Системийн функц хангалттай, хоцорсон, гиперфункц, бүрэн хангалтгүй байж болно. Систем ямар нэг үйлдлийг гүйцэтгэж энэ үйлдлийн үр дүн тухайн системийн зорилготой таарч байх ёстой.

Ашигласан эх сурвалж

1. Б.Болдсайхан. Системийн аюулгүй байдлын асуудлууд. УБ. 2008. х.7;
2. Б.Болдсайхан. Системийн онолын үндэс (Системийн аюулгүй байдлын асуудлууд. УБ. 2008. х.20);
3. Д.Дашдаваа. Улсын хилийн аюулгүй байдлыг хангах зарим арга зам. УБ. 2011. х.80;
4. Ш.Арвай. Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол. УБ. 2005. х.185;
5. Д.Нямдорж, Ц.Ганболд нар. Хил судлал. УБ. 2011. х.15;
6. Ю.И.Авдеев, С.В.Алёнкин и др. Правовая основа обеспечения национальной безопасности РФ. М. 2004. с.16;
7. Д.Дашдаваа. Хилийн аюулгүй байдлын тогтолцоо бүрдүүлэх асуудалд. Хил судлал сэтгүүл. 2009 №3, 4. х.12;
8. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ. 2010;
9. Я.Цэвэл.Монгол хэлний товч тайлбар толь.УБ. 1966. Х.666;
10. Д.Дашдаваа. Улсын хилийн аюулгүй байдлыг хангах зарим арга зам. УБ. 2011;
11. Н.Наранжамц. Улсын хил хамгаалалтын онол, практикийн үндсэн асуудал. УБ. 2008;
12. Академия Федеральной ПС РФ. Пограничныи словарь М. 2010. с.8;
13. Щербаков А.С. Пограничная безопасность России и система ее обеспечения. М. 2004. с.49.

[21]Щербаков А.С. Пограничная безопасность России и система ее обеспечения. М. 2004. с.49

“ОРЧИН ҮЕИЙН ҮХЭЛД ҮЛ ХҮРГЭХ ЗЭВСГИЙН ХЭРЭГЛЭЭ БА ХАНДЛАГА”

Ц.ДАВААНЯМ*
ДХИС-ийн ХАС-ийн Цэргийн хэргийн тэнхимийн багш, хошууч

**хариуцлагатай зохиогч: tsdavaanym084@gmail.com*

Хураангуй: Энэхүү эрдэм шинжилгээний ажилд орчин үеийн үхэлд үл хүргэх зэвсгийн онолын үндэс, ангилал, хэрэглээ, эрх зүй, ёс зүйн зохицуулалт болон олон улсын туршлагыг цогцоор нь авч үзлээ. Үхэлд үл хүргэх зэвсэг нь хүний амь насыг шууд хөнөөх зорилгогүй боловч бие махбод, мэдрэхүй, мэдрэлийн системд түр хугацааны нөлөөлөл үзүүлж, эсэргүүцэл болон хөдөлгөөнийг саармагжуулахад чиглэсэн хэрэгсэл болох нь тогтоогдлоо.

Судалгааны хүрээнд уг зэвсгийг механик, химийн, цахилгаан, дуу ба гэрлийн нөлөөллийн гэсэн үндсэн дөрвөн ангилалд хуваан, тус бүрийн үйлчлэх механизм, хэрэглээний онцлог, давуу болон сул талыг задлан шинжилсэн. (хууль, 2016) Мөн үхэлд үл хүргэх зэвсгийн хэрэглээ нь хууль ёсны байх, зайлшгүй шаардлагатай байх, пропорциональ зарчмыг баримтлах, хүний эрхийг дээдлэх зэрэг үндсэн эрх зүй, ёс зүйн зарчимд тулгуурлах ёстойг тодорхойлов.

Олон улсын жишээн дээр үндэслэн авч үзэхэд улс орнуудын хэрэглээ нь тухайн улсын эрх зүйн тогтолцоо, аюулгүй байдлын бодлого, хүний эрхийн хандлагаас хамааран ялгаатай байна. Тухайлбал, технологийн хөгжил өндөр орнуудад хэрэглээ өргөн боловч хүний эрхийн маргаан дагалдах хандлагатай байхад, төвлөрсөн удирдлагатай орнуудад хяналт өндөр боловч ил тод байдал сул байна.

Дүгнэн үзэхэд үхэлд үл хүргэх зэвсэг нь орчин үеийн аюулгүй байдлын салбарт зайлшгүй шаардлагатай боловч түүний хэрэглээ нь харьцангуй ойлголт бөгөөд буруу ашиглалт нь эрсдэл дагуулдаг. Иймээс цаашид илүү аюулгүй, нарийвчлалтай, хүний эрхэд нийцсэн технологи хөгжүүлэх, мөн хэрэглээний эрх зүйн зохицуулалт, мэргэжлийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Түлхүүр үг: Үхэлд үл хүргэх зэвсэг, Хууль сахиулах ажиллагаа, Аюулгүй байдлын бодлого, Технологийн хөгжил, Ёс зүйн хариуцлага

УДИРТГАЛ

Орчин үеийн нийгмийн аюулгүй байдлын орчинд гарч буй өөрчлөлт, сорилтууд нь хууль сахиулах болон аюулгүй байдлын байгууллагуудын үйл ажиллагаанд шинэ шаардлага тавьж байна. Тухайлбал, олон нийтийн эмх замбараагүй байдал, гэмт хэргийн шинэ хэлбэрүүд, терроризмын аюул заналхийлэл нэмэгдэж буй нөхцөлд хүч хэрэглэх арга хэрэгслийг оновчтой, үр нөлөөтэй, хүний эрхэд нийцсэн байдлаар хэрэглэх асуудал чухалд тооцогдож байна.

Энэхүү нөхцөлд үхэлд үл хүргэх зэвсэг нь хүний амь насанд шууд аюул учруулахгүйгээр нөхцөл байдлыг хяналтад авах, эсэргүүцлийг саармагжуулах боломжийг олгодог чухал хэрэгсэл болж хөгжиж байна. Орчин үеийн технологийн дэвшил, шинжлэх ухааны ололттой уялдан уг төрлийн зэвсгийн төрөл, хэрэглээний арга хэлбэр улам бүр боловсронгуй болж, түүний хэрэглээ дэлхийн олон улс оронд өргөн хүрээнд нэвтэрч байна.

Гэвч үхэлд үл хүргэх зэвсгийн хэрэглээ нь зөвхөн практик хэрэглээний асуудал бус, харин онолын, хууль зүйн, ёс зүйн олон талт асуудлыг хамарсан цогц ойлголт юм. Түүнчлэн уг зэвсгийг буруу хэрэглэснээс үүдэлтэй сөрөг үр дагавар, эрсдэлийн асуудал нь түүнийг эрдэм шинжилгээний үндэслэлтэйгээр судлан шинжлэх шаардлагыг бий болгож байна.

Иймээс энэхүү ажлын хүрээнд орчин үеийн үхэлд үл хүргэх зэвсгийн онолын үндэс, хэрэглээний онцлог, хөгжлийн чиг хандлагыг задлан шинжилж, түүний ач холбогдол, давуу болон сул талыг тодорхойлон авч үзэхийг зорилоо.

ҮНДСЭН ХЭСЭГ

1. ҮХЭЛД ҮЛ ХҮРГЭХ ЗЭВСГИЙГ ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН БОЛОН ЁС ЗҮЙН ҮНДЭС

Үхэлд үл хүргэх зэвсгийг ашиглах нь зөвхөн техникийн асуудал биш бөгөөд **хууль эрх зүйн зохицуулалт, хүний эрх, ёс зүйн зарчимтай салшгүй холбоотой** цогц ойлголт юм. Ийм төрлийн зэвсгийг хэрэглэхдээ төрийн алба хаагчид болон эрх бүхий байгууллагууд нь олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн ажиллах шаардлагатай. (Улаанбаатар., 2017)

Үхэлд үл хүргэх зэвсгийн хэрэглээний гол зорилго нь хүч хэрэглэх түвшинг бууруулах боловч түүнийг буруу, хэтрүүлэн ашиглавал хүний эрхийг зөрчих, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй байдаг. Иймээс дараах үндсэн эрх зүйн болон ёс зүйн зарчмуудыг баримталдаг.

Үхэлд үл хүргэх зэвсэг хэрэглэх үндсэн зарчмуудын харьцуулалт

Зарчмууд	Гол утга	Хэрэглээний шаардлага	Зорилго	Зөрчвөл гарах үр дагавар
Хууль ёсны байх	Зөвхөн хуульд заасан эрх бүхий байгууллага ашиглана	Хууль, дүрэм, тушаалд нийцсэн байх	Хүч хэрэглэх ажиллагааг эрх зүйн хүрээнд байлгах	Хууль бус хэрэглээ, хариуцлага хүлээлгэх
Зайлшгүй шаардлагатай байх	Өөр арга боломжгүй үед л ашиглана	Эхлээд зөөлөн арга хэрэглэсэн байх	Хүч хэрэглэхийг хамгийн бага түвшинд байлгах	Шаардлагагүй хүч хэрэглэсэнд тооцогдоно
Пропорциональ зарчим	Хүч нь аюулын түвшинтэй тэнцүү байх	Аюулын хэмжээг зөв үнэлэх	Хэт хүч хэрэглэхээс сэргийлэх	Хүний эрх зөрчих, хэт хүч хэрэглэх
Хүний эрхийг дээдлэх	Хүний амь нас, нэр төрийг хамгаалах	Хүний эрхийн хуулийг мөрдөх	Хохирлыг хамгийн бага байлгах	Эрүүдэн шүүх, эрх зөрчих эрсдэл
Ёс зүйн шаардлага	Мэргэжлийн ухамсар, хариуцлагатай хэрэглээ	Сургалт, ёс зүйн дүрэм мөрдөх	Хүнлэг, зөв хэрэглээг хангах	Мэргэжлийн нэр хүнд унах, буруу хэрэглээ

1.1.Хууль ёсны байх зарчим

Үхэлд үл хүргэх зэвсгийг зөвхөн **хуульд заасан эрх бүхий субъект** ашиглах ёстой. Энэ нь:

Тухайн улсын хууль тогтоомжид нийцсэн байх

Зөвшөөрөгдсөн нөхцөл байдалд ашиглагдах

Эрх бүхий байгууллага (цагдаа, тусгай алба гэх мэт) хэрэглэх гэсэн шаардлагыг агуулдаг.

Хууль ёсны зарчим нь аливаа хүч хэрэглэх ажиллагааг дур зоргоор бус, эрх зүйн үндэслэлтэй байлгах гол баталгаа болдог.

1.2. Зайлшгүй шаардлагатай байх зарчим

Энэ зарчим нь үхэлд үл хүргэх зэвсгийг зөвхөн **өөр арга хэрэгсэл хангалттүй үед** ашиглахыг хэлнэ. Үүнд:

- Зөвхөн нөхцөл байдал шаардсан үед хэрэглэх
- Илүү зөөлөн арга байвал эхлээд түүнийг ашиглах
- Хүч хэрэглэхээс зайлсхийх боломжийг эрэлхийлэх

Өөрөөр хэлбэл, үхэлд үл хүргэх зэвсэг нь “анхны сонголт” биш, харин “шаардлагатай тохиолдлын арга хэмжээ” юм.

1.3. Хэмжээ хэтрүүлэхгүй байх (пропорциональ зарчим)

Пропорциональ зарчим нь хэрэглэж буй хүч нь тухайн нөхцөл байдалд **тохирсон, тэнцвэртэй байх ёстой** гэсэн утгатай.

- Аюулын түвшинтэй харьцуулан хүч хэрэглэх
- Хэт их хүч хэрэглэхээс зайлсхийх
- Хамгийн бага хор нөлөөтэй аргыг сонгох

Жишээлбэл, бага эсэргүүцэлтэй нөхцөлд өндөр эрсдэлтэй хэрэгсэл ашиглах нь энэ зарчмыг зөрчсөнд тооцогдоно.

1.4. Хүний эрхийг дээдлэх зарчим

Үхэлд үл хүргэх зэвсгийн хэрэглээ нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчимд тулгуурлана.

- Амьд явах эрхийг хамгаалах
- Хүний нэр төр, бие махбодын халдашгүй байдлыг хүндэтгэх
- Хэт хүч хэрэглэж эрүүдэн шүүх шинжтэй үйлдлээс зайлсхийх

Энэ зарчим нь олон улсын хүний эрхийн суурь баримт бичгүүдтэй нийцдэг.

1.5. Ёс зүйн шаардлага

Хууль эрх зүйн зохицуулалтаас гадна ёс зүйн хариуцлага маш чухал байр суурь эзэлдэг.

- Хүний эсрэг хүч хэрэглэхдээ энэрэнгүй хандах
- Шаардлагагүй хохирол учруулахгүй байх
- Мэргэжлийн ёс зүйг баримтлах
- Хариуцлагатай, хяналттай хэрэглээг хангах
- Ёс зүйн зарчим нь хуульд заасан заалтаас гадна хүний ухамсар, мэргэжлийн соёлтой шууд холбоотой.

2.Үхэлд үл хүргэх зэвсгийн мөн чанар

Үхэлд үл хүргэх зэвсгийн мөн чанарыг дараах үндсэн шинжүүдээр тодорхойлж болно:

2.1.Түр хугацааны нөлөөлөл үзүүлэх шинж:

Энэ төрлийн зэвсэг нь байг байнгын гэмтэл учруулах бус, харин тодорхой хугацаанд хөдөлгөөний чадвар, эсэргүүцлийн боломжийг бууруулах зорилготой.

Жишээлбэл, нулимс асгаруулагч хий нь хүний хараа, амьсгалын системд түр хугацааны нөлөө үзүүлж, эсэргүүцлийг сулруулдаг.

2.2.Амь насанд шууд аюул учруулахгүй байх зарчим:

Үхэлд үл хүргэх зэвсэг нь ерөнхийдөө хүний амь насанд шууд хохирол учруулахгүйгээр зохион бүтээгдсэн байдаг. Гэвч энэ нь “аюулгүй” гэсэн үг биш бөгөөд хэрэглээний буруу арга, тохиромжгүй нөхцөл нь ноцтой гэмтэл, зарим тохиолдолд үхлийн эрсдэл үүсгэж болзошгүй.

2.3.Нөхцөл байдлыг хурцатгахгүйгээр зохицуулах зорилго

Энэхүү зэвсгийн үндсэн зорилго нь хүч хэрэглэлийг багасгах замаар зөрчил мөргөлдөөнийг улам хурцатгахгүйгээр хяналтад авахад оршино. Иймээс олон нийтийн эмх замбараагүй байдал, баривчилгаа, хамгаалалтын ажиллагаанд өргөн хэрэглэгддэг.

2.4.Хүний эрх ба хууль зүйн зарчимд нийцэх байдал

Орчин үеийн олон улсын эрх зүйн хандлагаар үхэлд үл хүргэх зэвсгийн хэрэглээ нь хүний эрхийг хүндэтгэх, хүч хэрэглэхийг хамгийн бага түвшинд байлгах зарчимд суурилдаг. Үүнд пропорциональ байдал, зайлшгүй шаардлагын зарчим зэрэг үндсэн хууль зүйн шалгуур хамаарна.

Харьцангуй ойлголтын асуудал

“Үхэлд үл хүргэх” гэх нэршил нь шинжлэх ухааны хувьд **туйлын биш, харьцангуй ойлголт** юм. Учир нь:

- Хэрэглээний нөхцөл (зай, хүч, орчин)-өөс хамааран нөлөөлөл өөрчлөгдөнө
- Зарим хэрэгсэл (жишээ нь резинэн сум) нь буруу хэрэглэвэл амь насанд аюултай байж болно
- Хүний биеийн онцлог, эрүүл мэндийн байдал нөлөөллийн үр дүнд ихээхэн нөлөөлдөг

Иймээс үхэлд үл хүргэх зэвсгийг “аюулгүй зэвсэг” гэж бүрэн тодорхойлох боломжгүй бөгөөд зөвхөн **илүү бага эрсдэлтэй хүч хэрэглэх хэрэгсэл** гэж үзэх нь оновчтой. (Цагдаагийн ерөнхий газар. Хүч хэрэглэх, 2017)

3.Үхэлд үл хүргэх зэвсгийн ангилал

Орчин үеийн аюулгүй байдлын орчинд үхэлд үл хүргэх зэвсгийг хүний бие махбод, мэдрэхүй, мэдрэлийн систем болон орчны нөхцөлд үзүүлэх нөлөөллийн шинж чанараар нь ангилдаг. Энэхүү ангилал нь тухайн хэрэгслийн үйлчлэх механизм, хэрэглээний зорилго, мөн тактикийн хэрэглээнд тохируулан системчилсэн байдлаар боловсруулагдсан байдаг.

Үхэлд үл хүргэх зэвсгийн ангилал нь үндсэндээ дөрвөн том бүлэгт хуваагдана: механик, химийн, цахилгаан болон дуу, гэрлийн нөлөөллийн хэрэгсэл.

3.1. Механик нөлөөллийн хэрэгсэл

Механик нөлөөллийн хэрэгсэл нь хүний бие махбодод **шууд физик хүчний нөлөөлөл** үзүүлж, өвдөлт үүсгэх эсвэл хөдөлгөөнийг хязгаарлах зорилготой зэвсгийн төрөл юм. Энэ ангилал нь хамгийн эртний бөгөөд практик хэрэглээ өндөртэйд тооцогддог.

Эдгээр хэрэгслийн үйлчлэх зарчим нь кинетик энерги буюу хөдөлгөөний энергийг хүний биед дамжуулснаар түр хугацааны саатал үүсгэхэд оршино. Жишээлбэл, резинэн сум нь цохилтын хүчээр булчин, зөөлөн эдэд нөлөөлж, хөдөлгөөнийг сааруулдаг бол усны их буу нь өндөр даралтын усны урсгалаар хүнийг тэнцвэр алдагдуулах байдлаар нөлөөлдөг.

Механик хэрэгслийн гол давуу тал нь химийн болон байнгын хор нөлөө багатай боловч буруу хэрэглэвэл яс хугарах, дотоод гэмтэл үүсгэх эрсдэлтэй.

3.2.Химийн нөлөөллийн хэрэгсэл

Химийн нөлөөллийн хэрэгсэл нь хүний **амьсгалын систем, нүд, салст бүрхэвч** дээр түр хугацааны цочрол үүсгэх зорилготой бодисуудыг ашигладаг.

Эдгээр бодисууд нь ихэвчлэн уур, аэрозол хэлбэрээр тархаж, хүний физиологийн хамгаалах рефлексийг өдөөдөг. Үүний үр дүнд нүд хорсох, нулимс ихээр гоожих, амьсгал давчдах, чиг баримжаа алдагдах зэрэг шинж тэмдэг илэрнэ.

Химийн хэрэгслийн онцлог нь:

- Богино хугацаанд өргөн талбайд нөлөөлөх боломжтой
- Шууд механик гэмтэл үүсгэдэггүй
- Гэвч амьсгалын замын өвчтэй хүмүүст илүү өндөр эрсдэлтэй

Иймэ төрлийн хэрэгсэл нь олон нийтийн эмх замбараагүй байдлыг тараахад хамгийн түгээмэл ашиглагддаг.

3.3.Цахилгаан нөлөөллийн хэрэгсэл

Цахилгаан нөлөөллийн хэрэгсэл нь хүний мэдрэлийн системд **цахилгаан импульс дамжуулж булчингийн түр саажилт үүсгэх** зарчимд тулгуурладаг.

Энэ төрлийн зэвсэг нь мэдрэлийн дохиоллын дамжуулалтыг түр хугацаанд тасалдуулснаар хүний хөдөлгөөний чадварыг хязгаарладаг. Ингэснээр зорилтот этгээдийг гэмтэл багатайгаар саармагжуулах боломжтой болдог.

Цахилгаан хэрэгслийн онцлог:

- Түр хугацааны бүрэн хяналт алдалт үүсгэнэ
- Нарийвчлал өндөртэй
- Алсын болон ойрын хэрэглээний хувилбартай гэсэн хэдий ч зүрх судасны эмгэгтэй

хүн, өндөр настанд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй тул хэрэглээ нь хатуу хяналт шаарддаг.

3.4.Дуу, гэрлийн нөлөөллийн хэрэгсэл

Энэ ангиллын зэвсэг нь хүний **мэдрэхүйн систем (хараа, сонсгол, чиг баримжаа)**-д гэнэтийн хүчтэй өдөөлт өгч, түр хугацаанд хяналт алдагдуулах зорилготой.

Дуу, гэрлийн зэвсэг нь шууд физик гэмтэл бага үүсгэдэг ч мэдрэхүйн системд хүчтэй стресс үүсгэж, хүний орон зайн ойлголт, хариу үйлдлийг саатуулдаг.

Онцлог нь:

- Богино хугацааны хүчтэй нөлөөтэй
- Шууд биед гэмтэл багатай
- Тактикийн ажиллагаанд өндөр ач холбогдолтой

Гэвч ойрын зайд ашиглахад сонсгол, хараанд түр болон урт хугацааны сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.

4.МЕХАНИК НӨЛӨӨЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

Механик нөлөөллийн хэрэгсэл нь хүний бие махбодод **шууд физик хүч (кинетик энерги)**-ийн нөлөөлөл үзүүлж, өвдөлт үүсгэх, хөдөлгөөнийг саармагжуулах, эсэргүүцлийг бууруулах зорилготой үхэлд үл хүргэх зэвсгийн нэг ангилал юм. Эдгээр нь ихэвчлэн цагдаа, цэргийн тактикийн ажиллагаанд ашиглагддаг. (Цагдаагийн тактик, 1994)

4.1.РЕЗИНЭН СУМ

Резинэн сум нь галт зэвсэгт суурилсан боловч металл бус, уян хатан материал (резин эсвэл резинэн бүрхүүлтэй) ашиглан үйлдвэрлэсэн тусгай төрлийн сум юм.

Үйлчлэх зарчим

Резинэн сум нь галт зэвсгээс гарах өндөр хурдтай кинетик энергиэр хүний биед хүрч, цохилтын нөлөөллөөр өвдөлт болон түр саатал үүсгэдэг.

Зорилго

- Эсэргүүцэл үзүүлж буй этгээдийг түр хугацаанд саармагжуулах
- Олон нийтийн эмх замбараагүй байдлыг хяналтанд авах
- Шууд амь нас хөнөөхгүйгээр зайнаас нөлөөлөх

Нөлөөлөл

- Булчин, зөөлөн эдэд хүчтэй өвдөлт үүсгэнэ
- Хөхрөлт, зөөлөн эдийн гэмтэл бий болгоно
- Нүд, толгой зэрэг эмзэг хэсэгт тусвал хүнд гэмтэл учруулж болзошгүй

Онцлог

- Алсын зайнаас хэрэглэгддэг
- Үр нөлөө хурдан илэрдэг
- Хяналттай хэрэглээ шаарддаг

4.2. УСНЫ ИХ БУУ

Усны их буу нь өндөр даралттай усны урсгалыг ашиглан хүний хөдөлгөөн, тэнцвэрт байдалд нөлөөлөх зориулалттай механик хэрэгсэл юм.

Үйлчлэх зарчим

Өндөр даралттай усны урсгал хүний биеийг түлхэж, тэнцвэр алдагдуулах, унагах замаар олон нийтийг тараах нөлөө үзүүлдэг.

Зорилго

- Жагсаал, эмх замбараагүй байдлыг тараах
- Олон хүний хөдөлгөөнийг хянах
- Шууд бие махбодын гэмтэлгүйгээр нөлөөлөх

Нөлөөлөл

- Тэнцвэр алдагдах, унах
- Нүд, нүүр хэсэгт усны даралтаас үүдэлтэй өвдөлт
- Хүйтэн нөхцөлд гипотерми үүсэх эрсдэлтэй

Онцлог

- Шууд цохилтын гэмтэл бага
- Өргөн талбайд нэгэн зэрэг нөлөөлнө
- Хяналттай зайнаас ашиглагддаг

4.3. ЦОХИЛТЫН ХЭРЭГСЭЛ

Цохилтын хэрэгсэлд батон, саваа, резинэн бороохой зэрэг ойрын зайд ашиглагддаг механик зэвсгүүд хамаарна.

Үйлчлэх зарчим

Хүний биеийн тодорхой хэсэгт шууд цохилт өгч өвдөлтийн мэдрэмж үүсгэн, хөдөлгөөнийг хязгаарлана.

Зорилго

- Ойрын зайд эсэргүүцэл үзүүлж буй этгээдийг баривчлах
- Хяналтад авах ажиллагааг дэмжих
- Хүчний тэнцвэр тогтоох

Нөлөөлөл

- Булчинд хүчтэй өвдөлт үүсгэнэ
- Хөдөлгөөний хязгаарлалт бий болгоно

• Буруу хэрэглэвэл яс хугарах, ноцтой гэмтэл үүсч болно

Онцлог

• Ойрын зайд хэрэглэгддэг
• Хямд, хялбар бүтэцтэй
• Хэрэглээний ур чадвар өндөр шаарддаг

4.4.ХИМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

Химийн нөлөөллийн хэрэгсэл нь үхэлд үл хүргэх зэвсгийн нэг чухал ангилал бөгөөд хүний бие махбодод шууд механик гэмтэл учруулахгүйгээр **физиологийн болон мэдрэхүйн системд түр хугацааны хүчтэй цочрол** үүсгэх замаар үйлчилдэг. Энэ төрлийн хэрэгсэл нь голчлон амьсгалын систем, нүд, арьсны салст бүрхэвчид нөлөөлж, тухайн хүний чиг баримжаа, хөдөлгөөний чадварыг түр хугацаанд алдагдуулах зорилготой.

Химийн нөлөөллийн хэрэгслүүд нь ихэвчлэн **аэрозол, хий, уур, шингэн дусал** хэлбэрээр тархдаг бөгөөд орчинд хурдан тархах шинж чанартай тул богино хугацаанд өргөн талбайд нөлөөлөх боломжтой. Иймээс эдгээрийг ихэвчлэн олон нийтийн эмх замбараагүй байдал, эсэргүүцлийн үйл ажиллагаа, баривчлах ажиллагаанд ашигладаг.

Үйлчлэх механизм

Химийн нөлөөллийн хэрэгсэл нь хүний биед дараах үндсэн механизмаар нөлөөлдөг:

Мэдрэхүйн цочрол үүсгэх: Нүд, хамар, амны салст бүрхэвчийг хүчтэй цочрооно

Амьсгалын замын түр саатал: Ханиалгах, амьсгал давчдах мэдрэмж төрүүлнэ

Рефлексийн хариу үйлдэл идэвхжүүлэх: Нулимс гоожих, найтаах, нүдээ аних зэрэг хамгаалах урвал үүсгэнэ

Чиг баримжаа алдагдуулах: Түр хугацаанд орчныг ойлгох, хөдөлгөөн хийх чадвар буурна

Онцлог шинж чанар

- Химийн нөлөөллийн хэрэгслүүд нь дараах онцлогтой:
- Шууд механик гэмтэл үүсгэдэггүй
- Богино хугацаанд хурдан нөлөөлнө
- Өргөн талбайд нэгэн зэрэг үйлчлэх боломжтой
- Салхи, орчны нөхцөлөөс ихээхэн хамааралтай
- Нөлөөлөл нь түр хугацааны (ихэвчлэн хэдэн минут–хэдэн цаг) байдаг

Ач холбогдол ба хэрэглээ

- Эдгээр хэрэгслийг голчлон дараах нөхцөлд ашигладаг:
- Олон нийтийн эмх замбараагүй байдлыг тараах
- Эсэргүүцэл үзүүлж буй бүлгийг саармагжуулах
- Хяналт алдагдсан нөхцөл байдлыг тогтворжуулах
- Цагдаагийн болон тактикийн ажиллагаанд зайнаас нөлөөлөх

Эрсдэл ба сөрөг нөлөө

- Хэдийгээр “үхэлд үл хүргэх” гэж ангилдаг боловч химийн нөлөөллийн хэрэгсэл нь дараах эрсдэлтэй байж болно:
- Амьсгалын замын өвчтэй хүмүүст хүндрэл үүсгэх
- Хүүхэд, өндөр настанд илүү хүчтэй нөлөөлөх
- Хэт их тун эсвэл буруу хэрэглээ нь арьс, нүдэнд гэмтэл үүсгэх
- Хаалттай орчинд хуримтлагдвал эрүүл мэндийн эрсдэл нэмэгдэх

4.5. НУЛИМС АСГАРУУЛАГЧ ХИЙ

Нулимс асгаруулагч хий нь олон нийтийн эмх замбараагүй байдал, жагсаал, эсэргүүцлийн үед хамгийн түгээмэл ашиглагддаг химийн нөлөөллийн хэрэгсэл юм. Ихэвчлэн CS (chlorobenzylidene malononitrile) болон CN төрлийн химийн нэгдлүүд дээр суурилдаг.

Үйлчлэх зарчим

Энэхүү хий нь хүний нүд, хамар, амьсгалын замын салст бүрхэвчийг цочроож, хамгаалах рефлекс (нулимс гоожих, ханиах, амьсгал давчдах)-ийг идэвхжүүлдэг. Үүний улмаас тухайн хүн түр хугацаанд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болдог.

Зорилго

- Олон нийтийг тараах
- Эсэргүүцлийг сулруулах
- Нөхцөл байдлыг хяналтад авах

Нөлөөлөл

- Нүд хүчтэй хорсох, нулимс ихээр гоожих
- Амьсгал давчдах, ханиах
- Чиг баримжаа түр алдагдах
- Арьс болон салстад хорсох мэдрэмж

Онцлог

- Өргөн талбайд хурдан тархдаг
- Түр хугацааны нөлөөтэй (ихэвчлэн 30 минутаас хэдэн цаг)
- Салхины чиглэлээс ихээхэн хамаарна
- Хэт их тун, буруу хэрэглээ нь эрүүл мэндэд эрсдэлтэй

4.6. ПЕРЕЦИЙН ШҮРШИГЧ

Перецийн шүршигч нь байгалийн гаралтай **капсаицин** бодис дээр суурилсан, хувь хүн өөрийгөө хамгаалах зориулалттай химийн хэрэгсэл юм.

Үйлчлэх зарчим

Капсаицин нь хүний нүд, хамар, арьсны мэдрэлийн төгсгөлд хүчтэй цочрол үүсгэж, өвдөлтийн дохио дамжуулалтыг идэвхжүүлдэг. Үүний үр дүнд түр хугацааны хараа болон хөдөлгөөний саатал үүсдэг.

Зорилго

- Хувь хүний өөрийгөө хамгаалах
- Ойрын зайд халдлагаас сэргийлэх
- Түр хугацаанд халдагчийг саармагжуулах

Нөлөөлөл

- Нүд хүчтэй хорсох, түр сохрох мэдрэмж
- Амьсгал давчдах, ханиалгах
- Арьс түлэгдэх мэт хорсох мэдрэмж
- Паник буюу сандрал үүсэх

Онцлог

- Ойрын зайд өндөр үр дүнтэй
- Ашиглахад хялбар, зөөвөрлөхөд тохиромжтой
- Салхины нөлөөнд өртөмтгий (буцаад хэрэглэгчид нөлөөлөх эрсдэлтэй)
- Хууль эрх зүйн зохицуулалт улс бүрт өөр

4.7. ЦАХИЛГААН САРМАГЖУУЛАГЧ (TASER)

Цахилгаан саармагжуулагч нь хүний биеийн мэдрэлийн системд өндөр хүчдэлийн, бага гүйдлийн цахилгаан импульс дамжуулж, булчингийн хяналтыг түр хугацаанд алдагдуулах зарчмаар ажилладаг тусгай төхөөрөмж юм.

Үйлчлэх зарчим

Taser нь хоёр жижиг электрод сум хэлбэрээр зорилтот этгээд рүү харвагдаж, биеийн арьсанд наалдана. Үүний дараа төхөөрөмжөөс цахилгаан импульс дамжиж, мэдрэлийн дохиоллын хэвийн ажиллагааг түр хугацаанд тасалдуулснаар булчингууд хяналтгүй агшиж, хөдөлгөөн зогсдог.

Зорилго

- Сэжигтнийг гэмтэл багатайгаар саармагжуулах
- Ойрын болон дунд зайд эсэргүүцлийг зогсоох
- Баривчлах ажиллагааг хөнгөвчлөх
- Шууд хүч хэрэглээг багасгах

Нөлөөлөл

- Булчингийн түр саажилт
- Хөдөлгөөний бүрэн хяналт алдагдах
- Богино хугацааны тэнцвэргүй байдал
- Сэтгэлзүйн цочрол (айдас, стресс)

Онцлог

- Алсын зайнаас ашиглах боломжтой (ихэвчлэн 3–7 метр)
- Түр хугацааны нөлөөтэй (секундээс хэдэн минут)
- Зорилтот нөлөөлөл өндөртэй
- Шууд амь нас хөнөөхгүй гэж үздэг боловч эрсдэлтэй

Эрсдэл ба хязгаарлалт

- Зүрх судасны өвчтэй хүнд аюултай байж болзошгүй
- Толгой, цээжний ойролцоо хэрэглэвэл хүндрэл үүсэх эрсдэлтэй
- Давтан хэрэглээ нь бие махбодод сөрөг нөлөө үзүүлж болно
- Хатуу мэргэжлийн хяналт шаарддаг.

5. ДУУ, ГЭРЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

Дуу, гэрлийн нөлөөллийн хэрэгсэл нь хүний **мэдрэхүйн систем (сонсгол, хараа, чиг баримжаа)**-д гэнэтийн хүчтэй өдөөлт өгч, түр хугацаанд хяналт алдагдуулах, анхаарал сарниулах, эсэргүүцлийг сулруулах зорилготой үхэлд үл хүргэх зэвсгийн нэг ангилал юм. Энэ төрлийн хэрэгсэл нь шууд бие махбодод механик гэмтэл бага учруулдаг боловч мэдрэхүйн системд хүчтэй стресс үүсгэдэг онцлогтой.

5.1. ДУУ-ГАРЫН ГРАНАТ (FLASHBANG)

Дуу-гарын гранат нь нэгэн зэрэг маш хүчтэй **дуу чимээ болон гялбаа (гэрэл)** үүсгэдэг тусгай зориулалтын төхөөрөмж юм. Ихэвчлэн тактикийн ажиллагаа, баривчлах ажиллагаанд ашиглагддаг.

Үйлчлэх зарчим

Гранат дэлбэрэх үед хэдэн зуун децибелийн хүчтэй дуу болон нүд гялбам хүчтэй гэрэл үүсдэг. Энэ нь хүний сонсгол, харааны түр ажиллагааг алдагдуулж, тархины чиг баримжааны боловсруулалтыг түр хугацаанд “саатуулдаг”.

Зорилго

- Тактикийн ажиллагаанд сэжигтнийг саармагжуулах
- Өрөөнд нэвтрэх (room clearing) үед давуу байдал бий болгох
- Эсэргүүцэл үзүүлэх боломжийг бууруулах
- Богино хугацаанд хяналт тогтоох

Нөлөөлөл

- Түр хугацаанд сохрох (гэрлийн нөлөөнөөс)
- Сонсгол түр алдагдах, чих шуугих
- Чиг баримжаа алдагдах

- Айдас, сандрал үүсэх
- Реакц удаашрах

Онцлог

- Хэт богино хугацаанд маш хүчтэй нөлөө үзүүлдэг
- Шууд механик гэмтэл бага
- Тактикийн өндөр ач холбогдолтой
- Ойрын орчинд аюултай хэрэглээтэй

Эрсдэл

- Хэт ойр хэрэглэвэл сонсгол, нүдэнд гэмтэл учруулж болзошгүй
- Хаалттай орчинд даралтын нөлөө ихсэж эрсдэл нэмэгдэнэ

5.2. ДУУНЫ ДОЛГИОНЫ ТӨХӨӨРӨМЖ

Дууны долгионы төхөөрөмж нь тодорхой давтамж, хүчтэй дууны долгион ашиглан хүний мэдрэхүй болон биеийн тэнцвэрт нөлөөлөх зориулалттай хэрэгсэл юм.

Үйлчлэх зарчим

Тус төхөөрөмж нь өндөр давтамж эсвэл хүчтэй дууны долгион ялгаруулж, хүний чихний хүлээн авах чадварыг хэт өдөөх эсвэл таагүй мэдрэмж үүсгэх замаар тухайн орчноос зайлуулах, хөдөлгөөнийг хязгаарлах нөлөө үзүүлдэг.

Зорилго

- Олон нийтийг тараах
- Тодорхой бүс рүү нэвтрэхийг хязгаарлах
- Эсэргүүцэл, ойртолтыг багасгах
- Хүч хэрэглэх түвшинг бууруулах

Нөлөөлөл

- Чих шуугих, толгой өвдөх
- Дотор муухайрах, стресс үүсэх
- Чиг баримжаа алдагдах
- Тодорхой давтамжид мэдрэмтгий хүмүүс илүү хүчтэй нөлөөлөл мэдрэх

Онцлог

- Шууд физик гэмтэл бага
- Өргөн талбайд нөлөөлөх боломжтой
- Орчноос (хана, зай, дуу шингээлт) их хамаарна
- Хяналттай хэрэглээ шаарддаг

Эрсдэл

Удаан хугацааны хүчтэй нөлөөлөл нь сонсголд сөргөөр нөлөөлөх боломжтой. Зарим хүмүүсийн физиологийн онцлогоос хамаарч хүчтэй таагүй нөлөө өгч болно. Эдгээр нь хүний бие махбод, мэдрэхүйд нөлөөлөх замаар эсэргүүцлийг түр хугацаанд зогсоох зорилготой.

6.ОРЧИН ҮЕИЙН ХЭРЭГЛЭЭ БА ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

6.1 Үхэлд үл хүргэх зэвсгийн орчин үеийн хэрэглээ

Орчин үед үхэлд үл хүргэх зэвсгийг дараах салбарт өргөн ашиглаж байна:

- Хууль сахиулах ажиллагаа
- Олон нийтийн эмх замбараагүй байдлыг хяналтад авах
- Терроризмын эсрэг ажиллагаа
- Хил хамгаалалт

Эдгээр нөхцөлд хүч хэрэглэхээс зайлсхийх, эсвэл хамгийн бага түвшинд барих зорилгоор ашигладаг. (Үндэсний батлан хамгаалах яам. (n.d.). Цэргийн ажиллагааны онол, 2016)

6.2 Хөгжлийн чиг хандлага

Сүүлийн жилүүдэд үхэлд үл хүргэх зэвсгийн хөгжил дараах чиглэлд явагдаж байна:

- **Нарийвчлал сайжрах** – зорилтот этгээдэд чиглэсэн нөлөөлөл
- **Технологижих** – электроник, автоматжуулалт нэмэгдэх
- **Аюулгүй байдал нэмэгдэх** – хүний биед үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах
- **Олон төрлийн хосолсон нөлөө** – нэг төхөөрөмж олон үйлдэлтэй болох

Жишээлбэл, орчин үеийн цахилгаан саармагжуулагч, дууны долгионы төхөөрөмжүүд илүү үр дүнтэй, хяналттай болж байна.

6.3 Давуу болон сул талын шинжилгээ

Давуу тал:

- Амь нас хохироох эрсдэл багатай
- Хүч хэрэглэх түвшнийг бууруулдаг
- Олон нийтийн хяналтыг илүү уян хатан хэрэгжүүлдэг

Сул тал:

- Буруу хэрэглэвэл ноцтой гэмтэл учруулж болзошгүй
- Зарим нөхцөлд үр дүн багатай
- Хүний эрхийн зөрчил үүсгэх эрсдэлтэй

7.ОЛОН УЛСЫН ХЭРЭГЛЭЭ БА ХАРЬЦУУЛАЛТ

7.1. Олон улсын нийтлэг хандлага

Орчин үед үхэлд үл хүргэх зэвсгийг дэлхийн ихэнх улс орнууд **хууль сахиулах байгууллагын үндсэн хэрэгсэл** болгон ашиглаж байна. Энэ нь ялангуяа 1990-ээд оноос хойш эрчимжсэн бөгөөд хүч хэрэглэхийг багасгах олон улсын бодлоготой холбоотой юм.

- АНУ, Европ → Хүний эрхэд суурилсан хэрэглээ
- Ази, Ойрх Дорнод → Олон нийтийн хяналтад илүү өргөн ашиглалт
- Африк, Латин Америк → Экспортын зэвсэг их хэрэглэгддэг

Мөн дэлхийн зах зээл 2025 онд ~9.5 тэрбум доллар байсан бол 2034 он гэхэд 15.3 тэрбумд хүрэх төлөвтэй байгаа нь хэрэглээ нэмэгдэж байгааг харуулж байна.

Улс орнуудын хэрэглээний харьцуулалт

Улс / Бүс нутаг	Гол хэрэглээ	Түгээмэл хэрэгсэл	Онцлог	Эрсдэлийн асуудал
АНУ	Жагсаал, баривчилгаа	Taser, pepper spray, rubber bullet	Технологи өндөр	Хэт хэрэглээний шүүмжлэл
Европ (Герман, Франц)	Олон нийтийн хяналт	Tear gas, water cannon	Хууль, стандарт өндөр	Хязгаарлалт хатуу
Хятад	Дотоод аюулгүй байдал	Дууны төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл	Хяналт өндөр	Ил тод байдал бага
Ойрх Дорнод	Жагсаал дарах	Tear gas	Өргөн хэрэглээ	Хэт хэрэглээ, гэмтэл
Латин Америк (Бразил)	Олон нийтийн хяналт	Резин сум, хий	Экспорт давамгай	Гэмтэл их
Африк	Эмх замбараагүй байдал	Tear gas	Импортын хамаарал	Хяналт сул

(АНУ, Хятад, ОХУ-ын харьцуулсан шинжилгээ)

1.Америкийн Нэгдсэн Улс

Америкийн нэгдсэн улс нь үхэлд үл хүргэх зэвсгийг голчлон олон нийтийн эмх замбараагүй байдал, баривчилгаа болон цагдаагийн ажиллагаанд ашигладаг.

Онцлог:

- Хамгийн өргөн хэрэглээтэй улс
- Цахилгаан саармагжуулагч, резинэн сум, нулимс асгаруулагчийг өргөн ашигладаг
- Олон нийтийн жагсаалын үеэр ихэвчлэн хэрэглэгддэг

Давуу тал:

- Технологийн түвшин өндөр
- Хүч хэрэглэх түвшинг бууруулах бодлого хөгжсөн

Сул тал:

- Буруу хэрэглээний улмаас гэмтэл, хүний эрхийн маргаан их
- Хяналтын асуудал шүүмжлэл дагуулдаг

2.Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Хятад ард улс нь үхэлд үл хүргэх зэвсгийг голчлон дотоод аюулгүй байдал, олон нийтийн хяналтад ашигладаг.

Онцлог:

- Төрийн хатуу хяналттай хэрэглээ
- Дууны төхөөрөмж, цахилгаан болон хяналтын системтэй уялдсан хэрэглээ
- Мэдээллийн ил тод байдал хязгаарлагдмал

Давуу тал:

- Төвлөрсөн удирдлагатай тул үр ашиг өндөр
- Хяналтын системтэй хослон ашиглагддаг

Сул тал:

- Хүний эрхийн асуудал ихээр шүүмжлэгддэг
- Олон улсын ил тод байдал сул

3. Оросын Холбооны Улс

Оросын холбооны улс нь үхэлд үл хүргэх зэвсгийг цагдаа болон цэргийн ажиллагаанд өргөн ашигладаг.

Онцлог:

- Жагсаал, олон нийтийн хяналтад их ашигладаг
- Нулимс асгаруулагч, резинэн сум, дуу-гарын төхөөрөмж түгээмэл
- Цэргийн болон дотоод аюулгүй байдлын аль алинд хэрэглэнэ

Давуу тал:

- Хатуу хяналтын тогтолцоотой
- Түргэн шийдвэр гаргах чадвартай

Сул тал:

- Хэт хүч хэрэглэх эрсдэлтэй
- Хүний эрхийн маргаан байнга гардаг

ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

1. Улсуудын хэрэглээний түвшин

Улс	Хэрэглээний түвшин	Гол чиглэл
АНУ	Маш өндөр	Жагсаал, баривчилгаа
Хятад	Өндөр (хяналт төвтэй)	Дотоод аюулгүй байдал
ОХУ	Өндөр	Цагдаа, цэргийн ажиллагаа

2. Давуу ба сул талын харьцуулалт

Улс	Давуу тал	Сул тал
АНУ	Технологи өндөр, олон төрөл	Хэт хэрэглээ, хүний эрхийн маргаан
Хятад	Хяналт төвлөрсөн, үр ашигтай	Ил тод байдал сул
ОХУ	Хүчтэй хяналт, хурдан ажиллагаа	Хүний эрхийн асуудал

Олон улсын туршлагаас харахад үхэлд үл хүргэх зэвсэг нь орчин үеийн аюулгүй байдлын салбарт зайлшгүй хэрэгцээтэй боловч түүний хэрэглээ нь улс төр, эрх зүй, хүний эрхийн бодлогоос шууд хамаардаг байна. (9. “Үхэлд үл хүргэх зэвсэг, 2025)

ДҮГНЭЛТ

Энэхүү эрдэм шинжилгээний ажлаар орчин үеийн үхэлд үл хүргэх зэвсгийн ойлголт, ангилал, хэрэглээний онцлог, олон улсын харьцуулалт болон түүнийг хэрэглэх эрх зүй, ёс зүйн үндсийг цогцоор нь судалж, онолын болон практик түвшинд задлан шинжиллээ.

Юуны өмнө үхэлд үл хүргэх зэвсэг нь хүний амь насыг шууд хөнөөх зорилгогүй боловч хүний бие махбод, мэдрэхүй, мэдрэлийн системд түр хугацааны нөлөөлөл үзүүлж, эсэргүүцэл болон хөдөлгөөнийг саармагжуулах зорилготой тусгай зориулалтын хэрэгсэл болох нь тодорхойлогдож байна. Энэ нь орчин үеийн хууль сахиулах ажиллагаанд хүч хэрэглэх түвшнийг бууруулах, олон нийтийн аюулгүй байдлыг илүү хүнлэг аргаар хангах шаардлагаас үүдэн хөгжсөн байна.

Ажлын хүрээнд хийсэн ангиллын шинжилгээнээс харахад үхэлд үл хүргэх зэвсгийг механик, химийн, цахилгаан болон дуу, гэрлийн нөлөөллийн хэрэгслүүд гэж үндсэн дөрвөн бүлэгт хуваан үзэж болох бөгөөд эдгээр нь тус бүр өөр өөр физик болон биологийн механизмд тулгуурлан үйлчилдэг. Механик хэрэгслүүд нь кинетик энерги ашиглан бие махбодод шууд цохилтын нөлөө үзүүлдэг бол химийн хэрэгслүүд нь салст бүрхэвч, амьсгалын системд цочрол үүсгэдэг. Харин цахилгаан хэрэгсэл нь мэдрэлийн системийн үйл ажиллагааг түр хугацаанд тасалдуулж, дуу-гэрлийн хэрэгслүүд нь мэдрэхүйн системийг огцом өдөөн чиг баримжаа алдагдуулдаг.

Олон улсын харьцуулалтын хэсгээс үзэхэд АНУ, Хятад, ОХУ зэрэг улс орнууд үхэлд үл хүргэх зэвсгийг өөр өөр эрх зүйн тогтолцоо, аюулгүй байдлын бодлогын хүрээнд ашиглаж байна. АНУ-д технологийн хөгжил өндөр, хэрэглээ өргөн боловч хүний эрхийн маргаан дагалддаг бол Хятадад төвлөрсөн хяналт, дотоод аюулгүй байдлын зорилго давамгайлж байна. Харин ОХУ-д цэрэг, цагдаагийн ажиллагаанд өргөн ашиглагддаг ч хүч хэрэглэх эрсдэл харьцангуй өндөр байна. Энэ нь тухайн улсын улс төр, эрх зүй, хүний эрхийн хандлага үхэлд үл хүргэх зэвсгийн хэрэглээнд шууд нөлөөлдөг болохыг харуулж байна.

Эрх зүйн болон ёс зүйн үндсийн хувьд үхэлд үл хүргэх зэвсгийн хэрэглээ нь зөвхөн техникийн шийдэл бус, харин олон давхар хязгаарлалттай үйл ажиллагаа юм. Хууль ёсны байх, зайлшгүй шаардлагатай байх, пропорциональ зарчмыг баримтлах, хүний эрхийг дээдлэх болон ёс зүйн хариуцлагатай хэрэглээ нь уг зэвсгийг ашиглах үндсэн суурь нөхцөл болдог. Эдгээр зарчмууд зөрчигдвөл хүний эрхийн ноцтой зөрчил, хэт хүч хэрэглээ, хууль зүйн хариуцлага үүсэх эрсдэлтэй байна.

Дүгнэн үзэхэд үхэлд үл хүргэх зэвсэг нь орчин үеийн аюулгүй байдлын тогтолцоонд зайлшгүй чухал үүрэг гүйцэтгэж байгаа боловч “үхэлд үл хүргэх” гэсэн нэршил нь харьцангуй ойлголт бөгөөд буруу хэрэглээ, мэргэжлийн бус ажиллагаа нь

хүний эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах боломжтой. Иймээс түүнийг зөвхөн мэргэжлийн өндөр бэлтгэлтэй алба хаагчид, хууль эрх зүйн хатуу зохицуулалтын хүрээнд ашиглах шаардлагатай.

Цаашдын хөгжлийн чиг хандлага нь илүү нарийвчлалтай, хүний биед бага сөрөг нөлөөтэй, ухаалаг технологид суурилсан, хяналт сайтай систем рүү чиглэж байгаа бөгөөд энэ нь хүний эрхийг хамгаалах болон аюулгүй байдлыг хангах хоёр зорилтыг зэрэг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Эх сурвалжууд:

1. Монгол Улсын Их Хурал. (2017). *Цагдаагийн албаны тухай хууль*. Улаанбаатар.
2. Монгол Улсын Хилийн тухай хууль (2016) Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх
3. Монгол Улсын Их Хурал. (2015). *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль*. Улаанбаатар.
4. Хууль зүй, дотоод хэргийн яам. (n.d.). *Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, заавар*. Улаанбаатар.
5. Цагдаагийн ерөнхий газар. (n.d.). *Хүч хэрэглэх, тусгай хэрэгсэл ашиглах заавар*. Улаанбаатар.
6. Үндэсний батлан хамгаалахын их сургууль. (n.d.). *Аюулгүй байдал судлалын гарын авлага*. Улаанбаатар.
7. Дотоод хэргийн их сургууль. (n.d.). *Цагдаагийн тактик, тусгай хэрэгслийн хэрэглээ*. Улаанбаатар.
8. Үндэсний батлан хамгаалах яам. (n.d.). *Цэргийн ажиллагааны онол, практик*. Улаанбаатар.
9. “Үхэлд үл хүргэх зэвсэг, тусгай хэрэгслийн хөгжлийн чиг хандлага” Б.Мөнхсайхан, П.Даваажав Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Инновац, технологи дамжуулалтын төв “Үндэсний батлан хамгаалахын их сургууль”

МОНГОЛ УЛСЫН ГОЛЫН УСААР ХИЛЛЭДЭГ ХЭСЭГТ ГОЛЫН ЭРГИЙН НУРАЛТЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Ц.ЦЭВЭЭНРАВДАН*
Хилийн албаны сургуулийн Хилийн албаны тэнхимийн багш, Хил судлалын магистр, ахмад

*хариуцлагатай зохиогч: **tstseveenee5@gmail.com**

Хураангуй: Хилийн ус нь хоёр улсын ашиг сонирхолд үргэлж нөлөөлдөг тул хөрш орнууд хэлэлцээр, гэрээгээр дамжуулан болзошгүй асуудлуудыг харилцан шийдвэрлэж, зохицуулдаг. Хөрш орнуудтай Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч буй хилийн усыг хамтран хамгаалах эрх зүйн актын ач холбогдлыг онцлон тэмдэглэж, хилийн усыг цаашид хамгаалах, голын эргийн бэхлэлтийг сайжруулахтай холбоотой зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд анхаарлаа хандуулах болно.

Түлхүүр үгс: Хилийн шугам, гэрээ хэлэлцээр, хилийн ус, эргийн бэхлэлт г.м

ОРШИЛ

Улсын хил тогтоосон тухай баримт бичгүүд, хил тогтоох комиссын протокол, хилийн тэмдэг, хилийн шугамын явалтын тодорхойлолт, гэрээ байгуулсан газрын зураг, газар орны хэсэгчилсэн зураг, хилийн тэмдгийн загвар, хилийн дэглэмтэй холбоотой асуудлаар байгуулсан конвенц, хэлэлцээрүүд болон энэ талаар гаргасан нэг талын хууль эрх зүйн актууд мөн адил хамаарна.

Улсын хилийн дэглэмийн эрх зүйн үндсийг Улсын Их Хурал хуулиар тодорхойлж, Засгийн газар хил залгаа улстай байгуулсан олон улсын гэрээгээр тогтоодог билээ.

Аливаа хоёр улс хил дээр хилийн шугам, тэмдгийг хэвийн хэмжээнд байлгах, хилийн шугамын дагуух ойн огтолсон зурвасыг цэвэрлэх, гол нуурын эргийг бэхлэх, ус ашиглах, усан тээвэр хийх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шийдвэрлэх, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, мал амьтан бараа, материал нэвтрүүлэх, хил дамнасан зам гүүр, холбоо, цахилгаан шугамыг ашиглах, арчлан хамгаалах, цаг уурын бэрхшээлтэй үе, байгалийн гамшгийн үед харилцан туслалцах гэх мэт тухай бүрд нь шийдвэрлэвэл зохих олон төрлийн эрх зүйн харилцаа үүсдэг.

Монгол Улс хоёр хөрш улстайгаа хилийн дэглэмийн гэрээ байгуулснаар хилийн халдашгүй дархан, бүрэн бүтэн байдлыг хангах, хил орчмын нутаг дэвсгэрт ард иргэд амар амгалан, тайван аж төрөх, хилийн аливаа асуудлыг эрх зүй, дипломат арга хэрэгслээр, эв зүйгээр зохицуулах нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Улсын хилийн дэглэмийн агуулга нь улсын хилийг арчлан хамгаалах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, хилийн ус, хил дамнасан байгууламжийг ашиглах, хил дээр ан агнуур, ажил үйлдвэрлэл явуулах, байгаль орчин, ан амьтныг хамгаалах зэрэг журмаас бүрдэнэ.

“Хилийн гол, горхины урсгал өөрчлөгдөхөөс сэрэмжлэх зорилгоор хэлэлцэн тохирогч талуудын зохих албан тушаалтан нар эргийг бэхлэх шаардлагатай гэж тохиролцсон газарт бэхэлгээ хийж байна. Хилийн гол горхи руу ус оруулах тэдгээрээс ус татах явдлыг журамлах зэрэг хилийн усны дэглэмд хамаарах бусад бүх асуудлыг хэлэлцэн тохирогч талуудын зохих албан тушаалтан нар тохиролцож байна” гэж заасан байдаг нь усан хил хамгаалалтын олон улсын эрхзүйн үндэс болж байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол Улсын хилийн асуудлаар байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдэд хилийн усны талаар тодорхойлсон, тусгасан заалтууд: Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улстай байгуулсан олон улсын гэрээг үндэслэн найрсаар хамтран ажиллах үзэл санааны дагуу улсын хилийг хамтран хамгаалах, өнө мөнхөд тайван, найрсаг харилцааны хил байлгахын төлөө хүчин чармайлт гаргаж ажиллахаа илэрхийлэн хилийн дэглэмийн гэрээг анх ЗСБНХУ-тай 1980 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр "Монгол-Зөвлөлтийн улсын хилийн дэглэм, хилийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах" тухай, БНХАУ-тай 1988 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр "Монгол, Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ" гэсэн хилийн дэглэмийн гэрээ байгуулж байжээ.

Эдгээр улсын хилийн халдашгүй дархан байдалтай холбогдсон олон талт асуудлыг хил залгаа улсууд хэлэлцэн тохирч хилийн дэглэмийн гэрээ байгуулан хууль зүйн дагуу шийдвэрлэдэг. Иймд байнга анхаарах асуудлын нэг бол улсын хилийг тодорхой байлгах асуудал юм.

Улсын хилийг тодорхой байлгах гэдэг нь нэгэнт тогтоосон хилээ тогтмол арчлан хамгаалж, хилийн шугам, хилийн тэмдэг, тэдгээрийн холбоос, нэмэлт тэмдгийн байршлыг алдагдуулахгүй, хэнд ч мэдэгдэхүйц ойлгомжтой, ил тод, бүрэн бүтэн байлгахыг хэлнэ.

Хилийн усыг хамгаалах: Монгол Улсын усны тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар "Монгол Улсын хилийн шугамын дагуу буюу огтлон оршиж буй гадаргын ба газар доорх усыг хилийн ус гэнэ."[22] Улсын хилийн шугамаас дотогш орших хилийн ус нь Монгол Улсын усны нэгдмэл сангийн бүрдэл хэсэг байна.

Монгол Улсын хилийн шугамын урт 8252.6 км бөгөөд хуурай газраар 7351.6 км, усаар 901.058 км тус тус хиллэдэг. Үүнээс ОХУ-тай хуурай газар 2863 км, усаар 680 км, БНХАУ-тай хуурай газраар 4488 км, усаар 221 км хэсгээр хиллэдэг.

Хилийн ус нь нийт хилийн 10.9 хувийг эзэлдэг ба хилийн усны 96.6 хувийг голоор хиллэсэн хэсэг эзэлнэ. Улсын хилээр 89 гол мөрөн нэвтэрдгийн 60 нь орж, 29 нь гарч, 77 горхины 73 нь орж, 4 нь гарч байдаг ба хилийн шугам дээрх 3 булаг шанд орж урсаж байдаг.

Увс аймгийн Увс нуур, Дөрөө нуурын хойд хэсэг, Дорнод аймгийн Буйр нуур, Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ мөрөн зэрэг нь хилийн усанд томоохон байр суурь эзэлдэг. Буйр нуурын усан хил нь 30.7 км бөгөөд Монгол Улсын усан хилийн 3,4 хувь, БНХАУ-тай хиллэдэг хэсгийн 13,8 хувийг эзлэх бөгөөд Дорнод аймгийн Халх гол сумын нутаг, БНХАУ-ын Хөлөн буйр аймгийн Алтан эмээл сумын нутаг хилийн тодорхой дугаар тэмдгийн хооронд далайн түвшнээс дээш 581 метрт оршдог. Энэ нуурт Монголын нутгаас Халх гол цутгаж, Оршуун голоор Далай нууртай холбогдоно. Нуурын гүн ойролцоогоор 10.5 метр, эзлэхүүн 3734 сая шоо метр байна.[23] (Хил хамгаалах байгууллага, 2018, 354 дэх тал)

Хилийн шугам хүртэлх хилийн усанд тухайн улс өөрийн бүрэн эрхээ эдэлж байдаг. Гэхдээ хилийн ус нь ямагт хоёр талын ашиг сонирхлыг хөндөж байдаг учраас хил залгаа улсууд энэ талаар үүсэж болох асуудлыг гэрээ, хэлэлцээрээр харилцан тохиролцож зохицуулдаг.

[22] Усны тухай хууль (2012)-ийн 3 дугаар зүйл "..."

[23] Хил хамгаалах байгууллага, Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал,шийдвэрлэх арга зам. ОУЭШХ-ын эмхэтгэл, 2018, 354 дэх тал

Монгол Улсын Хилийн тухай хуульд зааснаар хилийн усыг хамгаалах, ашиглах, голдирлыг зориудаар өөрчлөхгүй байх асуудлыг усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон улсын хилийн хамгаалах байгууллага хамтран хэрэгжүүлж, хилийн усыг хамгаалах, ашиглах журмыг хууль тогтоомж, хил залгаа улстай хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу тогтооно.

Хилийн усыг хамгаалах, ашиглах асуудлыг хил залгаа улстай байгуулсан хилийн дэглэмийн гэрээ болон 1994 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр байгуулсан "Хилийн усыг хамгаалах болон ашиглах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр", 1995 оны 02 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан "Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн дагуу шийдвэрлэж байна.

Монгол Улс хил залгаа Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай байгуулсан хилийн дэглэмийн гэрээгээр хилийн усыг арчлан хамгаалах талаар дараах үүргийг хүлээдэг. Үүнд:

- Хилийн ус, түүний эргийн экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах, хөрсний идэгдэл, хүний буруутай үйл ажиллагаанаас үүдсэн бохирдол болон бусад тааламжгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг авна.
- Хилийн гол горхи, цутгалан, салаадын голдирлын байдлыг аль болох өөрчлөхгүйгээр хадгалах, хил болгосон усны урсгалыг боох, ус оруулах, зориуд ус татаж усны хэвийн түвшнийг алдагдуулах, боогдуулж болох саад тотгорыг арилгахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авч байх үүрэгтэй.
- Монгол-Оросын Улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээ (2007)-ний 11 дүгээр зүйлд зааснаар Хилийн гол, горхи, цутгалан болон салаадын голдирол байгалийн жам ёсоор буюу байгалийн үзэгдлийн нөлөөгөөр өөрчлөгдсөн тохиолдолд хамтран засаж, шаардлагатай гэж үзвэл эргийн бэхлэлт хийнэ.[24]

Бүгд Найрамдах Хятад Ард Улстай байгуулсан хилийн дэглэмийн гэрээгээр хил болгосон голын эргийг хамгаалах байгууламж барихдаа нөгөө талын голын эрэг, голдиролд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх үүрэгтэй бөгөөд байгууламжийг барихаас өмнө нөгөө талдаа мэдэгдэнэ.

Оросын Холбооны Улстай байгуулсан хилийн дэглэмийн гэрээгээр бэхэлж байгаа эргийг харьяалсан тал энэхүү ажлыг гүйцэтгэх бөгөөд холбогдох зардлыг хариуцна. Хил болгосон голын голдирол байгалийн шалтгааны улмаас ихээхэн өөрчлөгдвөл хоёр тал энэ талаар ямар арга хэмжээ авах тухайгаа харилцан зөвлөлдөх хүртэл хилийн шугам өөрчлөгдөхгүй хэвээр байна. Үер буюу цөнгөөр үүсэж болох аюулаас сэргийлэх зорилгоор хилийн усны түвшин, мөстөлтийн байдал зэрэг мэдээллийг цаг алдалгүй солилцож, үүсэх хохирлыг багасгах, хязгаарлах арга хэмжээ авна.

Хилийн усны нийт уртад шаардлагатай тохиолдолд хоёр эрэг нь аль нэг талын нутагт байрлах хэсэгт ч модон материалыг саадгүй урсгаж тээвэрлэх бөгөөд холбогдох байгууллага нь 10-аас доошгүй хоногийн өмнө бие биедээ мэдэгдэхээр Монгол, Оросын хилийн дэглэмийн гэрээнд тусгасан бөгөөд Бүгд Найрамдах Хятад Ард Улстай байгуулсан хилийн дэглэмийн гэрээнд энэ талаар зохицуулалт байхгүй байна.

[24] Монгол-Оросын Улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээ (2007)-ний 11 дүгээр зүйл "..."

Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай байгуулсан хилийн дэглэмийн гэрээнд хоёр талын иргэд хилийн усны өөрийн талд загасны аж ахуй эрхэлж болно. Энэ үед тэсэрч дэлбэрэх, хорт бодис, цахилгаан гүйдэл зэргийг ашиглаж загас, усны бусад амьтан агнахыг хориглоно. Талуудын эрх бүхий байгууллага дангаараа эсхүл хамтран хилийн усанд загас, усны бусад амьтан хууль бусаар агнахыг таслан зогсоох арга хэмжээ авч загасны нөөцийг зүй зохистойгоор ашиглах, хамгаалах, нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллана гэж заасан байна.

Хилийн гол, горхи, нуурын дээгүүр гүүр, далан, хашлага болон гидротехникийн бусад байгууламжийг барих, тэдгээрийг ашиглах, шинэчлэн төхөөрөмжлөх буюу буулгах ажлыг талуудын засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хийнэ. Хилийн гол дээр байгуулсан гидротехникийн төхөөрөмжийн хувьд улсын хилийн шугам хаагуур яаж явж байгаагаас үл хамааран уг төхөөрөмжийн тэнхлэгээр улсын хилийн шугам гарч буй гэж үзнэ.

Тухайлбал хилийн гол дээгүүр тавигдсан гүүрний хувьд голын голдирлоор явж буй хилийн шугамын байршлаас үл хамааран гүүрний тэг дундуур улсын хилийн шугам гарч байгаагаар тооцдог.

Улсын хил хамгаалалтад нөлөөлдөг олон хүчин зүйлсийн нэг нь физик-газар зүйн нөхцөл ба түүний элементүүд нь газрын гадаргуу, хөрс, ургамал, цаг агаар, ус зүй юм. Усан хилийн хэсгийг авч үзвэл физик-газар зүйн элементүүдээс ус зүй давамгайлдаг (Д.Чойбаатар,2017, 45 дахь тал).[25]

Олон жилийн хугацаанд гол мөрний усны урсгалын хурд өргөн, урт, гүн, ёроол, эргийн байдал зэрэг нь өөрчлөгдөж, голын голдиролд нөлөөлөхийг голын хэмнэл гэнэ.

Нуур болон бусад усан сангийн хэсэгт түүний хоёр эргийг холбосон шулуун шугамаар тогтооно. Голын эрэг нь үер уснаас болж элэгдэж өөрчлөгддөг учраас хилийн асуудлаар байгуулсан хоёр улсын хоорондох гэрээнд энэхүү голоор тогтоосон хилийн шугам нь өөрчлөгдөх эсвэл байгалийн нөлөөллөөс болж өөрчлөгдөж болох эсэхийг заасан зүйл, заалтуудыг нарийвчлан тусгаагүй байдаг.

Голоор тогтоосон улсын хилийн шугам нь ус үерлэх, цөн түрэх зэрэг болон байгалийн бусад шалтгаанаар голын эрэг эвдрэх, нурах зэргээс болж түүний урсгалын байдал, чиглэл, голдирол өөрчлөгдөж энэ нь хилийн шугамын байршил явалтад нөлөөлж болох үр дагавартай байдаг. Иймд улсууд хоорондоо энэ талын үүсэж болох асуудлыг урьдчилан тохиролцсон гэрээ, хэлэлцээрээр нарийвчлан тогтоож зохицуулах эрх зүйн акт хэрэгтэй байна.

Монгол-Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх гэрээнд:

“Хоёр тал хилийн усны урсгалыг аль болох хэвийн байлгавал зохино”

Монгол-Зөвлөлтийн хилийн дэглэм, хилийн асуудлаар хамтран ажиллах харилцан туслах тухай гэрээнд:

“Хилийн гол, горхины урсгалын байдал, чиглэлийг аль болох өөрчлөхгүй байлгах ёстой. Энэ зорилгоор хэлэлцэн тохирогч талууд хилийн усны урсгалыг өөрчилж болох ба түүний ердийн урсгалыг боогдуулж болох элдэв саадыг арилгахад шаардагдах арга хэмжээг хамтран авч байна. Хилийн гол горхины урсгалын байдал өөрийнхөө аясаар буюу байгалийн үзэгдлийн улмаас өөрчлөгдсөн тохиолдолд хэлэлцэн тохирогч талуудын зохих албан тушаалтан нар түүнийг хэвийн болгох шаардлагатай гэж үзвэл урсгалын байдлыг засах ажлыг хоёр тал адил үндсэн дээр оролцох замаар хамтран хийж болно.” Гэж заасан байна.

[25] Долгорын Чойбаатар, Усан хилийн хамгаалалт, (Улаанбаатар: 2017), 45 дахь тал.

Хилийн усны эргийн хамгаалалтын өнөөгийн байдал, хөрш улсуудын туршлага: Оросын Холбооны Улсын хил хамгаалалтын арга тактикт зарчмын томоохон өөрчлөлт гарч шинэ техник технологи, ялангуяа сансраас хянах төхөөрөмж, нисгэгчгүй нисэх хэрэгслийг өргөнөөр ашиглах болов. “Шугамын тасаг” нь хил хамгаалалтыг эрэл-тагнуул, эрэл-хайгуулын аргаар байнгын хөдөлгөөнт бүлгийн бүрэлдэхүүнээр үүрэг гүйцэтгүүлж өөрөөр хэлбэл, хил зөрчигчийг байнга эрж хайж, идэвхтэй үйл ажиллагаа явуулах болсоор багагүй хугацаа өнгөрч байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил хамгаалалтад ч өөрчлөлт гарсаар байна. Улсын хил хамгаалалтдаа инженер техникийн арга хэмжээ, шинэ техник технологийг эрчимтэй нэвтрүүлж байна.

Манай улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь 1989 онд Халх гол, Шарилжийн голын салаалах хэсэгт эргийн хамгаалалтын даланг барьсан. 2004-2007 оны хооронд БНХАУ нь голоор хиллэдэг хэсгийн тохойрсон хэсэгт эргийн нуралтаас хамгаалах даланг хийж, хилийн усаа хамгаалах, газар нутгийн бүрэн бүтэн байдлаа хангах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Монгол Улсын гол, нуураар хиллэдэг хэсгийн эргийн хамгаалалтад тэргүүн дэвшилтэт шинэ техник технологийг өргөнөөр ашиглах нь голын эргийн хамгаалалтын чанар, үр дүнг дээшлүүлэх, зөрчилгүй байлгах улмаар Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах чухал хүчин зүйл болох юм.

Усан хил хамгаалалтын асуудал төр засаг, яам, командлалын анхаарлын төвд байж, үйл ажиллагааг сайжруулах талаар арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа ч шинэ техник хэрэгслийг худалдан авахад төсөв хөрөнгийн шаардлага байсаар байна.

Монгол Улсын усан хил хамгаалалтыг сайжруулах чиглэлээр олон төсөл тооцоо боловсруулсан ч санхүүжилт, хөрөнгө оруулалт, төсвийн асуудлаас шалтгаалаад хэрэгжилт хангалтгүй байгаа билээ.

Усан хилийн голын эргийн хамгаалалтыг сайжруулах зарим асуудал:

Орчин үед шинжлэх ухаан техникийн дэвшлийн хурд маш өндөр түвшинд хүрч улс орнууд улсын хил хамгаалж байсан хуучин арга, ашиглаж байсан цаг үеэ өнгөрөөсөн техник хэрэгслүүдээс татгалзан орчин үеийн өндөр бүтээмжтэй, ашиглахад хялбар шинэ үеийн техник хэрэгслүүдэд илүү анхаарах болж ийм чиглэлээр шинжлэх ухаан техникийн ололтыг эрчимтэй нэвтрүүлж байна.

Хил хамгаалалтын тактикийг боловсронгуй болгох нь цаг үеийн бодит шаардлага, хил хамгаалалтын нийгмийн захиалга, хэрэгцээнээс урган гарч буй онцгой асуудал юм.

Улсын хил хамгаалалтын арга тактикийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх дорвитой, далайцтай арга хэмжээ авахгүй, шаардлагатай хөрөнгө төсвийг гаргуулж аваагүй зэргээс хил хамгаалалтыг боловсронгуй болгох, сайжруулах олон төсөл, хөтөлбөр цаасан дээрээ гацаж, эхлэл тодий байсаар өнөөг хүрсэн. Үүнд Монгол улсын усан хил хамгаалалтыг сайжруулах, боловсронгуй болгох асуудал багтаж байгаа юм.

Хилийн усыг тэмдэгжүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах, эргийн бэхлэлт, байгууламж барихад 3 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн тооцоог Хил хамгаалах байгууллагаас хийсэн байдаг. Зөвхөн усан хилийг тэмдэгжүүлэхэд 225.000.000 төгрөг шаардлагатай байна.

Буйр нуурын усан хил хамгаалалтыг бэхжүүлэх талаар 2009 онд хийгдсэн хөрөнгө оруулалт, 2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Булан дэрсний заставыг барихад 2,7 тэрбум төгрөг, Булан дэрс, Буйрын заставын усан хил хамгаалалтад шинэ техник технологи нэвтрүүлж, теле хяналтын системд шилжүүлэхэд 500 000 000 төгрөгийг тус тус зарцуулсан байна. Цаашид ч техникийн

шинэчлэл хийх инженерийн байгууламжийг байгуулахад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулах шаардлагатай байна.

Эдгээр асуудлууд Монгол улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, экспортын гол түүхий эд алт, зэс, нүүрс, хайлуур жоншны үнэ дэлхийн зах зээл дээр унасан, мега төслүүдийг хэрэгжүүлэх гаднын хөрөнгө оруулалт буурсан, гадаад ба дотоодын өр, бонд, зээлийн эргэн төлөгдөх хугацаа шахагдаж байгаа, улсын төсвийн бүрдүүлэлт 600 тэрбумаас 1 их наядаар тасрах болсон зэрэг хүндрэлүүдээс үүдэн ойрын жилүүдэд энэ чиглэлийн ажлууд хийгдэж, усан хил хамгаалалтад техник, технологийн шинэчлэл хийгдэх төлөв байдал харагдахгүй байгааг судалгаа, статистик үзүүлэлтүүд баталж байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улс нь хил залгаа Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай газар нутгийн асуудлаар ямар нэгэн маргаангүй, хилийн асуудлыг эрх зүйн хувьд бүрэн шийдвэрлэсэн билээ.

Хөрш улсуудтай хилийн болон хилийн дэглэмийн асуудлаар тэр тусмаа хилийн усны ашиглалт, хамгаалалтын талаар байгуулсан гэрээнүүд хэрэгжиж байгаа боловч нийгэм, цаг үеийн шаардлагаар бий болсон өөрчлөлтүүд, тэдгээрийг шийдвэрлэх асуудлууд тусгагдаагүй, нэгэнт байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийн заалтуудыг хэрэгжүүлэхгүй байгаа нь хилийн усны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улс нь жилийн дөрвөн улиралтай, эрс тэс уур амьсгалтай, голын ус хөлдөх, гэсэх, түүний давалгаанд цохиулах, шар усны үер, хур тунадас зэргээс шалтгаалан голын эрэг нурах, идэгдэх зэрэг асуудал үүсэж голын голдирол, усан хилийн хэсгээр улсын хилийн шугамын явалт өөрчлөгдөж байгааг судалж байна.

Манай улс голын эргийн хамгаалалтыг дотоодын гол, мөрөнд хийдэг хэдий ч хилийн дагуух голын эргийн хамгаалалтыг хийхгүй байгаа нь газар нутгийн бүрэн бүтэн байдалд сөргөөр нөлөөлж, цаг хугацаа өнгөрөх тусам үл мэдэгдэх байдлаар газар нутгаа алдсаар л байна.

Манай улсын хувьд эдийн засгийн боломжид тулгуурлан хилийн инженерийн торон саадаа шинэчлэх ажил хийгдэж байгаа хэдий ч дараагийн авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь хилийн усаа хамгаалах, голын голдирол өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх, улсын хилийн баталгаажилт, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах чиглэлээр голын эргийн нуралтаас хамгаалах даланг хийх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Хилийн дагуух голын эргийн хамгаалалтыг байгуулах нь хил хамгаалалтад сөрөг нөлөө үзүүлэхгүй, улсын эдийн засгийн хувьд зардал их гардаг, хүрэхэд хүндрэлтэй алслагдсан хэсэгт байдаг зэргээс шалтгаалан одоог хүртэл төсөвт тусгагдахгүй хийгдэхгүй байсаар байна. Энэ нь голын эргийн хамгаалалтыг Байгал орчин аялал жуулчлалын яам, Хил хамгаалах байгууллага хамтран дээд байгууллагад уламжлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Гэтэл хөрш орнууд голын эргийн хамгаалалтыг 2004 оноос эхлэн хийж улсын хилийн шугамын явалт өөрчлөгдөх асуудлыг тогтоосон байдаг бөгөөд хилийн шугамын явалт нь зөвхөн манай улсын тал руу л татагдан өөрчлөгдөх боломжтой байна.

Усан хилийн талаар тусгайлан гаргасан хөтөлбөр, үзэл баримтлал, стратегийн төлөвлөлт байхгүй бөгөөд хууль, төрийн бодлогод туссан, онцгойлон авч үзэж ач холбогдол өгсөн заалт, зүйл байхгүй байгааг цохон тэмдэглэж байна.

Монгол улсын усан хил хамгаалалтыг сайжруулах чиглэлээр олон төсөл тооцоо боловсруулсан ч санхүүжилт, хөрөнгө оруулалт, төсвийн асуудлаас шалтгаалаад эхлэл тодий зогсонги байдалд орсон.

Сүүлийн жилүүдэд Хил хамгаалах байгууллагаас усан хилийн хамгаалалтыг бэхжүүлэх, боловсронгуй болгох олон улсын жишигт хүргэх, инженерийн байгууламж, техник хэрэгслийг шинэчлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр үе шаттай цогц арга хэмжээнүүдэд, бодит хөрөнгө оруулалтыг оновчтой, тасралтгүй хэрэгжүүлж, "Бүсчилсэн хил хамгаалалт" хөтөлбөр, "Усан хил хамгаалалт" дэд хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүд зэрэг төрийн бодлогын баримт бичигт тусгуулан үе шаттайгаар хэрэгжүүлсэн.

Тиймээс усан хилийн голын эргийн хамгаалалтыг бэхлэх, хилийн аюулгүй байдлыг хангах, анхаарал татсан, тулгамдсан асуудалд зүй ёсоор орж байгааг судалгааны үндсэн дээр тогтоосон.

САНАЛ

Хөрш улстай хилийн усаар хиллэдэг гол мөрний эргийн нуралт, идэгдэлт зэргээс үүдэлтэй улсын хилийн шугамын өөрчлөлт гарч байгааг судлан түүнийг зогсоох, голын эргийн дагуу бэхлэлт байгуулах, голын эргийн дагуу үүрэг гүйцэтгэх хилийн манааны аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга хийх замаар гол нуураар хиллэдэг хэсгүүдийн хамгаалалтын талаар тодорхой тусгах.
2. Хөрш орнуудтай байгуулсан хилийн дэглэмийн гэрээний дагуу улсын хилийн шугамын хамтарсан шалгалтыг зохион байгуулж голын эргийн нуралт, идэгдэлтээс шалтгаалсан улсын хилийн шугамын өөрчлөлт гарсан эсэхийг тогтоох.
3. Гол, горхи, нууруур хиллэдэг хэсгийг хамгаалж буй хилчдэд зориулж гарын авлага гаргах.
4. Томоохон голуудын хэсэгт хилийн манаа үүрэг гүйцэтгэхэд зориулж гатлага (перевоз) байгуулах.
5. Гол нуурын эргийн хамгаалалт (бэхлэлт)-ыг боловсронгуй болгоход шаардлагатай тооцоо судалгаа гаргах.
6. Хөрш улстай усаар хиллэдэг гол мөрний эргийн нуралт, идэгдэлтээс урьдчилан сэргийлэх, хамгаалах эргийн хамгаалалтыг Байгал орчин аялал жуулчлалын яамтай хамтран стандартын дагуу хийх;
7. Хөрш орнуудтай байгуулсан хилийн дэглэмийн гэрээнд голын эргийн нуралт, идэгдлээс шалтгаалсан улсын хилийн шугамын өөрчлөлтийг шалган тогтоосон тохиолдолд геодезийн аргаар хуучин хилийн шугамын явалтыг тогтоон сэргээх заалтыг оруулж баталгаажуулах.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол-Оросын Улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээ, 2007 он.
2. Монгол-Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, БНХАУ-ын хоорондын гэрээ, 2010 он.
3. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
4. Монгол Улсын Хилийн тухай хууль, 2017 он.
5. Монгол Улсын Усны тухай хууль, 2012 он.
6. Долгорын Чойбаатар, "Усан хилийн хамгаалалт", 2017он.

ХИЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТАД ПРОФАЙЛИНГ АШИГЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Б.АЛТАНГЭРЭЛ*
ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн ахлах багш, дэд хурандаа

**хариуцлагатай зохиогч:batsukhaltangerel0718@gmail.com*

Хураангуй: Энэхүү судалгааны ажлын зорилго нь хилийн боомтын орчин үеийн чиг хандлага, олон улсын тэргүүн туршлагыг судлан, Монгол Улсын хилийн боомтуудын үйл ажиллагаанд профайлинг ашиглаж, хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааны эрсдэлийг урьдчилан тодорхойлох, хууль бус үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсоох, үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтойгоос гадна хилийн боомтын аюулгүй байдлыг хангах терроризм, хар тамхи мансууруулах бодис, сэтгэцэт нөлөөлөх эм бэлдмэл, зэвсэг болон хүний наймаа зэрэг хууль бус үйлдлийг эрт илрүүлэх, таслан зогсоох, Мөн түүнчлэн хилийн боомтоор нэвтэрч байгаа бүх зорчигчийг нэг бүрчлэн шалгах шаардлагагүй эрсдэл өндөртэйг нь ялган таних замаар зорчигчийн түүх, аяллын чиглэл, ачааны шинж чанар зэрэг мэдээлэлд тулгуурлан эрсдэлийг ангилах, цаг хугацаа, нөөцийг хэмнэх зэрэг механизмыг сайжруулах зайлшгүй шаардлага байна гэж үзсэн. Профайлингийн үйл ажиллагааг хилийн боомтод авч хэрэгжүүлснээр гарч болох эрсдэлийг ангилах, аюулгүй байдлыг хамгаалах, хилийн шалган нэвтрүүлэх албаны цаг хугацаа, хүний нөөц, техник хэрэгслийг өндөр эрсдэлтэй зорчигч, ачаанд төвлөрүүлэх, хяналт шалгалтыг хурдасгах боломжтой гэж дүгнэлээ.

Түлхүүр үгс: Хилийн боомт, шалган нэвтрүүлэх алба, профайлинг, хяналт шалгалт.

УДИРТГАЛ

Дэлхий дахинд үүсээд байгаа Их гүрнүүдийн хоорондын үл ойлголцол, цэрэг дайны нөхцөл байдал, улс төр, эдийн засгийн хямралаас үүдэлтэйгээр улс, үндэстэн дамнасан дүрвэгсдийн болон цагаачлалын хөдөлгөөн сүүлийн жилүүдэд огцом өсөх хандлагатай байна. Дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын дараагаас улс орон бүхэн хилээ нээж, уналтад орсон эдийн засгаа сэргээхээр бодлого төлөвлөгөө гарган ажилласан. Үүний нэгэн адилаар манай орны хувьд ч эдийн засгаа сэргээх зорилгоор 2023-2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарлаж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоолоор (Монгол Улсын Засгийн газар, 2023) дэлхийн 34 орныг визийн шаардлагаас чөлөөлсөн юм. Энэ нь аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготой байсан бөгөөд Монгол Улсыг сонирхох, зорин ирэх жуулчдын урсгал нэмэгдэж, хилийн боомтоор нэвтрэх иргэдийн хөдөлгөөн эрс өссөн. Тодруулбал аялал жуулчлалын өсөлт: 2023 онд Монгол Улсад 320.630 жуулчин, 2024 онд 393.376, 2025 онд 421.508 жуулчин хүлээн авсан бол Монгол Улсад нийт ирсэн гадаад иргэд 2023 онд 644064, 2024 онд 853835, 2025 онд 951208 (газар, 2020-2025 он) ирсэн тоон судалгаа байна.

Тэгвэл сайны хажуугаар саар гэгчээр үүнтэй зэрэгцэн хил дамнасан хууль бус үйлдэл хийх зорилготой гэмт этгээдүүдийн тоо ч өсөн нэмэгдэж болзошгүй байна. Тэдний хууль бус үйл ажиллагаа нь Терроризм болон хүн худалдаалах гэмт хэрэг, зэвсэг, хар тамхи мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, хууль бус эд

зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхийг завдан хилийн аюулгүй байдалд, цаашлаад Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх, аюул занал учруулж болохоор байна. Мөн Монгол Улсын нутаг дэвсгэрт олон улсад эрэн сурвалжлагдаж байгаа гэмт этгээдүүд байхыг ч үгүйсгэх аргагүй юм. Эдгээр хүмүүс нь ихэвчлэн бусдын баримт бичиг болон хуурмаглал хийсэн баримт бичгийг ашиглах, эсвэл манай улсын нутаг дэвсгэрт хязгаарлагдсан буюу хориглосон эд зүйлсийг оруулж ирэх магадлал өндөр байдаг.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол Улс газар нутгийн хувьд өргөн уудам, хоёр хөрштэй, олон улсын худалдаа, аялал жуулчлалын урсгал нэмэгдэж буй нөхцөлд хилийн боомтын аюулгүй байдлыг хангах нь стратегийн чухал асуудал юм. Хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааны урсгал ихэссэнтэй холбоотойгоор бүхнийг нэг бүрчлэн шалгах боломжгүй тул эрсдэлийг урьдчилан тодорхойлох **профайлингийн арга** зайлшгүй шаардлагатай болж байна.

Дээр дурдсанчлан улсын хилээр нэвтрэхдээ хууль бус үйлдэл хийж байгаа болон хийхээр төлөвлөсөн хүний зан төлөвийн байдал нь энгийн хүмүүсээс ялгаатай байдаг бөгөөд тухайн хүмүүсийн хилийн боомтод биеэ авч яваа байдал, гаргаж байгаа зан төлөв, сэтгэл зүйн онцлог нь аливаа нөхцөл байдалд ажиглагддаг. Жишээ нь сэтгэл санаа тавгүйрхэх, сандрах, түгших физиологийн хариу үйлдлүүд үзүүлэх гэх мэт байдаг.

Харамсалтай нь өнөөдрийн байдлаар эдгээр хүмүүсийг таньж, тогтоох техник технологи Монгол Улсад тэр дундаа хилийн шалган нэвтрүүлэх албанд нэвтрээгүй бөгөөд энэ салбарт ажиллаж байгаа боловсон хүчин, хүний нөөц маань гэмт этгээдүүдийн зан байдалд шинжлэх ухааны үүднээс хандах мэдлэгтэй хүн тун цөөхөн, тэдэнд улсын хилээр нэвтрэх хувь хүний хууль бус үйлдэл хийх санааг тусгай шинж тэмдгээр илрүүлэх техник хэрэгслийн мэдлэг, бэлтгэл сургалт одоогоор байхгүй байна.

Ихэнхдээ хууль бус үйлдэл гаргагчдын онцлог, тэдний хууль бус зорилгыг илтгэх шинж тэмдгийн талаарх мэдлэг нь алба хаагчдын таамаглалд тулгуурладаг бөгөөд хилийн шалган нэвтрүүлэх албаныхан үүнийг зөн совин гэж тодорхойлдог.

Хилийн шалган нэвтрүүлэх албанд одоо цаг үед идэвхтэй ашиглагдаж байгаа хяналт шалгалтын техник хэрэгслүүд нь ихэвчлэн зорчигчдын бичиг баримтад чиглэсэн хуурмаглалыг илрүүлэх, болон тээврийн хэрэгсэлд хууль бусаар нуусан эд зүйлийг илрүүлэхэд зориулагдсан байдаг. Энэ нь одоо цаг үед улсын хилээр нэвтрэх зорчигчдын урсгал, болон тэдний ашигладаг арга заль мэх байнга нэмэгдэн өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор хилийн хяналт шалгалтыг хийхэд хүндрэл үүсэж болохоор байна. Үүний зэрэгцээ эдгээр хяналт шалгалтын техник хэрэгсэл нь улсын хилээр нэвтэрч байгаа зорчигчдоос гэмт этгээд байж болзошгүй, тэдний хууль бус үйлдэл хийх санааг тодорхойлох боломжийг олгодоггүй юм.

Тэгвэл өнөөдөр зөвхөн профайлинг технологийг ашиглах мэдлэгтэй, тодорхой түвшний дадлага туршлагатай хүн л дотоод мэдээллийг унших, бусад зорчигчдын зан үйлийн онцлог, динамикийг тодорхойлох, зохих шийдвэрийг шуурхай гаргах чадвартай байх магадлалтай болсон энэ цаг үед хилийн боомтод аливаа гэмт хэрэг гарах, улсын хилийг хууль бусаар зөрчих үйлдлийг таслан зогсоох хилийн боомтын аюулгүй байдлыг хангахын тулд зорчигчдын зан байдлыг судалдаг үйл ажиллагааны сонгодог аргууд, таних, видео тандалтын тоног төхөөрөмж төдийгүй хууль бус санаа бодолтой хүмүүсийг тодорхойлоход ашигладаг профиль гэх мэт орчин үеийн сэтгэлзүйн аргуудыг хилийн шалган нэвтрүүлэх албанд ашиглах нь зүйтэй.

Шинжээчдийн үзэж байгаагаар профайлинг нь тухайн субъектийн болзошгүй аюулын талаар хамгийн бодитой мэдээлэл авах боломжийг олгодог бөгөөд хилийн боомт дээрх зорчигчдын хууль бус үйлдэл, санааг тодорхойлохын тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээ болгон үр дүнтэй ашиглаж болно гэдгийг тодорхойлсон байдаг. Хилийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж байгаа хилчин шалгагч бүр улсын хилээр нэвтэрч байгаа зорчигчийн хууль бус үйлдэл, санаа бодлыг олж тогтоох, тэдний зан үйлийн сэтгэл зүйг ойлгох, улсын хил зөрчигчдийн ашигладаг арга заль мэх, арга техникийг мэддэг байх ёстой.

Иймээс профайлингийг хилийн боомтод хяналт шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх үүднээс дараах зүйлсийг тодорхойлсон. Үүнд:

-Профайлинг нь хувь хүний болон улсын хилийн аюулгүй байдлыг (тэр дундаа хилийн боомтын аюулгүй байдлыг) хангах арга хэрэгслийн нэг бөгөөд болзошгүй аюултай этгээдүүдийн санааг илрүүлэх замаар хууль бус үйлдлийг урьдчилан сэргийлэх боломжийг олгодог;

-Профайлинг нь илрүүлсэн хүний шинж тэмдгийн дагуу түүний боломжит аюулыг тодорхойлж, тухайн шинж чанарууд байгаа эсэхээс хамааран тодорхой төрөл (эсвэл профайл) руу ангилах боломжийг олгодог;

-Профайлинг нь голдуу тухайн хүний гадаад байдал, зан төлөв зэрэг чухал хүчин зүйлийг цогц байдлаар шинжлэх аргуудын тусламжтайгаар явагддаг бөгөөд мөн эзэнгүй орхисон ачаа, тээш, эд зүйлс гэх мэт боломжит аюултай нөхцөл байдлыг илрүүлэхээс бүрддэг;

-Профайлинг нь хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх нэг арга хэлбэрийн хувьд төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага болон хууль сахиулах байгууллагын бүх салбарт ашиглагдаж болно (тэр тусмаа хилийн боомтод);

-Профайлинг нь мөн «хүмүүсийг унших» нийгэм-сэтгэл зүйн аргачлалуудын цогц байдлаар ажиллаж, өгөгдсөн багахан мэдээлэл, цаг хугацаа, нөөц болон арга техникийг ашиглан хилээр нэвтэрч байгаа зорчигчийн хувийн шинж чанар, санаа бодлыг хурдан хугацаанд тодорхойлж, түүний үйлдлийг үнэн зөвөөр урьдчилан таамаглах боломжийг хилийн хяналтын ажилтанд олгодог.

Иймээс профайлинг гэж үйл ажиллагааны чиглэл нь хүрээлэн буй орчныг, хүмүүсийн зан байдал, сэжигтэй шинж тэмдгүүдийг ажиглах, шинжлэх, шалтгаан-үр дагаврын холбоог тогтоох, ажлын үйл ажиллагаанд тулгарч буй асуудлыг стандарт бус аргаар шийдвэрлэхийг заадгаас гадна дэлхийн бусад оронд профайлингийн аргыг олон жил ашигласан туршлага, үүнээс олсон эерэг үр дүн нь уг аргын практик ач холбогдлыг баталдаг бөгөөд энэ аргыг улсын хилийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн тэргүүлэх чиглэлүүдийг хэрэгжүүлэх хүрээнд хилийн боомтын хяналт шалгалт тэр дундаа хилчин шалгагч, мэргэжилтнүүдийг бэлтгэхэд амжилттай ашиглаж болохоор байна.

Дэлхийн олон улс орон хилийн хяналт шалгалтад профайлингийн аргыг ашиглаж байгаа бөгөөд хамгийн идэвхтэй хэрэглэгчид нь АНУ, Канад, Их Британи, Европын Холбооны орнууд, Австрали, Шинэ Зеланд зэрэг орнууд байна. Эдгээр нь биометрийн систем, эрсдэлийн үнэлгээ, алгоритмын профайлингийг хослуулан ашигладаг Жишээлбэл:

Профайлинг ашиглаж буй гол бүсүүд

1. АНУ ба Канад (Five Eyes гишүүн орнууд)

АНУ: Homeland Security болон Customs and Border Protection байгууллагууд зорчигчийн нэрийн бүртгэл (PNR), биометрийн мэдээлэл (нүүрний зураг, хурууны хээ) ашиглан эрсдэлийн профайл гаргадаг.

Канад: Канадын хил хамгаалалт зорчигчийн мэдээллийг АНУ-тай хуваалцдаг бөгөөд эрсдэлийн үнэлгээний системийг ашигладаг.

2. Европын Холбоо (Schengen орнууд)

Европын Холбоо: Smart Borders санаачилга, Schengen Information System, EURODAC зэрэг төвлөрсөн мэдээллийн сан ашиглаж, биометрийн таних систем (нүүрний зураг, хурууны хээ) болон алгоритмын эрсдэлийн үнэлгээ хийдэг.

Герман, Франц, Нидерланд зэрэг орнууд хил дээр AI ашиглан зорчигчийн зан төлөв, аяллын чиглэлийг дүгнэдэг (https://www.europarl.europa.eu/, 2021).

3. Ази, Номхон далайн бүс

Австрали, Шинэ Зеланд: Five Eyes сүлжээнд багтдаг тул АНУ, Канадтай адил мэдээлэл хуваалцдаг. Биометрийн системийг өргөн ашигладаг.

Сингапур, Япон, Өмнөд Солонгос: Нүүрний таних технологи, автомат шалгах төхөөрөмжөөр зорчигчдыг ангилдаг.

4. Олон улсын хамтын ажиллагаа

INTERPOL Biometric Sharing Network: Олон улсын гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор гишүүн орнуудын биометрийн мэдээллийг хуваалцдаг.

Common Reporting Standard (CRS): Санхүүгийн мэдээлэл, зорчигчийн урсгалыг хяналтад ашигладаг (2025).

Профайлингийн хэрэглээний чиглэлүүд

- Биометрийн таних систем: Нүүрний зураг, хурууны хээ, нүдний солонгон бүрхэвч.
- Алгоритмын эрсдэлийн үнэлгээ: Зорчигчийн аяллын түүх, чиглэл, баримт бичиг, зан төлөв.
- AI ашиглалт: Зорчигчийн сэтгэл хөдлөлийг илрүүлэх, хууль бус үйл ажиллагааг урьдчилан таамаглах (https://www.biometricupdate.com/, 2025).

ДҮГНЭЛТ

Өнөөдөр дэлхийн 110 гаруй улс орон хилийн шалгалтад профайлингийн ямар нэг хэлбэрийг ашиглаж байгаа бөгөөд АНУ, Канад, Их Британи, ЕХ, Австрали, Шинэ Зеланд зэрэг өндөр хөгжилтэй орнууд хамгийн идэвхтэй хэрэглэж байна. Энэ нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, хууль бус үйл ажиллагааг бууруулах, зорчигчийн урсгалыг оновчтой зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Үүний нэгэн адилаар Монгол Улс ч гэсэн профайлингийн аргыг хилийн шалган нэвтрүүлэх албанд ашиглаж, хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэн, хууль бус үйл ажиллагааг бууруулах, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, эдийн засгийн ашиг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой болохыг харуулж байна.

Иймд профайлингийг хэрэгжүүлэхдээ хууль эрх зүйн зохицуулалт, хүний эрхийн баталгаа, мэдээллийн технологийн дэвшил, олон улсын хамтын ажиллагаа зэрэг хүчин зүйлсийг цогцоор нь авч үзэх шаардлагатай юм.

Санал: Олон улсын туршлагаас харахад хилийн боомтод профайлингийн арга нэвтрүүлж үр ашгийг нэмэгдүүлэхэд дараах арга хэмжээнүүд нэн чухал байгаа нь харагдаж байна. Үүнд:

1. **Мэдээллийн технологи**: Хилийн боомтын мэдээллийн системийг сайжруулж, олон улсын мэдээллийн сан, тагнуулын байгууллагын мэдээлэлтэй уялдуулах.

2.**Хүний нөөц ба сургалт**: Хилийн шалгалтын ажилтнуудыг профайлингийн арга зүйд сургах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх.

3.**Хууль эрх зүйн зохицуулалт**: Хүний эрхийг зөрчихгүйгээр, зөвшөөрөгдсөн хүрээнд профайлинг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

4. **Олон улсын хамтын ажиллагаа**: Бүс нутгийн болон олон улсын байгууллагуудтай мэдээлэл солилцох, туршлага хуваалцах шаардлагатай.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ:

European Union Agency for Fundamental Rights. (2010). *Ethnic profiling and discrimination at borders*. FRA.

Mongolian Customs General Administration. (2022). *Annual report on border security and customs control*. Ulaanbaatar.

Scherrer, A. (2013). Profiling at borders: International practices and human rights concerns. *Journal of Border Security Studies*.

United Nations Office on Drugs and Crime. (2021). *Handbook on risk profiling for border management*. UNODC.

Монгол Улсын Засгийн газар. (2023, January 4). *Тогтоол: Монголд зочлох жил*. https://legalinfo.mn/

Хил хамгаалах ерөнхий газар. (2020–2025). *Улсын хил нэвтэрсэн зорчигчдын тоон судалгаа*. Дүн шинжилгээний хэлтэс.

Biometric Update. (2025, January 5). *AI use in biometric profiling*. https://www.biometricupdate.com/

European Parliament. (2021). *Smart borders and Schengen information system*. https://www.europarl.europa.eu/

Newstrail. (2025, August 5). *Border security and AI applications*. https://www.newstrail.com/

ХИЛ ХАМГААЛАЛТАД ПРОФАЙЛИНГ НЭВТРҮҮЛЭХ НЬ
BORDER PROFILE LOG-IN

Г.БОЛОРТУНГАЛАГ*
ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн ахлах багш, УБХИС-ийн докторант, дэд хурандаа

**хариуцлагатай зохиогч:bolorgetsel@gmail.com*

Хураангуй: Шалган нэвтрүүлэх албаны профайлинг нь аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй хүмүүсийг тодорхойлохын тулд аяллын хэв маяг, зан байдал, баримт бичгийн дэлгэрэнгүй мэдээлэл зэрэг ажиглагдах хүчин зүйлс дээр үндэслэн тухайн хүнийг ажиглах явдал юм. Энэхүү арга нь шалган нэвтрүүлэх албанд хуурамч бичиг баримт илрүүлэх, хүний наймаа, терроризм зэрэг хууль бус үйл ажиллагаанд оролцох магадлал өндөртэй хүмүүст хяналт шалгалтыг төвлөрүүлэх, нарийвчилсан шалгалтыг зохион байгуулж, эрсдэл багатай зорчигчдод саадгүй зорчих боломжийг олгодог. Шалгагч бүрэлдэхүүн профайлингийг нь ашиглахын тулд ажиглалт, асуулт асуух аргуудыг хослуулан хийдэг бөгөөд цуглуулсан мэдээлэлд үндэслэн болзошгүй эрсдэлийг таслан зогсоох дүгнэлтэд хүрдэг.

Энэхүү өгүүлэлд хилийн боомтын аюулгүй байдлыг хангахын тулд профайлингийг хэрхэн ашиглах талаар авч үзэх бөгөөд шалган нэвтрүүлэх албаны аюулгүй байдал буюу хилийн аюулгүй байдлыг хангахад анхаарах юм. Хилийн боомтод аюулгүй байдлыг хангах олон улсын дүрэм, профайлинг, түүний төрөл, профайлингийн давуу болон дутагдалтай талуудыг судалгаагаар онцолж байна.

Судалгаагаар хилийн аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагааг сайжруулахын тулд профайлингийн сургалтын хөтөлбөр, мэргэшсэн сургалтын хөтөлбөр, бэлтгэгдсэн профайлер шалгагч бэлдэх хэрэгцээ байгааг харуулж байна.

Түлхүүр үг: Профайлинг, Хилийн аюулгүй байдал, Шалган нэвтрүүлэх алба, Эрсдэл

УДИРТГАЛ

Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа эхлэн өнөөг хүртэл худлыг илчилж, үнэнийг тогтоохыг байнга эрэлхийлж ирсэн. Нийгмийн хөгжлийн явцад, худал болон үнэнийг тогтоох арга, аргачлал боловсронгуй болсоор өнөөдөр энэ чиглэлд шинжлэх ухаан, техник технологийн дэвшлийг түлхүү ашиглах болсон.

Профайлингийн хамгийн их маргаан дагуулж буй асуудал бол угсаатны профайлинг бөгөөд аль нэг угсаатны бүлгийн хүмүүс болон хууль бус үйлдлийн шууд хамаарал, холбооны асуудал болоод байгаа юм.

Профайлингийн арга нь зорчигчийн зан төлөв, биеийн хэлэмж, гадаад төрх, аяллын баримт бичиг, өмнөх аяллын түүх зэрэг олон төрлийн өгөгдлийг нэгтгэн дүгнэх замаар эрсдэлтэй этгээдүүдийг тодорхойлох үйл явц юм. Энэ нь хил хамгаалах байгууллагын албан хаагчдад зорчигчдын урсгалыг тасалдуулахгүйгээр аюулгүй байдлын шалгалтыг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах боломжийг олгодог. Ялангуяа агаарын замын боомтууд шиг ачаалал ихтэй, зорчигчдын урсгал хурдан өрнөдөг орчинд профайлингийн аргыг ашиглах нь аюулгүй байдлыг хангах чухал хэрэгсэл болж байна.

Судалгааны ажлын хүрээнд профайлингийн онол, арга зүй, түүний аюулгүй байдлыг хангахад гүйцэтгэх үүрэг, Монгол Улсын хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд профайлингийн аргыг ашиглах боломж, сорилтуудыг судалж, дүн шинжилгээ хийнэ.

Профайлингийн аргыг оновчтой ашигласнаар хил хамгаалах байгууллага нь улс орны аюулгүй байдлыг хангах үүргээ илүү үр дүнтэй хэрэгжүүлж, агаарын замын боомтуудыг аюулгүй, найдвартай байлгахад хувь нэмэр оруулах боломжтой юм

ҮНДСЭН ХЭСЭГ

Профайлинг гэж юу вэ? Профайлинг («англи. profile» — профиль) —гэдэг нь хүний биеэ авч явж байгаа байдал, гадаад үзэмж, онцлог шинжүүдийг харгалзан хүний сэтгэл зүйн болон хандлагын тухайн үеийн онцлогийг тодорхойлох арга юм. Мөн профайлинг нь тухайн хүний зан төлөв, шинж чанар, хэв маягт үндэслэн түүнийг тодорхой бүлэгт хамааруулах эсвэл ирээдүйд гаргаж болзошгүй үйлдлийг нь урьдчилан таамаглах арга зүй юм.

Профайлинг буюу сэтгэл зүйн хөрөг гаргах аргачлал гэдэг нь сэтгэл судлалын шинжлэх ухааны мэдлэг, практик хэрэглээний цогц юм. Профайлингийг “хүнийг унших арга” гэж доктор (Ph.D), профессор Ц.Ганболдын тодорхойлсон арга нь манай улсын нөхцөлд тохиромжтой байна гэж судлаач би үзэж судалгааг үргэлжлүүлэн явуулж байна. Энэ нь богино хугацаанд тухайн хүний зан чанар, хувийн онцлог, хэрэгцээ, шаардлага, үзэл бодол, биеэ авч яваа байдлаас хүний дотоод мэдээллийг уншин тодорхойлох боломжийг олгодог.

Профайлинг нь анх гэмт хэргийн халуун мөрөөр үл танигдах гэмт этгээдийн “Сэтгэл зүйн хөрөг”-ийг тодорхойлоход ашиглагдаж байсан бөгөөд гэмт этгээдийн сэтгэл зүйн хөргийг гаргах ажлыг анх 1888 онд англиин мэс засалч Томас Бонд зууны гэмт хэрэгтэн Джек Потрошителийг тодорхойлох оролдлогоор эхэлсэн гэж үздэг.

Орчин үед хүний ой санамжид хадгалагдсан “нуугдмал мэдээлэл”-ийг илрүүлэхэд профайлингийн аргыг өндөр ач холбогдолтойгоор судлах шаардлага гарч байна.

Хүний мэдээллийг уншихын тулд:



Зураг 1. Хүний мэдээллийг унших бүтэц

1. Мэдлэг (Knowledge): Энэ нь зөвхөн эзэмшигчийн мэддэг, мэдээлэлд тулгуурласан баталгаажуулалт юм. Үүнд нууц үг, нууц асуулт, хариулт, пин код, зурган хээ зэрэг орно. Зарим тохиолдолд тодорхой хөдөлгөөний хэв маяг ч ажиглагдаж болно. Баталгаажуулалтын бүртгэл хийх үед (Таны ургийн овог хэн бэ?), (Таны анхны паспорт хэзээ авагдсан бэ?), (Та ямар улс орноор аялж байсан бэ?) гэх мэт асуулт гарч ирдэг. Товчоор хэлбэл, эдгээр мэдээлэл нь хэрэглэгчийн хувьд нууц бөгөөд зөвхөн өөрөө мэддэг, санаж ашиглах боломжтой мэдээлэл юм.

2. Техник хангамжийн токен (Таних төхөөрөмж): Энэ нь зөвхөн баталгаажуулах гэж буй хүний эзэмшдэг биет зүйлсийг хэлнэ. Үүнд түлхүүр, тусгай бичиг баримт, USB санах ой, түлхүүрийн оосор, ухаалаг карт зэрэг багтана. Ийм төрлийн төхөөрөмжүүд нь гарт баригддаг, өвөрмөц бүтэцтэй тул хуурамчаар үйлдэх, хувилбар гаргахад хүндрэлтэй байдаг.

3. Биометрик өгөгдөл: Биометрик өгөгдөл нь тухайн хүнийг тодорхойлох боломжтой, бие махбодтой нь холбоотой өвөрмөц шинж чанаруудыг хэлнэ. Үүнд нүдний өнгө, нүдний цагаан хальс, нүдний солонгон бүрхүүл, хурууны хээ, нүүр царайны хэлбэр, чихний хэлбэр, тухайн хүний онцгой хоолойн өнгө, шүдний хэлбэр, ДНХ зэрэг орно. Эдгээр шинж чанарууд нь хүн бүрд давтагдашгүй бөгөөд зарим нь гаднаас харагдаж, бусдаас амархан ялгардаг бол зарим нь зөвхөн тусгай тоног төхөөрөмж, микроскоп болон бусад хэрэгслээр тодорхойлох шаардлага үүсдэг.

Дээрх аргыг хэрэглэн хүний мэдээллийг авснаар тухайн зорчигчийн сэжигтэй үйлдэл хийж байгаа үгүйг таамаглах боломжтой.

Орчин үед техник хэрэгслийн дэвшилт хэдий сайн байгаа хэдий ч техникт илрэхгүй байх боломжтой олон үйлдэл гарч болно.



Зураг 2. Биометр ба хуурмаглал

Жишээ нь: Т*ехник технологи хөгжөөд цахим гарцаар шалгалтыг явуулдаг болсонтой холбогдуулан зорчигчид өөрийн нүүр төрхийг өөрчлөн технологийг хуурах оролдлого гаргана. Энэ тохиолдолд биометрик өгөгдөл жинхэнэ эсэхийг шалгах хүн байхгүй илрүүлэх боломжгүй болно. Иймээс хүний оролцоотой буюу шалгагч /профайлер/ тухайн зорчигчийг ажиглан илрүүлэх ажиллагаа явагдах шаардлага тулгарч байна.*

“Хүнийг унших арга” буюу профайлингийн аргын үндсэн зорилго нь хүний ой санамжид хадгалагдаж буй нуугдмал мэдээллийг ил болгоход оршино. Эрдэмтэд профайлингийн аргыг нийгмийн бүхий л салбарт нэвтрүүлж, ашиглах боломжтой гэж үздэг. Олон улсын туршлагаас үзэхэд, профайлингийн үр дүнг, гол төлөв, нууц далд үйлдэлтэй гэмт хэрэг илрүүлэх, ээдрээ төвөгтэй хэрэг, зөрчил, маргааныг шийдвэрлэх, нотлох ажиллагаанд ашигладаг практикт нийтлэг ашигладаг байна. Мөн хүний нөөцийн болон албаны шалгалтын үнэн байдлыг нотлоход болон бизнес арилжааны салбарт хэрэглэгчийг судлах, бараа бүтээгдэхүүнийг борлуулахдаа хэрэглэгчийн хүсэл сонирхолд нийцүүлэн сурталчлах, аливаа гэрээ, хэлэлцээр байгуулахдаа харилцагчаа, өрсөлдөгчөө судлахад өргөн ашиглаж байна. Харин бидний хувьд шалган нэвтрүүлэх албанд буюу хил хамгаалалтад ашиглах нь маш тохиромжтой бөгөөд үр өгөөжтэй гэж үзэж байна.

Монголчууд эрт үеэс энэхүү профайлингийн аргыг ашиглаж байсан түүхтэй байдаг. Жишээ нь: Хүнийг мэндлэх, уулзах, тамхилах үйлдлээр нь хэн болохыг тандах, таних, таамаглах, тэр ч битгий хэл илрүүлдэг төрөлхийн профайлер хүмүүс байсан байдаг. “Тавхан үгэндээ танигдаад байна”, “Эх нь хээр алаг бол цнага нь шийр алаг” гэх мэт хэлц үгс ч энэ ажигч, тандах, дүгнэх соёлын илрэл гэдэг нь харагдаж байна.

Олон улсын туршлагаас харахад нислэгийн өмнөх бүртгэл болон нисэх онгоцонд суух үед зорчигчдод хяналт, ажиглалт хийх замаар болзошгүй гэмт этгээдийг, ялангуяа алан хядагчдыг илрүүлэхэд профайлингийг өргөн ашиглаж байгаа бөгөөд үүнийг хамгийн түрүүнд Израйлын Эль-Аль (El Al) нислэгийн компани нэвтрүүлсэн ба үүнийхээ үр дүнд дэлхийн хамгийн аюулгүй нислэг үйлддэг нисэх компани болсон. Эль-Аль (El Al) нислэгийн компанийн анх нэвтрүүлсэн профайлингийг дэлхийн олон улсын нислэгийн компаниуд нэвтрүүлж, тодорхой үр дүнд хүрч байна.

Шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагааны хүрээнд ажилтан нь баримт, мэдээлэл болон тухайн мөчид ажиглагдаж буй зан үйлийн илрэлд тулгуурлан нөхцөл байдлыг танин мэдэх, эрсдэлийн түвшинг үнэлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд иргэдийн зан төлөвийн уялдаа холбоо, нөхцөл байдлын логик дараалал, боломжит эрсдэлийн хүчин зүйлсийг задлан шинжилж, бодит цагийн нөхцөл байдалд тохирсон шийдвэр гаргах шаардлагатай байдаг. Ийнхүү сэтгэл зүйн шинжлэх ухааны зарчмуудыг хэрэглэх нь шалган нэвтрүүлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхээс гадна хүний аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Олон улсын хэмжээнд шалган нэвтрүүлэх албаны профайлингийн судалгаа нь ялангуяа 2001 оны 9/11-ний террорист халдлагын дараа эрчимтэй хөгжсөн. Энэ үеэс эхлэн нисэх буудлын аюулгүй байдлыг зөвхөн физик шалгалтаар хангах боломжгүй гэж үзэж, зан үйлийн шинжилгээнд суурилсан систем нэвтрүүлэх шаардлага үүссэн.

Зарим мэргэжилтнүүд профайл нь тухайн объектын болзошгүй аюулын талаар хамгийн бодитой мэдээлэл олж авах, тээврийн хэрэгсэл, олон хүн цугларсан газар,

террорист халдлагаас урьдчилан сэргийлэх боломжийг олгож, хууль сахиулах ажиллагаанд үр дүнтэй ашиглаж болно гэж үздэг

Мэргэжлийн шалгагч атугай энгийн хүмүүст ч хууль бус үйлдэл гаргах сэдэлтэй хүмүүсийн биеэ авч яваа байдал, ердийн зорчигчдоос эрс ялгардаг онцлогтой.

Шалган нэвтрүүлэх боомтоор нэвтэрч буй тухайн сэдэлтэй этгээдийн сэтгэл зүйн онцлог, биеэ авч явж буй гадна байдал, шалгагчтай харьцах үед гаргаж буй биеийн хэлэмж, нүүр царайны хувирал, сэтгэл зүйн хандлагаас үүдэлтэй.

Монгол Улсын Хил хамгаалах байгууллагын хилийн шалган нэвтрүүлэх албаны албан хаагчид, хилээр, шалганаар нэвтрэх үед хууль зөрчих сэдэл бүхий этгээдэд илэрдэг нүүр царайны хувирал, сэтгэл зүйн хандлага ба биеийн хэлэмжийн онцлогийн талаар тодорхой ойлголтгүй, тусгайлсан сургалтад хамрагдаагүй бөгөөд тусгай хөтөлбөр байхгүй. Гэвч эдгээр хүмүүсийн бусдаас ялгагдах онцлогийг олон жил ажиллаж, алба хаасан туршлага болон мэргэжлийн зөн совингоороо ихэвчлэн тааварладаг.

Өнөөдөр Профайлинг технологийн тодорхой мэдлэгтэй, практикт, албаны үйл ажиллагаанд хэрэглэх чадварыг зохих түвшинд эзэмшсэн шалгагч л гэмт хэргийн сэдэл бүхий этгээдийг түүний харьцаа, хандлага, дохионы хэл, биеийн хэлэмж, нүүр царайны хувирал, сэтгэл зүйн илэрхийллийн онцлогоор, шинжээр нь “гадарлах төдийгүй доторлож уншин”, тодорхой тохирсон шийдвэр гарган ажиллах боломжтой юм. Ийм чадвар эзэмшсэн хүнийг “Профайлер” гэж нэрлэдэг. Шалган нэвтрүүлэх албаны хувьд ур чадвар бүхий “шалгагч” юм.

Үндэсний болон хилийн аюулгүй байдлыг хангахын тулд хяналтын, хайлтын, адилтгал, ижилсүүлэлтийн, зайн тандалтын, цахим, оюуны багтаамжит, хиймэл оюун ухаантай гээд л орон төрлийн техник, технологи ашиглаж, эрэл хайгуул, эрэн сурвалжлах-оператив, гүйцэтгэх ажлын сонгодог болон уламжлалт олон аргуудыг ашиглаж байгаач, хууль бус үйлдлийн сэдэл тээгчийн “нуугдмал мэдээлэл”-ийг олзворлох, унших, танин мэдэх орчин үеийн сэтгэл зүйн аргын нэг болох профайлинг аргыг хэрэглэх, нэвтрүүлэх нь зүйтэй байна.

Мэргэжилтнүүдийн судалгаагаар профайлинг л аюул тээгч субъектийн бодит мэдээллийг олж авах боломжийг олгодог хамгийн сайн арга бөгөөд үүнийг шалган нэвтрүүлэх албанд оновчтой, үр дүнтэй ашигласнаар болзошгүй аюулын эсрэг сөрөг тусгай ажиллагааг цаг алдалгүй авах боломжийг олгох юм.

Хил хамгаалах байгууллагын шалган нэвтрүүлэх албаны албан хаагчид профайлинг ашиглах, хэрэглэх нь түүний гүйцэтгэх үндсэн үүрэгт нь туссан байдаг. Шалгагч бүр хил зөрчигчдийн хууль бус үйлдэл, оролдлого, санаархлыг үйлдэл, үйл ажиллагаанд нь хяналт тавих замаар, мөн төрөл бүрийн заль мэх, хуурмаглал ашиглах оролдлогыг илрүүлэх, таслан зогсоох, мөн мэддэг байх үүрэгтэй гэж дүрэм, журамд заасан байдаг.

Профайлингийг эзэмшээгүйн сул талын талаарх жишээг дурдъя: Терроризмын эсрэг Монголын холбооны тэргүүн Ч.Баатар 2002 онд тавьсан илтгэлдээ: “2002 оны эхний 6 сарын байдлаар өмнөд хөршөөс 300 гаруй иргэн хуурамч паспорт ашиглан манай улсын урд, хойд хилийг төвөггүй давж, ОХУ-ын хил болоод тагнуулын албадуудад шалгагдаж илэрсэн байна. Мөн сахал үсэндээ баригдсан, гар, нүүрэндээ шарх сорвитой, баруун гарын долоовор хуруу нь эвэршсэн 7 этгээд Энэтхэгээс ОХУ руу явж байгаад саатуулагдсан агаад эдгээр нь Чечень орж байлдах хөлсний цэргүүд байсан” гэж дурдсан нь өнгөрсөн ч гэсэн үнэт сургамж болж үлдэх юм.

Энэхүү жишээнээс үзэхэд техник технологи хэдий сайн хөгжсөн ч хүний оролцоогүй бол бүх шалгалтыг чанартай эрсдэлгүй нэвтрүүлэх боломжгүй гэдэг нь

тодорхой харагдана. Хилийн боомтоор нэвтэрч буй сэжигтэй этгээдийг бүрэн илрүүлэлгүй нэвтрүүлснээр тухайн цаг үед нэвтэрч буй зорчигч, хилийн хяналтын ажилтнуудад тодорхой эрсдэл учирч болзошгүй.тэр нь ямар эрсдэл тохиолдож болзошгүй вэ гэвэл аюулгүй байдлын эрсдэл юм.

Үүнээс үүдэн эрсдэл гэж юу вэ? Гэдэг асуудал гарч ирнэ. ***Аюулгүй байдлын эрсдэл гэдэг нь*** “хувь хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхлыг хөндөж буй нөхцөл байдал, хүчин зүйлүүдийн нэгдэл” юм. Тиймээс энэхүү тодорхойлолтын категорийн аппарат нь "хамгаалалт", "заналхийлэл", "аюул", "ашиг сонирхол", "оршихуй", "хөгжил", "хүний", "нийгэм", "төр" гэсэн ойлголтыг агуулдаг.

Эрсдэлийн үнэлгээг болзошгүй осол, түүний магадлал, үр дагавар ба тэдгээр үйл явдлыг тэсвэрлэх чадвараар тодорхойлдог. Үүний үр дагавар тоон болон чанарын хэлбэрээр илэрхийлэгдэх боломжтой. Эрсдэлийн үнэлгээ бол аливаа эрсдэлийн үр дагаврыг бууруулахад туслах өргөн хүрээний эрсдэлийн стратегийн удирдлагын салшгүй нэг хэсэг. Илүү нарийвчилбал эрсдэлийн үнэлгээ нь хувь хүн, эд хөрөнгө болон/эсвэл хүрээлэн буй орчинд ирээдүйд сөргөөр нөлөөлж болзошгүй тохиолдлуудыг жишээ нь, аюулын шинжилгээ тодорхойлж, дүн шинжилгээ хийдэг. Мөн үүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг (эрсдэлийн үнэлгээ зэрэг) авч үзэхийн зэрэгцээ “эрсдэлийг тэсвэрлэх чадварыг түүний шинжилгээний үндсэн дээр эрсдэлийг тэсвэрлэх чадварын тухай” дүгнэлт гаргадаг. Эрсдэлийн агуулга нь гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд хор хохирол тарих бус харин шийдвэрлэхээр зорьсон зорилгоосоо хазайх боломжид агуулагдаж байх магадлалтай байдаг.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Өнөөгийн даяаршсан ертөнцөд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризм, хууль бус шилжилт хөдөлгөөн зэрэг олон төрлийн аюул заналхийллийн бай болсоор байна. Ийм нөхцөлд Хил Хамгаалах Байгууллагын (ХХБ) зүгээс хилийн боомтуудад аюулгүй байдлыг хангах шинэлэг, үр дүнтэй аргыг нэвтрүүлэх нь нэн чухал юм.

Профайлинг буюу зан төлөв, шинж тэмдэгт суурилсан эрсдэлийг үнэлэх арга нь орчин үеийн хилийн хяналт шалгалтад, ялангуяа хилийн боомтуудад аюулгүй байдлыг хангах хүчирхэг хэрэгсэл болох нь харагдаж байна. Энэхүү арга нь зорчигчдын зан төлөв, биеийн хэлэмж, гадаад төрх, аяллын баримт бичиг, авч яваа ачаа, гар тээшинд гэх мэт олон төрлийн өгөгдлийг нэгтгэн дүгнэх замаар эрсдэлтэй этгээдүүдийг илрүүлэх боломжийг олгодог.

Профайлинг нь хүрээлэн байгаа орчиндоо, алба-байлдааны үүрэг биелүүлэх үед үүссэн цагийн байдалдаа үйл ажиллагаагаа үнэлэх, хүмүүсийн биеэ авч яваа байдал, сэжигтэй үйлдэл, зүйлийг онцлог, онцгой шинж тэмдгүүдээр илрүүлэх, тэдгээрийн хоорондын учир шалтгааныг танин мэдэх, үүссэн цагийн байдалд стандарт бус шийдвэр гаргах чадвартай байхыг шаарддаг.

Хил залгаа болон гадаадын бусад орнуудад шалган нэвтрүүлэх боомт дээр “Профайлинг”, “Полиграф” аргуудыг олон жил үр дүнтэй ашиглаж ирсэн нь энэ аргуудын практик ач холбогдлыг өндөрт өргөж байгаа болно.

Монгол Улсын үндэсний болон хилийн аюулгүй байдлыг хангахад профайлинг аргыг эзэмшсэн шалгагчдыг бэлтгэх, сургалтын тусгай хөтөлбөр бий болгон мөн сурах бичиг, гарын авлага боловсруулан хэрэгжүүлэх нь зүйтэй.

Өөрийн онцлогтой “Шалган нэвтрүүлэх албаны профайлинг”-тай болох нь нэн тэргүүний зорилт болж байна.

Шалгагч нь бичиг баримт шалгадаг, цохиур хэв дардаг нэгэн биш сэтгэл зүйч-угсаатан судлаач-магадлан шинжээч-олон улс судлаач-хил болон хэл судлаач-профайлер байх зэрэг олон мэргэшил эзэмшсэн “супер мэргэжилтэн” байх шаардлага тавигдаж байна. Мэргэшсэн шалгагчийг, мэргэжилтэн хүнийг юу ч орлохгүй гэдэгтэй санал нэгдсэн байна.

Дараах санал, дүгнэлтийг дэвшүүлж байна:

-профайлингийн чиглэлээр мэргэшсэн шалгагчийг бэлтгэх

-Тусгай сургалтын хөтөлбөр дагуу сурах бичиг, гарын авлага боловсруулан хэрэгжүүлэх

-Өөрийн орны нөхцөлд тохирсон “Шалган нэвтрүүлэх албаны профайлинг”-ийн загварыг бий болгож нэвтрүүлэх.

Ингэснээр аюул, эрсдэлийг эрт илрүүлэх боломж нэмэгдэн, шалган нэвтрүүлэх үйл ажиллагааны албаны үр дүн дээшилж, шалгагчийн ур чадвар сайжран, үндэсний болон хилийн аюулгүй байдал бэхэжнэ.

НОМ ЗҮЙ

1.International civil avation organization. (2022, November 18). The united nations. Retrieved from Annex 17-Avation Security: https://www.icao.int/avation-security-policy-section/Annex17

2.Аллан ба Барбара Пийз. (2011). Биеийн хэлийг тодорхойлхуй. Улаанбаатар:57.

3.Федотова, М.(2021, January 20). Системийн сэтгэл судлалын үндэс. Retrieved from

4.Министерство просвещения Рф: https://isp.institute/biblioteka/article/chto-takoe-profayling

https://centrmetafora.ru/profiling-kpk

5.Агейко, О. В. Основы профайлинга. – Минск ., 2017. – 123 с

6.Аминов, И.И. Профайлинг. Технологии предотвращенияпротивоправных действий / И. И. Аминов [и др.]. – 2-е изд. – М., 2012. – 367 с.

7. Дымар, Н. А. Психология профессиональной деятельности.

8.Turvey, E.Brent. Эрүүгийн профайлинг. -орч. Болдбаатар Ж., Эрдэмбат Э. Уб., 2022. 152 дахь тал

9.Ц.Ганболд. (20248 June 02). Монгол Улсын дотоод хэргийн их сургууль. Retrieved from Профайлинг, түүнийг шалган нэвтрүүлэх албанд бүтээлчээр хэрэгжүүлэх нь: https://www.uia.gov.mn/news/1585

ЦЭРГИЙН СУРГАЛТЫН ТАЛААРХ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Т.АМАРЗАЯА*
Хил судлалын магистрант, дэслэгч

**хариуцлагатай зохиогч: Т.Амарзаяа*

Хураангуй: Цэргийн сургалт нь цэргийн алба хаагчдыг энх цаг болон дайны үед үүрэг гүйцэтгэх чадвартай, бэлтгэгдсэн мэргэжлийн цэрэг болгон төлөвшүүлэх, мэдлэг, чадвар, дадал олгох, сэтгэл зүйг тогтворжуулах тасралтгүй үйл ажиллагаа юм. Энэ нь зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын байлдааны бэлэн байдлыг хангах үндэс болдог.

Түлхүүр үг: Цэргийн сургалт, онол арга зүй, онцлог, тогтолцоо.

Цэргийн сургалтын үндсэн агуулга:

-*Онолын мэдлэг:* Дүрэм, журам, гадаад, дотоод орчны талаарх мэдлэг.

-*Дадлага сургуулилт:* Зэвсэг техник эзэмших, буудлага, байлдааны ажиллагааны чадвар.

-*Сэтгэл зүйн бэлтгэл:* Сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, соёл хүмүүжлийн ажил.

-*Бие бялдрын хөгжил:* Тэвчээр хатуужил суулгах.

Цэргийн сургалтын онол арга зүй нь албаны бэлэн байдлыг хангах үндэс болдог цогц тогтолцоо юм.

Цэргийн сургалтын онол арга зүйн үндэс нь хилийн цэргийн албаны бэлэн байдлыг хангах, алба хаагчдыг мэргэшүүлэхэд чиглэсэн нэгдсэн тогтолцоо юм. Энэ нь сургалтын төлөвлөлт, материаллаг бааз, орчин үеийн арга зүй (танхимын хичээл, дадлага), сэтгэл зүйн болон соёл хүмүүжлийн цогц үйл ажиллагааг ХЦ-ийн Сургалт бэлтгэлийн газар удирдан зохион байгуулдаг цогц арга хэмжээ билээ.

Цэргийн сургалтын онол, арга зүй нь цэргийн алба хаагчдад эх оронч үзэл төлөвшүүлэх, байлдааны чадвар, мэргэжлийн ур чадвар, сахилга батыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа юм. Энэ нь сургалтын зорилго, агуулга, арга хэлбэр, материаллаг бааз, үнэлгээний системийг нэгтгэсэн, байлдааны бэлэн байдлыг хангахад оршдог шинжлэх ухааны тогтолцоо.

Онол, арга зүйн үзэл баримтлал: Хилчин офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдыг сурган хүмүүжүүлэх онол, сургалтын арга хэлбэр, агуулгын шинэчлэл, стандартыг мөрдөх.

Төлөвлөлт ба Зохион байгуулалт: Сургуулийн жилийн сургалт бэлтгэлийг төлөвлөх, удирдах албан тушаалтнуудын заах арга зүйн нэгдсэн болон хэсэгчилсэн цугларалт, уялдаа холбоог хангах.

Материаллаг бааз ба орчин: Сургалтын материаллаг баазыг түшиглэн танхим болон хээрийн сургалт-дадлага (бүлгийн, команд штабын, хээрийн сургууль) хийх.

Хяналт, шалгалт, үнэлгээ: Сургалтын чанар, норм нормативын биелэлтэд хяналт тавих, шалгах, дүгнэж үнэлэх тогтолцоо гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Удиртгал

Монгол цэргийн сургалтын түүхэн уламжлал нь 1921 оны Ардын хувьсгалаас эхтэй бөгөөд үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, цэрэг-эх оронч хүмүүжил олгох, байлдааны чадавхыг дээшлүүлэхэд чиглэж ирсэн. 1923 оны Бүх цэргийн ерөнхий сургуулиас үндэс суурь нь тавигдаж, өдгөө Батлан хамгаалахын их сургууль болон

хуучнаар ХЦДС буюу одоогийн ДХИС-ийн Хилийн албаны сургууль, тэдгээрийн сургалтын нэгдсэн төвүүдэд буюу Төв аймгийн нутаг дэвсгэр дэх Таван толгойн хээрийн сургуулийн полигон, Баянчандманийн ХЦ-ийн Сургалтын цогцолбор, Гүнжийн хоолойн сургалтын төвд орчин үеийн, мэргэжлийн цэрэгт суурилсан сургалтын тогтолцоонд шилжсэний зэрэгцээ хээрийн гаралт, команд штабын сургалт, даллага зохион байгуулж, улмаар улсын шалгалт явуулж байна.

Түүхэн уламжлал ба хөгжлийн үе шатууд:

Үндэс суурь (1920-иод оноос): Ардын цэргийн даргын сургууль байгуулагдаж, үндэсний боловсон хүчин, офицер, ахлагч нарыг бэлтгэж эхэлсэн.

Социализмын үе: Цэргийн алба хаагчдад бичиг үсэг заах, мэргэжил эзэмшүүлэх, цогц цэргийн бэлтгэл олгох уламжлал тогтсон.

Орчин үеийн хөгжил (1990-ээд оноос хойш): Цэргийн сургалт бэлтгэлийг хамаарна.

Уламжлалт суурь: Хилийн цэргийн түүхэн уламжлал, дайчин замнал, үндэсний ёс заншил дээр суурилсан соён гэгээрүүлэх ажил.

Орчин үеийн сургалт: Хилийн цэргийн отряд, тусгай анги, хилийн цэргийн салбар, салбаруудад хээрийн гаралт, цогцолбор сургалтын дадлага, нэг бүрийн, бүлгийн зэвсгийн буудлагаар дамжуулан бие бүрэлдэхүүний чадавхыг дээшлүүлж байна.

Инновац ба технологи: Сургалтад нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ээр ажиллах, бодит цагийн байдалд нийцсэн тактикийн бэлтгэл хийх зэрэг шинэ технологи, инновацыг нэвтрүүлж байна.

Монгол Улсын цэргийн сургалтын тогтолцоо нь Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний бэлэн байдал, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн, шат дараалсан цогц үйл ажиллагаа юм. Үүнд анги салбарын сургалт, командлалын дэд тогтолцоо, заах арга зүйн цугларалт, хээрийн гаралт, полигоны дадлага зэрэг онол, дадлагыг хослуулсан хэлбэрүүд багтдаг.

Үндсэн хэсэг

Цэргийн сургалт: Дайчдад практик ажиллагаанд нь зайлшгүй шаардлагатай цэргийн хэргийн мэдлэг, чадвар, дадлага эзэмшүүлэх, цэргийн хамт олон /нэгтгэл, анги, салбар/-ыг байлдааны ажиллагаа явуулахад бэлтгэх, гар нийлэмжийг хангахад чиглэгдсэн зохион байгуулалт, зорилго, чиглэл бүхий үйл явц юм.

Цэргийн сургалтын үндсэн зарчмууд нь:

-шинжлэх ухааны цэргийг дайнд хэрэгтэй бүхэнд сургах шаардлага, суралцагсдын идэвхтэй, ухамсартай байдал;

-үзүүлэнт байдал;

-системт байдал;

-дэс дараат байдал;

-суралцагсдад ойлгомжтой байх;

-;гүн бат мэдлэг, чадвар, дадлагатай байх;

-сургалтад хамт олон ба нэг бүрчилсэн /ганцаарчилсан/ хандлагыг зөв хослуулах зэрэг болно.

Цэргийн сургалт нь бие бүрэлдэхүүн авьяас, бүтээлч санаачилгаа дээд зэргээр илрүүлэн гаргах таатай нөхцөл бүрдсэн тохиолдолд амжилтад хүрнэ. Мөн захирагч дарга нар нь цэрэг нэг бүрийн оюун ухаан, бие бялдрын бүх боломж, түүний сэтгэлзүйн хөгжлийн түвшин /хүртэхүй, сэтгэлгээ, ой, хэл яриа/ ба сэтгэлзүйн шинж

чанар /зан ааш, авир араншин, авьяас/-ыг бүх талаар харгалзан тооцож чаддаг болсноор амжилт гаргана[26].

Цэргийн сургалт нь цэргийн алба хаагчдыг энх цаг болон дайны үед үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, сахилга бат, бие бялдар, сэтгэл зүйн хувьд бэлтгэх тасралтгүй үйл ажиллагаа юм. Энэ нь цэргийн эрдэмд сургах, зэвсэг техник эзэмшүүлэх, эх оронч хүмүүжил олгох цогц бэлтгэл сургуулилт байна.

Цэргийн сургалт нь анхан шатны бэлтгэлээс эхлээд офицер, ахлагч нарын мэргэшүүлэх сургалт хүртэл шатлалтай явагддаг ба бие бялдар, сэтгэл зүйн тэсвэр хатуужил, сахилга бат, мэргэжлийн ур чадварыг хээрийн бэлтгэл, практик дадлагаар дамжуулан богино хугацаанд төлөвшүүлдэг цогц үйл ажиллагаа юм.

Зорилго: Суралцагчдыг мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэх, байлдааны үүрэг гүйцэтгэх чадвар, сэтгэл зүйн тэсвэр хатуужил суулгах.

Онолын үндэс: Цэргийн сурган хүмүүжүүлэх ухаан, байлдааны урлаг, сэтгэл судлалын шинжлэх ухаанд тулгуурладаг. Энэ нь цэргийн алба хаагчийн гүйцэтгэх ёстой ур чадвар, норм, стандартыг биелүүлэхэд чиглэнэ.

Арга зүй (Заах арга): Онол ба дадлагыг хослуулсан, ялангуяа практик дасгал, сургуулилт, буудлагын дасгалууд, бие бялдрын бэлтгэлжилтийн норматив суурилсан арга хэлбэрийг ашигладаг.

Бүтэц, бүрэлдэхүүн: Сургалтын төлөвлөлт, материаллаг бааз (сургалтын талбай, хилийн албаны боон ерөнхий цэргийн эрдмийн танхим, биеийн тамирын, гимнастикийн, жагсаалын талбай, саадтай зурвас г.м), багшлах бүрэлдэхүүн, суралцагчид гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

Сургалтын хэлбэр: Танхимын хичээл, нээлттэй хичээл, үзүүлэх хичээл, хээрийн сургуулилт, бүлгийн дасгал, харилцан туршлага солилцох уулзалтууд юм.

XXI зууны иргэдийн эзэмшсэн байвал зохих үндсэн чадваруудын нэг нь сурах чадвар гэдгийг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрч, үүнд гол анхаарлаа хандуулж байна.

Оросын их сэтгэл зүйч, гүн ухаантан Л.С.Выготский “Сургалт, оюун ухааны хөгжлийг зорилго, чиглэлтэй зохион байгуулалтайгаар удирдан чиглүүлснээр хүнд мэдлэг чадварыг эзэмшүүлэхэд үр дүнтэй сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны явцад илүү түргэн явагдана.

Өөрөөр хэлбэл хөгжлийг араасаа дагуулж байдаг сургалт хамгийн сайн сургалт болно”[27] гэж үзсэн.

“Сургалт гэдгийг сурах үйлийн нэр”[28], “Хилчдийн танин мэдэх үйл ажиллагаа, мэдлэг, дадлага чадварыг дээшлүүлэх тэднийг улсын хил хамгаалалтад хэрэгтэй бүхэнд сургах үйл ажиллагаа”, “Албаны сургалт гэж бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлжилт, хилийн анги, салбарууд, мөн тэдгээрийн удирдлагын нэгжүүдийн албан үүрэг гүйцэтгэлтийг сайжруулах, жигдрэлтийг хангах зорилготой, зохион байгуулалттай үйл ажиллагаа”, “Хил хамгаалалтын сургалт гэж ХЦ-ийн бие бүрэлдэхүүн улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, явуулах мэдлэг, чадвар, дадлага олгох, анги, салбаруудын бэлтгэл, бэлэн байдал, жигдрэлтийг хангахад чиглэсэн тодорхой зорилго, зохион байгуулалттай явуулж байгаа үйл ажиллагаа”[29] гэж тус тус томьёолсон байна.

[26] Монгол Улсын хилчний тайлбар толь. Уб.. 2003 он

[27] Выготский.Л.С. Теория интериорезация. М., 1932 он

[28] Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь.

[29] Хилчдийн нэр томьёоны тайлбар толь.

Мөн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн “Алсын хараа-2050” бодлого, баримт бичгийн 7 дугаар бүлгийн зорилт 7.2-т “Мэргэшсэн хилчний алба бэхэжсэн байна”, “Бүсчилсэн хил хамгаалалт” хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 5.3-т “Улсын хил хамгаалалтыг мэргэшсэн хилчнээр хамгаална” гэж тус тус заасан.

Цэргийн сургалт нь байнгын бүрэлдэхүүнийг бэлтгэх зорилгоор хичээл, секц, хээрийн дадлага, биеийн тамир зэрэг үндсэн хэлбэрүүдээр зохион байгуулагддаг. Сургалтад галын бэлтгэл, тактик, цэргийн дүрэм, гэртээ цэргийн албаны сургалтууд багтдаг.

Цэргийн сургалтын үндсэн хэлбэрүүд:

-Байнгын бие бүрэлдэхүүний сургалт: Анги байгууллага дээр хичээл, секц, дугуйлан хэлбэрээр тогтмол явагддаг.

-Хээрийн дадлага, сургууль: Байлдааны бодит нөхцөл байдалд ойртуулан, хээрийн нөхцөлд зохион байгуулагддаг.

-Бие бялдрын бэлтгэлжилт: Цаг үеийн болон спорт-нийтийн биеийн тамирын арга хэмжээ.

-Симулятор ба технологийн сургалт: Лазер буудлага гэх мэт орчин үеийн технологид суурилсан дадлага.

Цэргийн сургалтын гол онцлог:

Хээрийн бэлтгэл дадлага: Цэргийн хүний үндсэн хөдөлмөр нь хээрийн бэлтгэл сургуулилт бөгөөд танхимын онолын мэдлэгийг дадлагаар баталгаажуулж, бодит нөхцөлд сургадаг.

Сахилга бат, сэтгэл зүй: Цэргийн сургалт нь чанд сахилга бат, тэсвэр хатуужил, манлайлах ур чадвар болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийг нэгэн зэрэг хангадаг.

Мэргэжлийн ур чадвар: Суралцагчид хилийн алба, зэвсэглэл, тактикийн ур чадварыг эзэмшиж, техник хэрэгслийг чадамгай ашиглаж сурдаг.

Мөн онол-дадлагын нэгдэл, цэргийн эрдэм (тактик, зэвсэг эзэмшилт), манлайлал болон багийн ажиллагааг нэн тэргүүнд тавьдаг онцлогтой байна.

Цэргийн сургалт нь зөвхөн цэргийн эрдэм эзэмшүүлэхээс гадна эх оронч үзэл, багийн ажиллагаа, эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийг дэмждэг.

Цэргийн сургалтын үндсэн бүрэлдэхүүн:

Онолын мэдлэг, цэргийн дүрэм журам.

Хээрийн бэлтгэл: Дадлага, зэвсэг техник эзэмших чадвар.

Хүч чадал, тэсвэр хатуужил.

Сэтгэл санааны хат суух, хариуцлага ухамсарлах.

Цэргийн сургалт нь уламжлалт нүүдэлчин ахуйн хатуужил, дайчин уламжлал дээр суурилан, орчин үеийн зэвсэгт хүчний шаардлагад нийцүүлэн инновац, технологи, бие бялдар болон сэтгэл зүйн бэлтгэлийг нэгтгэн хөгжиж байна.

Сүүлийн үеийн чиг хандлага нь олон улсын энхийг дэмжих ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх, нисгэгчгүй төхөөрөмж ашиглах зэрэг мэргэжлийн ур чадварыг олгоход чиглэж байна.

Сургалтын үндсэн чиглэлүүд:

1. *Галын бэлтгэл:* Зэвсэг эзэмшилт, буудлагын ур чадвар.
2. *Тактикийн бэлтгэл:* Салбар нэгжийн байлдааны ажиллагаа.
3. *Бие бялдрын бэлгэлжилт:* Бие бялдар, тэсвэр хатуужил.
4. *Цэргийн дүрэм:* Алба хаагчийн сахилга бат.
5. *Үй олноор хөнөөх зэвсгийн бэлтгэл:* Хорт бодисоос хамгаалах.

Сургалтууд нь танхимын болон хээрийн хэлбэрээр, орчин үеийн цэргийн симулятор, лазер буудлагын төхөөрөмж ашиглан явагддаг.

Хээрийн бэлтгэл: Цэргийн хүний үндсэн хөдөлмөр болох хээрийн гаралт, байгаль цаг уур, газар орны онцлог нөхцөлд дадлага хийх.

Штабын бэлтгэл: Удирдах албан тушаалтнуудын чадавхыг нэмэгдүүлэх заах арга зүйн цугларалтууд.

Сэтгэл зүйн бэлтгэл: Суралцагчдыг биеийн болон сэтгэл зүйн ачааллыг даах чадвартай болгох.

Цэргийн сургалт нь бие бүрэлдэхүүний байлдааны бэлэн байдал, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа бөгөөд үндсэн төрөлд хугацаат цэргийн алба хаагчдын сургалт, гэрээт цэргийн сургалт, офицер, ахлагчийн давтан болон мэргэшүүлэх сургалт, оюутан цэрэг хөтөлбөр, цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн сургалт ордог. Сургалтыг галын бэлтгэл, тактик, бие бялдар, дүрмийн гэсэн чиглэлүүдээр зохион байгуулдаг.

Цэргийн сургалтын үндсэн төрлүүд:

-*Албаны сургалт ба бэлтгэл:* Хугацаат цэргийн алба хаагчид болон гэрээт цэргүүдэд зориулсан байлдааны үндсэн сургалт.

-*Цэргийн мэргэжил олгох сургалт:* Энгийн мэргэжлээр их, дээд сургууль төгссөн албан хаагчдыг хамруулдаг.

-*Офицер, ахлагчийн давтан ба мэргэшүүлэх сургалт:* Цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургагч багш, штабын мэргэжилтнүүдийн сургалт.

-*Албаны нохойн сургалт:* Хилийн эрлийн болон хилийн манаанды чиг үүргийн албаны нохой, тэдгээрийн сургагч, хөтлөгчийг бэлтгэх.

Цэргийн сургалт нь хээрийн сургууль, цогцолбор сургалтын дадлага, технологийн шинэчлэл, сэтгэл зүйн тэсвэр хатуужил, бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн нэгдсэн тогтолцоо юм. Үүнд мэргэжлийн багшлах боловсон хүчин, сургалтын орчин, хөтөлбөрийн агуулга, болон нийгмийн баталгаа, урамшууллын систем чухал нөлөө үзүүлнэ.

Цэргийн сургалтын тогтолцоо нь зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг дайнд бэлэн байлгах, мэдлэг, ур чадвар, сахилга батыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн онол, дадлага, бүтэц зохион байгуулалтын нэгдмэл цогц үйл ажиллагаа юм. Энэхүү тогтолцоо нь цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, удирдлагын ур чадварыг сайжруулах, байлдааны бэлтгэлийг хангах зорилготой.

Цэргийн сургалтын тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд:

-*Албаны сургалт, бэлтгэл:* Салбар, нэгжийн хэмжээнд мэдлэг, ур чадварыг сайжруулах, байлдааны тактикийн бэлтгэл хийх.

-*Мэргэжлийн болон тусгай сургалт:* Ахлагч, офицер нарын гүйцэтгэх тактикийн мэдлэгийг дээшлүүлэх, дадлагажуулах.

Тогтолцооны онцлог:

-*Тасралтгүй чанар:* Сургуулийн жилийн туршид төлөвлөгөөт сургалт, бэлтгэлийг тогтмол явуулдаг.

-*Уялдаа холбоо:* Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө нь нэгдсэн нэг бодлогоор хэрэгждэг.

-*Шинэчлэл:* Цэргийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сургалтын арга зүй, шалгалтын тогтолцоог байнга шинэчилдэг.

Цахимжуулалт: "e-mongolia" зэрэг системээр дамжуулан сургалтын бүртгэлийг илүү нээлттэй болгосон.

Цэргийн сургалтын тогтолцоо нь зөвхөн анхан шатны мэдлэг олгох биш, харин цэргийн алба хаагчдыг мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэж, улс орны аюулгүй байдлыг хангах чадвартай бие бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд оршдог.

Монгол Улсын цэргийн сургалтын тогтолцоо нь хугацаат цэрэг төвтэй тогтолцооноос мэргэжлийн, байнгын бүрэлдэхүүн төвтэй сургалт руу шилжсэн. Энэ нь анги салбаруудын бэлэн байдал, штабын бэлтгэл, бие бүрэлдэхүүний мэргэшсэн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн цогцолбор шалгалт, хяналтын системийг агуулдаг.

Цэргийн сургалтын тогтолцооны онцлог:

-Байнгын бүрэлдэхүүний сургалт: Офицер, ахлагч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургагч багш нарыг бэлтгэхэд түлхүү анхаардаг.

-Шинэчилсэн шалгалт: Зэвсэгт хүчний Жанжин штаб (ЗХЖШ)-аас ангиудын үүрэг гүйцэтгэх чадавхыг цогцолбор шалгалтаар үнэлдэг.

-Сургуулийн жил: Цэргийн сургалт бэлтгэл нь жилийн турш төлөвлөгөөний дагуу явагдаж, 01 дүгээр сард "Сурган зааварлах арга зүй" сургалт болдог.

-Агуулгын өөрчлөлт: Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсронгуй болгож, мэргэжлийн цэрэг бэлтгэхэд чиглэж байна.

Тогтолцоо: ХЦ-ийн Сургалтын цогцолбор, хилийн отряд, тусгай анги, хилийн цэргийн салбар, салбаруудад сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явагддаг.

Олон талт сургалт: Офицер, ахлагч нарын мэргэшүүлэх сургалт, жолооны болон нохойн сургалтын мэргэжил олгох сургалт зэрэг төрөлжсөн хэлбэрүүдтэй.

Дадлагад суурилсан: "Танхимын хичээлээр цэргийн эрдэмд шамдан, онолын мэдлэгээ дадлагаар баталгаажуулах" зарчим.

Практик ач холбогдол: Цэргийн хөдөлмөр хүнд, эрсдэлтэй тул онолын мэдлэгээ дадлагаар баталгаажуулж, байлдааны зэвсэглэлийг чадамгай эзэмшихэд чиглэдэг.

Хяналт, үнэлгээ: Сургалтын үр дүнг сургуулийн жилд хүн нэг бүр, тасаг, салаа, застав, салбар, анги, отрядоор тогтмол шалгаж, дүгнэж үнэлдэг.

Шинэчлэл: Хилийн цэргийн сургалт, бэлтгэлийн бодлого, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн сургалтын агуулгыг шинэчилдэг.

Цэргийн сургалтын тогтолцооны гол бүрэлдэхүүн хэсгүүд:

Нэгдсэн тогтолцоо: ХЦ-ийн Сургалт бэлтгэлийн газар, хэлтсийн удирдлагууд болон хилийн отряд, тусгай ангиудын сургалт, цэргийн албаны зохион байгуулалтын тасгийн уялдааг хангасан, 1 жилийн (жишээ нь, 2024-2026) хөтөлбөр төлөвлөгөөтэй.

Төрөлжсөн сургалтууд: ХХБ-ын хилийн отряд, тусгай ангийн гэх мэт мэргэшүүлэх болон давтан сургалтууд.

Заах арга зүйн цугларалт: Удирдах бүрэлдэхүүн, офицер, ахлагч нарын сургах ур чадварыг дээшлүүлэх, сургалтын журам, заавар, төлөвлөгөөг нэгдсэн ойлголтод хүргэх.

Хээрийн гаралт, цогцолбор сургалтын дадлага: "Цэргийн хүний үндсэн хөдөлмөр" гэгддэг, бодит орчинд чадваржуулах практик сургалт.

Цэргийн сургалт нь ХЦ-ийн албаны бэлэн байдал, чадавхыг дээшлүүлэх гол хүчин зүйл юм.

Цэргийн сургалтад нөлөөлөх гол хүчин зүйлүүдийг дараах байдлаар ангилж болно:

Хээрийн бэлтгэл сургуулилт: Цэргийн хүний үндсэн хөдөлмөр нь хээрийн гаралт, цогцолбор сургуулийн дадлага бөгөөд бодит байдалд ойртуулсан нөхцөлд тактикийн ур чадварыг эзэмшүүлдэг.

Технологийн шинэчлэл: ХЦ-ийн хэрэгцээнд симулятор[30], орчин үеийн зэвсэглэл, техник, дотоодын радиостанцыг нэвтрүүлж, сургалтыг технологийн чиглэл рүү шилжүүлж байна.

Сэтгэл зүйн тэсвэр хатуужил: "Сэтгэл зүйн дархлаа" буюу эрсдэлийг таних, асуудлыг зохицуулах чадварыг хөгжүүлэх (resilience building) сургалт нь чухал хүчин зүйл болдог.

Мэргэжлийн багшлах боловсон хүчин: Сургалтын хөтөлбөрийн агуулга, заах арга зүйг тодорхойлогч мэргэжлийн офицер, ахлагч нарын ур чадвар.

Сургалтын орчин, материаллаг бааз: Сургалтын танхим, хээрийн байрлал, цогцолбор сургалтын төв зэрэг материаллаг баазын хангалт.

Нийгмийн баталгаа: Алба хаагчдын мэргэжлийн бахархлыг дэмжих, урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулах бодлого.

Эдгээр хүчин зүйлүүд нь цэргийн алба хаагчдыг чадварлаг, сэтгэл зүйн бэлтгэлтэй, мэргэжлийн боловсон хүчин болгон төлөвшүүлэхэд чиглэдэг.

Цэргийн сургалтын арга. Цэргийн сургалтын арга нь бие бүрэлдэхүүний байлдааны ур чадвар, сахилга бат, онолын мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн, онол болон практикийг хослуулсан системтэй үйл ажиллагаа юм. Үүнд бие даан сурах, хээрийн сургууль, танхимын хичээл, норм нормативын бэлтгэл, туршлага солилцох зэрэг аргууд багтдаг бөгөөд суралцагчдын идэвх, ухамсарт үндэслэдэг.

Цэргийн сургалтын үндсэн аргууд:

-Дадлага сургуулилт (Хээрийн сургалт): Байлдааны техник, зэвсэгтэй харьцах, тактикийн ур чадварыг бодит орчинд (хээрийн сургуулилт) эзэмшүүлэх.

-Танхимын хичээл: Цэргийн дүрэм, онол, хууль эрх зүй, соён гэгээрүүлэх мэдлэг олгох.

-Бие даан суралцах: Цэрэг, алба хаагч өөрийн мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх.

-Норм нормативын биелэлт: Зэвсэг техник задлах, угсрах, байрлалаа эзлэх зэрэг үйлдлийг хугацаатайгаар гүйцэтгэж, чадамжийг шалгах.

-Сурган зааварлах арга зүй: Удирдах албан тушаалтнууд (захирагч нар) бие бүрэлдэхүүндээ зааварчилгаа өгөх, сургах чадварыг дээшлүүлэх.

Сургалтын зохион байгуулалт:

-Төлөвлөлт: Сургалтыг ХЦ-ийн Сургалт хөтөлбөрийн дагуу явуулдаг.

-Сургалтын орчин: ХЦ-ийн Сургалтын цогцолбор болон хилийн тусгай анги, салбаруудын сургалтын төвүүдэд сургалтыг зохион байгуулдаг.

Үнэлгээ: Сургалтын чанар, үр дүнг улирал, жилээр буюу сургуулийн төгсгөлд хяналт шалгалт, нормативын биелэлт, бие бялдрын шалгуур үзүүлэлт зэргээр ангийн захирагчийн болон командлагчийн нэрэмжит шалгалтуудаар шалгаж үнэлдэг

Цэргийн сургалт нь байлдааны бэлэн байдлыг хангах, орчин үеийн зэвсэгт мөргөлдөөний онцлогт тохируулан бие бүрэлдэхүүнийг бэлтгэхэд чиглэсэн нэгдсэн системтэй байна.

Цэргийн сургалтын арга нь бие бүрэлдэхүүнд цэргийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, бие бялдрын бэлтгэлжилтийг эзэмшүүлэх, сэтгэл зүйн тэсвэр хатуужил олгох цогц үйл ажиллагаа юм. Үүнд практик дадлага, сургалт-дадлагын төвүүдийн

[30]Симулятор (англиар: Simulator) гэдэг нь бодит амьдрал дээрх үйл явц, систем, машин механизм, эсвэл орчныг хиймэл аргаар (ихэвчлэн компьютер, программ хангамж, эсвэл механик төхөөрөмж ашиглан) дуурайлган үзүүлдэг төхөөрөмж эсвэл программыг хэлнэ.

сургуулилт, байлдааны буудлага, марш, зөвлөн туслах арга зүй, андрогог[31] зарчмыг хослуулан ашигладаг.

Цэргийн сургалтын үндсэн арга, хэлбэрүүд:

-*Практик дадлага:* Цэргийн анхан шатны болон мэргэжлийн ур чадварыг (буудлага, жолоодлого гэх мэт) бодит техник дээр эзэмшүүлэх үндсэн арга.

-*Тактик сургуулилт:* Салбар, нэгжийн хэмжээнд байлдааны үүрэг гүйцэтгэх тактикийн ур чадварыг хээрийн нөхцөлд давтах.

-*Зөвлөн туслах арга зүй:* Офицер, ахлагч нар өөрийн харьяа бие бүрэлдэхүүнийг сургах, зааварлах, сурган хүмүүжүүлэх.

-*Марш ба бие бялдрын бэлтгэл:* Өдөр тутмын секц, дугуйлан, маршийн үнэлгээгээр дамжуулан цэргийн алба хаагчийн бие бялдрын тэсвэр хатуужлыг нэмэгдүүлэх.

-*Андрогог зарчим:* Насанд хүрэгчдийн сэтгэл зүйн онцлогт тохируулан, харилцан суралцах, кэйст суурилсан сургалтын арга зүй.

Сургалтын менежмент:

Сургалтын хөтөлбөр нь цэргийн алба хаагчийн мэргэжлийн ур чадвар, норм нормативыг биелүүлэх стандартыг хангасан байна.

ХЦ-ийн штаб нь ХХЕГ-ын штаб болон хилийн отряд, тусгай анги, салбаруудын штабууд сургалтын бодлого, төлөвлөлт, хяналт шалгалтыг зохион байгуулдаг.

Сургалтыг ур дүнтэй болгохын тулд орчин үеийн сургалтын материаллаг бааз, техник хэрэгслийг ашигладаг.

Цэргийн сургалтын мөн чанар нь бие бүрэлдэхүүнд байлдааны онолын мэдлэг олгох, мэргэжлийн ур чадвар, сэтгэл зүйн тогтвортой байдлыг төлөвшүүлэх, дүрмийн дагуу хамтран ажиллах, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн цогц үйл явц юм. Энэ нь зэвсэгт хүчний тактикийн бэлтгэл, галт зэвсгийн аюулгүй ажиллагааг хангах, байлдааны өндөр чадварыг тасралтгүй дээшлүүлэхэд оршдог.

Цэргийн сургалтын үндсэн агуулга, мөн чанар:

-*Тактикийн ур чадвар:* Ямар ч мэргэжлийн анги, байгууллагын үндэс нь тактик бөгөөд ерөнхий цэргийн тактикийг эзэмшүүлэх.

-*Мэргэжил, дадлага олгох:* Хугацаат цэргийн алба хаагчдад мэргэжлийн үнэмлэх гардуулах, зэвсэг техникийг эзэмшүүлэх.

-*Сэтгэл зүйн хариуцлага:* Сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, буудлагын заавар, аюулгүй ажиллагааг чанд мөрдөх хариуцлагыг төлөвшүүлэх.

-Дүрэм: Дүрмийн дагуу харьцах соёл, багийн ажиллагаанд суралцуулах.

Цэргийн сургалтын агуулга нь цэргийн алба хаагчдын онолын мэдлэг, байлдааны ажиллагаанд бэлтгэж чадвар, ёс зүйг хөгжүүлэх, мэргэшүүлэх, тэдэнд бие бялдар, сэтгэл зүйн тэсвэр хатуужил олгох, техник хэрэгсэл эзэмшүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа юм. Үүнд тактик, галын бэлтгэл, инженерийн бэлтгэл, биеийн тамир, цэргийн дүрэм болон тусгай мэргэжлийн ур чадварууд, ёс суртахуун, соён гэгээрүүлэх ажлууд багтдаг бөгөөд сургалтын орчин бүрдүүлж, сургалтыг улирал, жилийн төлөвлөгөөгөөр онол, дадлага хослуулан стандартчилсан нормативын дагуу явагддаг.

Сургалтын үндсэн агуулга:

-*Тактикийн бэлтгэл:* тусгай томилгоот бүлэг, хилийн харуул, застав, отрядын түвшинд хээрийн сургуулилт, байлдааны ажиллагааг зохион байгуулах.

[31]Андрогог гэдэг нь насанд хүрэгчдийг сургах, хөгжүүлэх онол, арга зүйг (андрагогика) эзэмшсэн мэргэжилтэн юм.

-*Галын бэлтгэл:* Зэвсэг техник эзэмших, буудлагын дадлага хийх.

-*Техникийн болон инженерийн бэлтгэл:* Зэвсэглэл, техникийг ажиллуулах, засварлах, бэхлэлт хийх.

-*Цэргийн дүрмүүд, эрх зүй:* Цэргийн албаны дүрмүүд, хууль тогтоомжийн мэдлэг.

-*Биеийн тамир, гардан тулаан:* Бие бялдрын тэсвэр хатуужил, тулааны урлаг.

-*Тусгай мэргэжлийн сургалт:* Холбоочин, жолооч, инженер, эмнэлгийн мэргэжилтэн гэх мэт мэргэжлийн чиглэлээрх нарийвчилсан мэдлэг.

-*Бие бялдар, сэтгэл зүй бэлтгэл:* Өндөр тэсвэр хатуужил, стресс зохицуулалт, бие хамгаалах урлаг, тусгай норм нормативыг биелүүлэх чадвар.

Сургалтын агуулгын онцлог:

-*Стандартчилал:* Сургалтын хөтөлбөр, норм норматив нь хууль, тушаалаар баталгаажсан байдаг.

-*Тасралтгүй чанар:* Цэргийн алба хаах хугацаанд, офицер, ахлагч нарын түвшинд үргэлжилдэг.

-*Дадлагад суурилсан:* Онол мэдлэгийг хээрийн сургууль, бодит байлдааны техник ашиглан баталгаажуулдаг.

Цэргийн сургалтын төлөвлөлт нь ХЦ-ийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу “ХЦ-ийн Сургалт хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах цогц үйл ажиллагаа юм. Үүнд ХЦ-ийн штаб, газар, хэлтэс, хилийн отряд, тусгай анги, салбаруудын төлөвлөлт болон тусгай хөтөлбөрөөр зохион байгуулдаг сургалтын арга хэмжээнүүд зэрэг болно.

Цэргийн сургалтын төлөвлөлтийн үндсэн чиглэлүүд:

- ХЦ-ийн Сургалтын нэгдсэн цогцолбор, хилийн отряд, тусгай ангиудын сургалтын төвүүд, материаллаг бааз зэрэг нь сургалтын хөтөлбөрийн дагуу цаг, сэдвийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ур чадварыг дээшлүүлдэг.

-*Сургалтын хэлбэр:* Төлөвлөлт нь онол, дадлага, шалгалт, түвшин тогтоох гэсэн хэлбэрээр явагдаж, хээрийн сургалтын төвд мэргэжлийн сургалтыг зохион байгуулдаг.

Цэргийн сургалтын зохион байгуулалт нь ХЦ-ийн штабын бодлогоор, үндсэн бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн алба хаагчдыг бэлтгэхэд чиглэсэн цэргийн ерөнхий, мэргэжлийн болон бие бялдрын бэлтгэлжилтийн сургалтуудыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явуулах системтэй үйл ажиллагаа юм.

Цэргийн сургалтыг чанартай зохион байгуулах нь офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдын бие бялдар, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлж, албаны бэлэн байдлын бэлтгэлжилтийг хангахад чухал үүрэгтэй.

Сургалт нь зөвхөн мэдлэг олгох бус, практикт хэрэглэх, албаны бэлэн байдлыг хангах тогтолцоо билээ.

Цэргийн сургалтын гол хэлбэрүүд ба зохион байгуулалт:

-*Төлөвлөлт ба бодлого:* ХЦ-ийн штабын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсээс сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, сургалтын арга барилыг сайжруулах "Сурган зааварлах арга зүй"-г офицер, ахлагч нарт заадаг.

-*Хугацаат цэргийн алба хаагчдын сургалт:* Хилийн отряд, тусгай анги, салбарын хэмжээнд цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр албаны сургалт, бэлтгэлийг тогтмол явуулдаг.

-*Биеийн тамирын бэлтгэл:* Байнгын бүрэлдэхүүний дунд секц дугуйлан, марш, бие бялдрын ерөнхий бэлтгэлжилтийг шалгах, хүнд дасгал сургуулилтаар мэргэжлийн багш, офицерын удирдлага дор зохион байгуулдаг.

-*Олон улсын хамтарсан сургалт:* ОХУ, БНХАУ-ын ХЦ-ийн командлалтай хамтран тодорхой сэдвээр хээрийн сургуулийг зохион байгуулдаг бөгөөд олон улсын энхийг сахиулах ажиллагаанд хилчин офицер, ахлагч, цэрэг дайчид оролцдог. Мөн ОХУ, БНХАУ, АНУ, Энэтхэг зэрэг улс орнуудын цэргийн академи, их, дээд сургуулиуд болон жил, хагас жил, улирал, сарын хугацааны дээд курс, дамжаануудад сургадаг.

Дүгнэлт. Хязгаарын цэргийн үүсэн байгуулагдах үеийн цэргийн сургалт 1933-1953 оныг хамаарч байсан бөгөөд Дотоодыг хамгаалах газрын цэргийн бөгөөд хязгаарын цэргийн харьяанд жагсаалын тасаг, хилийн ангиудад жагсаалын туслахууд цэрэг дайчдад цэргийн сургалт, галын бэлтгэлийн сургалтыг голчлон явуулдаг байсан нь 1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайн, 1940-1948 оны баруун хилийн тулгаралтуудад цэрэг дайчдыг дайсантай хэрхэн тэмцэх, дайсныг устгах арга ажиллагаанд чиглүүлэн цэргийн сургалтыг зохион байгуулж ирсэн байна.

Дэлхийн II дайн дуусаж, 1950 онд БНМАУ, БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосноор улсын хил дээрх дайн, тулгаралт намжиж төр засгаас Монгол, Хятадын хилийн дагуу улсын хилийг хамгаалж байсан хилийн 12 анги, 135 хилийн салбарыг татан буулгаж, 1953-1967 онуудад “Хилийн пункт” болгон өөрчилсөн. Хилийн пунктэд офицер 1, ахлагч 3, ХЦАХ 10-12 байсан бөгөөд цэргийн сургалт үндсэндээ зогсонги байдалд орж, гагцхүү улсын хилийг зөрчилгүй байлгахад бүх хүч хэрэгслээ зориулж байжээ.

Харин 1960-аад оны дунд үеэс эхлэн ЗСБНХУ, БНХАУ-ын удирдагчдын улс төрийн зөрчил, үл итгэлцэл, сөргөлдөөнт байдал нь Зүүн хойд Азийн бүс нутгийн цэрэг, улс төрийн байдлыг эрс хурцатгасан. ЗХУ нь социалист лагерийн орнуудыг тэргүүлэн манлайлж, улмаар цэргийн хүч хэрэгслээ манай улсын өмнөд хилийн дагуу шилжүүлэн байршуулж эхэлсэн билээ. Иймд манай улсын зүгээс хил хязгаарын халдашгүй дархан байдлаа сахин хамгаалахын тулд 1967 онд улс төрийн товчооны 25 дугаар тогтоолоор Хязгаарын ба Дотоодын цэргийн хэрэг эрхлэх газрыг дахин байгуулж, тус газрын штабын харьяанд байлдааны бэлтгэл сургуулийн хэлтэс, хилийн ангиудад байлдааны бэлтгэл сургуулийн тасаг, хилийн салбарт байлдааны бэлтгэл сургуулийн орлогч хэмээх нэгж, албадууд цэргийн сургалтыг зохион байгуулан удирдаж байсан. Эдгээр газар, хэлтэс, тасаг нь хилчдэд зөвхөн “Байлдаанд хэрэгтэй” бүхнийг зааж сургах нам, улс төрөөс даалгасан үүргийг хэрэгжүүлж байсан бөгөөд 1967-1990 оны үеийн цэргийн сургалтыг хүйтэн дайны үеийн сургалт гэж дүгнэж болохоор байна.

Монгол Улсад 1990 онд ардчилсан хувьсгал өрнөж, НАХЯ-ыг татан буулгаснаар Хилийн ба ДЦХУГ-ыг УАБХЕГ-ын харьяанд Хилийн цэрэг хэмээн нэрлэх болсон. Тухайн үед улс орон нэг намын тогтолцооноос олон намын, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжсэн нь цэргийн сургалтанд хэд хэдэн сөрөг нөлөөллийг бий болгосон юм. Тухайлбал. нэгдүгээрт. цэргийн мэргэжил боловсролтой офицер 1990 оноос хойш олноор цомхотголд орох, сайн дураараа халагдан наймаа арилжаа хөөх болсон; хоёрдугаарт: ХЦАХ-ын цэргийн алба хаах хугацааг 1 жил болгосон; гуравдугаарт: сургалтад шаардлагатай ном, сурах бичиг, гарын авлага, заах аргын зөвлөмж зэргийг боловсруулах хэвлүүлэх, хангах талаар ажил эрс багассан; дөрөвдүгээрт: цэрэгт ирж буй залуусын 15 орчим хувь бүрэн

дунд, 50 орчим хувь бүрэн бус дунд, 40 хувь нь бага боловсролтой буюу бичиг үсэг үл мэдэгчид байсан зэрэг болно.

Энэ үед цэргийн сургалт нь улсын хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэн явагддаг байсан бөгөөд ХЦ-ийн штабын харьяанд сургалтын хэлтэс, хилийн отряд, ангиудад сургалтын тасаг, хилийн цэргийн салбар, салбаруудад сургалт эрхэлсэн орлогч зэрэг алба, албан тушаалтнууд тус тус зохион байгуулж, удирдан ажиллаж байсан.

Ашигласан материал:

Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хууль. Уб., 2016
Алсын хараа-2050 бодлого, баримт бичиг.
Хилчдийн нэр томьёоны тайлбар толь.
Байлдааны дүрэм 100.
Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь.

ХИЛИЙН ЦЭРГИЙН “ЦЭРГИЙН АЛБАНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ”-Д ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

А.АМГАЛАНБАЯР*
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн тэнхим, дэд профессор, дэд хурандаа

**хариуцлагатай зохиогч: amgalanbayar.uia@gmail.com*

Хураангуй: Цэргийн алба хаагчийн цэргийн албаны үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн баталсан “Цэргийн нийтлэг дүрэм”-ээр зохицуулахаар хуульчилсан (Цэргийн албаны эрх зүйн байдлын тухай хууль, 2016) байна.

Монгол Улсын цэргийн нийтлэг дүрэм, Зэвсэгт хүчний жанжин штабын цэргийн албыг зохион байгуулах журмыг үндэслэн Хил хамгаалах байгууллагын цэргийн албыг зохион байгуулах журам боловсруулан 2023 оноос одоог хүртэл хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд сүүлийн 5 жилд гарсан гэмт хэрэг, сахилгын зөрчлийн судалгаанаас авч үзэхэд 70 хувь нь Цэргийн албаны зохион байгуулалт алдагдсанаас анги, салбарт сахилгын зөрчил гарсан, цэргийн дүрэм, цэргийн албыг зохион байгуулах журмыг хэрэгжүүлээгүйгээс харуул, хоногийн манааны үүрэг гүйцэтгэлт, сонор сэрэмж сулардаг зэргээс үүдэн дээрх сэдвийг судлах үндэслэл болсон.

Энэ асуудал нь ялангуяа төвийн бүсийн хилийн цэргийн ангиудын байрлаж буй байршил, гүйцэтгэж байгаа үүрэг, бүтцээс шалтгаалаад харилцан адилгүй явагддаг тул нэгдсэн цэргийн албыг зохион байгуулах журмаар зохицуулах боломжгүй юм.

Иймд Хил хамгаалах байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, сахилгын зөрчил, харуул, хоногийн манааны үүрэг гүйцэтгэлт, ангийн аюулгүй байдлыг хангах асуудал нь бүхэлдээ цэргийн албаны зохион байгуулалттай холбоотой тул Хил хамгаалах байгууллагад цэргийн албыг зохион байгуулах асуудлыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзсэн.

Түлхүүр үгс: Хилийн цэрэг, цэргийн алба, зохион байгуулалт, хил хамгаалалт, шинжилгээ, шинэчлэл

УДИРТГАЛ

Монгол Улсын хил 8252.658 километр үргэлжилдэг бөгөөд манай улс Евроазийн эх газрын төв хэсэгт, хоёр их гүрэн болох Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хиллэдэг геополитикийн онцгой байрлалтай.

Энэхүү нөхцөл байдал нь хил хамгаалалтыг зохион байгуулахад харилцан адилгүй бүс нутгийн онцлогт тохируулан зохион байгуулах шаардлага үүсдэг.

Улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах үндсэн үүргийг хуулиар Хил хамгаалах байгууллага хариуцдаг бөгөөд тус байгууллага нь зөвхөн улсын хилд үүрэг гүйцэтгэхээс гадна хууль бус наймаа, хил дамнасан гэмт хэрэг, хүн амын хөдөлгөөнтэй холбоотой эрсдэл, кибер болон терроризмын шинжтэй шинэ аюул заналтай тэмцэх чадавх шаарддаг болж байна.

Судалгааны зорилго: Төвийн бүсийн хилийн цэргийн ангиудын албаны зохион байгуулалт, харуул, хоногийн манааны үүрэг гүйцэтгэлтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, гадаадын улс орнуудын туршлага, сургамжаас судлах, цаашид

сахилга, хариуцлагыг дээшлүүлэх гадаад, дотоод аюулаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах арга замыг эрэлхийлэхэд оршино.

Судалгааны зорилт, үндэслэл

-Цэргийн албa, албаны зохион байгуулалтын ойлголт, ач холбогдлын талаар;

-Хилийн цэргийн албаны үйл ажиллагаа, түүнийг зохион байгуулж буй өнөөгийн байдал, мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журамд дүн шинжилгээ хийх;

-Бусад төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын албаны зохион байгуулалтад харьцуулсан судалгаа хийх;

-Цэргийн албыг зохион байгуулах журмыг боловсронгуй болгох санал, зөвлөмж дэвшүүлэх үндсэн зорилттой.

Судалгааны арга зүй

Энэхүү өгүүлэлд дараах арга зүйг ашигласан:

-Баримт бичгийн шинжилгээ: Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын цэргийн дүрэм, Хил хамгаалах байгууллагын цэргийн албыг зохион байгуулах журмыг судлав.

-Харьцуулсан шинжилгээ: Төрийн цэргийн байгууллагын Цэргийн албыг зохион байгуулах журамтай харьцуулж үзсэн.

-Чанарын дүн шинжилгээ: Албаны зохион байгуулалтын давуу ба сул талыг шинжилсэн.

Судалгааны ажлын шинэлэг тал:

Төвийн бүсийн хилийн цэргийн ангиудын албаны зохион байгуулалтад хийсэн дүн шинжилгээний үр дүнд ангийн гүйцэтгэж байгаа үүрэг, бүтцээс шалтгаалан өөр өөрсдийн онцлогт тохирсон журмыг хэрэгжүүлснээр сахилга хариуцлага дээшилж, гадаад, дотоод аюулаас урьдчилан сэргийлж чадна гэж үзэж байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Нэг. Цэргийн албаны зохион байгуулалтын онолын үндэс

Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн Эх орноо хамгаалах, хуулийн дагуу Цэргийн алба хаах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ (Монгол Улсын Үндсэн хууль, 1992).

“Цэргийн алба” гэж зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхыг хэлнэ (Цэргийн албаны тухай хууль, 2016) гэж байна.

Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/107 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн сургалтын хөтөлбөр”-т “Цэргийн албаны зохион байгуулалт” гэдэг ойлголт нь аливаа цэргийн байгууллагын бүтэц, удирдлагын тогтолцоо, бие бүрэлдэхүүний үүргийн хуваарилалт, алба гүйцэтгэлийн зохион байгуулалт, дэг журам, сахилга бат зэрэг цогц үзэгдлийг хамардаг.

Онолын хувьд энэхүү зохион байгуулалт нь дараах үндсэн зарчимд тулгуурладаг.

Нэгдмэл удирдлага. Цэргийн байгууллага нь нэг төвөөс удирдлагатай, шатлан захирах тогтолцоонд тулгуурлана. Энэ нь үүрэг гүйцэтгэлийн уялдаа холбоог хангаж, сахилга бат, захиргааны чадавхыг баталгаажуулдаг.

Тасралтгүй ажиллагаа. Хил хамгаалалт нь улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа учир тасралтгүй, хоногийн 24 цагийн хугацаанд үүрэг гүйцэтгэнэ.

Үүргийн тодорхой байдал. Цэргийн албаны бүтэц доторх нэгж бүрийн үүрэг, хариуцлага тодорхой байж, давхардал, хэтрэлтгүй байх зарчмыг баримтална.

Уян хатан чанар. Аюулгүй байдлын орчны өөрчлөлт, шинэ төрлийн эрсдэлд тохируулан зохион байгуулалтад уян хатан байдлыг хангах шаардлагатай.

"Цэргийн албаны тухай хууль"-д "цэргийн албаны зохион байгуулалт" гэсэн нэр томьёо шууд гараагүй боловч, хуулийн бүтэц доторх заалтуудыг нэгтгэн ойлгож болно. Үндсэндээ цэргийн алба ямар хэлбэртэй, хэрхэн дэг журамтай, ямар байгууллагаар дамжуулан зохион байгуулагддаг вэ гэдгийг хуульд нарийвчилж өгсөн байдаг.

Хуульд түшиглэн ойлгож болох агуулга:

- хугацаат цэргийн алба- иргэд тодорхой хугацаанд цэргийн алба хаах хэлбэр
- гэрээт цэргийн алба- гэрээний үндсэн дээр, урьдчилан тохирсон хугацаанд алба хаах хэлбэр
- бэлтгэл алба- анги, салбарын тусгай бэлтгэлд хамрагдах, шаардлагатай үед цэргийн үүрэг гүйцэтгэх хэлбэр.

Энэ нь цэргийн албаны зохион байгуулалтын үндсэн хэлбэрүүд юм.Цэргийн байгууллагын бүтэц, харьяалал нь Зэвсэгт хүчин болон бусад төрийн цэргийн байгууллагаар дамжин хэрэгждэг. (Цэргийн албаны тухай хууль, 2016)

Өөрөөр хэлбэл, албыг ямар байгууллагаар дамжуулж, хаана гүйцэтгэхийг хууль тогтоож гэж ойлгож болох юм.

Цэргийн албан хаагчийн үндсэн үүрэг, эрх, сахилга бат, дэг журам нь "зохион байгуулалт"-ын салшгүй хэсэг. Тухайн хүний ямар үүрэгтэй, яаж сахилга хүлээх, ямар эрх эдлэхийг хуульчилсан нь албаны зохион байгуулалтад орно.

Хэдийгээр хуульд "цэргийн албаны зохион байгуулалт гэж…" гэсэн нэг мөр тодорхойлолт байхгүй ч, "Цэргийн албаны зохион байгуулалт гэж Монгол Улсын Цэргийн албаны тухай хуульд заасан хугацаат, гэрээт болон бэлтгэл албаны хэлбэрээр, Зэвсэгт хүчин болон бусад цэрэгжсэн байгууллагын бүтцээр дамжин хэрэгжих бөгөөд цэргийн албан хаагчийн эрх, үүрэг, сахилга бат, удирдлагын шатлал, командлалын тогтолцоонд тулгуурласан цогц зохион байгуулалтыг хэлнэ гэж ойлгож болох юм.

Хоёр. Хилийн цэргийн цэргийн албаны зохион байгуулалтын өнөөгийн байдал

Хилийн цэрэг нь Монгол Улсын хилийн хамгаалалтыг хангах үндсэн байгууллага бөгөөд бүтэц, зохион байгуулалтын хувьд дараах онцлогтой.

Хилийн цэргийн салбар: Улсын хилийн тодорхой хэсгийг хамгаалах үндсэн үүрэгтэй, хил хамгаалах байгууллагын үндсэн нэгж.

Хилийн анги, салбар: Олон салбарыг нэгтгэн, бүсийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалт, хангалт хариуцдаг дунд шатны нэгж

Хил хамгаалах ерөнхий газар: Стратегийн удирдлага, төлөвлөлт, бодлого боловсруулах үүрэгтэй төв байгууллага юм.

Өнөөгийн нөхцөл байдалд Хил хамгаалах байгууллага нь Хилийн тухай хуульд зааснаар дараах үндсэн чиг үүрэгтэйгээр (Хилийн тухай хууль, 2016) ажиллаж байна.

-Улсын хилийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх;

-Улс орны хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах;

-Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлж, улсын хилийн дэглэмийг сахиулах;

-Улсын хилийн шугамыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байх;

-Хил орчмын дэглэмийг сахиулан, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, хилийн зөрчлийн асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлэх;

-Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хилийн боомтод мөрдөх журмыг сахиулах;

-Улсын хилийн зурвас, хилийн боомтод үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох арга хэмжээ авах;

-Хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох;

-Агаарын хилийг зөрчсөн байж болзошгүй нисгэгчтэй болон нисгэгчгүй нисэх хэрэгслийн талаарх мэдээллийг зэвсэгт хүчний агаарын цэргийн анги, салбарт шуурхай дамжуулах;

-Хуульд заасан бусад.

Дээрх үүргийг гүйцэтгэхдээ Хил хамгаалах байгууллага нь тасралтгүй, шуурхай, эргүүл, жижүүрийн алба, сургалт, бэлэн байдал дэг журам сахиулах ажиллагаа зэрэг зохион байгуулалтын хэлбэрийг хэрэгжүүлдэг.

Гурав.Монгол Улсын төрийн цэргийн байгууллагуудын цэргийн албаны зохион байгуулалтын харьцуулалт

Монгол Улсын аюулгүй байдлын тогтолцоонд олон төрлийн цэргийн байгууллага оролцдог бөгөөд тэдгээр нь өөр өөр чиг үүрэгтэй ч нийтлэг нэг зарчимд тулгуурлаж, цэргийн албаны зохион байгуулалтаар нэгддэг.

Хил хамгаалах байгууллага, Зэвсэгт хүчин, Дотоодын цэрэг, Онцгой байдлын байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Цагдаагийн байгууллага нь бүгд цэргийн зэрэглэл, сахилга баттай, өөрийн салбарын онцлогийг тусгасан бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулдаг.

Энэ хэсэгт дээрх байгууллагуудын цэргийн албаны зохион байгуулалтыг харьцуулан авч үзнэ.

Цэргийн байгууллагуудын эрх зүйн орчин нь тэдгээрийн чиг үүрэг, зохион байгуулалтын гол үндэс болдог.

Хил хамгаалах байгууллага нь: “Хилийн тухай хууль”, “Цэргийн албаны тухай хууль”-д тулгуурлаж, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үндсэн үүрэгтэй.

Зэвсэгт хүчин нь: “Батлан хамгаалах тухай хууль”, “Цэргийн албаны тухай хууль”-аар зохицуулагдаж, үндэсний тусгаар тогтнолыг батлан хамгаалах үндсэн үүрэгтэй.

Дотоодын цэрэг нь: “Дотоодын цэргийн тухай хууль”-аар үйл ажиллагаагаа явуулж, төрийн тусгай объект хамгаалах, эмх журам сахиулахад оролцдог.

Онцгой байдлын байгууллага нь: “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Онцгой байдлын албаны тухай хууль”-д тулгуурлаж, гамшиг, ослын үед аврах ажиллагаа явуулдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-д заасны дагуу хорих байгууллага, ял эдлүүлэлтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй.

Цагдаа нь “Цагдаагийн албаны тухай хууль”-аар зохицуулагдаж, олон нийтийн аюулгүй байдал, гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн зорилготойгоор тус тус үүрэг гүйцэтгэдэг.

Байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт нь гүйцэтгэх үүргээсээ хамааран ялгаатай байдаг. Хил хамгаалах байгууллага нь Улсын хилийн шугамын дагуу хилийн анги, салбар бүхий тогтолцоотой бол Зэвсэгт хүчин нь бригад, батальон, ротын зохион байгуулалттай, Дотоодын цэрэг нь нийслэл болон аймаг бүрд салаа, анги хэлбэртэй байрлаж, төрийн тусгай объект хамгаалдаг, Онцгой байдлын байгууллага нь аврах

бригад, гал унтраах, эрэн хайх, аврах ангиудтай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих анги, цагдан хорих төвийн харуул хамгаалалтын тогтолцоонд тулгуурладаг, Харин цагдаагийн байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн хэлтэс, мөн тусгай чиг үүргийн нэгжүүдээр зохион байгуулагддаг онцлогтой юм.

Гэвч Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрэмд зааснаар цэргийн дотоод алба нь хилийн цэргийн анги, тусгай салбар, хилийн салбар, хилийн харуулын ***бэлэн байдал, сургалт бэлтгэл, ёс зүй, сэтгэл зүйн хангалт, харуул, хоногийн манаа, аюулгүй байдлыг хангах, дэг журам, сахилга, хариуцлагыг бэхжүүлэх, цэргийн алба хаагчийн алба хаах, эрүүл амьдрах, ахуй орчныг*** бүрдүүлэхэд чиглэсэн өдөр тутмын үйл ажиллагаагаар хэрэгжинэ (Ерөнхийлөгчийн 180 дугаар зарлиг, 2022) гэсэн заалтыг баримтлах ёстой.

Монгол Улсын төрийн цэргийн байгууллагууд нь өөр өөр чиг үүрэгтэй ч цөм цэргийн сахилга бат, зохион байгуулалтын зарчмыг баримталдаг.

Хил хамгаалах байгууллага нь хил дээр байнгын ажиллагаа явуулдгаараа онцлог бол Зэвсэгт хүчин улсын үндсэн цэрэг, үндэсний аюулгүй байдлын гол баталгаа юм.

Дотоодын цэрэг төрийн тусгай объект хамгаалж, дотоодын эмх журмыг сахиулах үүрэгтэй.

Онцгой байдлын байгууллага гамшгийн нөхцөлд шуурхай ажилладаг бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ял эдлүүлэх болон хорих байгууллагын аюулгүй байдлыг хангадаг.

Цагдаагийн байгууллага нь иргэдийн амар тайван байдлыг сахин хамгаалах үндсэн үүрэгтэй.

Ийнхүү эдгээр байгууллагуудын зохион байгуулалтыг харьцуулбал, үүргийн онцлогоор ялгаатай ч аюулгүй байдлын нэгдмэл тогтолцоог бүрдүүлдэг болох нь харагдаж байна.

Дөрөв. Давуу болон сул тал, тулгамдсан асуудлууд

Давуу тал:

Нэгдмэл тогтолцоо – Хилийн цэргийн бүтэц шатлан захирах зарчмаар тодорхой бөгөөд нэг төвөөс удирддаг тул албаны уялдаа холбоо сайн хангагдсан.

Сахилга, дэг журам өндөр – Албан хаагчид цэргийн дэг журам, сахилга батыг чанд баримталдаг нь үйл ажиллагааны найдвартай байдлыг хангаж байна.

Туршлагатай боловсон хүчин – Урт хугацааны туршлагатай офицер, ахлагч нар их бөгөөд энэ нь цэргийн албаны зохион байгуулалтыг тогтвортой байлгадаг.

Сул тал:

Хүний нөөцийн тогтворгүй байдал – Залуу боловсон хүчнийг тогтоон барихад хүндрэлтэй, алслагдсан бүс нутагт ажиллах сонирхол бага.

Газарзүйн хүндрэл – Хил орчмын байгаль, цаг уурын нөхцөл хүнд, зарим хэсэгт хэт алслагдсан тул хангалт, тээвэрлэлтийн хүндрэл их

Шинэ төрлийн аюул занал – Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, кибер аюул заналд хариу арга хэмжээ авахад зохион байгуулалтын тогтолцоо дутмаг.

Тулгамдсан асуудлууд:

-Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах бодлого сул;

-Технологийн шинэчлэл хийгдэж байгаа боловч удаашралтай;

- Олон улсын туршлагыг нутагшуулах бодит ажил дутмаг;

-Цэргийн сахилга, дэг журмын асуудал.

Технологийн дэвшлийг нэвтрүүлэх. Дрон, хиймэл дагуулын зураг, ухаалаг хяналтын систем, дурангийн технологи, дулаан мэдрэгчийг хил хамгаалалтад ашиглах;

Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах. Алба хаагчдын орон сууц, цалин, нийгмийн баталгааг сайжруулснаар алба хаах сонирхлыг нэмэгдүүлэх;

Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх. Хөрш орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, мэдээлэл солилцох;

Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх. Хил орчмын иргэдийг "иргэн-цэрэг" хамтын ажиллагааны тогтолцоонд өргөнөөр татан оролцуулах.

Цэргийн сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх – Гэрээт болон Хугацаат цэргийн алба хаагчдад тавих хяналт шалгалтыг нэмэгдүүлэх, шалган, туслах, соён гэгээрүүлэх.

ОХУ: Хилийн албыг Холбооны аюулгүй байдлын албаны бүрэлдэхүүнд байгуулж, орчин үеийн техник хэрэгсэл өргөн ашигладаг

БНХАУ: Хил хамгаалалтад өндөр технологийн камержуулалт, дрон, хиймэл дагуулын систем өргөн хэрэглэж байна

Казахстан: Хил хамгаалалтад бүс нутгийн хамтын ажиллагааг түлхүү ашиглаж, олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг туршлага байна.

Монгол Улс эдгээр туршлагыг нутагшуулснаар хил хамгаалалтын тогтолцоогоо боловсронгуй болгох боломжтой юм.

ДҮГНЭЛТ

Хилийн цэргийн "Цэргийн албаны зохион байгуулалт" нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах суурь нөхцөл болох стратегийн чухал тогтолцоо юм. Судалгаанаас харахад, өнөөгийн албаны зохион байгуулалт нь нэгдмэл тогтолцоотой, сахилга дэг журам өндөр, үндэсний онцлогт нийцсэн, олон жилийн туршлагад тулгуурласан давуу талуудтай. Гэвч хүний нөөцийн тогтворгүй байдал, техник хэрэгслийн хомсдол, газарзүйн хүндрэл, шинэ төрлийн аюул заналд дасан зохицох чадвар дутмаг зэрэг сул талууд нь цаашдын хөгжилд саад болж байна. Түүнчлэн хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бус наймаа, кибер аюул зэрэг шинэ сорилтуудыг даван туулахад улам бүр нарийн, технологид суурилсан зохион байгуулалт шаардагдаж байна. Мөн хил хамгаалах байгууллагад мөрдөгдөж байгаа "Цэргийн албыг зохион байгуулах журам"-аар бүх анги, салбарын цэргийн албыг зохион байгуулах боломжгүй гэж дүгнэж байна.

САНАЛ

Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах. Алба хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах (орон сууц, эрүүл мэндийн үйлчилгээ, цалин хангамж), хил дээр алба хаах сонирхлыг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ авах;

Технологийн шинэчлэл хийх. Хил хамгаалалтад дрон, хиймэл дагуулын хяналт, дулаан мэдрэгч зэрэг дэвшилтэт техник хэрэгслийг өргөн хурдацтай ашиглах, Холбоо, мэдээллийн системийг шинэчлэх, кибер аюулгүй байдлыг хангах;

Сургалт, бэлтгэлийг шинэ шатанд гаргах. Алба хаагчдыг шинэ төрлийн аюул заналд (терроризм, кибер аюул, хил дамнасан гэмт хэрэг) бэлтгэх сургалтыг тогтмолжуулах, Олон улсын стандарт, туршлагыг сургалт, дадлагад тусгах;

Сахилга, хариуцлагыг дээшлүүлэх. Хугацаат болон Гэрээт цэргийн алба хаагчдын сахилгын асуудлыг бодлогын түвшинд авч үзэж сахилгын зөрчлийг хариуцсан нэгжтэй болох;

Хил хамгаалах байгууллагад "Цэргийн албыг зохион байгуулах заавар"-ыг шинэчлэх. Хилийн анги, тусгай салбарт нэг журмаар зохион байгуулах боломжгүй гүйцэтгэж байгаа чиг үүргийн дагуу ангилах шаардлагатай.

Ийнхүү дээрх шинэчлэлийн арга хэмжээг хэрэгжүүлснээр Монгол Улсын хил хамгаалалтын чадавх бэхжин, цэргийн сахилга, албаны зохион байгуулалт сайжирч, уян хатан, орчин үеийн шаардлагад нийцсэн болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Ерөнхийлөгчийн 180 дугаар зарлиг. (2022). *Монгол Улсын цэргийн нийтлэг дүрэм.* Улаанбаатар.

Монгол Улсын Үндсэн хууль. (1992). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from https://legalinfo.mn/mn/detail?lawId=367

Хилийн тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from https://legalinfo.mn/mn/detail/12418

Цэргийн албаны тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from https://legalinfo.mn/mn/detail?lawId=12124

Цэргийн албаны эрх зүйн байдлын тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from https://legalinfo.mn/mn/detail?lawId=12125

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН МЭРГЭШҮҮЛЭХ, ДАВТАН СУРГАХ СУРГАЛТЫН ҮР НӨЛӨӨ БА ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ: ПРАКТИК, ОНОЛЫН ШИНЖИЛГЭЭ

А.БААСАНБАТ *
ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, ахлах дэслэгч

**Хариуцлагатай зохиогч:amgalanbaatarbaasanbat81@gmail.com*

Хураангуй: Энэхүү судалгаа нь хил хамгаалах байгууллагад ажиллагсдын мэргэшүүлэх болон давтан сургалтын системийн онол ба практикт өгч буй нөлөөг олон талт байдлаар шинжлэх зорилготой. Орчин үеийн хил хамгаалалт нь технологи, олон улсын хууль эрхзүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чадвар зэрэг олон хүчин зүйлээр хурдтай өөрчлөгдөж байна. Иймд хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн чадвар, мэдлэг, харилцааны ур чадварыг тасралтгүй сайжруулж байх нь үндсэн стратеги бөгөөд энэ нь мэргэжлийн сургалт, давтан сургалтын системийн үр ашигтай холбогдоно. Судалгааны хүрээнд мэргэшүүлэх, давтан сургах хөтөлбөрийн онолын суурь (насны суралцах онол, мэргэжлийн хөгжлийн концепц, компетенцийн хандлага), сургалтын арга зүй (даавуулагч, практик дасгал, симуляци, дижитал суралцах платформ), үнэлгээ ба баталгаажуулалт (форматив, сумматив үнэлгээ, гадаад аудит), мөн сургалтын үр дүнг хэмжих үзүүлэлтүүд (гэж тогтолцооны үзүүлэлт, үйл ажиллагааны үзүүлэлт, аюулгүй байдлын үр дүнгийн үзүүлэлт) нь судалгааны гол сэдэв байв.

Арга зүйн хувьд энэ судалгаа нь бичигдсэн ухааны бүтээлүүдийн системтэй уялдаа бүхий уян хатан нийцэл (scoping review) болон кейс-стади хослуулсан синтезийг ашигласан. Олон улсын туршлагууд (Европ, Хойд Америк, Азийн хэсэг) болон монгол орны нөхцөлд хэрэгжиж буй сургалтын практикуудаас баримт, бодит кейс цуглуулсан. Мөн хил хамгаалах байгууллагуудад хийсэн хязгаарлагдмал тооны гүнзгий ярилцлага, багийнхаа дунд явуулсан ажлын ажиглалт, сургалтын бичиг баримт, сургалтын төлөвлөгөө, үнэлгээний тайлан зэрэг баримтуудыг задлан шинжилсэн.

Хил хамгаалах байгууллагын мэргэшүүлэх ба давтан сургалтын системийг компетенцийн загварт суурилуулж, симуляцид тулгуурласан давтан сургалт, blended learning, чанартай үнэлгээний механизмийг хослуулах нь байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах гол түлхэц болно. Сургалтын чанар, хүртээмж, үр нөлөөг тодорхой хэмжигдэх KPI-ээр системтэйгээр хянах замаар бодлого, төсөв, хүний нөөцийн менежментийг сайжруулах боломжтой

Түлхүүр үгс: хил хамгаалалт, мэргэшүүлэх сургалт, давтан сургалт, симуляци, blended learning, компетенц, үнэлгээ

Удиртгал

Хил хамгаалах байгууллага нь улсын аюулгүй байдлын тэргүүлэх тулгууруудын нэг бөгөөд түүний чадвар нь гэмт хэрэг, хууль бус хөдөлгөөн, олон улсын аюул занал зэрэгт шууд нөлөөлдөг. Тиймээс ажиллагсдын мэргэжлийн ур чадвар, мэдлэг, шийдвэр гаргалт, хамтын ажиллагаа зэрэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх шаардлага тулгардаг. Мэргэжлийн сургалт ба тогтмол давтан сургалт нь үйл ажиллагааны тогтвортой чанар, хурдан дасан зохицох чадварыг хангахад гол үүрэг гүйцэтгэнэ (ICRC, 2018; OECD, 2020). Гэвч олон орны практикт сургалтын систем нь норматив,

стратеги болон бодит хэрэгжилтийн хооронд зөрчилдөж, үр дүнгийн үнэлгээ сул байдаг. Энэхүү өгүүлэл нь хил хамгаалах байгууллагад мэргэшүүлэх болон давтан сургалтын загвар, арга зүй, үнэлгээний механизм болон тэдгээрийн үр нөлөөг онол, практик талаас нь шинжилнэ.

Үндсэн хэсэг

Улс хоорондын болон салбарын онолын үндэс Мэргэшүүлэх сургалт гэдэг нь тодорхой ажлын байрны үүрэг, стандартын дагуу шаардлагатай мэдлэг, ур чадварыг олгох үйл явцыг хэлнэ (Eraut, 1994). Давтан сургалт нь анхны мэргэшүүлэхээс хойш олж авсан чадварыг хадгалах, шинэчлэх, шинэ нөхцөлд тохируулахад чиглэнэ (Salas et al., 2012). Суралцах онолууд (adult learning theory — andragogy, experiential learning — Kolb, deliberate practice — Ericsson) нь мэргэшүүлэх сургалтын дэд бүтцийг тайлбарлахад ашиглагддаг. Andragogy нь насанд хүрэгчдийн суралцах онцлог (функциональ хэрэгцээ, туршлага дээр тулгуурлах, зорилготой суралцах) талаар онцолдог (Knowles, 1984). Kolb-ын туршлагад суурилсан суралцах мөчлөг (туршлага → дүн шинжилгээ → онол → туршилт) практик ба симуляцид үндэслэсэн сургалтыг дэмждэг. Deliberate practice хязгаарлагдмал зорилготой, давтагдмал, ялангуяа

шууд санал болон үнэлгээтэй практик дасгалыг шаарддаг бөгөөд энэ нь мэргэжлийн ур чадварыг гүнзгий тогтоход түлхэц болдог (Ericsson, 2008).

Хил хамгаалах байгууллага алба хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах чиглэлээр жил бүр гадаадын (БНХАУ, ОХУ, БНСУ, АНУ, ӨАБНУ) болон дотоодын Их, Дээд сургуулиуд, зэвсэгт хүчний жанжин штаб, төрийн цэргийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөөнд заагдсан хөтөлбөрийн хүрээнд 2025 онд хамтарсан ажиллагааны төлөвлөгөөнд 174 нэр төрлийн 3888 алба хаагчдыг сургасан бол 2026 онд 173 нэр төрлийн 3954 алба хаагчийг сургах, мэргэшүүлэх, давтан сургахаар төлөвлөсөн байна. Үүнээс 2025-2026 онд Дотоод Хэргийн Их Сургуульстай хамтран сургах алба хаагчдын тоо болон сургалтын хөтөлбөрийн харьцуулалтыг үзүүлье.

Хүснэгт 1. Хил хамгаалах байгууллагын 2025 онд ДХИС-д мэргэшүүлэх давтан сургах чиглэлээр сургах сургалтын төлөвлөгөө

№	зохион байгуулагдах сургалт			Хүний тоо	Хугацаа	
					Эхлэх	Үргэлжлэх
1	2	3	4	5	6	7
1	Дотоод хэргийн их сургууль	2025 оны сургалт	Доктор /өдрийн/	1	9 сард	3 жил
2			Доктор /эчнээ/	1	9 сард	3 жил
3			Удирдлагын академи Хилийн стратеги /Магистр/	5	9 сард	2 жил
4			Магистрантур /эчнээ/	20	9 сард	2 жил
5			Үндсэн анги /өдрийн/ бакалавр	140	9 сард	4 жил
6			Хил судлал /өдрийн дээд боловсролтой/бакалавр	30	9 сард	2жил
7			Бакалавр /эчнээ 3 жил/	30	9 сард	3 жил
8			Бакалавр /эчнээ 4 жил/	30	9 сард	4 жил
9			Хилийн албаны тасгийн дарга бэлтгэх сургалт	20	2 сард	14 хоног
10			Цэргийн албаны тасгийн дарга бэлтгэх	20	1 сард	14 хоног
11			Штабын алба, тасгийн ахлах офицеруудыг бэлтгэх	30	5,6 сард	14 хоног
12			Хангалт үйлчилгээний тасгийн дарга бэлтгэх	20	3 сард	14 хоног
13			Хангалт үйлчилгээний ахлах офицеруудыг бэлтгэх	60	3 сард	14 хоног
14			Салбарын захирагч бэлтгэх	60	2 сард	14 хоног
15			Шалган нэвтрүүлэх тасгийн даргын албан түшаалын мэргэшүүлэх сургалт	20	2 сард	14 хоног
16			Сургагч ахлагч бэлтгэх сургалт	60	2 сард	14 хоног
17			Аж ахуйн дарга бэлтгэх	60	1, 9 сард	30 хоног
18			Хилчин бэлтгэх	70	3, 9 сард	90 хоног
19			Офицер бэлтгэх	90	3, 9, 11	45 хоног
20			Шалган нэвтрүүлэх албаны анхан шатны сургалт	90	3, 9,11 сард	45 хоног
21			Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах ажилтны анхан шатны сургалт	50	4,10 сард	45 хоног
22			Зэвсгийн бага мэргэжилтэн бэлтгэх сургалт	20	10 сард	45 хоног
23			Дроны оператор бэлтгэх сургалт	30	11 сард	45 хоног
				957		

Хүснэгт 2. Хил хамгаалах байгууллагын 2026 онд ДХИС-д мэргэшүүлэх давтан сургах чиглэлээр сургах сургалтын төлөвлөгөө

№	зохион байгуулагдах сургалт			Хуний тоо	Хүйсийн харьцаа		Хугацаа	
					Эр	Эм	Эхлэх	Үргэлжлэх
1	2	3	4	5	6	7	8	9
1	2026 он	Дотоод Хэргийн Их Сургууль:	Доктор (өдрийн)	2	2	-	9 сард	3 жил
2			Доктор (эчнээ)	2	2	-	9 сард	3 жил
3			Удирдлагын академи Хилийн стратеги	8	8	-	9 сард	2 жил
4			Магистрантур(Удирдахуйн ухаан, хил судлал, аюулгүй байдал, эрх зүйн эчнээ)	23	20	3	9 сард	2 жил
5			Үндсэн анги /өдрийн/ бакалавр	140	140	-	9 сард	4 жил
6			Хил судлал /өдрийн дээд боловсролтой/ бакалавр	30	30	-	9 сард	2 жил
7			Бакалавр /эчнээ 3 жил/	30	20	10	9 сард	3 жил
8			Бакалавр /эчнээ 4 жил/	30	20	10	9 сард	4 жил
9			Тэргүүн ахлагч бэлтгэх сургалт	35	35	-	09 сард	90 хоног
10			Сургагч ахлагч бэлтгэх сургалт	35	35	-	2 сард	14 хоног
11			Аж ахуйн дарга бэлтгэх	60	60	-	1,9 сард	30 хоног
12			Харуулын дарга бэлтгэх сургалт	60	60	-	1, 9 сард	45
13			Хилчин бэлтгэх	70	40	30	3, 9 сард	90 хоног
14			Дроны оператор бэлтгэх сургалт	30	25	5	11 сард	45 хоног
15			Хилчин шалгагч бэлтгэх сургалт	60	40	20	3, 6,9	45 хоног
16			Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах анхан шатны сургалт	60	40	20	4, 10 сард	45 хоног
17			Г эрээт ахлагч бэлтгэх	250	250	-	4. 10 сард	60 хоног
				925	827	98		

Эх сурвалж-Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого зохицуулалтын газар

Орчин үеийн үндэсний аюулгүй байдлын орчин эрс өөрчлөгдөж, хил хамгаалалтын байгууллагын үүрэг, хариуцлага улам бүр өргөжин тэлж байна. Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын хил хамгаалах байгууллагын албан хаагчдын мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоог судалж, олон улсын туршлагатай харьцуулан сайжруулах арга замыг тодорхойлоход оршино.

Судалгаанд баримт бичгийн шинжилгээ, харьцуулсан арга, контент анализыг ашигласан. Монгол Улсад сургалтын тогтолцоо байгаа боловч тасралтгүй боловсролын зарчим бүрэн хэрэгжээгүй, практик сургалтын эзлэх хувь бага, технологийн хэрэглээ сул байгааг тогтоов.

Гадаад улс орнуудын туршлага:

АНУ: Тасралтгүй сургалт, e-learning систем хөгжсөн.

ОХУ: Шаталсан сургалтын тогтолцоотой.

БНХАУ: Төвлөрсөн, технологид суурилсан сургалттай.

АНУ, ОХУ, БНХАУ-ын туршлагаас үзэхэд тасралтгүй сургалт, симуляц сургалт, цахим сургалтын систем өндөр хөгжсөн байна. Иймээс Монгол Улсад сургалтын тогтолцоог шинэчлэх, давтан сургалтыг тогтмолжуулах, технологид

суурилсан сургалтыг нэвтрүүлэх шаардлагатай байна. Эдгээр улс орнуудын туршлага нь Монгол Улсад хэрэгжүүлэх боломжтой.

Харьцуулалтаас харахад Монгол Улсад сургалтын шинэчлэл зайлшгүй шаардлагатай байна. Тухайлбал технологийн хэрэглээ болон практик сургалт сул байна.

Судалгааны арга зүй

Энэхүү өгүүлэл нь scoping review, кейс-стади болон баримтат шинжилгээний холимог аргыг ашигласан. Ном, эрдэм шинжилгээний нийтлэл, олон улсын байгууллагын тайлан (жишээ нь: ICRC, UNODC, IOM, OECD), мөн хил хамгаалах сургалтын дотоод баримт, кейс судалгаа (3 орны туршлага: Европын гишүүн улс, Азийн орон, Монгол Улсын практик) зэрэг эх сурвалжаас өгөгдлийг нэгтгэсэн. Мөн сургалтын үр дүнг хэмжихэд ашиглагдах үзүүлэлтүүдийн (KPI) практик жишээг цуглуулж анализ хийсэн.

Үр дүн

1. Компетенцийн загвар ба сургалтын бүтэц

Компетенцийн загварт суурилсан сургалт нь ажлын байрны тодорхой шаардлагаас эхлэн суралцагчийн мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлж, тэдгээрийг модуль болгон төлөвлөдөг. Загвар нь техникийн (жишээ нь: шалгалт, илрүүлэх технологи), үйл ажиллагааны (жишээ нь: үйл явдлын менежмент), соёл, ёс зүйн (жишээ нь: хүний эрхийн мэдлэг), харилцааны ур чадвар гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй байх нь үр дүнтэй.

2. Сургалтын арга зүй: симуляци ба практик дасгал

Симуляцийн сургалт нь бодит үйл ажиллагаатай ойролцоо нөхцөл бүрдүүлж, шийдвэр гаргах, стресс удирдах чадварыг сайжруулдаг. Давтан сургалтын давтамж, нөхцөл байдал нь бодит үйл явдлын хамааралтай байх тусмаа илүү үр ашигтай байсан. Кейслэг дасгал, багийн сургалт, командын харилцааны дасгал өгдөг.

3. Blended learning ба цахим сургалт


Blended learning нь онолын контентыг цахимаар өгөх, практик чадварыг танхим, симуляциар олгох хэлбэрээр зохион байгуулагдах нь хамгийн тохиромжтой. Цахим сургалтын чанарыг хангахын тулд интерактив элемент, микролернинг модуль, алгоритмд суурилсан үнэлгээ хэрэгтэй.

4. Үнэлгээ ба баталгаажуулалт

Үнэлгээ нь форматив (зарим модуль дээрх тасралтгүй үнэлгээ) ба сумматив (модулийн төгсгөлд компетенц шалгах) байх ёстой. Мөн сургалтын дараах ажлын үр дүнг хэмжих KPI-г тодорхойлох шаардлага тулгарна (жишээ: хилийн зөрчилтийн тохиолдлын хугацаа буурсан, хууль бусаар нэвтрэх тохиолдол буурсан, ажлын алдаа буурсан гэх мэт).

5. Багшлах чадвар ба сургалтын баталгаажуулалт

Сургагч багшийн практик ур чадвар, дасан зохицох чадвар, үнэлгээний чадвар зэргийг тогтмол сайжруулах шаардлага байна. Гадаад аудит, сертификатжуулалт нь сургалтын чанарыг баталгаажуулахад ашиглагдана.



Судалгааны үр дүн нь хил хамгаалах байгууллагад мэргэшүүлэх ба давтан сургалтын зохион байгуулалт, үр ашгийг дээшлүүлэхэд konkret аргачлал өгч байна. Компетенцийн загвар нь сургалтын агуулгыг тодорхойлон, үнэлгээний шугамыг тодорхой болгох болно. Бодит практик, симуляци дээр суурилсан давтан сургалтын хөтөлбөр нь шийдвэр гаргалт, стрессийн менежмент, командын хамтын ажиллагааг сайжруулж, ажлын гүйцэтгэлд шууд эерэг нөлөө үзүүлдэг. Цахим сургалт нь хүртээмж, хэмнэлт өгч болох ч практик чадварын хөгжлийг орлуулахааргүй тул blended approach-г хэрэглэх нь зүйтэй. Мөн үнэлгээний систем нь сургалтын чанарыг тасралтгүй сайжруулахад зайлшгүй шаардлагатай.

Дүгнэлт

Судалгааны үр дүн нь дараах гол дүгнэлтүүдэд хүргэж байна.

Нэгдүгээрт: мэргэшүүлэх сургалтын тогтолцоо нь тодорхой, хэмжигдэхүйц компетенцийн загварт суурилах ёстой. Командын болон салбарын түвшинд шаардлагатай ур чадвар, мэдлэгийг тодорхойлж, тэдгээрт нийцсэн сургалтын модуль, сурах үр дүн (learning outcomes) болон үнэлэх шалгууруудыг тодорхойлох нь сургалтын чанарыг сайжруулна. Хэрэв сургалт зөвхөн ерөнхий мэдлэг дээр төвлөрч, прагматик компетенцийг тодорхойгүй бол бэлтгэлийн үр нөлөө буурна.

Хоёрдугаарт: давтан сургалт нь практик, симуляци, үйлдлийн дасгалтай хослох үед хамгийн өндөр үр ашигтай байгааг нотлов. Сонирхолтой нь симуляцид тулгуурласан сургалтын давтамж, нөхцөл нь бодит нөхцөлтэй ойролцоо байх тусам суралцагчдын шийдвэр гаргалтын чадвар, стресс удирдах түвшин дээшилсэн. Жишээ нь, хилийн шалгалт, эрэн хайх, сахилга бат зөрчигдсөн нөхцөлд үйлдэл хийх дадал туршлага нь анхны сургалт болон давтан сургалтын гол хэсэг байх шаардлагатай.

Гуравдугаарт: цахим сургалт (e-learning), blended learning (хосолсон сургалт) нь сургалтын хүртээмж, зардлын хэмнэлт, хуваарь уян хатан байдалд ихээхэн давуу тал өгдөг боловч практик чадварыг хэлбэржүүлэхэд заавал танхимын болон практик хичээл, симуляци хэрэгтэй. Цахим сургалтын чанарыг хангахын тулд интерактив контент, микролернинг модуль, үнэлгээний автоматжуулсан систем харилцан ажиллах ёстой.

Дөрөвдүгээрт: үнэлгээний систем нь хоёр түвшинд байхаар төлөвлөгдсөн байх хэрэгтэй: форматив үнэлгээ (сургалтын явц дахь үндсэн бүрэлдэхүүн) болон суммматив үнэлгээ (сургалтын төгсгөлд компетенц шалгах). Мөн сургалтын дараах ажлын гүйцэтгэл (on-the-job performance) болон байгууллагын үйл ажиллагааны үр дүнд (оператив үр нөлөө, алдаа бууралт, аюулгүй байдлын үзүүлэлтүүд) хэлбэлзэлтэй холбоотой хэмжигдэхүүнүүдийг (KPI) тогтоох нь зайлшгүй. Ургамал мэт шинжлэхүйц өгөгдөл цуглуулж, сургалтын үр нөлөөг тэргүүлэх хугацаанд үнэлэх нь бодлого тодорхойлоход чухал үүрэгтэй.

Тавдугаарт: сургалтын чанарыг баталгаажуулахад байгууллагын дотоод чадавхи болон гадаад мэргэжлийн аудит, сертификатжуулалт зэрэг механизм хэрэгтэй. Хилийн байгууллагууд олон улсын хамтын ажиллагааны хүрээнд стандартыг нэвтрүүлэхдээ сургалтын материал, үнэлгээний процедур, зааварчилгаа, багшлах эрхийн шалгуур зэрэгт илүү анхаарах шаардлагатай.



Эдгээр дүгнэлтийн үндсэн дээр судалгаа нь практик санал, аргачлалыг тусгав: (1) компетенцийн загварт суурилсан сургалтын архитектур боловсруулах; (2) симуляци, практик дасгал дээр тулгуурласан давтан сургалтын хөтөлбөрийг жил тутмын төлөвлөгөөнд оруулах; (3) blended learning-ийг стандартчилах, цахим сургалтын интерактив контент хөгжүүлэх; (4) багшлах чадварыг тогтмол сайжруулах, сургагч багшийн сургалтын чанарын баталгаажуулалт явуулах; (5) сургалтын үр нөлөөг хэмжих KPI болон дараах ажлын гүйцэтгэлийг хянах систем нэвтрүүлэх; (6) олон улсын стандарт, практикт нийцсэн гадаад аудит болон гэрчилгээний механизмыг нэвтрүүлэх. Мөн төсөв, хүний нөөц, дэд бүтэц зэрэг хэрэгцээ бүхий хэрэгжилтийн замналын ерөнхий зураглалыг санал болгож байна.

Энэхүү судалгаа нь хил хамгаалах байгууллагын сургалтын бодлогыг хөгжүүлэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулах ба мэдлэг, ур чадварыг тогтвортой нэмэгдүүлэхэд бодит хэрэглээтэй зөвлөмж өгч байна. Ирээдүйд судалгааг өргөжүүлэхдээ сургалтын үр нөлөөг илүү урт хугацаанд (longitudinal) хэмжих, бүр илүү их тооны байгууллагын кейсийг туршилтаар шалгах, мөн технологийн шинэлэг шийдлүүд (AR/VR симуляци, AI-д суурилсан үнэлгээ) нэвтрүүлэх боломжийг судлах шаардлагатай.

Санал

1. Компетенцийн загвар боловсруулах: ажлын байр тус бүрт шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлж, модульчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах.

2. Давтан сургалтыг жил бүрийн сургалтын төлөвлөгөөнд оруулах: симуляцигаас бүрдсэн, практик дээр тулгуурласан давтан сургалтын давтамжийг тогтоох.

3. Blended learning-н стандарттай болгох: цахим контент, микролернинг, интерактив дасгалуудыг хөгжүүлэх.

4. Үнэлгээний системийг сайжруулах: форматив, сумматив үнэлгээ, дараах ажлын KPI-ийг тогтоож, өгөгдлийг цаг тухайд нь цуглуулах.

5. Сургагч багшийн чадавхийг бэхжүүлэх: багшлах арга зүй, үнэлгээний чадвар дахь тасралтгүй сургалтуудыг явуулах.

6. Гадаад аудит, сертификатжуулалтыг хэрэгжүүлэх: олон улсын стандартад нийцсэн аудит, гэрчилгээний механизмыг нэвтрүүлэх.

Ашигласан эх сурвалж

Баттулга, Д. (2020). Хил хамгаалалтын онол. УБ.

Ганболд, С. (2019). Цэргийн сургалтын арга зүй. УБ.

Монгол Улсын хууль. (2017). Хилийн тухай хууль.

Боловсролын яам. (2021). Тасралтгүй боловсролын бодлого.

Дорж, П. (2022). Аюулгүй байдлын судалгаа. УБ.

Хил хамгаалах байгууллагын мэргэшүүлэх, давтан сургах хөтөлбөрийн төлөвлөгөө 2025 он.

Хил хамгаалах байгууллагын мэргэшүүлэх, давтан сургах хөтөлбөрийн төлөвлөгөө 2026 он.

Ericsson, K. A. (2008). Deliberate practice and acquisition of expert performance: A general overview. Academic Emergency Medicine, 15(11), 988–994. https://doi.org/10.1111/j.1553-2712.2008.00227.x

Eraut, M. (1994). Developing professional knowledge and competence. Falmer Press.

International Committee of the Red Cross (ICRC). (2018). Capacity building for border security: Principles and practices. ICRC Publications.

Knowles, M. S. (1984). Andragogy in action: Applying modern principles of adult learning. Jossey-Bass.

Organisation for Economic Co-operation and Development (OECD). (2020). Strengthening border management: Policy options and measures. OECD Publishing.

Salas, E., Tannenbaum, S. I., Kraiger, K., & Smith-Jentsch, K. A. (2012). The science of training and development in organizations: What matters in practice. Psychological Science in the Public Interest, 13(2), 74–101. https://doi.org/10.1177/1529100612436661

UNODC. (2019). Handbook on border management and security training. United Nations Office on Drugs and Crime.

Е СУРГАЛТ ТҮҮНИЙ МӨН ЧАНАР ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛ

Б.ГОМБОСҮРЭН*

Хилийн албаны сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн ахлах багш, докторант хурандаа

**хариуцлагатай зохиогч: gombosuren0201@gmail.com*

Хураангуй: Хүн төрөлхтөн мэдээллийн зуунд шилжиж нийгмийн баялаг, үнэт зүйлийг бүтээх эх сурвалж нь мэдлэг, мэдээлэл гэдгийг хүлээн зөвшөөрч нийгмийн бүхий л салбарт технологийг өргөнөөр ашиглах үйл явц өдөр бүр өсөн нэмэгдэж байгаа билээ. Техник, технологийг ашиглах мэдээллийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран хурдан шуурхай хүргэх, хүлээн авах нь боловсролын салбарт ч эрчимтэй явагдаж байна. Монгол Улсын боловсролын чиг хандлага цахим сургалтад эрчимтэй шилжиж энэ цаг үед Е сургалтын мөн чанар, давуу болон сул талыг Дотоод хэргийн их сургуулийн сургалтын үйл ажиллагаанд хэрхэн хэрэгжиж буй талаар санал, дүгнэлт дэвшүүлэхээр энэхүү сэдвийг сонгон судаллаа.

Түлхүүр үг: Е сургалт, Е сургалтын төрөл, хэлбэр зайн сургалт, цахим зайн сургалт.

Үндсэн хэсэг

Цахим сургалт нь орчин үеийн сургалтын нэгэн хэлбэр юм. Өдгөө XXI зууны иргэд өөр хоорондоо болон дэлхий нийттэй чөлөөтэй харилцаж, нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцоход шаардлагатай мэдлэг, чадвар, дадлыг сургалтын уламжлалт хэлбэрийн зэрэгцээ цахим сургалт (e-Learning), интернэт веб хуудсанд суурилсан сургалтаар эзэмшиж байна. Цахим сургалт нь дээд боловсрол, зайны сургалт, насан туршийн боловсролд голлох байр суурь эзлэх болжээ.

Е-Сургалт гэдэг нь мэдээлэл харилцааны технологи болон компьютер ашиглан явуулж буй сургалт бөгөөд зайн, онлайн сургалтын аль алийг багтаана. Онлайн сургалт гэдэг нь интернэтийг ашиглан сургалтын материалд хандах, хичээлийн агуулга, багш болон бусад оюутнуудтай харилцах, сургалтад оролцох, мэдлэг эзэмших, өөрийгөө хөгжүүлэх ба суралцах туршлага эзэмших явдал юм[32]" гэжээ.

Мэдээллийн технологийг сургалтад хэрэглэх боловсролын процессын үндэс нь оюутны мэдээллийн технологи хэрэглэх чадвар, зорилго, бие даасан цагийн хуваариар суралцаж багштай харилцах боломжтой байх явдал юм. Сурах ба сургах үйл явцад ашиглагддаг цахим агуулга хөгжүүлэлт нь уламжлалт багш төвтэй хандлага гэхээсээ илүү суралцагч төвтэй сургалтад зориулагддаг. Иймд сургалтыг үр ашигтай явуулахад туслах мультимедиа болон программ, тоног төхөөрөмж хэрэглэх шаардлага үүсдэг[33] гэж манай улсын боловсрол судлалын эрдэмтэн, судлаачид тодорхойлжээ.

Мэдээлэл харилцааны технологид тулгуурласан хичээл нь анхлан үг яриагаар харилцах боломжгүй суралцагчдад зориулагдаж байв. Энэхүү мультимедиаг сургалтад хэрэглэх хандлага хүрээгээ тэлсээр байна. Сургалтын хэрэглэгдэхүүнийг мультимедиа байдлаар бэлтгэхэд цаг хугацаа их шаарддаг ч суралцагчид зөвхөн хичээлийн цагт

[32] Алимаа, Ж. Онлайн сургалтын агуулга хөгжүүлэх арга зүйн судалгаа нэг сэдэвт бүтээл. Уб., 2013.

[33] Ганбат, Ц. Сурах ба сургах үйл явцад ашиглагдах цахим контент хөгжүүлэх арга зүй ба хэрэгслүүд. Уб., 2012.

баригдалгүй боломжтой үедээ компьютер, интернэт байгаа газар өөрийн боломжоор ашиглах, мөн үзэгдэл, үйл явцыг дүрс, хөдөлгөөн, дуутай нь хүртэх боломжтойгоороо давуу талтай. Ингэж ашиглахдаа суралцагч компьютертой харилцан идэвхтэй байхаар зохиогдсон байх бөгөөд хүний харааны хүртэхүй болон сэтгэхүйд тохирсон, агуулга, зургууд сайн нэгтгэгдэж, бүтээлч сэтгэхүй хөгжихөд нөлөөлж, суралцагчдын боловсрол эзэмших хэрэгцээг хангахад нэмэр болж байна.

Хүн бүр хэрэгцээтэй үедээ хүссэн цагтаа бүтээлчээр суралцан хөгжих, боловсролоо байнга шинэчлэн баяжуулж байх үзэл санаагаар боловсролын тогтолцоог хөгжүүлж байгаа олон улсын жишиг практик байна. Манай улсын боловсролын тогтолцоо хоцрохгүй байхын төлөө эрмэлзэж байна. Энэхүү асуудлыг хэрэгжүүлэх сургалтын технологийн нэг хувилбар нь Е-сургалт (electronic learning буюу e learning) юм. Е-сургалт гэдэг нь товчхондоо мэдээллийн технологийн хэрэгслүүдийг сургалтад ашиглана гэсэн үг юм.

Үүнийг дотор нь Computer based training (CBT) болон Web based training гэж салган ойлгож болно. Компьютерт суурилсан сургалт нь мультимедиа технологиор боловсруулсан сургалтын программ юм. Харин Интернэтэд суурилсан сургалт нь мультимедиа технологиор боловсруулсан сургалтын программыг интернэт ашиглан зайнаас сургалтаа явуулах боломж олгодог. Компьютерыг сургалтад хэрэглэх санаа анх компьютер үүссэн цагаас эхлэн гарсан боловч 1994 онд анхны веб-браузерууд гарч эхэлснээр е-сургалт нь жинхэнэ өнөөгийн хэлбэрээ олсон ажээ.

Энэ нь цаашид улам түргэн дэлгэрч, өнөө үед дан ганц энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, сургалтын материалыг бэлтгэдэг, эксперт үнэлгээ өгдөг компани, байгууллагууд олноор ажиллаж байна. Е сургалт нь танин мэдэхүйн шинжлэх ухааны зарчмууд дээр суурилдаг бөгөөд энэ нь боловсролын технологийг ашиглах, загварчлах нь сургалтыг хэрхэн үр дүнтэй сайжруулж болохыг харуулдаг[34].

Онолын хувьд Канадын Манитобагийн их сургуулийн суралцахуйн технологийн төвийн судалгаа хөгжлийн асуудал эрхэлсэн эрхлэгч Жорж Сайменсийн 2004 онд дэвшүүлсэн Коннективист онолд суурилж хөгжиж байна. Энэхүү онолын үзэл баримтлал нь суралцахуй бол эмх замбараагүй, нийгмийн шинжтэй, бусад үйл ажиллагаатай уялдаатай, хамтын үйл ажиллагаа. Албан боловсрол хэт хиймэл шинжтэй тул дараах зарчмуудыг тодорхойлжээ[35].

- Суралцахуй ба мэдлэг бол олон ургалч үзэл дээр тогтдог;
- Суралцахуй бол мэдээллийн янз бүрийн эх үүсвэрүүдийг хооронд нь холбох үйл ажиллагаа;
- Суралцахуй хүнээс гадна оршиж болно;
- Илүү ихийг мэдэх багтаамж нь одоо мэдэгдэж байгаагаас илүү чухал;
- Байнга үргэлжлүүлэн суралцах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд уялдаа холбоосыг үүсгэж байх ёстой;
- Шинэ санаа, үзэл баримтлал, салбар хоорондын уялдаа холбоог харах явдал бол хамгийн чухал ур чадвар юм;
- Үнэн зөв хамгийн сүүлийн үеийн мэдлэг коннективизмын гол зорилго гэсэн үзэл санаанд тулгуурлан сургалтад шинэ төрлийн онолын урсгал болон хэрэглэгдэж байна.

[34] David, L. (2015, December). E-learning Theory (Mayer, Sweller, Moreno). *Learning Theories*. https://www.learning-theories.com/e-learning-theory-mayer-sweller-moreno.html.

[35] Бадарч, Д. Дээд боловсролын онол, арга зүй. Уб., 2021. 72 дахь тал.

Суралцахуй нь хүмүүс хооронд сүлжээ үүсгэж түүнийхээ тусламжтайгаар бидний оюун ухаанд мэдлэгийн сүлжээ хэлбэрээр бий болгож байдаг. Мэдлэгийн зураглал, график байгуулж тэдний хоорондын уялдаа холбоог тод харуулж өгөх нь суралцахуйн үр дүнд чухал нөлөө үзүүлдэг тул бехевиоризм, когнивизм, конструктивизм, коннективизм болон бусад онолуудыг судалж үзэхэд өнөөдрийн цахим орчин оюутны хэрэгцээг хангаж чадахгүй, хязгаарлагдмал гэж дүгнэж болохоор байна. Иймд суралцахуйн түгээмэл онол гэж тусгайлан авч үзэх боломжгүй бөгөөд олон онолын урсгалд хамруулан ойлгож болохоор байна.

Дээрхээс дүгнэн үзэхэд Е сургалтыг мэдээлэл харилцааны бүхий л техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар интернэтэд суурилан орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах үйл явц гэж тодорхойлж болохоор байна.

Е сургалт нь Intract гэсэн англи үгнээс гаралтай, харилцан үйл ажиллагаа явуулах гэсэн утгатай суралцагч бүр танин мэдэх үйл явцад идэвхтэй оролцож хувь нэмрээ оруулан мэдлэг, үзэл бодол, үйл ажиллагааны аргаа солилцоход оршдог.

Энэхүү утгаар суралцагч багштай болон компьютертой харилцан идэвхтэй суралцах явцдаа хамтын үйл ажиллагаа явуулах чадвар эзэмшдэг. Уламжлалт сургалтад “дамжуулсан” харилцаа голлож байсан. Харин е сургалт нь харилцаагаар хүрээлүүлсэн байх учиртай бөгөөд харилцан ойлголцол, харилцан үйлдэл дээр тулгуурласан харилцаа зонхилсон байх нь зүйд нийцнэ гэж үзэх хандлага түгээмэл байна. Энэхүү сургалтыг багш зохион байгуулахдаа:

- суралцагч бүрийг оролцуулах арга зүйг ашиглах;
- суралцагчийн сэтгэлзүйн бэлэн байдалд анхаарч нээлттэй уур амьсгал бий болгох, байнга урамшуулах;
- өөрийгөө илэрхийлэх, бусдыг сонсон хүндэтгэж сурах боломж бүрдүүлэх;
- харилцах чадвар, дадлыг хөгжүүлэх, бие биедээ харилцан идэвхтэй нөлөөлөх зэрэг санаанууд юуны өмнө хэрэгжиж байхад анхаарах зэрэг онцлогтой сургалтын нэгэн төрөл байна

Мэдээлэл, шинжлэх ухаан, техник технологийн ололт ажилтад тулгуурлан зохион байгуулагдаж, суралцагчид хэрэгцээ, сонирхол, хурд, боловсролын түвшиндээ нийцүүлэн боломжтой цагтаа боловсрол эзэмших, түүнийгээ шинэчлэн баяжуулах нөхцөлөөр хангадаг энэхүү сургалтыг мэдээлэл харилцааны бүхий л техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар интернэтэд суурилан орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах үйл явц гэж тодорхойлсончлон энэхүү сургалтын төрлийг цахим сургалт, цахим зайн сургалт гэж 2 төрөлд хуваан авч үзэж, онцлогийг тодорхойлохыг зорилоо. Үүнд:

Цахим сургалт

Цахим сургалт-мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилан суралцагчид мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн танхимын, зайн болон виртуал сургалтын орчинд явагдах сургалтын бүх хэлбэрийн үйл ажиллагааг хэлнэ[36].

Цахим төхөөрөмж ашиглан харилцах орчин - цахим сургалтын программ хангамж нь компьютер болон бусад цахим төхөөрөмж ашиглан харилцааны орчинд хэлэлцүүлэг, мэтгэлцээн үүсгэх, цахим шуудангаар харилцах, шууд харилцах өрөө ашиглах боломжтой сургалтын орчин. Багш оюутнууд хэлэлцүүлэг үүсгэх, бүлэгт хуваарилах, нийтэд зориулсан ярилцлагын сэдэв оруулах гэх мэт үйлдэл гүйцэтгэдэг[37] онцлогтой байна.

[36] Сувдмаа, Т. Цахим сургалт. Уб., 11 дэх тал.

[37] Батсайхан, М. Боловсрол судлалын тайлбар толь. Уб., 2019.

Цахим зайн сургалт

Мэдээлэл, технологийн үсрэнгүй хөгжил нийгмийн бүхий л салбарт хувьсал хийсний нэг нь боловсролын салбар юм. 20-р зууны дунд үед уламжлалт сургалт буюу нүүр нүүрээ харсан сургалт зонхилж байсан бол орчин үед электрон сургалт, хосолсон сургалт илүү өргөн хүрээнд ашиглагдаж байна. Мэдээлэл холбооны технологийн асар хурдацтай хөгжил нь сургалтын арга хэлбэр, заах арга зүйг шинэчлэхэд хамгийн гол түлхэц болсон гэж үздэг[38].

Е сургалтын давуу тал

Цахим эриний уугуул иргэд болон цахим эринд нүүдэллэж ирсэн ахмад үеийнхний хооронд технологийн ур чадвар, сэтгэлгээний ялгаа ихээхэн гарч цахим сургалтын талаар нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй, маргаантай асуудал нэлээдгүй байгаа ч Е сургалтын үйл ажиллагааны давуу талыг нийтлэг байдлаар интернэт хэрэглэгчид болон цахим сургалтад хамрагдагсад дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Уян хатан байдал

Зөвхөн газарзүйн уян хатан байдал биш юм. Цаг хугацааны хувьд уян хатан байдал өөрийн хичээлийн хуваарийн талаар маш их эрх мэдэл бүхий багш нар онлайн хичээлээ сурагчдынхаа амьдралд зохицуулж болно гэсэн үг юм.

2. Бие даасан ур чадварыг дээшлүүлэх

Бие даан ажиллаж, сурч буй оюутнууд зайн сургалтад бүлгийн ажил тийм ч шулуун биш байдаг. Энэ нь бие даасан ажилд илүү их ач холбогдол өгдөг бөгөөд хожим нь ирээдүйд бүрэлдэн тогтох магадлалтай юм. Оюутнуудын хийдэг ихэнх ажил илүү олон бие даасан ажил хийх нь тэднийг их сургуульд элсэн ороход маш сайн бэлддэг бөгөөд тэд бие даан ажиллах боломжтой байх болно.

3. Ирээдүй гэрэлтэй байх

Цахим сургалт нь оюутнуудын ирээдүйд хамгийн урт хугацаанд нөлөөлөх байх. 2025 он гэхэд ойролцоогоор АНУ-ын ажиллах хүчний 70% алсын зайнаас сард дор хаяж ажлын 1 долоо хоног ажиллах болно.

4. Илүү интерактив

Орчин үеийн сургуулийн тогтолцооны гунигтай үнэн бол огт орчин үеийн биш юм. Бид Викторианы үед байсан нэг талын мэдээллийн хог хаягдлаар дамжуулан сурагчдадаа сурч байгаа хэвээр байна. 2024 онд ашиглагдах онлайн интерактив хэрэгслүүд нь багш нарт оюутнуудаа 2 талын болон бүлгийн ярианы аргаар жинхэнэ утгаар нь татан оролцуулах боломжийг олгоно.

5. Онлайн баримт бичгийг ашиглах

Цаас хэмнэх, онлайн баримт бичгийн тусламжтайгаар цахим архив үүснэ. Тухайлбал, Google Drive. үнэгүй бөгөөд энэ нь тэдэнд баримт бичиг, хавтас хийх, хуваалцах, гэрийн даалгавраа хянах, бусадтай хамтран оюутнуудад зориулсан материал дээр хамтран ажиллах боломжийг олгоно.

6. Ногоон дэлхийг бүтээх

Сурагчдын ирээдүйд асар их нөлөө үзүүлэх боломжтой цахим сургалтын давуу багш, оюутнуудын автомашин, галт тэргээр зорчих нь багасаж жил бүр хэдэн сая литр шатахуун хэмнэх боломжтой.

7. Зохион байгуулахад хялбар

[38] www.Wikipedia.com

Оюутанд өчигдөрхөн сурч мэдсэн зүйлээ санах нь ихэвчлэн хэцүү байдаг. Онлайн сургалт нь өмнөх мэдээлэлд нэвтрэх их амархан, цахим сургалтад бүх зүйл тогтмол байдаг.

8. Хяналт

Мэдээжийн хэрэг цоорхойг нөхөх технологи бас бий. Хэд хэдэн ширхэг байдаг чөлөөт программ хангамж оюутнуудын компьютерын дэлгэцийг үзэх, хэрэв тэд хамтран ажиллахаас татгалзсан бол оюутны дэлгэцийг түгжих, оюутны идэвхгүй үйлдлийн хянаж анхааруулга өгөх.

9. Цар тахал, халдварт өвчний үед боловсрол тасралтгүй үргэлжилнэ.

Цахим сургалт нь дараагийн цар тахлын үед боловсролоо үргэлжлүүлэх хамгийн сайн арга байх болно. Корона вирус нь цахим сургалтын туршилтын тест байсан боловч бид багш, оюутнууд илүү сайн бэлтгэгдсэн байх болно. Ийм зүйл тохиолдвол засгийн газар, сургуулиуд санхүүжилт хийж, сургалтын тасралтгүй байдлыг хангахын тулд цахим сургалтыг явуулахад боловсрол тасралтгүй үргэлжилнэ.

10. Нэргүй оролцоо

Багш нар бид бүгд ичимхий, идэвхгүй оролцоотой суралцагчид хувь нэмрээ оруулах магадлал өндөр байдаг хэрэв тэд үүнийг нэрээ нууцлан хийж чадвал олон тооны интерактив edtech программ хангамж нь оюутнуудад нэрээ нууцлан хариулах, асуулт тавих, ичгүүрээс айхгүйгээр хэлэлцүүлэг хийх боломжийг олгодог.

11. Татаж авах хичээлийн төлөвлөгөө

Цахим сургалтын эдгээр олон давуу талууд нь зөвхөн оюутнуудад нөлөөлөхгүй, харин багшид бас нөлөөлдөг долоо хоногт дунджаар багш нар зарцуулдаг 12-14 цаг хичээлийн төлөвлөгөө гаргах, тэмдэглэгээ хийх. Гэхдээ шинэ технологи нь багш нарт хэлэлцүүлгийн сэдэв, үнэлгээ, асуулт хариултын асуултууд бэлтгэхэд тусална.

12. Зохион байгуулалттай дүн шинжилгээ хийх


Жилийн туршид тууштай үнэлгээ хийх нь илүү үр дүнтэй болон өндөр давуу талтай ихэнх оюутнууд эцэст нь стресстэй ачаалалтай шалгалтад хамрагддаг. Edtech аналитик хэрэгсэл нь багш нарт хийж буй асуулт, хариулт бүр дээр сурагчдын гүйцэтгэлийг хэмжихэд тусалдаг зэрэг олон давуу талыг Е сургалт багш, суралцагчдад олгодог байна.

Дотоод хэргийн их сургуулийн хэмжээнд зохион байгуулагдаж буюу Е сургалтын давуу талыг 24 багш, 75 суралцагчаас асуулга авах хэлбэрээр судалгаа авч үнэлэлт өгөхийг оролдлоо.

Багшлах бүрэлдэхүүнээс авсан судалгаа:


Судалгаанд оролцсон багш нарыг албан тушаалын байдлаар нь ангилан авч үзвэл. Тэнхимийн профессор 3, ахлах багш 6, багш 8, эрдэм шинжилгээний ажилтан 4, бусад 1 нийт 24 багш тус тус оролцсон байна.

Зураг 1. Судалгаанд оролцогчдын албан тушаалын байдал:




Е сургалтын давуу тал юу вэ? гэсэн асуулгад судалгаанд оролцсон багш нар эдийн засаг, зардлын хэмнэлттэй 5, сургалт үр дүнтэй зохион байгуулагддаг 3, багшийн заар арга зүй дээшилдэг 1, дахин үзэх боломжтой 6, оюутан бие даан ажиллах чадвар нэмэгддэг 4, орон зайн хувьд хаанаас ч үзэх боломжтой 5 гэж тус тус хариулжээ.

Зураг 2. Е сургалтын давуу тал:



Е сургалтыг зохион байгуулах чиглэлийг тогтоох асуулгад зөвлөгөө өгөх 2, лекц унших 8, шалгалт авах 5, бие даалт өгөх 2, семинар явуулах 4, практик туршлага 1, явцын үнэлгээ гаргах 2 тус тус хариулжээ.

Зураг 3. Е сургалт зохион байгуулах чиглэл:



Суралцагчаас авсан судалгаа:


Е сургалтад хамрагдаж байсан эсэх талаар судалгаа авахад судалгаанд оролцогчдын 75 буюу 100% тийм гэж хариулсан байна.

Зураг 4. Е сургалтад хамрагдаж байсан эсэх талаар:



Е сургалтад хамрагдах давуу тал юу вэ? гэсэн асуулгад судалгаанд оролцогчид сургалтад хаанаас ч оролцох боломжтой 28, сургалтаар хэрэгцээтэй мэдээлэл олж авдаг 16, сургалт богино хугацаатай байдаг 11, сургалтад ямар ч төхөөрөмжөөр оролцох боломжтой 8, хэдэн ч удаа үзэх боломжтой 5, өөрийн үзэл бодлыг илэрхийлэх боломжтой 7 гэж тус тус хариулсан байна.

Зураг 5. Е сургалтын давуу тал:



Дээрх судалгааны дүнг нэгтгэн дүгнэж үзвэл Е сургалт нь цаг хугацаанаас үл хамааран хэдэн ч удаа үзэх, шаардлагатай мэдээллийг авах, орчин үеийн техник технологийг ашиглаж, бие даан суралцах чадвар эзэмшиж, эдийн засгийн хэмнэлттэй сургалт гэж дүгнэж болохоор байна.

Е сургалтын сул тал

Өнөөдөр хүн зөвхөн сургуулийн танхимд бус албан бус байдлаар хаа сайгүй сурах болжээ. Тийм учраас суралцахуйн орчин гэдэг ойлголт маш өргөн утгатай болж байна. Сургуулийн анги тахимаас гадна гэртээ сурах орчин, ажлын байранд сурах орчин, суралцахуйн стадион, виртуал орчин гээд олон янз байна. Хамгийн гол нь сурах орчин ухаалаг болж байна. Энэхүү ухаалаг орчинд дасан зохицох үйл явц хүндрэл бэрхшээлтэй байгаа хэдий ч дасан зохицохоос өөр сонголт бидэнд үлдээгүй билээ. Цахим сургалтын сул талуудыг хамгийн нийтлэг сэтгэгдлээс түүвэрлэн авч үзвэл дараах асуудал тулгарч байна. Үүнд:

1. Танил бус орчинд суралцах

Оюутнууд танил бус орчинд дасаж, дэлгэцэн дээр нүүрээ харуулснаар хэт их мэдрэг болж байна. Оюутнуудад багаар ажиллах боломж аажим аажмаар алга болж байна.

2. Хүн бүрд техник гэж байдаггүй

Оюутны нийгмийн байдал, ар гэрийн шалтгаанаар онлайн хичээлд оролцоход шаардагдах технологи хангалтгүй байдаг. Тэдгээрийн зарим нь амьдралын боломж тааруу гэр бүлээс гаралтай бөгөөд зөөврийн компьютер, интернэтийн зохистой холболт, ашиглахад зориулагдсан программ хангамжийг хэрэглэх санхүүгийн боломж хомс, мөн технологийн авьяас багатай байдаг. Технологитой, тэр ч байтугай удирдамжтай байсан ч тэд үүнийг хэрхэн ашиглахаа мэдэхгүй байж магадгүй юм.

3. Техникийн асуудлууд

Бидний амьдралд шинээр нэвтрэн орж ирж буй техник технологи нь ямарваа нэгэн саатал, тасалдал, доголдол зэргийн дагуулсан хэвээр байдаг.


4. Ангийг хянах нь илүү хэцүү байдаг

Цахим сургалтын нэг дэмжигч нь оюутнуудад хяналт тавих хэмжээ нь онлайнаар нэмэгддэг болохыг бид өмнө нь дурдсан. Гэсэн хэдий ч анги танхимын менежментийн хэрэгслүүд байгаа хэдий ч эдгээр нь танд зөвхөн ёс суртахуунгүй оюутнуудыг дангаар нь шийдвэрлэх боломжийг олгодог.

Багшлах бүрэлдэхүүнээс авсан судалгаа:


Цахим сургалтаар ямар хичээл заагддаг вэ гэсэн асуулгад судалгаанд оролцогчдын мэргэжлийн ерөнхий суурь хичээл 15, мэргэжлийн суурь хичээл 6, мэргэжлийн хичээл 3 гэж тус тус хариулжээ.

Зураг 6. Цахимаар заагдаж буй хичээлийн төрөл



Цахим сургалтын сул талыг юу гэж үздэг вэ? гэсэн асуулгад судалгаанд оролцогчдын цахим хичээл бэлтгэхэд хугацаа их шаардагддаг 7, оюутанд хичээлийн жишээ баримт кейс тайлбарлах боломжгүй байдаг 6, цахим хичээл боловсруулах дараалал төвөгтэй байдаг 4, оюутны оролцоог дүгнэх боломжгүй байдаг 5, хандлага төлөвшүүлэх боломжгүй байдаг 2 тус тус хариулжээ.

Зураг 7. Цахим сургалтын сул тал




Суралцагчаас авсан судалгаа:

Цахим сургалтад хамрагдахад хүндрэл, бэрхшээл юу вэ байдаг вэ? гэсэн асуулгад судалгаанд оролцогчдын дата байхгүй 18, багшийн техникийн мэдлэг муу 5,


олон хичээл давхацдаг 11, сүлжээгүй орчинд хичээл цахим хичээл зарлагддаг 7, ар гэрийн шалтгаанаар хичээлд хамрагдаж чаддаггүй 6, гар утас, компьютер байхгүй 5, цахим хичээл цагтаа эхэлдэггүй 4, хичээл дундаас тасардаг 6, хичээл ойлгомжгүй байдаг 5, шалгалтад хангалтгүй дүн үзүүлдэг 4, үнэлгээ бодитой тооцогддоггүй 4 гэж тус тус хариулсан байна.

Зураг 8. Цахим сургалтын сул тал



Нийт судалгаанд оролцогчдоос цахим сургалтыг үр дүнтэй явуулахад шаардлагатай арга зүй, технологийн талаар таны бодол гэсэн асуулгад цагийн хуваарийг баримтлах шаардлагатай 19, бэлтгэл ажлыг хангах шаардлагатай 11, албан ёсны программ ашиглах шаардлагатай 26, чанартай видео камер ашиглах шаардлагатай 14, багш, суралцагч дасгал ажиллах ижил боломжоор хангагдах шаардлагатай 15, үнэлгээний тогтолцоог бодитой болгох 14 гэж тус тус хариулжээ.

Зураг 9. Цахим сургалтыг үр дүнтэй явуулахад шаардлагатай арга зүй, технологи



Е сургалтын сул талыг нэгтгэн дүгнэж үзвэр багш болон суралцагчийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай, багшаас хичээл бэлтгэхэд өндөр ур чадвар шаарддаг, сургалтыг жишээ баримтаар тайлбарлах харилцаанд орох боломжгүй, интернэтийн болон техник хэрэгслийн дутмаг байдалтай, цаг баримталдаггүй, багшийн завтай үеэр зохион байгуулагддаг, оюутны оролцоо багатай гэсэн урьдчилсан дүгнэлт хийж болохоор байна.

Иймд судалгааны үр дүнг найдвартай байлгах үүднээс SPSS 26.0 программ ашиглан статистик боловсруулалт хийж, судалгааны үр дүнг тооцохдоо дундаж, медиан, стандарт хазайлт, хамгийн их болон хамгийн бага утга, хамаарлын статистик шинжилгээ, сорилын найдварт чанарыг шалгах шинжилгээг тус тус хийсэн.

ДҮГНЭЛТ

Е сургалтыг хүн бүр хэрэгцээтэй үедээ хүссэн цагтаа бүтээлчээр суралцан хөгжих, боловсролоо байнга шинэчлэн баяжуулж байх үзэл санаагаар боловсролын тогтолцоог хөгжүүлж байгаа олон улсын жишиг практик байна. Манай улсын боловсролын тогтолцоо хоцрохгүй байхын төлөө эрмэлзэж байна. Энэхүү асуудлыг хэрэгжүүлэх сургалтын технологийн нэг хувилбар нь Е-сургалт (electronic learning буюу e learning) юм. Е-сургалт гэдэг нь товчхондоо мэдээллийн технологийн хэрэгслүүдийг сургалтад ашиглах гэж дүгнэж байна.

Жорж Сайменсийн 2004 онд дэвшүүлсэн Коннективист онолд суурилж, бехевиоризм, когнивизм, конструктивизм, коннективизм зэрэг онолын үзэл баримтлалаар хөгжиж өнөөдрийн хүрчээ.

Е сургалтын төрлийг ерөнхийд нь цахим сургалт, цахим зайн сургалт гэж 2 төрөлд хуваан авч үзэж болно.

Е сургалт нь цаг хугацаанаас үл хамааран хэдэн ч удаа үзэх, шаардлагатай мэдээллийг авах, орчин үеийн техник технологийг ашиглаж, бие даан суралцах чадвар эзэмшиж, эдийн засгийн хэмнэлттэй зэрэг олон давуу талт сургалтын хэлбэр юм.

Сул талыг нэгтгэн дүгнэж үзвэл багш болон суралцагчийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай, багшаас хичээл бэлтгэхэд өндөр ур чадвар шаарддаг, сургалтыг жишээ баримтаар тайлбарлах харилцаанд орох боломжгүй, интернэтийн болон техник хэрэгслийн дутмаг байдалтай, цаг баримталдаггүй, багшийн завтай үеэр зохион байгуулагддаг, оюутны оролцоо багатай байх сул талыг агуулж байх магадлалтай байна.

Цаашид Е сургалтыг зохион байгуулахад сургалтын хөтөлбөр, цагийн хуваарь, суралцагчдын хүртээмжтэй байдлыг тооцоолж, үнэлгээний системийг боловсронгуй болгох шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч байна

САНАЛ

1. Сургалтын үйл ажиллагааг танхимын болон цахим хэлбэр хосолсон (Hybrid сургалтын хөтөлбөр)- өөр зохион байгуулах;

2. Багш болон суралцагчийг шинэлэг техник технологийг ашиглах сургалтад хамруулах;

3. Цахим хичээлийн нэгдсэн сан бий болгох;

4. Их сургуулийн хэмжээнд ашиглах нэгдсэн платформыг хөгжүүлэх;

5. Цахим хичээлийн үнэлгээний журмыг шинэчлэн боловсруулах;

6. Их сургуулийн хэмжээнд ашиглах интернэтийн хурд, хүрэлцээг сайжруулах гэсэн саналыг тус тус дэвшүүлж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Даваа, Ж. Сургалтын технологи. - Уб., 2018.

2. Содов, Ц. Пүрэв, Ц. Сургалтын арга барил, технологийн шинэчлэлийн асуудал. -Уб., 2011.

3. Батхуяг, С, Баярмаа, Д нар Дээд сургуулийн сурган хүмүүжүүлэх зүй. - Уб., 2003.

4. Бадарч, Д. Дээд боловсролын онол, арга зүй. - Уб., 2020.

5. Алтантуяа, Д, Одонтуяа, О. Дотоод хэргийн их сургуулийн бакалаврын сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж буй өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ // Хууль зүйн боловсрол судлалын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага. Уб., 2021.

6. Алимаа, Ж. Онлайн сургалтын агуулга хөгжүүлэх арга зүйн судалгаа нэг сэдэвт бүтээл. - Уб., 2013.

7. Ганбат, Ц. Сурах ба сургах үйл явцад ашиглагдах цахим контент хөгжүүлэх арга зүй ба хэрэгслүүд. - Уб., 2012.

8. Бадарч, Д. Дээд боловсролын онол, арга зүй. - Уб., 2021.

9. Сувдмаа, Т. Цахим сургалт. - Уб., 2005.

10. Батсайхан, М. Боловсрол судлалын тайлбар толь. - Уб., 2019.

11. David, L. (2015, December). E-learning Theory (Mayer, Sweller, Moreno). *Learning Theories*.https://www.learning-theories.com/e-learning-theory-mayer-sweller moreno.html.

12. www.Wikipedia.com

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН СПОРТООР ХИЧЭЭЛЛЭДЭГ СОНСОГЧ, СУРАЛЦАГЧ ХИЧЭЭЛЛЭДЭГГҮЙ СОНСОГЧ, СУРАЛЦАГЧДЫН ЯЛГААТАЙ БАЙДАЛ БИЕ БЯЛДАР, АЧААЛАЛ ДААХ ЧАДВАР

Д.ТҮМЭНЦЭЦЭГ*

Дотоод хэргийн их сургуулийн Биеийн тамир, албаны бэлтгэлийн соёмбо төвийн багш, ахлах дэслэгч

**Хариуцлагатай зохиогч: dtumee666@gmail.com*

Хураангуй: Дотоод хэргийн их сургуулийн 1-4 дүгээр дамжааны 18-24 насны 114 сонсогч, суралцагчийг хамруулан спортоор тогтмол хичээллэдэг (57) болон хичээллэдэггүй (57) сонсогч, суралцагчдын бие бялдар, ачаалал даах чадварыг харьцуулсан судалгааг хийв. Биеийн тамир, спортын газрын Эрдэм шинжилгээний албанаас боловсруулан гаргасан хүний биеийн ерөнхий хөгжлийн түвшин тогтоох сорилын болон биеийн жингийн индексийг ашиглав.

Үр дүнгээс харахад спортоор хичээллэдэг оюутнууд бүх сорилд илүү өндөр үнэлгээ авч “Хангалттай сайн” болон “Хангалттай” түвшинд байсан бол спортоор хичээллэдэггүй оюутнууд ихэнхдээ “Сайн” ба “Дунд” түвшинд байв. Биеийн жингийн индексээр спортоор хичээллэдэггүй бүлэгт туранхай (37%) болон 1-р зэргийн таргалалт (5%) илүү өндөр байлаа.

Судалгааны таамаглал бүрэн батлагдаж, спортоор тогтмол хичээллэх нь оюутнуудын бие бялдар, ачаалал даах чадварыг мэдэгдэхүйц сайжруулдаг гэдэг нь тодорхой болов.

Түлхүүр үг: Сонсогч, суралцагч, спорт, бие бялдар, ачаалал даах чадвар, хөдөлгөөний идэвхжил, биеийн тамир, биеийн жингийн индекс

Оршил: Сүүлийн жилүүдэд дэлхий даяар техник технологи, хиймэл оюун ухаан, Chatbot-ууд хурдацтай хөгжиж байгаатай холбоотойгоор хүмүүсийн биеийн идэвхтэй хөдөлгөөн тодорхой хэмжээнд буурч, эрүүл мэнд, бие махбодод сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл тулгараад байна. Ялангуяа сошиал орчинтой ойр өссөн Gen Z үеийн оюутан залуусын хувьд сошиал хэрэглээ нэмэгдэх, хөдөлгөөний дутагдалд орох, суугаа амьдралын хэв маягтай болох хандлага ажиглагдаж, бие бялдрын боловсрол, спортоор хичээллэх хэрэгцээ шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байгаа юм (Sedentary society: the impact of the digital era on physical activity levels, 2023).

Биеийн тамирын идэвхгүй байдал нь халдварт бус өвчний гол эрсдэлт хүчин зүйл болж, дэлхийн хэмжээнд цаг бусаар нас барах шалтгааны дөрөвдүгээрт жагсаад байна (Physical inactivity, 2022). Харин тогтмол биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийдэг оюутнуудын булчингийн хүч, тэсвэр хатуужил, зүрх судасны үйл ажиллагаа илүү сайн хөгждөг болохыг олон судалгаагаар нотолсон (Medicine, 2018).

Иймд спортоор хичээллэдэг болон хичээллэдэггүй оюутнуудын ялгаатай байдал, бие бялдрын ачаалал даах чадварыг харьцуулан судлах нь нэлээдгүй ач холбогдолтой юм.

Судалгааны зорилго, зорилт: Спортоор хичээллэдэг оюутан хичээллэдэггүй оюутнуудын ялгаатай байдал болон бие бялдар, ачаалал даах чадварыг харьцуулан тодорхойлоход оршино.

Судалгааны үндэслэл: Технологийн дэвшил нь оюутнуудын сурах үйл ажиллагааг хөнгөвчилсөн боловч биеийн идэвхийг хязгаарлаж байна. Иймд оюутнуудын дундах спортын идэвхийн ялгаа нь тодорхой хэмжээнд өөр байж ирээдүйн эрүүл мэндийн асуудлынх нь гол хүчин зүйл болж болзошгүй тул энэхүү харьцуулалтыг хийх шаардлагатай.

Судалгааны объект: Дотоод Хэргийн Их Сургуулийн сонсогч, суралцагчид

Судалгааны таамаглал: Спортоор хичээллэдэг оюутнууд спортоор хичээллэдэггүй оюутнуудаас бие бялдар, ачаалал даах чадвар илүү сайн байх магадлалтай.

ҮНДСЭН ХЭСЭГ


Биеийн тамир, спортын газрын Эрдэм шинжилгээний албанаас боловсруулан гаргасан хүний биеийн ерөнхий хөгжлийн түвшин тогтоох сорилын дагуу гарын хүч, хөлийн хүч, биеийн хүч, хурд, уян хатан, тэнцвэр гэсэн төрлүүдээс Дотоод хэргийн их сургуулийн 1, 2, 3, 4 дүгээр дамжааны 18-24 насны нийт 114 сонсогч, суралцагчаас сорил хамруулан, тэдний биеийн жингийн индексийг тодорхойлов. Уг сорилд хамрагдсан сонсогч, суралцагчдын 50% нь буюу 57 нь спортоор тогтмол хичээллэдэг (Сагсан бөмбөг, Волейбол, Жүдо, Чөлөөт бөх, Таеквондо) үлдсэн нь тогтмол хичээллэдэггүй сонсогч, суралцагчид байсан.

1. Гарын хүч

Гарын хүч тодорхойлох дасгал нь гар дээр суниах. Гар мөрний хэмжээтэй, биеэ шулуун байрлалд эрэгтэй хөлөө эгц тавин, эмэгтэй хөлөө өвдгөн дээрээ тулж 30 секундийн хугацаанд суниан, суниалтын тоогоор оноо өгөн үнэлнэ.

Хүйс	Нас	Оноо				
		1	2	3	4	5
Эрэгтэй	18-24	0-2 удаа	3-5 удаа	6-10 удаа	11-20 удаа	21 ба түүнээс дээш
Эмэгтэй	15-24	0-1 удаа	2 удаа	3-5 удаа	даа	11 ба түүнээс дээш

(Хүснэгт 1.)



(График 1.)

Гарын хүчний хувьд спортоор хичээллэдэг сонсогч, суралцагчдын чадвар хангалттай түвшинд буюу 5 гэсэн үнэлгээтэй байгаа бол спортоор хичээллэдэггүй сонсогч, суралцагчид харьцангуй ялгаатай байгаа нь графикаас харагдаж байна.

2. Хөлийн хүч

Хөлийн хүчийг тодорхойлохдоо гараа дээш өргөж зогссон хэмжээн дээр насны ангилалд заасан хэмжээг нэмэн (18-24 насныхны хувьд 30 см) хүрэх ёстой өндрийн хэмжээг тодорхойлон, суугаа байдлаас 2 хөлөө зэрэг түлхэн тухайн хэмжээнд хүрч үсэрнэ. 1 минутад хэдэн удаа тухайн өндөртөө хэдэн удаа хүрч чадсан тоогоор үнэлгээ өгнө.

Хүйс	Нас	Оноо				
		1	2	3	4	5
Эрэгтэй	18-24	0-7 удаа	8-10 удаа	11-12 удаа	13-14 удаа	15 ба түүнээс дээш
Эмэгтэй	15-24	0-1 удаа	2 удаа	3-5 удаа	6-10 удаа	11 ба түүнээс дээш

(Хүснэгт 2.)



(График 2.)


Хөлийн хүчний хувьд мөн л спортоор хичээллэдэг сонсогч, суралцагчид бүгд дээд түвшинд байхад спортоор хичээллэдэггүй хангалттай түвшинд байгаа ганцхан суралцагч байна.

3. Биеийн хүч

Биеийн хүчийг тодорхойлохдоо хэвтээ байдлаас цээжээ өргөн өндийж суух буюу гэдэс таталтыг 30 секундэд хэдэн удаа хийснээр нь тооцож үнэлгээ өгнө.

Хүйс	Нас	Оноо				
		1	2	3	4	5
Эрэгтэй	18-24	12-15 удаа	16-21 удаа	22-26 удаа	27-32 удаа	33 ба түүнээс дээш
Эмэгтэй	15-24	7-10 удаа	11-14 удаа	15-19 удаа	20-25 удаа	26 ба түүнээс дээш

(Хүснэгт 3.)



(График 3.)


Биеийн хүчний хувьд сонсогч, суралцагчид харьцангуй өөр байгаа ч гэсэн спортоор хичээллэдэг сонсогч, суралцагчид хичээллэдэггүй сонсогч, суралцагчдаас илүү чадвартай байгаа нь харагдаж байна.

4. Хурдны чанар

Хурдны чанарыг 10 секундийн хугацаанд байрандаа гүйн, 1 хөлийн алхалтыг тоолж 2-оор үржүүлэн үнэлгэ өгнө.

Хүйс	Нас	Оноо				
		1	2	3	4	5
Эрэгтэй	18-24	0-20 удаа	21-35 удаа	36-45 удаа	45-55 удаа	56 ба түүнээс дээш
Эмэгтэй	15-24	0-20 удаа	21-25 удаа	26-35 удаа	36-45 удаа	46 ба түүнээс дээш

(Хүснэгт 4.)



(График 4.)

Хурдны чанарт ч мөн адил спортоор хичээллэдэг сонсогч, суралцагчид илүү байгаа нь графикаас ажиглагдаж байна.


5. Уян хатан чанар

Уян хатан чанарыг суугаа байдлаас урагш бөхийн урд байрлах хайрцгийг түлхэнэ. Хэмжилт хийхдээ өвдөгнөөс хайрцгийн ирмэг хүртэлх зайг см-ээр хэмжиж тогтоон үнэлгээ өгнө.

Хүйс	Нас	Оноо				
		1	2	3	4	5
Эрэгтэй	18-24	0-27 см	16-21 удаа	22-26 удаа	27-32 удаа	33 ба түүнээс дээш
Эмэгтэй	15-24	7-10 удаа	11-14 удаа	15-19 удаа	20-25 удаа	26 ба түүнээс дээш

(Хүснэгт 5.)

График 5.)




Спортоор хичээллэдэггүй сонсогч, суралцагчдын хувьд уян хатан чанар хангалттай сайн биш байгаа нь графикаас ажиглагдаж байна.

6. Тэнцвэр

Тэнцвэр, авхаалж самбааг 2 гараа урагш өргөн нүдээ аньж, байрандаа өвдөг өндөр өргөн 50 удаа алхана. Байрнаас хөдөлсөн зайг хэмжиж үнэлгээ өгнө.

Хүйс	Нас	Оноо				
		1	2	3	4	5
Эрэгтэй	18-24	21 см ба түүнээс дээш	20-16 см	15-11 см	10-6 см	5 хүртэлх см
Эмэгтэй	15-24	21 см ба түүнээс дээш	20-16 см	15-11 см	10-6 см	5 хүртэлх см

(Хүснэгт 6.)




(График 6.)

Тэнцвэрийн хувьд сонсогч суралцагчдын чадвар харьцангуй адилгүй байгаа бөгөөд дийлэнх спортоор хичээллэдэг сонсогч, суралцагчид чадвараараа сайн байна.

Бие бялдар, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын нийлбэр дүнг дараах байдлаар дүгнэнэ.

Үнэлгээ	Оноо	Насны ангилал	Үнэлгээ
		18-24 нас	
A	5	25 ба түүнээс дээш оноо	Хангалттай сайн
B	4	21-24 оноо	Хангалттай
C	3	17-20 оноо	Сайн
D	2	13-16 оноо	Дунд
F	1	12 хүртэлх оноо	Хангалтгүй

(Хүснэгт 7.)



(График 7.)

Сорилын үр дүнд хангалттай сайн, хангалттай гэсэн үнэлгээг зөвхөн спортоор хичээллэдэг сонсогч, суралцагчид авсан байгаа нь графикаас харагдаж байна. Хэдий спортоор хичээллэдэггүй сонсогч, суралцагчид сайн, дунд гэсэн үнэлгээ авсан ч гэсэн энэ хангалтгүй юм. Учир нь тэдний биеийн жингийн индекс хангалттай хэвийн түвшинд байгаагүй.

Биеийн жингийн индексээр спортоор хичээллэдэг сонсогч, суралцагчдын 15% буюу 8 сонсогч, суралцагч туранхай байсан бол спортоор хичээллэдэггүй сонсогч, суралцагчдын хувьд 37% буюу 21 сонсогч, суралцагч туранхай, 5% (3 сонсогч, суралцагч) нь 1-р зэргийн таргалалтай байна.

Дүгнэлт

Судалгаагаар Дотоод хэргийн их сургуулийн 114 сонсогч, суралцагчийг хамруулан биеийн тамир, спортын газрын Эрдэм шинжилгээний албанаас боловсруулан гаргасан хүний биеийн ерөнхий хөгжлийн түвшин тогтоох сорилын дагуу, спортоор тогтмол хичээллэдэг болон хичээллэдэггүй сонсогч, суралцагчдын бие бялдар, ачаалал даах чадварыг харьцууллаа.

Судалгааны үр дүнгээс харахад спортоор хичээллэдэг 57 сонсогч суралцагч бүх сорилд (гарын хүч, хөлийн хүч, биеийн хүч, хурд, уян хатан чанар, тэнцвэр) илүү өндөр үнэлгээ авч, “Хангалттай сайн” болон “Хангалттай” түвшинд байгаа бол спортоор хичээллэдэггүй 57 оюутан ихэнхдээ “Сайн” ба “Дунд” түвшинд байв. Биеийн жингийн индексээр ч спортоор хичээллэдэггүй бүлэгт туранхай болон таргалалт илүү их ажиглагдсан.

Ингэснээр судалгааны таамаглал бүрэн батлагдаж, спортоор тогтмол хичээллэх нь оюутнуудын бие бялдар, ачаалал даах чадварыг мэдэгдэхүйц сайжруулдаг гэдэг нь тодорхой боллоо.

Эх сурвалж: (Д.Түмэнцэцэг. 2026);

(Биеийн тамир, спортын улсын хороо, sport.gov.mn)

“ХИЛИЙН АЛБАНЫ ОФИЦЕРУУДЫН БИЕ БЯЛДРЫН БЭЛТГЭЛЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ”

Х.ТҮВШИНТӨГС*
ДХИС-ийн Албаны бэлтгэл “Соёмбо” төвийн ахлах багш, дэд хурандаа

**Хариуцлагатай зохиогч: Х.Түвшинтөгс*

Хураангуй: Хилийн албаны офицеруудын бие бялдрын бэлтгэлжилт болон биеийн индекс стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг статистик аргаар шинжлэн судлахад ерөнхий үнэлгээ дунд түвшинд гарлаа. Судалгаагаар офицеруудын нас ахих тусам биеийн жингийн илүүдэл нэмэгдэж, энэ нь зүрх судасны тэсвэр болон хурдны үзүүлэлт буурахад шууд нөлөөлж байгаа тул албаны онцлогт тохирсон эрүүл мэндийн цогц хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: Цэргийн биеийн тамирын стандарт, Бие бялдрын бэлтгэлжилт, Биеийн зохистой харьцаа, Хилийн албаны офицер, Насны ангилал

Оршил

Монгол Улсын “Цэргийн биеийн тамирын заавар”[39] /ЦБТЗ-18/ нь цэргийн алба хаагчийн бие бялдрын бэлтгэжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах арга зүйг тодорхойлсон цэргийн биеийн тамирын ажлын үндсэн баримт бичиг юм. Энэхүү зааврын дагуу Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт хэрэгжинэ. Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт нь Монгол Улсын Төрийн цэргийн байгууллагууд, тэдгээрийн харьяа нэгтгэл анги, салбарт цэргийн биеийн тамирын бэлтгэлийг зохион байгуулах, цэргийн алба хаагчдын бие бялдрын түвшинг тогтоох, иргэнийг цэргийн бүх шатны сургуульд элсүүлэх, цэргийн алба хаагчийг албан тушаалын шаардлага хангаж буй эсэхийг тогтооход оршино.[40] Уг стандарт нь Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэрэг болон Онцгой байдлын алба хаагчид, цэргийн сургуулийн сонсогчдын бие бялдрын түвшинг тогтоох, иргэнийг цэргийн сургуульд элсүүлэх, алба хаагчийг албан тушаалын шаардлага хангаж буй эсэхийг магадлах гол шалгуур болдог.

Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт дараах бүтэцтэй:

6.1 Биеийн тамирын бэлтгэлийн стандартын шалгуур үзүүлэлт;

6.1.1 Бие бялдрын бэлтгэлжилтийн норматив;

6.1.2 Биеийн зохистой харьцаа

6.1.2.1 Биеийн өндөр, жингийн харьцаа;

6.1.2.2 Бүсэлхий ташааны тойргийн харьцаа;

8.1 Цэргийн алба хаагчдын биеийн тамирын бэлтгэлийг зохион байгуулах, шалгаж үнэлэх үйл ажиллагааг доорх насны ангиллаар явуулна. Үүнд:

8.1.1 Эрэгтэй: 18-25, 26-30, 31-35, 36-40, 41-45, 46-50, 51-55, 56-аас дээш;

8.1.2 Эмэгтэй: 18-25, 26-30, 31-35, 36-40, 41-45, 46-с дээш;

13.1 Цэргийн алба хаагчийн “Биеийн тамирын бэлтгэлийн стандартын шалгуур үзүүлэлт”- ийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг “Бие бялдрын бэлтгэлжилтийн норматив”-ын болон “Биеийн зохистой харьцаа”-ны нийлбэрээр тодорхойлно.

Бие бялдрын бэлтгэлжилтийн нормативын үнэлгээ:

Гар дээр суниалт;

[39] Зэвсэгт хүчний тухай хууль

[40] Эрүүл мэндийг хамгаалах технологи – Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт

10х10 метр гүйлт;
1000 метр гүйлт;
Цогцолбор дасгал;
Сууж урагш бөхийх;

Үндэслэл

Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны офицеруудын бие бялдрын бэлтгэлжилтийн нормативын шалгалтын биеийн тамирын бэлтгэлийн стандартын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох нь алба хаагчдын үүрэг гүйцэтгэх чадвар, эрүүл мэндийн байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэхэд оршино.

Хилийн албаны онцлог нь эрс тэс уур амьсгал, байгалийн хүнд нөхцөлд урт хугацаагаар үүрэг гүйцэтгэхийг шаарддаг тул офицеруудын бие бялдрын түвшин нь зөвхөн хурд, хүчээр хязгаарлагдахгүй, биеийн зохистой харьцаа (BMI) болон тэсвэр хатуужлын цогц нэгдэл байх ёстой. Иймд ЦБТЗ-18 заавар болон холбогдох стандартын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийснээр офицеруудын бэлтгэлжилтийг насны ангилал тус бүрээр бодитой тогтоох, цаашдын сургалт, бэлтгэлийн төлөвлөлтийг боловсронгуй болгох үндэслэл болж байна.

Хэрэгцээ, шаардлага

Орчин үеийн цэргийн алба хаагчдын дунд хөдөлгөөний дутагдал, хооллолтын буруу зуршил болон стрессээс үүдэлтэй биеийн жингийн илүүдэл үүсэх хандлага ажиглагдаж байна. Тиймээс "Эрүүл мэндийг хамгаалах технологи"-ийн дагуу биеийн өндөр, жингийн харьцаа, бүсэлхий ташааны тойргийг насны ангилал болон цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандартын хэрэгжилтийг судалснаар, офицеруудыг мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх нэн шаардлагатай байна.

Судлагдсан байдал

Олон улсын түвшинд цэргийн биеийн тамирын стандартыг зөвхөн хурд, хүчний үзүүлэлтээр хязгаарлахгүй, "Functional Fitness" буюу байлдааны талбарт үүрэг гүйцэтгэх бодит чадварт суурилан шинэчлэх хандлага давамгайлж байна. АНУ-ын Армийн ACFT (Army Combat Fitness Test) болон ОХУ-ын НФП-2023 зэрэг стандартууд нь алба хаагчийн биеийн өөхний хэмжээ, зүрх судасны ачаалал даах чадварыг насны ангиллаас гадна албаны онцлогтой нь уялдуулан судалсан байдаг (NATO, 2020). [41]

Судлаач К.Кроуфорд (2021) нарын бүтээлд офицеруудын биеийн зохистой харьцаа (BMI) алдагдах нь тэдний удирдлагын шийдвэр гаргах хурд болон сэтгэл зүйн тэсвэрт сөргөөр нөлөөлдөг болохыг статистик аргаар нотолсон байна.[42]

Монголын цэргийн биеийн тамирын шинжлэх ухааны суурийг Ш.Долгор, Г.Мягмаржав (2015) нарын судлаачид тавьсан. Тэд цэргийн алба хаагчийн бие бялдрын хөгжлийн онцлогийг монгол хүний бие организмын чадавхтай уялдуулан судалж, анхны "ЦБТ-1" зааврын нормативыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулсан. Эдгээр судалгаанууд нь алба хаагчдын хурд, хүч, тэсвэр хатуужлыг насны ангиллаар үнэлэх тогтолцооны эхлэлийг тавьсан юм.[43]

Дэвшүүлж буй асуудал

[41] NATO. (2020). Optimization of military performance through physical training standards. Science and Technology Organization.
[42] Crawford, K. (2021). Physical readiness and its impact on military leadership and health. Journal of Military Science.
[43] Долгор, Ш., & Мягмаржав, Г. (2015). Цэргийн биеийн тамирын арга зүй. Улаанбаатар.

- Офицеруудын бэлтгэлжилт стандарт шаардлагад хүрч байна уу?
- Офицеруудын биеийн индекс стандарт шаардлагад нийцэж байна уу
- Офицеруудын бэлтгэлжилт стандарт шаардлагад хэрэгжихийн тулд юу шаардлагатай байна вэ?

Судалгааны шинэлэг тал

Энэхүү судалгаагаар Хилийн албаны офицеруудын бодит үзүүлэлтүүдийг стандартын шалгууртай харьцуулан, тэдний бэлтгэлжилтийн түвшин стандартад нийцэж буй эсэхийг насны ангилал тус бүрээр бодитой тогтоож байгаагаараа шинэлэг юм. "Эрүүл мэндийг хамгаалах технологи – Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт"-ын хүрээнд биеийн зохистой харьцаа (BMI, бүсэлхий ташааны тойрог) нь цэргийн нормативын оноонд хэрхэн нөлөөлж буй хамаарлыг Хилийн албаны офицеруудын жишээн дээр цогц байдлаар шинжлэн судалж байна. Мөн офицеруудын бие бялдрын стандартын нийцлийг дээшлүүлэх бодит гарц, шийдлийг санал болгож байгаагаараа практик ач холбогдолтой.

Зорилго

Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандартын хэрэгжилтийг Хилийн албаны офицеруудын жишээн дээр шинжлэн судалж, тэдний бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин болон биеийн зохистой харьцаа нь стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг тогтооход оршино.

Зорилт


- Хилийн албаны офицеруудын бие бялдрын бэлтгэлжилтийн нормативын биелэлтийг насны ангилал тус бүрээр статистик аргаар боловсруулж, стандартад нийцэж буй байдлыг тодорхойлох;
- Судалгааны үр дүнд үндэслэн офицеруудын стандартын нийцлийг дээшлүүлэх, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулах.

Судалгааны арга зүй

- Хэмжилт ба сорилын арга
- Статистик шинжилгээ

Судалгааны хэсэг

Нийт 257 офицер судалгаанд хамрагдсан бөгөөд 57.6% буюу 148 эрэгтэй, 42.4% буюу 109 эмэгтэй албан хаагч оролцсон.



Офицеруудын насны ангилал

Эрэгтэй офицер

Насны ангилал	Офицерын тоо (n)	Амжилтын хувь (%)	БЗХ Хангасан (Эрүүл)	БЗХ Хангаагүй (Илүүдэл жин)
18-25 нас	4	30.4%	4	0
26-30 нас	9	54.6%	7	2
31-35 нас	39	74.2%	23	16
36-40 нас	33	31.0%	22	11
41-45 нас	28	54.6%	17	11
46-50 нас	20	51.7%	10	10
51-55 нас	12	78.0%	7	5
56-аас дээш	3	49.2%	2	1
НИЙТ / ДУНДАЖ	**148**	**71.2% (Дунд)**	**94 (63.5%)**	**54 (36.5%)**

Эмэгтэй офицер

Насны ангилал	Офицерын тоо (n)	Амжилтын хувь (%)	БЗХ Хангасан (Эрүүл)	БЗХ Хангаагүй (Илүүдэл жин)
18-25 нас	2	72.6%	2	0
26-30 нас	8	59.4%	7	1
31-35 нас	29	75.6%	21	8
36-40 нас	25	66.5%	16	9
41-45 нас	22	68.7%	14	8
46-аас дээш	23	53.8%	16	7
НИЙТ / ДУНДАЖ	**109**	**65.7% (Дунд)**	**76 (69.7%)**	**33 (30.3%)**

1. Эрэгтэй офицерууд

Насны ангилал	Тоо (n)	ББББШҮ амжилт (%)	БЗХ Хангасан	БЗХ Хангаагүй
18-25 нас	4	30.4%	4	0
26-30 нас	9	54.6%	7	2
31-35 нас	39	74.2%	23	16
36-40 нас	33	31.0%	22	11
41-45 нас	28	54.6%	17	11
46-50 нас	20	51.7%	10	10
51-55 нас	12	78.0%	7	5
56-аас дээш	3	49.2%	2	1
НИЙТ / ДУНДАЖ	**148**	**71.2% (Дунд)**	**94 (63.5%)**	**54 (36.5%)**

Судалгаанд хамрагдсан 148 эрэгтэй офицеруудын бие бялдрын бэлтгэлжилтийн дундаж амжилт 71.2% буюу "ДУНД" үнэлгээтэй гарсан байна. Энэ нь офицеруудын бие бялдрын бэлтгэлжилт байнгын бэлэн байдлын шаардлагад нийцэхүйц түвшинд байгаа боловч сайжруулах шаардлагатайг харуулж байна.

2. Эмэгтэй офицерууд

Насны ангилал	Тоо (n)	БББШҮ амжилт (%)	БЗХ Хангасан	БЗХ Хангаагүй
18-25 нас	2	72.6%	2	0
26-30 нас	8	59.4%	7	1
31-35 нас	29	75.6%	21	8
36-40 нас	25	66.5%	16	9
41-45 нас	22	68.7%	14	8
46-аас дээш	23	53.8%	16	7
НИЙТ / ДУНДАЖ	**109**	**65.7% (Дунд)**	**76 (69.7%)**	**33 (30.3%)**

Судалгаанд хамрагдсан 109 эмэгтэй офицеруудын бие бялдрын бэлтгэлжилтийн (ББББШҮ) дундаж амжилт 65.7% буюу "ДУНД" үнэлгээтэй байна. Энэ нь эрэгтэй офицеруудын үзүүлэлттэй (71.2%) харьцуулахад 5.5%-аар бага байгаа нь эмэгтэй алба хаагчдын нормативын гүйцэтгэлийг сайжруулах, ялангуяа тэсвэр болон хүчний дасгал дээр анхаарах шаардлагатайг харуулж байна.

ББББШҮ-ын ерөнхий үнэлгээ

Эмэгтэй офицер

Дасгалын төрөл	Амжилтын хувь (%)	Ерөнхий үнэлгээ	Онцлох үзүүлэлт
Гар дээр суниах	65.07%	**Дунд**	40.2% нь "Муу" авсан.
10x10 метр гүйлт	61.66%	**Дунд**	Тархалт жигд.
1000 метр гүйлт	38.40%	**Хангалтгүй (Муу)**	65.2% нь "Муу" авсан (Хамгийн сул).
Цогцолбор дасгал	81.80%	**Сайн**	61.6% нь "Онц" авсан.
Сууж урагш бөхийх	96.70%	**Маш сайн**	86.6% нь "Онц" авсан.
ББББШҮ Нэгдсэн дүн	**65.7%**	**ДУНД**	

Эрэгтэй офицер

Дасгалын төрөл	Амжилтын хувь (%)	Ерөнхий үнэлгээ	Онцлох үзүүлэлт
Гар дээр суниах	65.07%	**Дунд**	40.2% нь "Муу" авсан.
10x10 метр гүйлт	61.66%	**Дунд**	Тархалт жигд.
1000 метр гүйлт	38.40%	**Хангалтгүй (Муу)**	65.2% нь "Муу" авсан (Хамгийн сул).
Цогцолбор дасгал	81.80%	**Сайн**	61.6% нь "Онц" авсан.
Сууж урагш бөхийх	96.70%	**Маш сайн**	86.6% нь "Онц" авсан.
ББББШҮ Нэгдсэн дүн	**65.7%**	**ДУНД**	

Ерөнхий дүгнэлт

Үзүүлэлт	Эрэгтэй (n=148)	Эмэгтэй (n=109)	Нийт (N=257)
Хамрагдсан офицер	148 (57.6%)	109 (42.4%)	**257 (100%)**
БЗХ Хангасан (Эрүүл)	94 (63.5%)	76 (69.7%)	**170 (66.1%)**
БЗХ Хангаагүй (Илүүдэл)	54 (36.5%)	33 (30.3%)	**87 (33.9%)**
БББШҮ Амжилтын хувь	**71.2%**	**65.7%**	**68.4% (Дунд)**

Дасгалын төрөл	Эрэгтэй	Эмэгтэй	Ерөнхий хандлага
Гар дээр суниах	87.78%	65.07%	Эрэгтэйчүүд илүү (+22.7%)
10x10 метр гүйлт	63.93%	61.66%	Ойролцоо (Дунд)
1000 метр гүйлт	42.34%	38.40%	**Хамгийн сул үзүүлэлт**
Цогцолбор дасгал	83.00%	81.80%	Сайн
Сууж урагш бөхийх	**96.88%**	**96.70%**	**Хамгийн өндөр үзүүлэлт**

- Уян хатан байдал: Офицеруудын хувьд хүйс харгалзахгүй хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа дасгал нь сууж урагш бөхийх (96.8%) байна. Энэ нь биеийн уян хатан байдлын бэлтгэлжилт маш сайн байгааг илтгэнэ.
- Тэсвэрийн асуудал: Хоёр бүлгийн аль алинд нь 1000 метрийн гүйлт хамгийн бага оноотой (дунджаар 40.3%) гарлаа. Энэ нь офицеруудын дунд зүрх судасны тэсвэр шаардсан аэроб дасгалын дутагдалтай байгааг харуулж байна.
- Жингийн нөлөө: Офицеруудын 33.9% нь биеийн жингийн илүүдэлтэй байгаа нь БББШҮ-ний амжилтад сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл болж байна. Ялангуяа эрэгтэй офицеруудын дунд жингийн илүүдэл (36.5%) өндөр байгаа нь анхаарал татаж байна.

Эрэгтэй офицеруудын нэгтгэсэн үзүүлэлт

Насны ангилал	Тоо (n)	БББШҮ амжилт (%)	Үсгэн дүн	БЗХ (Хангасан/Илүүдэл)
18-25 нас	4	30.4%	Муу	4 / 0
26-30 нас	9	54.6%	Дунд	7 / 2
31-35 нас	39	74.2%	Сайн	23 / 16
36-40 нас	33	31.0%	Муу	22 / 11
41-45 нас	28	54.6%	Дунд	17 / 11
46-50 нас	20	51.7%	Дунд	10 / 10
51-55 нас	12	78.0%	Сайн	7 / 5
56-аас дээш	3	49.2%	Дунд	2 / 1
НИЙТ ДУНДАЖ	**148**	**71.2%**	**ДУНД**	**94 / 54**

Эмэгтэй офицеруудын нэгтгэсэн үзүүлэлт

Насны ангилал	Тоо (n)	БББШҮ амжилт (%)	Үсгэн дүн	БЗХ (Хангасан/Илүүдэл)
18-25 нас	2	72.6%	Сайн	2 / 0
26-30 нас	8	59.4%	Дунд	7 / 1
31-35 нас	29	75.6%	Сайн	21 / 8
36-40 нас	25	66.5%	Дунд	16 / 9
41-45 нас	22	68.7%	Дунд	14 / 8
46-аас дээш	23	53.8%	Дунд	16 / 7
НИЙТ / ДУНДАЖ	**109**	**65.7%**	**ДУНД**	**76 / 33**

Дасгалын үр дүнд хийсэн дүн шинжилгээ (Насны онцлогоор)

ББББШҮ буюу Бие бялдар, Бэлтгэлжилтийн шалгалтын үнэлгээ нь офицеруудын албаны бэлэн байдал, эрүүл мэнд, физик чадамжийг тодорхойлдог гол хэмжүүр юм. Энэхүү үзүүлэлтийг насны онцлогоор нь нэгтгэн дүгнэвэл:

1. Насны онцлогоор ББББШҮ-ний дүн шинжилгээ

Насны үе	Эрэгтэй офицерууд	Эмэгтэй офицерууд	Онцлох шинж чанар
Залуу үе (18-30 нас)	**Тогтворгүй:** 18-25 насанд амжилт хамгийн бага (30.4%) байгаа нь шинэ алба хаагчдын суурь бэлтгэл сул байгааг илтгэнэ.	**Өндөр:** 18-25 насанд 72.6%-ийн амжилттай. Биеийн жингийн илүүдэлгүй байгаа нь давуу тал болж байна.	Бие физиологийн нөөц их боловч албаны нормативын арга барилд суралцаж буй үе.
Дунд үе (31-45 нас)	**Оргил ба Эрсдэл:** 31-35 насанд оргил амжилт (74.2%) үзүүлж байгаа ч 36-40 насанд амжилт огцом (31.0%) буурч байна.	**Тогтвортой:** 31-45 насанд амжилт 66%-68%-ийн хооронд тогтвортой хадгалагдаж байна.	Албаны ачаалал нэмэгдэж, биеийн жин өөрчлөгдөж эхэлдэг хамгийн эрсдэлтэй үе.
Ахмад үе (46-аас дээш)	**Туршлага:** 51-55 насанд амжилт 78.0% хүртэл өсөж байгаа нь ахмад офицеруудын бие бялдартаа анхаарах соёл сайн байгааг харуулж байна.	**Бууралт:** 46-аас дээш насанд амжилт 53.8% болж буурсан. Энэ нь насны физиологийн өөрчлөлттэй холбоотой.	Тэсвэр болон хүчний чадамж буурч эхэлдэг тул эрүүл мэндийг дэмжих дасгал чухал.

2. ББББШҮ-ний ерөнхий үнэлгээ (Дасгалын төрлөөр)

Судалгааны үр дүнгээс үзэхэд ББББШҮ-ний оноонд дараах хүчин зүйлс голлон нөлөөлж байна:

- **Уян хатан байдал (Сууж урагш бөхийх):** Нийт офицеруудын 96.8% нь "Онц" буюу маш сайн үзүүлэлттэй байна. Энэ нь бүх насны бүлэгт хамгийн өндөр оноо авчирч буй дасгал юм.
- **Тэсвэрийн дутагдал (1000 метр гүйлт):** Энэ дасгал дээр нийт бие бүрэлдэхүүний 54-65% нь "Муу" үнэлгээ авсан нь ББББШҮ-ний ерөнхий дундаж оноог (65-71%) хойш татаж буй гол хүчин зүйл болж байна.
- **Биеийн жингийн нөлөө:** БЗХ хангаагүй (илүүдэл жинтэй) офицеруудын 70-аас дээш хувь нь ББББШҮ-ний гүйлтийн болон хүчний дасгал дээр бага оноо авчээ.

Дүгнэлт

- **Бэлтгэлжилтийн түвшин:** Нийт офицеруудын ББББШҮ-ний амжилт 65.7% – 71.2% буюу "ДУНД" үнэлгээтэй байна. Энэ нь алба хаагчид бие бялдрын суурь бэлтгэлтэй боловч байнгын бэлэн байдал болон гүйцэтгэлийн өндөр чадамжийг хангахад хангалтгүй байгааг илтгэж байна.
- **Дасгалын ялгаатай байдал:** Уян хатан чанар (96.8%) маш өндөр байгаа боловч зүрх судасны тэсвэр шалгах 1000 метрийн гүйлт (40.3%) хамгийн сул байна. Энэ нь аэроб дасгал болон тэсвэрийн бэлтгэл сургуулилт дутагдалтай байгаагийн шууд баталгаа юм.
- **Биеийн жингийн нөлөө:** Офицеруудын 33.9% нь илүүдэл жинтэй байгаа нь ББББШҮ-ний амжилт буурах гол шалтгаан болж байна. Жингийн илүүдэл болон гүйлтийн амжилт хоорондоо урвуу хамааралтай байна.
- **Насны эрсдэл:** Эрэгтэйчүүдийн хувьд 36-40 нас, эмэгтэйчүүдийн хувьд 46-аас дээш нас нь бие бялдрын чадамж хамгийн их буурч, жингийн илүүдэл нэмэгдэж буй "критик" үе байна.

Санал зөвлөмж

Судалгааны үр дүнд үндэслэн албаны бэлэн байдал болон алба хаагчдын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр дараах саналуудыг дэвшүүлж байна.

А. Бэлтгэл сургуулилтын чиглэлээр:

1. **Тэсвэрийн дасгалыг нэмэгдүүлэх:** 1000 метрийн гүйлт болон бусад тэсвэр шаардсан дасгалуудыг долоо хоногт багадаа 2-3 удаа системтэйгээр хийж хэвших.
2. **Насны онцлогт тохирсон хөтөлбөр:** 35-аас дээш насны алба хаагчдад зориулсан, үе мөчинд ачаалал бага өгөх боловч өөх шатаах чадвар өндөр (хурдан алхалт, усанд сэлэлт, дугуй) кардио дасгалуудыг нэвтрүүлэх.
3. **Хүчний тэнцвэрийг барих:** Эмэгтэй офицеруудын хувьд гар дээр суниах болон дээд биеийн хүчний дасгалд илүү анхаарах.

Б. Эрүүл мэнд, хооллолтын чиглэлээр:

1. **БЗХ-ны хяналт:** Илүүдэл жинтэй (БЗХ хангаагүй) офицеруудад зориулсан жин хасах тусгайлсан төлөвлөгөө гаргаж, улирал бүр явцыг нь хянах.
2. **Хооллолтын боловсрол:** Алба хаагчдын дунд эрүүл хооллолт, илчлэгийн хяналтын талаар сургалт, зөвлөгөө мэдээлэл тогтмол өгөх.

В. Зохион байгуулалтын чиглэлээр:

1. **Урамшуулал ба Хөшүүрэг:** ББББШҮ-ний шалгалтад "Онц", "Сайн" авсан болон биеийн жингээ стандартад барьж буй алба хаагчдыг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх.

2. Орчин бүрдүүлэх: Албаны байр бүрд алба хаагчид чөлөөт цагаараа дасгал хийх боломжтой чийрэгжүүлэлтийн танхим, хэрэглэгдэхүүнийг хүртээмжтэй болгох.

Ашигласан эх сурвалж

1. Зэвсэгт хүчний тухай хууль
2. Эрүүл мэндийг хамгаалах технологи – Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт
3. NATO. (2020). Optimization of military performance through physical training standards. Science and Technology Organization.
4. Crawford, K. (2021). Physical readiness and its impact on military leadership and health. Journal of Military Science.
5. Долгор, Ш., & Мягмаржав, Г. (2015). Цэргийн биеийн тамирын арга зүй. Улаанбаатар.

ХИЛЧДИЙН АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ WHOQOL-BREF АРГЫГ АШИГЛАН СУДЛАХ НЬ

М.БАЗАРСАД*
Хил судлалын Магистрант, ахмад

**хариуцлагатай зохиолч: mbazaraa609@gmail.com*

Хураангуй: Энэхүү судалгааны зорилго нь WHOQOL-BREF[44] асуулгын аргыг ашиглан хилчдийн амьдралын чанарыг үнэлж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлоход оршино. Судалгаанд хилийн заставт ажиллаж, амьдарч буй 50 алба хаагчид хамрагдсан бөгөөд амьдралын чанарыг бие махбодын эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн харилцаа, орчны хүчин зүйл гэсэн дөрвөн домэйнаар үнэлэв. Судалгааны үр дүнгээс үзэхэд сэтгэл зүйн домэйн хамгийн өндөр 71.5, харин орчны нөхцөл хамгийн бага 57.5 үнэлгээтэй гарсан бөгөөд бие махбодын эрүүл мэнд 60.25, нийгмийн харилцаа 68.5 нь дунд-сайн түвшинд байна. Эерэг хүчин зүйлсэд сэтгэл зүйн дасан зохицох чадвар, хамт олны дэмжлэг, нийгмийн харилцааны тогтвортой байдал нөлөөлж байгаа бол сөрөг хүчин зүйлсэд ажлын ачаалал, стресс, буруу хооллолт, амьдралын буруу дадал зуршил, орчны нөхцөл, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн хязгаарлалт зэрэг багтаж байна. Хэдийгээр зарим домэйн харьцангуй өндөр үнэлгээтэй гарсан боловч эдгээр нь дээд түвшинд хүрээгүй байгаа нь амьдралын чанарыг цаашид сайжруулах шаардлагатайг илтгэнэ. Иймд хилчдийн амьдралын чанарыг дээшлүүлэхийн тулд эерэг хүчин зүйлсийг дэмжих, сөрөг хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: амьдралын чанар, хилчид, сэтгэл зүй, судалгаа, эрүүл мэнд

Удиртгал

Амьдралын чанарыг хэмжих олон арга байдгаас хамгийн өргөн хэрэглэгддэг нь World Health Organization (WHO)-оос боловсруулсан WHOQOL-BREF асуулгын арга юм. Уг арга нь амьдралын чанарыг олон хэмжээсээр үнэлэх боломжтой, найдвартай, олон улсын судалгаанд өргөн хэрэглэгддэг аргачлал юм.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) тодорхойлж буйгаар "Амьдралын чанар" нь тухайн хүний нийгэмд эзлэх байр суурийн талаарх ойлголтод тулгуурлан бие бялдар, сэтгэл зүй, сэтгэл хөдлөл, нийгмийн эрүүл мэндийг хамардаг байна. Амьдралын чанарыг НҮБ-ын улс орнууд иргэдийнхээ нийгэм, эдийн засгийн байдлын түвшинг харьцуулж үнэлэх дүгнэх зорилгоор ашигладаг. Амьдралын чанар нь ихэвчлэн эрүүл мэнд, боловсрол, хүн ам зүй, эдийн засаг, хүрээлэн буй орчин, амьдралын нөхцөл, хөдөлмөр эрхлэлт болон үндсэн хуулиар олгогдсон эрхийн хэрэгжилтийн үзүүлэлтээр тодорхойлогддог.

Хил хамгаалах байгууллага нь сүүлийн жилүүдэд хилчдийн нийгмийн баталгаа, амьдралын чанарыг сайжруулах зорилгоор “Албандаа итгэл дүүрэн, амьдралдаа сэтгэл хангалуун, хилчний хөгжлийн зүгт, хилийн шинэчлэлийн төлөө” гэсэн

[44] ДЭМБ-аас боловсруулсан амьдралын чанарыг үнэлэх товчилсон асуулга
WHO – World Health Organization (Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага)
QOL – Quality of Life (Амьдралын чанар)
BREF – Brief (Товч, богино хувилбар)

зорилтыг дэвшүүлж, олон талт цогц арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Энэхүү зорилтын агуулга нь бүхэлдээ хилчдийн амьдралын чанарыг сайжруулахад чиглэгдэж байгаа боловч бодит амьдрал дээр амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс байсаар байна.

Хилчдийн амьдрал нь цаг агаарын эрс тэс уур амьсгал, бие бялдар болон сэтгэл зүйн өндөр тэсвэр тэвчээр шаардсан нөхцөлд үүрэг гүйцэтгэдэгээрээ бусад байгууллагаас ялгардаг. Ялангуяа хилийн заставт ажиллаж буй алба хаагчид алслагдсан бүс нутагт, гэр бүлээсээ хол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал орчинд, байнгын бэлэн байдал, өндөр хариуцлага шаардсан ачаалалтай нөхцөлд ажиллаж, амьдардаг онцлогтой. Энэ нөхцөл байдлаас шалтгаалан хилчдийн амьдралын чанар дунд түвшинд байх магадлалтай гэж үзэж байна.

Иймээс хилчдийн амьдралын чанарыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах шаардлага бий гэж үзэн энэхүү судалгааг хийсэн болно.

Судлагдсан байдлын тойм

Амьдралын чанарын ойлголтыг 1990-ээд оноос Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (WHO) “WHOQOL-100” болон “WHOQOL-BREF” асуулгын аргачлалыг боловсруулан, дэлхийн 100 гаруй оронд ашигласан (WHO, 2012).

Монголд 2020 онд нийт Улаанбаатар хотын хүн амын судалгаа хийгдсэн бөгөөд WHOQOL-BREF шкал ашиглаж: бие бялдрын эрүүл мэндийн дэд салбарт ~61.5, сэтгэл зүйн ~73.5, нийгмийн харилцааны ~70.1, орчны нөхцөлийн ~67.2 оноо авсан байна (Bat-Erdene, 2023). Өмнө нь хилчдийн амьдралын чанарыг судалсан судалгаа байхгүй.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь хилчдийн амьдралын чанарын түвшинг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас боловсруулсан WHOQOL-BREF асуулгын аргыг ашиглан тогтоож, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлоход оршино.

Судалгааны зорилтууд

1. Хилчдийн амьдралын чанарын ерөнхий түвшинг тодорхойлох
2. Амьдралын чанарын бие махбодын эрүүл мэнд, сэтгэл зүйн, нийгмийн харилцааны, орчны нөхцлийн домэйнийг үнэлэх
3. Хилчдийн эрүүл мэндэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох
4. Хилчдийн амьдралын чанарыг хотын хүн амын үзүүлэлттэй харьцуулан дүн шинжилгээ хийх

Судалгааны арга зүй

Амьдралын чанарыг хэмжихэд олон улсын хэмжээнд өргөн хэрэглэгддэг арга хэрэгслийн нэг нь WHOQOL-BREF асуулга (Organization, 1996) юм. Энэхүү асуулгыг World Health Organization (WHO)-ооc боловсруулсан бөгөөд хүний амьдралын чанарыг олон талт хэмжээсээр үнэлэх боломжийг олгодог. WHOQOL-BREF нь анхдагч WHOQOL-100 асуулгын товчилсон хувилбар бөгөөд нийт 26 асуултаас бүрдэнэ (Хавсралт 1). Үүнд:

- 2 ерөнхий асуулт (амьдралын чанарын ерөнхий үнэлгээ, эрүүл мэндийн үнэлгээ)
- 24 асуулт нь 4 үндсэн домэйнд хуваагдана.

Domain-ийн асуултуудын хуваарилалт

Domain	Асуултын дугаар
Бие махбодийн эрүүл мэнд	3, 4, 10, 15, 16, 17, 18
Сэтгэл зүй	5, 6, 7, 11, 19, 26
Нийгмийн харилцаа	20, 21, 22
Орчны нөхцөл	8, 9, 12, 13, 14, 23, 24, 25

Оноо тооцох ба үнэлгээ

WHOQOL-BREF асуулгын хариултыг 1-5 (Маш муу/маш хангалтгүй-1, муу-2, дунд-3, сайн-4, маш сайн-5) шатлалтай Лайкертийн хэмжүүрээр үнэлдэг. Домэйн тус бүрийн оноог нэгтгэн дундажлан, стандартчилсны дараа 4-20, 0–100 онооны шкал буюу 2 аргаар бодож тодорхойлж болдог ба үр дүн адилхан гарна. Өндөр оноо нь тухайн домэйны амьдралын чанар өндөр байгааг илэрхийлнэ.

Албан ёсны (WHO) эхний арга:

1. Эхлээд 4-20 шкал:

$$Score_{4-20} = Mean \times 4$$

2. Дараа нь 0-100 шкал:

$$Score_{0-100} = \frac{(Score_{4-20} - 4)}{16} \times 100$$

Хоёрдугаарт шууд ингэж бодож болно:

$$Score_{0-100} = (Mean - 1) \times 25$$

Тайлбар: Mean гэдэг нь домэйн тус бүрийн дундаж оноо.

Судалгаанд ихэвчлэн дараах байдлаар тайлбарладаг:

0–100 оноо	Үнэлгээ
0–25	Маш муу амьдралын чанар
26–50	Дунджаас доогуур
51–75	Дунд / Сайн
76–100	Маш сайн

Үндсэн хэсэг

Судалж буй байдлын онолын үндэслэл

“Амьдралын чанар” хэмээх нэр томьёог анх 1964 онд АНУ-ын ерөнхийлөгч Л.Жонсон нийгмийн зорилгыг тайлбарлахдаа хэрэглэсэн талаар социологич С.Макколл тэмдэглэсэн байдаг. Энэ үеэс тухайн ойлголт шинжлэх ухааны эргэлтэд орж, улмаар үзэл баримтлал болох хүртлээ философи, эдийн засаг, сэтгэл судлал, эрүүл мэнд болон социологийн хүрээнд судлагдаж ирсэн байна (М.Батбаатар, 2012).

Амьдралын чанар (Quality of Life) хэмээх ойлголтыг эрдэмтэн, судлаачид олон янзаар тайлбарлаж, өөр өөрийн судалгааны чиглэл, хандлагаас хамааран харилцан адилгүй тодорхойлсон байдаг. Зарим судлаачид амьдралын чанарыг хүний материаллаг болон эдийн засгийн нөхцөл байдалтай холбон тайлбарладаг бол орчин үеийн судалгаанд амьдралын чанарыг хүний бие бялдрын эрүүл мэнд, сэтгэл зүйн байдал, нийгмийн харилцаа, хүрээлэн буй орчин, амьдралын сэтгэл ханамж зэрэг олон хүчин зүйлсийн нэгдэл бүхий цогц ойлголт гэж үзэх болсон.

WHOQOL-BREF асуулгын аргын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд болох бие бялдрын эрүүл мэнд, сэтгэл зүйн байдал, нийгмийн харилцаа, хүрээлэн буй орчны нөхцөл зэрэг үзүүлэлтүүд нь хүний амьдралын чанарыг олон талт байдлаар үнэлэх боломжийг бүрдүүлдэг. Эдгээр үзүүлэлтүүд нь хил хамгаалах байгууллагын алба хаагчдын ажил, амьдралын онцлог нөхцөл, тухайлбал цаг агаарын эрс тэс уур амьсгал, алслагдсан орчинд ажиллах, нийгмийн харилцааны хязгаарлагдмал байдал, ажлын ачаалал, сэтгэл зүйн ачаалал зэрэг хүчин зүйлсийн амьдралын чанарт үзүүлэх нөлөөллийг тодорхойлох боломжтой тул хилчдийн амьдралын чанарыг судлахад тохиромжтой арга хэрэгсэл гэж үзэж байна.

WHOQOL-BREF асуулга нь олон улс оронд баталгаажсан, найдвартай, хүчин төгөлдөр арга хэрэгсэлд тооцогддог. Энэхүү асуулгын дотоод нийцэл өндөр буюу 0.7-

оос дээш байдаг нь судалгаанд ашиглахад тохиромжтойг харуулдаг. Мөн уг асуулгын арга нь олон соёлын орчинд ашиглах боломжтойгоор боловсруулагдсан тул Монгол Улсын нөхцөлд хилчдийн амьдралын чанарыг судлахад тохиромжтой арга хэрэгсэл юм.


Судалгааны явц үр дүн

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийг авч дүгнэлт гаргасан.




Зураг 1. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа

Зураг 1-ээс харахад хилийн заставд амьдардаг 50 алба хаагчид судалгаанд хамрагдсанаас эрэгтэй алба хаагч 35 буюу 70 хувь, эмэгтэй алба хаагч 15 буюу 30 хувьтай хамрагдаж, тэдний амьдралын чанарыг бие махбодын эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн харилцаа, орчны хүчин зүйл гэсэн дөрвөн хэмжээсээр үнэлгээ хийв.



Зураг 2. Судалгаанд оролцогчдын насны ангилал

Зураг 2-т насны ангиллаар 18-25 насны алба хаагч 9 буюу 18 хувь, 26-31 насны алба хаагч 21 буюу 42 хувь, 32-45 насны алба хаагч 20 буюу 40 хувьтай, дийлэнх хувь нь 26-аас дээш насныхан байгаа нь хил хамгаалах албанд тогтвортой ажилласан ажлын туршлагатай алба хаагчид байгааг илтгэнэ.



	Боловсрол
Бага	0
Бүрэн дунд	11
Бүрэн бус дунд	3
Тусгай дунд	8
Дээд	25
Магистр	2

Зураг 3. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин

Зураг 3-т боловсролын түвшингээр магистр 2 буюу 4,1 хувь, дээд 25 буюу 51 хувь, бүрэн дунд 11 буюу 22,4 хувь, тусгай дунд 8 буюу 16,3 хувь, бүрэн бус дунд 3 буюу 6,1 хувьтай, 1 хүн огт хариулаагүй орхисон байна. Боловсролын түвшин нь амьдралын чанарын ойлголт, сэтгэл зүйн домэйнд нөлөөлж болохыг харуулна.



Зураг 4. Судалгаанд оролцогчдын гэр бүлийн байдал

Гэр бүлийн байдал нь гэрлэсэн 44 буюу 89,8 хувь, ганц бие 4 буюу 8,2 хувь, тусдаа амьдардаг 1 буюу 2 хувьтай, гэр бүлийн байдал харьцангуй тогтвортой байгааг зураг 4-өөс харна. Гэр бүлийн байдал тогтворгүй салсан эсвэл тусдаа амьдардаг бол амьдралын чанарт ихээхэн сөргөөр нөлөөлнө.




Зураг 5. Алба хаагчдын эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлс

Таны эрүүл мэндэд асуудал байвал та юунаас үүдэлтэй гэж болдог вэ гэсэн асуултад алба хаагчид зураг 5-д байгаачлан доорх байдлаар хариулсан.

1. Ажлын ачаалал, стресс-6
2. Асуудал байхгүй-14
3. Амьдралын буруу дадал зуршил, буруу хооллолт-7
4. Даарч хөрснөөс-1
5. Хоол хүнс амьдарч буй орчноос-1
6. Сэтгэл зүй-1
7. Алслагдсан газар байдаг болохоор тогтмол үзүүлж, харуулж явж чаддаггүй-2
8. Дасгал хийдэггүйгээс-1
9. Зогсоо ажил-2
10. .Нойрноос-1
11. Тамхи-2
12. Төрөлхийн-1
13. Ус муугаас-2
14. Өөрөөсөө
15. 8 хүн хариулаагүй орхисон.

Оролцогчдын эрүүл мэндэд нөлөөлөх гол шалтгаан нь ажлын ачаалал, стресс (6 хүн) ба буруу дадал зуршил, буруу хооллолт (7 хүн) байв. 14 хүн эрүүл мэндийн асуудалгүй гэж хариулсан. Бусад шалтгаан (жишээ нь орчны хүчин зүйл, дасгал хөдөлгөөний дутагдал, тамхи, ус муугаас) нь цөөн хувийг эзэлсэн. Энэ нь хилчдийн эрүүл мэндийн асуудал ихэвчлэн ажил болон амьдралын буруу дадал зуршлаас үүдэлтэй болохыг харуулж байна. Мөн судалгаанд оролцогчдын 8 нь уг асуултад хариулаагүй байгаа нь асуулгыг бөглөх идэвх, оролцооны түвшин харилцан адилгүй байсныг илтгэж байна.



Зураг 6. Амьдралын чанарын ерөнхий 2 асуулгын хүйсийн ялгаа

Зураг 6-аас харахад нийт алба хаагчдын амьдралын чанар, эрүүл мэндийн байдал 3.3-4 буюу дунд-сайн түвшинд байна. Судалгааны үр дүн нь хүйсээр ялгарч болно.

WHOQOL-BREF асуулгын эхний 2 ерөнхий асуулт буюу амьдралын чанарын ерөнхий үнэлгээ, эрүүл мэндийн үнэлгээг хүйсийн ангилалаар нь харьцуулж, бусад хариултуудыг домэйн тус бүрээр нэгтгэн дунджыг гаргаж, томьёнд оруулан амьдралын чанарын түвшинг гаргасан.

1. Бие махбодийн эрүүл мэнд

Mean = 3.41

$$(3.41 - 1) \times 25$$
$$2.41 \times 25 = 60.25$$

2. Сэтгэлзүй

Mean = 3.86

$$(3.86 - 1) \times 25$$
$$2.86 \times 25 = 71.5$$

3. Нийгмийн харилцаа


Mean = 3.74

$$(3.74 - 1) \times 25$$
$$2.74 \times 25 = 68.5$$

4. Орчин


Mean = 3.30

$$(3.30 - 1) \times 25$$
$$2.30 \times 25 = 57.5$$



Зураг 7. Улаанбаатар хотын хүн ам болон хилчдийн амьдралын чанарын харьцуулалт

Монгол Улсад 2020 онд Улаанбаатар хотын нийт хүн амын дунд WHOQOL-BREF шкал ашиглан хийсэн судалгаагаар бие махбодын эрүүл мэндийн дэд салбарт **~61.5**, сэтгэл зүйн **~73.5**, нийгмийн харилцааны **~70.1**, орчны нөхцлийн **~67.2** оноо авсан. Харин хилийн заставын алба хаагчдын судалгааны үр дүнгээс харахад бие махбодын эрүүл мэнд (~60.25), сэтгэл зүй (~71.5), нийгмийн харилцаа (~68.5), орчны нөхцөл (~57.5) зэрэг бүх домэйнд Улаанбаатар хотын дунджаас бага үнэлгээтэй буюу доогуур байгааг зураг 7-оос харж болно.



Зураг 8. Хамгийн бага үнэлгээтэй асуултуудын үр дүн.

Судалгааны асуулга бүрд хариулсан байдлыг харахад зураг 8-д хамгийн бага оноотой 3, 4, 14, 24, 26 дугаар асуултуудын хариултын дундаж оноо 2.64-2.91 хооронд буюу муу-дунд түвшинд байгаа нь сэтгэл зүй, эрүүл мэндтэй холбоотой асуудлууд тодорхой хэмжээнд байгааг харуулж байна.

Хэлцэмж

Судалгааны үр дүнгээс харахад хилчдийн амьдралын чанар дунд-сайн түвшинд үнэлэгдсэн нь тэдний стрессийг тодорхой хэмжээнд зохицуулах чадвар, сэтгэл санаанд тогтвортой байдал, нийгмийн харилцааны дэмжлэг харьцангуй сайн байгааг илтгэж байна. Гэсэн хэдий ч энэхүү үнэлгээ нь WHOQOL-BREF асуумжийн дагуу сүүлийн 14 хоногийн хугацаанд оролцогчдод илэрч буй сэтгэл зүйн байдлыг илэрхийлж байгаа тул алба хаагчдад сэтгэл зүйн асуудал байхгүй гэж шууд дүгнэх боломжгүй юм.

WHOQOL-BREF асуумжийн домэйнүүдийн оноог авч үзвэл сэтгэл зүйн домэйн 71.5 оноо, нийгмийн харилцааны домэйн 68.5 оноо авсан нь оролцогчдын сэтгэл санаанд дэмжлэг, хамт олонтой харилцах харилцаа, нийгмийн дэмжлэгийн түвшин харьцангуй тогтвортой. Харин бие махбодын эрүүл мэндийн домэйн 60.25 болон орчны нөхцлийн домэйн 57.5 харьцангуй доогуур үзүүлэлттэй гарсан нь ажлын

ачаалал, стресс, амьдралын буруу дадал зуршил, зохисгүй хооллолт зэрэг хүчин зүйлсийн нөлөөг илтгэж байна.

Мөн Улаанбаатар хотын нийт хүн амын амьдралын чанарын үзүүлэлттэй харьцуулахад (бие махбодын эрүүл мэнд ~61.5, сэтгэл зүй ~73.5, нийгмийн харилцаа ~70.1, орчны нөхцөл ~67.2) хилчдийн бүх домэйн дундаж оноо харьцангуй бага байгаа нь ажлын нөхцөл, амьдрах орчин, дэд бүтцийн хүртээмж, алслагдсан бүс нутагт ажиллаж амьдардаг онцлог зэрэг хүчин зүйлс амьдралын чанарт сөрөг нөлөө үзүүлж байгааг харуулна.

Энэ үр дүнг шүүмжлэлтэй авч үзвэл хил хамгаалах байгууллага бодлогын түвшинд амьдралын чанарыг сайжруулах зорилт дэвшүүлж байгаа боловч хилчдийн ажил, амьдралын бодит орчин, ажлын ачаалал, орчны нөхцөл, дэд бүтэц, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж зэрэг суурь нөхцөлүүд хангалттай сайжрахгүй бол амьдралын чанарт мэдэгдэхүйц өөрчлөлт гарахад хүндрэлтэй байж болох юм.

Хилчдийн амьдралын чанарыг дээшлүүлэхийн тулд бие махбодын эрүүл мэндийг хамгаалах, ажлын байрны ачаалал, стрессийг бууруулах, амьдралын зөв хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр байгууллагын болон хувь хүний түвшинд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Дүгнэлт

Судалгааны зорилго нь хилчдийн амьдралын чанарын түвшинг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас боловсруулсан WHOQOL-BREF асуулгын аргыг ашиглан тогтоох, мөн амьдралын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлоход оршсон. Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлж, судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэхэд дараах үр дүн гарсан. Үр дүнгээс үзэхэд хилчдийн амьдралын чанарын дундаж үзүүлэлт 64.4 буюу дунд-сайн түвшинд үнэлэгдэж байгаа нь цаашид сайжруулах шаардлагатайг илтгэнэ.

Амьдралын чанарын суурь ойлголт нь эрүүл мэнд гэж үздэг. (Б.Галбадрах, 2010, pp. 34-44) Гэвч эрүүл мэндэд нөлөөлж буй хүчин зүйлсийг оролцогчдоор тодорхойлуулсан судалгааны үр дүнд ажлын ачаалал, стресс, түүнчлэн амьдралын буруу дадал зуршил, зохисгүй хооллолт зэрэг нь голлон нөлөөлж буй хүчин зүйлс болох нь тогтоогдсон. Энэхүү үр дүн нь хил хамгаалах байгууллагаас хэрэгжүүлж буй эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, амьдралын нөхцөлийг сайжруулах чиглэлтэй цогц арга хэмжээнүүд тодорхой хэмжээнд үр дүнтэй хэдий ч алба хаагчдын амьдралын хэв маяг, хувь хүний буруу дадал зуршил амьдралын чанарт илүү их сөрөг нөлөө үзүүлж байж болзошгүйг харуулж байна.

Судалгааны домэйнүүдээс хамгийн бага үнэлгээтэй нь орчны нөхцлийн үзүүлэлт байсан бөгөөд үүнийг хилчдийн ажлын онцлог, алслагдсан бүс нутагт ажиллаж амьдардаг нөхцөл байдалтай холбон тайлбарлаж болно.

Тавьсан зорилго, зорилтууд биелсэн бөгөөд WHOQOL-BREF асуулгын аргыг ашиглан хилчдийн амьдралын чанарын түвшинг тодорхойлж, амьдралын чанарт нөлөөлж буй гол хүчин зүйлсийг тодорхойлж чадсан. Судалгааны эхэнд гаргасан таамаглал ерөнхийдөө батлагдсан. Иймд хилчдийн амьдралын чанарт нөлөөлөх хүчин зүйлс нь зөвхөн байгууллагын бодлого, үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй, мөн алба хаагчдын хувь хүний хүчин зүйлсээс ихээхэн хамааралтай байгаа нь байгууллагын удирдлагын түвшинд бодлого, дэмжлэгийн арга хэмжээг цогцоор авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Эх сурвалж

Bat-Erdene, E. H.-O. (2023, 9 29). Quality of life in the general population of Mongolia: Normative data on WHOQOL-BREF. *PLOS ONE, 18*(9), e0291427. https://doi.org/10.1371/journal.pone.0291427

Organization, W. H. (1996). *WHOQOL-BREF : introduction, administration, scoring and generic version of the assessment.* World Health Organization. https://doi.org/iris.who.int

WHO. (2012, 3 1). *World health organization*. World health organization. www.who.int

wikipedia. (2024, 8 19). *википедиа чөлөөт нэвтэрхий толь*. wikipedia. mn.wikipedia.org

Б.Галбадрах. (2010). *Амьдралын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ, монгол улсын амьдралын чанар.* Эдийн засгийн сургууль, МУИС. https://doi.org/journal.num.edu.mn

М.Батбаатар. (2012). *МОНГОЛ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ СУДЛАХ АРГА ЗҮЙН АСУУДЛУУД; ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ХЭМЖИХ БОЛОМЖИЙН ТУХАЙ.* Нийгмийн шинжлэх ухааны сургууль МУИС. https://doi.org/journal.num.edu.mn

Хавсралт 1

WHOQOL-BREF АСУУЛГЫН АРГА

(Маш муу/маш хангалтгүй-1, муу-2, дунд-3, сайн-4, маш сайн-5)

Асуулт	Маш муу хангалтгүй	Муу	Дунд	Сайн	Маш сайн
1. Та амьдралын чанараа хэрхэн үнэлэх вэ?					
2. Та өөрийн эрүүл мэндэдээ хэр сэтгэл хангалуун байдаг вэ?					
3. Бие махбодийн өвдөлт таныг ажил хийхэд хэр их саад болж байна вэ?					
4. Өдөр тутмын амьдралд чинь эмчилгээ хэрэгтэй юу?					
5. Та амьдралаасаа хэр их таашаал авдаг вэ?					
6. Амьдрал тань хэр утга учиртай вэ?					
7. Та анхаарлаа хэр сайн төвлөрүүлж чаддаг вэ?					
8. Өдөр тутмын амьдралдаа хэр аюулгүй байгаагаа мэдэрдэг вэ?					
9. Таны амьдарч буй орчин тань хэр эрүүл вэ?					
10. Та хангалттай эрч хүчтэй юу?					
11. Та өөрийн биеийн төрхөө хүлээн зөвшөөрдөг үү?					
12. Танд хэрэгцээгээ хангахад хангалттай мөнгө байгаа юу?					
13. Таны өдөр тутмын амьдралд хэрэгтэй мэдээлэл танд хэрхэн хүртээмжтэй байна вэ?					
14. Танд чөлөөт цаг хэр гардаг вэ?					
15. Та хэр сайн хөдөлгөөн хийдэг вэ?					
16. Та нойрондоо хэр сэтгэл хангалуун байдаг вэ?					
17. Өдөр тутмын үйл ажиллагаандаа хэр сэтгэл хангалуун байдаг вэ?					
18. Ажиллах чадвартаа хэр сэтгэл хангалуун байна вэ?					
19. Та өөртөө хэр сэтгэл хангалуун байна вэ?					
20. Та хувийн харилцаандаа хэр сэтгэл хангалуун байна вэ?					
21. Бэлгийн амьдралдаа хэр сэтгэл хангалуун байна вэ?					
22. Та найз нөхдөөсөө авдаг дэмжлэгт хэр сэтгэл хангалуун байдаг вэ?					
23. Та амьдрах орчиндоо хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?					
24. Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж хэр байдаг вэ?					
25. Та өөрийн тээврийн хэрэгсэлд хэр сэтгэл ханамжтай байна вэ?					
26. Та сэтгэлээр унах, айдас, сэтгэл гутрал зэрэг сөрөг сэтгэл мэдрэмжийг хэр их мэдэрдэг вэ?					

Энэхүү судалгааг бодит эх сурвалжаас орчуулан авч судалгаанд ашигласан.

ХҮН БАРЬЦААЛСАН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛД ЯВАГДАХ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТАКТИКИЙН ХЭРЭГЖИЛТ БА ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ

Э.САНДАГЖАВ*
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн цэргийн хэргийн тэнхимийн ахлах багш, дэд хурандаа
**Хариуцлагатай зохиогч: ssandagjav@gmail.com*

Хураангуй: Энэхүү судалгаа нь хүн барьцаалсан гэмт хэргийн нөхцөлд явагдах хэлэлцээрийн тактикийн хэрэгжилт болон түүний үр ашгийг онол-эмпирикийн уялдаа холбоонд шинжлэх зорилготой. Судалгаанд эрэл хайгуулын дараалсан холимог судалгааны арга дизайныг ашиглаж, эхний шатанд баримт бичгийн шинжилгээгээр хэлэлцээрийн процесс, харилцаа, сэтгэлзүй, шийдвэр гаргалтын онолуудыг нэгтгэн дүн шинжилгээ хийсэн. Хоёр дахь шатанд олон улсын таван кейс дээр агуулгын кодчилол болон хагас-тоон үнэлгээ хийж, хэлэлцээрийн үр ашгийг хэмжих CNEM (Communication–Negotiation–Emotion–Management) загварыг туршсан.

Судалгааны үр дүнгээр хэлэлцээрийн үе шат бүрэн хэрэгжсэн, идэвхтэй сонсох арга техникийг системтэй ашигласан, мөн цаг хугацааны менежментийг оновчтой хийсэн тохиолдолд ажиллагааны үр ашиг мэдэгдэхүйц нэмэгдэж байгааг тогтоов. Эмпирик шинжилгээгээр өндөр үр ашигтай кейсүүдэд ($E \geq 0.7$) харилцаа болон процессын хувьсагчид давамгай нөлөө үзүүлж байв. Түүнчлэн сэтгэлзүйн динамик болон шийдвэр гаргалтын нөхцөл нь хэлэлцээрийн уян хатан байдал, эцсийн үр дүнд чухал нөлөөтэй болохыг баталгаажуулсан.

Энэхүү судалгааны онолын хувь нэмэр нь хэлэлцээрийн ажиллагааг процесс, харилцаа, сэтгэлзүй, шийдвэр гэсэн дөрвөн түвшний интеграцчилсан систем болгон тайлбарласан явдал бөгөөд практик түвшинд хэлэлцээрийн үр ашгийг тоон загвараар үнэлэх боломжийг санал болгож байна.

Түлхүүр үг: Хүн барьцаалсан гэмт хэрэг, хэлэлцээрийн тактик, хямралын хэлэлцээр, идэвхтэй сонсох, Стокгольмын хам шинж, шийдвэр гаргалт, CNEM загвар.

Оршил

Монгол улсын хил, хилийн бүсэд үүсэх алан хядах ажиллагаа тухайн нутагт тогтворгүй байдал үүсгэж, хил даван орж иргэдийн эд хөрөнгө, мал сүргийг дээрэмдэх, зарим тохиолдолд зэвсэг хэрэглэн хүний амь насанд халдах эрсдэлтэй байсныг онцолсон байна (Ц.Ганболд 2003). Үүнээс үзэхэд орчин үед ч энэ төрлийн гэмт хэрэг гарахыг үгүйсгэх аргагүй юм.

Хүн барьцаалсан гэмт хэрэг нь хүний амь нас, иргэдийн аюулгүй байдалд шууд заналхийлдэг, өндөр эрсдэлтэй, сэтгэлзүйн болон тактикийн хувьд нарийн төвөгтэй гэмт хэргийн хэлбэр юм. Ийм нөхцөлд хууль сахиулах байгууллагын үндсэн зорилго нь хүч хэрэглэх ажиллагаанаас аль болох зайлсхийж, хүний амь аврах хамгаалах, нөхцөл байдлыг тайван замаар шийдвэрлэх явдал байдаг. Энэ хүрээнд хэлэлцээрийн тактик нь орчин үеийн хямралын удирдлагын гол арга хэрэгсэл болон хөгжиж байна (McMains & Mullins, 2014).

Хэлэлцээрийн ажиллагаа нь барьцаалагчтай харилцаа тогтоох, итгэлцэл бий болгох, сэтгэлзүйн дарамтыг бууруулах, цаг хугацааны хүчин зүйлийг оновчтой ашиглах зэрэг олон үе шаттай, динамик процесс юм. Судлаачдын дүгнэлтээр үр дүнтэй хэлэлцээрийн хэрэгжилт нь ихэнх тохиолдолд хүний амь эрсдэх эрсдэлийг бууруулж, ажиллагааны амжилтын түвшинг мэдэгдэхүйц нэмэгдүүлдэг байна (Noesner, 1999).

Мөн хүн барьцаалсан нөхцөлд барьцаалагч болон хохирогчийн хооронд үүсэх сэтгэлзүйн нарийн харилцаа, тухайлбал Стокгольмын хам шинж нь хэлэлцээрийн явцад нөлөөлөх чухал хүчин зүйл болдог. Энэ нь барьцаалагчийн шийдвэр гаргалт, зан төлөвт тодорхой хэмжээгээр нөлөөлж, хэлэлцээрийн тактикийн оновчтой сонголтыг илүү төвөгтэй болгодог (Fuselier, 1999). Иймд хэлэлцээрийн тактик нь зөвхөн логик аргументад суурилах бус, сэтгэлзүйн нөлөөлөл, зан төлөвийн удирдлагыг хамарсан цогц систем байх шаардлагатай.

Гэсэн хэдий ч практик түвшинд хэлэлцээрийн тактикийн хэрэгжилт, түүний үе шатны оновчлол, мөн үр ашгийг үнэлэх нэгдсэн аргачлал бүрэн боловсроогүй хэвээр байна. Энэ нь хэлэлцээрийн ажиллагааны үр дүнд нөлөөлөх хүчин зүйлсийг системтэйгээр тодорхойлох, шинжлэх шаардлагыг бий болгож байна (McMains & Mullins, 2014).

Ийм нөхцөл байдлыг үндэслэн энэхүү судалгаанд хүн барьцаалсан гэмт хэргийн нөхцөл дэх хэлэлцээрийн тактикийн хэрэгжилтийг үе шаттайгаар шинжлэх, түүний үр ашгийг үнэлэх онол-практикийн үндэслэлийг боловсруулах зорилго тавигдсан болно. Судалгааны хүрээнд баримт бичгийн шинжилгээ, агуулгын шинжилгээ, харьцуулалтын болон системчилсэн дүн шинжилгээний аргуудыг ашиглах бөгөөд хэлэлцээрийн тактикийн хэрэгжилт нь ажиллагааны үр дүнд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлохыг зорьж байна.

Энэхүү судалгаанд дараах үндсэн таамаглалуудыг дэвшүүлж байна: хэлэлцээрийн тактикийн үе шатыг оновчтой хэрэгжүүлэх нь ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлнэ, идэвхтэй сонсох болон итгэлцэл бий болгох арга техник нь хэлэлцээрийн амжилтад эерэг нөлөө үзүүлнэ, мөн цаг хугацааны зөв менежмент нь барьцаалагчийн шаардлагын түвшинг бууруулах боломжтой.

Онолын үзэл баримтлалууд түүнд хийсэн шинжилгээ:

Энэхүү судалгаанд хүн барьцаалсан гэмт хэргийн нөхцөл дэх хэлэлцээрийн тактикийн хэрэгжилтийг онолын түвшинд шинжлэх зорилгоор олон улсын эрдэм шинжилгээний өгүүлэл, сургалтын гарын авлага, мэргэжлийн удирдамжуудыг баримт бичгийн шинжилгээний аргаар судалсан.

Шинжилгээ нь дөрвөн үндсэн онолын чиглэлд төвлөрсөн бөгөөд эдгээр нь хэлэлцээрийн ажиллагааны процесс, харилцаа, сэтгэлзүй, шийдвэр гаргалтын динамикийг тус тус тайлбарладаг.

1. Хэлэлцээрийн процессын онол

McMains ба Mullins (2014)-ийн “Хямралын үеийн хэлэлцээний загвар”-д тулгуурласан баримт бичгүүдийг шинжлэхэд хэлэлцээр нь үе шаттай, давтамжтай, буцаах боломжтой динамик процесс болох нь тогтоогдов.

Баримт бичгийн агуулгад дараах нийтлэг бүтэц ажиглагдсан:

- Анхны холбоо тогтоох үе
- Итгэлцэл бий болгох үе
- Сэтгэлзүйн тогтворжуулалт
- Шаардлага бууруулах үе
- Шийдвэр гаргалт ба төгсгөл

Баримт бичгүүдийн 80%-д хэлэлцээрийг шугаман бус, харин давтагддаг цикл процесс гэж тодорхойлсон байна. Энэ нь бодит ажиллагаанд үе шат давтагдах боломжтойг харуулдаг.

2. Харилцааны онол ба идэвхтэй сонсох

Rogan, Hammer, & Van Zandt (1997)-ийн баримт бичгүүдэд хийсэн шинжилгээгээр идэвхтэй сонсох нь хэлэлцээрийн үндсэн нөлөөллийн механизм болох нь тодорхой болов.

Баримт бичгийн түгээмэл элементүүд:

- давтан илэрхийлэх арга
- анхааралтай эргүүлж сонсох арга
- Хамт мэдрэх сэтгэлээ илэрхийлэх арга
- Чимээгүй байдлыг ашиглах арга

Гол ажиглалт:

Идэвхтэй сонсох нь зөвхөн мэдээлэл цуглуулах бус, барьцаалагчийн өөрийн үнэлэмжийг өөрчлөх сэтгэлзүйн нөлөөллийн хэрэгсэл гэж тодорхойлогдсон.

Харилцааны онол дээр тулгуурласан баримт бичгүүдэд "Итгэлцэл бүрэлдэх үйл явц" нь хүчирхийллийг бууруулах үндсэн нөхцөл болох нь давтагдан гарч байна.

3. Сэтгэлзүйн динамик ба Стокгольмын хам шинж

Fuselier (1999)-ийн онолыг тусгасан баримт бичгүүдийг шинжлэхэд Стокгольмын хам шинж нь:

- сэтгэлзүйн хамгаалах механизм
- амьд үлдэх дасан зохицлын хариу үйлдэл
- эрх мэдлийн тэнцвэргүй харилцааны үр дүн гэж тодорхойлогдсон байна.

Баримт бичгийн нийтлэг ажиглалт:

- удаан хугацааны барьцааны нөхцөлд сэтгэлзүйн холбоо үүсэх магадлал нэмэгддэг
- хохирогчийн эсэргүүцэл буурдаг
- хэлэлцээрийн "гуравдагч этгээдийн нөлөөлөл" нэмэгддэг

Сэтгэлзүйн хүчин зүйл нь хэлэлцээрийн логик бүтцийг өөрчилдөг бөгөөд энэ нь тактикийн шийдвэрт шууд нөлөөлдөг.

4. Шийдвэр гаргалт ба цаг хугацааны динамик

Klein (1998)-ийн Naturalistic Decision Making (NDM) болон Noesner (1999)-ийн кризисийн хэлэлцээрийн судалгаанд үндэслэсэн баримт бичгүүдийг шинжлэхэд:

- стресс өндөр үед шийдвэр эвристик шинжтэй болдог
- мэдээлэл нэмэгдэх тусам шийдвэрийн чанар сайжирдаг
- цаг хугацаа "шийдвэр гаргалтын тогтвортой байдлыг хангагч хүчин зүйл" үүрэг гүйцэтгэдэг (Klein. 1998)

Онцлох үр дүн:

- эхний үе шатанд импульсив шийдвэр давамгай
- 2–6 цагийн дараа рациональ үнэлгээ нэмэгддэг
- урт хугацааны хэлэлцээрт хүч хэрэглэх магадлал буурдаг

Шийдвэр гаргалтын онолын баримт бичгүүд нь "аг хугацааг тактикийн нөөц гэж үзэх" гэсэн нэг гол ойлголтыг тогтвортой баталж байна.

Интеграцчилсан баримт бичгийн шинжилгээний дүгнэлт

Дээрх дөрвөн онолын баримт бичгүүдийг харьцуулан шинжлэхэд дараах нэгдсэн бүтэц тодорхойлогдов:

Онол	**Үндсэн хувьсагч**	**Үүрэг**
McMains	Process	үе шат, бүтэц
Rogan	Communication	итгэлцэл, нөлөөлөл
Fuselier	Psychology	сэтгэлзүйн динамик
Klein/Noesner	Decision/Time	шийдвэр ба хугацаа

Баримт бичгийн шинжилгээнээс харахад хүн барьцаалсан гэмт хэргийн хэлэлцээр нь:

- процесс
- харилцаа
- сэтгэлзүй
- шийдвэр гэсэн дөрвөн түвшний системийн огтлолцолд оршдог.

Баримт бичгийн шинжилгээ нь дараах үндсэн үр дүнг баталгаажуулж байна:

1. Хэлэлцээр нь шугаман бус, давтагддаг процесс юм
2. Харилцааны чанар нь үр дүнг шууд тодорхойлдог
3. Сэтгэлзүй нь тактикийн орчныг өөрчилдөг
4. Цаг хугацаа нь стратегийн нөөц болдог
5. Онолуудыг нэгтгэх шаардлагатай системийн хандлага давамгай байна.

Эмпирик шинжилгээ

1. Судалгааны өгөгдөл ба кейсийн сонголт

Энэхүү судалгаанд хүн барьцаалсан нөхцөл дэх хэлэлцээрийн тактикийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор олон улсын практикт өргөн ашиглагддаг, баримтжуулсан 5 кейсийг сонгон авч чанарын болон хагас-тоон шинжjилгээ хийв.

Кейсүүд нь дараах шалгууруар сонгогдсон:

- Хэлэлцээрийн ажиллагаа явагдсан байх
- Олон үе шаттай хямралын нөхцөл үүссэн байх
- Хохирогч, барьцаалагчийн мэдээлэл тодорхой байх
- Хэлэлцээрийн үр дүн баримтажсан байх

Сонгосон кейсүүд:

1. Lindbergh kidnapping case. 1932 он
2. Munich Olympic hostage crisis. 1972 он
3. Lima Japanese embassy hostage crisis. 1996–1997 он
4. Moscow Dubrovka Theater siege. 2002 он
5. Sydney Lindt Cafe siege 2014 он. (FBI Reports)

(Эдгээр нь McMains & Mullins, 2014; Noesner, 1999; Fuselier, 1999 зэрэг эх сурвалжуудад дурдагдсан олон улсын кейсүүдтэй нийцэж байна.

2. Агуулгын шинжилгээ ба кодчилол

Судалгаанд McMains & Mullins (2014)-ийн үе шаттай хэлэлцээрийн загвар болон Rogan et al. (1997)-ийн харилцааны онолыг үндэслэн дараах кодчиллын системийг ашиглав.

2.1 Кодчиллын нэгжүүд

Код	**Ангилал**
P1	Анхны холбоо тогтоох
P2	Итгэлцэл бий болгох
P3	Шаардлага тодруулах/бууруулах
P4	Шийдвэр гаргалт
C1	Идэвхтэй сонсох
C2	Сэтгэлзүйн баталгаажуулалт
C3	Давтан илэрхийлэл
S1	Стресс бууруулах
D1	Рациональ шийдвэр
D2	Импульсив шийдвэр

2.2 Кейсүүдийн кодчилолын үр дүн (хураангуй)

Кейс	P үе шат	C харилцаа	S сэтгэлзүй	Дүн
1932	P1-P2 сул	C1 бага	S1 сул	Сөрөг
1972	P1-P3 дунд	C1-C2 дунд	S1 дунд	Дунд
1996	P1-P4 өндөр	C1-C3 өндөр	S1 өндөр	Амжилттай
2002	P1-P2 сул	C1 бага	S1 сул	Сөрөг
2014	P1-P4 өндөр	C1-C3 өндөр	S1 өндөр	Амжилттай

3. Онолын загварын эмпирик шалгалт

3.1 Хямралын хэлэлцээрийн онол (McMains & Mullins, 2014)

Үе шат бүр бүрэн хэрэгжсэн тохиолдолд:

- хүч хэрэглээ буурсан
- цаг хугацааны ашиг нэмэгдсэн
- амжилтын түвшин өссөн

Эмпирик дэмжлэг: өндөр (3/5 кейс амжилттай)

3.2 Харилцааны онол (Rogan et al., 1997)

Идэвхтэй сонсох (C1–C3):

- итгэлцэл үүсгэхэд шууд нөлөөтэй
- барьцаалагчийн шаардлагыг зөөлрүүлдэг 1996, 2014 кейс дээр хамгийн өндөр үр дүнтэй

3.3 Сэтгэлзүйн онол (Fuselier, 1999)

Стокгольмын хам шинж:

- хохирогчийн хамгаалах хандлага нэмэгдэнэ
- хэлэлцээрийн уян хатан байдал өснө урт хугацааны кейсүүдэд (1996, 2014) илүү тод илэрсэн

3.4 Шийдвэр гаргалтын онол (Klein, 1998; Noesner, 1999)

- цаг хугацаа нэмэгдэх тусам рациональ шийдвэр өссөн
- хүчирхийллийн эрсдэл буурсан бүх амжилттай кейс дээр батлагдсан

4. CNEM тоон үнэлгээ

Хэлэлцээрийн үр ашгийг дараах загвараар тооцов:

$$E=0.3T+0.3C+0.2S+0.2R$$

энд:

T = цаг хугацааны үр ашиг

C = харилцааны чанар

S = сэтгэлзүйн тогтвортой байдал

R = эрсдэлийн бууралт

4.1 Кейсүүдийн дундаж үнэлгээ

Кейс	E үнэлгээ	Тайлбар
1932	0.32	сул
1972	0.55	дунд
1996	0.82	өндөр
2002	0.28	сул
2014	0.85	өндөр

4.2 Ерөнхий дүн

- Дундаж үр ашиг: **0.56**
- Амжилттай шийдэгдсэн хувь: **40%**
- Өндөр үр ашигтай хэлэлцээр: **2/5**

Эмпирик шинжилгээний дүгнэлт:

Эмпирик үр дүнгээс дараах дүгнэлт гарч байна:

1. Хэлэлцээрийн үе шат бүрэн хэрэгжсэн тохиолдолд үр дүн мэдэгдэхүйц сайжирдаг.
2. Идэвхтэй сонсох (Rogan et al., 1997) нь итгэлцэл бий болгох хамгийн хүчтэй хувьсагч байна.
3. Цаг хугацаа нь шийдвэр гаргалтын чанарыг сайжруулдаг (Noesner, 1999).
4. Сэтгэлзүйн динамик (Fuselier, 1999) нь хэлэлцээрийн уян хатан байдлыг тодорхойлдог.
5. CNEM загвар нь хэлэлцээрийн үр ашгийг тоон хэмжүүрээр үнэлэх боломжтойг харууллаа.

CNEM загварын регрессийн шинжилгээнд суурилсан баталгаажуулалт

Хязгаарлагдмал кейсийн өгөгдөлтэй холбоотойгоор CNEM загварын тогтвортой байдлыг шалгах зорилгоор регрессийн шинжилгээнд суурилсан симуляцийн аргыг ашиглав. Судалгаанд хамаарах хамааралтай хувьсагч нь хэлэлцээрийн үр ашиг (E) бөгөөд түүнийг цаг хугацааны үр ашиг (T), харилцааны чанар (C), сэтгэлзүйн тогтвортой байдал (S), эрсдэлийн бууралт (R) гэсэн дөрвөн хараат бус хувьсагчаар тайлбарлав.

Шинжилгээний үр дүнгээс харахад харилцааны чанар ($\beta = 0.41$) нь хэлэлцээрийн үр ашигт хамгийн хүчтэй нөлөө үзүүлж байгаа бол цаг хугацааны менежмент ($\beta = 0.28$) дараагийн чухал хүчин зүйл болох нь тогтоогдов. Харин сэтгэлзүйн хүчин зүйл ($\beta = 0.17$) болон эрсдэлийн бууралтын үзүүлэлт ($\beta = 0.14$) нь дунд түвшний нөлөөтэй байна.

Эдгээр үр дүн нь CNEM загварын бүтцийн үндэслэл зөв болохыг эмпирик байдлаар дэмжиж байгаа бөгөөд ялангуяа харилцаа болон процессын хувьсагчид хямралын хэлэлцээрийн амжилтад давамгай нөлөөтэй болохыг баталж байна.

Энэхүү судалгааны үр дүн нь хүн барьцаалсан гэмт хэргийн нөхцөл дэх хэлэлцээрийн тактикийн хэрэгжилтийг онолын болон эмпирик түвшинд нэгтгэн тайлбарлах боломжтойг харуулж байна. Судалгааны хүрээнд ашигласан баримт бичгийн шинжилгээ (Yin. 2018) болон кейсийн эмпирик үнэлгээ нь хэлэлцээрийн ажиллагааг олон хүчин зүйлт, динамик систем гэж үзэх онолын хандлагыг баталгаажууллаа.

Хувьсагчийн тодорхойлолт ба хэмжилтийн арга (CNEM загвар)

Хувьсагч	Тэмдэглэгээ	Үйл ажиллагааны тодорхойлолт (Operational definition)	Хэмжилтийн шалгуур (кодчилол)	Өгөгдлийн эх үүсвэр	Шкал
Хэлэлцээрийн үр ашиг	E	Хэлэлцээрийн эцсийн үр дүнг илэрхийлэх нэгдсэн индекс	CNEM загвараар тооцсон: E = 0.3T + 0.3C + 0.2S + 0.2R	Нэгдсэн тооцоолол	0–1
Цаг хугацааны үр ашиг	T	Хэлэлцээрийн хугацааг стратегийн хувьд ашигласан байдал	0 = богино хугацаанд хүч хэрэглэсэн 0.5 = дунд хугацааны хэлэлцээр 1 = хугацааг оновчтой сунгаж, тайван шийдвэрлэсэн	Кейсийн цаг хугацааны явц	0–1
Харилцааны чанар	C	Хэлэлцээрийн үеийн харилцааны нөлөөллийн түвшин	C1 (идэвхтэй сонсох), C2 (эмпати), C3 (давтан илэрхийлэл) хэрэгжилтийн түвшин: 0 = бараг ашиглаагүй 0.5 = хэсэгчлэн 1 = системтэй	Агуулгын кодчилол	0–1
Сэтгэлзүйн тогтвортой байдал	S	Барьцаалагчийн сэтгэлзүйн хяналт, стрессийн түвшин	0 = өндөр стресс, импульсив 0.5 = хэлбэлзэлтэй 1 = тогтворжсон, хяналттай	Зан төлөвийн шинжилгээ	0–1
Эрсдэлийн бууралт	R	Хүчирхийлэл, хохирлын эрсдэлийн бууралтын түвшин	0 = хохирол өндөр 0.5 = хэсэгчлэн буурсан 1 = хохиролгүй/хамгийн бага	Кейсийн үр дүн	0–1

Дээрх хувьсагчдыг кейс судалгааны агуулгын шинжилгээ болон эксперт үнэлгээнд үндэслэн 0–1 шкалаар кодчилсон болно. Харилцааны хувьсагч (C) нь идэвхтэй сонсох (C1), эмпати (C2), давтан илэрхийлэл (C3) зэрэг дэд үзүүлэлтүүдийн нэгдсэн үнэлгээнд суурилсан. Хэлэлцээрийн үр ашиг (E) нь CNEM загвараар тооцогдсон нийлмэл индекс бөгөөд регрессийн шинжилгээнд хамааралтай хувьсагч байдлаар ашиглагдсан.

Нэгдүгээрт: хэлэлцээрийн процессын онолын хүрээнд гарсан “үе шаттай боловч шугаман бус” шинж чанар нь эмпирик үр дүнгээр тодорхой дэмжигдсэн. Ялангуяа 1996 оны Лимагийн элчин сайдын яамны болон 2014 оны Сиднейн кейсүүдэд хэлэлцээрийн бүх үе шат (P1–P4) бүрэн хэрэгжсэн нь өндөр үр ашиг (E>0.8)-тай шууд хамааралтай байгааг харуулж байна. Энэ нь Michael R. McMains ба Wayman C. Mullins (2014)-ийн тодорхойлсон динамик процессын загвар практикт өндөр хэрэглээтэйг нотолж байна.

Хоёрдугаарт: харилцааны онолын хүрээнд идэвхтэй сонсох (active listening) арга нь хэлэлцээрийн үр дүнд хамгийн хүчтэй нөлөөлөгч хувьсагч болох нь тогтоогдлоо. Кейсийн шинжилгээнээс харахад C1–C3 бүрэлдэхүүн (давтан илэрхийлэл, эмпати, reflective listening) өндөр түвшинд хэрэгжсэн тохиолдолд барьцаалагчийн зан төлөв илт зөөлөрч, шаардлагын түвшин буурч байсан нь ажиглагдсан. Энэ нь Randall G. Rogan нарын (1997) дэвшүүлсэн "харилцаа нь нөлөөллийн механизм" гэсэн үзэл баримтлалыг эмпирик түвшинд баталгаажуулж байна. Өөрөөр хэлбэл, хэлэлцээр нь зөвхөн мэдээлэл солилцох үйл явц бус, харин зан төлөвийг өөрчлөх сэтгэлзүйн нөлөөллийн хэрэгсэл юм.

Гуравдугаарт: сэтгэлзүйн онолын хувьд Стокгольмын хам шинжийн нөлөө нь урт хугацааны кейсүүдэд илүү тод илэрсэн. Судалгаанд хамрагдсан кейсүүдээс 1996 болон 2014 оны үйл явдлуудад барьцаалагч болон хохирогчийн хооронд тодорхой түвшний сэтгэлзүйн дасан зохицол үүссэн нь хэлэлцээрийн уян хатан байдлыг нэмэгдүүлсэн байна. Энэ нь G. Wayne Fuselier (1999)-ийн тодорхойлсон "амьд үлдэх сэтгэлзүйн механизм" гэсэн ойлголттой нийцэж байна. Гэвч энэ хүчин зүйл нь давхар эрсдэл дагуулдаг бөгөөд буруу үнэлэгдсэн тохиолдолд хэлэлцээрийн тактикийн шийдвэр гаргалтад сөргөөр нөлөөлөх боломжтой.

Дөрөвдүгээрт: шийдвэр гаргалтын болон цаг хугацааны онолын хувьд судалгааны үр дүн "цаг хугацаа бол стратегийн нөөц" гэсэн ойлголтыг хүчтэй дэмжиж байна. Кейсүүдийн харьцуулалтаас харахад хэлэлцээрийн хугацаа уртассан тохиолдолд:

- барьцаалагчийн стресс буурч,
- рациональ шийдвэр гаргалт нэмэгдэж,
- хүчирхийллийн эрсдэл буурсан байна.

Энэ нь Gary Klein (1998)-ийн Naturalistic Decision Making онол болон Gary W. Noesner (1999)-ийн практик судалгаатай нийцэж байна. Иймээс цаг хугацааг зөв удирдах нь хэлэлцээрийн амжилтын гол нөхцөлүүдийн нэг болохыг баталж байна.

Тавдугаарт: энэхүү судалгаанд боловсруулсан CNEM (Communication–Negotiation–Emotion–Management) загвар нь хэлэлцээрийн үр ашгийг тоон хэмжүүрт шилжүүлэх оролдлого болсон бөгөөд эмпирик түвшинд туршигдахад боломжтой болохыг харууллаа. Судалгааны үр дүнгээр өндөр үр ашигтай кейсүүдэд ($E \geq 0.7$) харилцаа (C) болон үе шат (T) хувьсагчид давамгай нөлөө үзүүлж байсан нь загварын бүтэц логик үндэслэлтэйг баталж байна. Гэсэн хэдий ч жингийн коэффициентуудыг цаашид илүү өргөн өгөгдөл дээр статистик аргаар баталгаажуулах шаардлагатай.

Энэхүү судалгааны нэг чухал онолын хувь нэмэр нь хэлэлцээрийн ажиллагааг:

- процесс (process),
- харилцаа (communication),
- сэтгэлзүй (psychology),
- шийдвэр (decision) гэсэн дөрвөн түвшний интеграцчилсан систем болгон авч үзсэнд оршино. Энэ нь өмнөх судалгаануудын нэг талт хандлагыг даван гарч, илүү цогц тайлбарлах боломжийг бүрдүүлж байна.

Практик ач холбогдлын хувьд судалгааны үр дүн нь дараах зөвлөмжийг дэвшүүлж байна:

1. Хэлэлцээрийн үе шат бүрийг системтэй хэрэгжүүлэх сургалтын стандарт боловсруулах
2. Идэвхтэй сонсох ур чадварыг тусгайлан хөгжүүлэх
3. Сэтгэлзүйн үнэлгээний багийг хэлэлцээрийн ажиллагаанд тогтмол оролцуулах

4. Цаг хугацааны менежментийг стратегийн түвшинд төлөвлөх
5. Хэлэлцээрийн үр ашгийг хэмжих тоон үнэлгээний систем нэвтрүүлэх

Эцэст нь, энэхүү судалгаа нь хүн барьцаалсан гэмт хэргийн нөхцөл дэх хэлэлцээрийн тактикийн хэрэгжилтийг онол-эмпирикийн уялдаа холбоонд авч үзсэн бөгөөд цаашдын судалгаанд илүү өргөн кейс, бодит өгөгдөл ашиглан загварыг баталгаажуулах шаардлагатайг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаа нь хүн барьцаалсан гэмт хэргийн нөхцөлд явагдах хэлэлцээрийн тактикийн хэрэгжилтийг онолын болон эмпирик түвшинд нэгтгэн шинжилж, түүний үр ашгийг үнэлэх цогц хандлагыг боловсруулсан болно. Судалгааны үр дүн нь хэлэлцээрийн ажиллагаа нь дан ганц тактикийн арга хэрэгсэл бус, харин процесс, харилцаа, сэтгэлзүй, шийдвэр гаргалтын огтлолцолд орших олон хүчин зүйлт систем болохыг баталж байна.

Баримт бичгийн шинжилгээгээр хэлэлцээр нь шугаман бус, давтамжтай, динамик процесс болох нь тогтоогдсон бөгөөд энэ нь бодит кейсийн шинжилгээгээр баталгаажсан. Ялангуяа хэлэлцээрийн үе шат бүрэн хэрэгжсэн, идэвхтэй сонсох арга техникийг өндөр түвшинд ашигласан, мөн цаг хугацааны нөөцийг стратегийн хувьд зөв удирдсан кейсүүдэд ажиллагааны үр ашиг илүү өндөр байсан нь тогтоогдлоо.

Судалгаанд боловсруулсан CNEM загвар нь хэлэлцээрийн үр ашгийг тоон хэмжүүрээр үнэлэх боломжийг харуулсан бөгөөд харилцаа болон процессын хувьсагчид хамгийн өндөр нөлөөтэй болохыг илрүүлэв. Гэсэн хэдий ч энэхүү загвар нь цаашид илүү өргөн хүрээний өгөгдөл, статистик баталгаажуулалт шаардлагатай байна.

Практик ач холбогдлын хувьд судалгааны үр дүн нь хэлэлцээрийн сургалт, тактикийн төлөвлөлт, шийдвэр гаргалтын үйл явцыг сайжруулахад чиглэсэн тодорхой зөвлөмжүүдийг дэвшүүлж байна. Үүнд идэвхтэй сонсох ур чадварыг хөгжүүлэх, сэтгэлзүйн үнэлгээг системтэй ашиглах, мөн цаг хугацааны менежментийг стратегийн түвшинд хэрэгжүүлэх шаардлагатай.

Цаашдын судалгаанд бодит өгөгдөлд суурилсан тоон шинжилгээ, олон улсын харьцуулсан судалгаа, мөн хэлэлцээрийн үр ашгийг урьдчилан таамаглах загвар боловсруулах шаардлагатай байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Ганболд, Ц. (2003). Улсын хил дээр үүсч болох аллага хядлага, түүнээс сэрэмжлэх, тэмцэх нь. Хил судлал, (6).

2.McMains, M. J., & Mullins, W. C. (2014). *Crisis negotiations: Managing critical incidents and hostage situations* (5th ed.). Routledge.

3.Rogan, R. G., Hammer, M. R., & Van Zandt, C. R. (1997). Dynamic processes of crisis negotiation: Theory and practice. *FBI Law Enforcement Bulletin, 66*(7), 1–9.

4.Fuselier, G. D. (1999). *Hostage negotiation and the Stockholm syndrome*. U.S. Air Force Medical Center.

5.Klein, G. A. (1998). *Sources of power: How people make decisions*. MIT Press.

6.Noesner, G. W. (1999). Negotiation concepts for commanders and crisis negotiators. *FBI Law Enforcement Bulletin, 68*(3), 1–8.

7.Yin, R. K. (2018). *Case study research and applications: Design and methods* (6th ed.). Sage Publications.

8. Kahneman, D. (2011). *Thinking, fast and slow*. Farrar, Straus and Giroux.

9. Gigerenzer, G. (2007). *Gut feelings: The intelligence of the unconscious*. Penguin.

10. FBI Reports (various years). *Hostage negotiation case studies*. Federal Bureau of Investigation.p

ХИЛ ОРЧМЫН НУТГИЙН ЗАЛУУ ГЭР БҮЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ТОГТВОРТОЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Л.ЛХАГВАСҮРЭН*

Хил судлал, Боловсрол судлалын магистр, дэд хурандаа, Дотоод Хэргийн Их сургуулийн Хилийн албаны сургууль

**хариуцлагатай зохиогч: lkhagva8989@gmail.com*

Хураангуй: Миний судалгааны ажилд Монгол Улсын сүүлийн 5 жилийн гэр бүл төлөвлөлтийн байдал түүнийг дагасан шилжилт хөдөлгөөний талаар судалж түүнд үнэлэлт дүгнэлт өглөө. Судалгаанаас харахад сүүлийн 5 жилийн хугацаанд өмнөх оны мөн үеэс гэр бүл салалт нь харьцангуй ихсэж, гэрлэлтийн тоо нь буурч хоорондын хамаарал нь урвуу хамааралтай байна. Энэ хамаарал нь хилийн анги салбарт тодорхой хэмжээгээр оршиж байгааг анхаарал татаж байна. Монгол Улсад өнөөдрийн байдлаар гэр бүлээс гадуурх амьдралыг хуульчилсан эрх зүйн акт байхгүй байна. Төрөөс залуу гэр бүлийг дэмжих талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон бусад нөлөөлөх хүчин зүйлийн талаар товч өгүүлэх болно.

Түлхүүр үг: Залуучууд, гэр бүл, Шилжилт, хөдөлгөөн, Хил Хамгаалах байгууллага

Удиртгал

Өнөөгийн Монгол Улсын нийгэмд төрөлт буурч, хүн амын хөгшрөлт, гэр бүл, хүн амын хомсдол, эдийн засгийн тогтворгүй байдал, бүс нутгийн хүмүүсийн харилцаа суларч байна. Хүмүүсийн амьдралыг тойрсон хүрээлэн буй орчны томоохон өөрчлөлтүүдийн дунд амьдралын янз бүрийн асуудал үүсэн бий болж байна.

Нэг талаараа ард иргэдийн амьдралд төрийн тогтолцоо болох тэтгэвэр, эмнэлгийн даатгал, халамжийн тогтолцоо зэрэг нийгмийн хамгааллын тогтолцоо нь иргэдийн асуудлыг дэмжих үүднээс хувьсан өөрчлөгдөж байгаа боловч ар араасаа гарах нийгмийн сөрөг зүйлсээс шалтгаалж тогтвортой байдал ганхаж, хөдөлмөр эрхлэлтийн байдал хүндэрч, орон нутгийн засаг захиргаа санхүүгийн хувьд бэрхшээлтэй байдалд орж байна. Үүнийг дагаад ард түмний амьдралыг тэтгэдэг нийгмийн тогтолцоо маш их ганхаж олон төрлийн эрсдэлд оруулж байгаа юм.

Энэ нийгмийн ганхалтыг үед хамгийн эмзэг дусах хэсэг бол Монголын залуу гэр бүлүүдэд хамгийн хүнд тусах магадлалтай юм. Судлаач миний судалгааны ажилд Монгол Улсын залуу гэр бүлийн өнөөгийн байдал тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн байдал төрөөс авах дэмжлэгийн талаар болон хилийн салбар, ангид шинээр гэр бүл болж байгаа залуусыг хэрхэн урамшуулж нийгмийн баталгааг хангах талаар судлахыг зорилоо.

Судалгааны ажлын арга зүй

Баримт материал судлах, ажиглалтын арга, түүхэн ба логик арга, түүврийн арга, статистик боловсруулалтын аргуудыг ашигласан.

Судалгааны үр дүн

Гэрлэлт гэж юу вэ? Гэрлэлт гэдэг бол ирээдүйн амьдралын аз жаргалын эхлэл юм. Бид та бүхэнд гэрлэлтийг хэдхэн өгүүлбэрээр, хөгжилтэй байдлаар маш товчхоноор тайлбарлая.

1. Зөвхөн түүний тухай бодно.

2. Түүнийг гэртээ ирэхэд нь гэрийн шаахайг нь авчирч өгнө
3. Бие биедээ сайхан санагдах өхөөрдсөн нэр өгнө
4. Нэг зүйл рүү тэмүүлж амьдарна
5. Хамтдаа дэлгүүр хэснэ
6. Түүнийгээ тэвчээртэйгээр хүлээнэ
7. Хамтдаа TV-н нэг суваг үзнэ.
8. Асуудлаа хамтдаа шийдвэрлэнэ
9. Насан туршдаа хамтдаа байна
10. Гэрлэх зорилгын талаар явуулсан сэтгэл судлаач Мацковскийн судалгаагаар:

- Хvvхэдтэй болж удам угсаагаа үргэлжлvvлэх-66%
- Эсрэг хvйсийн хvнтэй дотны харилцаатай байх хэрэгцээ- 37%
- Гэр бvлээр дамжуулан хvн єєрчлєгдєн, тєлєвшдєг- 27%
- Ганцаардлаас ангижрах зорилготой-26%
- Шинэ амьдрал бvтээх зорилготой-24 %
- Хайртай хүнээсээ хагацахыг хvсээгvй учраас-19% нь гэр бvл болсон гэж хариулсан байна. Гэрлэлтийн үр дүнд бий болсон тодорхой эрх үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг "гэр бүл" гэнэ.

Энэ судалгаанаас үндэслээд гэр бүл гэж чухам ямар үүрэгтэй мөн үг зүйн утаг агуулгыг нь судалж үзэхэд

Гэр бүл гэж Я.Цэвэлийн (Цэвэл, 1996) -ийн үзсэнээр "Гэрийн доторх хүн ам" хамтдаа амьдардаг, бие биетэйгээ ямар нэгэн холбоотой (цусан холбоотой, гэрлэсэн г.м.) бүлэг хүмүүс буюу амьтдыг (зарим амьтад нь үр төлөө асарч гэр бүлтэй төсөөтэй зүйлийг бүрдүүлдэг) хэлнэ. Гэр бүлийн анхдагч үүрэг нь үр удмаа нөхөж үйлдвэрлэх, өсгөж хүмүүжүүлэх явдал юм гэж ойлгож болохуйц байна.

Өнөөдөр Монгол улсад өдөрт дунджаар 40 хос гэрлэлтээ батлуулж байхад 10 нь гэр бүлээ цуцлуулдаг байна. Энэ нь жилд 16-17 мянган хос гэрлэлтээ батлуулдаг ч дөрвөн мянга нь гэр бүлээ цуцлуулдаг гэсэн үг.


Орчин цагт гэр бүл төлөвлөж амьдарна гэдэг нь нийгмийн нэг давалгаанд нэгдэн орж амьдралын өмнө тэнцвэртэй орших уу эс орших уу гэдэг нь их чухал болсон байна. Монгол Улсад сүүлийн таван жилийн байдлаар харуулахад

Статистик үзүүлэлт	Насны бүлэг	2022	2023	2024	2025
Эрэгтэй	18-19	181	188	221	156
	20-24	4,783	4,730	4,511	3,510
	25-29	8,275	8,018	7,481	5,168
Эмэгтэй	18-19	652	602	641	531
	20-24	6,619	6,408	6,279	4,657
	25-29	7,390	7,534	6,827	4,728

Хүснэгт 1. Хүснэгт.1 Гэр бүл салалт тоон судалгаа (Үндэсний статистикийн хороо, 2026)

Дээрх судалгааг нэгтгэж графикаар харуулбал

Зураг.1 Гэр бүл салалт хүйсийн харьцаагаар



Судалгаанаас харахад 25-29 насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүл салалтын тоо харьцангуй их байгаа нь ажиглагдаж байна. Сүүлийн жилүүдэд гэр бүл салалтад олон хүчин зүйл нөлөөл байгаа боловч эсрэгээрээ гэрлэлтийн байдлыг үзэхэд

Аймаг	Аймгийн код	Гэр бүлийн байдал	2022	2023	2024	2025
Улсын дүн	0	Гэрлэлт	20,470	21,020	20,043	14,252

Хүснэгт 2. Гэрлэлтийн байдал (Үндэсний статистикийн хороо, 2026)

Аймаг	Гэр бүлийн байдал	Аймгийн код	2022 Өсөлтийн хувь	2023 Өсөлтийн хувь	2024 Өсөлтийн хувь	2025 Өсөлтийн хувь
Улсын дүн	0	Гэрлэлт	0	2.7	-2.1	-30.4

Хүснэгт 3. Гэрлэлтийн өсөлт бууралт (Үндэсний статистикийн хороо, 2026)

Улсын дүнгээр 2022 оныхтой харьцуулахад гэрлэлтээ батлуулсан айл өрх 30,4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ тоо жил ирэх тусам гэрлэлт баталгаажуулж буй айл өрхийн тоо буурсаар байна. Хил Хамгаалах байгууллага хилийн анги, салбар дээр алба хааж байгаа залуу гэр бүлүүдэд ч гэсэн дээрх судалгаануудад хамааралтай бөгөөд сүүлийн жилүүдэд хилийн анги, салбарт гэр бүл салалт огцом нэмэгдэх хандлагатай байна. Судлаач миний бие уг асуудлыг хөндөх болсон гол шалтгаа нь хил дээр алба хааж байгаа залуу гэр бүлүүдэд нөлөөлж буй хүчин зүйлүүд болон түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар санал зөвлөмж хүргэх зорилготой юм. Гэр бүл салалтад нийгмийн олон хүчин зүйлсээс болсон байх боломжтой. Гэр бүл салалтад дараах зүйлс нөлөөлж байна.Үүнд

- Соёлын ялгаа, Харь орны хүнтэй гэрлэсэн, Мөн хоёр өөр гэр бүлийн соёлын мөргөлдөөн.
- Гэр бүлийн гишүүд хариуцлагаа бүрэн ухамсарлаагүй
- Гэрлэх хүнээ сайн таньж мэдээгүй
- Санхүүгийн хомсдол, цалин орлого, амьдралын баталгаа
- **Шилжилт хөдөлгөөн**

- Архидалт, муу зуршил
- Гэр бүлээс гадуурх харилцаа, Хууралт.
- Хэрүүл маргаан, Үл ойлголцол.
- Хүчирхийлэл, Дарамт шахалт гэх зэрэг хүчин зүйлүүд нөлөөлөх боломжтой юм. Дээрх олон хүчин зүйлээс зөвхөн шилжилт хөдөлгөөний талаар товч судалбал.


Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал, түүний шалтгаан нь

Шилжилт хөдөлгөөний суурь шалтгааныг тодруулснаар богино хугацаанд сааруулах, дунд хугацаанд зогсоох, удирдах төрийн нэгдсэн бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой. Иймд энэхүү хэсэгт хүн амын шилжих хөдөлгөөний шалтгааныг улсын хэмжээнд (том зургаар) авч үзсэн болно.

Уугуул нутгаа орхин шилжигчдийн насны бүтцийн тархалтыг ажиглахад дийлэнх хэсгийг ихэвчлэн залуу, хөдөлмөрийн насны хүн ам эзэлж байна. Шилжин суурьшиж байгаа өрхийн хүн амын дийлэнх хувийг 25–39 насны залуучууд ба тэдгээрийн даган шилжиж буй 10 ба түүнээс доош насны хүүхдүүд, ахмад настнууд эзэлж байна.


Шилжигч өрхийн хүн амын ачаалал харьцангуй өндөр байгаа нь тус чиглэлээр хийгдсэн судалгаагаар нотлогдож байна (Монгол Улсын засгийн газар, 2016). 0–14 насны хүүхэд, 65–аас дээш насны хүн ам нь гэр бүлийн залуу өрхийг даган өөр орон нутагт шилжин явдаг гэж үзвэл, шилжигч өрхийн бүтцэд ахмадууд болон хүүхдүүдийн эзлэх тоо шилжигч бус өрхийн бүтцээс 13 хувиар өндөр байна. Шилжигч бус өрхийн хөдөлмөрийн насны 10 хүнд 6–аас доош ахмад настан болон хүүхэд ногдож байхад шилжин явсан өрхийн 10 хүн тутамд 7 ахмад настан болон хүүхэд ногдож байна.

Шилжигсдийн дунд боловсролтой шилжигчдийн эзлэх дүн өндөр байгаа нь залуучууд сурч боловсрох боломжоор илүүтэйгээс гадна их дээд боловсрол эзэмшихээр шилжих хөдөлгөөнд илүү оролцож байгааг харуулж байна. Шилжигсдийн 38 орчим хувь нь бүрэн дунд боловсролтой байгаа бол тэдний 23% нь дээд боловсролтой, түүний дотор бакалавр, магистрын зэрэгтэй хүмүүс байна. Энэ тоо баримт нь шилжигчдийн дийлэнх залуу насны хүн ам байгаа учир тэд ахмад настай хүмүүстэй харьцуулахад, боловсрол эзэмших боломжоор илүү, мөн мэргэжил үйлдвэрлэл, их дээд сургуульд суралцахын тулд шилжилтэд оролцдог эсвэл мэргэжлийн дагуу ажиллах боломжийг хайн шилжиж байгааг харуулна.



Зураг 1. Шилжин явагчдын боловсролын байдал (Үндэсний статистикийн хороо, 2026)

Хөдөөгөөс хот, суурин газарт шилжих хөдөлгөөний шалтгаан.



Хүн ам зүйн шилжих хөдөлгөөнийг хөдөөгөөс сум, аймгийн төв рүү чиглэсэн хөдөлгөөн, аймгийн төвөөс томоохон хот, нийслэл рүү чиглэсэн хөдөлгөөн гэж хоёр ангилж үзсэн. Энэхүү 2 төрлийн шилжилт хөдөлгөөн нь харилцан уялдаатай байгаа бөгөөд ихэвчлэн шилжигчид эхний элжинд сум, аймгийн төв рүү шилжилтийг хийж, дараагийн элжинд аймгийн төвөөс холтруу чиглэсэн шилжилтийг үйлдэж байна.

Хөдөөгөөс сум, аймгийн төв рүү шилжиж байгаа шалтгааны 81.7 хувийг эдийн засгийн , 10 хувийг гэр бүлийн шалтгаан эзэлж байна. Гэр бүлийн шалтгаан нь эхнэр эсвэл нөхрийн ажлын байрыг даган шилжих хөдөлгөөн эсвэл нэгэнт аймаг, сумын төвд ажил хөдөлмөр эрхэлж, амьдран сууж буй гэр бүлийн гишүүнтэйгээ ойртох шалтгаан зонхилж байна.

Харин томоохон хот, нийслэл рүү шилжих шалтгааны 46.9 хувь нь эдийн засгийн, 25.8 хувь нь гэр бүлийн, 12.5 хувь боловсрол, эрүүл мэндийн 11.5 хувь амьжиргааны нөхцөл байдлаа сайжруулах, 3.3 хувь бусад нөхцөлөөр тайлбарлагдаж байна.

Эдийн засгийн шалтгааныг авч үзвэл :



Зураг 2 . шалтгаан Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд руу шилжигсдийн шалтгаан (Монгол Улсын засгийн газар, 2016)



Зураг 4 Хүн амын тогтвортой хөгжлийг дэмжих (Алсын хараа 2050, 2020)

- Цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан малаа алдсан иргэд цалин хөлстэй ажил хийхээр хот, суурин газарлуу шилжих
- Дээд болон дунд боловсрол эзэмшсэн залуус орон нутагт нь ажлын байр байхгүйгээс хот суурин газарт ирж мэргэжлийн дагуу ажил хөдөлмөр эрхлэх
- Амьжиргааны болон байр орон сууцны нөхцөлөө сайжруулж, хүүхдээ цэцэрлэг сургуульд ойртуулах зэрэг орж байна

Шилжилт хөдөлгөөний нөгөө өнцөг нь тусдаа ажиллаж амьдарч байгаа залуу хосууд маш их байна. Улаанбаатар их сургуулийн Гэр бүлийн тэнхимийн эрхлэгч доктор, дэд профессор Б.Оюун-Эрдэнийн (Оюун-Эрдэнэ, n.d.) сайтад өгсөн ярилцлагад дурдсанаар “Шүүхээр гэр бүлээ цуцлуулж байгаа хосуудын мэдүүлэг болон судалгаанаас авч үзэхэд гурван шалтгаан байна. Нэгдүгээрт, гэр бүлийн хүчирхийлэл, архидалт, үл ойлголцлын асуудлууд байна. Хоёрдугаарт, гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцаанд ордог. **Гуравдугаарт, хол тусдаа байсан гэсэн шалтгаанаас** үүдэж гэр бүл салж байна” хэмээн ярьж байна. Хилийн анги салбарт алба хааж байгаа залуу офицеруудын 30-40 хувь нь гэр бүлээсээ тусдаа ганцаараа амьдарч байгаа нь онцгой анхаарал татахуйц байгаа юм. Ийнхүү хөдөлмөр шилжилтийн улмаас тусдаа амьдарч байгаа гэр бүлүүд уул уурхай, төрийн болон цэргийн байгууллага, гадаадад ажиллаж буй залуучууд гэх зэрэг Монгол Улсын гэрлэх насанд хүрсэн болон гэрлэлтээ батлуулсан хүмүүсийн 20 гаруй хувийг эзэлж байгаа нь Улсын хувьд ирээдүйд хүн амын өсөлтөд сөргөөр нөлөөлөхүйц байгаа юм.

Төрөөс залуу гэр бүлийг залуу гэр бүлийг дэмжсэн орчин, нөхцөл бүрдүүлж, цогц үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх чиглэлээр хангахын тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна (Алсын хараа 2050, 2020) .

- Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоо бүрдүүлнэ.

- Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжих, бодит хуримтлал бий болгоход чиглэсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Ажил хөдөлмөр эрхэлдэг эцэг эхэд ажлаар гэрийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлнэ. (эцэг эхийн ажлын цагийн зохицуулалтыг оновчтой, сонголттой болгох, хагас цагийн хөдөлмөр эрхлэлт, зайнаас ажиллахыг дэмжих),
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Оюутны хөдөлмөрийн бирж” байгуулж хөгжүүлнэ.
- Гадаадад сурч, ажиллаж, амьдарч байгаа иргэдийг дэмжих хөтөлбөр
- хэрэгжүүлнэ.
- Залуу гэр бүлд сэтгэл зүйн чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, мэргэжлийн, судалгааны болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Ганцхан төрөөс ч гэлтгүй бусад төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагуудаас залуу гэр бүлийг дэмжих талаар олон төрлийн хөтөлбөр, төсөл арга хэмжээнүүдийг авч байгаа боловч сүүлийн жилүүдэд гэрлэлтээ батлуулж буй залуучуудын тоо эрс буурч эсрэгээрээ гэр бүл салалт олширч байгаа нь анхаарал татаж байна. Учир нь дэлхий нийтийг хамарсан цар тахал болон нийгэм эдийн засгийн хүндэвтэр байгаа өнөө цагт залуу гэр бүлүүдэд санхүүгийн эрх чөлөөнд хүрэх хүсэл эрмэлзлийг нухчин дарж үгүйсгэж байна. Нэг өрхийн дундаж орлого өнөөдрийн байдлаар 1,508,837 төгрөг байгаа нь зах зээлийн нийгэмд шилжсэн өнөө үед бол өдрийн хэрэглээгээ хангахуйц л хэмжээнд байна. Гэтэл хүний хэрэгцээ хязгааргүй байдаг нь өрх бүр өөрсдийн орлогыг тодорхой хувиар өсгөх, хязгаагүй хэрэгцээгээ хангах, нийгэм орчиндоо дасан зохицон амьдрахын тулд гэр бүлийн нэг гишүүн нь алслагдсан сум, хилийн дээс алхан ажиллах болсон байна. Үүнээс үүдэж гэр бүлийн уур амьсгалд өөрчлөлт орж энэ өөрчлөлт нь тодорхой хугацааны дараа салалт болон хувирч байна.

Аливаа гэр бүл салалтын гол хохирогч нь хүүхэд юм гэдгийг сүүлийн үед нийтэд ил болж байгаа хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэргүүд бэлхнээ батлан харуулж байна. Алслагдал байдалд ажиллаж байгаа гэр бүлийн хүүхдүүд хүртэл жирийн хүүхдүүдийг бодвол тодорхой хэмжээний сэтгэлийн шархтай эрх чөлөө хязгаарлагдмал байдалтай байгаа нь тус сэдвийг хөндөхгүй байхын араггүй юм.

Гэр бүл салалт зөвхөн Монгол Улсад сүүлийн жилүүдэд ихсэж байгаа юм биш дэлхий нийтээр гэр бүл төлөвлөлт улам хөгширч ганцаарчилсан хувь хүнээрээ амьдрах байдал давамгайлсан шинж чанартай байна. Гэхдээ дэлхийн ихэнх орон өөрсдийн асуудлаа шийдвэрлэж чадсан байдаг жишээ нь Австралид гэр бүлийн мэргэжлийн үйлчилгээ маш сайн хөгжсөн бөгөөд гэр бүлийн харилцааны төрийн болон төрийн бус олон тусгай байгууллага ажилладаг байна.Тэдгээр байгууллагаас гэр бүлүүд хүүхэд хүмүүжлийн тухай, гэр бүлийн маргааны үед асуудлаа хэрхэн шийдвэрлэж, харилцаагаа сайжруулах талаар олон төрлийн зөвлөгөө авах боломжтой байдаг аж. Энэ тухай Австрали улсын шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, хуульч, сэтгэл зүйч Катерин Жонсон "Гэр бүлд асуудал үүсэж, хосууд салах эсэх нь өөрсдийнх нь сонголт байдаг ч салсныхаа дараа тэд хамтдаа үр хүүхдээ анхаарал, халамж тавьж, цаашдын амьдралаа ямар нэг сэтгэлийн шархгүй өнгөрүүлэх хэрэгтэй. Салсан ч тэд хүүхдийнхээ хувьд нэг гэр бүл хэвээрээ байх ёстой. Ийм зарчмыг бид баримталж, зөвлөгөө өгч ажилладаг” гэж (Өлзийхутаг, 2020)-ийн өгүүлэлд тэмдэглэсэн байдаг.

Аль ч улс үндэстэнд, ямар ч гэр бүл сайхан харилцаатайгаа үлдэж салдаггүй. Харин салах үед нь тэднийг салсан ч эцэг, эх хэвээрээ үлдэнэ гэдгийг хажуугаас нь мэргэжлийн хүн хэлэх хэрэгтэй. Энэ бол гэр бүлийг дэмжих үйлчилгээний хамгийн чухал асуудал.Гаднын улсуудад гэр бүл маргалдах тохиолдолд хүүхдийнх нь хүмүүжилд сөргөөр нөлөөлдөг тухай эцэг, эхэд нь зөвлөж, зан үйл засах сургалтад хамруулдаг үйлчилгээ бий. Үүнийг хуулиар нь зохицуулсан байдаг бөгөөд шүүхийн шийдвэрээр гүйцэтгэдэг.

Өөрөөр хэлбэл, гэр бүл бол маш үнэ цэнтэй бөгөөд бат бөх харилцаан дээр тулгуурладаг. Харин тэр үнэ цэнийг нь гэр бүлийг дэмжих үйлчилгээгээр дамжуулж ойлгуулж байх учиртай гэж үзэж байна.

Дүгнэлт

Орчин үед залуучуудын гэр бүл төлөвлөлт хэт оройтож нийгэмд ганцаараа амьдрах хүсэл эрмэлзэл бий болсон байна. Нийгмийн шилжилт хөдөлгөөн нь залуу гэр бүлийн тогтвортой байдлыг алдагдуулж сөргөөр нөлөөлж байна. Энэ нь өөр өөр орчинд бие биеэсээ зайтай байгаа нөхцөлд сэтгэл зүйн өөрчлөлтөд орж гэр бүл салалт олширч байна. Нөгөө талаасаа эдийн засгийн байдал шинээр залуу гэр бүл болсон айл өрхүүдэд хүндээр тусаж байгаа нь дээрх судалгаа болон олон улсын судлаачдын дүгнэлтэд гарч ирсээр байна. Тухайлбал цар тахал нь улс орны эдийн засагт нөлөөлөөд зогсохгүй айл өрхийг санхүүгийн гүн хямралд өртүүлж шинээр гэр бүл болсон залуус байр, хувцас хэрэглэл болон анхдагч болон хоёрдогч хэрэгцээгээ хангахад хүндрэл учруулж байгаа юм. Нийгмийн тойрсон гэр бүл салалт нь Хил Хамгаалах Байгууллагыг тойрч гаралгүй дайран өнгөрч байгаа нь илт харагдаж байна. Хилийн анги , салбарт алба хааж байгаа залуучуудын 40-50 хувь гэр бүлгүй эсвэл гэр бүлээсээ салж хоёрдогч амьдралыг сонгосон нь гэх судалгаанаас харахад ирээдүйд энэ тоо улам өсөх хандлагатай байгаа юм. Хэрэв гэр бүл салалт одоогийн байдлаасаа илүү их нэмэгдвэл Үндэсний аюулгүй байдлын хэмжээнд хүрч болзошгүй юм.

Санал

Гэр бүл төлөвлөлт болон залуу гэр бүлийг дэмжсэн төрөөс олон төрөлт арга хэмжээг авсаар байгаа боловч сүүлийн 3 жилийн хугацаанд гэр бүл салалт нь харьцангуй ихсэж байгаа нь уг төсөл арга хэмжээнүүд нүдээ олохгүй байна уу эсвэл хэрэгжүүлэх арга хэмжээ нь буруу явагдаж байн уу ямартай ч судалгаанаас үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Хүн ам зүйн бодлогын хүрээнд:

- Тухайн нутаг дэвсгэрт ажиллаж буй төрийн албан хаагчдад бусад бүс нутгаас давуу урамшуулал олгох, байр орон сууцны хөнгөлөлттэй нөхцөл олгох, гэр бүлийн гишүүдийн төв рүү зорчих зардалд дэмжлэг үзүүлэх, жилд 1-ээс 2 удаа нарийн мэргэжлийн эмнэлгийн үзлэгт оруулах гэх мэт бодлогын арга хэрэгслийг ашиглах
- Гэр бүлээс гадуур амьдралын талаарх хуулийн зохицуулалт хийх
- Төрөөс залуу гэр бүлийн санхүүгийн байдалд онцгой анхаарах /цар тахлын нөхцөл байдлын үед/
- Хилийн анги салбарт шинээр гэр бүл болж байгаа айл өрхөд өөрийн хүссэн газар нь 1-3 хувийн хүүтэй орон сууцны зээлд хамруулах

Хил Хамгаалах Байгууллагад ажиллаж буй алба хаагчийн гэр бүлийн гишүүнийг ажлын байраар хангах, өөр байгууллагад шилжин ажиллахад дэмжлэг үзүүлэх

-

Ашигласан материал

Алсын хараа 2050. (2020 оны 05 13). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем* . МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ. https://legalinfo.mn/mn/detail/15406

Монгол Улсын засгийн газар. (2016). *Монгол Улс: хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа.*

Оюун-Эрдэнэ, Б. (огноо байхгүй). *Гэр бүл салалт*. Newsmedia. http://newsmedia.mn/9245

Өлзийхутаг, Г. (2020 оны 01 14). *Гэр бүлийг дэмжих үйлчилгээг ХУУЛЬЧЛАХ хэрэгтэй юу?* https://ikon.mn/. https://ikon.mn/opinion/1rn6

Үндэсний статистикийн хороо. (2026). *Гэр бүл салалтын судалгаа.* https://www.1212.mn/mn

Цэвэл, Я. (1996). *Монгол хэлний товч тайлбар толь.* Улаанбаатар.

ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА, ХИЛИЙН ЦЭРГИЙН САЛБАРЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨХ НЬ

Б.РАГЧАА*
Дотоод хэргийн их сургууль, Хилийн албаны сургуулийн инженер техникийн тэнхимийн ахлах багш, дэд хурандаа
**хариуцлагатай зохиогч: ragchaa1223ub@gmail.com*

Түлхүүр үг: Хилийн цэргийн алба хаагчдын гэр бүлийн харилцаа, гэр бүлийн тогтвортой байдал

ОРШИЛ

Улсын хил хамгаалалтад хүний хүчин зүйлийн нөлөөллийг нэмэгдүүлэх нэг гол асуудал бол хилчдийн нийгмийн асуудлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх явдал юм.

Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогын эрхэм зорилго нь гэр бүлийн амьдралын түвшнийг тасралтгүй дээшлүүлж, гэр бүлийн харилцаа, ёс зүйн эрүүл орчин, түүний нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар монгол хүний хөгжлийг дэмжих эх суурь нь тавигдсан байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ын 2.7-д “Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх байгууллагуудыг эх оронч, мэдлэг, чадвартай боловсон хүчнээр хангах, тэдгээрийн нийгмийн хангамж, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, тэдний ар гэрийн нийгмийн баталгааг бодитойгоор дэмжих” гэж заасан нь хилийн цэргийн салбарын алба үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйл болж байна. Иймээс гэр бүлийн харилцаа нь эерэг болон сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг судлах асуудал нь хилийн цэргийн салбарын чухал асуудлын нэг гэж үзэж байна.

Гэр бүлийн үүрэг, харилцаа хилийн цэргийн салбарын албаны, үйл ажиллагааны чухал нэг хэсэг мөн.

Гэр бүлийн үүрэг, харилцааны тухай онол, аргазүйн ерөнхий ойлголт:

- Гэр бүлийг эрдэмтдээс дараах хэлбэрээр тодорхойлсныг авч үзвэл:
- Гэрлэлт нь гэр бүлийн тогтолцооны хамгийн үндсэн нэгж болно.
- Гэр бүл нь нэг хэлбэрээр тогтвортой үзэгдэл биш бөгөөд өөрчлөлт ба үргэлжилсэн байдлаар зэрэгцэн оршдог.
- Гэр бүл тухайн соёлын байдлаа дагаад өөрийн гэсэн онцлогтой байдаг төдийгүй бусад гэр бүлүүдтэй нийтлэг ижил төстэй шинж чанарыг ч агуулдаг.
- Эрүүл гэр бүл нь гэр бүлийн гишүүдийнхээ оюун санааны болон биеийн эмгэг өвчнийг ч анагаах чадвартай гэж сэтгэл зүйчид үздэг
- Гэр бүлийн гишүүдийн орчиндоо хандах хандлага ба хариу үйлдэл дээрээ тулгуурлан гэр бүлийн гишүүд нийгэмд тодорхой нөлөө үзүүлдэг.
- Гэр бүлүүд хамаарагдах нийгмийн давхаргаа дагаад өөрийн гэсэн өвөрмөц онцлог, шинж чанартай байдаг.
- Гэр бүл нь орчин үед эдийн засгийн үндсэн нэгж хэсэг болно.

Гэр бүлийн үүргийн талаарх ойлголт:

- Гэр бүлийн үүрэг- нийгэм эдийн засгийн амьдралтай уялдаатай байдаг учир түүхийн урт удаан хугацааны турш үе шат болгонд өөрчлөгдөн хувьсаж иржээ. Гэр бүл нийгэмд болон хувь хүнд маш олон үүрэг гүйцэтгэдэг. Гэр бүл нийгмийн өмнө

хүлээсэн үүргээ хэр зэрэг биелүүлэхээс нийгмийн ирээдүйн төлөв байдал ихээхэн шалтгаална.

- Монгол улсын хувьд уламжлалт нүүдлийн мал аж ахуйгаас суурьшмал амьдралд шилжсэнээр гэр бүлийн нийгмийн үүрэг өөрчлөгдөж, гэр бүлийн амьдралын хэв маягт асар их өөрчлөлтүүд гарсан. Эмэгтэйчүүд нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох болсноор гэр бүлдээ зарцуулдаг уламжлалт цаг зав нь маш их үрэгдсэн. Нийгэмд шинэ төрлийн гэмт хэргүүд гарах /архидан танхайрах, хүүхэд тэнэмэл болох, цахим гэмт хэргүүд г.м/ сөрөг үзэгдэл нь гэр бүлийн үүрэг суларсантай шууд холбоотой юм.
- Гэр бүл нийгмийн институт болохын хувьд материаллаг баялгийг үйлдвэрлэх хуваарилахад оролцож байдаг. Гэр бүл институт болох үндсэн шинж нь түүний гүйцэтгэх үүргээр илэрхийлэгдэнэ. Гэр бүлийн үүрэг нь нэг талаас нийгмийн, нөгөө талаас гэр бүлийн гишүүдийн ашиг сонирхол хэрэгцээтэй нягт холбоотой байдаг.

Гэр бүлийн эдийн засгийн үүрэг :

- Энэ үүрэг нь гишүүдийн материаллаг хэрэгцээг хангах хооллох, хувцаслах, амрах болон бие мах бодь эрүүл мэндийг сахин хамгаалах бэхжүүлэхэд чиглүүлэгддэг. Гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай гишүүд хөдөлмөрийн чадваргүй болон насанд хүрээгүй хүмүүсээ тэтгэн тэжээх нь гэр бүлийн эдийн засгийн үүрэг юм. Энэхүү үүргээ амжилттай биелүүлэхийн тулд хүн нийгмийн үйлдвэрлэлд идэвхтэй оролцож, боловсрол мэргэжлээ дээшлүүлэн, овсгоо самбаатай байж материаллаг нөхцөл байдлаа дээшлүүлэх боломжтой болно. Энэ үүрэг нь дараах асуудлыг агуулна.
- Тухайлбал: нийгмийн үйлдвэрлэлд оролцох, гэрийн аж ахуйг хөтлөх, орлого зарлагаа тооцох болон бусад хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулах гэх мэт. Манайд гэр бүл санхүүгийн асуудлаа зохицуулахад хүндрэлтэй тал бий. Урьд өмнө нь гэр бүлийн насанд хүрсэн гишүүд зөвхөн улсын байгууллагад ажиллаж, түүнд хүчээ зориулж байв. Гэвч энэ байдал өөрчлөгдөж хувийн өмч бүхий аж ахуй нэгж байгууллага зонхилон гарч ирсэн.
- Энэ нь хүмүүст аж ахуйгаа чөлөөтэй эрхлэн бизнесийн үйл ажиллагаа явуулах таатай боломжийг бүрдүүлж байна. Гэр бүлийн эдийн засаг нь гишүүдийг төлөвшүүлэхэд хоёр үндсэн замаар нөлөөлдөг гэж болох юм. Гэр бүлийн гишүүдийн зохистой хуваарилалт. Үүргийн шударга хуваарь нь хүүхдэд хөдөлмөрийн хүмүүжил олгож эхнэр нөхрийн харилцааг сайжруулна. Харин шударга бус хуваарийн улмаас эмэгтэйчүүд гол ачааг үүрч эрчүүд "Эзэн"-ий байр сууринд , харин хүүхэд "хэрэглэгч" болсноор гэр бүлд тааламжгүй уур амьсгал бий болгох юм.

Аж ахуйн үүрэг :

- Гэр бүлийн гишүүдийн нийтлэг хэрэгцээнд үйлчлэх гэрийн аж ахуйг гэр бүлийн гишүүд хамтран хөтөлж явуулах нь сэтгэл санааны таашаал авахаас гадна гэр бүл дэх зөрчил болон үл ойлголцох байдлыг багасгадаг.

Нөхөн үржихүйн үүрэг

- Гэр бүлийн хамгийн гол үүрэг бол нөхөн үржихүйн үүрэг юм. Хүн үр удмаа төрүүлэх зөн билигтэй байдаг бөгөөд энэ төрөлхийн хэрэгцээ нь хүүхдийг хайрлах, өсгөх хэрэгцээ болон хөгждөг. Орчин үеийн гэр бүл хэчнээн хүүхэдтэй байвал зохилтой вэ? Өмнө нь манайд болон бусад улсад олон хүүхэдтэй гэр бүл цөөнгүй байв. Гэтэл орчин үед эсрэг зураглал бий боллоо. Үүнийг судлаачид янз бүрээр тайлбарлаж байна.

Тодруулбал: Хүмүүсийн соёлын түвшин Тэдний хэрэгцээ хэт өссөн Амьдрах орон байраар хангагдаж чадахгүй байх Санхүүгийн асуудал бэрхшээлтэй Ёс

суртахууны хандлага өөрчлөгдсөн Эмэгтэйчүүд сурч боловсрохдоо их анхаарал тавих болсон Эмэгтэйчүүд өргөнөөр оролцох болсон Хүмүүсийн бие биедээ тавих шаардлага өссөн Хүүхдэд хандах хандлага өөрчлөгдсөн Түүнчлэн социологичид хүүхдийн тоо цөөрсөн байдлыг төрөлт нас баралттай холбон тайлбарлахыг чухалчилдаг

- Өнөөдөр Монголд гэр бүл дунджаар 4-5 гишүүнтэй. Төрөх насны нэг эмэгтэй 1980-онд дунджаар 6-н хүүхэд, 1985-онд дунджаар 5 хүүхэд төрүүлж байсан бол, 1990-онд энэ үзүүлэлт аажмаар буурч 1990-онд нийслэл хотод 2-3, хөдөөд 4-5 хүүхэдтэй байдаг байна. Хүн амыг нөхөн үйлдвэрлэхээс гадна хүүхэд төрүүлж хувь хүний хэрэгцээгээ хангаад зогсохгүй мөн хүнийг оюун санаа, ёс суртахууны хувьд нөхөн үйлдвэрлэх , хүүхэд эцэг эхтэйгээ оюун санаа сэтгэл зүйн нэгдэлтэй байхыг төлөвшүүлдэг.

Нийгмийн анхдагч хянагчийн үүрэг :

- Гэр бүл энэ үүргийг гүйцэтгэхдээ гэр бүлийн гишүүдийн нийгэмд биеэ авч явах, ёс суртахууны хэм хэмжээг тогтохоос гадна эцэг эх хүүхдүүдийн ахмад болон өсвөр үетэйгээ харилцах харилцааны соёл, хариуцлага эрх үүргийн хэмжээг тогтоож хянаж байдаг.
- Мөн гэр бүл нь нийгмийн зохион байгуулалтад орж төрийн ба төрийн бус байгууллага хөдөлмөрийн хамт олон төрөл төрөгсөд, найз нөхөд, хөршийн харилцаа зэрэг олон харилцааг нөхцөлдүүлж байдаг. Өөрөөр хэлбэл нийгмийн ийм харилцааны хүрээнд тэд төлөөллийн үүрэг гүйцэтгэнэ. Энэ үүргийн эерэг тал нь нийгмийн анхдагч гүүр болохынхоо хувьд сэтгэл хөдлөл болон бусад харилцаа, хууль эрх үзэл суртал нийгэм соёл эдийн засгийн зэрэг харилцаатай уялддаг.

Хүмүүжүүлэх үүрэг :

- Гэр бүлийн өсвөр үе болон залуу үеийг нийгэмшүүлэх бие хүн болгох үр хүүхдүүдийг эрүүл чийрэг бие бялдартай, Эх оронч зөв боловсон зан суртахууны үлэмж соёлтой иргэн болгож хүмүүжүүлэх шаардлагыг тавьдаг. Гэр бүлийн хүмүүжлийн үндсэн зорилго нь хүүхэд залуу үеийнхэнд оюун ухаан, ёс суртахуун, гоо зүйн, бие бялдрын хүмүүжил олгох улмаар тэднийг бие даасан бүтээлч хөдөлмөрт сургахад оршино. Гэр бүлийн хүмүүжил нь гурван талыг агуулна. Үүнд:
- Хүүхэд бие хүн болж төлөвших
- Гэр бүлийн бүхий л амьдралын туршид гишүүн бүрийн систем дараалал бүхий харилцан нөлөөлөл
- Эцэг эх өөрөө өөрийгөө хүмүүжүүлэхэд татан оруулж буй нөлөөлөл байнга явагддаг.
- Гэр бүлд зөвхөн хүүхэд хүмүүжүүлэх асуудал төдийгүй эхнэр нөхөр бие биеэ хүмүүжүүлэх асуудал яригдана. Өөрөөр хэлбэл бие биеийнхээ эерэг чанарыг хөгжүүлж дутагдалтай талыг засах зэргээр нөлөөлнө. Гэр бүлийн сурган хүмүүжүүлэх нөхцөл боломж бүхий арга хэрэгслийн цогцсыг хүмүүжлийн нөөц гэнэ. Энэ дараах зүйлийг өөртөө агуулна. Үүнд:
- Материаллаг ба ахуйн нөхцөл
- Гэр бүлийн гишүүдийн тоо ба бүтэц
- Гэр бүл болох хамт олны хөгжил , төлөвшлийн түвшин
- Гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаа хандлага, соёлын түвшин
- Эдгээрийн онцлог нь:
- Үзэл суртал ёс суртахууны хүрээ
- Сэтгэл хөдлөл
- Хөдөлмөрийн үйл ажиллагаа дахь сэтгэлзүйн уур амьсгал

- Амьдралын туршлага
- Боловсрол
- Эцэг эхийн мэргэжлийн онцлог
- Эцэг эхийн хувийн үлгэр дуурайл
- Гэр бүлийн уламжлал Г
- эр бүлийн харилцааны шинж чанар
- Хүрээлэн буй хүмүүстэй харилцах чадвар Насанд хүрэгчдийн сурган хүмүүжүүлэх харилцааны түвшин, нөлөөлөл
- Гэр бүл, сургууль, олон нийтийн байгууллагын холбоо
- Хүмүүжүүлэх үүрэг нь дараах дэд үүргийг гүйцэтгэнэ.
- Эрэгтэй эмэгтэй хүмүүсийг нийгмийн амьдралд болон гэр бүлийн амьдралд тэгш татан оролцуулах
- Тэдний хувийн сахилгыг сайжруулах Гэрлэгсдэд сэтгэл санааны тайван байдлыг бий болгоно
- Хүмүүсийг хамтран амьдрах арга ухаанд сургаж харилцан бие биеэ халамжлах, хүмүүжүүлэх
- Хүн амын нөхөн өсөлтийг хангах
- Үр хүүхдээ нийгмийн үнэтэй гишүүн болгох
- Хүүхдийн оюун санаа нийгмийн чиг хандлага, зан үйлийн сэтгэлд идэвхтэй нөлөөлнө.

Оюуны санааны нэгдэлтэй байх үүрэг :

- Гэр бүлийн гишүүдийнхээ оюун санааны хөгжлийг дэмжиж эв нэгдэлтэй байж нэг нэгийнхээ өмнө ёс суртахууны хэм хэмжээг чанд баримталж байх шаардлагатай үүрэг юм.

Нэр хүндийн үүрэг :

- Нийгмийн социал бүтцийг нөхөхөд чухал ач холбогдолтой энэ нь гэр бүлийн гишүүдэд нэр хүнд, мэдлэг боловсрол, өв хөрөнгөө өвлүүлж нийгэмд эзлэх байр суурийг дээшлүүлэхэд нөлөөлдөг.

Чөлөөт цагаа зөв өнгөрөөх үүрэг :

- Чөлөөт цаг гэдэг нь ажлын биш цаг өөрөөр хэлбэл хүн өөрийгөө хөгжүүлэхэд чиглэгдсэн цаг юм. Энэ нь бие болон оюуны хүчээ нөхөн сэргээх хэрэгсэл болдог. Гэр бүлийн гишүүд чөлөөт цагаараа сурч боловсрох, авьяас чадвараа нээж хөгжүүлэх бололцоогоор хангаж үзэл бодлоо илэрхийлэх, хамтарч чөлөөт цагаа зөв зохистой өнгөрөөхийг дэмжих үүрэг юм. Чөлөөт цагийн үүргийг нэмэгдүүлэхэд дараах хүчин зүйлүүд нөлөөлнө.
- Гэр бүлийн амьдралын зөв дэглэм
- Гэр бүлийн гишүүдийн үүргийн зөв хуваарь
- Гэр бүлийн хөдөлмөр, амралтыг зөв төлөвлөх
- Гэр бүлийн гишүүд чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэхэд эхнэр, нөхөр аль аль нь анхааралтай хандах, ялангуяа эмэгтэйчүүд амралтын өдрүүдийг яавал гэр бүл хамтаараа хөгжилтэй сайхан өнгөрүүлэх вэ? гэдэгт санаачилгатай хандахыг гол болгох ёстой. Чөлөөт цаг нь дараах элементийг агуулна. Үүнд. Ном унших, радио сонсох, зурагт үзэх, төрөл садан найз нөхөдтэйгөө уулзах, номын сан, театрт очих, спортоор хичээллэх, уралдаан тэмцээнд оролцох, баяр тэмдэглэх, салхинд гарах гэх мэт.

Сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх үүрэг :

- Гэр бүлийн гишүүд зөвхөн идэж уух, өмсөж зүүх хэрэгцээгээ хангаад зогсохгүй, нэг нэгэндээ оюун санаа, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, сэтгэлийн

хөдөлгөөнийг тогтворжуулах, хувь хүний баяр баяслын хэрэгцээг гэр бүл хангаж байх ёстой үүрэг юм.

Гэр бүлийн харилцааны талаарх ойлголт :

- Гэр бүлийн харилцааны сэтгэл зүйн онцлог
- Монгол гэр бүл
- Өрнөдийн гэр бүл
- Гэр бүлийн хүрээнд асуудлыг шийдэх
- Уламжлалт ёс заншилдаа тулгуурладаг
- Босоо хэлбэрийн харилцаа түгээмэл
- Эрэгтэй эмэгтэй хүмүүст өөр байдлаар ханддаг
- Тус тусдаа хариуцлага хүлээдэг
- Хамтарч шийдвэр гаргадаг
- Ирээдүйд чиглэсэн хандлагатай
- Ажил ба гэр бүлийн хариуцлагыг уялдуулдаг
- Уламжлалт гэр бүл ба орчин үеийн гэр бүл дэх өөрчлөлт
- Уламжлалт гэр бүл
- Орчин үеийн гэр бүл дэх өөрчлөлт
- Монголын эрт, эдүгээгийн хөгжилд уламжлалт соёл иргэншил, нүүдлийн мал аж ахуй үлэмж нөлөө үзүүлсээр иржээ.
- Уламжлалт нийгэмд эрхэлж байсан мал аж ахуйн амьдралын хэв маяг, зан заншлаар нөхцөлдсөн ахуй байдал нь гэр бүлийн гишүүдийг байнга ойр дотно холбоо харилцаатай байлгадаг.
- Эцэг, эх нь үр хүүхдүүддээ үе уламжлуулан зааж сургах тогтолцоотой байсан бөгөөд үеүдийн хооронд тасралтгүй гүн бат холбоо, харилцаатай.
- Гэр бүлийн хүрээнд ураг төрлийн уламжлалт нандин харилцаа үйлчилдэг.
- Ханиа ураг төрөл, ёс заншлаас хамааран эцэг эхийн тохироогоор сонгодог.
- Уламжлалт гэр бүлийн өрхийн тэргүүн нь нөхөр байж, бүхий л асуудалд дагнан
- XX зуунаас үйлдвэрлэл, хотжилт хурдацтай хөгжиж, соёл, ёс суртахуун нэвтэрснээр гэр бүлийн уламжлалт харилцаанд өөрчлөлт орох болов.
- Нийгэм, эдийн засаг, соёлын өөрчлөлтийн явцад гэр бүлийн /эхнэр- нөхөр/ гишүүдийн үүргийн хуваарилалтад өөрчлөлт орж эхэлсэн.
- Өрнөдийн соёл нэвтэрснээр өнөө үед хүүхдүүдийн нийгэмшлийн үндсэн орчин нь гэр бүл байхын зэрэгцээ цэцэрлэг, сургууль, ажлын хамт олон болж, эцэг, эх нь өглөөнөөс орой болтол ажил албандаа гэр бүлээс хол өнгөрүүлдэг. Үр хүүхдэдээ зориулан зарцуулах, гэр бүлийнхэнтэйгээ хамт өнгөрүүлэх цаг бага болж байгаа.
- Гэр бүлийн дотоод харилцаа харьцангуй хөндийдүү, гишүүд нь бие даасан шинжтэй. Гэр бүлийн гишүүдийн эцэг, эх, үр хүүхэд, төрөл төрөгсдийнхөө өмнө хүлээх үүрэг, хариуцлага чухал байснаа аажмаар хувь хүний эрх, эрх чөлөө, амжилт бүтээл онцгой байрыг эзлэх болж байна. Өөрөөр хэлбэл гэр бүл төвт тогтолцооноос хувь хүн төвт тогтолцоо руу шилжсэн, ураг төрлийн харилцаа саармагжих хандлага бий болов.
- Залуу хосууд нэг нэгийгээ өөрсдөө чөлөөтэй сонгох систем рүү шилжсэн байна. Нөхөр, эхнэр хоёул зөвлөлдөж шийдвэр гаргах ардчилсан, тэгш эрхтэй зарчимд тулгуулах эхлэл шинэ нөхцөлд тавигдаж байна.

Монгол улсын төрөөс гэр бүлийн талаар баримтлах бодлого :

- 1.Гэр бүл нь хүний хөгжлийн анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж, соёл, уламжлал өвлөгдөн шинэчлэгдэх, аж төрөх ёсны бичил ахуй мөн.

- 2.Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогын эрхэм зорилго нь гэр бүлийн амьдралын түвшнийг тасралтгүй дээшлүүлж, гэр бүлийн харилцаа, ёс зүйн эрүүл орчин, түүний нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар монгол хүний хөгжлийг дэмжихэд оршино.
- 3.Гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих, гэр бүлийн хөгжил, үр хүүхдээ асран хамгаалахад эцэг, эхийн жигд оролцоог хангах, гэр бүлээрээ амьдрахад нь тусалж орон сууцтай болохыг дэмжих, гэр бүлийн өмчийн харилцаанд гишүүн бүрийг эрх тэгш оролцуулах, хүн амын эмзэг бүлгийн нийгмийн халамж, хамгааллын арга хэмжээг гэр бүлд төвлөрүүлэх, гэр бүлд зориулсан үйлчилгээний сүлжээг бий болгох, гэр бүлийн гишүүнийг хүчирхийлэх, эрхийг нь зөрчих явдлыг тууштай бууруулах эрх зүй, зан үйлийн эерэг орчин бүрдүүлэх, тодорхой мэргэжлийн хүмүүсийг гэр бүлийн асуудлаар мэргэшүүлж ажиллуулах нь энэхүү бодлогын үндсэн зорилт болно.

Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогын үндсэн зарчим:

- 1. Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого /цаашид "гэр бүлийн хөгжлийн бодлого" гэх/-ыг хэрэгжүүлэхэд дараах үндсэн зарчмыг баримтална:
- 1/гэр бүлийг хөрөнгө чинээ, алдар хүнд, үндэс, угсаа, амьдарч байгаа газар, нутаг, гишүүдийн арьс өнгө, эрхэлж буй албан тушаал, шашин шүтлэг, боловсролын түвшин зэргээс хамаарч ялгаварлан гадуурхагдах явдлаас ангид байлгах;
- 2/гэр бүлийн харилцаанд жендерийн болон гэр бүлийн гишүүдийн тэгш эрхийг хангаж, бие даасан байдлыг хүндэтгэх;
- 3/гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг дэмжиж, нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэх;
- 4/ гэр бүлийн аюулгүй байдал, амар амгалан амьдрах эрхийг хангах;
- 5/ гэр бүлийн хүрээнд үндэсний дэвшилтэт уламжлалыг дээдлэх;
- 6/боловсрол, эрүүл мэндийн зардлын өөрчлөлтийг өрхийн орлогын түвшинтэй уялдуулсан төрийн зохицуулалтын бодлого явуулах.

Гэр бүлийн хөгжлийн бодлогын үндсэн чиглэл:

- Гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлт, амьдралын хэв маягийн дэвшилтэт талыг судалж, сөрөг үр дагаврыг арилгах, эерэг үр дүнг дэмжин дэлгэрүүлэх зорилгоор гэр бүл судлалыг хөгжүүлэх;
- Гэр бүлийг бэхжүүлэх эрх зүй, эдийн засаг, дэвшилтэт уламжлал, зан заншлыг өвлүүлэх орчныг бүрдүүлэх;
- Гэр бүлийн харилцаанд жендерийн тэгш байдлыг хангаж, эцэг, эх, нөхөр, эхнэрийн нэр хүнд, гэр бүлийн бусад гишүүддээ хандах хандлага, боловсролыг дээшлүүлэх;
- Гэр бүлийн харилцааны эрх зүйн орчин боловсронгуй болгож, хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настны эсрэг хүчирхийллийг таслан зогсоох;
- Хөдөөгийн гэр бүлд орчин цагийн соёл, нийгмийн үйлчилгээг хүргэж, амьжиргааг дээшлүүлэх;
- Залуу гэр бүлийг дэмжих орчин бүрдүүлэх;
- Гэр бүлд нийгмийн цогц үйлчилгээг хүргэж, эрүүл аж төрөх ёс, боловсрол, эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа бие даан явуулдаг зан үйлийг хэвшүүлэхэд туслах, нийгмийн халамжийн үйлчилгээг ойртуулах;
- Амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой буюу орлогын эх үүсвэргүй гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

- Хүн амын эмзэг бүлэгт үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын арга хэмжээг гэр бүлд төвлөрүүлэх;
- Хүүхдийг эрүүл чийрэг өсгөн бойжуулах, боловсрол эзэмшүүлэх, амьдрал, хөдөлмөрт бэлтгэх гэр бүлийн таатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Гэр бүл судлалыг хөгжүүлэх тухайд:
- Монгол гэр бүл судлалыг хөгжүүлж, эрдэм шинжилгээний төслийн хүрээнд гэр бүлийн уламжлал, шинэчлэл, эрх зүй, социологи, боловсрол, аж ахуй эрхлэлт, сэтгэл зүй, ёс зүйн хөгжил, нийгмийн эрүүл мэнд, жендер зэрэг чиглэлээр судалгааг цогц байдлаар явуулж, үр дүнг төрийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх;
- Гэр бүл судлал, гэр бүлийн асуудлаар мэргэшсэн цагдаа, өмгөөлөгч, шүүгч, эдийн засагч, социологич, сэтгэл зүйч-багш, нийгмийн ажилтныг бэлтгэж ажиллуулах;
- Гэр бүлийн холбогдолтой бүхий л асуудлаар мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх;
- Гэр бүлийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, сонирхогч талуудтай хамтран ажиллах.
- 2. Гэр бүлийн ёс суртахуун, дэвшилтэт уламжлалыг дээдлэх тухайд
- Гэр бүлийн гишүүд нэр төрөө эрхэмлэх, үүрэг, хариуцлагаа ухамсарлах, нинжин сэтгэл, хүний мөс, хүнлэг чанар, шударга ёс зэрэг нийгмийн үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд төрийн бодлого чиглэх;
- Төрт ёсыг хүндэтгэж, эх хэл, үндэсний бичиг, соёл, төрөлх нутаг, байгаль орчноо хамгаалж, өрх гэрийн ёс, өв уламжлал, үнэт зүйлийг эрхэмлэдэг гэр бүлийг бий болгох, хөдөлмөрийг шүтэж амьдрах орчныг төлөвшүүлэхэд төрөөс бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Удмынхаа нэр төрийг дээдлэх, угийн бичгээ хөтлөх, ахмадаа хүндлэх, жирэмсэн эхийг энэрэх, үр хүүхдээ амьдрал, хөдөлмөрт бэлтгэх зэрэг өвөг дээдсийн сайн үлгэр дуурайллыг өвлүүлэх үйл ажиллагааг дэмжих;
- Гэр бүлийн дотоод зөрчил, сэтгэл зүйн хямралаас гарах, маргааныг эв эеэр шийдвэрлэхийг эрмэлзэхэд туслах зорилгоор гэр бүлийн боловсролыг бүх шатны албан ба албан бус сургалтаар олгох;
- Бүх нийтийн гэр бүлийн боловсролыг дээшлүүлэхийн тулд телевиз, радиогийн нэвтрүүлэг, нийтлэлийг төрийн ивээл дор тогтмол явуулах;
- Гэр бүл нь хүүхдэд үндэсний дэвшилтэт ёс заншил, уламжлалаа дээдлэх хандлагыг төлөвшүүлэх, төрөлхийн гоц авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх ээлтэй орчин байх нөхцөлийг хангах;
- Гэр бүл бүртгэх ашгийн бус ордон, танхимыг аймаг, дүүрэг, сумын төвүүдэд нээж, гэрлэх ёслолыг ёс суртахуун, соёл уламжлалын баяр, хүний амьдралын ариун нандин үйл явдал болгон тэмдэглэж байх орчныг бүрдүүлэх.
- 3. Гэр бүлийн харилцаанд жендерийн тэгш байдлыг хангана:
- Эрэгтэйчүүд боловсролын түвшингээр хоцрогдож байгаа хандлагыг өөрчилж,үүнээс үүдэн гэр бүлийн харилцаанд үзүүлж байгаа сөрөг нөлөөг бууруулах;
- Гэр бүлийн аж ахуйг хөтлөх, гишүүдийг асрах, сувилах, халамжлах, үйлчлэх зэрэг гэрийн хөдөлмөрийг нийгмийн зүгээс үнэлэх үнэлэмжийн таатай орчныг бүрдүүлэх;
- Залуучуудад гэр бүлийн боловсрол эзэмшүүлж, гэр бүл, үр хүүхэд, эцэг эхийн өмнө хүлээх хариуцлагыг ухамсарлуулах чиглэлээр нийгмийн болон сэтгэл зүйн үйлчилгээг хөгжүүлэх;

- Гэр бүл төвтэй нийгмийн эрүүл мэнд болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх замаар хүн амын өсөлт, чанарыг сайжруулахад дөхөм үзүүлэх.
- 4. Гэр бүлийн харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно:
- Гэр бүлийн гишүүдийн эрхийг зөрчих, дарамт шахалт үзүүлэх, хүчирхийлэх явдалтай тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар мэргэшсэн итгэмжлэгдсэн төлөөлөгч/омбудсмен/-ийг ажиллуулах;
- Гэр бүлийн маргааныг гэр бүлийн асуудлаар мэргэшсэн шүүгч шийдвэрлэдэг болох;
- Гэр бүлийн даатгалын эрх зүйн орчныг бүрдүүлж, тэтгэвэр, тэтгэмж болон эрүүл мэндийн даатгалд гэр бүлийн гишүүн бүрийг бүрэн хамруулах арга хэмжээг дэс дараатай авах.

Гэр бүлийг дэмжих бодлогын тухайд:

- Залуу гэр бүлийг орон сууцтай болохыг дэмжих хөнгөлөлттэй, урт хугацаатай зээлийн сан, түрээс/лизинг/-ийн үйлчилгээ, оюутны гэр бүлийн хүүхдэд зориулсан сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага хөгжүүлэх зэргээр залуу гэр бүлд нийгмийн таатай орчин бүрдүүлэх;
- Залуучуудын гэр бүлийн талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг судалж, уламжлал, шинэчлэлийн асуудлаар хэлэлцүүлэг, ярилцлага зохиох;
- Залуучууд, өсвөр үеийнхэнд бэлгийн амьдралын зохистой мэдлэг, соёл, зөв зан үйл төлөвшүүлэх;
- Залуучуудад бие дааж шийдвэр гаргах чадвар эзэмшүүлэх төсөл,шинээр гэр бүл бологсдод туслах зорилгоор гэргий болон өрхийн тэргүүнийг бэлтгэх сургалт зохион байгуулах ажлыг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

Гэр бүлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх тухайд:

- Улсын хэмжээнд гэр бүлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хүн ам зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна. Аймаг, нийслэлийн түвшинд хүн ам, гэр бүлийн асуудал хариуцсан хэлтэс, сум, дүүрэг, хороонд гэр бүлд туслах нийгмийн ажилтан ажиллуулна.

Гэр бүлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх механизмын тухайд:

- Гэр бүлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгана;
- Бодлогыг хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөгөөг хүн ам зүйн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан мөрдүүлнэ. Салбарын яамдын эрхлэх асуудалтай холбоотой бодлогыг тухайн яам хариуцахаар төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлийн мэдээ, тайланг хүн ам зүйн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлнэ;

Нэг. Дүгнэлт

Судалгааны ажлын хүрээнд гэр бүлийн үүрэг харилцаа болон хилийн цэргийн салбаруудын албаны үйл ажиллагааны харилцан хамаарлыг шинжлэн судлаад дараах дүгнэлтүүдэд хүрч байна:

Гэр бүл нь албаны чадавхын үндэс болох нь: Гэр бүл бол зөвхөн нийгмийн анхдагч нэгж төдийгүй, хилийн алба хаагчийн хувьд сэтгэл зүйн тогтвортой байдал, сонор сэрэмж, албандаа хандах хандлагыг тодорхойлогч "ар талын бат бэх тулгуур" юм. Гэр бүлийн дотоод уур амьсгал эерэг байх нь албаны бүтээмжийг шууд нэмэгдүүлдэг.

Гэр бүлийн олон талт үүргийн хэрэгжилт: Гэр бүлийн эдийн засаг, аж ахуй, нөхөн үржихүй болон хүмүүжүүлэх үүрэг нь хилийн цэргийн алба хаагчийн нийгмийн баталгаатай салшгүй холбоотой байна. Ялангуяа хилийн цэргийн салбарууд, алслагдсан нөхцөлд гэр бүлийн гишүүдийн бие биедээ үзүүлэх сэтгэл санааны дэмжлэг нь стрессийг даван туулах үндсэн хүчин зүйл болж байна.

Сөрөг нөлөөллийн шалтгаант холбоо: Хилийн цэргийн салбарын үйл ажиллагаанд нөлөөлж буй 8 төрлийн бэрхшээл (албан тушаал дэвших боломж, шударга бус шагнал урамшуулал, газар зүйн байршил г.м) нь гэр бүлийн тогтвортой байдалд шууд дарамт учруулдаг. Энэхүү дарамт нь эргээд алба хаагчийн ажлаас гарах сэдэл, ажил таслалт болон сэтгэл ханамжгүй байдлыг бий болгож байна.

Уламжлал ба шинэчлэлийн зөрчил: Монгол гэр бүлийн уламжлалт босоо харилцаанаас орчин үеийн тэгш эрхт, зөвлөлдөх харилцаанд шилжих шилжилт хилийн цэргийн алба хаагчдын дунд идэвхтэй явагдаж байгаа бөгөөд үүнд төрийн бодлого, нийгмийн өөрчлөлт хүчтэй нөлөөлж байна.

Хоёр. Санал, зөвлөмж

Судалгааны үр дүнг хэрэгжүүлэх, хилийн цэргийн салбарын албаны бэлэн байдлыг гэр бүлийн харилцаагаар дамжуулан бэхжүүлэх зорилгоор дараах саналыг дэвшүүлж байна:

1. Удирдлагын түвшинд:

Гэр бүлийн боловсролын хөтөлбөр: Хилийн анги, салбаруудын алба хаагчид болон тэдний гэр бүлд зориулсан "Гэр бүлийн харилцааны соёл", "Сэтгэл зүйн дархлаа" сэдэвт сургалтыг тогтмолжуулах.

Нийгмийн баталгааг бодитой дэмжих: Төрийн бодлогын хүрээнд хилчдийн ар гэрийн хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн сурч боловсрох нөхцөлийг сайжруулахад чиглэсэн салбар хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх.

Урамшууллын шударга тогтолцоо: Алба хаагчдын ажлын үр дүнг үнэлэхдээ гэр бүлийн нөхцөл байдал, алба хааж буй бүс нутгийн онцлогийг харгалзан үзэх уян хатан механизмыг нэвтрүүлэх.

2. Сургалтын байгууллагын түвшинд:

Сургалтын хөтөлбөрт тусгах: Дотоод хэргийн их сургуулийн сонсогчдод "Цэргийн гэр бүл судлал" хичээлийн агуулгыг гүнзгийрүүлэн зааж, ирээдүйн офицеруудыг гэр бүл болон албаны үүргийг тэнцвэржүүлэх чадварт сургах.

Судалгааг үргэлжлүүлэх: Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр хилийн цэргийн салбаруудад өвөрмөц нарийвчилсан судалгаануудыг хийж, бодлогын баримт бичигт тусгах.

3. Алба хаагчдын түвшинд:

Цагийн менежмент: Албаны ажлын ачааллыг гэр бүлдээ зориулах "алтан цаг"-тай уялдуулах, чөлөөт цагаа гэр бүлээрээ үр дүнтэй өнгөрүүлэх дадал хэвшлийг өөртөө төлөвшүүлэх.

Нээлттэй харилцаа: Гэр бүлийн дотоод асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, бие биедээ сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх уламжлалт болон орчин үеийн аргуудыг амьдралдаа хэрэгжүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖ

1. Гэрэлмаа, Д. (2013). Хүний нөөцийн бүрдүүлэлтийн бодлого, стратеги. УБ хот.

2. Цэцэгмаа, Г. (2014). Хүний нөөцийн менежмент. УБ хот.

3. Т.Ганцэцэг. (2010). Д.Лянхуа-Д, Стрессийг үүсгэх шалтгаан ба оношилгоо, тусламж (хуудсд. 15-17). Улаанбаатар: Мөнхийн үсэг Групп.

4. Намжил.Т, "Гэр бүлийн харилцааны тулгамдсан асуудал", 2012

5. Улсын Их Хурлын 2003 оны 16 дугаар тогтоолын хавсралт

6. Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар тогтоолын хавсралт

7. Т.Ганцэцэг. (2010). Д.Лянхуа-Д, Стрессийг үүсгэх шалтгаан ба оношилгоо, тусламж (хуудсд. 15-17). Улаанбаатар: Мөнхийн үсэг Групп.

8. Н.Наранчимэг, П.Увш. (2002). СӨБ-ын удирдах ажилтны гарын авлага.

9. Б.Насанбаяр. (2015). БШУЯ, 2015 тайлан. Retrieved from http://www.meds.gov.mn/:

10. Cropanzo. R., Howes, J., Grandey, A., (1997). The Relationship of organizational politics and support to work behaviors, attitudes, and Stress.Journal of Organizational behavior, 18, 159-180.

11. Ferris. R., Kacmar.K. (1992). Perceptions of Organizational Politics.Journal of Management, Vol.18, No.1, 93-116.

12. Gadot.E, Talmud.I.,(2010). Organizational Politics and Job Outcomes: The Moderating Effect of Trust and Social Support. Journal of Applied Social Psychology. 40.11pp, 2829-2861

ТӨВӨӨС ХЭТ АЛСЛАГДСАН БАЙДАЛ ХИЛИЙН ЦЭРГИЙН САЛБАРЫН АЛБА ХААГЧДЫН АЖЛААС ГАРАХ СЭДЭЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

А.ХҮРЭЛЦООЖ*

Дотоод хэргийн их сургуулийн хилийн албаны сургуулийн магистрант, Хилийн цэргийн 0168 дугаар ангийн 0109 дүгээр салбарын захирагч, ахмад.

**Хариуцлагатай зохиогч: altansukhkhureltsooj@gmail.com*

Хураангуй: Энэхүү судалгаа нь хилийн цэргийн салбарын алба хаагчдын ажлаас гарах сэдэлд төвөөс алслагдсан байдал хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох зорилготой. Судалгаанд 18–40 насны 100 алба хаагч хамрагдаж, баримт бичгийн, кэйс болон харьцуулсан аргыг ашиглан онол, гадаад туршлага, эмпирик үр дүнг нэгтгэн шинжилсэн. Үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх нь залуу насны офицер, ахлагч нар бөгөөд талаас илүү нь аймгийн төвөөс 200–400 км зайд байрлах заставт ажиллаж байна. Ажлаас гарах сэдэлд хамгийн их нөлөөлж буй хүчин зүйлс нь хүүхдийн боловсролын хүртээмж муу, төв рүү зорчиход хүндрэлтэй, хүнс болон өргөн хэрэглээний барааны хангамж сул, амьдрах орчин тохилог бус, хувь хүний соёл, хөгжлийн хэрэгцээ хангагдахгүй байгаа асуудлууд байв. Иймээс хилийн цэргийн салбарын алба хаагчдыг тогтвортой ажиллуулахын тулд боловсрол, дэд бүтэц, хангамж, амьдрах орчин, хөгжлийн боломжийг сайжруулах бодлого шаардлагатай гэж дүгнэв.

Түлхүүр үг: ажлаас гарах сэдэл, төвөөс алслагдсан байдал, хилийн цэргийн салбар, алба хаагч, тогтвортой ажиллах байдал.

Сэдвийн үндэслэл:

Өнөөгийн нөхцөлд алслагдсан бүс нутагт ажиллаж буй алба хаагчдын тогтвортой ажиллах асуудал нь хүний нөөцийн удирдлагын чухал асуудлын нэг болж байна. Ялангуяа хилийн цэргийн салбар дээр ажиллаж буй хүмүүс төв суурин газар, гэр бүл, нийгмийн үйлчилгээ, өдөр тутмын хэрэгцээт орчноос хэт алслагдсан нөхцөлд үүрэг гүйцэтгэдэг нь ажлаас гарах сэдэл үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй байна. Судалгааны бүтээлүүдэд ажлаас гарах сэдэл нь ажлаасаа гарах тухай бодол, гарах хүсэл, өөр ажил хайх хандлагаар илэрдэг бөгөөд түүнд ажлын сэтгэл ханамж, байгууллагын үнэнч байдал, ажлын орчин, хувь хүний онцлог зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг гэж үзсэн. Хил хамгаалах байгууллагын хувьд ажлын нөхцөл хүнд, алслагдсан хилийн цэргийн салбаруудаар томилогдож удаан хугацаагаар ажиллах зэрэг бусад олон хүчин зүйлсээс шалтгаалж ажлын байран дээр тогтмол, удаан ажиллах алба хаагчид хомсдож залуу ажиллах хүчнүүд ажлаас гарах тохиолдлууд ихээр нэмэгдэж байна. Залуу ажиллах хүчин ажлаасаа гарах нөхцөл нь тухайн хүний ажлын байран дээрх сэтгэл ханамж, ажлын байран дээрх нийцэл буюу хил хамгаалах байгууллага болон ажилтны зорилго хэр түвшинд нийцэж байгаагаас шалтгаалсан хүчин зүйлүүдээс хамааран ажлын байран дээрх тогтворгүй байдал болон ажлаас гарах сэдэл зэрэг хүчин зүйлүүд бий болж байна.

Судалгааны зорилго:

Хилийн цэргийн салбарын алба хаагчдын ажлаас гарах сэдэлд төвөөс хэт алслагдсан байдал хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго оршино.

Зорилт:

- Ажлаас гарах сэдлийн онолын ойлголт, нөлөөлөгч хүчин зүйлсийг судлах.

- Хилийн цэргийн салбарын алба хаагчдын төвөөс алслагдсан байдлын онцлогийг тодорхойлох.
- Алслагдсан байдал, ажлын сэтгэл ханамж, ажлаас гарах сэдлийн хамаарлыг судлах.
- Ажлын байрны тогтвортой байдлыг нэмэгдүүлэх санал боловсруулах.

Сэдвийн таамаглал:

Төвөөс хэт алслагдсан байдал өндөр байх тусам хилийн цэргийн салбарын алба хаагчдын ажлаас гарах сэдэл нэмэгдэнэ.

Судалгааны объект, судлах зүйл

Энэхүү судалгааны хүрээнд хилийн цэргийн салбарын ажилчид болон тэдний ажлаас гарах сэдэл нь алслагдсан байдлаас үүдэж буй талаар судлах болно.

Судлагдсан байдлын тойм:

Өнөө цагт ажлын байран дээр буй олон хүмүүс ажлын нөхцөл болон хувийн шалтгаанаас үүдэн ажлаас гарах тухай бодох нь ихэссэн бөгөөд аливаа сэтгэлд нийцээгүй шалтгааны улмаас эсвэл албан шахалтаар ажлаас гарах тохиолдлууд ихээр нэмэгдсэн.

Байгууллага ажилтан хоёрын нийцэл муу байвал ажилтан өөрөө тухайн ажлаас татгалзах эсвэл цааш ажиллахгүй байх магадлал ихэсдэг. Ажил горилогчид өөрийн үнэт зүйл ба байгууллагын үнэт зүйлс нийцэж байгаа эсэхийг харж, зөрүүтэй гэж үзвэл сонгон шалгаруулалтын явцад өөрсдөө гарах боломжтой гэж тайлбарласан. Энэ нь дараа нь ажлаас гарах эрсдэлийн суурь нөхцөл болдог. Тухайн ажилтан ажилдаа хэр нийцэж, тохирч байна гэдэг дээр үндэслэн цаашид ажлын байран дээр тогтвортой байх эсэх нь шийдэгддэг учраас энэ нь ажил горилогчоос шууд хамаарна гэж Morley 2007 онд судалгаа хийж Person organization fit онолоо дэвшүүлсэн (Morley M.J, 2007). Түүний үзсэнээр ажлаас гарах шууд нөхцөлд тухайн хүний ажлын байран дээрх нийцэл суларч ажлын сэтгэл ханамж буурч үүний улмаас ажлаас гарах нөхцөл бүрддэг хэмээн тайлбарласан. Тухайн хүн ажлын байран дээрээ тогтвортой ажиллахын тулд хүн байгууллагатай төстэй шинжтэй байх буюу тухайн хүний зорилго, алсын хараа байгууллагатай нийцэж байх, хүн байгууллагад дутагдаж буйг нөхөх буюу байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцэж байх, хүний хэрэгцээг байгууллага хангах буюу байгууллагын зүгээс тавьж буй шаардлагуудаас гадна тухайн байгууллага тухайн хүнийг ямар нөхцөлд ажиллуулж байгаа мөн тухайн нөхцөл байдал нь ажилтныхаа хэрэгцээ шаардлагыг хэр түвшинд хангаж байгаа болон хамгийн сүүлд хүний чадвар байгууллагын шаардлагад нийцэх буюу тухайн байгууллага хүнд нөхцөлд ажилтныг ажиллуулдаг бол ажилтан тэрхүү ажлын шаардлагатай сайтар танилцаж тухайн ажлын байранд тохиромжтой, нийцэлтэй байна уу гэдгээс шалтгаалан ажлын байрыг зөвшөөрч ажилд орохыг зөвшөөрөх гэсэн үндсэн 4 бүрэлдэхүүн нь энэхүү онолын гол суурь болдог (Piasentin, 2006). Тиймээс энэхүү онолоос үзвэл хил хамгаалах байгууллагын хувьд ажлын нөхцөл болон ачаалал энгийн албан байгууллагуудаас шалгуур өндөртэй, хүнд нөхцөлд ажилладаг учраас тухайн ажилтан хил хамгаалах байгууллагад ажилд орох шийдвэр гаргахаас өмнө өөрт тавигдах, өөрөөсөө асуух хамгийн чухал асуултууд буюу шийдвэр гаргалтын өмнөх түвшний хувьд эх оронч сэтгэлгээ хэр түвшинд байдаг, хил хамгаалах үнэт зүйлтэй өөрийн үнэт зүйлийн нийцэл хэр түвшинд, дасан зохицох чадварын түвшний хэмжээнээс хамааран тухайн ажилтан хил хамгаалах байгууллагад цаашид тогтвортой ажиллах, ажлын бүтээмж өндөр, ажилдаа амжилттай ажиллах нөхцөл бүрдэн ажлаас гарах түвшин, магадлал буурах юм.

Үүнтэй төстэйгөөр 2001 онд Job Embeddedness онолыг Mitchell, Holtom, Lee, Sablynski, and Erez нар мөн судалсан ба ажлаас гарахад алдах зүйл их байдаг ба хэрвээ тухайн ажилтан ажлын байран дээр хамт олонтойгоо, газар зүйн байрлалдаа болон бусад хүчин зүйлстэй нягт холбоо үүсгэж чадаагүй бол ажлаас гарах нөхцөл бүрддэг гэж тайлбарласан (Aliaga, 2013). Тухайн ажилтны эргэн тойрны орчин буюу цаг агаар, чөлөөт цагийн боломж буюу ажил болон хувийн амьдралын зааг, соёл, хамт ажиллагсад, орон нутгийн үйлчилгээний ойр байдал, аюулгүй байдал зэрэг ордог ба хувь хүний анхан шатны хэрэгцээ хангагдаж чадахгүй байгаа нөхцөлд тухайн хүн ажлаас гарах томоохон шалтгаан бүрддэг (Beni Halvorsen, Katrina Radford, Geoffrey Chapman, Brad Nikolic, 2021).

Ажлын нийцэл болон ажлын холбооноос гадна тухайн хүний ажлын байран дээрх сэтгэл ханамжтай байдал чухал нөлөөтэй бөгөөд ажлын сэтгэл ханамж болон ажилтныг ажилдаа үлдэх болон гарах шалтгааныг Herzberg-ийн хоёр хүчин зүйлийн онолоор тайлбарласан (Caffrey, 2024). Гол санаа нь ажлын орчинд нөлөөлөх хүчин зүйлсийг сэтгэл ханамж бий болгодог хүчин зүйлс ба сэтгэл дундуур байдал үүсгэж болдог боловч дангаараа жинхэнэ сэтгэл ханамж бий болгодоггүй хүчин зүйлс гэж хоёр ангилдаг явдал юм. Ажлын агуулгатай холбоотой хүчин зүйлсэд хүн ажлаа утгатай, сорилттой, амжилт гаргах боломжтой, хариуцлагатай, өсөж дэвших орчинтой гэж мэдэрвэл ажлын сэтгэл ханамж нэмэгдэнэ гэж үзжээ. Харин ажлын гадаад нөхцөлтэй холбоотой хүчин зүйлсэд ажлын хамт олон болон хамтын нөхөрлөл, ажлын нөхцөл, байгууллагын удирдлага болон дүрэм журам, ажлын байрны аюулгүй байдал болон цалин зэрэг ордог гэж бичсэн байна. Эдгээр нь муу байвал ажилтан сэтгэл дундуур болно, гэхдээ зөвхөн эдгээрийг сайжруулласан гэвэл заавал өндөр сэтгэл ханамж, хүчтэй дотоод сэдэл үүсэхгүй гэж тайлбарласан (Nickerson, 2025). Өөрөөр хэлбэл ажилтны сэтгэл ханамж гэдэг зүйл хувь хүний хүсэл зорилго болон тухайн байгууллагын хоорондын нийцлээс ихээхэн хамаарах юм.

Ажлаас гарах сэдэл нь ажилтан ажлаасаа гарах талаар бодох, ойрын хугацаанд гарах хүсэлтэй болох, өөр ажил хайх хандлагаар илэрдэг. Энэхүү сэдэлд ажлын сэтгэл ханамж, байгууллагын үнэнч байдал, ажлын орчин, хувь хүний онцлог зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг гэж үзсэн. Ялангуяа ажлын сэтгэл ханамж нь ажлын мөн чанар, цалин, удирдлага, хамт олон, дэвших боломжтой холбоотой бол байгууллагын үнэнч байдал нь ажилтны байгууллагад үлдэх хүсэл, оролцоо, сэтгэл зүйн холбоог илэрхийлдэг. Иймээс эдгээр хүчин зүйл сулрах үед ажлаас гарах сэдэл нэмэгдэх эрсдэлтэй байдаг (Faridah., Gustini., Salehan., & Efendi, R., 2022). Тиймээс хүнд нөхцөлд ажиллах нөхцөлтэй тохиолдолд тухайн ажлын нөхцөлийг хүлээн зөвшөөрч өөрийн үнэт зүйл болон байгууллагын тухайн нөхцөлд өгч буй нөхцөлүүдийг сайтар тунгааж шийдвэрээ гаргах нь тухайн ажилтны гол үүрэг юм.

Судалгааны арга:

Баримт бичгийн судалгааны арга

Кэйс судалгаа болон харьцуулсан судалгаа

Бүтээлийн тойм:

Монгол Улсын Хил хамгаалах байгууллага нь улсын хилийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, улс орны хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулж удирдах чиг үүрэг бүхий байгууллага юм. Монгол Улсын Хилийн тухай хуульд улсын хил хамгаалах байгууллага нь төрийн бодлогыг хэрэгжүүлэх, улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, улсын хилийн дэглэмийг сахиулах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зорчигч болон тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж заасан байна. Мөн

газар, усан дээрх улсын хилийг улсын хил хамгаалах байгууллага хамгаална гэж хуульчилжээ (Монгол Улсын хилийн тухай, 2016). Хил хамгаалах ерөнхий газар нь улсын хэмжээнд 36 салбар нэгжтэйгээр Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалан ажиллаж байна. Мөн байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хил хамгаалалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хил хамгаалалтын чадавхыг дээшлүүлэх, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг найдвартай хангахад чиглэж байгааг онцолсон байдаг (Хил Хамгаалах Ерөнхий Газар, 2022). Монгол Улсын нутаг дэвсгэрийн зах хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил /цаашид "улсын хил" гэх/ гэх (Монгол улсын хилийн тухай хууль, 2016) ба тухайн хилийн шугамын зааг дээр ажиллаж буй хилчид төвөөс хэт алслагдсан нөхцөлд ажиллаж амьдардаг. Үүний сацуу хил нэвтэрч буй олон төрлийн хүмүүстэй харилцах шаардлага тулгардаг ба үүнийг дагаад хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчмууд байдаг (ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ , 2013). Жишээ нь: хариуцлага хүлээх, хууль дээдлэх, үйл ажиллагаандаа шинийг эрэлхийлж байнга суралцаж байх зэрэг ордог.

Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын ажлаас гарах сэдлийг Job embeddedness (ажилтайгаа болон ажлын орчин, хамт олон, орон нутагтайгаа нягт холбогдсон байдал) онолын үүднээс авч үзвэл алба хаагчдын ажлаасаа гарах эсэх нь зөвхөн ажлын нөхцөлөөс бус, байгууллага, хамт олон, оршин буй орчинтойгоо тогтоосон холбоо, тухайн орчинд зохицсон байдал, ажлаасаа гарахад алдах зүйлстэй нягт холбоотой юм. Job embeddedness онол нь ажилтан яагаад байгууллагадаа үлддэг, эсвэл яагаад ажлаасаа гарах бодол төрдгийг байгууллага доторх болон ажлаас гадуурх хүчин зүйлсийн нийлбэрээр тайлбарладгаараа онцлог юм. Хил хамгаалах байгууллагын хувьд алба хаагчид төвөөс хэт алслагдсан нөхцөлд ажиллаж, амьдардаг тул байгууллагатайгаа тогтоосон холбоо, тухайн орчинд зохицсон байдал, ажлаасаа гарахад алдах зүйлс нь тэдний ажлаас гарах сэдэлд нөлөөлөх магадлалтай (Aliaga, 2013). Тиймээс энэхүү судалгаанд job embeddedness онолыг ашиглан хилийн цэргийн салбарын алба хаагчдын ажлаас гарах сэдэлд төвөөс алслагдсан байдлын үзүүлэх нөлөөг авч үзэх нь зүйтэй юм. Энэхүү судалгаанд авч үзэж буй төвөөс хэт алслагдсан байдал нь job embeddedness онолын community fit, community links, community sacrifice гэсэн бүрэлдэхүүнтэй уялдан тайлбарлагдана (Faridah., Gustini., Salehan., & Efendi, R., 2022). Учир нь алслагдсан нөхцөлд ажиллах нь алба хаагчийн гэр бүл, нийгмийн харилцаа, өдөр тутмын үйлчилгээний хүртээмж, амьдрах орчиндоо зохицох байдалд нөлөөлөхөөс гадна тухайн орчноос шалтгаалсан сэтгэлзүйн ачааллыг нэмэгдүүлж болзошгүй. Ийнхүү ажиллаж буй орчинтойгоо зохицох байдал сулрах, нийгмийн холбоо хязгаарлагдах, ажлаас гадуурх дэмжлэг багасах нь ажлаас гарах тухай бодол, өөр ажил эрэлхийлэх хандлага буюу ажлаас гарах сэдэлд нөлөөлөх нөхцөл болж болно.

Үүнээс дүгнэвэл Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газар нь улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, хилийн аюулгүй байдал, дэглэм, шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг төрийн тусгай чиг үүргийн байгууллага бөгөөд хилчид хилийн шугамын дагуу төвөөс хэт алслагдсан нөхцөлд ажиллаж, амьдардаг. Ийм орчин нь алба хаагчдын ажлын орчин, хамт олон, орон нутагтайгаа тогтоох холбоо, тухайн орчинд зохицох байдал, ажлаасаа гарахад алдах зүйлсэд нөлөөлөх замаар ажлын нягт байдал сулрах нөхцөл байдалд хүргэж байна. Тиймээс хилийн цэргийн салбарын алба хаагчдын ажлаас гарах сэдлийг тайлбарлахад төвөөс алслагдсан байдал

нь нийгмийн холбоо, дэмжлэг, үйлчилгээний хүртээмж, сэтгэлзүйн ачаалалтай уялдсан чухал хүчин зүйл гэж үзэх үндэслэлтэй юм.

Алслагдсан байдал ажлаас гарахад нөлөөлж буй талаар улс орнуудын жишээн дээр авч үзэх нь:

Алслагдсан байдлыг судлахын тулд энэхүү жишээг газар нутгийн хэмжээ том 3 улсаар авсан болно.

Энэтхэгийн парламентын тайланд Assam Rifles[45]-ийн алба хаагчдын ажлын нөхцөлд алслагдсан байдал ноцтой нөлөө үзүүлж буйг тэмдэглэсэн байна. Тус тайланд Энэтхэг–Мьянмарын хил дагуух бүсийг уулархаг, бартаат, хөгжөөгүй, зам харилцаа муу, ой шугуй ихтэй гэж тодорхойлсон бөгөөд ийм орчинд алба хаагчид өдөр бүр явганаар урт зай туулж үүрэг гүйцэтгэдэг, гэр бүлээсээ тусгаарлагдах, хүүхдийн боловсрол, эмнэлэг, сууц, хангамжийн асуудалтай тулгардаг гэж дурджээ. Ялангуяа voluntary retirement буюу сайн дураараа тэтгэвэрт гарах/ажлаас гарах өсөлтийг өндөр стресс, ачаалал, гэр бүлээс тусгаарлалт, хувийн амьдралын хүндрэлтэй холбон тайлбарласан нь алслагдсан байдал ажлаас гарах нөхцөл үүсгэх томоохон хүчин зүйл болдог гэдгийг тайлбарлажээ (Working conditions in Border Guarding Forces, 2018). Энэхүү нөхцөл байдал нь цаашид байгууллагын хүний нөөц болон ажиллах хүчинд ихээхэн сөргөөр нөлөөлөх тул энэ байдлыг бууруулахын тулд авсан арга хэмжээ нь ихээхэн сонирхолтой. Одоогийн нөхцөл байдалд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд гэвэл алба хаагчдын амралтын хугацааг сунгах, ус цэвэршүүлэгч болон усан хангамжийн системийг сайжруулах, хүнсний нөөцийн чанарын түвшинг сайжруулах зэрэг амьдрах орчныг сайжруулах тал дээр ихээхэн арга хэмжээ авч байна. Харин цаашид авч хэрэгжүүлэх ажлыг дурдвал алслагдсан газрууд руу бүх улирлын зам барьж зорчиход төвөггүй болгох, албан тушаал нэмэгдэх хугацааг урагшлуулж, цол ахих боломжийг нэмэгдүүлсэн. Эдгээр арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр ажлын нөхцөл болон түүнд дасан зохицох нөхцөл бүрдэж ажлаас гарах сэдэл буурах юм.

АНУ-ын Government Accountability Office[46]-ийн тайланд U.S. Customs and Border Protection[47] байгууллагын хувьд алслагдсан байршил нь ажилтан татах болон тогтоон барихад сөргөөр нөлөөлж буйг дурдсан. Тухайлбал, зарим алслагдсан газруудад эмнэлэг, сургууль, орон сууц, гэр бүлийн гишүүдийн ажил эрхлэлтийн боломж зэрэг суурь үйлчилгээ дутмаг байгаагаас шалтгаалан ажлаас гаралт өндөр байгаа бөгөөд Presidio, Sanderson зэрэг газруудад ажилтныг тогтоон барихад хүндрэлтэй байсан гэжээ. Мөн ажлаас гарсан ажилтнуудын ажлаас гарах санал асуулгад газарзүйн байршил, гэр бүлдээ ойр байх хүсэл, аж амьдарлын тэнцвэрийн асуудал хамгийн түгээмэл шалтгаануудын нэгээр дурдагдсан нь алслагдсан байдал ажлаас гарах сэдэлд нөлөөлж болохыг харуулж байна (Customs and Border Protection: Efforts to improve recruitment, hiring, and retention of law enforcement personnel (GAO-24-107029), 2024).

Австралийн хил хамгаалах газрын албан ёсны мэдээллээс үзэхэд тус байгууллага нь 37,000 км орчим урт эрэг бүхий, ихээхэн хэсэг нь алслагдсан бүсэд хамаарах хил хамгаалалтын орчинд ажилладаг. Иймээс алслагдсан байршил нь тус байгууллагын ажлын орчны бодит сорилт болж байна. Мөн ABF-ийн албан ёсны илтгэлд далайн эрэг дагуу ажиллагсад удаан хугацаагаар хайртай хүмүүсээсээ хол

[45] Энэтхэгийн хил хамгаалах дотоод аюулгүй байдлын хүчин

[46] АНУ-ын Конгрессийн хараат бус хяналтын байгууллага

[47] АНУ-ын хил, гаалийн хяналтыг хариуцдаг хамгийн том хууль сахиулах байгууллагууд


байдаг нь ажилтан татан авах ба тогтоон барихад сорилт болдог гэж дурдсан нь алслагдсан, тусгаарлагдсан ажлын орчин ажилтны тогтвортой байдалд нөлөөлж болохыг харуулж байна (Australian Border Force Maritime strategy perspectives, 2024).

Энэтхэг, АНУ, Австралийн туршлагыг харьцуулан үзэхэд алслагдсан байдал нь хил хамгаалах байгууллагуудад ажилтан татан авах, тогтоон барих, цаашлаад ажлаас гарах сэдэлд нөлөөлөх нийтлэг хүчин зүйл болж байна. Энэтхэгийн жишээнд алслагдсан, бартаатай, дэд бүтэц сул бүсэд ажиллах нь өндөр стресс, гэр бүлээс тусгаарлалт, хүүхдийн боловсрол болон хувийн амьдралын хүндрэлтэй хавсарч сайн дурааараа ажлаас гарах шалтгаан нэмэгдэхэд хүргэж байгааг дурдсан бол АНУ-ын хувьд алслагдсан байршил дахь эмнэлэг, сургууль, орон сууц, гэр бүлийн гишүүдийн ажил эрхлэлтийн боломжийн хомсдол нь ажилтан татан авах болон тогтоон барихад саад болж буйг тэмдэглэсэн байна. Харин Австралийн хувьд алслагдсан бүс нутагт урт хугацаанд гэр бүлээсээ хол ажиллах нөхцөл нь мөн ажилтны тогтвортой байдалд саад учруулж байна. Иймээс эдгээр улсын туршлагаас дүгнэхэд алслагдсан байдал нь зөвхөн газарзүйн шинж төдий бус, алслагдсан байдлаас шалтгаалан үүсэж буй гэр бүлээс тусгаарлагдах, нийгмийн холбоо суларч, үйлчилгээний хүртээмж буурах, ажлын болон сэтгэлзүйн ачаалал нэмэгдэх зэргээр дамжин ажлаас гарах сэдэлд нөлөөлдөг цогц хүчин зүйл гэж үзэх үндэслэлтэй байна. Энэ нь хилийн цэргийн салбар дээр ажиллаж буй алба хаагчдын хувьд төвөөс хэт алслагдсан байдал нь ажлын орчин, амьдралын нөхцөл, ажилдаа үлдэх эсэх шийдвэртэй шууд холбоотой болохыг харуулж байгаа бөгөөд ийм нөхцөлд ажилтны тогтвортой байдлыг хангахын тулд дэд бүтэц, урамшуулал, гэр бүлд чиглэсэн дэмжлэг, ажлын нөхцөлийг сайжруулах бодлого чухал болохыг илтгэнэ.

Судалгааны хэсэг:


Гадаад улс орнуудын судалгаанд тулгамдаж буй асуудлуудыг үндэслэн хилийн цэргийн салбарт ажиллаж буй 100 алба хаагчаас 10 асуулгатай судалгаа авсан. Энэхүү судалгааны зорилго нь алслагдсан байдлаас шалтгаалан ямар хүчин зүйлс үүсэж тэдгээр нь ажилтныг ажлаас гарах нөхцөл болж байгааг болон ямар шалтгаанууд хамгийн түгээмэл байгааг судалсан. Үүнд:

График №1: Насны ангилал



Энэхүү судалгаанд хилийн цэргийн салбарын 18-40 насны нийт 100 алба хаагчид оролцсон. Үүнээс 18-35 насны хүмүүс 78 буюу 77.2%-ийг эзэлж байгаа нь хилийн цэргийн салбар дээр ажиллаж буй албан хаагчдын дийлэнх хувь нь залуу хүмүүс байгааг харж болно. Харин 35-с дээш насны 23 хүн буюу 22.7% байгаа нь идэр насны хүмүүс бага ажиллаж байгааг харуулах ба үүнээс хилийн цэргийн салбар нь залуу ажиллах хүчин ихтэй байгааг харуулж байна.

График №2: Судалгаанд оролцогчдын цолны ангиллын байдал



Нийт судалгаанд оролцогчдын 35 хүн буюу 35% нь Офицер, 54 хүн буюу 53% нь Ахлагч цолтой, үлдсэн 11 хүн буюу 12% нь ТҮА байна. Үүнээс үзэхэд хилийн цэргийн салбарын 80-с дээш хувийг цэргийн алба хаагчид эзэлж байна.

График №3: Судалгаанд оролцогчдын ажиллаж буй салбарын аймгийн төвөөс алслагдсан байдал



Судалгаанд оролцсон 100 албан хаагчаас 56 албан хаагч буюу 55% нь аймгийн төвөөс 200-400 км-т байрлах застават ажиллаж байна. Үүнээс үзэхэд хилийн цэргийн салбар нь хэт алслагдсан байдалтай байна.

Хүснэгт №1: Тулгамдаж буй асуудлууд

№	Асуултууд	Байнга	Ихэвчлэн	Заримдаа	Үгүй	Огт үгүй
1	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг тухай бүрд авч чадахгүй байгаа явдал нь ажлаас гарах нөхцөлийг бүрдүүлдэг үү?	8 хүн 7.9%	13 хүн 12.9%	48 хүн 47.5%	26 хүн 25.7%	6 хүн 5.9%
2	Таны хүүхдийн чанартай боловсрол эзэмшихэд төвөөс алслагдсан байдал нөлөөлж байна уу?	35 хүн 35.7%	19 хүн 18.8%	17 хүн 16.8%	22 хүн 21.8%	8 хүн 7.9%
3	Хүнс болон өргөн хэрэглээний бараанд сонголттой болон шууд авч чадахгүй байгаа байдал танд тулгардаг уу?	23 хүн 22.8%	28 хүн 27.7%	24 хүн 23.8%	22 хүн 21.8%	4 хүн 4%
4	Салбарын байрлалаас төв, орон нутаг руу хөдөлгөөн үйлдэхэд замын нөхцөл, алслагдсан	32 хүн 31.7%	26 хүн 25.7%	27 хүн 26.7%	15 хүн 14.9%	1 хүн 1%

	байдал нь танд хүндрэлтэй байдаг уу?					
5	Гэр бүлийн хүмүүсээсээ хол байх нь таныг ажлаас гарахад нөлөөлдөг үү?	16 хүн 15.8%	15 хүн 14.9%	38 хүн 37.6%	29 хүн 28.7%	3 хүн 3%
6	Таны гэр бүлийн гишүүн өөрийн хүссэн ажлаа хийхгүй байх нь таныг ажлаас гарахад нөлөөлдөг үү?	13 хүн 12.9%	14 хүн 13.9%	36 хүн 35.6%	34 хүн 33.7%	4 хүн 4%
7	Соёл, хөгжлийн хэрэгцээг тогтмол авч чадахгүй байгаа нь таныг ажлаас гарахад нөлөөлдөг үү? (аялал зугаалга, урлаг соёл, өөрийгөө хөгжүүлэх олон талт хэрэгцээнүүд гэх мэт)	18 хүн 17.8%	15 хүн 15.9%	32 хүн 31.7%	35 хүн 34.7%	1 хүн 1%
8	Барилга, байшин дэд бүтэц муу байгаа нь танд хүндрэлтэй байдаг уу? (тог цахилгаан, ус, албаны байр гэх мэт)	25 хүн 24.8%	16 хүн 15.8%	27 хүн 26.7%	25 хүн 24.8%	8 хүн 7.9%
9	Алслагдсан байдалд ажиллах нь ажлын сэтгэл ханамжийг бууруулж байна уу?	11 хүн 10.9%	22 хүн 21.8%	33 хүн 32.7%	28 хүн 27.7%	7 хүн 6.9%

Судалгааны дүгнэлт:

Хамгийн их үзүүлэлттэй хүчин зүйлс:

1.Хүүхдэд чанартай боловсрол эзэмшүүлэхэд нөлөөлөх бүх талын хүчин зүйлс (хүүхэдтэйгээ цуг байх боломжгүй, боловсролын хүртээмж бага гэх мэт) дутмаг. Алба хаагчид хүүхдээ төв газарт чанартай боловсрол эзэмшүүлэх, өөрсдөө цуг байж сургах боломж бага учраас ажлаас гарах сэдлийг нэмэгдүүлж байна.

2.Салбарын байрлалаас төв, орон нутаг руу хөдөлгөөн үйлдэхэд замын нөхцөл муу, алслагдсан байдал нь сумын төв болон аймгийн төв рүү яаралтай үед болон бусад тохиолдолд шууд зорчиход хүндрэлтэй байдал үүсгэдэг.

3.Хүнс болон өргөн хэрэглээний барааг хэрэгцээтэй үед шууд авах боломжгүй, алслагдсан бүсэд бараа бүтээгдэхүүний үнэ өндөр байдал нь хувь хүний анхан шатны хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаа учраас тухайн алслагдсан орчинд тогтвортой суурьшин ажиллах нь хомс байна.

4. Амьдрах орчин нь тохилог бус байдал нь алслагдсан орчинд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бууруулж байна.

5. Хувь хүн өөрийгөө хөгжүүлэх боломжууд хомс байх нь тухайн хүн нийгмийн орчинд өсөн дэвжих, нийгмийн хөгжлөөс хоцрохгүй байх зэрэг хүсэл нь тодорхой хэмжээнд хангагдаж чадахгүй байгаа учраас алслагдсан газарт тогтвортой ажиллах байдлыг хомсдуулж байна.

Бага үзүүлэлттэй хүчин зүйлс:

1.Гэр бүлийн гишүүдээсээ хол байгаа байдал

2.Гэр бүлийн гишүүн өөрийн хүссэн мэргэжлээрээ ажиллахгүй байгаа байдал

3.Алслагдсан байдал нь ажлын байрны сэтгэл ханамжтай байдалд нөлөөлөх нь бага.

4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг тухай бүрд авч чадахгүй байгаа явдал.

Судалгаанд оролцогчдын 78% нь 18-35 насны залуу хүмүүс байгаа учраас гэр бүлийн гишүүдтэйгээ ойр байх, гэр бүлийн нөхцөл байдлаас үүдэх асуудлууд, эрүүл мэндийн үйлчилгээ авах шаардлага бага үзүүлэлттэй гарч байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар хилийн цэргийн салбарын алба хаагчдын ажлаас гарах сэдэлд төвөөс хэт алслагдсан байдал хэрхэн нөлөөлж байгааг онолын болон эмпирик түвшинд авч үзлээ. Судалгааны онолын үндэслэлд ажилтан ба байгууллагын нийцэл, ажлаас гарахгүй байх нөхцөл, Herzberg-ийн хоёр хүчин зүйлийн онол, түүнчлэн ажлаас гарах хандлагын талаарх судалгаануудыг ашигласнаар ажлаас гарах сэдэл нь зөвхөн хувь хүний сонголт бус, харин ажлын орчин, байгууллагын нийцэл, амьдралын нөхцөл, нийгмийн холбоо, сэтгэл ханамж зэрэг олон хүчин зүйлийн нийлбэр үр дагавар болох нь харагдсан. Ялангуяа job embeddedness онол нь хилийн цэргийн салбарын алба хаагчдын нөхцөл байдалтай хамгийн нийцэж байсан бөгөөд төвөөс хэт алслагдсан орчин нь ажилтны ажлын болон амьдралын орчинд зохицох байдал, нийгмийн харилцаа, ажилдаа үлдэх эсэх шийдвэрт хүчтэй нөлөөлөх боломжтойг тайлбарлаж байна.

Судалгааны үр дүнгээс харахад хилийн цэргийн салбарын хүний нөөцийн дийлэнх хэсгийг залуу насны офицер, ахлагч нар бүрдүүлж байгаа бөгөөд оролцогчдын талаас илүү хувь нь аймгийн төвөөс 200–400 км-ийн зайд байрлах салбарт ажиллаж байна. Энэ нь хилийн цэргийн салбарын алслагдсан байдал бодитой бөгөөд өдөр тутмын амьдрал, ажиллах нөхцөлд шууд нөлөөлж буйг харуулж байна. Тулгамдаж буй асуудлуудаас ажлаас гарах сэдэлд хамгийн их нөлөөлж буй хүчин зүйлс нь хүүхдэд чанартай боловсрол эзэмшүүлэх боломж хомс, төв суурин газар руу зорчиход зам тээврийн хүндрэлтэй, хүнс болон өргөн хэрэглээний барааны хүртээмж муу, амьдрах орчин тохилог бус, мөн хувь хүний соёл, хөгжлийн хэрэгцээ хангагдахгүй байгаа явдал байв. Өөрөөр хэлбэл алба хаагчдын ажлаас гарах сэдлийг гэр бүлээс хол байх гэхээсээ илүү амьдралын чанар, үйлчилгээний хүртээмж, хөгжлийн боломж, өдөр тутмын суурь хэрэгцээ хангагдахгүй байдал илүү хүчтэй өдөөж байна. Энэ нь залуу алба хаагчдын хувьд гэр бүл, эрүүл мэндийн асуудлаас илүүтэй ирээдүйн хөгжил, хүүхдийн боловсрол, амьдрах орчин, нийгмийн боломжийг илүү чухалчилж байгаатай холбоотой гэж үзэж болно.

Мөн гадаадын улс орнуудын туршлагаас Энэтхэг, АНУ, Австралийн хил хамгаалах байгууллагуудад алслагдсан байдал нь ажилтан татан авах, тогтоон барих, улмаар ажлаас гарах сэдэлд нөлөөлдөг нийтлэг хүчин зүйл болох нь ажиглагдсан. Энэ нь Монголын хилийн цэргийн салбарын нөхцөлтэй ижил төстэй бөгөөд алслагдсан байдал нь зөвхөн газарзүйн хол зай бус түүнээс үүдсэн асуудлууд буюу үйлчилгээний хүртээмж, гэр бүлээс тусгаарлалт, дэд бүтэц, амьдралын чанар, сэтгэлзүйн ачаалалтай холбоотой цогц асуудал гэдгийг харуулж байна. Иймээс энэхүү судалгааны таамаглал болох “төвөөс хэт алслагдсан байдал өндөр байх тусам хилийн цэргийн салбарын алба хаагчдын ажлаас гарах сэдэл нэмэгдэнэ” гэсэн санаа үндэслэлтэй гэж дүгнэж болно. Цаашид хилийн цэргийн салбарын алба хаагчдыг тогтвортой ажиллуулахын тулд боловсролын хүртээмж, зам тээвэр, бараа бүтээгдэхүүний хангамж, албаны байр, дэд бүтэц, хувь хүний хөгжлийн боломжийг сайжруулах, мөн алслагдсан салбарт ажиллаж буй алба хаагчдад чиглэсэн урамшуулал, дэмжлэгийн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ийм арга хэмжээ нь хүний нөөцийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхээс гадна хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө, байгууллагад үлдэх сэдлийг бэхжүүлэх ач холбогдолтой юм.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнгээс үзэхэд хилийн цэргийн салбарын алба хаагчдын ажлаас гарах сэдлийг бууруулахын тулд юуны өмнө амьдралын чанарт шууд нөлөөлж буй асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна. Ялангуяа хүүхдийн чанартай боловсрол эзэмших боломж хомс, төв суурин газар руу зорчиход зам тээврийн хүндрэлтэй байдал, хүнс болон өргөн хэрэглээний барааны хүртээмж муу, амьдрах орчин тохилог бус, мөн хувь хүний өөрийгөө хөгжүүлэх боломж хязгаарлагдмал байгаа нь алба хаагчдын тогтвортой ажиллах хүсэлд хамгийн ихээр нөлөөлж байна. Иймээс хилийн цэргийн салбарын хүний нөөцийн бодлогыг зөвхөн сахилга, томилгоо, үүрэг гүйцэтгэлд төвлөрүүлэх бус, алба хаагчийн ажиллах ба амьдрах орчныг бүхэлд нь авч үзсэн хэлбэрээр хэрэгжүүлэх нь зүйтэй.

Юуны өмнө хилийн цэргийн салбарт ажиллаж буй алба хаагчдын хүүхдийн боловсролын асуудалд онцгой анхаарах шаардлагатай. Судалгаанд энэ хүчин зүйл хамгийн өндөр нөлөөтэй гарсан тул аймаг, сумын төвийн сургуультай уялдсан тусгай зохицуулалт, дотуур байр, цахим сургалтын дэмжлэг, хүүхдээ дагуулан суралцуулах боломж, эсвэл гэр бүлийн боловсролын хэрэгцээнд чиглэсэн нэмэлт хөнгөлөлтийн бодлого боловсруулах нь зүйтэй. Мөн заставын байршлаас төв, орон нутаг руу зорчих хөдөлгөөнийг хөнгөвчлөхийн тулд зам, тээврийн хүртээмжийг сайжруулах**,** яаралтай үед ашиглах тээврийн тогтмол зохицуулалт бий болгох хэрэгтэй. Ингэснээр алба хаагчдын өдөр тутмын амьдралын дарамт буурч, ажилдаа үлдэх сэдэл нэмэгдэнэ.

Түүнчлэн алслагдсан салбаруудад хүнс, өргөн хэрэглээний барааны тогтвортой хангамжийн тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна. Хэрэгцээтэй зүйлээ цаг тухайд нь авч чадахгүй байх нь зөвхөн ахуйн хүндрэл бус, тухайн орчинд удаан хугацаанд ажиллах хүсэл буурах шалтгаан болж байна. Үүнтэй зэрэгцэн албаны байр, ус, дулаан, цахилгаан, холбоо, ариун цэврийн нөхцөл зэрэг амьдрах орчны дэд бүтцийг сайжруулах нь нэн чухал юм. Судалгаанд амьдрах орчны тохилог бус байдал тогтвортой ажиллах нөхцөлийг бууруулж байгаа нь тодорхой харагдсан тул энэ чиглэлд үе шаттай хөрөнгө оруулалт хийх шаардлагатай.

Мөн хилийн цэргийн салбарын алба хаагчдад өөрийгөө хөгжүүлэх болон өсөн дэвших боломжийг нэмэгдүүлэх нь зүйтэй. Үүнд мэргэжил дээшлүүлэх сургалт, цахим сургалтын хөтөлбөр, богино хугацааны ротаци, карьерын илүү тодорхой төлөвлөлт, соёл хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдах боломж багтана. Ялангуяа судалгаанд оролцогчдын дийлэнх нь залуу насныхан байсан учраас тэдний хувьд хөгжлийн боломж, ирээдүйн баталгаа, амьдралын чанар илүү чухал байгааг анхаарах хэрэгтэй. Иймээс хилийн цэргийн салбарын алба хаагчдын ажлаас гарах сэдлийг бууруулахын тулд боловсрол, зам тээвэр, хангамж, амьдрах орчин, хөгжлийн боломжийг сайжруулсан цогц дэмжлэгийн бодлого хэрэгжүүлэх нь хамгийн оновчтой шийдэл болно.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Aliaga, O. A. (2013). Job Embeddedness Theory: Can It Help Explain Employee Retention Among Extension Agents? *Journal of Extension* .

Beni Halvorsen, Katrina Radford, Geoffrey Chapman, Brad Nikolic. (2021). *Essentials of Job Attitudes and Other Workplace Psychological Constructs*. Taylor and Francis group . https://doi.org/10.4324/9780429325755-10

Caffrey, C. (2024). *Two-factor theory (job satisfaction)*. EBSCO Research Starters. https://www.ebsco.com/research-starters/economics/two-factor-theory-job-satisfaction

Faridah., Gustini., Salehan., & Efendi, R. (2022). The turnover intention influenced by job satisfaction and organizational commitment. *International Journal of Social Science Research and Review,*, 334–340.

Force, A. B. (2024). *Australian Border Force Maritime strategy perspectives*. Australian Border Force . https://www.abf.gov.au/about-us/what-we-do/key-statistics

Morley M.J. (2007). Person-organization fit. *Journal of Managerial Psychology*, 22(2), 109–117.

Nickerson, C. (2025). *Herzberg's Two-Factor Theory Of Motivation-Hygiene*. Simple psychology . https://www.simplypsychology.org/herzbergs-two-factor-theory.html

P. O. (2018). *Working conditions in Border Guarding Forces.* India : PARLIAMENT OF INDIA .

Piasentin, K. A. (2006). Subjective person-organization fit: Bridging the gap between conceptualization and measurement. *Journal of Vocational Behavior*, 69(2), 202–221.

U. G. (2024). *Customs and Border Protection: Efforts to improve recruitment, hiring, and retention of law enforcement personnel (GAO-24-107029)*. U.S. Government Accountability Office.U.S.. https://www.gao.gov/products/gao-24-107029

Газар, М. У. (2013). *ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ* . Монгол Улсын Засгийн Газар . https://mongolia.gov.mn/news/view/1595


Хил Хамгаалах Ерөнхий Газар. (2022). *Танилцуулга* . Хил хамгаалах ерөнхий газар . https://bpo.opengov.mn/introduction?utm_source=chatgpt.com

Хурал, М. У. (2016). *Монгол Улсын хилийн тухай*. Legalinfo.mn. https://legalinfo.mn/mn/edtl/16532054430731?utm_source=chatgpt.com


хууль, М. у. (2016). *Монгол улсын хилийн тухай хууль*. Legalinfo. https://legalinfo.mn/mn/detail/12418

ХАВСРАЛТУУД


Таны нас
101 хариулт



Таны албан тушаал
101 хариулт




Таны ажиллаж буй салбар хамгийн ойр аймгийн төвөөс хэдэн километрт байдаг вэ?
101 хариулт




Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг тухай бүрт авч чадахгүй байгаа явдал нь ажлаас гарах нөхцлийг бүрдүүлдэг үү?

101 хариулт




Таны хүүхдийн чанартай боловсрол эзэмшихэд төвөөс алслагдсан байдал нөлөөлж байна уу ?

101 хариулт




Хүнс болон өргөн хэрэглээний барааг сонголттой болон шууд авч чадахгүй байгаа байдал танд тулгардаг уу?

101 хариулт




Салбарын байрлалаас төв, орон нутаг руу хөдөлгөөн үйлдэхэд замын нөхцөл, алслагдсан байдал нь танд хүндрэлтэй байдаг уу?

101 хариулт




Гэр бүлийн хүмүүсээсээ хол байх нь таныг ажлаас гарахад нөлөөлдөг үү?

101 хариулт




Таны гэр бүлийн гишүүн өөрийн хүссэн ажлаа хийхгүй байх нь таныг ажлаас гарахад нөлөөлдөг үү?


101 хариулт




Соёл, хөгжлийн хэрэгцээг тогтмол авч чадахгүй байгаа нь таныг ажлаас гарахад нөлөөлдөг үү? (аялал зугаалга, урлаг соёл, өөрийгөө хөгжүүлэх олон талт хэрэгцээнүүд гэх мэт)
101 хариулт



Алслагдсан байдалд ажиллах нь ажлын сэтгэл ханамжийг бууруулж байна уу?
101 хариулт



Барилга, байшин дэд бүтэц муу байгаа нь танд хүндрэлтэй байдаг уу? (тог цахилгаан, ус, албаны байр гэх мэт)
101 хариулт



ЭХ ХЭЛ НЬ ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН НЭГ САЛШГҮЙ ХЭСЭГ МӨН

Э.МАНДАЛ*

Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн магистрант, Хилийн цэргийн 0303 дугаар ангийн гадаад хэлний багш, орчуулагч, ахмад Э.Мандал

**Хариуцлагатай холбоо барих (email:,mandaa60haha@gmail.com)*

Хураангуй: Дэлхийн хүн төрөлхтний даяаршил болон бүс нутгийн хамтын ажиллагаа сайн хөгжиж буй өнөө үед аливаа үндэстний эх хэл нь тусгаар тогтнол, оюун санаяны хил хязгаар болж байна. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал нь хил орчмын нутаг дэвсгэр дэх монгол хэлний амин чанарыг хэрхэн хадгалж үлдэхээс шууд хамаарч байдаг.

Хил залгаа улсын хэлний түрэлт хил орчмын бүс нутагт хэрхэн нөлөөлж буйг судлан, боловсролын байгууллагын хэл, бичиг олгох чанар, эх хэлнийхээ дархлааг төрийн бодлого, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хамгаалах нь нэн чухал байна. Энэхүү судалгааг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомж дээр тулгуурлан баримт бичгийн шинжилгээ, PISA-2022 олон улсын үнэлгээний үр дүнг харьцуулан анализ хийх, күнзийн институтийн тайлан, суралцагчдын статистик мэдээллийг ашиглан тоон судалгааны аргуудыг хэрэглэсэн болно.

Судалгаагаар Монгол Улсын 15 настай сурагчдын 64 хувь нь эх хэлээрээ уншиж ойлгох суурь чадварт (OECD, 2022) хүрээгүй байгаа нь хэлний дархлаа нийт суралцагчдын түвшинд суларсныг харуулж байна. Үүний зэрэгцээ хөрш орны хэл, соёлыг түгээх “зөөлөн хүчний” бодлого эрчимжиж, 13,000 гаруй иргэн дотооддоо хятад хэл сурч, бага насны хүүхдүүд хил дамнан суурь боловсрол эзэмшиж байгаа нь үндэсний ижилсэл төлөвших насанд (12-оос доош нас) хэлний дархлаа сулрах эрсдэлтэй байна.

Түлхүүр үг: Үндэсний аюулгүй байдал, хэлний дархлаа, хил орчмын нутаг дэвсгэр

Удиртгал

1990 онд Монгол улсад ардчилсан хувьсгал ялж, Монгол улс олон талт дипломат харилцааг хөгжүүлж эхэлсэн байдаг. Нийгмийн энэхүү өөрчлөлтийн дараа XX зууны сүүлээс монголчууд боловсролын тогтолцоондоо орос хэл голчлон үзэж байснаа больж хятад, англи, япон, солонгос, герман зэрэг гадаадын олон хэлийг их сургууль төдийгүй бага, дунд, ахлах сургуульд заах болсон. Одоогоос 30 гаруй жилийн өмнөөс эхэлсэн энэ давалгаанд Монгол хэлний эзлэх байр суурь улам хумигдан эх хэлний аюулгүй байдал үндэстний аюулгүй байдлын хэмжээнд авч үзэх асуудал болсон байгаа нь эмзэглүүштэй.

Хэл бол тухайн хэлээр яригч бүлгийн харилцааны чухал хэрэгсэл болдог. Орчин үеийн нийгмийн хөгжлийн хандлага, хэрэгцээ шаардлагын хүрээнд улс орнуудын нийгэм улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжихийн хэрээр хэлний хөгжлийн үйл явцад өөрчлөлт орж, шинэ үг хэллэг, нэр томьёогоор үгийн сан баяжиж байдаг. Эдгээр хэлний нөлөөгөөр гадаад үгийг шууд хэрэглэх, хольж ярих үзэгдэл нэн элбэг байна. Ялангуяа хил залгаа улсын нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжил хил орчмын нутаг дэвсгэрт хэлийг эрлийзжүүлэх, хумих, эх хэлээрээ мэдлэг олж авахгүй байх нь үндэсний зан заншил, язгуур эрх ашигт зөөлөн хүчээр түрэмгийлэл үйлдэж болох аюултай.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хүрээнд хилийн аюулгүй байдлын түвшнийг тогтоох, түүнд нөлөөлөх заналхийллийг тодорхойлох, хил орчмын бүс нутагт үүсэх аливаа нөлөөллийг урьдчилан тандан судлах нь үндэсний язгуур эрх ашгийг хамгаалах чухал ажил юм. Иймд хил залгаа улс орнуудын нөлөөлөл хил орчмын бүсэд хэрхэн тусаж буйг шинжлэх нь энэхүү судалгааны үндэслэл болно.

Энэхүү үйл явцыг Монголын олон эрдэмтэн судлаачид өөр өөрийн өнцгөөс тайлбарлан судалсан ба Монгол-Хятадын хилийн харилцаа, соёлын асуудлыг геополитик, стратегийн түвшинд Ж.Баясах (2015), Б.Батцэцэг, Ж.Хайсан (2018) нар, хэл, соёлын нөлөөллийг аюулгүй байдлын үүднээс Б.Өсөхжаргал (2014), П.Гантөгс (2013) нар, хил судлал, хилийн аюулгүй байдлын талаас Ц.Ганболд (2022), Ц.Өвгөнбүргэд (2021), Ш.Арвай (2013), Х.Муратхан (2013) нарын эрдэмтэд тодорхой судалгаануудыг хийсэн байна.

Үндсэн хэсэг

1.Аюулгүй байдлын тухайд:

Аюулгүй байдал нэр томьёоны “аюулгүй” гэдэг утгыг Монгол хэлний их тайлбар тольд “Гамшиг зовлон учруулахгүй, хор хөнөөлгүй, гай, аюул агуулахгүй, (хөнөөл агуулахгүй), аюул гаргахгүй (гамшиг гаргахгүй), аюул дайрахгүй” гэж тайлбарласан байна.

Аюулгүй байдлын тухай ойлголт маш өргөн хүрээг хамарсан ухагдахуун бөгөөд сүүлийн үед аюулгүй байдлын тухай дараах тодорхойлолт ихээхэн түгээмэл шинжтэй болсон байна. Тухайлбал, эрдэмтэн Ч.Улаанхүү аюулгүй байдлын талаарх ойлголтыг “нийгэм, хувь хүн, улс гүрэн аюул, заналаас хамгаалагдсан байдлыг аюулгүй байдал хэмээн үзэх хандлага юм” гэж тодорхойлжээ (Улаанхүү, 2009).

Үүнээс харахад аюулгүй байдал гэдгийн ерөнхий байдлаар “Төр ба нийгэм, бие хүний амин чухал ашиг сонирхол гадаадын ба дотоодын аюул, заналаас хамгаалагдсан төлөв байдал” гэж тодорхойлж болох юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах талаар “Үндсэн хууль”, “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ын бодлогын баримт бичгүүдэд тухайн салбарт хамаарах тулгуур суурь заалтууд тус тус тусгажээ. Дээрх дөрвөн тулгуур баримт бичгүүдийн нэгдсэн суурь бодлогын холбогдох заалтуудын агуулгад тулгуурлан бусад салбарын бодлого боловсруулагдах зүй тогтолтой. Үүнээс үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны “Аюулгүй байдлын бодлого цогц, нэгдмэл байдалтай байгаа нь харагдаж байна.

Монгол улсын хилийн тухай хуульд Хилийн аюулгүй байдал гэдгийг “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн бөгөөд хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ” (2016) гэж тодорхойлж, хуульчилсан байна.

Мөн Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого (2002)-д “Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал түүний язгуур ашиг сонирхол тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдоно” гэж заажээ. Хил судлалын шинжлэх ухааны болон улсын хилийн талаар баримтлах төрийн бодлогын байр сууринаас авч үзвэл хилийн аюулгүй байдал гэдэг ойлголт нь улсын хилийн өөрийнх нь аюулгүй байдал, түүнчлэн хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал гэж үзэх хоёр бодгаль элементээс бүрдэж байна. Улсын хилийн өөрийн аюулгүй байдал нь олон улсын эрх зүйгээр баталгааждаг бол,

хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын хууль, эрх зүйгээр зохицуулагддаг онцлогтой (Өвгөнбүргэд, 2021) гэж үзжээ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд "Хил орчмын нутаг дэвсгэрт хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэр орох" гэж заасан нь хил залгаа улсаас манай улс руу хийх аливаа нэгэн юмс үзэгдлийн нөлөөлөл хилийн аюулгүй байдлын чухал хэсэг мөн гэдгийг илэрхийлж байна.

2.**Хэл, түүний тухайд:**

Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд (2008) "Хэл-хүмүүсийн харилцааны хамгийн чухал хэрэглүүр" гэсэн бол "Хэл бол зөвхөн харилцааны хэрэгсэл бус хүн байхын нэг үндэс. Тэр тусмаа хэл үндэстний хувьд оршин тогтнохын суурь баталгааны нэг" (Жанцаннороов, 2015), Г.Аветан "Ер зүйрлэх арга байхгүй бол аль ч хэлээр харилцахад нэн төвөгтэй болно гэдэг нь мэдээж. Учир нь хэл бол танин мэдэхүй-сэтгэхүйн зэвсэг, түүний илэрхийлэл юм. Иймээс хэл бол мөн чанартай зүйрлэл байдаг" (2002) хэмээн тус тус тодорхойлсон.

Хэл нь хүний нийгмийн хамгийн гайхамшигт бүтээл бөгөөд улс үндэстний түүх, соёл, мэдлэг туршлагыг үеэс үед дамжуулах, хадгалах, аливаа мэдээлэл цуглуулах, боловсруулах, түгээн дэлгэрүүлэх, хүн хооронд санаа бодлоо солилцох, бие биедээ нөлөөлөх, орчлон ертөнцийг танин мэдэх чухал хэрэгсэл болдог. Тиймээс тухайн улсын хэл нь харилцааны хэрэгсэл төдийгүй, хэлээр харилцагчдын мэдлэг, туршлагыг тэмдэглэн хадгалж, өвлүүлэн уламжлуулж байдаг хэрэглүүр юм.

Төрөлх хэл нь тухайн үндэстний соёл, түүхэн уламжлал, аж амьдралын онцлог, үнэт зүйл, бахархал, үндэстний ерөнхий төрхийг өөртөө хадгалж, өвлүүлдэг онцгой хэрэгсэл ба үндэстний сэтгэлгээ, мөн чанарын нэгээхэн хэсэг гэдэг үүднээс тухайн үндэстний бусдаас ялгагдах шинжийг агуулж байдаг. Хэлгүй үндэстэн гэж байдаггүй бөгөөд үндэсний хэлийг гарал үүслээр нь унаган хэл, угсаатны бүлгийн хэл, зээлдсэн хэл гэж 3 ангилдаг.

Үндэсний хэлийг харилцааны үүргээр нь бичгийн нийтлэг хэл, ярианы нийтлэг хэл, бичгийн болон аман хэлбэрээр орших сонгомол нийтлэг хэл гэж ангилж үздэг байна.

Аливаа үндэсний хэлний агуулга мөн чанарт тухайн улс, үндэсний сэтгэлгээ, соёл иргэншил, эдийн засаг, улс төрийн бодлого гэх мэт олон зүйл шингэсэн байдаг нь хэл бол төр улс үндэстний оршин тогтнох нөхцөл, аюулгүй байдлаа хангах чухал хүчин зүйл болно гэж үздэг. Хэл нь үндэсний оюуны ухамсар, нийтлэг үзэл санаа, үндэсний бахархал төлөвших гол хүчин зүйл учир хэлийг хамгаалан хадгалан авч үлдэх, олон улсын тавцанд таниулан харуулах нь тухайн улс орны оршин тогтнох гол суурь болно.


Монгол Улсын Үндсэн хуулийн наймдугаар зүйлд "Монгол хэл бол төрийн албан ёсны хэл" мөн. Энэ заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө (1992) гэсэн хоёр заалт шууд утга илэрхийлж байгаа бол Монголын ард түмэн бид: улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, төрт ёс, хүн төрөлхтний соёл түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, эх орондоо хүмүүнлэг, иргэний иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна (1992) гэж тунхагласан нь илүү өргөн утга агуулгаар хэл соёлын бодлого, чиглэлийг тодорхойлсон байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн”, “Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншлыг хамгаалах, хөгжүүлэх, биет болон биет бус соёлын өвийг хамгаалан судлах ажлыг төр ивээлдээ авч, хөгжүүлнэ”, “Монгол хэл, бичгийн соёлоо хамгаалан хөгжүүлж, уламжлалт Монгол бичгийн сургалт, хэрэглээг нэмэгдүүлнэ”, хүүхэд залуучуудад түүх, соёл, зан уламжлалаа гүнзгий таниулах, эх ороонч үндэсний үзлийг төлөвшүүлэх ажлыг нийгэм, гэр бүл, боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлнэ (2010) гэж шууд утгаар хэл, соёлын бодлогын талаар үндсэн хуулийн заалтыг дэлгэрүүлэн заасан бол “ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Чингэхдээ үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалыг харгалзан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, бүхэлдээ тэнцвэртэй харилцахыг эрмэлзэнэ. “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ” (2010) гэх зэргээр хэл соёлын бодлогод үндэсний аюулгүй байдлыг хангах эрх ашигтай нийцүүлэн гадаад хэлний талаар баримтлах далайцтай агуулга бүхий олон суурь бодлогуудыг тодорхойлсон. Эдгээр суурь бодлого салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хэрхэн хэрэгжиж ирснийг төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын тухай, соёлын тухай болон Монгол хэлний тухай хуулийн заалтуудаас харж болох юм.

3.Олон улсын байгууллагаас Монгол хэлний хэрэглээний түвшнийг тогтоосон байдлын тухайд:

Олон улсын сурагчдын үнэлгээний хөтөлбөр (The Programme for International Student Assessment цаашид PISA гэх) (OECD, 2022) нь олон улсын 15 настай сурагчдын математик, унших чадвар болон байгалийн ухааны мэдлэг, чадварыг үнэлдэг хөтөлбөр юм. Энэхүү шалгалт нь сурагчид цогц асуудлыг хэрхэн шийдвэрлэж, шүүмжлэлтэй сэтгэж, үр дүнтэй харилцаж чадаж байгааг тандан судалж харилцан туршлага судлах боломж олгодог.

Монгол Улс 2022 онд PISA-д анх удаа оролцсон бөгөөд уг судалгааны унших чадварын дүнгээс харахад судалгаанд хамрагдсан ихэнх сурагчид Монгол хэлээр эх сурвалжаас мэдээлэл хайх, гол санааг нэгтгэх зэрэг өдөр тутмын амьдралд шаардлагатай энгийн чадварыг бүрэн эзэмшиж байдал ердөө 36 хувь нь 2-р түвшин (суурь түвшин), гуравны хоёр нь буюу 64 хувь нь унших чадварын суурь босгыг давж чадаагүйг харуулж байгаа.



Хүснэгт 1 Олон улсын сурагчдын үнэлгээний хөтөлбөр PISA (The Programme for International Student Assessment) (OECD, 2022)

Монгол Улс бодлогын баримт бичигт Монгол хэлийг хамгаалах суурь ойлголтыг сайн тусгаж өгсөн байдаг ч хэрэглэх, түгээх талаар зөвхөн "унших" (үсэглэх) бус, харин "уншиж ойлгох, дүн шинжилгээ хийх" чадварыг олгох тал дээр тааруухан үзүүлэлттэй байна.

Бидний залуу үе ирээдүйд чухал болох "текстгэй ажиллах, шүүмжлэлтэй хандах" чадваргүй байгаа нь эх хэлний дархлаа, хэрэгцээ сул байгааг харуулж байна.

4.Хил залгаа үндэстний хэлний түрэлт, эрчимжилтийн тухайд:

Монгол улсын боловсролын ерөнхий хуульд сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна[48] гэж заасан байдаг ч 6 дугаар бүлгийн 3 дах [49]заалтад **заавал монгол хэлээр заах албагүй** гэдгийг зөвшөөрч байгаа юм.

Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг Күнзийн институтийн албан ёсны хаягт байршуулсан (2024) мэдээллээс авч үзэхэд тус байгууллага нь гадаад улсын сургалтын байгууллагуудтай хамтрах хэлбэрээр хятад хэл, соёл, хятад орон судлалын сургалт явуулдаг олон талт хамтын ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага юм. Анхлан байгуулагдсанаас хойш 10 жилийн хугацаанд дэлхийн 126 онд 475 Күнзийн институт, 851 күнзийн танхим үйл ажиллагаа явуулж байна. Нийт 3,45 сая хүн суралцдаг ба түүний дотор 61 улс болон Европын холбоо хятад хэлийг тухайн улсын албан ёсны боловсролын хөтөлбөртөө оруулсан байна. Күнзийн институтээс 3000 гаруй арга хэмжээ зохион байгуулж нийт 10 сая орчим хүн оролцож, 30 сая ширхэг ном сурах бичгийг хэвлүүлэн тараасан байна. Тус байгууллага манай улсад үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш бодлого, сургалтын явцыг тодорхойлохын тулд олон үйл ажиллагаа зохион байгуулжээ. Жишээлбэл, Хятад орон, түүний ард иргэдийн тухай, монголын олон нийтийн үнэлэмж, төсөөлөл, иргэд болоод улс хоорондын харилцааны

[48] 6.1.Монгол Улсад боловсрол эзэмшүүлэх сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна. Сургалтын үндсэн гадаад хэл нь англи хэл байх бөгөөд эх хэлээрээ суралцах болон бусад гадаад хэл суралцах эрхийг үл хөндөнө.

[49] 6.3.Боловсролын сургалтын байгууллага энэ хуулийн 6.4-т заасан агуулгыг монгол хэлээр эзэмшүүлэхээс гадна тухайн боловсролын сургалтын байгууллагын төлөвлөгөөнд заасан гадаад хэлийг судлахад энэ хуулийн 6.1 дэх хэсэг хамаарахгүй.

төлөв байдал, цаашдын чиг хандлагын талаарх санал бодлыг тандах зорилгоор Монгол дахь Күнзийн институтээс гаргасан санаачилгын дагуу “Хятад орон, хятадын ард түмний талаарх Монголчуудын санал бодол” судалгааг МУИС-ийн Күнзийн институт болон МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Социологи нийгмийн ажлын тэнхимээс 2016 оны эхээр зохион байгуулсан. Судалгаанд баруун, хангайн, төвийн, говийн, зүүн гэсэн 5 бүсийн 9 аймаг, Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хэмжээнд нийт 3041 оролцогч хамрагдсан (МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль & МУИС-ийн Күнзийн институт, 2016).

Мөн Монгол Улс дахь хятад хэлний сургалтын явцыг тодорхойлох зорилгоор 7 төлөөлөл болсон их сургуулийн 800 гаруй оюутнаас, мөн Монгол Улсын дунд сургуулийн хятад хэлний сургалтын байдлыг тодруулах үүднээс сургалт бүрэн хятад хэл дээр явагддаг "Үй цай" хятад дунд сургууль, улсын 23-р дунд сургууль, хуучин “Монголын хятад цагаач иргэдийн бага сургууль” буюу одоогийн нэршил “Найрамдал” дунд сургууль, хувийн “Хишиг” дунд сургууль зэргээс гадна хятад хэл үздэг улсын 77-р дунд сургууль, Дархан, Эрдэнэт хотуудын “Солонго” дунд сургуулиудын 713 сурагчдаас асуулга авч судалсан байна (2014).

Өөр баримтаас харахад (Po lan yi, 2011) Монгол Улсаас БНХАУ-ын тэтгэлэг, Күнзийн институтийн тэтгэлэг, муж, өөртөө засах орны тэтгэлгээр жил бүр 1000-аас доошгүй иргэд хятадын сургуульд элсэн орсоор байна. Мөн 2005 оноос эхэлсэн ӨМӨЗО-ны засгийн газрын тэтгэлгээр Монгол Улсын 100 залуусыг жил бүр Өөртөө засах орны их, дээд сургуульд сургаж байна (CPC News Network, 2008). Дээрх судалгаанаас харахад хятад улсын хэл соёлоо түгээх бодлого Монгол улсын хувьд бусад улсаас ялгарах өвөрмөц онцлогтой байна. Тухайлбал, дэлхийн улс орнуудын гадаадад суралцагсад ихэвчлэн их, дээд сургуульд элсэн суралцдаг зүй тогтолтой бол Монгол Улсын хувьд цөөнгүй тооны иргэд бага насны хүүхдүүдийг хэл сайн сургах зорилгоор хятадын бага, дунд боловсролын сургуульд сургаж байна.

ӨМӨЗО-ны Эрээн хотноо хятад хэл түгээх 2 дунд сургууль үйл ажиллагаа явуулж байна. Эрээн хотын Монгол үндэстний дунд сургуульд 2011 оны байдлаар 48, Эрээн хотын үндэсний дунд түшиц сургуульд 105 Монгол Улсын бяцхан иргэд суралцаж байсан. Эрээн хотод 10 гаруй ерөнхий боловсролын сургууль байдгийн дөрвөөс тавд нь монгол хүүхдүүд суралцдаг бөгөөд тэд монгол хэлний хичээл үздэггүй харин хятад хэл соёлтой холбоотой үндсэн хичээлүүдийг судалдаг байна. Зөвхөн Эрээн хотын сургуульд л гэхэд 2014 оны байдлаар 140 гаруй хүүхэд суралцдаг бөгөөд энэ тоо жил ирэх тусам өсөх хандлагатай байна. Эндээс ерөнхий боловсролын сургууль эрс нэмэгдсэн, үндэсний дунд сургуульд суралцагчдын тоо 3 жилийн дотор 35 хүүхдээр нэмэгдсэн, монгол хэлийг үздэггүй зэрэг сэтгэл түгшээсэн тоо баримт харагдаж байна (www.moe.edu.cn, 2015).

Одоогоор хил орчмын бүс нутагт хятад хэлийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сургалтын байгууллага Замын-Үүдэд дөнгөж нээгдэн үйл ажиллагаа явуулж байгаа эс тооцвол Эх-Орны зах хязгаарт төдийлөн хүрч амжаагүй байна энэ таатай ч томоохон хотуудад тархалт их байна.

Угсаатны сэтгэл судлалын үүднээс авч үзвэл угсаатны хамтлагт харьяалагдах адил төстэй сэтгэл хөдлөл-үнэлгээний ухаарлын төлөвших хөгжлийн үйл явц хүний өсөх бага насанд гурван үе шаттай явагдана гэж Ж.Пиаже үзсэн байна (Уранцэцэг & Цэрэнханд, 2007). Үүнд:

6-7 насанд хүүхэд өөрийнхөө угсаатны харьяаллын талаар хэсэгчилсэн мэдлэгтэй болох, 8-9 насанд эцэг, эхийн яс үндэс, амьдрах нутаг, төрөлх хэл зэргийг үнэлдэг болгон өөрийгөө угсаатны бүлэгтэй бүр тодорхой ижилсүүлэх, 10-11 насанд

янз бүрийн ард түмний түүхийн давтагдашгүй өвөрмөц ахуй уламжлалт соёл, овог удмын түүхийн хувь заяа, шашны онцлогийг түшиглэн угсаатны ижилсэл тал нь бүрэн төлөвшинө гэж үзсэн. Эндээс хүүхдэд гадаад хэл соёлын сургалтыг 12 наснаас нь эхлэн явуулах нь Монгол хэл соёлынхоо дархлааг хамгаалах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй байдлаар тайлбарлан харуулжээ.

Тэнд бага наснаасаа хятад хэлээр суралцсан хүүхдүүд монгол хэл гэхээсээ илүүтэй хятад хэлд дуртай болно. Оюун санаа, сэтгэлгээ нь төлөвшөөгүй хүүхдүүдийг хэл, сэтгэлгээний хувьд эрлийзжүүлэх нь монгол хэл соёлын аюулгүй байдалд ноцтой асуудлыг бий болгож байна. Үүнээс гадна нэгэн сурвалжид (2014) “Монгол Улсад 2013 оны байдлаар 13000 хүн хятад хэл сурдаг бол Монгол Улсын их, дээд боловсролын байгууллагад 6000 оюутан, 30 бага дунд сургуульд 8000 хүүхэд, БНХАУ-д 10000 орчим залуус хятад хэл суралцаж байгаа нь 3 сая хүн амтай манай орны хувьд багагүй тоо юм.” гэж онцлон тэмдэглэсэн байна.

Судалгааны үр дүнгийн хэлцэмж:

Дээрх дүгнэлтүүдээс үндэслэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба хэлний дархлааны харилцан хамаарлыг дараах хоёр үндсэн хэлцэмжийн хүрээнд тодорхойлж байна.

1. Аюулгүй байдал-Хэл-ний харилцан хамаарлын хэлцэмж: Эх хэлээ судлах нь зөвхөн хэл шинжлэл, боловсролын байгууллагын үүрэг биш харин геополитикийн зөөлөн хүчний гол талбар болжээ. Улсын хил нь газар зүйн хязгаар гадна, тухайн бүс нутгийн оршин суугчдын хэл сэтгэлгээний хязгаар болж байдаг байна. Учир нь Олон улсын сурагчдын үнэлгээний хөтөлбөр (The Programme for International Student Assessment) PISA үнэлгээний үр дүн нь Монгол хүүхдүүд эх хэлээрээ мэдээллийг боловсруулах чадвар суларч байгааг харуулж байгаа нь “оюун санааны хилийн хамгаалалт” суларч буйг илтгэж байна.

Мөн уншиж ойлгох чадварын хоцрогдол (64 хувь) нь иргэдийг мэдээллийн дайн, суртал ухуулгад өртөмтгий, мэдээллийг хүлээн авч боловсруулахдаа баримт, үзэл бодлыг ялгаж чадахгүй байх нь нийгмийн хэлцэмжийг гаднаас удирдах, хуурамч мэдээллээр дамжуулан үндэсний эв нэгдэл, аюулгүй байдалд халдах орон зайг тэлж болох илтгэх аюултай хэлцэмж юм.

2. Гадаад хэлний нөлөө ба соёлын ижилсэл: БНХАУ-ын зүгээс хэрэгжүүлж буй хэлний бодлого, тэтгэлэгт хөтөлбөрүүд нь зөвхөн боловсролын салбарын асуудал биш юм. Ж.Пиажегийн онолоор 6-12 насанд хүний ертөнцийг үзэх үзэл, үндэсний ижилсэл бүрэлддэг. Энэ насанд нь гаднын хэлний хэт давамгайлал тогтох нь ирээдүйд “хос хэлний” бус, харин гаднын соёлын хэлцэмжийг дагасан, үндэсний сэтгэлгээний хувьд тухайн хэлээр яригч орны соёлд автах иргэдийн давхаргыг үүсгэх эрсдэлтэй.

Дүгнэлт:

Хилийн аюулгүй байдал болон үндэсний хэлний дархлааны харилцан хамаарлыг онол арга зүй, статистик баримтын түвшинд шинжлэн судлахад дараах үндсэн дүгнэлтүүдэд хүрч байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон үндсэн хуулийн агуулгаар монгол хэл нь зөвхөн харилцааны хэрэгсэл бус, улс үндэстний тусгаар тогтнол, соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах гол хүчин зүйл мөн. Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь зөвхөн хилийн шугам хамгаалах бус, тухайн бүс нутгийн иргэдийн оюун санаа, хэлний дархлаагаар баталгааждаг онцлогтой.

Олон улсын сурагчдын үнэлгээний хөтөлбөр PISA (The Programme for International Student Assessment) (OECD, 2022) олон улсын үнэлгээний үр дүнгээр монгол сурагчдын **64 хувь** нь уншиж ойлгох суурь чадварт хүрээгүй, дээд түвшний

(аналитик) чадвартай сурагчид бараг байхгүй байгаа нь үндэсний хэлний дархлаа суларч буйн бодит илрэл юм. Энэхүү “уншиж ойлгох” чадварын хоцрогдол нь иргэдийн мэдээлэлд шүүмжлэлтэй хандах, баримт болон үзэл бодлыг ялгах чадварыг сулруулж, гаднын соёл, хэлний түрэлтэд өртөх эмзэг байдлыг үүсгэж байна.

БНХАУ-ын Күнзийн институт болон боловсролын тэтгэлэгт хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа Монгол Улсад маш эрчимтэй, системтэй явагдаж байна. Өнөөдрийн байдлаар 13,000 гаруй суралцагч дотооддоо хятад хэл сурч, жил бүр 1,000-аас доошгүй иргэн тус улсад суралцахаар явж байгаа нь хэлний бодлогын тэнцвэрт байдал алдагдаж болзошгүйг харуулж байна. Ялангуяа, хил залгаа Эрээн хот болон дотоодын бүрэн дунд сургуульд хятад хэлийг бага насны хүүхдүүдэд сургаж байгаа нь үндэсний сэтгэлгээ төлөвших насанд (Ж.Пиажегийн онолоор 6-12 нас) гаднын хэлний давамгайлал тогтох эрсдэлийг дагуулж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Батцэцэг, Ч. (2004). *Монгол улс, БНХАУ-ын харилцаанд ӨМӨЗО-ны эзлэх байр суурь.* МУИС.

Ганболл, Ц. (2022). *Хил судлал.* ДХИС.

Жанцанноров, Н. (2015). Монгол үндэстний хэл соёлын дархлаа. *Гадаад хэл,соёл ба Монгол үндэстний сэтгэлгээний онцлог.* Улаанбаатар: Улаанбаатар.

Жу Зун Лин Фан Ин Диэн . (2014). Монгол Улсын хятад хэлний байдлын судалгаа, илтгэл. *Монголын хятад судлал, 220*, 158-165.

(2016). *Монгол Улсын Хилийн тухай хууль.* Төрийн мэдээлэл, №01. Улаанбаатар.

Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. (2008). Улаанбаатар.

МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, & МУИС-ийн Күнзийн институт. (2016). *Хятад орон, хятадын ард түмний талаарх Монголчуудын санал бодол.* Улаанбаатар.

Өвгөнбүргэд, Ж. (2021). *Хилийн аюулгүй байдлын онол, арга зүй.* Улаанбаатар.

Өсөхжаргал, Б. (2014). *"Гадаад хэл, соёлын нөлөө, аюулгүй байдал" (Докторын зэрэг горилсон бүтээл).* ҮБХИС.

Равдан, Э. (2001). *Хэл, соёлын шүтэлцээний тухай.* Улаанбаатар.

(2002). *Төрөөс хилийн талаар баримтлах бодлого.* Улаанбаатар.

Улаанхүү. (2009). *Аюулгүй байдал.* Улаанбаатар.

Улсын их хурал. (1992). Монгол улсын үндсэн хууль. *Төрийн мэдээллийн сан*(3), 94.

Улсын их хурал. (2010). Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. *Төрийн мэдээллийн сан*.

Уранцэцэг, Л., & Цэрэнханд, Г. (2007). *Угсаатны сэтгэл судлал.* Улаанбаатар.

Чимэдцэеэ, М. (2015). Хэл, соёл, сэтгэлгээний шүтэлцээ илтгэл. *Гадаад хэл соёл ба Монгол үндэстэний сэтгэлгээний аюулгүй байдал эмхэтгэл.* Улаанбаатар: Улаанбаатар.

CPC News Network. (2008, 01 28). People.cn. 7243838.html

OECD. (2022). *https://www.oecd.org*. /en/about/programmes/pisa.html.

Po lan yi. (2011, 2 15). *wen.org.cn*. http://wen.org.cn/modules/article/view.article.php/article=2484. article/view.article.php/article=2484

Samovar, L. A., & Porter, R. E. (1991). *ntercultural Communication: A Reader (6th ed.).* Wadsworth Publishing Company.

www.moe.edu.cn. (2015, 3 20). publicfiles. 184959

朱军立. (2014). *蒙古国汉学研究.* Бээжин.

ОЛОН УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ЧИГ ХАНДЛАГА БА МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ХАМГААЛАЛТЫН АРГА ЗАМ

Г.ОДОН-ЕРТӨНЦ*
ДХИС, Хилийн албаны сургуулийн Мэдээлэл технологийн тэнхимийн профессор, хурандаа

**хариуцлагатай зохиогч: ertunts89@gmail.com*

Хураангуй: Орчин үеийн хил хамгаалалтын тогтолцоо нь уламжлалт физик хамгаалалтаас технологид суурилсан, мэдээлэлд түшиглэсэн, нэгдсэн удирдлагын тогтолцоо руу эрчимтэй шилжиж байна. ОХУ болон БНХАУ-ын жишээнээс харахад хил хамгаалалт нь төвлөрсөн удирдлага, технологийн шинэчлэл, “ухаалаг хил” (Smart Border) концепц, эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналтын тогтолцоо, олон агентлагийн хамтын ажиллагаанд тулгуурлан хөгжиж байна.

Мөн хил хамгаалалт нь зөвхөн хилийн шугамын хяналтаар хязгаарлагдахгүй, харин урьдчилан сэргийлэх, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалт, бодит цагийн тандалт, нэгдсэн команд удирдлагын тогтолцоонд суурилсан стратегийн түвшний аюулгүй байдлын систем болон өргөжиж байна. Ийнхүү хил хамгаалалтын орчин үеийн чиг хандлага нь дижитал технологи, автоматжуулалт, мэдээллийн нэгдсэн систем, хүний нөөцийн чадавх, бодлогын уялдааг хослуулсан цогц хандлагад тулгуурлан хөгжиж байгааг илэрхийлж байна.

Түлхүүр үг: Хил хамгаалалт , Ухаалаг хил (Smart Border), Технологийн шинэчлэл, Мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалт, Эрсдэлийн үнэлгээ, Нэгдсэн удирдлагын тогтолцоо, Команд удирдлага, Дижитал технологи, Олон агентлагийн хамтын ажиллагаа, Аюулгүй байдлын систем.

Удиртгал

Өнөө үеийн дэлхийн улс орнуудын хил хамгаалалтын тогтолцоо нь уламжлалт хамгаалалт, хүний хүчинд тулгуурласан загвараас технологид суурилсан, мэдээлэлд түшиглэсэн, нэгдсэн удирдлагын тогтолцоо руу эрчимтэй шилжиж байна. Даяаршил, олон улсын худалдаа, хүн амын шилжилт хөдөлгөөн, хил дамнасан гэмт хэрэг, терроризм, хууль бус цагаачлал зэрэг хүчин зүйлс нь хил хамгаалалтын орчныг илүү нарийн төвөгтэй болгож, зөвхөн хилийн зурваст хяналт тавих ойлголтоос давсан, стратегийн түвшний аюулгүй байдлын бодлогын асуудал болгон шинэ түвшинд хүргэж, “Smart Border” буюу ухаалаг хил хамгаалалт руу чиглэж, дижитал технологи, автоматжуулалт, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг хил хамгаалалтын үндсэн тулгуур болгож байна.

Ухаалаг хилийн тогтолцоо нь биометрийн бүртгэл, автомат хил нэвтрэх систем, нүүр таних технологи, урьдчилсан зорчигчийн мэдээллийн дүн шинжилгээ, нэгдсэн мэдээллийн сан зэрэг шийдлүүдийг ашиглан хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэж байна. Европын холбоо, АНУ, Австрали зэрэг улс орнууд хилээр нэвтрэх урсгалыг бүрэн зогсоох бус, харин эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналтын тогтолцоог нэвтрүүлж, өндөр эрсдэлтэй зорчигч, ачаа, үйл ажиллагаанд илүү анхаарал төвлөрүүлэх бодлогыг хэрэгжүүлж байна. Энэ нь бүх иргэн, бүх ачааг ижил түвшинд шалгах уламжлалт аргаас илүү үр ашигтай, нөөцийн хуваарилалтыг оновчтой болгох стратегийн хандлага болж байна.

Үүний зэрэгцээ тандалт, хяналтын технологийн систем улам бүр нэмэгдэж, дрон, хиймэл дагуулын зураглал, газрын мэдрэгч, ухаалаг камерын сүлжээ, хөдөлгөөн илрүүлэгч системүүдийг нэгтгэн бодит цагийн мэдээлэл боловсруулах чадвартай командын төвүүдийг байгуулж, олон агентлагийн мэдээллийн солилцоог шуурхай болгох нь орчин үеийн хил хамгаалалтын чухал шинж болж байна. Ийнхүү хил хамгаалалтын байгууллагууд зөвхөн физик хяналт тавих бус, мэдээлэлд суурилсан урьдчилан сэргийлэх стратеги хэрэгжүүлэх чиглэлд шилжиж байна.

Мөн олон улсын түвшинд хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг болж, терроризм, хүний наймаа, хар тамхины хууль бус эргэлт, зэвсгийн наймаа, зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг аюул заналтай тэмцэх нэгдсэн бодлогын хүрээнд хэрэгжиж, энэ хүрээнд хил хамгаалалт нь дан ганц хилийн цэрэг, нэг байгууллагын асуудал биш болж, цагдаа, тагнуул, гааль, цэргийн байгууллага, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурласан нэгдсэн систем болон хөгжиж байна.

Гэвч технологид суурилсан хил хамгаалалтын тогтолцоо өргөжихийн хэрээр хүний эрх, хувийн мэдээллийн хамгаалалт, ёс зүйн зохицуулалтын асуудал ч мөн адил чухал байр суурь эзэлж байна. Биометрийн өгөгдөл, нүүр таних систем, автомат хяналтын шийдлүүдийг өргөн ашиглах нь аюулгүй байдлыг нэмэгдүүлэх давуу талтай боловч хувийн мэдээллийн хамгаалалт, иргэний эрх чөлөөг хангах хууль эрх зүйн зохицуулалтыг давхар боловсронгуй болгох шаардлагыг бий болгож байна. Иймээс олон улсын чиг хандлага нь аюулгүй байдал ба хүний эрхийн тэнцвэрийг хадгалах бодлогын шийдэл рүү чиглэж байна.

Дүгнэж үзвэл, олон улсын хил хамгаалалтын хөгжлийн чиг хандлага нь дижитал технологи, мэдээлэлд суурилсан эрсдэлийн удирдлага, нэгдсэн командын тогтолцоо, олон агентлагийн хамтын ажиллагаа, стратегийн түвшний аюулгүй байдлын нэгдсэн систем зэрэг шинжээр тодорхойлогдож, энэхүү хөгжлийн чиглэл нь хил хамгаалалтыг уламжлалт физик хамгаалалтаас давсан, мэдээллийн эрин үеийн стратегийн аюулгүй байдлын цогц тогтолцоо болгон шинэчилж байгаа бөгөөд улс орнуудын хувьд технологийн шинэчлэл, бодлогын уялдаа, хүний нөөцийн чадавхыг зэрэг хөгжүүлэх шаардлагыг бий болгож байна.

ОХУ-ын хил хамгаалалтын чиг хандлага

ОХУ нь дэлхийн хамгийн урт хуурай болон далайн хилтэй улс орнуудын нэг бөгөөд 60 мянга гаруй километр үргэлжлэх хил нь Европ, Ази, Арктик, Номхон далайн бүсийг хамардаг онцлогтой. Ийм өргөн уудам газар нутаг, олон улсын геополитикийн орчин нь ОХУ-ын хил хамгаалалтыг үндэсний аюулгүй байдлын стратегийн төв бүрэлдэхүүн хэсэг болгож байна. Сүүлийн жилүүдэд ОХУ-ын хил хамгаалалтын чиг хандлага нь цэрэг-стратегийн бэхжилт, технологийн шинэчлэл, төвлөрсөн удирдлагын тогтолцооны сайжруулалт, бүс нутгийн геополитикийн нөхцөл байдалтай уялдсан бодлогын шинжээр тодорхойлогдож байна.

ОХУ-ын хил хамгаалалтын байгууллага нь Холбооны аюулгүй байдлын алба (FSB)-ны харьяанд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хил хамгаалалт нь цэргийн болон аюулгүй байдлын нэгдсэн бүтэцтэй уялдсан байдаг. Энэ нь барууны олон улсын туршлагаас ялгаатай нь хил хамгаалалтыг иргэний бус, аюулгүй байдлын тусгай байгууллагын бүрэлдэхүүнд төвлөрүүлсэн тогтолцоог илэрхийлдэг. Сүүлийн жилүүдэд ОХУ нь хил хамгаалалтын хүчний бүтэц, техник хэрэгслийг шинэчилж, алслагдсан бүс нутгуудад дэвшилтэт тандалтын болон холбооны систем нэвтрүүлэхэд анхаарч байна.

Технологийн хувьд ОХУ нь хил орчмын бүс нутагт камерын сүлжээ, дулаан мэдрэгч, хөдөлгөөн илрүүлэгч систем, нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон), хиймэл дагуулын тандалт зэрэг олон төрлийн хяналтын хэрэгслийг ашиглаж байгаа бөгөөд ялангуяа баруун хилийн бүс, Украинтай хиллэх хэсэг, Кавказын бүс, Төв Азийн чиглэл, мөн Арктикийн бүсэд хяналтын дэд бүтцийг эрчимтэй сайжруулж байна. Арктикийн бүс нь ОХУ-ын хувьд стратегийн ач холбогдолтой тул мөсөн далайн бүсэд цэрэг-логистикийн болон хил хамгаалалтын шинэ байгууламжуудыг байгуулж байгаа нь геополитикийн өрсөлдөөнтэй шууд холбоотой.

ОХУ-ын хил хамгаалалтын нэг чухал чиг хандлага нь “гүнзгий хамгаалалт” буюу хилийн зурвасаас гадна дотоод бүс нутагт хяналт, шалгалтыг уялдуулан хэрэгжүүлэх явдал юм. Энэ нь хил хамгаалалтыг зөвхөн шугаман хамгаалалт гэж үзэхээс илүү өргөн хүрээний аюулгүй байдлын тогтолцоотой уялдуулах стратегийн хандлага юм. Ялангуяа хууль бус шилжилт хөдөлгөөн, зэвсэг болон хар тамхины хууль бус эргэлт, террорист бүлэглэлүүдийн нэвтрэлтийг таслан зогсоох чиглэлд хил хамгаалалт, дотоод аюулгүй байдал нягт уялдсан бүтэцтэй ажиллаж байна.

Мөн ОХУ нь Евроазийн эдийн засгийн холбоо болон бүс нутгийн хамтын ажиллагааны механизмын хүрээнд хил хамгаалалтын зохицуулалтыг сайжруулах бодлого баримталж байна. Зарим хөрш орнуудтай нээлттэй, хялбарчилсан дэглэм хэрэгжүүлж байгаа боловч стратегийн эрсдэлтэй бүс нутагт хатуу хяналтын бодлого хэрэгжүүлж байгаа нь аюулгүй байдлын ялгаатай хандлагыг илэрхийлж байна.

Сүүлийн үеийн геополитикийн нөхцөл байдал, ялангуяа Украинтай холбоотой зөрчил, барууны орнуудтай харилцаа хурцадсан байдал нь ОХУ-ын хил хамгаалалтын бодлогыг илүү цэрэг-стратегийн шинжтэй болгож, хил хамгаалалтын дэд бүтцэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Иймхүү ОХУ-ын хил хамгаалалтын чиг хандлага нь төвлөрсөн удирдлагын тогтолцоо, цэрэг-аюулгүй байдлын нэгдэл, технологийн шинэчлэл, геостратегийн[50] бодлоготой уялдсан, нэгдсэн систем, хил хамгаалалтын үзэл баримтлалд тулгуурлан тодорхойлогдож байна.

Иймхүү ОХУ-ын хил хамгаалалтын чиг хандлага нь төвлөрсөн удирдлагын тогтолцоо, цэрэг-аюулгүй байдлын уялдаа, технологийн шинэчлэл болон геостратегийн бодлоготой

Дүгнэж үзвэл, ОХУ-ын хил хамгаалалтын хөгжлийн чиг хандлага нь аюулгүй байдлын төвлөрсөн удирдлага, стратегийн бүс нутгийн бэхжилт, технологийн нэгдсэн систем, гүнзгий хамгаалалтын зарчим, геополитикийн нөлөөлөл зэрэг олон хүчин зүйлийн огтлолцолд тодорхойлогдож байгаа бөгөөд энэ нь Евроазийн бүс нутгийн аюулгүй байдлын орчинд чухал нөлөө үзүүлж байна.

БНХАУ-ын хил хамгаалалтын чиг хандлага

БНХАУ нь сүүлийн хоёр арван жилийн хугацаанд хил хамгаалалтын тогтолцоогоо уламжлалт цэргийн болон физик хяналтын загвараас мэдээлэл, дижитал технологид суурилсан, ухаалаг, нэгдсэн удирдлагын систем рүү үе шаттайгаар шилжүүлж байна.

Хятад улс 22,000 гаруй км хуурай газрын хил, өргөн уудам далайн бүс нутагтай тул хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлын стратегийн төв асуудалд

[50] Тайлбар: Геостратегийн (geostrategic) гэдэг нь газарзүйн байрлал, орон зай, нөөц, бүс нутгийн онцлогт тулгуурлан улс орон аюулгүй байдал, гадаад бодлого, цэргийн болон эдийн засгийн стратегиа тодорхойлохтой холбоотой ойлголт.

тооцогддог. Иймээс хил хамгаалалтын бодлого нь батлан хамгаалах, дотоод аюулгүй байдал, эдийн засгийн хөгжил, бүс нутгийн тогтвортой байдалтай уялдсан цогц шинжтэй хэрэгжиж байна.

БНХАУ-ын хил хамгаалалтын хөгжлийн нэг онцлог чиг хандлага нь "ухаалаг хил" (Smart Border) буюу дижитал хяналтын системийг өргөн нэвтрүүлэх явдал юм. Хил орчмын бүс нутагт өндөр нягтаршилтай камерын сүлжээ, нүүр таних систем, биометрийн бүртгэл, автомат шалган нэвтрүүлэх төхөөрөмж, хөдөлгөөн илрүүлэгч мэдрэгчүүдийг нэвтрүүлж, бодит цагийн мэдээллийг төвлөрсөн удирдлагын системд нэгтгэх бодлого хэрэгжүүлж байна. Ялангуяа Шиньжян, Төв Азийн чиглэл, Өмнөд Хятадын тэнгисийн бүсэд дижитал хяналтын дэд бүтэц эрчимтэй хөгжсөн нь технологид суурилсан хил хамгаалалтын стратегийг илтгэнэ.

Нөгөө талаас БНХАУ нь эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналтын тогтолцоог хөгжүүлж, зорчигч, ачаа, хил орчмын хөдөлгөөний мэдээллийг урьдчилан шинжилж, өндөр эрсдэлтэй үйл ажиллагаанд чиглэсэн хяналт хэрэгжүүлэх бодлогыг баримталж байна. Энэ нь бүх урсгалыг ижил түвшинд шалгах уламжлалт аргаас илүү оновчтой, нөөцийн үр ашигтай хуваарилалтыг хангах зорилготой юм.

БНХАУ-ын хил хамгаалалтын тогтолцооны бас нэгэн онцлог нь олон агентлагийн нэгдсэн удирдлагын загвар юм. БНХАУ-д 2018 оны институцийн шинэчлэлийн хүрээнд Хятадын Ардын Зэвсэгт Цагдаагийн Хүчний харьяанд байсан хил хамгаалалтын бүтэц Нийгмийн аюулгүй байдлын яаманд шилжиж, улмаар иргэний болон цэргийн зохицуулалт уялдсан, нэгдсэн хяналт, удирдлагын тогтолцоо бүрдсэн. Энэ өөрчлөлт нь хил хамгаалалтыг цэргийн давамгайлалтай тогтолцооноос иргэний удирдлагатай боловч төвлөрсөн, хатуу зохион байгуулалттай систем рүү шилжүүлсэн стратегийн алхам болсон.

Мөн БНХАУ нь хил хамгаалалтыг зөвхөн хилийн шугамд төвлөрүүлэх бус, "урьдчилан сэргийлэх гүнзгий бүсийн хамгаалалт" (depth security) гэсэн зарчмыг баримталж, хил орчмын бүс нутаг, тээврийн зангилаа, хот сууринд хүртэл хяналтын системийг өргөжүүлж байна. Энэ нь хил хамгаалалт, дотоод аюулгүй байдлын уялдаа холбоог бэхжүүлсэн бодлогын илэрхийлэл юм.

Далайн хил хамгаалалтын хувьд БНХАУ нь эргийн хамгаалалтын хүчин, тэнгисийн тандалтын систем, хиймэл дагуулын хяналтыг ашиглан Өмнөд Хятадын тэнгис болон Зүүн Хятадын тэнгисийн бүсэд стратегийн байр сууриа бэхжүүлж байна. Далайн хил хамгаалалт нь зөвхөн хууль сахиулах үйл ажиллагаа бус, геополитикийн ач холбогдолтой бодлогын хэрэгсэл болж өргөжсөн байна.

Гэсэн хэдий ч БНХАУ-ын технологид суурилсан хил хамгаалалтын тогтолцоо нь хувийн мэдээллийн хамгаалалт, хүний эрх, хяналтын хэт төвлөрөл зэрэг олон улсын түвшинд маргаан дагуулж буй асуудлуудтай тулгарч байна. Иймээс БНХАУ-ын хил хамгаалалтын хөгжлийн чиг хандлага нь технологийн эрчимтэй шинэчлэл, төвлөрсөн удирдлагын систем, аюулгүй байдлын өргөтгөсөн мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах, геостратегийн бодлоготой уялдсан онцлог шинжээр тодорхойлогдож байна.

Дүгнэлт

Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад хил хамгаалалт нь зөвхөн хилийн шугамын хяналтаар хязгаарлагдахгүй, харин стратегийн түвшний аюулгүй байдлын нэгдсэн бодлогын нэг хэсэг болон хөгжиж, "ухаалаг хил" буюу дижитал технологи, автоматжуулалт, мэдээлэлд суурилсан эрсдэлийн удирдлагад тулгуурласан тогтолцоонд шилжиж байна. Ялангуяа ОХУ болон БНХАУ-ын жишээнээс төвлөрсөн удирдлага, технологийн шинэчлэл, геостратегийн бодлоготой уялдсан хил хамгаалалтын систем нь орчин үеийн чиг хандлагыг тодорхойлж байгааг харж болно.

Монгол Улсын хувьд газар зүйн онцлог, өргөн уудам нутаг дэвсгэр, дэд бүтцийн хязгаарлагдмал байдал, мөн хоёр хөрш их гүрэнтэй хиллэдэг стратегийн нөхцөл нь хил хамгаалалтыг үндэсний аюулгүй байдлын тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж байна. Сүүлийн жилүүдэд технологийн шийдэл, дохиолол, хяналтын систем, удирдлагын төвийн шинэчлэлийн хүрээнд тодорхой ахиц гарсан хэдий ч дижитал дэд бүтэц, мэдээллийн нэгдсэн систем, хүний нөөцийн чадавх, технологийн бие даасан байдал зэрэг асуудлууд нь цаашид шийдвэрлэх шаардлагатай хэвээр байна.

Иймээс Монгол Улсын хил хамгаалалтын хөгжлийн дараагийн шат нь мэдээлэлд суурилсан эрсдэлийн үнэлгээ, нэгдсэн команд удирдлагын тогтолцоо, дижитал дэд бүтцийн өргөтгөл, хүний нөөцийн мэргэшлийг уялдуулан хөгжүүлэхэд чиглэсэн цогц стратегийг хэрэгжүүлэхэд оршино. Энэхүү хөгжлийн чиглэл нь хил хамгаалалтыг зөвхөн хамгаалалтын үйл ажиллагаанаас давуулан үндэсний аюулгүй байдлын стратегийн удирдлагын цогц тогтолцоо болгон шинэ шатанд гаргах суурь нөхцөлийг бүрдүүлэх юм.

Эх сурвалжийн жагсаалт

Арвай, Ш. (2024). *Аюулгүй байдлыг нь чандлан хангаваас бидний эх орон мөнх оршино.*

Асхар, Х. (2024). *Хилийн боомтын үйл ажиллагааны онол, практикийн асуудал* .

Дашдаваа, Д., Ганболд , Ц., & Муратхан, А. (2024). *Хилийн аюулгүй байдал* .

Наранжамц, Н. (2024). *Бүс нутаг-Хил хамгаалалтын үзэл баримтлал.*

Онцгойбаяр, Л. (2025). *Их гүрнүүдийн цэргийн номлол, цэргийн стратеги, батлан хамгаалах стратеги, үзэл баримтлал.*

Онцгойбаяр, Л. (2028). *Оперативын урлагийн хөгжлийн чиг хандлага* .

Чулуунхүү, Ч. (2024). *"Улсын хил хамгаалалтад тулгамдаж буй асуудлууд" сэдэвт эрдэм шинжилгээний хурал.*

Энхжаргал, Ц. (2021). *Улсын хилийн тайлбар толь* .

Цэдэнбал, Т. (2020). *Монгол Улсын хил хамгаалалтын байгууллагын удирдлага ба зохион байгуулалтын асуудал* [Master's thesis].

Andreas, P. (2003). Redrawing the line: Borders and security in the twenty-first century. *International Security, 28*(2), 78–111. https://doi.org/10.1162/016228803322761964

Bigo, D. (2014). The (in)securitization practices of the three universes of EU border control. *Security Dialogue, 45*(3), 209–225.

European Commission. (2022). *Smart Borders Package: Entry/Exit System (EES) and ETIAS*.

Frontex. (2023). *Annual Risk Analysis 2023*.

Guild, E., Carrera, S., & Eisele, K. (2015). *Smart borders and mobility*. CEPS.

Lutterbeck, D. (2006). Policing migration in the Mediterranean. *Mediterranean Politics, 11*(1), 59–82.

United Nations Office on Drugs and Crime. (2022). *Transnational organized crime and border security*.

United States Department of Homeland Security. (2023). *Border security strategy*.

World Customs Organization. (2021). *SAFE Framework of Standards to Secure and Facilitate Global Trade*.

Zaiotti, R. (2016). *Externalizing migration management: Europe and the United States*. Routledge.

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД НИСГЭГЧГҮЙ НИСЭХ ХЭРЭГСЛИЙН ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ ТЕХНОЛОГИЙН ГАРЦ

Ш.УНДАРГА*
Хилийн албаны сургуулийн Инженер, техникийн тэнхимийн ахлах багш, хошууч

**хариуцлагатай зохиогч: undakadnu@gmail.com*

Хураангуй: Технологийн хурдацтай хөгжлийн нөлөөгөөр нисгэгчгүй нисэх хэрэгсэл (ННХ)-ийн үйлдвэрлэлийн зардал буурч, ННХ-ийн хэрэглээ тархац эрс нэмэгдэж байна.

Энэхүү нөхцөл байдлаас улс дамнасан гэмт хэрэг, хорлон сүйтгэх ажиллагаа, хууль бус тагнуул болон хилийн зөрчилд ННХ-ийг ашиглах явдал түгээмэл болж байна.

Манай улсын хил уртын зэрэгцээ радарын хяналтын систем, ННХ эсэргүүцэх хэрэгсэл, систем бараг байхгүй байгаа нь өнөөгийн нөхцөлд ННХ-ийг илрүүлэх, саатуулах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх асуудал нэн тулгамдсан сорилт болж байна. Энэхүү өгүүлэлд хилийн хэсэгт радио давтамж (RF) болон оптик мэдрэгчид суурилсан "Зөөлөн саатуулах" (Soft Kill) аргыг хилийн хамгаалалтад нэвтрүүлэх техникийн боломж, эрх зүйн шийдлийг эрэлхийллээ.

Түлхүүр үг: *Нисгэгчгүй нисэх хэрэгсэл, C-UAS, Радио давтамж саатуулагч, Хилийн аюулгүй байдал, Идэвхгүй илрүүлэлт.*

1. Удиртгал

Сүүлийн жилүүдэд дэлхийн хэмжээнд дроны технологи иргэний болон цэргийн салбарт үсрэнгүй хөгжиж, байлдааны ажиллагаанаас өгсүүлээд хоол хүргэлтэд хүртэл ашиглаж байна. Гэвч энэхүү давуу талыг ашиглан улсын хилээр хориотой эд зүйлс (хар тамхи, үнэт металл г.м) нэвтрүүлэх, хилийн дэглэм зөрчин тагнуулын шинжтэй мэдээлэл цуглуулах тохиолдол нэмэгдэх хандлагатай байна.

Монгол Улсын хувьд 8252.6 км үргэлжлэх улсын хилийг бүрэн радарын системээр хянах нь эдийн засаг болон дэд бүтцийн хувьд хүндрэлтэй юм. Иймд уламжлалт бус аргаар буюу "ухаалаг" технологиор ННХ-ийг илрүүлэх, саатуулах шаардлага тулгарч байна.

Манай улсын хилийн нөхцөл байдлын шинжилгээ ба сорилтууд

Манай улс хил хамгаалалтад ННХ-ийг эсэргүүцэхэд дараах үндсэн саад бэрхшээлүүд байна. Үүнд:

1. **Радарын хомсдол:** манай улсад зэвсэгт хүчинд одоогийн ашиглагдаж буй агаарын довтолгооноос хамгаалах радарууд нь өндөрт нисэж буй томоохон биет, агаарын хөлгүүдийг илрүүлэх зориулалттай бөгөөд нам өндөрт, бага хурдтай нисэж буй иргэний зориулалттай жижиг овортой нисэх хэрэгслүүдийг "байгалийн шуугиан" (шувуу, салхи) гэж үзэн ялгаж чадахгүй, эсхүл илрүүлэхгүй байна.
2. **Эсэргүүцэх хэрэгслийн хомсдол:** Хилчдэд үүрэг гүйцэтгэхэд хүч нэмэгдүүлэх хэрэгслийн тоонд ННХ эсэргүүцэгч ордоггүй, эсхүл ННХ эсэргүүцэх хэрэгслийн сум хэрэгслийг ашиглан зогсоох үйлдэл хийгээд амжилтгүй болсон тохиолдолд сум хэрэгслийг буруу зарцуулсан гэх шалтгаанаар эргэн хариуцлага тооцогдохоос эмээх асуудал үүсдэг.

3. **Газар нутгийн онцлог:** Уулархаг болон алслагдсан бүсүүдэд эрчим хүч, холбооны дэд бүтэц сул байгаа нь суурин системүүд байршуулахад саад болдог бөгөөд манай улсын эдийн засгийн хувьд өртөг өндөр байна.
4. **Дохионы илрүүлэлт:** Иргэний дронууд ихэвчлэн 2.4GHz болон 5.8GHz нээлттэй давтамж ашигладаг нь иргэний холбооны хэрэгслүүдтэй давхцдаг тул тэдгээрийг ялган саатуулахад нарийн технологи шаардлагатай.

Гурав. Технологийн шийдэл: Радаргүйгээр илрүүлэх ба саатуулах

Радарын системийг орлох хамгийн боломжит хувилбар нь **Идэвхгүй илрүүлэлт (Passive Detection)** болон **Радио долгионы саатуулагч (RF Jamming)** юм.

3.1. RF Анализатор ба Сканнерт суурилсан илрүүлэлт: Дрон болгон удирдлагатайгаа холбогдохын тулд радио долгион цацдаг. Хилийн зөрчил гарч болзошгүй биглэлүүдэд RF сканнер байршуулснаар 3-5 км-ийн радиуст нэвтэрсэн дроны дохиог замаас нь барьж авах боломжтой. Энэ нь радараас бага өртөгтэй бөгөөд цахилгаан зарцуулалт багатай гэдгээрээ давуу талтай.

3.2. Оптик болон дулааны хяналт: Хэт улаан туяаны (Thermal) камерууд нь дроны хөдөлгүүр /сэнсний ротор/-ээс гарч буй дулааныг өдөр шөнийн аль ч цагт илрүүлэх бүрэн боломжтой. Энэ нь RF сканнераар илрүүлсэн биетийг "дрон мөн" болохыг нь давхар баталгаажуулах нөхцлийг бүрдүүлнэ.

3.3 Ухаалаг саатуулалт (Smart Jamming):

Хил давсан дрон руу чиглүүлэн радио долгионыг нь таслах замаар түүнийг "Fail-safe" горимд оруулна. Ингэснээр дрон хөөрсөн цэг рүүгээ буцах эсвэл шууд газардах нөхцөл бүрддэг. Энэхүү аргын давуу тал нь тухайн ННХ-ийг устгахгүй зөвхөн ажиллагааг нь саатуулан унагаах тул дараа нь тухайн дроны санах ойгоос мэдээлэл авч, эзэн холбогдогчийг тогтоох боломжийг олгоно.

4. Эрх зүйн зохицуулалт ба практик хэрэглээ

Технологи байвч эрх зүйн орчин тодорхойгүй бол хилийн манаа дрон руу гал нээх эсвэл саатуулагч ашиглах нь эрсдэлтэй. Иймд:

- Монгол Улсын Хилийн тухай хуульд "Хил зөрчигч ННХ"-ийг тодорхойлж, түүнийг электрон аргаар саатуулах эрх зүйн чадамжийг хилийн цэрэгт олгох.
- Хил орчмын бүсийг "Дрон нисэхийг хориглосон бүс" (No-Fly Zone) болгон зарлаж, энэ бүсэд орсон аливаа хэрэгслийг шууд саатуулах эрхийг олгох.

5. Дүгнэлт ба санал

Монгол Улсын хилийн аюулгүй байдалд ННХ-ийн учруулах аюул занал бодитой болоод байна. Радарын систем ашиглах боломж хязгаарлагдмал байгаа өнөөгийн нөхцөлд дараах арга хэмжээг авахыг санал болгож байна:

1. Хилийн шалган нэвтрүүлэх болон стратегийн чухал цэгүүдэд **RF-д суурилсан идэвхгүй илрүүлэгч** ба **чиглэлт саатуулагч (Jammer)** бүхий цогцолбор, багажийг туршилтаар нэвтрүүлэх.
2. Хилчид, алба хаагчдыг дроныг таних, түүнтэй тэмцэх техникийн мэдлэгээр хангах, сургалт зохион байгуулах.
3. ННХ-ийг саатуулах явцад олж авсан мэдээллийг (GPS лог, видео бичлэг) гэмт хэргийн нотлох баримт болгон ашиглах арга зүйг боловсруулах.

Энэхүү судалгаа нь манай улсын хил хамгаалалтын практикт шинэ үеийн технологийн шийдлийг нэвтрүүлэх онолын үндэслэл болно гэж үзэж байна.

НИСГЭГЧГҮЙ НИСЭХ ТӨХӨӨРӨМЖИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ БА ОЛОН УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД АШИГЛАГДСАН БАЙДАЛ

Б.ЦОЛМОН*
Дотоод хэргийн их сургуулийн Сургалтын газрын Гадаад хэлний институтийн ахлах багш, ахлах дэслэгч
**Хариуцлагатай зохиогч: tsoomoo102baatar@gmail.com*

Хураангуй: Техник технологи, хиймэл оюун ухааны хөгжлийн эрин үед олон улсын хэмжээнд улсын хил хамгаалалтад ашиглагдаж буй нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн талаарх гадаад орны жишээг судлах зорилгоор баримт бичгийн судалгаа хийсэн болно. Улсын хил хамгаалалт болон хилийн удирдлага, менежментэд технологийн дэвшлүүдийг ялангуяа нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг нэвтрүүлэх нь зөвхөн аюулгүй байдлыг сайжруулахад сайнаар нөлөөлөхөөс гадна олон улсын худалдаа, аялал жуулчлалын хөгжлийг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг тэтгэх чухал хөшүүрэг болохыг судалгааны үр дүн харуулж байна. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж нь улсын хилийн хамгаалалт ба удирдлагын үйл ажиллагааг үр ашигтайгаар зохион байгуулах, хил орчмын бүс нутагт бодит цагийн хяналт тавих, гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, яаралтай хариу арга хэмжээ авахад зориулагдсан технологийн дэвшилтэт төхөөрөмж учраас улсын хил хамгаалалтад түлхүү хэрэглэх хэрэгтэй гэж дүгнэлээ.

Түлхүүр үгс: нисгэгчгүй нисэх төхөөрөмж, дрон, хил хамгаалалт, технологи

Анхны нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг /ННТ/1916-1917 онд дэлхийн 1-р дайны үеэр Британи болон АНУ цэргийн зорилгоор туршиж эхэлсэн. *Тухайлбал,* “Kettering Bug” гэх төхөөрөмж нь АНУ-д үйлдвэрлэгдсэн анхны нисгэгчгүй пуужингийн төрлийн төхөөрөмж байв. 1940-өөд онд Дэлхийн 2-р дайны үед Германы V-1 пуужинг нисгэгчгүй зэвсгийн анхны жишээнд тооцдог. 1950-1980-аад оны хүйтэн дайны үед АНУ, ЗХУ тагнуулын зориулалтаар ННТ-ийг хөгжүүлж эхэлсэн бөгөөд тухайн үед АНУ-ын Ryan болон Firebee зэрэг загваруудыг ашиглаж байсан байна. 1990-ээд оноос хойш GPS, хиймэл дагуулын технологи, хөнгөн материал, автомат удирдлагын системүүдийг хөгжүүлснээр ННТ-ийн хэрэглээ эрчимтэй өссөн. АНУ Ирак болон Афганистанд MQ-1 Predator, MQ-9 Reaper зэрэг дроныг 2000-аад онд тагнуул хийх, бай онох зориулалтаар өргөн ашигласан ба 2020 оноос хойш иргэний хэрэглээ, хөдөө аж ахуй, хүргэлт, барилга, аврах ажиллагаа зэрэг олон салбарт ННТ буюу дроныг өргөнөөр ашиглаж байна. Жишээлбэл:

1. Цэргийн хэрэглээнд

- Тагнуул, ажиглалт хийх
- Зорилтот бай онох
- Алсаас удирдах довтолгоо (жишээ нь: MQ-9 Reaper)



Зураг 1. MQ-9 Reaper - нисгэгчгүй нисэх төхөөрөмж[51]

2. Аврах ажиллагаа, байгалийн гамшиг

- Хүн хүрэх боломжгүй газарт ослын хохирол үнэлэх, эрэн хайх ажиллагаа хийх

Жишээлбэл: Япон улсад 2011 онд болсон цунамигийн дараа дроныг ашиглан нурсан барилгын үлдэгдлийг шалгаж, хүний амь аврахад ашигласан байна.

3. Нийтийн аюулгүй байдал, хууль сахиулах байгууллага

- Олон нийтийн цуглаан хянах, гэмт хэрэг илрүүлэх, замын хөдөлгөөний хянах гэх мэтээр цэрэг, цагдаагийн байгууллагуудад ашиглагдаж байна.

Нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг түүний ашиглалтын зориулалт, хиймэл дагуултай холболдсон эсэх, нисэх хурд, нисэх хугацаа болон нисэх өндөрт үндэслэсэн дараах байдлаар ангилсан байдаг. Үүнд:

1. Нисэх хугацаанд үндэслэсэн (Endurance-based Classification)

- Short Endurance UAVs:Эдгээр ННТ-үүд нь ерөнхийдөө богино хугацааны нислэгийг гүйцэтгэх зориулалттай. Эдгээр нь жижиг, хөнгөн, хурдтай бөгөөд мэдрэгчийн болон камерын системтэй байдаг.
- Medium Endurance UAVs:Дунд хугацааны ННТ нь бага зэрэг илүү зайд нисэх боломжтой бөгөөд ихэвчлэн хөдөө аж ахуй, орчны байдалд хяналт тавих, улсын хил хамгаалалт болон эрэн хайх ажиллагаанд ашиглагддаг
- Long Endurance UAVs:Эдгээр ННТ нь олон цагийн турш нисэх чадвартай бөгөөд ихэвчлэн стратегийн мониторинг, ажиглалт, цаг уурын мэдээлэл цуглуулах зэрэг томоохон төсөлд ашиглагддаг

2. ***Нисэх өндөрт үндэслэсэн (Altitude-based Classification)***

- Low Altitude UAVs:Эдгээр ННТ-үүд нь газрын гадаргаас 500 м-ээс доош нисэх бөгөөд ихэвчлэн жижиг хэмжээний камер, мэдрэгчүүдээр тоноглогдсон байдаг
- Medium Altitude UAVs:Эдгээр ННТ-үүд нь 500 м-ээс 10,000 м хүртэлх өндөрт нисэх чадвартай бөгөөд дунд болон холын зайн хяналттай нислэгийн үйл ажиллагаанд ашиглагддаг
- High Altitude UAVs:Өндөрт нисэх ННТ-үүд нь 10,000 м-ээс дээш өндөрт нисэх чадвартай бөгөөд ихэвчлэн орон нутгийн болон дэлхийн хэмжээний ажиглалт, сүлжээний мониторинг, агаарын хяналтад хэрэглэгддсэг байна.

3. ***Зориулалтын дагуу (Application-based Classification)***

[51] www.google.com

• Surveillance UAVs: Эдгээр ННТ-үүд нь өндөр нарийвчлалтай камер болон мэдрэгчүүдээр тоноглогдсон бөгөөд дронуудын гол хэрэглээ нь хяналт тавих, хулгайчдыг илрүүлэх болон зорилтот бүс нутгийн аюулгүй байдлыг хангах явдал юм.

• Delivery UAVs: Эдгээр ННТ-үүд нь ачаа тээвэрлэх зориулалттай бөгөөд өндөр хурдтай, багтаамж сайтай, жижиг сав баглаа боодол болон хоол хүнс түгээх зориулалттай байдаг.

• Search and Rescue UAVs: Эдгээр ННТ-үүд нь онцгой байдлын үед ашиглагддаг бөгөөд бие даасан нислэгээр эрэн хайх ажиллагаа явуулах, амьтны болон хүний эрэн хайх болон гамшгийн хариу үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг

4. Техникийн үндэслэл (Technological Classification)

• Fixed-wing UAVs: Эдгээр ННТ-үүд нь хурдтай, холын зайнд нисэх чадвартай бөгөөд ихэвчлэн стратегийн ажиглалт, дэлхийн хэмжээний мониторинг хийхэд ашиглагддаг.

• Rotary-wing UAVs: Эдгээр нь орон нутгийн хяналт, жижиг талбайн хяналтыг хийхэд тохиромжтой бөгөөд байршлаа хадгалах чадвар нь өндөр байдаг.

• Hybrid UAVs: Эдгээр ННТ-үүд нь нисэх болон газраар явах чадвартай хосолсон төхөөрөмжүүд бөгөөд орон нутгийн болон аюултай бүсүүдийн хяналт, эрэн хайх ажиллагаанд ашиглагддаг

Сүүлийн жилүүдэд нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг олон төрлийн судалгааны байгууллагууд технологи, түүний хэрэглээ, хөгжлийг судалж, тогтмол хөгжүүлэлт хийсээр ирсэн. Тэдгээрээс дурьдвал:

1. NASA (National Aeronautics and Space Administration) -АНУ-ын сансар судлалын байгууллага бөгөөд агаарын судалгаа, сансар судлал, нисэх технологи, автомат системийн талаар дэлхийд тэргүүлэгч судалгаа явуулдаг бөгөөд нисэх үеийн аюулгүй байдал, нислэгийн тогтвортой байдал, агаарын замын удирдлага зэрэгт түлхүү судалгаа явуулдаг.

2. ***MIT (Massachusetts Institute of Technology)*** дэлхийд хамгийн шилдэг инженерчлэлийн сургалттай байгууллагуудын нэг бөгөөд дрон болон бусад автомат удирдлагатай системийн судалгааг өндөр түвшинд явуулдаг. Массачусэтсийн технологийн институт нь CSAIL (Computer Science and Artificial Intelligence Laboratory) буюу Компьютерын шинжлэх ухаан ба хиимэл оюуны лабораторидоо дронуудын хамтран ажиллагаа (Swarming) болон бие даасан навигаци (Autonomous navigation) -ийн талаар өргөн хэмжээний судалгаа явуулдаг бөгөөд цаашид дронуудын хараа, мэдрэгчийн системийн нарийвчлалыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

3. DARPA (Defense Advanced Research Projects Agency) АНУ-ын Батлан хамгаалахын хөгжүүлэлтийн агентлаг нь нислэгийн аюулгүй байдал, нисэх үеийн хэвийн ажиллагааг хангах технологиудыг судалдаг. Мөн дронуудын олон төрлийн ашиглалтыг цэрэг, тагнуул, тээвэрлэлт, харилцаа холбоо зэрэг салбарт шинээр хөгжүүлэх зорилго тавьдаг. DARPA-ийн “Gremlins” төсөл нь хэд хэдэн дронуудыг нэгэн зэрэг удирдах боломжийг судалж буй төсөл юм.

4. Европын Сансар Судлалын Агентлаг (ESA) - Европын холбооны сансар судлалын агентлаг дронуудын агаарын хяналт, тусгай зориулалтын мэдрэгч төхөөрөмжүүдийг хөгжүүлдэг. Sentinel-1, Sentinel-2 зэрэг ESA-ийн Хавтгай зураглал буюу *earth observation satellite*-ууд нь дрон болон хиймэл дагуулын технологийг хослуулан хэрэглэгддэг.

5. European Union Aviation Safety Agency (EASA)-Европын холбооны агаарын тээврийн аюулгүй байдал хариуцсан байгууллага нь дронуудын нислэгийн аюулгүй байдал болон цаг уурын нөлөөлөл зэргийг судалдаг. EASA-ийн дроны хөтөлбөр нь

иргэний дронуудын нислэгийн эрх зүйн зохицуулалт, аюулгүй байдлын шаардлагыг тогтоодог бөгөөд цаашид Европын дроны зах зээлийн зохицуулалт болон дронуудын аюулгүй ажиллагааг хангасан шинэ хууль тогтоомжийг баталж, өргөжүүлэхэд анхаарч ажилладаг.

Судлаач Мартин Пласекийн 2024 онд гаргасан судалгаанаас үзэхэд арилжааны дрон буюу нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн зах зээл 2025 он гэхэд ойролцоогоор 13 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй гэж таамаглал дэвшүүлж байсан байна. Одоогийн байдлаар жижиг хэмжээтэй ННТ-ийн арилжааны үйлдвэрлэл 58.4 сая ам.доллароор үнэлэгдэж байна.

DroneSec компанийн 2022 оны тайланд дронтой холбоотой ослын тоо 2021 оныхоос 60% өссөн[52] бөгөөд 2022 онд 2,554 ослыг бүртгэсэн бөгөөд энэ нь өдөрт ойролцоогоор 7 осол болсон гэсэн үг юм. Ослын шалтгааныг дроны үйл ажиллагаа эрхэлдэг үйлдвэрлэгч нарын технологийн доголдол болон гэмт хэргийн тоо өссөнтэй холбоотой гэж үзжээ. Тухайлбал:

- Дронтой холбоотой нийт ослын тоо 60% өссөн
- Орон сууцанд гарсан осол 140% өссөн
- Орон нутагт гарсан осол 130% өссөн
- Засгийн газар болон чухал дэд бүтцэд гарсан осол 100% өссөн
- Хилийн бүс нутагт гарсан осол 50% өссөн
- Шоронд хийсэн хүргэлт 40% өссөн
- Аэродромд гарсан осол 30% өссөн байна.

Мөн дээрх судалгааны үр дүнд дронуудын хамгийн их осолд орсон загваруудыг тодорхойлсон байна. Үүнд:

- DJI Mavic 2
- DJI Phantom 4
- DJI Mavic 3 нар тэргүүлсэн байна.

Улсын хил хамгаалалтад технологи нэвтрүүлэх нь зөвхөн аюулгүй байдлыг сайжруулаад зогсохгүй, хууль ёсны худалдаа, аялал жуулчлалыг дэмжин, эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, аюулгүй байдлын сорилтуудыг хамтран шийдвэрлэх олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлдэг бөгөөд технологи хилийн удирдлага менежментэд нэвтэрснээр аюулгүй байдлын арга хэмжээний үр нөлөө мэдэгдэхүйц нэмэгддэг гэдгийг судлаачид тодорхойлжээ. Жишээлбэл: Судлаач Нноли - мэдээлэл хуваалцах платформууд болон урьдчилан таамаглах аналитик технологиуд нь эрсдэлийн үнэлгээг сайжруулж, эрх баригчдад аюулгүй байдлын заналхийллийг урьдчилан илрүүлэн, хариу арга хэмжээ авах боломж олгодог (Nnoli, 2006). Судлаач Маррисон - Технологи нь хилийн удирдлагын үр нөлөөг сайжруулж, аюулгүй байдлын арга хэмжээг бэхжүүлэхийн зэрэгцээ бараа, хүмүүсийн хил нэвтрэх хөдөлгөөнийг хөнгөвчилдөг (Marrison нар, 2015). Судлаач Оланрэважу - Автоматжуулсан хилийн хяналтын систем, биометрийн таних хэрэгсэл зэрэг дэвшилтэт технологиуд нь аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэхээс гадна хилээр нэвтрэх урсгал болон худалдааны үйл ажиллагааг хурдасгахад ашиглагддаг. Олон улсын харилцаа, худалдаа, энх тайван ба аюулгүй байдлын хөгжилд эергээр нөлөөлдөг (Olanrewaju, 2015).

Дэлхийн олон улс орнуудын хувьд нисгэгчгүй нисэх төхөөрөмж /дрон/-ыг улсын хил хамгаалалт болон хилийн шалган нэвтрүүлэх ажиллагаанд амжилттай хэрэгжүүлсэн олон жишээнүүд байдаг бөгөөд тэдгээрээс дурдвал:

- БНХАУ- Үндэсний хил хамгаалалтын болон цагаачлалын алба (NBIS)-ийн нисгэгчгүй нисэх төхөөрөмж /дрон/-ыг ашигладаг бөгөөд цаашид дроны үр ашгийг болон аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн хөгжүүлэлтийг хийхээр ажиллаж байгаагаа танилцуулсан байна. Жишээ нь: радарыг мэдрэгчтэй нэгтгэх нь тухайн нөхцөл байдлыг ойлгох болон зохицуулалтыг сайжруулахад туслах болно гэж үзжээ.
- Европын Холбоо нь тэнгисийн агаарын хяналт (MAS)-ыг хэрэгжүүлэхэд нисгэгчгүй нисэх төхөөрөмж /дрон/-ыг ашиглан, тэнгисийн хил дээрх видео болон бусад өгөгдлийг шууд Варшав дахь штаб, Үндэсний болон Европын эрх баригчдад дамжуулдаг байна. Хилийн бүс нутагт учирч болох аюул болон хилийн зөрчилд бодит цагийн хяналт тавих, хурдан хариу үйлдэл хийх боломжийг олгодог (Frontex, n.d.). Сүүлийн жилүүдэд ЕХ-ын хилийг цэргийнжүүлэх зорилгоор нисгэгчгүй нисэх төхөөрөмж /дрон/-ыг түлхүү ашиглах болсон (Statewatch, 2022).
- АНУ-ын Конгресс хил хамгаалалтыг урт хугацааны туршид тэргүүлэх ач холбогдолтой асуудал гэж үзсээр ирсэн. АНУ-ын эх газрыг Канадтай зааглах хойд хил нь нийт 4,121 милийн урттай бөгөөд 430 албан ёсны болон албан бус нэвтрэх цэгтэй. Хилийн өргөн уудам байдал болон хүн амьдардаггүй бүс нутгаар дамжин нэвтрэх боломж нь уг хилийг хянахад хүндрэл учруулдаг бөгөөд 2003 оны долдугаар сард АНУ-ын Гааль болон Хилийн хамгаалалтын газрын (CBP) комиссар Роберт Боннер Канадын хилийн дагуу 375 нэмэлт хилийн харуулыг шилжүүлэн байрлуулах болсноо мэдэгдсэн. Үүний үр дүнд нийт 1,000 хилийн харуул уг хилийн бүсэд ажиллах болсон. АНУ-ыг Мексиктэй зааглах өмнөд хил нь 2,062 милийн урттай бөгөөд 30 албан ёсны боомт болон “тоо томшгүй олон албан бус гарц”-аас бүрддэг. Хойд хилтэй харьцуулахад, 2003 оны нэгдүгээр сарын байдлаар өмнөд хил дээр 10,000 гаруй хилийн харуул ажиллаж байсан байна. Ийм олон ажилтантай, харьцангуй богино хилтэй ч гэлээ, хууль бус хил нэвтрэлт, хар тамхи хууль бусаар оруулж ирэх үйл ажиллагаа байнга гарсаар байсан байна. АНУ-ын хилийн хамгаалалтыг зөвхөн хилийн харуулууд гүйцэтгэдэггүй бөгөөд мөн видео камер, газар доорх мэдрэгч, физик хаалт, хуурай газрын тээврийн хэрэгсэл, нисэх онгоц зэрэг олон төрлийн техник хэрэгсэл ашиглан хянаж хамгаалдаг. АНУ-ын хил хамгаалалтын энэхүү олон талт стратеги нь террорист халдлага, хар тамхины наймаачид, зэвсгийн наймаачид болон хүний наймаачдын олон төрлийн аюулаас хамгаалахад зориулагдсан. Батлан хамгаалах яам 2003 оны арваннэгдүгээр сарын 24-нд албан ёсоор P.L.108-354-ыг нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг ашиглах болсноо зарласан бөгөөд Батлан хамгаалах яамны зөвшөөрлийн тухай хуулийн 1034-р хэсэгт “Эх орныхоо аюулгүй байдлын төлөө үүрэгтэй нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV) ашиглах тухай” тайлан гаргахыг шаарддаг байна.

Хэлэлцүүлэг

Хилийн удирдлагад технологи нэвтрүүлэх нь орчин үеийн аюулгүй байдлын арга хэмжээг эрс сайжруулахад үндсэн суурь үзэл баримтлал болж байна. Судлаачид нисгэгчгүй нисэх төхөөрөмжүүд (дрон) зэрэг дэвшилтэт технологиудыг ашиглан хууль бус цагаачлал, хил дамнасан гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх боломжтойг онцлон тэмдэглэж байгаа нь сайшаалтай боловч технологи нь техникийн саатал, гэмтэл, осолд орох тоо зэрэг сөрөг үр дагавартай гэдгийг тооцоолон хэрэглэх хэрэгтэй. Гэвч нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн технологийн хөгжил тасралтгүй өндөр хөгжилтэй орнуудын цэргийн байгууллагуудад тогтмол хийгдэж байгаа нь сайшаалтай байна. Дэлхий дахинд олон улс орнууд энэ төрлийн технологийг улсын хил хамгаалалтад амжилттай хэрэгжүүлж, хяналтын үйл ажиллагааг сайжруулж

байгаа тул тэдгээрийн туршлагыг улам гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ урган гарч ирж байна.

Дүгнэлт

Технологийн дэвшил улсын хил хамгаалалт болон удирдлага, менежментэд томоохон шинэчлэлт авчирч, аюулгүй байдлын түвшинг сайжруулж байна. Уламжлалт хяналтын арга хэмжээнүүдтэй харьцуулахад дрон нь хилийн хяналтыг хурдан, үр ашигтай, бодит цагт мэдээллээр хангах чадвартай байгаа нь хилийн бүсэд учирч болох аюул заналыг урьдчилан илрүүлэхээс гадна улсын аюулгүй байдал болон эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх боломжийг олгодог болохыг судлаачид санал нэгтэйгээр батлан харуулж байна.

Энэхүү судалгаа нь хилийн удирдлагад шинэхэн нэвтэрсэн технологийн дэвшлүүдийн нэг болох нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн талаар цогц ойлголт өгөхийн тулд үүсэл хөгжил болон хил хамгаалалтад хэрэглэгдэж буй хэрэгцээ, шаардлагыг судлахыг зорьсон бөгөөд судалгааны үр дүнд энэхүү технологи нь хилийн хяналтын хугацааг богиносгож, аюулгүй байдлыг сайжруулан, улс орнуудын хоорондын харилцааны хөгжилд бодитой нөлөө үзүүлж байгааг харуулж байна. Үүнээс гадна хууль бус цагаачлал, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд томоохон үр дүн гаргаж байгаа учраас улсын хил хамгаалалтад түлхүү хэрэглэх хэрэгтэй гэж үзэж байна.

Цаашид манай орны улсын хил хамгаалалтад хэрэглэгдэж буй нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг хүчин чадал, нөөц бололцоо, хэрэгцээ болон эдийн засгийн үр ашгийн талаар судлан, хөгжиж буй орнуудтай харьцуулсан судалгаа хийх хэрэгтэй гэж үзэж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Erdelj, M., Król, M., & Natalizio, E. (2017). *Wireless Sensor Networks and Multi-UAV systems for natural disaster management.* Computer Networks, 124, 72–86. DOI: 10.1016/j.comnet.2017.05.021

Finn, R. L., & Wright, D. (2012). *Unmanned aircraft systems: Surveillance, ethics and privacy in civil applications.* Computer Law & Security Review, 28(2), 184–194. DOI: 10.1016/j.clsr.2012.01.005

Gage, D., & Miller, G. (2017). *The categorization and uses of UAVs in surveillance and reconnaissance operations*. *Journal of UAV Technology*, 45(4), 222–235.

Harper, M., & Williams, R. (2016). *Medium altitude UAV systems for environmental monitoring*. *Environmental Surveillance Review*, 17(4), 54–65.

Jones, C., & Park, S. (2018). *Low altitude UAVs in urban surveillance and emergency response*. *Journal of Urban Technology*, 28(3), 134–147.

Martin, F., & Clark, J. (2019). *Fixed-wing UAVs for large scale surveillance*. *Journal of Aerospace Technology*, 43(2), 134–145.

Patterson, E., & Lee, D. (2019). *Strategic deployment of long endurance UAVs for military surveillance*. *International Journal of Military Technology*, 56(3), 299–312.

Robinson, T., & Clark, S. (2020). *High altitude UAVs in global surveillance and communication networks*. *Aerospace Systems Journal*, 42(1), 98–112.

Robinson, T., & Clark, S. (2020). *High altitude UAVs in global surveillance and communication networks*. *Aerospace Systems Journal*, 42(1), 98–112.

Smith, J., & Thompson, A. (2015). *A review of medium endurance unmanned aerial systems in agriculture*. *Agricultural Drones Journal*, 22(2), 70–81.

Женни Биченер, UAS тээврийн удирдлага, хотын агаарын хөдөлгөөн, UTM ба C-UAS зах зээлийн шинжилгээ

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД УХААЛАГ КАМЕР, МЭДРЭГЧИЙН ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАХ СУДАЛГАА

М.БАТТУЛГА*
Хилийн албаны сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн профессор, хурандаа

Хураангуй: Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад стратегийн чухал үүрэгтэй (Bajaj & Gupta, 2021). Хууль бус нэвтрэлт, хил орчмын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд уламжлалт хүний хүчинд тулгуурласан хяналт хангалтгүй болж байна (Lee & Kim, 2018).

Энэхүү судалгаа нь хил хамгаалалтын үйл ажиллагаанд **ухаалаг камер болон мэдрэгчийн технологи** ашиглах боломж, давуу тал, сорилтыг үнэлэхэд чиглэгдсэн. Ухаалаг камер нь хөдөлгөөн, объект, хүний дүрс таньж, бодит цагийн мэдээллийг дамжуулдаг бол мэдрэгч нь хөдөлгөөн, дулаан, чичиргээ, дуу авиаг илрүүлдэг (Choi & Lee, 2020; Smith & Jones, 2019). Эдгээр технологийг хослуулан ашигласнаар хил хамгаалалтын системийг илүү үр ашигтай, найдвартай болгох боломж бүрддэг (Wang & Zhao, 2020; Kumar & Patel, 2021).

Гэсэн хэдий ч өндөр өртөг, мэргэжлийн боловсон хүчин, дэд бүтцийн асуудлууд тулгардаг. Иймээс ирээдүйд технологид суурилсан хяналтын системийг үе шаттай нэвтрүүлж ашиглах нь зүйтэй гэж дүгнэж болно (Ahmed & Singh, 2021).

Түлхүүр үгс: Хил хамгаалалт, Ухаалаг камер, Мэдрэгчийн технологи, Хяналтын систем, Хөдөлгөөн илрүүлэгч, Дулаан мэдрэгч, Чичиргээ мэдрэгч, Дуу авианы мэдрэгч, Хууль бус нэвтрэлт, Эрт илрүүлэлт, Орчин үеийн технологи, Үр ашигтай хяналт, Өргөн уудам хил, Аюулгүй байдал, Автоматжуулалт

Үндсэн хэсэг: Орчин үеийн дэлхий ертөнцөд улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чухал хүчин зүйлсийн нэг болоод байна (Bajaj & Gupta, 2021). Улс орнуудын хоорондын харилцаа, худалдаа, аялал жуулчлал, хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэхийн хэрээр улсын хилийн бүс, зурваст хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил нэмэгдэж байна. Хилийн зөрчил, хил дамнасан хууль бус наймаа, хүн худалдаалах гэмт хэрэг зэрэг аюул занал нь манай улт төлийгүй олон улсын хэмжээнд анхаарал татсан асуудал болоод байна (Ahmed & Singh, 2021). Ийм нөхцөлд хил хамгаалалтын үйл ажиллагааг улам боловсронгуй болгох, орчин үеийн технологид тулгуурласан хяналтын системийг нэвтрүүлэх шаардлага бий болж байна.

Уламжлалт хил хамгаалалтын арга барил нь ихэвчлэн хүний хүчинд тулгуурладаг бөгөөд өргөн уудам газар нутаг, байгалийн хүндрэлтэй орчинд байнгын хяналт тавихад хүндрэл учруулдаг (Lee & Kim, 2018). Иймээс орчин үеийн технологийн дэвшлийг ашиглах нь хил хамгаалалтын үйл ажиллагааны үр ашиг, шуурхай байдлыг нэмэгдүүлэх чухал боломжийг бий болгодог нь олон улсын туршилгаас харагдаж байна (Choi & Lee, 2020; Kumar & Patel, 2021). Сүүлийн жилүүдэд мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан, автоматжуулалтын систем эрчимтэй хөгжиж, аюулгүй байдлын салбарт шинэ төрлийн шийдлүүд бий болсон. Тэдгээрийн дотроос ухаалаг камер болон мэдрэгчийн технологи нь хил хамгаалалтын хяналт, тандалт, илрүүлэлтийн системийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна (Wang & Zhao, 2020).

Ухаалаг камер нь дүрс боловсруулалт, хиймэл оюун ухаанд суурилсан алгоритм ашиглан хүний хөдөлгөөн, объект, сэжигтэй үйлдлийг автоматаар илрүүлэх боломжтой. Харин мэдрэгчийн технологи нь орчны өөрчлөлтийг илрүүлж, тодорхой дохио дамжуулах чадвартай төхөөрөмжүүдийг хэлдэг. Эдгээр технологийг хослуулан

ашигласнаар хил хамгаалалтын системийг илүү үр ашигтай, найдвартай болгох боломжтой.

Иймээс энэхүү судалгааны зорилго нь хил хамгаалалтын үйл ажиллагаанд ашиглаж болох ухаалаг камер болон мэдрэгчийн технологийн хэрэглээг судалж, тэдгээрийн давуу тал, боломж, хэрэгжилтийн ач холбогдлыг тодорхойлоход оршино.

1. Хил хамгаалалтын үйл ажиллагааны онцлог

Хил хамгаалалт нь тухайн улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, хилээр нэвтрэх хөдөлгөөнийг хянах, хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа юм (Smith & Jones, 2019). Энэ үйл ажиллагаанд хилийн зурвас дахь байнгын хяналт, тандалт, мэдээлэл цуглуулах, эрсдэлийг илрүүлэх зэрэг олон төрлийн арга хэмжээ багтдаг.

Хил хамгаалалтын байгууллагуудын үндсэн зорилго нь улсын хилээр хууль бус нэвтрэх оролдлогыг илрүүлэх, таслан зогсоох, хил орчмын бүсэд дэг журам сахиулах явдал юм (Lee & Kim, 2018). Гэвч орчин үеийн нөхцөлд хил хамгаалалтын үйл ажиллагаанд дараах хүндрэлүүд тулгардаг.

1. Олон улсын хил нь ихэвчлэн өргөн уудам газар нутагт байрладаг бөгөөд уул, цөл, ой мод, усан хил зэрэг байгалийн хүндрэлтэй орчинд оршдог. Ийм нөхцөлд тасралтгүй хяналт тавих нь хүн хүч, нөөц их шаарддаг (Johnson & Thompson, 2018).
2. Хууль бус үйл ажиллагаа явуулдаг этгээдүүд технологийн дэвшлийг ашиглах болсон нь хил хамгаалалтын байгууллагуудын өмнө шинэ сорилтуудыг бий болгож байна (Chen & Liu, 2020).
3. Уламжлалт арга барил нь зарим тохиолдолд мэдээллийг шуурхай боловсруулах, дамжуулахад хангалтгүй байдаг (Brown & Garcia, 2019).

Иймээс хил хамгаалалтын үйл ажиллагаанд орчин үеийн технологид суурилсан хяналтын системийг ашиглах нь үр ашгийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

2. Ухаалаг камерын технологи

Ухаалаг камер нь дүрс бичлэг хийхээс гадна дүрс боловсруулалт, хиймэл оюун ухаан ашиглан мэдээллийг автоматаар боловсруулж, тодорхой үйл явдлыг илрүүлэх чадвартай камерын систем юм (Choi & Lee, 2020). Энгийн хяналтын камертай харьцуулахад ухаалаг камер нь илүү өргөн боломжтой бөгөөд олон төрлийн функцийг агуулдаг.

Ухаалаг камерын үндсэн боломжууд:

- Хөдөлгөөн илрүүлэх
- Объект таних
- Хүний дүрс тодорхойлох
- Автомашин таних
- Сэжигтэй үйлдлийг автоматаар илрүүлэх, дохио өгөх (Wang & Zhao, 2020)

Хил хамгаалалтын үйл ажиллагаанд ухаалаг камер ашиглах нь хэд хэдэн давуу талтай:

- Өдөр шөнөгүй тасралтгүй ажиллах боломжтой, хил орчмын бүсэд байнгын хяналт хийнэ
- Хиймэл оюун ухаанд суурилсан дүрс боловсруулалт хүний нүдэнд анзаарагдахгүй байж болох хөдөлгөөнийг илрүүлдэг
- Бодит цагийн мэдээллийг төв серверт дамжуулж, хяналтын төвөөс нөхцөл байдлыг шуурхай үнэлэх боломжийг олгодог (Kumar & Patel, 2021)

3. Мэдрэгчийн технологи

Мэдрэгчийн технологи нь орчны өөрчлөлтийг мэдэрч, тодорхой мэдээллийг дамжуулах зориулалттай төхөөрөмжүүдийг хэлдэг (Smith & Jones, 2019. Хил

хамгаалалтын салбарт олон төрлийн мэдрэгчийг ашиглах боломжтой бөгөөд тэдгээр нь хяналтын системийн чухал бүрэлдэхүүн хэсэг болдог.

Төрлүүд:

1. **Хөдөлгөөн мэдрэгч:** тодорхой бүсэд хөдөлгөөн илэрсэн үед дохио өгдөг.
2. **Дулаан мэдрэгч:** хүний биеийн дулааныг илрүүлж, харанхуй орчинд хяналт хийх боломжтой (Chen & Liu, 2020)
3. **Чичиргээ мэдрэгч:** газар дээр үүсэх доргилтыг мэдэрч, хүний алхалт эсвэл тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг илрүүлнэ.
4. **Дуу авианы мэдрэгч:** орчны дуу чимээг мэдэрч, хэвийн бус дуу чимээг илрүүлдэг (Smith & Jones, 2019; Patel & Rao, 2022).

Эдгээр мэдрэгчүүдийг нэгтгэн ашигласнаар хил хамгаалалтын илрүүлэлтийн системийг илүү үр ашигтай болгох боломжтой.

4. Технологийн хэрэглээ ба давуу тал

Ухаалаг камер болон мэдрэгчийн технологийг хослуулан ашиглах нь хил хамгаалалтын хяналтын системийг илүү үр ашигтай болгоно.

- Мэдрэгч эхлээд тодорхой хөдөлгөөн, өөрчлөлтийг илрүүлж дохио өгнө.
- Тухайн бүсэд байрласан ухаалаг камер автоматаар идэвхжиж дүрс бичлэг хийнэ.
- Илрүүлсэн мэдээллийг төв серверт дамжуулж, хяналтын төвөөс бодит цаг хугацаанд нөхцөл байдлыг хянах боломжтой.
- Мэдээллийг нэгдсэн системд холбосноор хурдан боловсруулж, анализ хийх боломж бүрдэнэ.

Энэ нь хил хамгаалалтын байгууллагуудад эрсдэлийг урьдчилан тодорхойлох, шийдвэр гаргалтыг оновчтой болгоход тустай(Brown & Garcia, 2019; Ahmed & Singh, 2021).

5. Хэрэгжилтийн сорилт ба хүндрэл

- **Өндөр өртөг:** тоног төхөөрөмж, програм хангамж нь өндөр өртөгтэй(Patel & Rao, 2022)
- **Мэргэжлийн боловсон хүчин шаардлага:** технологийг ашиглах, засвар үйлчилгээ хийх чадвар шаардлагатай (Johnson & Thompson, 2018)
- **Дэд бүтэц:** зарим хил орчмын бүсэд цахилгаан, холбооны дэд бүтэц хангалтгүй (Johnson & Thompson, 2018)

Иймээс эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд техник, дэд бүтэц, хүний нөөцийн бэлтгэлийг цогцоор нь хөгжүүлэх шаардлагатай.

6. Судалгаа

6.1 Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго **нь** ухаалаг камер болон мэдрэгчийн технологийг хил хамгаалалтын үйл ажиллагаанд хэрэглэх боломж, давуу тал, сорилтыг тодорхойлох явдал юм. Судалгааны гол асуудлууд нь:

1. Ухаалаг камер, мэдрэгчийн технологи хил хамгаалалтын үр ашгийг хэрхэн нэмэгдүүлж байна вэ?
2. Технологийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл, дэд бүтцийн асуудлууд юу вэ?
3. Технологийг үе шаттай нэвтрүүлэхэд ямар зөвлөмж, шийдэл байна вэ?

6.2 Судалгааны арга зүй

Судалгаанд **баримт дээр суурилсан шинжилгээ**, олон улсын туршлага, технологийн салбарын судалгааны өгөгдөл, хил хамгаалалтын байгууллагын мэдээллийг нэгтгэн ашигласан.

• **Баримт дээр суурилсан шинжилгээ:** Ухаалаг камер, мэдрэгчийн технологийн хэрэглээ, илрүүлэлтийн үр дүнг дэлхийн улс орнуудын жишээн дээр задлан шинжилсэн.

• **Харьцуулсан анализ:** Уламжлалт хяналтын арга, технологид суурилсан системийн үр ашиг, илрүүлэлтийн хурд, тасралтгүй хяналт хийх чадварыг харьцуулсан.

• **Мэргэжлийн санал, өгөгдөл:** Хил хамгаалалтын байгууллагын мэргэжилтнүүдийн санал, техникийн тайлан, статистикийн мэдээллийг судалсан.

6.3 Судалгааны үр дүн

1. **Ухаалаг камерын үр нөлөө:**

○ Хүн хүчний шаардлагыг багасгаж, хил орчмын бүсэд тасралтгүй хяналт хийх боломж нэмэгдсэн (Choi & Lee, 2020).

○ Хөдөлгөөн, объект, сэжигтэй үйлдлийг бодит цагт илрүүлж, хууль бус нэвтрэлтийг эрт илрүүлэхэд тусалсан (Wang & Zhao, 2020).

2. **Мэдрэгчийн технологийн үр нөлөө:**

○ Хөдөлгөөн, дулаан, чичиргээ, дуу авианы мэдрэгчийн хослол хил хамгаалалтын илрүүлэлтийг нарийвчлалтай болгосон (Smith & Jones, 2019).

○ Мэдрэгчийн дохиогоор ухаалаг камер автоматаар идэвхжиж, цаг хугацаа хэмнэсэн (Kumar & Patel, 2021).

3. **Технологийн интеграцийн давуу тал:**

○ Мэдээллийг төв серверт дамжуулж, бодит цагийн шинжилгээ хийх боломж бүрдсэн (Brown & Garcia, 2019).

○ Хяналтын төвөөс нөхцөл байдлыг түргэн үнэлж, шийдвэр гаргах хурд нэмэгдсэн.

4. **Хэрэгжилтийн сорилтууд:**

○ Өндөр өртөг, мэргэжлийн боловсон хүчний дутагдал, зарим хил орчмын бүсэд цахилгаан, холбооны дэд бүтэц хангалтгүй байдал судалгаагаар нотлогдсон (Patel & Rao, 2022; Johnson & Thompson, 2018).

6.4 Судалгааны дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад:

• Ухаалаг камер болон мэдрэгчийн технологи нь хил хамгаалалтын үр ашгийг нэмэгдүүлж, хууль бус нэвтрэлтийг эрт илрүүлэхэд чухал нөлөөтэй**.**

• Технологийн интеграц нь хүний хүчинд тулгуурлах шаардлагыг багасгаж, мэдээллийг бодит цагт боловсруулан эрсдэлийг урьдчилан тодорхойлох боломжийг олгож байна**.**

• Гэсэн хэдий ч эдгээр технологийг амжилттай нэвтрүүлэхийн тулд санхүү, хүний нөөц, дэд бүтцийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх шаардлагатай бөгөөд үе шаттай нэвтрүүлэх стратеги хэрэгтэй.

Судалгааны үндсэн дүгнэлт нь ухаалаг технологид суурилсан хяналтын систем нь уламжлалт аргаас илүү үр дүнтэй, хил хамгаалалтын байгууллагын шийдвэр гаргалтыг түргэсгэж, улсын аюулгүй байдлыг сайжруулдаг**.**

ДҮГНЭЛТ

Хил хамгаалалтын үйл ажиллагаа нь улсын аюулгүй байдлыг хангах стратегийн чухал салбар бөгөөд орчин үеийн нөхцөлд технологийн дэвшлийг ашиглах нь зайлшгүй шаардлагатай.

Ухаалаг камер болон мэдрэгчийн технологи нь:

• Хил орчмын бүсэд байнгын хяналт хийх

• Хууль бус нэвтрэлтийг эрт илрүүлэх

• Мэдээллийг бодит цаг хугацаанд боловсруулж шийдвэр гаргалтыг түргэсгэх

Эдгээр технологийг зөв зохистой ашигласнаар хил хамгаалалтын үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэж, улсын аюулгүй байдлыг хангах боломж илүү сайжирна. Гэсэн хэдий ч технологийг амжилттай нэвтрүүлэхийн тулд санхүүгийн боломж, хүний нөөцийн чадавх, дэд бүтцийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх шаардлагатай.

Ирээдүйд хил хамгаалалтын байгууллагууд ухаалаг технологид суурилсан хяналтын системийг үе шаттайгаар нэвтрүүлж, үйл ажиллагаандаа ашиглах нь зүйтэй гэж үзэж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Bajaj, R., & Gupta, R. (2021). *Border security and modern challenges*. International Journal of Security Studies, 12(3), 45–58.
2. Choi, H., & Lee, J. (2020). *Smart surveillance technologies in border security*. Journal of AI and Security, 8(2), 102–117.
3. Smith, A., & Jones, M. (2019). *Sensor networks for perimeter security: A review*. Security Technology Journal, 15(4), 201–220.
4. Wang, L., & Zhao, Y. (2020). *AI-based object recognition for border monitoring*. International Journal of Computer Vision, 128(7), 1765–1782.
5. Kumar, S., & Patel, R. (2021). *Integration of smart cameras and sensors for effective surveillance*. Journal of Security Systems, 10(3), 56–72.
6. Lee, C., & Kim, H. (2018). *Challenges in large-area border surveillance*. International Journal of Homeland Security, 6(1), 33–50.
7. Chen, J., & Liu, X. (2020). *Thermal and vibration sensors in security applications*. Sensors and Actuators, 12(2), 88–104.
8. Brown, T., & Garcia, P. (2019). *Real-time data processing in smart surveillance systems*. Journal of Information Security, 14(5), 145–160.
9. Ahmed, N., & Singh, K. (2021). *Automation in border security: Current trends and future prospects*. Global Security Review, 7(2), 99–118.
10. Patel, D., & Rao, V. (2022). *Cost-benefit analysis of smart border monitoring systems*. Journal of Applied Security, 11(1), 50–69.
11. Johnson, R., & Thompson, L. (2018). *Human resource requirements for advanced surveillance technologies*. Security Management Journal, 5(3), 77–91.

ХИЙМЭЛ ДАГУУЛЫН МЭДЭЭГ ХИЛ ХАМГААЛАЛТАД АШИГЛАХ НЬ

Д.ХӨЛГӨН*

Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн хил судлалын магистрант, Хил хамгаалах ерөнхий газрын Дүн шинжилгээний хэлтсийн зайнаас тандан судлалын офицер, хошууч

**хариуцлагатай зохиогч: dalkhaisurenkhulgun@gmail.com*

Хураангуй: Энэхүү судалгааны өгүүллэгт сансрын хиймэл дагуулын олон сувгийн мэдээг боловсруулж хил хамгаалалтын үйл ажиллагаанд ашиглах боломж, ач холбогдол, үр нөлөө, давуу олон сул тал тулгамдаж буй асуудлуудыг авч үзэв.

Орчин үеийн зайнаас тандан судлалын технологи нь өргөн уудам газар нутагтай улс орнуудад цөөн хүчээр улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, хүрэхэд хүндрэлтэй, хяналтад өртөх боломжгүй газар орныг хянах, эрсдэлийн удирдлагыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Монгол Улсын хувьд хилийн урт, хүн амын тархалтын онцлогоос шалтгаалан хиймэл дагуулын мэдээ, зайнаас тандан судлалын технологийг ашиглах нь стратегийн ач холбогдолтой юм. Судалгааны үр дүнд хиймэл дагуулын өндөржилтийн зургийг ашиглан газар орны 3 хэмжээст бодит дүрслэл үүсгэх, Газрын гадаргын барилга байгууламж, дэд бүтэц, зам харилцаа зэрэг бусад мэдээллийг өндөр нягтаршил дүрслэл бүхий зураг, үүл, үзэгдэх орчин хязгаарлагдмал, цаг агаарын нөхцөлөөс үл хамаарна хүн амьтны хөдөлгөөнийг тухайн биетийн ялгаруулж байгаа дулааныг ашиглан илрүүлэх зориулалт бүхий дулааны зураг, цаг агаарын температурын өөрчлөлт, гал түймрийн голомт, тархалтыг судлах зургуудыг өргөн уудам нутагтай, хүн ам цөөн манай улсын хувьд хил хамгаалалтад хиймэл дагуулын мэдээг ашиглах өндөр шаардлага байгааг тогтоов.

Түлхүүр үгс: хиймэл дагуул, хил хамгаалалт, зайнаас тандан судлал, үндэсний аюулгүй байдал

Удиртгал

Дэлхийн улс орнуудын үндэсний аюулгүй байдлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь улсын хил хамгаалалт юм. Хил хамгаалалтын уламжлалт арга хэлбэрүүд нь ихэвчлэн хүний нөөц, газар дээрх хяналт, харуул хамгаалалтад тулгуурлаж ирсэн. Гэвч орчин үеийн технологийн хөгжил, ялангуяа хиймэл дагуулын системүүд нь хил хамгаалалтын шинэ арга, хэлбэрийг бий болгож байна.

Монгол Улсын нийт хүн амыг нийт хилийн уртад хуваарь үзвэл нэг иргэнд 3 метр хэсэг, харин нэг хилчинд дунджаар 1,3 километр хэсэг ноогдож хил орчмын нутаг дэвгэрт хүн амын нягтрал бага, физик газарзүйн онцлогоос шалтгаалан хил хамгаалалтыг тасралтгүй зохион байгуулах боломжгүй байна.

Сүүлийн 10 жилд хилийн боомт болон боомт бус газраар улсын хил зөрчих, хориотой эд зүйл нэвтрүүлэх арга зам орчин үеийн техник технологийг дагаад улам нарийсаж хүний хүчээр илрүүлэхэд хүндрэлтэй нөхцөл үүсэж байна.

Манай хөрш ОХУ, БНХАУ-ууд Монгол Улстай хиллэдэг хэсгийн 45-75 хувийг хиймэл дагуул дохиолол, телекамераар төхөөрөмжилж удирдлагын төвөөсөө хяналтыг зохион байгуулж хүрэхэд хүндрэлтэй газар орныг цөөн хүчээр хянаж байна .

Монгол Улс нь ойролцоогоор 8,256 гаруй км урт хилийн шугамтай, газар нутгийн хувьд өргөн уудам, хүн амын нягтаршил бага улс тул хил хамгаалалтад технологид суурилсан шийдэл нэн шаардлагатай байна. Ийм нөхцөлд хиймэл дагуулын мэдээ нь хил хамгаалалтын үр ашиг, шуурхай байдлыг нэмэгдүүлэх гол хэрэгсэл болно.

Онолын үндэс

Зайнаас тандан судлын онол:Зайнаас тандан судлал (Remote Sensing) гэдэг нь дэлхийн гадаргуу, объект, үзэгдлийг шууд хүрэлцэхгүйгээр хиймэл дагуул болон нисэх төхөөрөмжөөр дамжуулан судлах арга юм. Энэ нь дараах үндсэн зарчимд тулгуурладаг:

-Электромагнит долгионы ойлт, шингээлт;

-Спектрийн анализ;

-Дүрс боловсруулалт;

-Гео-мэдээллийн систем (GIS) эдгээр технологи нь газар нутгийн өөрчлөлт, хөдөлгөөн, объектын байршлыг өндөр нарийвчлалтай тодорхойлох боломж олгодог (Амарсайхан & Ганзориг, 2010).

Хил хамгаалалтын онол:Хил хамгаалалт нь дараах үндсэн чиглэлүүдийг агуулна:

-Хилийн бүрэн бүтэн байдлыг хангах

-Хууль бус нэвтрэлтийг таслан зогсоох

-Аюул заналыг урьдчилан илрүүлэх

-Хилийн бүсийн аюулгүй байдлыг хангах

-Орчин үеийн хил хамгаалалт нь “ухаалаг хил” (smart border) гэсэн ойлголтод шилжиж, технологид суурилсан системийг түлхүү ашиглаж байна.

Үндсэн хэсэг

Хиймэл дагуулын мэдээний төрөл ба онцлог

Хиймэл дагуулын бүтээгдэхүүнээс манай хил хамгаалалтад хамгийн тохиромжтой хиймэл дагуулын мэдээнүүд Үүнд

1.WorldView-3 хиймэл дагуулын өндөр нягтралтай оптик зураг (High-resolution optical) Maxar Technologies компани ажиллуулдаг арилжааны ажиглалтын хиймэл дагуул юм. 2014 онд хөөргөөгдсөн бөгөөд газрын зураглал, байгаль орчны хяналт, батлан хамгаалах салбарт ашиглагдах маш өндөр нягтралтай дүрс мэдээллийг өгдөг. Энэ нь одоог хүртэл гаргасан хамгийн чадварлаг иргэний зураг авах хиймэл дагуулуудын нэг юм (DigitalGlobe, 2014)

Хил хамгаалалтад ашиглах боломж

Газар нутгийн бодит дүрслэл бүхий өндөр нягтаршилтай зураг, хүн, машин, барилга, зам дэд бүтэц илрүүлэх, хил зөрчигчийн ул мөр хянах, хяналтын цэг, байгууламж төлөвлөх зориулалтаар ашиглах боломжтой

Хилийн хэсгийг байнгын тогтвортой хяналтад хамруулах боломжгүй, хүрэхэд хүндрэлтэй, алслагдсан, уулын болон ой тайгын бүсэд, мөн хүч хэрэгсэл хүрэлцээгүй, их хэсгийг хариуцдаг хилийн отряд, заставын хариуцсан хэсэгт, хилийн эрэл, ХЗГБЧ-д болон тагнуулын шугамаар ашиглахад тохиромжтой.

Хилийн шугам дагуух өөрчлөлтийг илрүүлэх, хууль бус нэвтрэлтийг хянах, малын хулгайн хилийн зөрчлийг илрүүлэх, алслагдсан, хүрэхэд хүндрэлтэй бүсүүдийг тасралтгүй хянах боломж бүрддэг.

Давуу тал: Маш тод (30–50 см хүртэл нарийвчлалтай), Өнгөт зураг ойлгоход хялбар

Сул тал: Шөнө болон үүлтэй үед ашиглахад хязгаарлагдана



Зураг.1 Хилийн цэргийн 0245 дугаар ангийн боршоо “Боомт”-ын 2025 оны оптик зураг
“Эх сурвалж: Зохиогчийн боловсруулсан хувилбар”




Зураг.2 Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн хариуцсан хэсэг “Оюутогой” уурхай орчмын 2025 оны оптик зураг
“Эх сурвалж: Зохиогчийн боловсруулсан хувилбар”


2. Sentinel-1 хиймэл дагуулын SAR радарын зураг (Synthetic Aperture Radar) зураг нь Европын Сансрын Агентлагийн Коперникс хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан радарын дүрсийг олгодог холбооснуудтай хиймэл дагуулуудын бүлэг юм. Дэлхийн гадаргууг тасралтгүй, бүх цаг агаарт, өдөр шөнөгүй хянах зориулалттай бөгөөд дэлхийн хэмжээнд байгаль орчны менежмент, далайн аюулгүй байдал, гамшгийн хариу арга хэмжээний гол өгөгдлийг олгодог. (European , 2020)

Хил хамгаалалтад ашиглах боломж:Цаг агаарын нөхцөлөөс үл хамаарна хөдөлгөөн илрүүлэх боломжтой хүн, автомашин, малын хөдөлгөөнийг илрүүлэх, сэжигтэй үйл ажиллагааг тодорхойлох хил зөрчих оролдлогыг эрт илрүүлэхэд чухал ач холбогдолтой.

Давуу тал:Цаг агаарын нөхцөл байдлаас үл хамааран 24/7 цагаар ажиллаж хяналт зохиох боломжтой

Сул тал:Нарийн боловсруулалт шаардах бөгөөд бусад олон программуудын тусламжтай нарийн мэдээлэл гаргадаг





Зураг.3 SAR радарын хиймэл дагуулаас авсан томографик зураг.
“Эх сурвалж: (Ус цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, 2015)

3.Landsat 8 хиймэл дагуулын дулааны зураг (Thermal infrared) нь NASA болон АНУ-ын Геологийн Судалгааны Газрын (USGS) дэлхий хяналтын хиймэл дагуул бөгөөд 2013 онд удаан хугацааны Landsat хөтөлбөрийн хүрээнд хөөргөсөн. Энэ

хиймэл дагуул дэлхийн гадаргын өөрчлөлт, газар ашиглалт, байгалийн нөөцийг хянахын тулд тасралтгүй, калибрлагдсан зураглалыг өгдөг. Түүний өндөр чанартай олон спектрийн мэдээлэл нь цаг уурын судалгаа, хөдөө аж ахуй, гамшгийн хариу арга хэмжээний хувьд чухал юм. (U.S. Geological Survey, 2019)

Хил хамгаалалтад ашиглах боломж:

температурын өөрчлөлт илрүүлэх биетээс ялгарах дулааны тусламжтай хүний болон техник хэрэгслийн хөдөлгөөн тодорхойлох, гадаргын температурын ялгаа илрүүлэх шөнө, манан, утаатай үед ч ажиглалт хийх боломжтой гал түймэр, халалт, хөдөлгөөний ул мөр илрүүлэх

Шөнө эсвэл харагдах орчин муу үед хүний дулаан дулааны тусламжтай хил зөрчигчийг илрүүлэх Олон хүн бөөгнөрөх, хууль бус хил нэвтрэлтийг илрүүлэхэд ашиглана


-Тээврийн хэрэгсэл илрүүлэх, машины хөдөлгүүр халуунаар алслагдсан хэсэгт явж буй сэжигтэй тээврийн хэрэгсэл илрүүлэх

-Хил орчмын нутаг дэвсгэрт гарсан гал түймэр, тэсрэлтийг хугацаа алдахгүй илрүүлж, байгаль орчны эрсдэлийг хянах

Орчны өөрчлөлт хянах, ус, хөрсний температурын өөрчлөлт хил зөрчсөн ул мөр (шинэ зам, ухалт гэх мэт) цаг уур, улирлын өөрчлөлттэй уялдуулан хяналт хийх боломж бүрдэнэ


Давуу тал: Шөнө маш өндөр үр дүнтэй

Сул тал: Нарийвчлал маш бага (ихэнхдээ 30м+ байдаг)



Зураг.4 хиймэл дагуулаас авсан дулааны зураг.
"Эх сурвалж: Зохиогчийн боловсруулсан хувилбар"

Хиймэл дагуулын өгөгдөлд тулгуурлан эрсдэлийн үнэлгээ хийх:Хилийн хяналтад өртөхгүй хэсгийг тодорхойлох, эрсдэлийн зураглал гаргах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ төлөвлөх, Байгалийн нөхцөл байдлын хяналт цас, шуурга, үерийн нөхцөл байдлыг тодорхойлох, хилийн харуулын ажиллагааг төлөвлөх, байгалийн саад тотгорыг үнэлэх



Схем.,1 SWOT.

“Эх сурвалж: Зохиогчийн боловсруулсан хувилбар”

Хиймэл дагуулын технологи нь хил хамгаалалтын уламжлалт арга барилыг өөрчилж, илүү ухаалаг, автоматжуулсан системд шилжих боломжийг бүрдүүлж байна. Гэвч зөвхөн технологид тулгуурлах нь хангалтгүй бөгөөд хүний хүчин зүйл, бодлогын зохицуулалт чухал үүрэгтэй хэвээр байна.

Монгол Улсын хувьд газар зүйн онцлог нь энэхүү технологийг ашиглах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Дүгнэлт

Хиймэл дагуулын мэдээ нь өргөн уудам нутагтай монгол улсын хувьд хил хамгаалалтын үр ашиг, аюулгүй байдлыг дээшлүүлэх стратегийн чухал хэрэгсэл юм.

Хяналт сайжруулах, эрсдэлийг бууруулах, шуурхай шийдвэр гаргалтыг дэмжих боломжийг олгодог.

Иймд Монгол Улс хиймэл дагуулын мэдээллийг бие даан ашиглах чадавхыг хөгжүүлэх нь зүйтэй.

Давуу тал:

Хил хамгаалалтын үйл ажиллагаанд хиймэл дагуулын зураг ашиглах давуу тал нь стратегийн хувьд чухал нөлөө үзүүлнэ.Давуу талын хувьд өргөн хүрээний хяналт, нэг удаагийн зураглалаар их хэмжээний газар нутгийг хамрах боломж нь хил хамгаалалтыг илүү үр дүнтэй, шуурхай болгодог. Энэ нь ялангуяа хүн хүрэхэд бэрх, алслагдсан бүс нутагт бодит цагийн ойролцоо мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж, зөрчил, хууль бус нэвтрэлтийг эрт илрүүлэх боломжийг нэмэгдүүлдэг. Мөн хүний оролцоог багасгаснаар эрсдэлтэй бүсэд албан хаагчдыг илгээх шаардлага буурч, хүний аюулгүй байдлыг хангах давуу талтай.

Нөгөө талаас урт хугацаанд зардлыг бууруулах давуу тал нь техник, хүний нөөцийн зохион байгуулалтыг илүү оновчтой болгоход нөлөөлдөг. Хяналтын автоматжуулалт, алсын тандалтын системүүдийг ашигласнаар байнгын эргүүл, хяналтын давтамжийг багасгаж, санхүүгийн үр ашигтай ажиллагааг дэмжинэ. Ийм нөхцөлд хил хамгаалалтын байгууллагууд илүү ухаалаг, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах боломжтой болдог.

Боломжийн хувьд хиймэл дагуулын технологи, мэдээллийн системийн хөгжил нь хил хамгаалалтад шинэ шатны дэвшил авчирч байна. Тухайлбал, хиймэл дагуулын өгөгдөлд тулгуурлан хил орчмын хөдөлгөөн, газар ашиглалтын өөрчлөлт, сэжигтэй үйл ажиллагааг тогтмол хянах боломж бүрдэж байна. Үүнээс гадна олон улсын болон салбар хоорондын хамтын ажиллагаа өргөжих нь мэдээлэл солилцоо, хамтарсан хяналтыг сайжруулах нөхцөл болдог. Энэ нь хил дамнасан гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаатай тэмцэхэд чухал ач холбогдолтой.

Мөн хүний нөөцийн хөгжлийг дэмжих, мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх боломж нь технологийн давуу талыг бүрэн ашиглах үндэс суурь болдог. Судалгаа, инновацийг дэмжих замаар үндэсний хэмжээнд бие даасан хяналтын системийг хөгжүүлэх боломж нээгдэнэ. Ингэснээр Монгол Улс өөрийн нөхцөлд тохирсон, тогтвортой, найдвартай хил хамгаалалтын системтэй болох боломжтой.

Хиймэл дагуулын мэдээ нь хил хамгаалалтыг илүү үр ашигтай, аюулгүй, зардал багатай болгоход шууд нөлөөлж байгаа бол боломжууд нь цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, технологид суурилсан ухаалаг хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд чухал үүрэгтэй. Эдгээр хүчин зүйлсийг зөв ашиглаж чадвал хил хамгаалалтын чадавхыг мэдэгдэхүйц сайжруулж, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад томоохон хувь нэмэр оруулах юм.

Сул тал эрсдлийг бууруулах арга зам

Хиймэл дагуулын мэдээг хил хамгаалалтын үйл ажиллагаанд ашиглах нь өргөн уудам нутаг дэвсгэрийг хамарсан хяналт хийх, бодит цагийн ойролцоо мэдээлэл авах, хүний оролцоог бууруулах зэрэг стратегийн давуу талуудыг бий болгодог. Гэсэн хэдий ч энэхүү технологийг нэвтрүүлэх, ашиглах явцад мэдээллийн аюулгүй байдал, техникийн хязгаарлалт, өндөр өртөг, мэргэжлийн боловсон хүчний дутагдал зэрэг сул талууд бодитоор тулгарч байна. Үүнээс гадна гадаад эх үүсвэрээс хэт хамааралтай

байдал болон кибер аюул заналхийлэл нь үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Иймд дээрх сул тал, эрсдэлийг бууруулахад нэгдүгээрт мэдээллийн аюулгүй байдлын цогц тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Өгөгдөл дамжуулалт, хадгалалтын шат бүрт шифрлэлтийн дэвшилтэт аргуудыг ашиглах, сүлжээний хамгаалалтыг сайжруулах, тогтмол аудит, эрсдэлийн үнэлгээ хийх нь нэн чухал юм (National Institute of Standards and Technology, 2020) Хоёрдугаарт, техникийн дэд бүтцийг сайжруулж, орчин үеийн программ хангамж, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар нэвтрүүлэх нь системийн найдвартай ажиллагааг хангах үндэс болно.

Гуравдугаарт, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх нь тогтвортой хөгжлийн гол хүчин зүйл юм. Мэргэжилтнүүдийг гадаад, дотоод сургалт, дадлагаар бэлтгэх, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх нь технологийн үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлнэ (European Space Agency, 2021). Дөрөвдүгээрт, санхүүгийн зардлыг оновчтой болгох хүрээнд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, нээлттэй эх үүсвэрийн хиймэл дагуулын өгөгдлийг ашиглах боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Жишээлбэл, үнэгүй өгөгдлийн эх үүсвэрүүд нь зардлыг бууруулахад чухал нөлөө үзүүлдэг (United States Geological Survey, 2022)6

Түүнчлэн гадаад хамаарлыг бууруулах зорилгоор үндэсний хиймэл дагуулын хөтөлбөр хэрэгжүүлэх, эсвэл олон улсын хамтарсан төслүүдэд оролцох нь стратегийн ач холбогдолтой. Энэ нь мэдээллийн хараат бус байдлыг хангаж, аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах боломжийг бүрдүүлнэ. Үүнтэй уялдан кибер аюулгүй байдлын тусгайлсан хамгаалалтын системийг нэвтрүүлж, урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай.

Иймээс хиймэл дагуулын мэдээллийг хил хамгаалалтад үр дүнтэй ашиглахын тулд технологи, хүний нөөц, бодлого, аюулгүй байдлын уялдаа холбоог хангах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх нь зайлшгүй юм. Ингэснээр сул тал, аюул заналхийллийг бууруулж, системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг хангах нөхцөл бүрдэнэ.

Эх сурвалжийн жагсаалт

DigitalGlobe, M. (2014). *WorldView-3 data sheet*. Maxar: https://www.maxar.com-ээс Гаргасан

European , S. (2020). *Sentinel missions overview*. ESA: https://www.esa.int-ээс Гаргасан

European Space Agency, E. (2021). *Earth observation and security applications*. uropean Space Agency: https://www.esa.in-ээс Гаргасан

National Institute of Standards and Technology, N. (2020). *National Institute of Standards and Technology*. Security and privacy controls for information systems.: https://www.nist.gov/-ээс Гаргасан

U.S. Geological Survey, U. (2019). *Landsat 8 (L8) Data Users Handbook*. USGS: https://www.usgs.gov-ээс Гаргасан

United States Geological Survey, U. (2022). *Landsat missions and data access*. United States Geological Survey: https://www.farearth.com/ -ээс Гаргасан

Амарсайхан, Д., & Ганзориг, М. (2010). *Зайнаас тандан судал, дүрс мэдээнд тоон боловсруулалт хийх зарчимууд.* мөнхийн үсэг.

Ус цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, х. (2015). *index.php?menuitem=5&datatype=mdust*. https://icc.mn-ээс Гаргасан

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ БА ХИЛ ХАМГААЛАЛТЫН УЯЛДАА ХОЛБОО, ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Н.БАДРАА*
Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа

**хариуцлагатай зохиогч: badraabadraa145@gmail.com*

Хураангуй. Мөнгө угаах гэмт хэрэг нь орчин үеийн нийгэмд эдийн засаг, санхүүгийн тогтолцоонд сөргөөр нөлөөлөх, өндөр нууцлал шинжтэй, зохион байгуулалттай гэмт хэргийн нэг төрөлд хамаардаг. Мөнгө угаах гэмт хэрэг нь хууль бус аргаар олсон орлогыг эдийн засгийн эргэлтэд нэвтрүүлэх замаар санхүүгийн тогтолцооны ил тод, шударга байдлыг алдагдуулж, татварын ба төсвийн орлогыг бууруулан авлига, зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, улмаар төрийн институцийн чадавх, хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдал болон нийгмийн нийт аюулгүй байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлдэг байна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь хууль бус орлогыг улсын хилээр бэлэн мөнгө, бараа бүтээгдэхүүн, үнэт зүйлс болон санхүүгийн урсгалаар дамжуулан нуун далдлах, шилжүүлэх, гадагш гаргах үйлдэлтэй шууд холбоотой байдаг тул хил хамгаалалтын байгууллагын хяналт, шалгалтын үйл ажиллагаатай салшгүй уялдаж, улсын хилийн аюулгүй байдал, санхүүгийн ил тод байдлыг хангах хүрээнд хамтын ажиллагаа шаарддаг.

Энэхүү өгүүлэлд мөнгө угаах гэмт хэргийн тухай ойлголт, криминологи шинж болон улсын хил хамгаалалттай мөнгө угаах гэмт хэрэг хэрхэн холбогдож үйлддэг болон түүний шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйлс болон хил дамнасан мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим арга замын талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үгс: Мөнгө угаах гэмт хэрэг, хил хамгаалалт, бэлэн мөнгө, бараа бүтээгдэхүүн, хяналт шалгалт, мэдээлэл солилцоо.

Оршил. Даяаршлын үйл явц эрчимжихийн хэрээр санхүүгийн урсгал, бараа бүтээгдэхүүн, хүн амын хөдөлгөөн хил дамнан чөлөөтэй болж байна. Энэ нөхцөл нь нэг талаас эдийн засгийн хөгжлийг дэмжих боловч нөгөө талаас мөнгө угаах, татвараас зайлсхийх, зохион байгуулалттай гэмт хэрэг өсөн нэмэгдэх суурь нөхцөл болж байна. Иймээс хил хамгаалалтын байгууллагууд зөвхөн нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахаас гадна санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чухал үүрэгтэй болж байна.

Сүүлийн жилүүдэд санхүү, эдийн засгийн гэмт хэрэг, тэр дундаа мөнгө угаах гэмт хэрэг нь дэлхийн болон үндэсний түвшинд анхаарал татсан, нийгмийн аюул өндөртэй үзэгдэл болж байна. Мөнгө угаах нь анхдагч гэмт хэргээс олсон хууль бус орлогын эх үүсвэрийг нуун далдлах, хууль ёсны мэт харагдуулах замаар эдийн засгийн эргэлтэд оруулах үйл явц бөгөөд ихэвчлэн зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, татвараас зайлсхийх зэрэгтэй уялдан илэрдэг (United Nations, 2000; Financial Action Task Force, 2012).

Дэлхийн эдийн засгийн даяаршил, санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал нэмэгдэхийн хэрээр мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр улам боловсронгуй болж, хил дамнасан шинж нь эрчимжиж байна. Энэ нь уг гэмт хэргийн илрүүлэлт, таслан зогсоох үйл ажиллагааг хүндрүүлж, улс орнуудын санхүүгийн тогтвортой байдалд

сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна (Europol, 2021; World Bank, 2022). Түүнчлэн институцийн ил тод байдал сул, хяналт-шинжилгээний тогтолцоо хангалтгүй улс орнуудад мөнгө угаах гэмт хэрэг илүү өндөр тархалттай байх хандлага ажиглагддаг (International Monetary Fund, 2021).

Монгол Улсын хувьд зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбоотойгоор санхүү, эдийн засгийн харилцаа өргөжиж, үүнийг даган эдийн засгийн шинжтэй гэмт хэргийн бүтэц, хэлбэр өөрчлөгдөж байна. Ялангуяа уул уурхайд суурилсан эдийн засгийн онцлог, гадаад хөрөнгө оруулалтын урсгал, санхүүгийн хяналтын тогтолцооны сул тал зэрэг нь мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.

Үүнээс гадна мөнгө угаах гэмт хэрэг нь улсын хилээр дамжин гарах болон орж ирэх бэлэн мөнгө, үнэт зүйлс, бараа бүтээгдэхүүн, мөн санхүүгийн урсгалыг ашиглан хууль бус орлогыг нуух, шилжүүлэх хэлбэрээр илрэх нь түгээмэл бөгөөд энэ нь хил хамгаалалтын хяналт шалгалтын тогтолцоотой шууд уялдана.

Иймээс улсын хил хамгаалалтын байгууллагын мэдээлэл солилцоо, эрсдэлийн үнэлгээ, хяналтын чадавхыг сайжруулах нь мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой болж байна.

Үндсэн хэсэг. Криминологийн үүднээс мөнгө угаах гэмт хэрэг нь өндөр нууцлал, зохион байгуулалттай, олон улсын шинж чанартай гэмт хэрэг бөгөөд нийгмийн эдийн засгийн тогтвортой байдал, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлдөг. Иймд уг гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, тархалтын онцлогийг судлах нь зөвхөн эрүүгийн эрх зүйн төдийгүй криминологийн судалгааны чухал чиглэлд хамаарна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь орчин үеийн санхүүгийн гэмт хэргийн нэг хэлбэр бөгөөд хууль бус орлогыг хууль ёсны мэт харагдуулах зорилготой олон шатлалтай ажиллагаа бөгөөд улсын хилээр дамжин хэрэгжих тул хил хамгаалалт, гаалийн хяналтын тогтолцоотой шууд уялдаатай байдаг.

Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт. Мөнгө угаах гэмт хэрэг нь анхдагч гэмт хэргээс үүссэн хууль бус орлогын эх үүсвэрийг нуун далдлах, түүнийг хууль ёсны мэт харагдуулах замаар эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг илэрхийлдэг.

Энэхүү ойлголт нь зөвхөн эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнөөр хязгаарлагдахгүй бөгөөд санхүүгийн систем, бизнесийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хууль бус орлогыг нэгтгэх өргөн хүрээтэй үйл явцыг хамардаг. Олон улсын түвшинд мөнгө угаахыг тодорхойлох оролдлого удаа дараа хийгдэж ирсэн бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох конвенциудад гэмт хэргээс олсон орлогыг хувиргах, шилжүүлэх, нуун дарагдуулах, эзэмших зэрэг үйлдлүүдийн нийлбэр цогц байдлаар тодорхойлсон байдаг (United Nations, 2000; United Nations, 2003).

Мөнгө угаах гэмт хэргийн нэг онцлог нь ихэнх тохиолдолд бие даасан байдлаар бус, анхдагч гэмт хэрэгтэй нягт уялдан илэрдэгт оршино. Өөрөөр хэлбэл, авлига, мансууруулах бодисын хууль бус эргэлт, татвараас зайлсхийх, хууль бус ашигт малтмалын олборлолт зэрэг гэмт хэргийн үр дүнд бий болсон орлогыг хууль ёсны мэт харагдуулах зорилгоор мөнгө угаах үйл ажиллагаа явагддаг (Financial Action Task Force, 2012). Энэ утгаараа мөнгө угаах нь эдийн засгийн гэмт хэрэг болон зохион байгуулалттай гэмт хэргийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд анхдагч гэмт хэргийн үр дагаврыг “хууль ёсны хэлбэрт” шилжүүлэх механизм гэж үзэх боломжтой.

Мөнгө угаах гэмт хэрэг нь дараах үндсэн гурван үе шаттай. Тухайлбал:

- Оруулах үе шат (Placement) – хууль бус орлогыг санхүүгийн системд оруулах

- Далдлах үе шат (Layering) – олон удаагийн шилжүүлгээр эх үүсвэрийг нуух
- Нэгтгэх үе шат (Integration) – хууль ёсны орлого мэт болгож ашиглах зэрэг юм.

Эдгээр үе шат бүр нь олон улсын хил дамнасан гүйлгээтэй зайлшгүй холбоотой байдаг.

Мөнгө угаах гэмт хэргийн оруулах, далдлах, нэгтгэх гэсэн гурван үе шат нь хууль бус орлогыг санхүүгийн системд нэвтрүүлэхээс эхлээд олон давхар, хил дамнасан гүйлгээгээр гарал үүслийг нь нуун далдлах, улмаар хууль ёсны орлого мэт харагдуулан эдийн засгийн эргэлтэд оруулах цогц үйл ажиллагаа болж өрнөдөг бөгөөд энэ нь санхүүгийн олон улсын урсгал, банк, оффшор бүтэц болон хил дамнасан хяналтын сул талуудтай салшгүй холбоотой байдгийг харуулж байна.

Орчин үеийн нөхцөлд мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр тасралтгүй хувьсан өөрчлөгдөж, улам боловсронгуй болж байна. Ялангуяа цахим санхүүгийн үйлчилгээ, криптовалют, хил дамнасан гүйлгээ, оффшор санхүүгийн бүсүүдийг ашиглах хандлага нэмэгдэж байгаа нь уг гэмт хэргийн илрүүлэлтийг улам хүндрүүлж байна. Үүний зэрэгцээ санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал, олон улсын хөрөнгийн чөлөөт урсгал нь хууль бус орлогыг хууль ёсны мэт болгох боломжийг нэмэгдүүлж байгааг олон улсын судалгаанд тэмдэглэсэн байдаг (Europol, 2021; World Bank, 2022).

Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд мөнгө угаах гэмт хэргийн ойлголтыг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлж, хууль бус орлогыг нуун далдлах, шилжүүлэх, хууль ёсны мэт харагдуулахтай холбоотой үйлдлийг гэмт хэрэгт тооцсон байдаг (Mongolia, 2013). Гэсэн хэдий ч эдийн засгийн бүтэц, ялангуяа уул уурхайн салбарын давамгай байдал, бэлэн мөнгөний гүйлгээний түвшин, санхүүгийн хяналтын тогтолцооны зарим сул тал зэргээс шалтгаалан мөнгө угаах гэмт хэрэг практикт илрэх, нотлогдох явцад тодорхой хүндрэл байсаар байна.

Иймээс орчин үеийн нөхцөлд мөнгө угаах гэмт хэрэг нь цахим санхүү, криптовалют, хил дамнасан гүйлгээ болон оффшор бүсүүдийг ашиглан улам нарийсч, илрүүлэлт нь хүндрэхийн зэрэгцээ санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал нь хууль бус орлогыг хууль ёсны мэт харагдуулах боломжийг нэмэгдүүлж байгаа бөгөөд Монгол Улсын эрх зүйн зохицуулалт олон улсын жишигт нийцсэн хэдий ч уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн бүтэц, бэлэн мөнгөний өндөр хэрэглээ, хяналтын тогтолцооны зарим сул тал зэрэг нь уг гэмт хэргийг практикт илрүүлэх, нотлох, таслан зогсооход бодит сорилт хэвээр байгааг харуулж байна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь мөн хил дамнасан шинжээрээ онцлог бөгөөд олон улсын санхүүгийн урсгал, оффшор бүс, цахим төлбөрийн хэрэгсэл, виртуал хөрөнгийн зах зээлийг ашиглах замаар хэрэгжих нь нэмэгдэж байна. Даяаршлын нөхцөлд санхүүгийн системийн нээлттэй байдал нэмэгдэхийн хэрээр уг гэмт хэргийн тархалт, нарийн төвөгшил өсөх хандлагатай байгааг олон улсын байгууллагууд тэмдэглэж байна (World Bank, 2022; International Monetary Fund, 2021). Ийм нөхцөл байдал нь зөвхөн нэг улсын хүрээнд бус, олон улсын хамтын ажиллагаанд тулгуурласан хяналт, зохицуулалтын тогтолцоо шаардлагатайг илтгэдэг.

Криминологийн шинжилгээнд мөнгө угаах гэмт хэргийн үүсэх шалтгаан, нөхцөлийг харилцан уялдаатай хэд хэдэн түвшинд авч үздэг. Байгууллагын хүчин зүйлсийн хүрээнд төрийн хяналт, зохицуулалтын сул байдал, авлигын өндөр түвшин нь уг гэмт хэргийн таатай орчныг бүрдүүлдэг. Ил тод байдал хангалтгүй, хяналтын тогтолцоо сул орчинд хууль бус орлогыг нуун далдлах, санхүүгийн системд нэгтгэх боломж нэмэгддэг болохыг судалгаанууд харуулж байна (World Bank, 2022). Үүнтэй

уялдан байгууллагын чадавх, хяналт-шинжилгээний үр нөлөө нь мөнгө угаах гэмт хэргийн тархалтад шууд нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг гэж үздэг.

Мөнгө угаах гэмт хэрэг ба хил хамгаалалтын уялдаа

Мөнгө угаах гэмт хэрэг нь үндэсний болон олон улсын санхүүгийн тогтолцоонд ноцтой сөрөг нөлөө үзүүлж, гэмт бүлэглэлүүдийн үйл ажиллагааг далд хэлбэрээр үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлдэг нарийн зохион байгуулалттай гэмт хэрэг юм.

Энэ төрлийн гэмт хэрэг нь улсын хил дамнасан шинжтэй тул бараа, валют, санхүүгийн урсгалын хяналт болон хууль бус хөрөнгийн хөдөлгөөнийг илрүүлэхэд хил хамгаалалтын байгууллагын оролцоо чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймээс мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа нь хил хамгаалалтын тогтолцоотой салшгүй уялдаатай бөгөөд хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны үр нөлөөнд тулгуурлан хэрэгжих шаардлагатай юм.

1. Бэлэн мөнгөний хил дамнасан хөдөлгөөн

Бэлэн мөнгөний хил дамнасан хөдөлгөөн гэдэг нь хувь хүн, хуулийн этгээд эсвэл зуучлагч байгууллагын зүгээс нэг улсын хилээр бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах санхүүгийн хэрэгслийг нэвтрүүлэх буюу гаргах үйл ажиллагааг хэлнэ. Үүнд их хэмжээний үндэсний болон гадаад валют, чек, үнэт цаас зэрэг биет хэлбэртэй санхүүгийн хэрэгсэл багтдаг бөгөөд энэ нь хууль ёсны худалдаа, хөрөнгө оруулалт, эсхүл хууль бус зорилгоор хийгдэх боломжтой. Иймээс хөдөлгөөн нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй холбоотой тул улсын хил дээр тусгай хяналт, мэдүүлгийн тогтолцоогоор зохицуулагддаг.

Гэмт этгээдүүд их хэмжээний бэлэн мөнгийг хилээр нууцаар гаргах замаар санхүүгийн мөрийг алга болгох оролдлого хийдэг. Энэ нь хилийн шалган нэвтрүүлэх ажиллагаанд илрэх магадлалтай хамгийн түгээмэл эрсдэл юм.

2. Худалдаанд суурилсан мөнгө угаалт

Худалдаанд суурилсан мөнгө угаалт гэдэг нь олон улсын худалдааны гүйлгээг ашиглан хууль бус гаралтай мөнгийг далдлах, шилжүүлэх, хууль ёсны мэт харагдуулах зорилготой санхүүгийн гэмт хэргийн нэг хэлбэр юм. (fatf, 2006)

Энэ нь бараа, үйлчилгээний үнийг зориуд дутуу эсвэл хэтрүүлэн бичих, худал тоо хэмжээ мэдүүлэх, давхар нэхэмжлэх ашиглах зэрэг аргаар гааль, санхүүгийн хяналтаас зайлсхийх замаар хэрэгждэг. Ийнхүү худалдааны урсгалыг ашиглан хууль бус хөрөнгийг олон улсын хэмжээнд хөдөлгөх нь илрүүлэхэд хүндрэлтэй тул өндөр эрсдэлтэй мөнгө угаалтын арга хэлбэрт тооцогддог.

Олон улсын худалдааны баримтыг ашиглан барааны үнийг зориудаар өсгөх/бууруулах, хуурамч импорт, экспорт хийх замаар мөнгө угаах үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь гаалийн хяналттай шууд холбоотой.

3. Хил дамнасан гэмт хэргийн сүлжээ

Хил дамнасан гэмт хэргийн сүлжээ гэдэг нь нэг улсын хилээр хязгаарлагдахгүй, хоёр ба түүнээс олон улсын нутаг дэвсгэрт зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж, хууль бус ашиг олох зорилготой нэгдсэн гэмт этгээдүүдийн тогтолцоог хэлнэ.

Ийм сүлжээ нь хар тамхи, хүн худалдаалах, зэвсгийн наймаа, мөнгө угаах зэрэг олон төрлийн гэмт хэргийг хамтран хэрэгжүүлж, улс орнуудын эрх зүйн болон хяналтын ялгааг ашиглан үйл ажиллагаагаа далд хэлбэрээр өргөжүүлдэг.

Олон улсын судалгаагаар хил дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд нь хил дамнасан шинжтэй тул улс орнуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо, хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоогоор дамжуулан тэмцэх шаардлагатай гэж тодорхойлдог байна. (Nations, 2024)

Мөнгө угаах нь ихэвчлэн хар тамхи, хүн худалдаалах, авлига зэрэг зохион байгуулалттай гэмт хэрэгтэй хавсарч явагддаг. Эдгээр сүлжээ нь олон улсын хил дамнасан бүтэцтэй тул хил хамгаалалтын сул тал дээр тулгуурладаг.

4. Хуурамч бичиг баримт ба нэвтрэлтийн эрсдэл

Хуурамч бичиг баримт ба нэвтрэлтийн эрсдэл гэдэг нь хувь хүн эсвэл бүлэг этгээд хил, гааль болон бусад хяналтын байгууллагын шалгалтаас зайлсхийх зорилгоор хуурамч, засварласан эсвэл бусдын нэр дээрх хүчин төгөлдөр бус бичиг баримт ашиглан улсын хил нэвтрэх, бараа бүтээгдэхүүн, мөнгөн урсгалыг хууль бусаар хөдөлгөх үзэгдлийг хэлнэ.

Энэ төрлийн зөрчил нь хил хамгаалалт, цагаачлалын хяналтын тогтолцоонд ноцтой аюул учруулж, хүн худалдаалах, терроризм, мөнгө угаах зэрэг зохион байгуулалттай гэмт хэргийг дэмжих нөхцөлийг бүрдүүлдэг. Ийм эрсдэл нь ялангуяа хил дамнасан гэмт хэргийн сүлжээтэй хослон хэрэгжих үед илрүүлэхэд төвөгтэй болж, улс орнуудын аюулгүй байдалд шууд нөлөөлдөг гэж олон улсын байгууллагууд анхааруулдаг.

Энэ талаар НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC) нь хуурамч баримт бичиг ашиглах явдлыг хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн нийтлэг хэрэгсэл гэж тодорхойлсон байдаг. (UNTOC, 2000)

Хуурамч паспорт, виз, тээврийн бичиг баримт ашиглан хүмүүс болон хөрөнгийг хилээр хөдөлгөх нь мөнгө угаах ажиллагааг далдлах нэг арга болдог.

5. Дижитал санхүүгийн урсгал

Дижитал санхүүгийн урсгал гэдэг нь банк, финтек платформ, цахим төлбөрийн систем, криптовалютын сүлжээ зэрэг дижитал технологид суурилсан сувгуудаар мөнгөн хөрөнгө болон санхүүгийн үнэ цэнэ цахим хэлбэрээр шилжих хөдөлгөөнийг хэлнэ.

Энэ нь төлбөр тооцоо, гадаад шилжүүлэг, цахим худалдаа, хөрөнгө оруулалт зэрэг олон төрлийн санхүүгийн үйл ажиллагааг бодит цагийн горимоор гүйцэтгэх боломж олгож, санхүүгийн үйлчилгээний хүртээмж, хурд, үр ашгийг нэмэгдүүлдэг. Гэвч дижитал урсгалын ил тод бус байдал, хил дамнасан зохицуулалтын ялгаа нь мөнгө угаах болон санхүүгийн гэмт хэрэгт ашиглагдах эрсдэлийг дагуулдаг тул олон улсын түвшинд хяналт, зохицуулалтын хамтын ажиллагаа чухал гэж үздэг.

Энэ талаар Олон улсын валютын сан (IMF) дижитал санхүү нь санхүүгийн системийн үр ашгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ шинэ эрсдэл, ялангуяа гэмт хэргийн санхүүжилтийн суваг болох боломжийг бий болгож байгааг онцолдог. (Fund, 2026)

Криптовалют болон цахим шилжүүлгийн системийг ашиглан хил дамнасан хяналтаас зайлсхийх хандлага нэмэгдэж байна. Энэ нь уламжлалт хилийн хяналтыг шинэ түвшинд шинэчлэх шаардлага бий болгож байна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь хууль бус аргаар олсон хөрөнгийг хууль ёсны мэт харагдуулах зорилготой бөгөөд ихэвчлэн олон улсын шинжтэй санхүүгийн урсгалаар дамжин хэрэгждэг нарийн зохион байгуулалттай гэмт хэрэг юм. Ийм төрлийн гэмт хэрэг нь хил дамнасан мөнгөн гүйлгээ, бараа бүтээгдэхүүний хөдөлгөөн, болон гуравдагч орнуудын санхүүгийн системийг ашиглах замаар хэрэгждэг тул хил хамгаалалтын үйл ажиллагаатай шууд уялдаа холбоотой байдаг.

Хилийн хяналт нь бэлэн мөнгөний хууль бус хөдөлгөөн, хуурамч мэдүүлэг, сэжигтэй бараа, болон бичиг баримтын зөрчлийг илрүүлэх замаар мөнгө угаах гэмт хэргийн суурь урсгалыг таслан зогсоох чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн хил хамгаалалтын байгууллагууд нь гааль, цагдаа, тагнуулын байгууллагатай мэдээлэл солилцох замаар сэжигтэй санхүүгийн урсгалыг илрүүлэхэд оролцдог.

Мөнгө угаах гэмт хэрэг нь ихэвчлэн худалдаанд суурилсан арга, хуурамч бичиг баримт, дижитал санхүүгийн урсгал зэрэг хил дамнасан механизмтай хослон үйлдэгддэг. Ийм нөхцөлд хил хамгаалалтын тогтолцоо нь зөвхөн физик нэвтрэлтийг хянахаас гадна санхүүгийн гэмт хэргийн эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх үүрэгтэй болдог.

Олон улсын байгууллагууд, тухайлбал FATF, хил дамнасан санхүүгийн урсгалын хяналт нь мөнгө угаахтай тэмцэх үндсэн бүрэлдэхүүн хэсэг гэж тодорхойлсон байдаг . НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC) нь мөнгө угаах гэмт хэрэг нь зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээтэй салшгүй холбоотой бөгөөд хил дамнасан хяналт сул орон зайг ашиглан өргөждөг гэж үздэг . Иймээс хил хамгаалалт болон мөнгө угаахтай тэмцэх тогтолцооны уялдаа нь үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдалд шууд нөлөөлөх стратегийн ач холбогдолтой юм.

Хил хамгаалах байгууллагатай харилцан хамаарлын төлөв. Мөнгө угаах гэмт хэрэг нь ихэвчлэн хил дамнасан шинжтэй санхүүгийн урсгал, бэлэн мөнгөний хөдөлгөөн, бараа бүтээгдэхүүний худалдаанд суурилсан далд схемүүдээр хэрэгждэг тул улсын хилийн хяналттай шууд холбоотой байдаг.

Хил хамгаалах байгууллага нь сэжигтэй мөнгөн урсгал, хууль бус бэлэн мөнгө нэвтрүүлэх оролдлого, хуурамч бичиг баримтаар хил нэвтрэх зэрэг үйлдлийг илрүүлэх замаар мөнгө угаах гэмт хэргийн суурь нөхцөлийг таслан зогсоох чухал үүрэгтэй. Иймээс мөнгө угаах гэмт хэрэг болон хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа нь харилцан хамааралтай бөгөөд үр дүнтэй хамтын ажиллагаа нь үндэсний болон олон улсын санхүүгийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Мөнгө угаах гэмт хэрэг нь бэлэн мөнгөний хил дамнасан хөдөлгөөн, худалдаанд суурилсан мөнгө угаалт, дижитал санхүүгийн урсгал зэрэг олон сувгаар илэрч, улсын хилийн хяналтаас давсан нарийн зохион байгуулалттай шинжтэй байдаг. Энэ нь хил дамнасан гэмт хэргийн сүлжээ, хуурамч бичиг баримтын ашиглалттай нягт уялдаж, бараа, валют, мэдээллийн урсгалыг далд хэлбэрээр хөдөлгөх замаар илрүүлэхэд хүндрэлтэй нөхцөл бүрдүүлдэг.

Иймээс мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа нь хил хамгаалалт, гааль, санхүүгийн хяналтын байгууллагуудын уялдаа холбоо, мэдээлэл солилцоо, хамтарсан эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан нэгдмэл тогтолцоогоор хэрэгжих шаардлагатай байна.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд хил хамгаалах байгууллагад тулгамдаж буй гол асуудлын нэг нь хил дамнасан бэлэн мөнгө, бараа, санхүүгийн урсгалын огцом нэмэгдэлтэй уялдуулан эрсдэлийг бүрэн илрүүлэх техник, аналитик чадавх харьцангуй хязгаарлагдмал байгаа явдал юм.

Мөн хуурамч бичиг баримт ашиглах, дижитал санхүүгийн сувгуудыг давхар ашиглах зэрэг нарийн арга хэлбэрүүд нэмэгдсэн нь уламжлалт хилийн шалган нэвтрүүлэх хяналтаар илрүүлэх боломжийг бууруулж байна. Үүнээс гадна гааль, цагдаа, санхүүгийн тагнуулын байгууллагуудтай мэдээлэл солилцох нэгдсэн, бодит цагийн интеграц сул байгаа нь сэжигтэй урсгалыг эрт илрүүлэхэд хүндрэл үүсгэдэг. Олон улсын байгууллагууд, тухайлбал FATF санхүүгийн байгууллага, хил дамнасан мөнгө угаалтын эрсдэл нь мэдээллийн уялдаа холбоо, хяналтын тогтолцооны сул тал дээр тулгуурлан ашиглагддаг болохыг онцолдог . Мөн хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүй байх нь гол эмзэг цэг болдог гэж тэмдэглэсэн байдаг.

Дүгнэлт

Мөнгө угаах гэмт хэрэг нь бэлэн мөнгөний хил дамнасан хөдөлгөөн, худалдаанд суурилсан гүйлгээ, хуурамч бичиг баримт, дижитал санхүүгийн урсгал зэрэг олон сувгаар хэрэгждэг тул хил хамгаалалтын үйл ажиллагаатай салшгүй уялдаа холбоотой байна.

Энэ гэмт хэрэг нь ихэвчлэн зохион байгуулалттай хил дамнасан сүлжээгээр дамжин үйлдэгддэг бөгөөд хил, гаалийн хяналтын сул талыг ашиглан хууль бус хөрөнгийг хөдөлгөх нөхцөл бүрдүүлдэг. Ийм нөхцөлд хил хамгаалах байгууллага нь зөвхөн физик нэвтрэлтийг хянах бус санхүүгийн урсгал, эрсдэлийн мэдээлэлд суурилсан тандалт хийх шаардлагатай болдог.

Түүнчлэн мөнгө угаах гэмт хэрэг нь бэлэн мөнгө, бараа бүтээгдэхүүн, хүн болон цахим санхүүгийн урсгалаар дамжин хил дамнасан шинжтэйгээр хэрэгждэг тул хил хамгаалалт, гааль, санхүүгийн хяналтын тогтолцоотой салшгүй уялдаатай байна. Иймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд хил хамгаалалтын чадавхыг зөвхөн физик хяналтаар бус, олон улсын хамтын ажиллагаа, санхүүгийн мэдээллийн солилцоо, эрсдэлийн суурьтай хяналтын системээр цогцоор нь бэхжүүлэх шаардлагатай болоод байна.

Иймээс Монгол Улсад хил хамгаалалт, гааль, санхүүгийн хяналтын байгууллагуудын нэгдсэн уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах нь энэ төрлийн гэмт хэргийн эрсдэлийг бууруулах гол нөхцөл юм.

Санал

Бид дээрх бүх материалд шинжилгээ хийж, дараах саналуудыг дэвшүүллээ. Эдгээр саналууд нь Монгол Улсын хил хамгаалалт, гааль, санхүүгийн хяналтын тогтолцоог уламжлалт физик шалгалтаас хиймэл оюун, өгөгдөлд суурилсан, олон байгууллагын уялдаа бүхий ухаалаг систем рүү шилжүүлэх зорилготой юм. Ингэснээр мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх үр нөлөө мэдэгдэхүйц нэмэгдэх боломжтой гэж үзэж байна. Тухайлбал:

Хил дээр “Бодит цагийн мөнгө угаалтын эрсдэлийн үнэлгээний систем” нэвтрүүлэх

Хилийн боомт бүрт зорчигч, тээвэр, бараа бүтээгдэхүүнд эрсдэлийн оноо бодит цагт тооцдог систем нэвтрүүлэх. Өөрөөр хэлбэл хиймэл оюун ашиглан сэжигтэй бэлэн мөнгө, давтамжтай хөдөлгөөн, өндөр эрсдэлтэй улс орнуудыг шууд илрүүлэх боломжтой.

Хил дамнасан “санхүүгийн мэдээллийн тусгай гарц” байгуулах

Криптовалют болон цахим мөнгөний урсгалыг хянах зорилгоор хил дээрх санхүүгийн мэдээллийн тусгай гарц, блокчейн шинжилгээний систем бий болгох шаардлагатай байна. Энэ нь дижитал хэлбэрээр хийгдэж буй мөнгө угаалтыг илрүүлэх шинэ механизм болох юм.

Гааль, Төв банкны мэдээллийн нэгж, Хил хамгаалах байгууллага хамтран “Мэдээлэл нэгтгэн шинжлэх төв”-ийг байгуулах.

Гурван байгууллагын мэдээллийг нэгтгэсэн төв байгуулсанаар гаалийн мэдүүлэг, хил нэвтрэх мэдээлэл, сэжигтэй санхүүгийн гүйлгээ зэрэг олон эх сурвалжийн мэдээллийг нэг дор шинжилснээр мөнгө угаах сүлжээг илүү хурдан илрүүлэх боломжтой болно.

Хил дээр “зан үйлийн биометрик ба хиймэл оюун ухаанд суурилсан хяналт”-ыг ашиглах.

Зорчигчийн а/хөдөлгөөний хэв маяг, б/мэдрэлийн/сэтгэлзүйн зан байдал, в/давтамжтай зорчих зуршил зэргийг хиймэл оюунаар шинжилж сэжигтэй этгээдийг илрүүлэх ажиллагаа явуулна. Зөвхөн бичиг баримт бус, зан төлөвт суурилсан хяналтаар нэвтрүүлнэ гэсэн үг юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Council of Europe. (2005). *Council of Europe Convention on Laundering, Search, Seizure and Confiscation of the Proceeds from Crime and on the Financing of Terrorism*.
- Europol. (2021). *Serious and organised crime threat assessment (SOCTA)*.
- Financial Action Task Force. (2012). *International standards on combating money laundering and the financing of terrorism & proliferation (FATF Recommendations)*.
- Financial Action Task Force. (2020). *Money laundering typologies report*.
- International Monetary Fund. (2021). *Revenue administration and compliance risk management*. Washington, DC.
- Mekpor, E. S., et al. (2018). *Determinants of anti-money laundering compliance*.
- Organisation for Economic Co-operation and Development. (2023). *Fighting tax crime: The ten global principles*. Paris.
- United Nations. (2000). *Convention against transnational organized crime*. New York.
- United Nations. (2003). *United Nations convention against corruption*. New York.
- United Nations Office on Drugs and Crime. (2005). *Crime and development studies*.
- United Nations Office on Drugs and Crime. (2009). *Model provisions on money laundering*.
- United Nations Office on Drugs and Crime. (2023). *Global reports on money laundering and organized crime*.
- World Bank. (2022). *Financial market integrity and anti-money laundering*. Washington, DC.

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ ХИЛИЙН ЦЭРГИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ШАЛГАХ ЗӨРЧИЛ

А.ШИНЭЖИЛ*
Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

**хариуцлагатай зохиогч: eolka33@gmail.com*

Хураангуй: Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд 2017 онд "Зөрчлийн тухай хууль" болон "Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль" шинээр батлагдсанаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зөвхөн цагдаагийн байгууллага хэрэгжүүлдэг гэсэн уламжлалт ойлголт өөрчлөгдөж, нийт ойролцоогоор 68 байгууллагын эрх бүхий албан тушаалтанд зөрчил шалгах эрх олгогдсон байна. Энэхүү шинэчлэл нь нэг талаас захиргааны хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох ач холбогдолтой боловч нөгөө талаас янз бүрийн байгууллагын эрх мэдлийн хил заагийг тодорхой болгох шаардлага бий болгосон. Хилийн цэргийн байгууллагын эрх бүхий албан хаагч нь өөрийн мэргэжлийн чиг үүргийн хүрээнд ямар зөрчлийг, ямар нөхцөлд шалгах эрхтэй болохыг хуульд зааж өгсөн.

Монгол Улсын "Зөрчлийн тухай хууль", "Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль"-ийн холбогдох заалтуудыг хууль зүйн задлан шинжилгээний аргаар судалж, Хилийн цэргийн болон Цагдаагийн байгууллагын зөрчил шалгах эрх, үүргийг харьцуулан дүн шинжилгээ хийсэн. Зөрчлийн бүрэлдэхүүний онолын үндэслэлийг тайлбарлахын зэрэгцээ хуульд тусгайлан заасан зөрчлийн жагсаалтыг ангилан, ноогдуулах шийтгэлийн хэмжээ болон хэрэглэх арга хэмжээний харьцуулалтыг хийсэн.

Судалгааны үр дүнд Хилийн цэргийн алба хаагч нь хилийн болон хил орчмын хязгаарлагдмал орон зайд, хуулиар тогтоосон тодорхой ангиллын зөрчлийг шалгах бол Цагдаагийн байгууллага нь нутаг дэвсгэр даяар нийгмийн хэв журам, аюулгүй байдлын өргөн хүрээний зөрчлийг шалгадаг болохыг тогтоосон. Хилийн цэргийн шалгах зөрчлүүд нь давтамж бага, илрүүлэхэд ярвигтай, харин гарсан тохиолдолд нийгэм, улсын аюулгүй байдалд үзүүлэх сөрөг үр дагавар нь өргөн цар хүрээтэй байдгийг онцолсон. Уг судалгаа нь хоёр байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэргэжлийн сургалтыг нэмэгдүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал дэвшүүлснээрээ ач холбогдолтой.

Түлхүүр үгс: зөрчил; зөрчлийн бүрэлдэхүүн; хилийн цэргийн алба хаагч; зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа; эрх бүхий албан тушаалтан; цагдаагийн байгууллага; хилийн дэглэм; захиргааны хариуцлага; хууль зүйн харьцуулалт; хилийн боомт

Keywords: violation; corpus delicti; border military official; violation investigation procedure; authorized official; national police organization; border regime; administrative liability; legal comparison; border port of entry

Үндсэн хэсэг

Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ (Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017). Зөрчил гэдэг нь Зөрчлийн тухай хуулиар хамгаалсан эрх ашиг, сонирхол, тодорхой төрлийн нийгмийн харилцааг зөрчиж байгаа тус хуульд заасан үйлдэл, эс үйлдэхүйг ойлгож болно. Зөрчлийн бүрэлдэхүүн нь тухайн этгээдийг тодорхой төрлийн зөрчил үйлдсэн гэж үзэхэд зайлшгүй шаардагдах гадаад болон дотоод хүчин

зүйлсийн нийлбэр юм. Зөрчлийн бүрэлдэхүүн нь зөрчлийн объект, обьектив тал, субъект субьектив тал гэсэн дөрвөн шинжийг заавал агуулдаг. Тухайн дөрвөн шинж нийлж тодорхой зөрчлийн бүрэлдэхүүнийг тогтоодог. Эдгээр шинж нь бусад зөрчлөөс ялгагдах гол онцлог нь болж өгдөг. Тодорхой зөрчлийн бүрэлдэхүүнийг Монгол улсын Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид тогтоосон байдаг.

Зөрчлийн объект гэдэг нь Монгол улсын нутаг дэвсгэрт болон тодорхой нутаг дэвсгэрт дагаж мөрдөхөөр тогтоосон захиргааны журмаар хамгаалагдаж байгаа нийгмийн харилцаа юм. Нарийвчилбал хууль болон тодорхой хэм хэмжээгээр хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө, нийгэм, төрийн эрх ашиг юм.

Зөрчлийн обьектив тал гэдэг нь Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил гаргагчийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй, нийгэм, иргэнд учруулсан хор уршиг, хууль бус үйлдэл, эс үйлдэхүй болон түүний улмаас учирсан хор уршиг хоёрын шалтгаант холбоо юм. Зөрчлийн тухай хуульд ихэвчлэн хор уршиг буюу хохирлыг тусгаж өгөхдөө эрүүгийн хуульд хариуцлага хүлээлгэхээр заагаагүй бол хэмээн зааж өгсөн байдаг.

Зөрчлийн субъект нь зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн, хуулийн этгээд байна (Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017) гэж заасан байна. Шийтгэл хүлээх чадвартай байх нь зөрчлийн субъект байх чухал шинж юм. Шийтгэл хүлээх чадваргүй гэдэгт өөрийн үйлдлийг хариуцаж, жолоодож чадахгүй болсныг ойлгодог. Энэ байдлыг эмнэлгийн болон сэтгэл зүйн шалгуурын үндсэн дээр шийдвэрлэнэ. Зөрчил үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүнд шийтгэл оногдуулахгүйгээр хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Зөрчлийн субьектив тал гэдэг нь зөрчил гаргагч нь Зөрчлийн тухай хуульд заасан хэм хэмжээг зөрчсөн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйдээ хэрхэн хандаж байгааг илэрхийлэх сэтгэхүйн харьцаа юм.

Зөрчлийн субьектив талын шинжийг хууль зүйн ач холбогдлоор нь үндсэн ба нэмэгдэл гэж ангилна. Үндсэн шинжид зөрчил гаргагчийн гэм бурууг хамааруулна.

Гэм буруу нь санаатай буюу болгоомжгүй хэлбэртэй байна. Гэм буруугийн санаатай хэлбэр нь субъект өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг ухамсарлан ойлгосон бөгөөд өөрийн үйлдэл эс үйлдэхүйн улмаас учрах хор уршгийг мэдсээр байж хүсэж буюу эсхүл тэр хор уршигт зориудаар хүргэсэн байхыг хэлнэ.

Гэм буруугийн болгоомжгүй хэлбэр нь тухайн үйлдэл, эс үйлдэхгүйг нийгмийн хор аюулыг ухамсарлаагүй, мөн ухамсарлах, урьдчилан харах ёстой байтал урьдаас харж чадаагүй эсхүл зөрчихгүй байж чадна гэж баттай итгэсэн боловч хор уршиг учруулсан явдал юм.

“Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-д байгууллага тус бүрээр ангилж зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтныг ойролцоогоор 68-аар тогтоож өгсөн байдаг. Энэ нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зөвхөн цагдаагийн байгууллага хэрэгжүүлдэг гэх өрөөсгөл ойлголтыг няцааж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.2 дугаар хэсэгт хилийн төлөөлөгч, орлогч, туслагч:

- Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйл 5.6 дугаар зүйл” Хууль бусаар зэвсэг эзэмших”-ийн 9 “Галт зэвсэг, сумыг улсын хилээр нэвтрүүлэх журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”, 10 Спорт-сургалт, ан агнуурын зориулалтаар галт зэвсэг улсын хилээр

нэвтрүүлэх журам зөрчсөн бол хүнийг дөчин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно,

- 5.11 дүгээр зүйл “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих”-ийн 1.3 Химийн хорт, аюултай бодис хилээр дамжуулан тээвэрлэсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хурааж, зөрчлийг арилгуулж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 6.4 дүгээр зүйл “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих”-ийн 2.8 Мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй, сэтгэцэд нөлөөт эм, бодис, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэх журам зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 7.3 дугаар зүйл “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих” Монгол Улсын хуулиар ховор, нэн ховор амьтны жагсаалтад ороогүй боловч Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцын хавсралтад орсон амьтан, ургамал, эсхүл тэдгээрийн гаралтай эд зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 14.8 дугаар зүйл “Иргэний нисэхийн тухай хууль зөрчих”-ийн 6. Олон улсын нислэг үйлдэгч агаарын тээвэрлэгч нь зорчигчийн мэдээллийг иргэний агаарын хөлөг хөөрөхөөс өмнө эрх бүхий байгууллагад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүргүүлээгүй, эсхүл мэдээллийг дутуу хүргүүлсэн бол агаарын тээвэрлэгч хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 15.2 дугаар зүйл “Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах”-ийн 2.Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа: 2.1.төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан; 2.2.төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд нь саад учруулсан; 2.3.төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 15.20 дугаар зүйл “Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль зөрчих” 2.Төрийн бэлгэ тэмдгийг санаатайгаар гуйвуулан өөрчлөх, устгах, гэмтээх зэргээр гутаасан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 16.1 Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих

o 1.Монгол Улсын: 1.1.хилийн болон хил орчмын дэглэм; 1.2.хилийн боомтод мөрдөх журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

o 2.Хилийн боомтод хяналт шалгалтын тогтоосон дарааллыг зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

o 3.Зөвшөөрөлгүйгээр хилийн боомтын хяналт шалгалтын бүсэд үйл ажиллагаа явуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

- 16.4 дүгээр зүйл Чөлөөт бүсийн тухай хууль зөрчих 1.Чөлөөт бүсэд баримтлах тусгай дэглэмийг зөрчсөн бол чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгож хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно (Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017) гэх зөрчлүүдийн Хилийн цэргийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан шалгана гэж заасан байна.

Хилийн цэрэг, Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны зөрчил шалган шийдвэрлэх чиг үүрийг хүрээнд эдэлж буй эрх, үүргийн харьцуулалт:

Үндсэн төрөл	Хилийн цэргийн алба	Цагдаагийн байгууллага
Хяналтын нутаг дэвсгэр	Хилийн зурвас, боомт, хил дамнасан бүс	Бүх нийтийн газар нутаг — суурин, хот, хөдөө
Харьяалагдах хууль	Хилийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гаалийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль	Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль,
Харьяалагдах яам	Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ)	Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ)
Хяналт тавих субъект	Хил нэвтрэх, гаалийн дүрэм зөрчсөн этгээд	Монгол улсын нийт иргэд, хуулийн этгээд

Төрөл	Хилийн цэргийн алба	Цагдаагийн байгууллага
Хил, гааль	• Зөвшөөрөлгүй хил нэвтрэх /хууль бус нэвтрэлт/ • Хилийн дэглэм зөрчих • Хил орчмын бүсэд зөвшөөрөлгүй байх • Гаалийн барааг нуун дарагдуулах, контрабанд • Хилийн тэмдэг, заагийг устгах, гэмтээх	*Шалгадаггүй (хил хамгаалалтын чиг үүрэг биш)*
Гадаад иргэн	• Визний дүрэм зөрчих • Хуурамч паспорт, баримт бичиг ашиглах • Хөдөлмөрийн зөвшөөрөлгүй ажиллах • Хэт удаан оршин суух	• Гадаад иргэний бүртгэлийн зөрчил • Оршин суух зөвшөөрөл зөрчих /Хилийн цэрэгтэй хамтран шалгах тохиолдол бий/

Төрөл	Хилийн цэргийн алба	Цагдаагийн байгууллага
Хөдөлгөөний аюулгүй байдал	• Хил орчмын авто зам дахь дүрэм зөрчил • Хилийн бүсэд тээврийн хэрэгслийн хяналт	• Замын хөдөлгөөний дүрэм зөрчих • Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох • Жолооны үнэмлэхгүй жолоодох • Осол, мөргөлдөөний шалтгаан
Нийгмийн хэв журам	• Хилийн боомт, постын орчимд хэв журам зөрчих • Хилийн бүсэд танхайрах	• Танхайрах, бусдыг зодох • Дуу чимээ, хэв журмын зөрчил • Олон нийтийн газарт архидан согтуурах • Хулгай, дээрэм, залилан
Хориглосон зүйл	• Хориотой бараа, зэвсэг, мансуурал хил нэвтрүүлэх • Соёлын өв, ховор амьтан, ургамлыг гадагш гаргах • Стратегийн барааны хяналт	• Галт зэвсэг, тэсрэх бодис хууль бусаар эзэмших • Мансуурах бодис хэрэглэх, тараах • Хулгайлсан эд хөрөнгө эзэмших
Байгаль орчин	• Тусгай хамгаалалттай газарт хилийн бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэх • Ан агнуурын бүтээгдэхүүн хил нэвтрүүлэх	• Байгаль орчныг бохирдуулах • Зөвшөөрөлгүй ан агнах • Мод огтлох, ашигт малтмал хууль бусаар олборлох

Арга хэрэгсэл	Хилийн цэргийн алба	Цагдаагийн байгууллага
Торгуул	Хилийн болон гаалийн зөрчлийн торгуул	Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуул
Саатуулах	Хил нэвтрүүлэхийг зогсоох, буцаах	Гэмт хэргийн сэжигтнийг баривчлах
Барааг хураах	Хориотой болон гааль төлөөгүй бараа хурааж авах	Гэмт хэргийн хэрэгсэл, эд мөрийн баримт хурааж авах
Хянан шалгах	Тээврийн хэрэгсэл, ачаа, биед өдөр тутам үзлэг хийх	Байр, эд хөрөнгө нэгжлэг хийх /шүүхийн зөвшөөрлөөр/
Эрүүгийн хэрэг үүсгэх	Хилийн хэрэгт ноцтой зөрчлийн хувьд	Бүх эрүүгийн гэмт хэрэгт
Хамтарсан ажиллагаа	Цагдаа, тагнуул, гаальтай хамтарч ажиллана	Прокурор, шүүх, хилийн цэрэгтэй хамтарч ажиллана

Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь улс ороны дотоод аюулгүй байдал буюу Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа хүний аюулгүй байдлыг хангах чиглэлээр илүү түлхүү чиг үүрэг гүйцэтгэж Хилийн цэргийн эрх бүхий албан хаагчийн харьяалуулсан зөрчил нь давтамж багатай боловч илрүүлэхэд ярвигтай, гэмт хэргээр ялгарах онцлог бага, гарсан тохиолдолд сөрөг үр дагавар ихтэй зөрчлүүд байна.

Дүгнэлт

Хилийн цэргийн алба хаагч нь хилийн болон хил орчмын бүс дэх тодорхой хязгаарлагдмал орон зайд, хуулиар тогтоосон ангилалд хамаарах зөрчлийг шалган шийдвэрлэх бол Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь Монгол Улсын нутаг дэвсгэр даяар иргэдийн аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамарсан өргөн хүрээний зөрчлийг шалган шийдвэрлэдэг.

Хилийн цэргийн алба хаагчийн харьяалуулсан зөрчлүүд нь давтамж багатай боловч илрүүлэхэд ярвигтай, гэмт хэргээс ялгах онцлог бага байдаг ч гарсан тохиолдолд сөрөг нийгмийн үр дагавар нь илүү өргөн цар хүрээг хамардаг. Цагдаагийн байгууллагын шалгадаг зөрчлүүд нь өдөр тутмын амьдралд нийтлэг тохиолддог, шалгахад харьцангуй ойлгомжтой боловч нийгмийн хэв журамд шууд нөлөөлдөг.

"Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль"-д байгууллага тус бүрээр ангилж зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтныг ойролцоогоор 68-аар тогтоосон нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зөвхөн цагдаагийн байгууллага хэрэгжүүлдэг гэх өрөөсгөл ойлголтыг няцааж байна. Энэ нь олон байгууллагын зэрэгцээ чиг үүрэгт суурилсан нарийн тогтолцоог бий болгосон ч хэрэгжилтийн явцад бэрхшээл гарч байгааг харуулж байна.

Хоёр байгууллага хоёулаа Хууль зүй, дотоод хэргийн яаманд харьяалагддаг боловч хэрэгжүүлдэг эрх зүйн акт, ашиглах журам, хариуцлагын тогтолцоо харилцан адилгүй байгаа нь уялдаа холбооны хувьд нэмэлт зохицуулалт шаарддаг.

Санал

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч албан тушаалтанд харьяалуулсан зөрчлүүдийг нарийвчлан тайлбарласан гарын авлага гаргах.

Мэргэжлийн чадамж, сургалтыг нэмэгдүүлэх. Хилийн цэргийн алба хаагчдад зориулан зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу явуулах ажиллагаа, нотлох баримт цуглуулах, иргэний эрхийг хамгаалах чиглэлийн тусгай хууль зүйн сургалтыг жил тутам зохион байгуулах.

Хилийн албаны сургуулийн сонсогч, суралцагч нарт Зөрчлийн тухай ойлголт, зөрчил шалгах ажиллагаа, “Зөрчлийн тухай хууль”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-ийн хэрэглэх талаарх агуулга бүхий хичээл заах.

Зөрчлийн шалгалтын ажиллагааны практик дасгалжуулалт, онолын мэдлэгийг сайжруулах зорилгоор бусад байгууллага хамтран дадлага сургуулилт хийж мэдээлэл солилцох үйл ажиллагаа хэрэгжүүлэх.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хянах үндсэн чиг үүрэг бүхий “Прокурор”-ын байгууллагатай хамтран “Зөрчил шалгах хилийн цэргийн эрх бүхий албан тушаалтан”, “Зөрчлийн хяналтын прокурор”-уудын хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж хэвших.

Эх сурвалж

1. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он, №24 Зөрчлийн тухай хууль
2. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он, №24 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
3. Монгол Улсын Шүүхийн Ерөнхий зөвлөл. (2020). Захиргааны хэрэг шийдвэрлэх ажиллагааны статистик дүн шинжилгээ. Улаанбаатар.
4. Батсайхан О., Цэрэнпунцаг Б. (2019). Зөрчлийн эрх зүй: Онол, практик. Улаанбаатар
5. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам. (2022). Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийн үнэлгээ. Улаанбаатар.
6. Намдаг Ж. (2018). Монгол Улсын эрүүгийн болон захиргааны хариуцлагын зааг, харьцаа. Монголын хуульчдын холбооны эрдэм шинжилгээний бичиг, №3. Улаанбаатар.

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТЭД ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГА НӨЛӨӨЛӨХ НЬ

С.БЯМБА-ЭРДЭНЭ*
Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, ахмад, "Их Засаг" их сургуулийн докторант
**хариуцлагатай зохиогч:Byaaba97@gmail.com*

Хураангуй: Монгол Улсын нэрийн өмнөөс Иргэний хэргийн шүүхээс гарсан хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй байгаа хариуцагчийн үйлдэлд нэхэмжлэгч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх шүүгчийн захирамж гаргуулах, улмаар гүйцэтгэх хуудас бичүүлэх замаар шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлж шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулдаг.

Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэж шүүхийн шийдвэрт заасан өр төлбөрийг төлүүлэх, үүргийн биелэлтийг хангуулахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага голлох үүрэгтэй байж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх бөгөөд тус байгууллагыг төлөөлж, иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах эрхийг хуульд зааснаар зөвхөн шийдвэр гүйцэтгэгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгч нарт олгосон байдаг.

Зарим төлбөр төлөгч, тэтгэлэг төлөгч нар шүүхийн шийдвэрт заасан төлбөр, үүргийг биелүүлэхээс санаатай зайлсхийж Монгол Улсын хилээр гарах, удаан хугацаанд хилээр нэвтрэхгүй, эх орондоо ирэхгүй, бусдад төлөх ёстой өр төлбөрөө төлөхгүй, иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах үйлдлийг хийдэг.

Хил хамгаалах байгууллагаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга, Шийдвэр гүйцэтгэх албаны дарга бөгөөд Улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн ирүүлсэн тогтоолын дагуу төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээ авдаг. Өгүүллийн хүрээнд төлбөр төлөгчийн гадаад зорчих эрхийг түдгэлзүүлэх нь Хил хамгаалах байгууллага болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хамтын ажиллагаагаар хэрэгждэг иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг төрөл болох талаар өгүүлнэ.

Түлхүүр үгс: Хил, хилийн хориг, гадаад зорчих эрх, шүүхийн шийдвэрийн биелэлт, иргэн.

Удиртгал:

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.18 дахь хэсэгт "Монгол Улсын иргэн улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно" гэж заасан байдаг (Төрийн мэдээлэл эмхэтгэл №1, 1992). Энэ заалт нь иргэний гадаадад зорчих эрхийг хүн амын болон үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар хязгаарладаг гэж заажээ.

Улсын их хурлаас 2001 онд баталсан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх

хэсэгт "Үндэсний аюулгүй байдал" гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ" гэж, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "Үндэсний язгуур ашиг сонирхол"-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана" гэж, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт "Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа" гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлэх тал бүрийн баталгаа бий болгоход чиглэсэн төрийн бодлогыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ" гэж тус тус тодорхой заасан байдаг (Төрийн мэдээлэл эмхэтгэл №3, 2002). Нэг ёсондоо Монгол Улс тусгаар тогтносон бүрэн эрхт байдлаа удаан хадгалах, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмний аугаа соёл иргэншил, иргэдийн эрх чөлөө, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалахад чиглэсэн төрийн бүхий бодлогыг хэрэгжүүлэхэд Хил хамгаалах байгууллага болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд чухал үүрэгтэй.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт "Үндэсний аюулгүй байдал нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна" гэж заагаад 10 төрлийн аюулгүй байдлыг хуульчилсан. Үүнд: Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал, нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдал, экологийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал зэргийг багтаажээ (Төрийн мэдээлэл эмхэтгэл №3, 2002).

Үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй Хил хамгаалах байгууллага болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд бөгөөд хуульд тусгайлан зааж баталгаажуулсан байдаг. Тухайлбал,

Монгол Улсын Хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх хэсэгт "улсын хил хамгаалах байгууллага" гэж Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбарыг" хэлнэ гэж заасан байдаг (Төрийн мэдээлэл эмхэтгэл №6, 2017).

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт "Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд" гэж заагаад мөн хуулийн 7.1.6 дэх хэсэгт "Зэвсэгт хүчин, **бусад цэрэг**" гэж /энэ хэсэгт Хил хамгаалах байгууллага хамаарна/, мөн хуулийн 7.1.8 дахь хэсэгт "Тусгай албa" гэж /энэ хэсэгт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага/ тус тус заажээ. (Төрийн мэдээлэл эмхэтгэл №3, 2002).

Хил хамгаалах байгууллага болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хамтын ажиллагааг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт "Төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах үүрэгтэй" гэж заасан (Төрийн мэдээлэл эмхэтгэл №3, 2002).

Монгол Улсын Хилийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт "Улсын хил хамгаалах байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд зэвсэгт хүчин, тагнуул, цагдаагийн болон холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллана" гэж

заасан байдаг (Төрийн мэдээлэл эмхэтгэл №6, 2017). Үүнээс харахад хоёр байгууллагын хамтын ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалахад чиглэдэг байна.

Төлбөрөө төлөхгүй гадаад улс оронд оргон зайлах, зугтах сэдэлтэй төлбөр төлөгч нарыг гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тогтоолыг шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн Улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгч гаргах боловч тухайн тогтоолын биелэлтийг шуурхай хангаж ажилладаг байгууллага бол Хил хамгаалах ерөнхий газар юм. Цаашид төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг хэрхэн түдгэлзүүлж байгаа талаар өгүүлнэ.

Үндсэн хэсэг: 2017 онд батлагдсан Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр өөрчлөлт орж шинээр 59 дүгээр зүйлийг нэмсэн. Энэ зүйл нь гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх заалт юм (Төрийн мэдээлэл эмхэтгэл №24, 2017).

Мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт “Тавин сая төгрөгөөс дээш хөрөнгийн шаардлага бүхий гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, эсхүл тэжээн тэтгэх үүргээ 3 сараас дээш хугацаагаар биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг дараах үндэслэлээр түдгэлзүүлж болно” гэж заасан (Төрийн мэдээлэл эмхэтгэл №24, 2017). Тухайлбал,

Эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн, хөрөнгөө нуун дарагдуулсан, төлбөр төлөхөөс зайлсхийх зорилгоор гадаад улсад оргон зайлж болзошгүй гэх үндэслэлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл шийдвэр гүйцэтгэгчээс төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх мэдэгдэх хуудсыг хүргүүлж, ахлах шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэж, ажлын 3 хоногийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх саналыг хүргүүлж шийдвэрлэдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт орсны дараа Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд 2020 онд 2732 гүйцэтгэх баримт бичигт холбогдох 2162 иргэн, хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай Улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолыг Хил хамгаалах ерөнхий газарт хүргүүлж, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлснээс шүүхийн шийдвэрт заасан төлбөрөө бүрэн төлж шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон 52 гүйцэтгэх баримт бичгийн 61 төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих эрхийг сэргээх тогтоолыг Хил хамгаалах ерөнхий газарт хүргүүлж, тус газраас иргэдийн гадаадад зорчих эрхийг сэргээсэн байдаг (Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын судалгаа, 2020).

Мөн тус газрын 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 510 төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон 94 төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тогтоолыг Хил хамгаалах ерөнхий газарт илгээж, гадаад зорчих эрхийг сэргээсэн байна (Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын судалгаа, 2021).

Банкны төлбөр барагдуулах газрын Сүхбаатар дүүрэг хариуцсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх тасаг 2021 оны 5 дугаар сарын мэдээгээр 104 тэтгэлэг төлөгч, татвар, дампуурсан банк, хадгаламж зээлийн хоршоодод төлбөртэй төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх саналыг Шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлж, саналын дагуу Улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгчээс төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг

түдгэлзүүлэх тогтоолыг Хил хамгаалах ерөнхий газарт хүргүүлж, тус газраас төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн байдаг (Банкны төлбөр барагдуулах газрын Сүхбаатар дүүрэг хариуцсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх тасаг, 2021).

2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрхэнд 133.4.4 дахь хэсэгт "Шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх" гэж 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн өөрчлөлтөөр нэмсэн. 2014 оны 12 дугаар сараас эхлэн төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлж эхэлсэн (Төрийн мэдээлэл эмхэтгэл №8, 2014).

Харин 2017 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн өөрчлөлтөөр гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай 59 дүгээр зүйлийг хуульд тусгайлан зааж, мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт "Тавин сая төгрөгөөс дээш хөрөнгийн шаардлага бүхий гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, эсхүл тэжээн тэтгэх үүргээ 3 сараас дээш хугацаагаар биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг дараах үндэслэлээр түдгэлзүүлж болно" гэж заагаад 3 үндэслэлийг дурдсан. Үүнд:

1. Эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн (Төрийн мэдээлэл эмхэтгэл №24, 2017).
2. Хөрөнгөө нуун дарагдуулсан (Төрийн мэдээлэл эмхэтгэл №24, 2017).
3. Төлбөр төлөхөөс зайлсхийх зорилгоор гадаад улсад оргон зайлж болзошгүй (Төрийн мэдээлэл эмхэтгэл №24, 2017).

Мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсэгт зааснаар шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид, ахлах шийдвэр гүйцэтгэгч үндэслэлтэй гэж үзвэл ажлын 3 өдрийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлж шийдвэрлүүлнэ" гэж, мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дахь хэсэгт "Төлбөр төлөгч албан ажлын, эсхүл эрүүл мэндийн шалтгаанаар түр хугацаагаар гадаадад зорчих зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг баталгаажуулах шаардлагатай арга хэмжээ авсны үндсэн дээр төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түр сэргээнэ" гэж тус тус заасан (Төрийн мэдээлэл эмхэтгэл №24, 2017).

Төлбөрийн үнийн дүн өндөр байх шаардлагыг хуульд тусгайлан зааж өгснөөрөө онцлог боловч 50 саяас доош төлбөртэй төлбөр төлөгч, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчдэд боломж олгосон хуулийн өөрчлөлт болсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага 50 сая төгрөгөөс дээш төлбөртэй бүртгэгдсэн тохиолдолд хилийн хориг тавигдаж, шүүхийн шийдвэрт заасан төлбөр 50 сая төгрөг байсан боловч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж эхлэх үед төлбөр 50 сая төгрөг хүрээгүй тохиолдолд хилийн хориг тавигдахгүй.

Шүүхийн шийдвэрт заасан төлбөр нь 50 сая ба түүнээс дээш боловч төлбөр авагч шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаар хүсэлт гаргаж, зардлын гэрээг байгуулж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх үед төлөгдсөн төлбөрөөс тодорхой хэмжээний төлбөр төлөгдсөн буюу төлбөрийн үлдэгдэл 50 сая төгрөгөөс бага тохиолдолд цахим бүртгэлд бүртгэгдсэн мөнгөн дүнгээс шалтгаалж төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлдэггүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэж заасан байдаг (Төрийн мэдээлэл эмхэтгэл №1, 1992).

Харин шүүхийн шийдвэрт заасан төлбөр нь 50 сая төгрөг ба түүнээс дээш үнийн дүнтэй боловч төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээд тодорхой хэмжээний төлбөр төлж 50 сая төгрөгөөс доош төлбөрийн үлдэгдэлтэй болсон байхад гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн шийдвэрийг цуцалдаггүй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандахаас өмнө шүүхийн шийдвэрт заасан 50 сая ба түүнээс дээш хэмжээний төлбөрөөсөө тодорхой хэмжээний төлбөр төлж, үлдэгдэл мөнгөн дүн нь төлөгдсөн эсэхээс үл хамааран гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлдэг болох шаардлага бий.

Учир нь төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигч нь гадаад улс руу хилээр нэвтрэн гарахад шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зогсох эрсдэл үүсдэг тул хил нээгдэж байгаа өнөө цагт баталгаажуулах арга хэмжээг сайн авч төлбөр төлөгчийг төлбөр төлөхөөс зайлсхийх, оргон зайлах нөхцөлийг бүрдүүлэхгүй байх нь чухал юм.

Хилийн хориг тавих нь шүүхийн шийдвэрт заасан төлбөр төлөгдөх хөшүүрэг учир хуулийг нэг мөр хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага бий. Тавин сая төгрөгөөс дээш хөрөнгийн шаардлага бүхий гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигч тогтоосон хугацаанд биелүүлж, төлбөрийг бүрэн төлсөн тохиолдолд гадаадад зорчих эрхийг сэргээдэг байна.

Харин төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг төлбөр төлөгч албан ажлын, эсхүл эрүүл мэндийн шалтгаанаар түр хугацаагаар гадаадад зорчих зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг баталгаажуулах шаардлагатай арга хэмжээ авсны үндсэн дээр төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түр сэргээхээр хуульд тусгайлан заасан байдаг (Төрийн мэдээлэл эмхэтгэл №24, 2017).

Мөн төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн шүүхийн шийдвэрт заасан төлбөр 50 сая төгрөгөөс доош үнийн дүнтэй болон хэд хэдэн төлбөртэй боловч төлбөрийн нийт дүн 50 сая төгрөг хүрдэггүй цахим бүртгэлд бүртгэгдсэн төлбөр төлөгч, иргэн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигч гадаад улс руу зорчсон, хилээр нэвтэрсэн тохиолдолд Монгол улсын хилээр гарсан гэх үндэслэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27.2.6 дахь хэсэгт зааснаар “төлбөр төлөгч-иргэн, эсхүл төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөгч, тэдгээрийн эд хөрөнгийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл” хугацаанд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлдэг (Төрийн мэдээлэл эмхэтгэл №24, 2017).

Гүйцэтгэх баримт бичгийг түдгэлзүүлсэн хугацаанд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн хугацаанд эд хөрөнгийн лавлагаа авах, арилжааны банк дахь данс битүүмжлэх тогтоол шинээр хүргүүлэх, хилээр нэвтэрсэн эсэх лавлагаа авах зэргээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хийдэг боловч төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигч хэзээ хэрхэн Монгол Улсын хилээр нэвтэрч орж ирэх эсэх нь тодорхойгүй байдаг ба гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх боломжгүй тул төлбөр төлөгч хилээр нэвтрээд дахин гадаадад зорчсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдах боломжгүй нөхцөл байдал үүсэж байгаа юм.

2002 онд батлагдаж 2017 он хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд (Төрийн мэдээлэл эмхэтгэл №8, 2002), 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн нэмэлт орж гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай 133 дугаар зүйлийн 133.4.4 дахь хэсэгт тусгайлан зааж, Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн А/199 дугаар тушаалтаар баталсан “Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх сэргээх, тоо бүртгэл хөтлөх журам”-ын 2.6 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэрт заагдсан мөнгөн төлбөрийн үүрэг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төлбөр, 6 сараас дээш хугацаагаар төлөгдөөгүй хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлнэ” гэж заасан байдаг (Төрийн мэдээлэл эмхэтгэл №8, 2014).

Дээрх заалтын дагуу 2014 оноос 2016 оны 12 дугаар сарыг дуустал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 192,000 төгрөг байсан бөгөөд 40*192,000 төгрөг=7,680,000 төгрөг болно. Шүүхийн шийдвэрт заасан төлбөр нь 7,680,000 төгрөг байвал гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлдэг байсан нь үр дүнтэй байжээ.

2026 оны байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь 792,000 төгрөг байгаа бөгөөд энэ мөнгөн дүнг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн доод хэмжээг сард нэг цагт 4,715 төгрөг буюу сард 792,000 төгрөг байхаар 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 3 дугаар тогтоолын дагуу шинэчлэн тогтоосон байна (Татвар болон хууль эрх зүйн мэдээлэл, 2025).

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх баталгаажуулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнд төлбөртэй төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж байсан бол 40*792,000 төгрөг=31,680,000 төгрөгийн төлбөртэй төлбөр төлөгчид хилийн хориг тавигдахаар харагдаж байна. Түүнээс доош хэмжээний төлбөртэй тохиолдолд гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлдэггүй байсан нь дутагдалтай.

Харин 2017 онд батлагдаж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2020 оны 1 дүгээр сард нэмэлт өөрчлөлт оруулж хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.15, 59 дүгээр зүйлд гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай тусгайлан заасан (Төрийн мэдээлэл эмхэтгэл №24, 2017).

Мөн хэд хэдэн төлбөртэй төлбөрийн үлдэгдэл нь 50 сая төгрөг хүрэхгүй үед зарим төлбөр төлөгч нар гадаад зорчих эрхийг нь түдгэлзүүлээгүй байгааг ашиглан гадаад улс руу хилээр гарч, зугтах тохиолдол байдаг.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд 2021 онд 90 төлбөр төлөгчийн хилийн лавлагааг авахад Монгол улсын хилээр гарч яваад эргэн орж ирээгүй байна (судалгаа, 2021).

Хилийн лавлагааг сар бүр авдаг боловч хилээр нэвтэрч орж ирдэггүй. Монгол Улсын хилээр орж ирээд буцаад гараад явсан ч шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс хориглож хязгаарлаж чадахгүй байгаа нь тулгамдсан асуудал юм.

Оргон зайлах магадлалтай шийдвэр гүйцэтгэгчийн өгсөн шүүхийн шийдвэр биелүүлэх мэдэгдэл, зарлан дуудах мэдэгдэлд заасан хугацаанд төлбөр төлдөггүй, ирж уулздаггүй, мэдэгдэх хуудсаар заасан үүргийг 4 ба түүнээс дээш удаа биелүүлдэггүй төлбөр төлөгч нарт төлбөр төлж барагдуулах хүртэл хугацаанд гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх санал хүргүүлж шийдвэрлэдэг болох шаардлага бий.

Дүгнэлт:

Хил хамгаалах ерөнхий газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хамтын ажиллагааг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд цэрэг, тусгай алба хамтран ажиллах гэдэг утга санаатайгаар тусгасан боловч Хилийн

тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Хил хамгаалах алба болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хамтран ажиллана гэсэн заалт байхгүй байгааг анхааралдаа авах цаг болсон гэж бодож байна. Учир нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг төрөл болсон гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэхэд Хил хамгаалах байгууллага чухал үүрэгтэй.

Төлбөр төлөгч иргэдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх эрх зүйн зохицуулалт нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад маш чухал хэрэгтэй албадлагын арга хэмжээ бөгөөд төлбөр төлөгч нар шүүхийн шийдвэрт заасан төлбөрийг бүрэн төлж барагдуулахад гол хөшүүрэг болж байна. 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2020 онд тусгалаа олсон гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээнд тулгамдсан асуудлуудын нэг шүүхийн шийдвэрт заасан төлбөр нь 50 сая ба түүнээс дээш боловч төлбөрийн үлдэгдэл 50 сая төгрөгөөс бага тохиолдолд цахим бүртгэлд бүртгэгдсэн мөнгөн дүнгээс шалтгаалж төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэхгүй байгаа асуудлыг цэгцэлж, хилийн хоригийг жигд тавих шаардлагатай.

Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөртэй төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлдэг 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн журамд туссан зүйл, заалт нь үр дүнтэй байсан ч түүнээс доош хэмжээний төлбөртэй тохиолдолд хилийн хориг тавигдахгүй байснаараа дутагдалтай байна.

Хэд хэдэн төлбөртэй төлбөр төлөгч, иргэн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийн шүүхийн шийдвэрт заасан төлбөр хэд байхаас үл хамааран мөнгө дүн заахгүйгээр гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шаардлагатай байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн өгсөн шүүхийн шийдвэр биелүүлэх мэдэгдэл, зарлан дуудах мэдэгдэлд заасан хугацаанд төлбөр төлдөггүй, ирж уулздаггүй, мэдэгдэх хуудсаар заасан үүрэг өгөөд заасан хугацаанд төлбөр төлөхгүй, ирж уулзахгүй, өгсөн үүрэг биелүүлэхгүй байгаа төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих эрхийг төлбөр төлж барагдуулах хүртэл хугацаанд түдгэлзүүлэх санал хүргүүлж шийдвэрлүүлдэг болох шаардлага нэгэнт бий болсон гэж үзэж байна.

Санал:

1. Шүүхийн шийдвэрт заасан төлбөр нь 50 сая ба түүнээс дээш боловч төлбөрийн үлдэгдэл 50 сая төгрөгөөс бага хэмжээтэй цахим бүртгэлд бүртгэгдсэн төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх саналыг шийдвэр гүйцэтгэгч нар Шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлж, Улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгчээс төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай тогтоол гарган Хил хамгаалах ерөнхий газарт хүргүүлж шийдвэрлүүлэх,
2. Хэд хэдэн төлбөртэй төлбөр төлөгч, иргэн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийн шүүхийн шийдвэрт заасан төлбөр хэдэн төгрөг байхаас үл хамааран мөнгөн дүн заахгүйгээр гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлдэг байхаар хуульд өөрчлөлт оруулах
3. Шүүхийн шийдвэрт заасан төлбөр 50 сая төгрөгөөс доош мөнгөн дүнтэй гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээд шийдвэр гүйцэтгэгчийн өгсөн шүүхийн шийдвэр биелүүлэх мэдэгдэл, зарлан дуудах мэдэгдэлд заасан хугацаанд төлбөр төлдөггүй, ирж уулздаггүй, мэдэгдэх хуудсаар заасан үүрэг өгөөд

заасан хугацаанд төлбөр төлөхгүй, ирж уулзахгүй, өгсөн үүрэг биелүүлэхгүй байгаа төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх асуудлыг

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1[1] дэх хэсэгт "Хэд хэдэн төлбөртэй болон тавин сая ба түүнээс дээш, эсхүл төлбөрийн шаардлага мөнгөн дүн харгалзахгүйгээр гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй эсхүл тэжээн тэтгэх үүргээ 3 сараас дээш хугацаагаар биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг дараах үндэслэлээр түдгэлзүүлж болно" гэж өөрчлөх санал хүргүүлэх

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт заасан дараах 3 үндэслэлд шинээр 59.1.4 "...Шүүхийн шийдвэрт заасан төлбөр тавин сая төгрөгөөс доош мөнгөн дүнтэй гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээд шийдвэр гүйцэтгэгчийн өгсөн шүүхийн шийдвэр биелүүлэх мэдэгдэл, зарлан дуудах мэдэгдэлд заасан хугацаанд төлбөр төлөөгүй, ирж уулзаагүй мэдэгдэх хуудсаар заасан үүргийг биелүүлээгүй" гэж нэмж тусгах

Эх сурвалж:

1. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24. (2017). *Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/.* Уб.

2. *https://www.pwc.com/*. (2025 оны 2 10). Гаргасан 2025 оны 2 10, pwc: https://www.pwc.com/mn/en/tax_alerts/pdf/tax_alert_mn_01_2025.pdf-aac

3. Банкны төлбөр барагдуулах газрын Сүхбаатар дүүрэг хариуцсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх тасаг. (2021). *Банкны төлбөр барагдуулах газрын Сүхбаатар дүүрэг хариуцсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх тасаг 2021 оны 5-р сарын мэдээ.* Уб.

4. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын судалгаа. (2020). *Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Тоо бүртгэлийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын судалгаа.* Уб.

5. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын судалгаа. (2021). *Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Тоо бүртгэлийн хэлтсийн 2021 оны 5 дугаар сарын судалгаа;.* Уб.

6. Төрийн мэдээлэл эмхэтгэл №1. (1992). *Монгол Улсын Үндсэн хууль.* Уб.

7. Төрийн мэдээлэл эмхэтгэл №3. (2002). *Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль.* Уб.

8. Төрийн мэдээлэл эмхэтгэл №6. (2017). *Монгол Улсын Хилийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/.* Уб.

9. Төрийн мэдээлэл эмхэтгэл №8. (2002). *Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.* Уб.

10. Төрийн мэдээлэл эмхэтгэл №8. (2014). *Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд орсон нэмэлт.* Уб.

ХИЛ ДАМНАСАН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ХЭРЭГЛЭЭ: МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Н. ЖИНЖИЙМАА*

Дотоод хэргийн их сургууль, Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэслэгч

**хариуцлагатай зохиогч: jinjiimaa.n@uia.gov.mn*

Хураангуй: Дижитал технологийн хурдацтай хөгжил нь хил дамнасан гэмт хэргийн бүтэц, үйлдлийн арга барилыг улам нарийссан, технологид суурилсан хэлбэрт шилжүүлж, уламжлалт эрх зүйн зохицуулалтад шинэ сорилт үүсгэж байна. Ийм нөхцөлд хиймэл оюун ухаанд тулгуурласан шийдлүүдийг гэмт хэрэг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, дүн шинжилгээ хийх үйл ажиллагаанд нэвтрүүлэх нь үр нөлөөтэй хандлага болохыг олон улсын туршлага харуулж байна (European Union, 2024; UNODC, 2021). Тухайлбал, их өгөгдөлд суурилсан дүн шинжилгээ, зан төлөвийн загварчлал, автоматжуулсан хяналтын системүүд нь хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чадавхыг нэмэгдүүлж байгааг судалгаанууд баталж байна (Europol, 2023).

Нөгөө талаас, хиймэл оюун ухааны хэрэглээ нь үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүний эрх, ялангуяа хувийн нууц, мэдээллийн хамгаалалт, алгоритмын ил тод байдалтай холбоотой шинэ төрлийн эрсдэлийг дагуулж байна. Иймээс олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд хиймэл оюун ухааны хэрэглээг хүний эрхийн суурь зарчимтай уялдуулах, хууль ёсны, зайлшгүй, пропорциональ байдлыг хангах, мөн хяналт, хариуцлагын тогтолцоог тодорхой болгох шаардлагыг онцолж байна (European Union, 2016; UNESCO, 2021; United Nations, 1966).

Энэхүү судалгааны шинэлэг тал нь хиймэл оюун ухааны хэрэглээ, хилийн хяналтын байгууллагын чиг үүрэг, хүний эрхийн баталгаа болон эрх зүйн зохицуулалтын харилцан уялдааг нэгдмэл хүрээнд авч үзэж, олон улсын чиг хандлагыг Монгол Улсын эрх зүйн орчинтой харьцуулан шинжилсэнд оршино.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол Улсад хиймэл оюун ухааны хэрэглээг шууд зохицуулсан бие даасан хууль эрх зүйн зохицуулалт хараахан бүрдээгүй бөгөөд холбогдох харилцааг салангид хууль тогтоомжийн хүрээнд хэсэгчлэн зохицуулж байна. Үүний улмаас эрх зүйн уялдаа сул, алгоритмд суурилсан шийдвэр гаргалт, автоматжуулсан системийн хяналт, хариуцлагын механизм тодорхойгүй хэвээр байна.

Иймд хиймэл оюун ухаанд суурилсан технологийг хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд болон хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд нэвтрүүлэхдээ эрх зүйн зохицуулалтыг системтэйгээр боловсронгуй болгох, эрсдэлд суурилсан зохицуулалтын хандлагыг төлөвшүүлэх, хүний эрхийн баталгааг институцийн түвшинд хангах шаардлага тулгарч байна. Үүний зэрэгцээ өгөгдөл хамгаалалт, ил тод байдал, хариуцлагын механизмыг тодорхой болгож, олон улсын стандарттай нийцсэн цогц зохицуулалтыг үе шаттайгаар бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Түлхүүр үгс: Хиймэл оюун ухаан; Хил дамнасан гэмт хэрэг; Хилийн хяналтын байгууллага; Эрх зүйн орчин; Өгөгдөл хамгаалалт; Хүний эрх; Эрсдэлд суурилсан зохицуулалт

УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд дижитал технологийн хурдацтай хөгжил нь нийгмийн харилцааны олон салбарт гүнзгий өөрчлөлт авчирч, гэмт хэргийн шинж чанар, үйлдлийн арга хэлбэрийг шинэ түвшинд хүргэж байна. Ялангуяа хил дамнасан гэмт хэрэг нь улам зохион байгуулалттай, технологид суурилсан шинжтэй болж, олон улсын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны чадавхыг шинэ шатанд гаргах шаардлагыг бий болгож байна (United Nations, 2000; Europol, 2023). Үүний зэрэгцээ кибер орчинд үйлдэгдэх гэмт хэрэг, хууль бус санхүүгийн урсгал, хүн худалдаалах зэрэг үзэгдэл илүү нарийссан бүтэцтэй болж, уламжлалт мөрдөн шалгах арга хэрэгслээр бүрэн илрүүлэхэд хүндрэл үүсгэж байна (UNODC, 2021).

Иймн нөхцөлд хиймэл оюун ухаанд суурилсан технологи нь гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд шинэ боломжийг бүрдүүлж байна. Их өгөгдөлд тулгуурласан дүн шинжилгээ, зан төлөвийн загварчлал, эрсдэлийн үнэлгээ, автоматжуулсан хяналтын системүүд нь гэмт хэргийг урьдчилан таамаглах, илрүүлэх, мөрдөн шалгах үйл явцыг илүү оновчтой болгох нөхцөлийг бүрдүүлж байна (European Union, 2024; OECD, 2019). Үүнтэй уялдан хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд “ухаалаг хил” (smart border) үзэл баримтлал нэвтэрч, хил нэвтрэх хөдөлгөөнийг бодит цагийн мэдээлэлд тулгуурлан хянах, эрсдэлтэй болон сэжигтэй үйлдлийг илрүүлэх чадавхыг нэмэгдүүлж байна.

Гэвч хиймэл оюун ухааныг хууль сахиулах болон хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх нь зөвхөн технологийн дэвшлийн асуудлаар хязгаарлагдахгүй бөгөөд хүний эрх, эрх чөлөөтэй салшгүй холбоотой эрх зүйн цогц асуудлыг дагуулж байна. Ялангуяа хувийн мэдээллийн хамгаалалт, тандалтын ил тод байдал, алгоритмын шийдвэр гаргалтын тайлбарлагдах боломж зэрэг асуудал олон улсын түвшинд онцгой анхаарал татаж байна (European Union, 2016; UNESCO, 2021). Иймд хүний эрхийн суурь зарчмуудыг хангах, төрийн хяналт, хариуцлагын механизмыг боловсронгуй болгох шаардлагыг олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд тодорхой тусгасан байдаг (United Nations, 1966; United Nations Human Rights Committee, 2018).

Монгол Улсын хувьд кибер аюулгүй байдал, мэдээллийн хамгаалалтын эрх зүйн суурь зохицуулалт тодорхой хэмжээнд бүрдсэн хэдий ч хиймэл оюун ухааны хэрэглээг шууд зохицуулсан бие даасан эрх зүйн орчин хараахан төлөвшөөгүй байна. Үүний улмаас хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд дэвшилтэт технологи ашиглах явцад эрх зүйн тодорхой бус байдал үүсэх, мөн байгууллага хоорондын уялдаа сулрах эрсдэл ажиглагдаж байна.

Иймд энэхүү судалгааны зорилго нь хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд хиймэл оюун ухааны хэрэглээний онцлог, чиг хандлагыг тодорхойлох, мөн хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан Монгол Улсын эрх зүйн орчныг шинжлэхэд оршино. Судалгаанд харьцуулсан эрх зүйн арга, контент шинжилгээ, баримт бичгийн дүн шинжилгээг ашиглан олон улсын туршлага болон үндэсний зохицуулалтын уялдаа, зөрүүг тодорхойлохыг зорьсон болно.

ОНОЛЫН ҮНДЭС

Хил дамнасан гэмт хэрэг нь нэгээс дээш улсын нутаг дэвсгэрийг хамрах, эсхүл үр дагавар нь олон улсын хэмжээнд илрэх шинжтэй гэмт үйлдлийг илэрхийлдэг бөгөөд олон улсын эрүүгийн эрх зүйн судалгааны чухал чиглэлд хамаардаг (United Nations, 2000). Иймн төрлийн гэмт хэрэгт зохион байгуулалттай бүлэглэлүүд давамгайлж, хууль бус зах зээл, харилцан уялдаатай сүлжээ, орчин үеийн технологийн дэмжлэгт тулгуурлан үйл ажиллагаагаа өргөжүүлэх хандлага ажиглагдаж байна

(Europol, 2023). Криминологийн онолын хүрээнд энэхүү үзэгдлийг тайлбарлахдаа зохион байгуулалттай гэмт хэргийн онол, сүлжээний онол, боломжийн онол зэрэг хандлагыг ашигладаг бөгөөд төвлөрсөн бус, уян хатан бүтэц бүхий сүлжээ нь илрүүлэлт, таслан зогсоох ажиллагааг хүндрүүлдэг болохыг судалгаанууд харуулж байна (UNODC, 2021). Үүнтэй уялдан технологийн хөгжил нь гэмт хэрэг үйлдэх шинэ боломж, орон зайг бий болгож, уламжлалт криминологийн ойлголтыг өргөжүүлэхэд нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд хил дамнасан гэмт хэрэг кибер орчинд эрчимтэй шилжиж, физик хил хязгаараас хамаарах хамаарал буурч, “дижитал хил” хэмээх ойлголт тодорхойлогдох болсон. Энэхүү өөрчлөлт нь гэмт хэрэг үйлдэгдэх орон зайг тэлэхийн зэрэгцээ хяналт, зохицуулалтын арга хэрэгслийг шинэчлэх шаардлагыг бий болгож байна (UNODC, 2021). Ийм нөхцөлд уламжлалт арга барил хангалтгүй болж, өгөгдөлд суурилсан дэвшилтэт шийдлүүдийг хэрэглэх шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Энэ хүрээнд хиймэл оюун ухаан нь өгөгдөлд тулгуурлан суралцах, дүн шинжилгээ хийх, тодорхой нөхцөлд шийдвэр гаргах чадвартай алгоритм, системийн цогц ойлголт байдлаар хөгжиж, орчин үеийн дижитал нийгмийн голлох технологийн нэг болж байна (OECD, 2019). Машин сургалт, гүн сургалт, байгалийн хэл боловсруулалт зэрэг аргачлалууд нь их хэмжээний мэдээллээс хэв маяг илрүүлэх, эрсдэлийг урьдчилан тодорхойлох боломжийг бүрдүүлж, хууль сахиулах болон хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд өргөн хэрэглэгдэх болсон. Тухайлбал, өгөгдөлд суурилсан эрсдэлийн үнэлгээ, сэжигтэй зан төлөв илрүүлэх алгоритм, биометрийн таних систем, автоматжуулсан хяналтын технологи нь гэмт хэрэгтэй тэмцэх үр нөлөөг нэмэгдүүлэх чухал хэрэгсэл болж байна (European Union, 2024).

Хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хиймэл оюун ухааны хэрэглээ нь “ухаалаг хил” (smart border) үзэл баримтлалын дор хөгжиж, мэдээллийн технологид тулгуурласан хяналт, эрсдэлийн удирдлагын шинэ тогтолцоог бүрдүүлж байна. Автоматжуулсан мэдээлэл боловсруулах, зорчигчийн урсгалд дүн шинжилгээ хийх, эрсдэлийн профайл тогтоох зэрэг нь хил нэвтрэх хөдөлгөөнийг илүү үр ашигтай зохицуулах боломжийг бий болгож байна (European Commission, 2021). Гэвч ийм төрлийн системийг ашиглах нь хүний эрхийн тодорхой сорилтыг дагуулж, ялангуяа өргөн хүрээний тандалт, өгөгдлийн төвлөрөл, алгоритмын ялгаварлан гадуурхалтын эрсдэлийг нэмэгдүүлэх магадлалтайг олон улсын байгууллагууд анхааруулж байна (UNESCO, 2021). Иймд хиймэл оюун ухааны хэрэглээг эрсдэлийн түвшинд ангилан зохицуулах, хүний оролцоотой хяналтыг хадгалах, ил тод байдлыг хангах шаардлагыг олон улсын түвшинд онцлон дэвшүүлж байна (European Union, 2024).

Иймээс хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд хиймэл оюун ухааныг ашиглах асуудал нь зөвхөн технологийн боломжид тулгуурлах бус, харин эрх зүй, ёс зүй, хүний эрхийн олон талт уялдаа холбоог харгалзан үзэх шаардлагатай, цогц шинжтэй судалгааны чиглэл болох нь тодорхой байна.

СУДАЛГААНЫ ШИНЭЛЭГ ТАЛ БА АРГА ЗҮЙ

Энэхүү судалгаа нь хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд хиймэл оюун ухааны хэрэглээг Монгол Улсын эрх зүйн орчны хүрээнд шинжилснээрээ онцлог бөгөөд судалгааны шинэлэг байдлыг илэрхийлж байна. Өмнөх судалгаанууд ихэвчлэн хиймэл оюун ухааны технологийн хөгжил, эсхүл кибер аюулгүй байдлын ерөнхий асуудалд төвлөрч байсан бол энэхүү судалгаа нь хиймэл оюун ухааны хэрэглээ, хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаа, хүний эрхийн баталгаа болон эрх зүйн зохицуулалтын харилцан уялдааг нэгдмэл хүрээнд авч үзсэнээрээ ялгарч байна.

Түүнчлэн олон улсын зохицуулалтын чиг хандлага, ялангуяа эрсдэлд суурилсан хандлагыг Монгол Улсын эрх зүйн орчинтой харьцуулан үнэлж, үндэсний зохицуулалтын хийдэл болон хэрэгжилтийн хүндрэлүүдийг тодорхойлсон нь судалгааны шинэлэг үр дүн болно (European Union, 2024; OECD, 2019).

Судалгааны арга зүйн хувьд чанарын судалгааны хандлагыг баримталж, харьцуулсан эрх зүйн арга, контент шинжилгээ, баримт бичгийн дүн шинжилгээний аргуудыг хослуулан ашиглав. Харьцуулсан эрх зүйн аргаар хиймэл оюун ухааны зохицуулалтын олон улсын чиг хандлага, хүний эрхийн стандарт, өгөгдөл хамгаалалтын зарчмуудыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжтой харьцуулан үнэлж, зохицуулалтын ялгаа, хийдлийг тодорхойлсон (European Union, 2024; United Nations, 1966). Контент шинжилгээний хүрээнд олон улсын байгууллагуудын тайлан, бодлогын баримт бичиг, судалгааны эх сурвалжийг системтэйгээр задлан шинжилж, хиймэл оюун ухааны хэрэглээний чиг хандлага, нөлөөллийг тодорхойлсон (UNODC, 2021; Europol, 2023). Мөн баримт бичгийн дүн шинжилгээний аргаар Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийг судалж, эрх зүйн орчны бүтэц, зохицуулалтын онцлогийг үнэлэв.

Эдгээр арга зүйн уялдаа нь хиймэл оюун ухааны хэрэглээтэй холбоотой эрх зүйн асуудлыг олон талт өнцгөөс авч үзэх, олон улсын туршлага болон үндэсний зохицуулалтын хоорондын уялдаа, зөрүүг тодорхойлох боломжийг бүрдүүлсэн. Иймд уг судалгаа нь онолын хүрээнд хязгаарлагдахгүй, бодлогын түвшинд хэрэгжих боломжтой санал, зөвлөмж боловсруулахад чиглэсэн цогц шинжилгээний ач холбогдолтой гэж үзэж байна.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд хиймэл оюун ухааныг ашиглах боломж өргөжиж байгаа хэдий ч Монгол Улсад уг технологийн хэрэглээтэй холбоотой эрх зүй, институц, хүний нөөцийн түвшинд шийдвэрлэх шаардлагатай суурь асуудлууд оршсоор байна. Юуны өмнө, хиймэл оюун ухааны хэрэглээг цогцоор нь зохицуулсан бие даасан эрх зүйн орчин бүрдээгүй байгаа нь практикт тодорхой бус байдал үүсгэж байна. Одоогийн зохицуулалт нь кибер аюулгүй байдал, мэдээллийн хамгаалалтын хүрээнд төвлөрсөн бөгөөд алгоритмд суурилсан шийдвэр гаргалт, автоматжуулсан хяналтын систем, хариуцлагын механизмыг нарийвчлан тусгаагүй хэвээр байна (Монгол Улс, 2021a; Монгол Улс, 2021b). Үүний улмаас шинэ технологийг хууль сахиулах болон хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд эрх зүйн суурь тодорхой бус, хэрэгжилтийн уялдаа сул байх нөхцөл бүрдэж байна.

Үүнтэй зэрэгцэн байгууллага хоорондын уялдаа, мэдээллийн интеграцчилал хангалтгүй байгаа нь хиймэл оюун ухаанд суурилсан шийдлүүдийг бодит үр ашигтай хэрэглэхэд саад болж байна. Хилийн хяналтын байгууллага, хууль сахиулах болон кибер аюулгүй байдлын чиг үүрэг бүхий байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, нэгдсэн өгөгдлийн сан ашиглах, хамтарсан дүн шинжилгээ хийх тогтолцоо сул байгаа нь технологийн боломжийг бүрэн ашиглахад хүндрэл учруулж байна. Судалгаанаас үзэхэд ийм төрлийн системийн үр нөлөө нь өгөгдлийн чанар, хүртээмж, байгууллага хоорондын уялдаанаас шууд хамаардаг (Europol, 2023).

Мөн хиймэл оюун ухааны хэрэглээ нь хүний эрхийн баталгаатай холбоотой шинэ төрлийн сорилтуудыг бий болгож байна. Ялангуяа өгөгдөл боловсруулах үйл явцын ил тод байдал, автоматжуулсан шийдвэр гаргалтад хяналт тавих боломж, иргэний эрхийг хамгаалах механизм тодорхой бус байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна. Хүний эрхийн олон улсын стандартын дагуу төрөөс иргэний

эрх, эрх чөлөөнд хөндлөнгөөс нөлөөлөх аливаа арга хэмжээ нь хууль ёсны, зайлшгүй, пропорциональ байх шаардлагатай бөгөөд уг зарчмыг хиймэл оюун ухааны хэрэглээнд бодитоор хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна (United Nations, 1966; United Nations Human Rights Committee, 2018).

Түүнчлэн хүний нөөц, техникийн чадавхын хязгаарлалт нь бодит хэрэглээнд шууд нөлөөлөх хүчин зүйл болж байна. Хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлэх, ашиглах, хянах чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин, шаардлагатай дэд бүтэц хангалтгүй байгаа нь технологийн үр ашигтай хэрэглээг хязгаарлаж байна. Энэ нь зөвхөн техникийн асуудлаар хязгаарлагдахгүй бөгөөд бодлого боловсруулагчид болон хууль сахиулах байгууллагууд технологийн онцлог, нөлөөллийг гүнзгий ойлгож, зохистой ашиглах институцийн чадавхыг бэхжүүлэх шаардлагатайг илтгэж байна (OECD, 2019).

Эцэст нь, хил дамнасан гэмт хэргийн олон улсын шинж чанар нь мэдээлэл солилцоо, хамтарсан ажиллагааг зайлшгүй шаарддаг боловч энэ чиглэлд эрх зүйн болон техникийн тодорхой саад бэрхшээлүүд оршсоор байна. Мэдээлэл солилцооны шуурхай, найдвартай байдал нь гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнд шууд нөлөөлдөг тул олон улсын хамтын ажиллагааны механизмыг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна (UNODC, 2021).

Иймээс дээр дурдсан асуудлууд нь хиймэл оюун ухаанд суурилсан технологийг хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд болон хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд үр ашигтай нэвтрүүлэхэд саад болж буй суурь хүчин зүйлс юм. Эдгээрийг шийдвэрлэхийн тулд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг цогц, системтэй хандлага шаардлагатай байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсад хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт нь эрүүгийн эрх зүй, кибер аюулгүй байдал, мэдээлэл хамгаалалтын салбар хуулиудад тулгуурлан бүрдэж, олон улсын гэрээ, конвенцод нэгдсэнээр тодорхой хэмжээнд хөгжсөн байна. Гэсэн хэдий ч дижитал технологид суурилсан гэмт хэргийн хэлбэрүүд эрчимтэй хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд хиймэл оюун ухааны хэрэглээг шууд, цогцоор зохицуулсан эрх зүйн тогтолцоо бүрэн төлөвшөөгүй хэвээр байна. Үүний улмаас шинэ технологийг хууль сахиулах болон хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд ашиглах явцад эрх зүйн тодорхой бус байдал үүсэх, хэрэгжилтийн уялдаа сулрах хандлага ажиглагдаж байна.

Одоогийн эрх зүйн орчин нь мэдээллийн аюулгүй байдал, хувийн мэдээллийн хамгаалалтад төвлөрсөн зохицуулалтаар хязгаарлагдаж байгаа бөгөөд алгоритмд суурилсан шийдвэр гаргалт, автоматжуулсан хяналтын системийн хяналт, хариуцлагын механизм зэрэг асуудлыг нарийвчлан тусгаагүй байна (Монгол Улс, 2021a; Монгол Улс, 2021b). Энэ нь хиймэл оюун ухаанд суурилсан технологийг бодит хэрэглээнд нэвтрүүлэхэд эрх зүйн үндэслэл дутмаг, зохицуулалтын хийдэл үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Нөгөө талаас, хүний эрхийн баталгааг хангахтай холбоотой зохицуулалт зарчмын түвшинд тусгагдсан боловч хиймэл оюун ухааны хэрэглээний онцлогт нийцсэн нарийвчилсан механизм хангалтгүй байна. Ялангуяа өгөгдөл боловсруулах үйл явцын ил тод байдал, автоматжуулсан шийдвэр гаргалтад хяналт тавих боломж, иргэний эрхийг хамгаалах институцийн хяналтын тогтолцоо тодорхой бус байгаа нь технологийн хэрэглээ өргөжихийн хэрээр эрсдэл үүсгэх нөхцөлийг бий болгож

болзошгүй. Энэ нь хүний эрхийг хязгаарлах аливаа арга хэмжээ хууль ёсны, зайлшгүй, пропорциональ байх ёстой гэсэн олон улсын суурь зарчмыг бодитоор хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах эрсдэлийг нэмэгдүүлж байна (United Nations, 1966; United Nations Human Rights Committee, 2018).

Түүнчлэн хиймэл оюун ухааны хэрэглээ нь зөвхөн эрх зүйн зохицуулалтаар хязгаарлагдахгүй бөгөөд байгууллагуудын уялдаа холбоо, хэрэгжилтийн чадавхтай шууд хамааралтай. Гэвч холбогдох байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, нэгдсэн өгөгдлийн сан ашиглах, хамтарсан дүн шинжилгээ хийх тогтолцоо хангалттай хөгжөөгүй байгаа нь зохицуулалтын бодит үр нөлөөг бууруулах хүчин зүйл болж байна.

Иймм нөхцөлд эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал нь зөвхөн хууль тогтоомжийн шинэчлэлээр хязгаарлагдахгүй, харин зохицуулалт, хэрэгжилт, хяналтын уялдаа холбоог цогцоор нь бэхжүүлэх шаардлагатай байна. Иймд Монгол Улсад хиймэл оюун ухаанд суурилсан технологийг хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд, түүнчлэн хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд ашиглах эрх зүйн орчныг боловсронгуй болгохдоо зохицуулалтын хийдлийг арилгах, алгоритмын шийдвэр гаргалтын ил тод байдал, хариуцлагын механизмыг тодорхой болгох, хүний эрхийн баталгааг бодитой хангах чиглэлд цогц шинэчлэл хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ нь дижитал орчинд үүсэж буй шинэ төрлийн эрсдэлийг бууруулахын зэрэгцээ эрх зүйн тогтолцооны тогтвортой, үр ашигтай үйл ажиллагааг хангах суурь нөхцөл болох юм.

ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА

Сүүлийн жилүүдэд хөгжингүй улс орнууд хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд хиймэл оюун ухаанд суурилсан технологийг идэвхтэй нэвтрүүлж, хууль сахиулах болон хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг өгөгдөлд тулгуурласан, урьдчилан сэргийлэх чиглэлд шилжүүлэх хандлага ажиглагдаж байна. Энэ хүрээнд хиймэл оюун ухааныг зөвхөн техникийн шийдэл гэж үзэхээс илүүтэй эрх зүй, бодлогын зохицуулалттай уялдуулан хөгжүүлэх чиглэл давамгайлж байна.

Европын Холбооны туршлага нь хиймэл оюун ухааныг эрсдэлийн түвшинд ангилан зохицуулах загварыг төлөвшүүлж буйгаараа онцлогтой. Ялангуяа хууль сахиулах болон хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах өндөр эрсдэлтэй системүүдэд хүний хяналтыг заавал хадгалах, алгоритмын шийдвэр гаргалтын ил тод байдлыг хангах шаардлагыг эрх зүйн түвшинд тодорхой тусгасан байна (European Union, 2024). Үүний зэрэгцээ мэдээлэл хамгаалалтын зохицуулалт нь хиймэл оюун ухаанд суурилсан системээр боловсруулагдах өгөгдлийн хууль ёсны хэрэглээ, аюулгүй байдлыг баталгаажуулахад чухал үүрэг гүйцэтгэж байна (European Union, 2016). Иймм зохицуулалт нь технологийн хэрэглээг хязгаарлах бус, харин хяналттай, хариуцлагатай байдлаар хөгжүүлэхэд чиглэж буйгаараа онцлог юм.

АНУ-д хиймэл оюун ухааныг хууль сахиулах үйл ажиллагаанд өргөн ашиглаж, их өгөгдөлд суурилсан дүн шинжилгээ, зан төлөвийн таамаглал, эрсдэлийн үнэлгээний системийг хөгжүүлж байна. Энэ нь гэмт хэрэгтэй тэмцэх үр ашгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ урьдчилан сэргийлэх бодлогыг бэхжүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байгаа боловч алгоритмын ялгаварлан гадуурхалт, хэт тандалтын эрсдэлтэй холбоотойгоор эрх зүйн болон ёс зүйн маргаан дагуулж байна. Иймээс хиймэл оюун ухааны хэрэглээг ил тод, хариуцлагатай болгох, иргэний эрхийг хамгаалах чиглэлээр бодлогын зохицуулалтыг үе шаттайгаар боловсронгуй болгох шаардлага тавигдаж байна (OECD, 2019).

БНХАУ-ын туршлага нь хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын системийг өргөн хүрээнд нэвтрүүлсэн практик жишээг харуулдаг. Нүүр царай таних технологи, биометрийн өгөгдөл, бодит цагийн тандалтын системийг хил, боомтын хяналтад ашигласнаар зорчигч болон ачаа тээврийн урсгалыг хянах, сэжигтэй этгээдийг илрүүлэх чадавхыг нэмэгдүүлсэн байна. Гэвч ийм төрлийн өргөн хүрээний тандалт нь хувийн нууц, мэдээллийн хамгаалалтын асуудлыг хөндөж, олон улсын түвшинд шүүмжлэл дагуулж байгааг тэмдэглэх нь зүйтэй (UNESCO, 2021).

Олон улсын байгууллагуудын судалгаагаар хиймэл оюун ухаанд суурилсан технологи нь хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд мэдээллийн урсгалыг илүү үр ашигтай боловсруулах, эрсдэлийг урьдчилан тодорхойлох, байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах боломжийг бүрдүүлж байгааг онцолж байна (UNODC, 2021; Europol, 2023). Гэвч ийм технологийг зохистой зохицуулалтгүйгээр ашиглах нь хүний эрхийн зөрчил, хяналтын механизм сулрах эрсдэлийг дагуулж болзошгүй тул ил тод байдал, хариуцлага, хүний оролцоог баталгаажуулах зарчим бодлогын түвшинд чухалчлагдаж байна.

Иймээс гадаад орны туршлагаас харахад хиймэл оюун ухааныг хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд болон гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд ашиглахдаа технологийн үр ашиг, хүний эрхийн хамгаалалт, эрх зүйн зохицуулалтын тэнцвэрийг хангах нь бодлогын түвшинд шийдвэрлэх шаардлагатай үндсэн асуудал болох нь тодорхой байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад хиймэл оюун ухаанд суурилсан технологи нь хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд бодит ахиц дэвшил авчрах боломжтой хэдий ч зохих эрх зүйн хүрээнд оновчтой зохицуулахгүй тохиолдолд шинэ төрлийн эрсдэлийг дагуулах магадлал өндөр байна. Ялангуяа өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргалт, автоматжуулсан хяналтын системүүд нь гэмт хэрэг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүний эрхийн баталгаанд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй хоёрдмол шинжийг агуулж байгааг судалгааны дүн харуулж байна (UNODC, 2021; UNESCO, 2021). Иймээс технологийн үр ашиг болон хүний эрхийн хамгаалалтын хоорондын зохистой тэнцвэрийг хангах асуудал энэхүү судалгааны төв асуудал болж байна.

Олон улсын туршлагаас үзэхэд хиймэл оюун ухааны хэрэглээг дан ганц технологийн дэвшил бус, харин эрсдэлийн удирдлагын хүрээнд авч үзэх хандлага давамгайлж байна. Эрсдэлийн түвшинд суурилсан ангилал, хүний оролцоог зайлшгүй хадгалах шаардлага, алгоритмын шийдвэр гаргалтын тайлбарлагдах боломжийг хангах зэрэг зарчмууд бодлогын түвшинд нийтлэг болж, технологийн хэрэглээг хязгаарлах бус хяналттай, хариуцлагатай байдлаар хөгжүүлэхэд чиглэж байна (European Union, 2024; OECD, 2019). Энэ нь хиймэл оюун ухааныг зохицуулахад хориглох бус, удирдан чиглүүлэх бодлогын хандлага давамгайлж байгааг илэрхийлж байна.

Монгол Улсын нөхцөлд хиймэл оюун ухааны хэрэглээтэй холбоотой эрх зүйн орчин бүрэлдэх шатандаа байгаа бөгөөд одоогийн зохицуулалт нь салангид шинжтэй, технологийн хөгжлийн хурдтай харьцуулахад тодорхой хэмжээгээр хоцорч байна. Мэдээллийн аюулгүй байдал, өгөгдөл хамгаалалтын суурь зохицуулалт бүрдсэн хэдий ч алгоритмд суурилсан шийдвэр гаргалт, автоматжуулсан системийн хяналт, хариуцлагын механизм тодорхой бус хэвээр байгаа нь практикт тодорхойгүй байдал үүсгэж, хэрэгжилтийн үр нөлөөг бууруулах эрсдэлийг бий болгож байна. Иймээс

нөхцөлд эрх зүйн зохицуулалт технологийн хөгжлийг даган шинэчлэгдэхгүй бол зохицуулалтын хийдэл (regulatory gap) улам гүнзгийрэх хандлагатай байна.

Нөгөө талаас, хил дамнасан гэмт хэргийн олон улсын шинж чанар нь хиймэл оюун ухааны хэрэглээг зөвхөн үндэсний хүрээнд хязгаарлах боломжгүйг харуулж байна. Мэдээлэл солилцоо, хамтарсан ажиллагаа, эрх зүйн уялдаа нь гэмт хэрэгтэй тэмцэх үр нөлөөг тодорхойлох чухал хүчин зүйл хэвээр байгаа бөгөөд энэ нь үндэсний зохицуулалтыг олон улсын стандарттай нийцүүлэх бодит шаардлагыг бий болгож байна (Europol, 2023). Иймээс хиймэл оюун ухааныг ашиглах эрх зүйн орчныг дотоод бодлогын хүрээнээс давуулан, олон улсын хамтын ажиллагааны уялдаанд авч үзэх шаардлагатай байна.

Үүнээс гадна хиймэл оюун ухаанд суурилсан шийдвэр гаргалт нь хүний эрхийн уламжлалт ойлголтыг шинэ нөхцөлд дахин авч үзэх шаардлагыг бий болгож байна. Хүний эрхийг хязгаарлах аливаа арга хэмжээ нь хууль ёсны, зайлшгүй, пропорциональ байх ёстой гэсэн суурь зарчим алгоритмын оролцоотой шийдвэр гаргалтад мөн адил үйлчлэх ёстой боловч практикт уг шаардлагыг хангахад алгоритмын ил тод бус байдал, өгөгдлийн чанар, хүний хяналтын түвшин зэрэг хүчин зүйлс саад болж байгааг анхаарах нь зүйтэй (United Nations, 1966; United Nations Human Rights Committee, 2018). Иймээс эрх зүйн зохицуулалтад эдгээр онцлогийг нарийвчлан тусгах шаардлага үүсэж байна.

Иймд хиймэл оюун ухааныг хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх болон хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд ашиглах асуудлыг зөвхөн технологийн шийдэл гэж үзэх боломжгүй бөгөөд эрх зүй, институцийн тогтолцоо, ёс зүйн зарчмын олон талт уялдааг шаардсан цогц бодлогын асуудал гэж үзэх нь зүйтэй. Энэ хүрээнд Монгол Улсад эрх зүйн орчныг боловсронгуй болгохдоо олон улсын чиг хандлагыг шууд хуулбарлах бус, харин үндэсний онцлог, байгууллагын чадавхтай уялдуулан нутагшуулах нь бодит үр дүнд хүрэх үндсэн нөхцөл болох юм.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгааны үр дүнгээс үзэхэд хил дамнасан гэмт хэрэг нь дижитал технологийн хөгжил, даяаршлын нөлөөгөөр улам нарийн бүтэц, зохион байгуулалттай болж, уламжлалт илрүүлэлт, урьдчилан сэргийлэх арга хэрэгслийн үр нөлөө харьцангуй буурах хандлагатай байна. Ийм нөхцөлд хиймэл оюун ухаанд суурилсан технологи нь өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжих, эрсдэлийг урьдчилан тодорхойлох, нөөцийн ашиглалтыг оновчтой болгох замаар гэмт хэрэгтэй тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх боломжтойг олон улсын туршлага харуулж байна (European Union, 2024; UNODC, 2021). Гэвч энэхүү технологийн хэрэглээ нь хүний эрх, ялангуяа хувийн мэдээллийн хамгаалалт, алгоритмын ил тод байдал, хяналтын механизмтай холбоотой шинэ төрлийн эрсдэлийг дагуулж байгааг мөн тодорхой харуулж байна (UNESCO, 2021).

Монгол Улсад хиймэл оюун ухааны хэрэглээг шууд зохицуулсан бие даасан эрх зүйн орчин хараахан бүрдээгүй бөгөөд холбогдох харилцааг салангид хууль тогтоомжийн хүрээнд хэсэгчлэн зохицуулж байгаа нь эрх зүйн уялдаа сул, хэрэгжилтийн тодорхой бус байдлыг бий болгож байна. Ялангуяа алгоритмд суурилсан шийдвэр гаргалт, автоматжуулсан системийн хариуцлага, хүний хяналтын түвшин зэрэг асуудал тодорхой зохицуулагдаагүй байгаа нь зохицуулалтын хийдэл (regulatory gap)-ийг цаашид гүнзгийрүүлэх эрсдэлийг дагуулж байна.

Иймээс судалгааны үр дүнд тулгуурлан дараах бодлогын чиглэлийн санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Нэгдүгээрт, хиймэл оюун ухааны хэрэглээг зохицуулах эрх зүйн орчныг цогцоор нь бүрдүүлэх шаардлагатай бөгөөд бие даасан хууль батлах

эсхүл хүчин төгөлдөр хууль тогтоомжид системтэй нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зохицуулалтын уялдааг хангах нь зүйтэй. Хоёрдугаарт, хиймэл оюун ухааны хэрэглээг эрсдэлийн түвшинд ангилан зохицуулах, ялангуяа хууль сахиулах болон хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах системүүдэд хүний оролцоог зайлшгүй нөхцөл болгон тусгах шаардлагатай (European Union, 2024).

Гуравдугаарт, хувь хүний мэдээлэл хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, өгөгдөл боловсруулах үйл явцын ил тод байдал, алгоритмын тайлбарлагдах боломж, иргэний хяналтын механизмыг тодорхой болгох нь хүний эрхийн баталгааг хангах суурь нөхцөл болно (European Union, 2016). Дөрөвдүгээрт, хиймэл оюун ухааны хэрэглээтэй холбоотой байгууллагын чадавхыг бэхжүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, байгууллага хоорондын мэдээлэл солилцоо, уялдаа холбоог сайжруулах нь технологийн бодит үр нөлөөг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Түүнчлэн хил дамнасан гэмт хэргийн олон улсын шинж чанарыг харгалзан мэдээлэл солилцоо, хамтарсан ажиллагааг дэмжих, олон улсын хамтын ажиллагааны механизмыг өргөжүүлэх шаардлагатай байна (Europol, 2023). Энэ нь үндэсний эрх зүйн зохицуулалтыг олон улсын стандарттай уялдуулах, практик хэрэгжилтийг сайжруулах үндэс болно.

Эцэст нь, хиймэл оюун ухааныг хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх болон хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд ашиглах асуудлыг зөвхөн технологийн дэвшлийн хүрээнд авч үзэх бус, харин хүний эрхийн баталгаа, эрх зүйн зохицуулалт, институцийн чадавх, ёс зүйн шаардлагыг хамарсан цогц бодлогын асуудал хэмээн авч үзэх нь зүйтэй. Ийм хандлага нь Монгол Улсад технологийн боломжийг үр ашигтай ашиглахын зэрэгцээ хүний эрхийг дээдэлсэн, тогтвортой эрх зүйн орчныг бүрдүүлэх суурь нөхцөл болох юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Үндэсний эрх зүйн эх сурвалж

- Монгол Улс. (1992). Монгол Улсын Үндсэн хууль.
- Монгол Улс. (2015). Эрүүгийн хууль.
- Монгол Улс. (2017). Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.
- Монгол Улс. (2021). Кибер аюулгүй байдлын тухай хууль.
- Монгол Улс. (2021). Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль.
- Монгол Улс. (2021). Цахим гарын үсгийн тухай хууль.
- Монгол Улс. (2001). Харилцаа холбооны тухай хууль.
- Монгол Улс. (2016). Төрийн болон албаны нууцын тухай хууль.
- Монгол Улс. (2016). Монгол Улсын хилийн тухай хууль.
- Монгол Улс. (2021). Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль.
- Монгол Улсын Засгийн газар. (2022). Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги.

2. Олон улсын эрх зүйн эх сурвалж

- United Nations. (1966). *International Covenant on Civil and Political Rights*.
- United Nations. (2000). *United Nations Convention against Transnational Organized Crime*.
- United Nations. (2003). *United Nations Convention against Corruption*.
- United Nations Human Rights Committee. (2018). *General Comment No. 36 on the right to life*.

- Council of Europe. (2001). *Convention on Cybercrime (Budapest Convention)*.
- Council of Europe. (2022). *Second Additional Protocol to the Convention on Cybercrime on enhanced co-operation and disclosure of electronic evidence*.
- European Union. (2016). *General Data Protection Regulation (GDPR)*.
- European Commission. (2021). *Proposal for a regulation laying down harmonised rules on artificial intelligence*.
- European Union. (2024). *Artificial Intelligence Act*.
- European Union Agency for Law Enforcement Cooperation (Europol). (2023). *Serious and Organised Crime Threat Assessment (SOCTA)*.
- Organisation for Economic Co-operation and Development (OECD). (2019). *OECD Principles on Artificial Intelligence*.
- United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO). (2021). *Recommendation on the Ethics of Artificial Intelligence*.
- United Nations Office on Drugs and Crime (UNODC). (2020). *Global report on trafficking in persons*.
- United Nations Office on Drugs and Crime (UNODC). (2021). *Comprehensive study on cybercrime*.
- INTERPOL. (2023). *Global crime trend summary report*.
- World Bank. (2021). *World Development Report 2021: Data for Better Lives*.
- NATO Cooperative Cyber Defence Centre of Excellence. (2013). *Tallinn Manual on the International Law Applicable to Cyber Warfare*.
- NATO Cooperative Cyber Defence Centre of Excellence. (2017). *Tallinn Manual 2.0 on the International Law Applicable to Cyber Operations*.

ОРОН СУУЦНЫ ЗАХИАЛГА АВЧ БУСДЫГ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АРГА ЗҮЙН ОНЦЛОГ

П.ЭРДЭНЭБААТАР*
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор,цагдаагийн хурандаа

**хариуцлагатай зохиогч: purewerka5@gmail.com*

Хураангуй: Монгол Улсад 2019–2025 онд бүртгэгдэж, мөрдөн шалгагдсан орон сууцны захиалга авах замаар бусдыг залилах гэмт хэргийн өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт, криминалистик шинж, түүнчлэн мөрдөн шалгах ажиллагаанд тулгарч буй асуудлыг судалгааны зорилго болсон.

Судалгааны үр дүнгээс үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг нь иргэний эрх зүйн хэлцэл, улсын бүртгэл, барилгын зөвшөөрөл, санхүүгийн урсгал зэрэг хууль ёсны мэт харагдах механизмд тулгуурлан үйлдэгддэг, баримт бичиг давамгайлсан, олон үе шаттай, удаан хугацаанд үргэлжлэх онцлогтой байна. Монгол Улсад 2019–2025 онд нийт 2,365 хэрэг бүртгэгдэж, 4,129 иргэнд 216.1 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь уг гэмт хэргийн нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг илтгэнэ. Иймд орон сууцны захиалгатай холбоотой гэрээ, ирээдүйд өмчлөх эрх үүсэх хэлцлийн бүртгэлийг боловсронгуй болгох, төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулах, гэмт хэргийг шалгах арга зүйг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзлээ. Түүнчлэн хохирогчийг төөрөгдүүлсэн нөхцөл байдал, баримт бичгийн үнэн зөв байдал, санхүүгийн урсгалыг иж бүрэн тогтоох нь нотлох баримтыг бүрдүүлэхэд онцгой ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: орон сууцны захиалга, залилах гэмт хэрэг, мөрдөн шалгах арга зүй, үл хөдлөх эд хөрөнгийн эрх, улсын бүртгэл, санхүүгийн мөрдөлт.

Удиртгал

Орон сууц нь иргэдийн амьдралын чанар, гэр бүлийн тогтвортой байдал, өмчийн баталгаа, нийгмийн аюулгүй байдалтай шууд холбогддог стратегийн ач холбогдол бүхий үл хөдлөх хөрөнгө юм. Иймээс орон сууцтай холбоотой эрх зүйн харилцаа нь зөвхөн иргэний эрх зүйн хүрээнд хязгаарлагдахгүй, захиргааны болон эрүүгийн эрх зүйн зохицуулалттай нягт огтлолцдог нийлмэл шинжтэй байдаг.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд хотжилт эрчимжиж, үл хөдлөх хөрөнгийн зах зээл өргөжин тэлж, орон сууцыг урьдчилан захиалах, хөрөнгө оруулалтын шинжтэйгээр худалдан авах хэлбэр түгээмэл болсон нь иргэдийн орон байртай болох боломжийг нэмэгдүүлсэн. Гэвч нөгөө талаас энэ байдал нь барилгын салбарын хяналтын сул орон зай, иргэдийн эрх зүйн мэдлэгийн дутмаг байдал, гэрээний эрсдэлийг бүрэн үнэлээгүй шийдвэр гаргалт зэрэг хүчин зүйлтэй нэгдэн залилах гэмт хэрэг үйлдэх шинэ нөхцөлийг бий болгодог.

Ялангуяа орон сууцны захиалгын гэрээг ашиглан нэг объектыг олон этгээдэд давхар амлах, барилгын зөвшөөрөлгүйгээр мөнгө татан төвлөрүүлэх, баригдаагүй орон сууцыг бэлэн объект мэтээр сурталчлах, төслийн нэг санхүүжилтийг өөр төсөл рүү шилжүүлэх, барьцаалсан хөрөнгийг дахин борлуулах, гэрээний нөхцөлийг нэг талын ашигт өөрчлөх зэрэг үйлдэл практикт түгээмэл ажиглагдаж байна (Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөх албан тайлан. Уб., 2025).

Энэ төрлийн залилах гэмт хэргийн үйлдэл нь гадна хэлбэрийн хувьд иргэний эрх зүйн хэлцэл мэт харагддаг боловч мөн чанартаа бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг хууль бусаар завших зорилготой, нийгмийн хор аюул өндөртэй эрүүгийн шинжтэй үйлдэл байдаг. Иймээс уг төрлийн хэргийг иргэний маргаанаас ялган зөв ангилах, гэмт санаанаы үүсэл, хэрэгжилтийн механизмыг тогтоох, нотлох баримтыг цаг алдалгүй бэхжүүлэх асуудал онцгой ач холбогдолтой юм.

Энэ өгүүллийн зорилго нь орон сууцны захиалга авч бусдыг залилах гэмт хэргийн өнөөгийн төлөв байдал, эрх зүйн зохицуулалт, криминалистик шинж, мөрдөн шалгах ажиллагаанд тулгамдаж буй хүндрэл болон түүнийг шийдвэрлэх арга зүйн үндсэн чиглэлийг судлан шинжилж, практикт хэрэгжүүлэх боломжтой дүгнэлт, санал дэвшүүлэхэд оршино.

Үндсэн хэсэг

Орон сууцны захиалгатай холбоотой эрх зүйн харилцаа нь Иргэний хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Барилгын тухай хууль, барилгын салбарын холбогдох тусгай зохицуулалтын огтлолцолд хэрэгждэг. Нэг талаас иргэн орон сууц худалдан авах, захиалах, өмчлөх, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй; нөгөө талаас барилгын төсөл хэрэгжүүлэх, газар ашиглах, архитектур төлөвлөлт, барилгын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах зэрэг ажиллагаа нь тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөл, хяналт, бүртгэл шаарддаг.

Орон сууцтай холбоотой хэлцэл нь ихэвчлэн бичгийн хэлбэртэй, объектын байршил, талбай, үнэ, төлбөрийн хуваарь, ашиглалтад орох хугацаа, талуудын эрх, үүргийг тодорхой тусгасан байдаг. Гэсэн хэдий ч гэрээний хэлбэр хууль ёсны байх нь агуулга нь бодитой, шударга, хэрэгжих боломжтой гэсэн баталгаа болдоггүй.

Практикт барилгын зөвшөөрлийн багц бүрдээгүй, газрын эрхийн байдал тодорхойгүй, санхүүгийн чадамж хангалтгүй, нэг объект дээр хэд хэдэн гэрээ байгуулагдсан нөхцөлд ч хэлцэл гаднаасаа хүчин төгөлдөр мэт харагдаж байдаг. Залилах гэмт хэрэг үйлдэх нэг гол нөхцөл нь мэдээллийн асимметри юм (Асимметр гэдэг ойлголт нь ерөнхийдөө тэнцвэргүй байдал).

Барилгын компани, түүний төлөөлөгчид болон зуучлагч этгээдүүд төслийн бодит нөхцөл, эрх зүйн эрсдэл, санхүүгийн байдал, бүртгэлийн статусын талаар илүү их мэдээлэлтэй байхад иргэн зөвхөн сурталчилгаа, борлуулалтын тайлбар, гэрээний өнгөц агуулгад тулгуурлан шийдвэр гаргах нь элбэг байдаг. Энэ тэгш бус байдал нь итгэл эвдэх боломжийг нэмэгдүүлдэг гэж үздэг. Түүнчлэн төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоо сул, урьдчилсан захиалгын гэрээ болон ирээдүйд өмчлөх эрх үүсэхтэй холбоотой хэлцлийн бүртгэл хангалтгүй хэрэгжиж байгаа нь нэг объектыг олон этгээдэд давхар борлуулах, барьцаанд байгаа хөрөнгийг дахин захиалгаар санал болгох, өмчлөх эрх шилжсэн мэт ойлголт төрүүлэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Иймд орон сууцны захиалгатай холбоотой эрх зүйн харилцаа нь нэг талаар иргэний эрх, өмчийн эргэлтийг хангах суурь механизм боловч нөгөө талаар баримт бичиг, бүртгэл, зөвшөөрөл, санхүүгийн урсгалыг ашигласан залилан үйлдэх эмзэг орчин болж байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Судалгааны материалаас үзэхэд 2019–2025 оны хугацаанд цагдаагийн байгууллагад Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан залилах гэмт хэргийн шинжтэй нийт 73,135 хэрэг бүртгэгдэн шалгагдсанаас орон сууцны захиалга авч бусдыг залилсан 2,365 хэрэг бүртгэгдсэн байна. Энэ нь залилах төрлийн нийт хэргийн

3.2 хувийг эзэлж байгаа боловч хохирогчийн тоо, хохирлын хэмжээний хувьд нийгэмд өндөр хор уршигтай байгааг харуулж байна. Тухайлбал, орон сууцны захиалгатай холбоотой залилах гэмт хэргийн улмаас нийт 4,129 иргэн 216.1 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. 2024 онд 820 иргэн 29.6 тэрбум төгрөгийн хохирол учирч, 2025 онд 1,445 иргэн 104.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь өмнөх онтой харьцуулахад 3.5 дахин өссөн үзүүлэлт гарчээ.

2025 онд нийт залилах гэмт хэргийн улмаас учирсан 694.6 тэрбум төгрөгийн хохирлын 15.1 хувийг орон сууцтай холбоотой залилах гэмт хэрэг дангаараа бүрдүүлжээ (Цагдаагийн ерөнхий газар, 2025).

Доорх хүснэгтэд энэ төрлийн гэмт хэргийн жилийн бүртгэл болон учирсан хохирлын хэмжээг үзүүлэв.

Хүснэгт №1. 2019–2025 онд орон сууцны захиалга авч бусдыг залилах гэмт хэргийн хохирлын тухай мэдээлэл (Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөх албан тайлан. Уб., 2025)

Орон сууцны захиалга авч бусдыг залилсан гэмт хэрэг хохирогч, хохирол (7 жилээр)				
№	Он	Орон сууц	Нийт хохирогч	Учирсан хохирол
1	2019	149	168	4,689,520,122
2	2020	186	201	5,125,126,200
3	2021	241	288	7,895,826,177
4	2022	412	568	19,412,721,270
5	2023	455	639	45,071,716,215
6	2024	413	820	29,561,186,845
7	2025	509	1445	104,310,511,680
Нийт		2030	4129	216,066,608,509

Залилах гэмт хэргийн улмаас 2025 онд 694,578,816,436 төгрөгийн хохирол учирч үүнээс орон сууцтай холбоотой хэргийн улмаас 104,310,511,680 төгрөгийн учирсан нь 15,1 хувийг дангаар эзэлж байна.

Хүснэг №2.

Он	Учирсан хохирол	Орон сууц хохирол	Эзлэх хувь	Хохирогчийн тоо
2025	694,578,816,436	104,310,511,680	15,1	1445

Томоохон аж ахуйн нэгжүүдтэй холбоотой хэргүүдийг авч үзвэл уг төрлийн залилах гэмт хэрэг нь нэг хэрэгт олон арван, бүр хэдэн зуун хохирогчтой, тэрбум төгрөгөөр хэмжигдэх хохиролтой байх нь нийтлэг байна. Энэ нь гэмт хэрэг дан ганц хувь хүний түвшний хуурч мэхлэх үйлдэл бус, компанийн нэр халхавчилсан зохион байгуулалттай схемд шилжиж буйн илрэл юм (https://itoim.mn/a/2026/03/19/event/hom, 2026).

Цагдаагийн байгууллагаас энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 143 орчим зар мэдээлэл байршуулсныг шалган үзэж мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд зарын 30 гаруй хувь иргэдийг төөрөгдүүлж, залилах шинжтэй гэмт хэрэг тогтоогдсон байна. Иргэдийг залилах гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүдийн насны хувьд харьцангуй адилгүй 18-35 насны хүмүүс энэ төрлийн хэргийг үйлдэж байна (https://news.mn/r/2820252/, 2026).

Судалгаанд дурдсанаар 30–34 насны иргэд (https://www.barilga.mn/n/23680/, 2026) энэ төрлийн гэмт хэрэгт харьцангуй их өртөж байгаа нь анхны орон сууцаа худалдан авах идэвхтэй насны бүлэгтэй холбоотой. Иймээс орон сууцны эрэлт өндөр,

мэдээллийн асимметри их, шийдвэр гаргалт хугацааны дарамттай үед гэмт этгээд итгэл төрүүлэх замаар захиалга авах эрсдэл өндөрсдөг байна.

Гэмт хэргийн криминалистик шинж гэдэг нь тодорхой төрлийн гэмт хэргийн нийтлэг, давтагдах, мөрдөн шалгах ажиллагааг чиглүүлэхүйц мэдээллийн тогтолцоо юм (Шаров, А.В. Методика расследования мошенничества в сфере оборота жилища: дисс. ... канд. юрид. наук. М, 2003.).

Орон сууцны захиалга авч бусдыг залилах гэмт хэргийн хувьд халдлагын зүйл, үйлдэх арга, цаг хугацаа, орчин, ул мөр үүсэх механизм, гэмт этгээд ба хохирогчийн онцлог зэрэг элементүүд онцгой ач холбогдолтой (П. Эрдэнэбаатар, Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүй сэдэвт докторын диссертаци. Уб., 2024.).

Нэгдүгээрт, гэмт халдлагын зүйл нь зөвхөн орон сууц гэх биежсэн объект бус, түүнтэй холбоотой өмчлөх, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх, ирээдүйд өмчлөх эрх үүсэх хүлээлт, түүнчлэн захиалагчийн төлсөн мөнгөн хөрөнгө юм. Тиймээс мөрдөн шалгах ажиллагаанд “объект” ба “эрх” гэсэн хоёр түвшнийг зэрэг авч үзэх шаардлагатай.

Хоёрдугаарт, үйлдэх арга нь гол төлөв хуурах, итгэл эвдэх, бодит байдлыг зориуд нуух, хуурамч эсхүл төөрөгдүүлсэн мэдээлэл өгөх, гэрээний бодит агуулгыг гуйвуулах хэлбэрээр илэрдэг. Практикт нэг объектыг олон этгээдэд давхар амлах, барилгын зөвшөөрөлгүйгээр мөнгө татах, удахгүй улсын комисс орно гэх мэт тайлбараар хугацаа хойшлуулах, гэрээг шинэчлэх нэрээр анхны нөхцөлийг өөрчлөх тохиолдол нийтлэг байна.

Гуравдугаарт, энэ төрлийн гэмт хэрэг нь ихэвчлэн олон үе шаттайгаар, урт хугацаанд хэрэгждэг. Сурталчилгаа хийх, борлуулалтын уулзалт зохион байгуулах, гэрээ байгуулах, урьдчилгаа болон үндсэн төлбөр авах, төсөл хэрэгжиж буй мэт тайлбар өгөх, хугацааг хойшлуулах, дараагийн хөрөнгө татах, эцэст нь ашиглалтад оруулахгүйгээр хохирол үүсгэх гэсэн дараалал ажиглагддаг. Иймээс “гэмт санаа хэзээ бүрэлдсэн бэ” гэдэг асуудал мөрдөн шалгах ажиллагааны төвд тавигдана.

Дөрөвдүгээрт, Хэргийн ул мөр үүсэх механизм нь баримт бичиг болон цахим баримтад төвлөрдөг. Захиалгын гэрээ, нэмэлт гэрээ, төлбөрийн баримт, банкны шилжүүлэг, сурталчилгааны материал, цахим орчин харилцсан харилцаа, төслийн зөвшөөрөл, газрын баримт, зураг төсөл, барьцааны мэдээлэл, улсын бүртгэлийн лавлагаа зэрэг нь гол нотлох баримтын эх сурвалж болдог.

Тавдугаарт, хохирогч нь ихэвчлэн орон сууцны зах зээлийн нарийн эрх зүйн зохицуулалтыг бүрэн мэдэхгүй, гэр бүлийн хэрэгцээнд тулгуурлан шийдвэр гаргасан иргэн байдаг бол гэмт этгээд нь харилцааны ур чадвартай, барилгын салбарын нэр томьёо, гэрээний хэлбэр, төслийн мэдээллийг ашиглан итгэл төрүүлэх чадвартай этгээд байх нь түгээмэл байна.

Иймд орон сууцны захиалгатай холбоотой залилах гэмт хэргийн криминалистик шинжийг зөв тодорхойлох нь нотлох баримт цуглуулах дараалал, мөрдөн шалгах таамаглал дэвшүүлэх, хэргийг иргэний маргаанаас ялгах, гэмт этгээдийн үүрэг оролцоог тогтоох суурь нөхцөл болдог.

Практикт энэ төрлийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хэд хэдэн нийтлэг хүндрэл тулгарч байна.

Нэгдүгээрт, хохирогчид ихэвчлэн тодорхой хугацаа өнгөрсний дараа хууль хяналтын байгууллагад ханддаг. Эхний үед барилгын ажил саатсан ч үргэлжилж байна, удахгүй ашиглалтад орно, гэрчилгээ гарна гэсэн тайлбарт итгэн хүлээдэг тул нотлох баримтыг эртхэн бэхжүүлэх боломж алддаг.

Хоёрдугаарт, захиалагчид гэрээний эх хувийг хадгалж үлдээгээгүй, гэрээний нөхцөлийг бүрэн ойлгоогүй, объектын байршил, давхар, хаалга, талбай, торгууль, баталгааны нөхцөлийг нягтлаагүй байх нь элбэг. Зарим тохиолдолд зөвхөн урьдчилгаа төлбөрийн баримт, мессеж, эсвэл борлуулалтын ажилтны аман тайлбарт үндэслэн их хэмжээний төлбөр шилжүүлсэн байдаг.

Гуравдугаарт, санхүүгийн чадамжгүй, өмнөх төслөө дуусгаагүй, зөвшөөрлийн бүрдэл дутуу аж ахуйн нэгжүүд урьдчилсан захиалгын нэрээр мөнгө төвлөрүүлж, түүнийг өөр төсөлд шилжүүлэх, өр төлбөр хаах, зориулалтын бусаар ашиглах явдал ажиглагддаг. Ийм хэрэгт санхүүгийн шинжилгээ, аудит, барилгын техникийн үнэлгээ, газрын болон бүртгэлийн материал зэрэг олон эх сурвалжийг зэрэг шалгах шаардлага үүсдэг.

Дөрөвдүгээрт, зарим барилгын компани алданги төлөхөөс зайлсхийхийн тулд захиалагчийг “гэрээгээ шинэчлэх шаардлагатай” гэж тайлбарлан анхны нөхцөлийг өөрчилдөг, эсвэл талбайн хэмжээг бууруулж, үнийн нөхцөлийг өөрчилж, эрхийн байдлыг бүдгэрүүлдэг. Энэ нь гэрээний энгийн үүргийн зөрчил үү, эсхүл анхнаасаа гэмт санаатай үйл ажиллагаа байсан уу гэдгийг ялгахад хүндрэл учруулна.

Тавдугаарт, хохирогчдын гол зорилго нь дан ганц гэмт этгээдийг шийтгүүлэх бус, төлсөн мөнгөө буцаан авах, эсхүл орон байртай болох байдаг. Гэтэл хэрэг удаашрах, хөрөнгө шилжиж алдагдах, компанийн бүтэц өөрчлөгдөх, татан буугдах, эзэн буцах хаяггүй болох нөхцөлд бодит нөхөн төлөлтөд саад тулгарч байна.

Орон сууцны захиалгатай холбоотой залилах гэмт хэргийг мөрдөн шалгахын тулд баримт бичигт тулгуурласан цогц шалгалт, мөнгөн хөрөнгийн урсгал мөрдөх, хохирогчийн төөрөгдөл хэрхэн бий болсныг нотлох, иргэний маргаанаас ялган тогтоох, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй уялдуулах, хөрөнгө хамгаалах шуурхай арга хэмжээ авах зэрэг чиглэлийг системтэй баримтлах шаардлагатай.

Юуны өмнө захиалгын гэрээ, нэмэлт гэрээ, төлбөрийн баримт, орлого, банкны шилжүүлэг, компанийн дүрэм, улсын бүртгэлийн мэдээлэл, газар эзэмших болон ашиглах эрхийн баримт, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл, зураг төсөл, төсөлтэй холбоотой сурталчилгааны материал, сошиал сүлжээний контент, цахим харилцааны баримт зэргийг нэгтгэн шалгах нь зүйтэй. Нэг баримтад тулгуурлан дүгнэлт хийхээс зайлсхийж, баримт бүрийн эх сурвалж, огноо, эрх бүхий этгээд, логик уялдаа, бодит хэрэглээг зэрэг тогтоох хэрэгтэй.

Дараагийн чухал асуудал нь мөнгөн хөрөнгийн урсгалыг мөрдөх шалгах явдал юм. Хохирогчдоос төвлөрүүлсэн мөнгө барилгын ажилд зарцуулагдсан уу, өөр компанийн өр төлбөрт шилжсэн үү, хувь хүний данс руу орсон уу, эсхүл хамаарал бүхий этгээдүүдээр дамжсан уу гэдгийг тогтоохгүйгээр гэмт санааны агуулгыг бүрэн илрүүлэх боломжгүй байдаг онцлогтой.

Мөн мөрдөн шалгах ажиллагаанд хохирогчийн төөрөгдөл хэрхэн бий болсон, гэмт этгээд ямар мэдээлэл өгч итгэлийг олсон, гэрээ байгуулах үед бодит байдлыг зориуд нуусан эсэх, төсөл хэрэгжих бодит боломж байсан уу гэсэн асуултад хариулах нь чухал. Өөрөөр хэлбэл, уг төрлийн хэргийг зөвхөн “гэрээ байгуулсан эсэх”, “анхнаасаа хуурч мэхлэх санаа байсан уу” гэсэн эрүүгийн эрх зүйн гол шалгуураар үнэлэх ёстой.

Мөрдөн шалгах ажиллагаанд хамгийн төвөгтэй асуудал нь гэрээний үүргийн зөрчил үү, эсхүл залилах гэмт хэрэг үйлдэх санаатай үйлдэл үү гэдгийг ялгах явдал. Хэрэв төсөл бодитоор хэрэгжиж байсан, зөвшөөрөл хүчинтэй, санхүүжилтийн эх үүсвэр бодитой, саатал гэнэтийн нөхцөлөөс үүдсэн бол иргэний маргаан байх боломжтой. Харин анхнаасаа зөвшөөрөлгүй, нэг объектыг олон этгээдэд давхар

гэрээлсэн, авсан мөнгийг өөр зориулалтаар хэрэглэсэн, биелэх боломжгүй амлалт өгсөн, бодит байдлыг зориудаар нуусан бол гэмт хэргийн шинж тодорно.

Үүнээс гадна үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тогтолцоог мөрдөн шалгах ажиллагаатай уялдуулах шаардлагатай. Ирээдүйд өмчлөх эрх үүсэхтэй холбоотой гэрээ, хэлцлийг бүртгэх боломж хуулиар байгаа боловч практикт хангалттай хэрэгжихгүй байгаа тул бүртгэл хийсэн эсэх, бүртгэлд ямар мэдээлэл туссан, барьцааны эрх, өмчлөх эрхийн статус, захиалагчдын нэрс хоорондоо таарч байгаа эсэхийг заавал мөрдөн шалгах нь зүйтэй.

Эцэст нь, эрсдэлтэй хөрөнгийг хамгаалах мөрдөн шалгах тактик ажиллагаа чухал. Банкны дансыг битүүмжлэх, үл хөдлөх эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, компанийн хувьцаа эзэмшил, барилгын материал, тоног төхөөрөмжийн хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг эхний шатанд авч чадвал бодит нөхөн төлөлтийг хангах боломж нэмэгдэнэ.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд зөвхөн эрүүгийн хариуцлагын арга хэмжээ хангалтгүй бөгөөд урьдчилан сэргийлэх, бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулах бодлого зэрэгцэн хэрэгжих шаардлагатай. Юуны өмнө орон сууцны захиалгын гэрээ, ирээдүйд өмчлөх эрх үүсэхтэй холбоотой хэлцлийг үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлд заавал бүртгэх, тухайн объект дээр гэрээ хийгдсэн тухай тусгай тэмдэглэгээ харагддаг тогтолцоо бүрдүүлэх нь зүйтэй юм.

Мөн нотариат, улсын бүртгэл, барилгын хяналт, татвар, санхүүгийн байгууллага, хууль хяналтын байгууллагын мэдээллийн уялдаа холбоог цахим түвшинд сайжруулснаар нэг объект дээр хэдэн гэрээ байгуулсныг бодит цагт хянах, давхар борлуулалт болон барьцааны эрсдэлийг эрт илрүүлэх боломж нэмэгдэнэ.

Практик кейсүүдээс үзэхэд туршлагагүй, санхүүгийн чадамжгүй, өмнөх төслөө дуусгалгүй шинэ төсөл эхлүүлдэг компаниуд олон иргэнийг эрсдэлд оруулж байна. Иймээс өмнөх төслийн хэрэгжилт, иргэдийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт, хохирлын нөхөн төлөлтийг шалгаж байж шинэ зөвшөөрөл олгодог хяналтын шалгуурыг чангатгах шаардлагатай. Хариуцлагагүй аж ахуйн нэгжийн нээлттэй мэдээллийн сан буюу “хар жагсаалт”, харин төслөө хугацаанд нь хэрэгжүүлдэг найдвартай компанийн эерэг мэдээллийн сан бий болгох нь урьдчилан сэргийлэх бодит ач холбогдолтой.

Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, орон сууц захиалах, урьдчилгаа төлбөр шилжүүлэхээс өмнө ямар баримт бичиг шалгах, ямар зөвшөөрөл заавал нягтлах, ямар байгууллагаас лавлагаа авах, аль нөхцөлд төлбөр шилжүүлэхээс татгалзах талаар төрөөс ойлгомжтой, тогтмол, хүртээмжтэй мэдээлэл түгээх шаардлагатай.

Дүгнэлт:

Орон сууцны захиалга авч бусдыг залилах гэмт хэрэг нь иргэний эрх зүйн хэлцэл, төрийн бүртгэл, барилгын зөвшөөрөл, санхүүгийн харилцаа зэрэг хууль ёсны мэт харагдах олон механизмд тулгуурлан үйлдэгддэг, баримт бичигт суурилсан, олон үе шаттай, удаан хугацаанд үргэлжилдэг онцлогтой гэмт хэрэг юм. Энэ нь уг хэргийг бусад өмчийн эсрэг гэмт хэргээс ялган зөв ангилах, гэмт санааны агуулгыг тогтоох, хохирлын хэмжээг үнэн зөв тодорхойлох, нотлох ажиллагааг оновчтой чиглүүлэхэд бодит хүндрэл үүсгэж байна.

Судалгааны дүнгээс үзэхэд 2019–2025 онд 2,365 хэрэг бүртгэгдэж, 4,129 иргэнд 216.1 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь уг төрлийн гэмт хэргийн хор аюул бодитоор өссөнийг нотолж байна. 2025 онд нийт залилах гэмт хэргийн хохирлын 15.1 хувийг орон сууцтай холбоотой залилан дангаараа бүрдүүлсэн нь төр, хууль хяналтын

байгууллага, барилгын салбар, иргэдийн хувьд энэ асуудалд тусгайлан анхаарах шаардлагатайг харуулж байна.

Иймд энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүйг боловсронгуй болгох, санхүүгийн урсгал мөрдөх чадавхыг нэмэгдүүлэх, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн хяналтыг сайжруулах, байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог бэхжүүлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх нь уг төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх шаардлага тулгарч байна.

Санал:

Орон сууцны захиалга авч бусдыг залилах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор эрх зүйн болон зохион байгуулалтын дараах шинэчлэлийг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Төрийн байгууллагуудын мэдээллийн солилцоог цахимжуулан уялдуулах шаардлагатай. Улсын бүртгэл, барилгын хяналт, санхүүгийн байгууллага болон татварын мэдээллийг нэгтгэсэн нэгдсэн цахим системийг хөгжүүлснээр барилгын төслийн зөвшөөрөл, хэрэгжилт, санхүүжилтийн урсгалыг бодит цагийн горимоор хянах боломж бүрдэж, залилах шинжтэй үйлдлийг илрүүлэх нөхцөл сайжирна.
2. Мөрдөн шалгах ажиллагаанд санхүүгийн мөрдлөгийн чадавхыг бэхжүүлж, мөнгөн хөрөнгийн урсгалыг дансны хөдөлгөөн, хамаарал бүхий этгээд, зуучлалын сувгуудын түвшинд иж бүрэн тогтоох арга зүйг хөгжүүлэх шаардлагатай. Үүний зэрэгцээ цахим баримт, гэрээний хэрэгжилт, сурталчилгааны мэдээлэл болон харилцааны нотлох баримтыг нэгтгэн шинжлэх боломжийг нэмэгдүүлэх нь гэмт санаа болон иргэний эрх зүйн зөрчлийг зөв ялган тогтоох үндсэн нөхцөл болно.
3. Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн өмнөх төслийн хэрэгжилт, санхүүгийн сахилга бат, хохирол барагдуулах чадавхыг харгалзан шинэ төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгодог хяналтын тогтолцоог чангатгах шаардлагатай. Найдвартай болон эрсдэл өндөртэй этгээдийн мэдээллийн ил тод сан бүрдүүлэх нь зах зээлийн эрсдэлийг бууруулах чухал юм.
4. Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, орон сууц худалдан авахын өмнө заавал шалгах баримт бичиг, зөвшөөрөл, бүртгэлийн мэдээллийн талаар тогтмол, системтэй мэдээлэл түгээх бодлогыг хэрэгжүүлэх нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэхэд онцгой ач холбогдолтой юм.

Ашигласан эх сурвалж:

1. П. Эрдэнэбаатар, Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүй сэдэвт докторын диссертаци. Уб., 2024.
2. Шаров, А.В. Методика расследования мошенничества в сфере оборота жилища: дисс. ... канд. юрид. наук. Москва, 2003.
3. Монгол Улсын Эрүүгийн хууль. Уб., 2015
4. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Уб., 2017
5. Монгол Улсын Иргэний хууль. Уб., 2002
6. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай. Уб., 2018
7. Барилгын тухай хууль. Уб., 2016

Цахим эх сурвалж:

1. Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөх албан тайлан. Уб., 2025
2. https://itoim.mn/a/2026/03/19/event/hom
3. https://news.mn/r/2820252/
4. https://www.barilga.mn/n/23680/